ХААН Банкны худалдааны санхүүжилтийн мэргэжилтнүүдийн баг гадаад худалдаа эрхлэгч ААН-үүдийн гадаад худалдааны үйл ажиллагааг дэмжих, тэдний үйл ажиллагааны онцлог, холбогдох худалдааны эрсдэлийг бууруулан удирдахад зориулан олон улсад өргөнөөр ашиглагддаг худалдааны төлбөр тооцооны хэрэгсэл, санхүүжилтийн үйлчилгээг Олон улсын худалдаа аж үйлдвэрийн танхимгаас гаргасан UCP, URDG, ISP, Incoterms зэрэг нийтлэг стандартын дагуу санал болгон ажиллаж байна. Энэ диглэлээр



2023 5 29

БҮР
2023
сэр

Тайванийн экспорт импортын банк, Atlantic Forfaiting, ODDO BHF Bank, Commerzbank, La Caixa Bank, Erste Bank гэх мэт олон улсын 30 гаруй банк, санхүүгийн байгууллагаас 200 гаруй сая ам.долларын худалдааны шугам нээлгэн харилцагчдынхаа гадаад худалдааг санхүүжүүлж байна. ХААН Банк нь Азийн хөгжлийн банк (ADB), Европын сэргээн босголт хөгжлийн банк (EBRD), Олон улсын санхүүгийн корпорацийн (IFC) Худалдааны санхүүжилтийг дэмжих хөтөлбөрийн гишүүн банк бөгөөд эдгээр хөтөлбөрийн хүрээнд олон улсын 800 гаруй шилдэг банктай худалдааны санхүүжилтийн чиглэлээр хамтран ажилладаг. ХААН Банкны худалдааны санхүүжилтийн нийт эргэлт 2022оны 12 дугаар сарын байдлаар 141.4 сая ам.доллар байгаа бөгөөд үүний 88% нь худалдааны зээл, 12% нь төлбөрийн хэрэгслээс бүрдэж байна. ХААН Банк нь EBRD-ийн Худалдааны санхүүжилтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд "Хамгийн идэвхтэй худалдааны санхүүжүүлэгч банк" шагналыг 13 дахь удаагаа, ADB-ийн хөтөлбөрийн хүрээнд мөн "Худалдааны санхүүжилтийн шилдэг банк" шагналыг 5 дэх удаагаа тус тус хүртлээ. Түүнчлэн EBRD болон ADB-тай хамтран нийт 50 орчим ажилтныг худалдааны санхүүжилтийн нарийн мэргэжлийн, 1,000 гаруй ажилтан болон харилцагчдыг худалдааны санхүүжилтийн олон улсын сертификаттай сургалтад тус тус хамруулан чадавхжуулав.

ХААН Банк нь гадаад худалдаа эрхэлдэг харилцагчдаа аккредитивийн төлбөр тооцоог дахин санхүүжүүлэх, ачилтын өмнөх болон дараах санхүүжилтийг харилцагчдынхаа санхүүгийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн хүргэсээр байгаа бөгөөд үүний үр дүнд нийт худалдааны санхүүжилтийн хэрэгслүүд, олгосон санхүүжилтийн хэмжээ тогтмол өндөр өсөлттэй гарсаар байна.

Олон улсын SWIFT сүлжээгээр 13 төрлийн валютаар (USD, EUR, CNY, JPY, CHF, GBP, CAD, AUD, KRW, RUB, SGD, NZD, HKD) харилцагчдын гадаад төлбөр тооцоог шуурхай, найдвартай дамжуулдаг. ХААН Банк олон улсын 28 банкан дахь 49 ностро дансаар дамжуулан гадаад гуйвуулгын үйлчилгээг үзүүлж, жилд нийт 4.4 тэрбум ам.долларын нийт дүн бүхий 131 мянга гаруй гадаад гуйвуулгыг гүйцэтгэн ажиллаж байна.

2022 оны эцсийн байдлаар ХААН Банкны SWIFT сүлжээгээр хийгдсэн нийт гадаад гүйлгээний тоо өмнөх оны мөн үеэс 4%-иар буурч, харин нийт дүнгээр 29%-иар өссөн ба илгээсэн гуйвуулгын хувьд зах зээлд III, хүлээн авсан гуйвуулгын хувьд зах зээлд I байрыг тус тус эзэлсэн байна. Нийт гуйвуулгыг улс орноор нь ангилан үзвэл нийт илгээсэн болон хүлээн авсан гүйлгээний тоон үзүүлэлтээр БНСУ (40%) тэргүүлсэн бол БНХАУ (23%) болон Сингапур (17%) улсууд удаалж байна.

ХААН Банк нь SWIFT гpи үйлчилгээг Монгол Улсын зах зээлд анхлан 2019 онд нэвтрүүлсэн. Энэ үйлчилгээ нь харилцагчийн гадаад төлбөр тооцоог гүйлгээний байршил, гүйлгээг дамжуулахад оролцогч банкууд, тэдгээрийн тооцсон шимтгэл, дамжуулахад зарцуулсан хугацаа, гүйлгээ хүлээн авагчид очсон эсэхийг бодит цаг хугацааны горимд лавлах боломжийг бүрдүүлдэг.

ХААН Банк нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай олон улсын дүрэм журам болон Монгол Улсын хууль дүрэм, дотоодын бодлого, журмын хэрэгжилтийг ханган ажилладаг ба олон улсын банк, санхүүгийн байгууллагуудтай шинээр харилцаа тогтоож үйл ажиллагаагаа улам өргөжүүлэн ажиллаж байна.

Мөн техник технологийн хөгжил, үүлэн болон блокчэйн технологид суурилсан гадаад төлбөр тооцооны шийдлийг нэвтрүүлж, гадаад гуйвуулгын урсгалыг саадгүй, хурдан шуурхай дамжуулах боломжийг бүрдүүлэхээр шаргуу ажиллаж байна. 2022 онд ХААН Банк БНСУ-ын Хана банктай хамтран "Hana EZ" мөнгөн шилжүүлгийн үйлчилгээг нэвтрүүлснээр БНСУ-д сурч, ажиллаж амьдардаг иргэд Монгол руу 1 минутын дотор хамгийн хямд зардлаар шуурхай мөнгө шилжүүлэх, хуримтлал үүсгэх боломж бүрдүүлэн ажилласан.

Валют арилжаа

ХААН Банк нь валютын арилжааны дотоодын зах зээлийн арилжааны эргэлтийн 30 орчим хувийг бүрдүүлдэг бөгөөд банкны өргөн сүлжээ, салбар тооцооны төвүүдээрээ дамжуулан 13 төрлийн

МОНГОЛ
УЛСЫН
ХААН БАНК
1115203447

МХБ-ийн гишүүн
Андеррайтер
Брокер, дилерийн
"БНДИЕК"
1115203447

2023 5 29 1

валютын хослолыг санал болгон харилцагчдынхаа гадаад валют арилжааны эрэлт хэрэгцээг хангаж ажилладаг.

Харилцагчдын гадаад валютын эрэлт хэрэгцээг хангах, банкны гадаад валютын позицййн удирдлагыг хэрэгжүүлэх үүднээс Saxo Bank, StoneX, Raiffeisen Bank, Transcapital Bank, Kookmin, KEB Hana Bank зэрэг олон улсад нэр хүнд бүхий банк санхүүгийн байгууллагуудтай хамтын ажиллагаагаа үргэлжлүүлэн ажиллаж байна. Банкны зүгээс өндөр дүнтэй валют арилжаа хийж буй харилцагчдад "Валют арилжааны хэлцэл" буюу самбарын ханшаас илүү сайн ханшаар арилжааны ханш тохирох үйлчилгээг санал болгодог. Банк нь жилд дунджаар 7 гаруй мянган валют арилжааны хэлцлийг хийж, харилцагчдынхаа валют арилжааны эрэлт хэрэгцээг хангаад байна. Банк нь өдөрт дунджаар 31 сая ам.доллартай тэнцэхүйц валют арилжааг гадаад болон дотоодын харилцагч нартайгаа хийдэг ба валютын захын хамгийн том оролцогчдын нэг юм. Түүнчлэн сүүлийн жилүүдэд ХААН Банк нь Монголбанкнаас зохион байгуулдаг валютын дуудлага худалдааны арилжааны эргэлтийн 30 орчим хувийг дангаар бүрдүүлсэн байна. Мөн Монголбанкны цахим арилжааны системд 2017 оноос хойш тасралтгүй үндсэн дилерээр сонгогдон ажиллаж байна. Эдгээр үзүүлэлтүүд нь ХААН Банкны системийн хэмжээнд тэргүүлэгчийн байр суурийг улам бүр бататгаж өгсөн.

Валютын своп, форвард арилжаа

Банк нь гадаад худалдааны бизнес эрхлэгч харилцагчдадаа гадаад валютын ханшийн эрсдэлээс хамгаалах 3 хүртэлх сарын хугацаатай санхүүгийн үүсмэл хэрэгслүүд болох своп, форвард арилжааг санал болгон ажиллаж байна.

ХААН Банк нь 2016 оноос хойш гадаад худалдааны үйл ажиллагаа эрхэлдэг харилцагчдадаа зориулан богино хугацаат своп, форвард хэлцлийг санал болгож ирсэн.

Мөн олон улсын санхүүгийн байгууллагуудаас татсан урт хугацаат, гадаад валютын эх үүсвэрүүдийг Монголбанкттай урт хугацаат своп хэлцэл хийж Монгол Улсын гадаад валютын албан нөөцийг нэмэгдүүлэхэд хувь нэмрээ оруулж ирсэн юм.

Алтны арилжаа

2014 оноос алт олборлогч ААН болон хувь хүмүүст биет алтны арилжааг санал болгож эхэлсэн. Өнөөдрийн байдлаар банк нь Улаанбаатар хот болон Баянхонгор аймагт байрлаж буй алт худалдан авах цэгүүдээр дамжуулан биет алт худалдан авч байна. Мөн 2020 онд алт олборлогч ААН болон харилцагч нартаа зориулан шинэ бүтээгдэхүүнийг санал болгож эхэлсэн. Энэхүү бүтээгдэхүүний онцлог нь харилцагч (алт олборлогч ААН болон хувь хүн) олон улсын зах зээл дээрх өөрийн зорилтот ханшин дээрээ биет алтаа зарах захиалгыг банкаар дамжуулан өгөх боломжтой гэдгээрээ энгийн арилжаанаас давуу талтай юм.

Мөнгөний захын үйл ажиллагаа

ХААН Банк нь ам.доллороор сул мөнгөн хөрөнгийг хүүгийн орлого олдог, хөрвөх чадвартай активт байршуулах зорилгоор Монгол Улсын олон улсын зах зээл дээр гаргасан ам.доллороорх евро бонд, АНУ-ын ЗГ-ын үнэт цаас, гадаадын банканд нэг жил хүртэлх овернайт хадгаламж болон Монголбанканд BIS хүүн дээр хадгаламж байршуулж ажиллаж байна.

2022 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар АПУ Хорооноос тогтоож өгсөн лимит нь 283 сая доллар байна. Банк 229 сая ам.долларын үнийн дүн бүхий бондыг 5.55%-ийн ЖДХ-гээр эзэмшиж байна. Мөн 2022.12.07-с эхлэн АПУХорооны шийдвэрээр тогтоосон лимитийн хүрээнд нийт 15 сая ам.долларын үнийн дүн бүхий 4.53%-ийн ЖДХ-тай АНУ-н ЗГ-н өрийн үнэт цаасыг эзэмшиж байна.



2023 5 29

Урт хугацаат репо хэлцэл

Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй 10 их наядын хөтөлбөрийн нэг хэсэг болох Монголбанкны урт хугацаат репо санхүүжилттэй хөтөлбөрийг ХААН Банк дэмжин ажиллаж байна. Энэхүү хөтөлбөр нь жижиг дунд үйлдвэрлэл, уул уурхайн бус экспорт, үйлчилгээ, боловсруулах үйлдвэрлэл, 200 болон түүнээс дээш ажилтантай бөөний болон жижиглэн худалдааны салбарт үйл ажиллагаа явуулж буй этгээдүүдийн үйл ажиллагааг дэмжих зорилготой юм.

Эрсдэл хуваах нөхцөлтэй зээлийн гэрээ

ХААН Банк болон Европын сэргээн босголт, хөгжлийн банк нь хамтран эрсдэл хуваах нөхцөлтэй зээл санхүүжүүлэх зорилгоор 25 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий банк хоорондын зээлийн гэрээг байгуулах тохиролцоонд хүрээд байна. Энэхүү зээлийн гэрээнд банк болон Европын сэргээн босголт, хөгжлийн банк хамтран харилцагчдад анх удаа хувьсах хүүтэй зээлийг санал болгох нөхцөлийг оруулж байгаагаараа онцлогтой.

Картын бүтээгдэхүүн**Дебит картын бүтээгдэхүүн**

ХААН Банк иргэд болон байгууллагын харилцагчдадаа төлбөр тооцоогоо шуурхай, саадгүй хийх, дансанд байгаа мөнгөн хөрөнгөө эрсдэлгүй зарцуулахад нь туслах зорилгоор олон улс болон дотоодод ашиглах боломжтой иргэдийн хэрэгцээнд зориулсан 8 төрөл, байгууллагын хэрэгцээнд зориулсан 2 төрлийн дебит картыг санал болгодог.

Харилцагчид интернэт банк, ХААН Банк аппликэйшн, КИОСК төхөөрөмж болон Үйлчилгээний нэгдсэн төвөөр дамжуулан карт захиалах боломжтой ба захиалсан картаа шуудангын хаягаар хүргүүлэн хүлээн авдаг. Харилцагчдын захиалсан нийт картын 85-90 хувийг харилцагчийн хүссэн хаягт шуудангаар шуурхай хүргэн ажиллаж байна. Түүнчлэн, картын бусад үйлчилгээг зайнаас буюу цахим орчинд үзүүлдэг. 2022 оны эцсийн байдлаар 1.8 сая харилцагч, давхардсан тоогоор 2.4 сая ширхэг идэвхтэй төлөвтэй дебит карт үйлчилгээнд байсан бөгөөд дебит картын тоогоор 54%, идэвхтэй гүйлгээ хийгддэг картын хувьд 65%-ийн зах зээл эзэлж байна.

Кредит картын бүтээгдэхүүн

ХААН Банкны харилцагчид болон бизнес эрхлэгч нарт зориулан санхүүгийн хэрэгцээг уян хатан хангах, төлбөр тооцоо гүйцэтгэх зорилгоор 8 төрлийн кредит картын бүтээгдэхүүн үйлчилгээг санал болгодог. Кредит картууд нь харилцагчийн онцлог хэрэгцээнд тохирсон байх зорилготойгоос гадна худалдан авалтын хөнгөлөлт, онооны урамшуулал, буцаан олголт гэх мэт урамшууллын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлдэг.


Кредит картын борлуулалтын зах зээл эзлэлт (картын тоогоор) 2022 оны эцсийн байдлаар 56% байсан.

Картаар үйлчлэгч байгууллагын үйлчилгээ

ХААН Банкны харилцагч болон бизнес эрхлэгчдэд зориулан картаар төлбөр тооцоо гүйцэтгэх дэд бүтцийг бүрдүүлэх, бэлэн бус төлбөр тооцооны хэрэглээг нэмэгдүүлэх зорилгоор ПОС төхөөрөмжийг санал болгон ажилладаг.

Эдгээр ПОС төхөөрөмж дээр дотоодын болон олон улсын туузан, EMV чиптэй болон контактлес бүх төрлийн картыг хүлээн авахаас гадна PASS ухаалаг түрийвчээр хийсэн төлбөр тооцоог QR кодоор хүлээн авч гүйцэтгэдэг. Түүнчлэн онлайн худалдаа эрчимтэй нэмэгдэж буй энэ үед дотоодын банкуудын гаргасан нийт картууд болон гадаадын банкны гаргасан Виза картыг И-коммерс буюу цахим худалдаанд хүлээн авах үйлчилгээг мөн санал болгож байна.

Картаар үйлчлэгч байгууллагуудад зориулсан бүтээгдэхүүн үйлчилгээнүүдээс дурдвал:



2023 5 29 1



- Cashback - ХААН Банкны төлбөрийн карт эзэмшигчид ХААН Банкны ПОС төхөөрөмж ашигладаг картаар үйлчлэгч байгууллагаас 200,000 төгрөг хүртэл бэлэн мөнгийг авах боломжтой үйлчилгээ;
- Агент - Юнител болон Скайтилийн хэрэглэгчид ХААН Банкны ПОС төхөөрөмж дээр төлбөр төлөх, нэгж авах, шинэ дугаар авах зэрэг үйлчилгээг авах боломжтой;
- ECR – холболт - Банкны ПОС терминалыг кассын машинтай холбох үйлчилгээ ба карт уншигч машин дээр гараас дүн оруулахгүй, кассын ажилтны гар ажиллагаа багасгаж түргэн шуурхай үйлчлэх нөхцөл бүрдэнэ;
- PASS ухаалаг түрийвч - ХААН Банкны төлбөрийн карт эзэмшигчид картаа PASS ухаалаг түрийвч үйлчилгээнд холбосноор төлбөр тооцоог гар утаснаасаа буюу аппликэйшнээр хийх боломжтой.
- Цахим худалдаа үйлчилгээ - Онлайн картаар үйлчлэгч байгууллагуудад зориулсан төлбөр тооцоо хүлээн авах үйлчилгээ бөгөөд бүх төрлийн картуудыг хүлээн авах боломжтой. Түүнчлэн бид олон улсын Виза картыг цахим худалдаа үйлчилгээнд төлбөр тооцоо гүйцэтгэх Visa 3D Secure V.2 үйлчилгээг 2022 оны 2 дугаар сард зах зээлд анх удаа нэвтрүүлээ;
- Alipay төлбөрийн үйлчилгээ - Хятад болон Зүүн өмнөд Азид түгээмэл ашиглагддаг Алипэй төлбөрийн аппликэйшнийг Монгол Улсын картаар үйлчлэгч байгууллагууд төлбөр тооцоондоо хүлээн авах боломжийг нээн тус үйлчилгээг 2022 оноос эхлэн харилцагчдадаа санал болгож эхэлсэн. Ингэснээр гадаадын жуулчид, бизнес эрхлэгчдэд үзүүлсэн бараа, үйлчилгээний төлбөрийг шуурхай хүлээн авах боломж нээгдэж байна.

Картын лоялти:

Арилжааны банкууд дундаа хамгийн анхдагч лоялти систем нэвтрүүлэн карт эзэмшигчдийнхээ сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх зорилготойгоор лоялти урамшуулалт хөтөлбөрүүдийг тогтмол хэрэгжүүлдэг. Лоялти урамшуулалт хөтөлбөр нь картын бүтээгдэхүүний төрөл, тухайн цаг үеийн нөхцөл байдалд тохируулан оноо цуглуулан зарцуулах, купон олгон хөнгөлөлт эдлэх, худалдаа үйлчилгээний байгууллагуудад худалдан авалт хийхдээ тодорхой хувиар шууд хөнгөлөлт эдлэх боломжтой. ХААН Банкны карт тус бүрийн онцлогт тохирсон лоялти КҮБ-уудыг элсүүлж, өнөөдрийн байдлаар байнгын хөнгөлөлтөөр хамтардаг 215 байгууллагатай болсон. Эдгээр лоялти байгууллагуудыг карт эзэмшигч харилцагч нартаа хялбар, ухаалаг байдлаар харуулах боломжтой "THANKS.MN" апп-ийг нэвтрүүлэн амжилттайгаар ажиллаж байна.

Цахим бүтээгдэхүүнүүд

ХААН Банкны цахим банканд интернэт банк, ХААН Банк аппликэйшнээс гадна мобайл банк, телефон банк, АТМ, Киоск зэрэг зайны сувгуудаар хийгддэг үйлчилгээ багтдаг.

1.8 сая Карт эзэмшигч	1.4 сая Интернэт банк	941 мянга USSD мобайл банк
116 мянга Телефон банк	37 мянга Пос	1,428 АТМ
		234 Киоск

Интернэт банк

Интернэт банк нь интернэтэд холбогдсон дурын төхөөрөмжөөс www.khanbank.com вэбсайтаар дамжуулан орон зай, цаг хугацаанаас үл хамааран банкны үйлчилгээг хүргэдэг.



2023 5 29 1



ХААН БАНК

2023-09-03
БҮРТГЭЭР.02

Харилцагч иргэддээ интернэт банкаар дамжуулан данс, гүйлгээ, карт, зээл, төлбөртэй холбоотой болон бусад үйлчилгээг санал болгодог бол бизнес эрхлэгчдэд данс, гүйлгээ, төлбөр тооцоо болон бусад үйлчилгээг үзүүлж байна.

ХААН Банк аппликэйшн

Ухаалаг гар утасны апп ашиглан санхүүгийн болон санхүүгийн бус үйлчилгээг хүссэн газраасаа авах боломжтой.

Киоск

Киоск машин нь ХУР системтэй холбогдон, харилцагчийг хамгийн өндөр түвшинд танин баталгаажуулж чаддаг, мөн цахим үйлчилгээг хэрэглэж дадаагүй харилцагч нарт дуут зааварчилгаа өгөхөөс гадна онлайн туслахтай холбогдон дүрсээр зааварчилгаа өгдгөөрөө давуу талтай.

Харилцагч киоск машинаас онлайн операторын тусламжтайгаар дансны хуулга, тодорхойлолт авах, гүйлгээ хийх, бүх төрлийн хөрөнгийн татвар төлөх, цахим үйлчилгээнд бүртгүүлэх, мэдээллээ шинэчлэх зэрэг үйлчилгээ авах боломжтой.

Мобайл банк 2.0

Бүх төрлийн гар утаснаас *1917# дугаарт залган банкны үйлчилгээ авах боломжтой. Мобайл банк 2.0 нь USSD технологид суурилсан Мобайл банк үйлчилгээний шинэчлэгдсэн хувилбар юм.

Мобайл банк нь интернэтийн сүлжээ шаардахгүй, гар утсанд нэмэлт тохиргоо хийх шаардлагагүй, Сим картан дээр цэс суулгах шаардлагагүй, бүх төрлийн гар утаснаас авах боломжтой, өөрийн сим картаа ямар ч утсанд холбосон шууд хэрэглэх зэрэг давуу талтай. Харилцагч мобайл банкаар гүйлгээ, төлбөр хийх, үлдэгдэл хуулга харна. Мөн гүйлгээний баримтаа и-мэйл хаягаараа авах боломжтой үйлчилгээ юм. Энэ үйлчилгээг Мобиком, Скайтел, Юнителийн хэрэглэгч нар авах боломжтой.

АТМ

ХААН Банкны бэлэн мөнгөний машин АТМ (Automated Teller Machine)-ын үйлчилгээ.

Бэлэн мөнгөний машинаар орлого, зарлагын гүйлгээ хийх, банк доторх шилжүүлэг хийх, төлбөр төлөх, карт идэвхжүүлэх, пин код солих, интернэт банкны пин код авах, дансны үлдэгдэл шалгах, дансны хуулга, гүйлгээний баримт авах зэрэг үйлчилгээ авах боломжтой.

Телефон банкны үйлчилгээ

ХААН Банкны Үйлчилгээний нэгдсэн төвийн 1800-1917 тусгай дугаарт холбогдон гүйлгээ, шилжүүлэг хийх, төлбөр төлөх, дансны мэдээллээ хянах, валют арилжаа болон албан ханшийн мэдээллийг утсандаа мессежээр авах, картаа хаах зэрэг үйлчилгээ авах боломжтой.


Ухаалаг мэдээ

Ухаалаг мэдээ үйлчилгээнд бүртгүүлсэн харилцагч өөрийн дансандаа хийгдсэн гүйлгээ бүрийн мэдээллийг гар утсандаа шууд хүлээн авах, өөрийн дансаа хянах боломжтой. Дансанд хийгдсэн 5000 төгрөг болон түүнээс дээш дүнтэй орлого зарлагын мэдээлэл гар утсанд ирэх бөгөөд аль ч үүрэн телефоны хэрэглэгч "Ухаалаг мэдээ" үйлчилгээг авах боломжтой.

Корпорэйт гэтвэй (байгууллага)

Open Banking API технологи дээр суурилсан энэхүү үйлчилгээг олон улсын вендор байгууллага Google Arisee, гадаадын болон дотоодын ERP, санхүүгийн программ хөгжүүлэгч байгууллагуудтай хамтран байгууллагын харилцагчдад хүргэн ажиллаж байна.

Харилцагч байгууллагууд нь энэхүү үйлчилгээг өөрийн онцлогт тааруулан ашиглах боломжтой ба давхар шивэлт хийх шаардлагагүй болох, гүйлгээ хийх болон дансны хуулга татах үйлчилгээг автоматжуулах,



2023 5 29

2023.06.09
БҮР

нягтлан бодох, санхүүгийн үйл ажиллагаандаа нэвтрүүлэн ашиглах, гүйлгээний мэдээллийг нэгдсэн байдлаар хүлээн авч, хяналт тавих, гүйлгээний эрхийн тохиргоо хийх, тоон гарын үсгээр гүйлгээг баталгаажуулах зэрэг давуу талуудыг үүсгэж байна.

Цалин дамжуулах үйлчилгээ (байгууллага)

Байгууллагын харилцагч гэрээгээ шинэчлэн тус үйлчилгээнд нэгдсэнээр банкны салбарт очих, эсвэл интернэт банк ашиглах шаардлагагүйгээр <https://corporate.khanbank.com> хуудсаар дамжуулан хэзээ ч, хаанаас ч цалингийн гүйлгээгээ хийх боломжтой.

Свип үйлчилгээ (Байгууллага)

Харилцагчийн Монгол орон даяар байрших борлуулалт, үйлчилгээний салбар, нэгжүүдийн орлогыг нэгдсэн төв дансанд автоматаар төвлөрүүлж, бэлэн мөнгө нь бизнесийн хэрэгцээт үйл ажиллагаанд цаг алдалгүй зарцуулагдах боломжийг олгодог үйлчилгээ.

QPay үйлчилгээ

ХААН Банкнаас зах зээлд анхлан нэвтрүүлсэн, QR кодоор төлбөр төлөх, гүйлгээ хийх боломж бүхий үйлчилгээ.

- ✓ Санхүүгийн программтай байгууллагууд QPay холболтыг хийснээр нэхэмжлэлдээ автоматаар QR код үүсгүүлэх боломжтой.
- ✓ Орлого хүлээн авах дансандаа QR код үүсгэж хэрэглэгчдээс төлбөр хүлээн авах боломжтой.
- ✓ QR кодыг QPay үйлчилгээнд нэгдсэн бусад банкуудын апп-нээс уншуулах боломжтой.

Хөрөнгө оруулалтын болон кастодиан үйлчилгээ

Хөрөнгө оруулалтын үйлчилгээ

Валют арилжаа – Банк нь дотоодын валютын зах зээлд тэргүүлэгч байр суурьтай оролцдог бөгөөд банкны өргөн сүлжээ, салбар тооцооны төвүүдээрээ дамжуулан 12 төрлийн валютын хослолыг харилцагчдадаа санал болгон гадаад валютын эрэлт хэрэгцээг нь ханган ажилладаг. Түүнчлэн гадаад худалдааны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ААН-үүдэд ханшийн эрсдэлээ оновчтой удирдахад нь зориулж богино хугацаатай валютын своп болон форвард арилжааг санал болгодог.

Алтны арилжаа - 2015 оноос эхлэн алт олборлогч ААН болон хувь хүмүүст биет алтны арилжааг санал болгоод байна. Өнөөдрийн байдлаар Банк нь Улаанбаатар хот болон Баянхонгор аймагт байрлаж буй алт худалдан авах цэгүүдээр дамжуулан биет алт худалдан авч байна.

Мөн 2020 онд алт олборлогч ААН болон харилцагч нартаа зориулан шинэ бүтээгдэхүүнийг санал болгож эхэлсэн. Энэхүү бүтээгдэхүүний онцлог нь харилцагч (алт олборлогч ААН болон хувь хүн) олон улсын зах зээл дээрх өөрийн зорилтот ханшин дээрээ биет алтаа зарах захиалгыг банкаар дамжуулан өгөх боломжтой байдгаараа энгийн арилжаанаас давуу талтай юм.

Кастодианы үйлчилгээ

ХААН Банк нь 2015 оноос кастодианы үйлчилгээг үзүүлж эхэлсэн бөгөөд гадаад болон дотоодын хөрөнгө оруулагч нарт олон улсын жишигт нийцсэн кастодиан банкны үйлчилгээг банкны бусад үйлчилгээний хамт цогц байдлаар үзүүлж байна.


ХААН Банк нь харилцагчийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны төрөл, онцлогоос хамааран хөрөнгө оруулагчдад үзүүлэх үйлчилгээ, хөрөнгө оруулалтын санд үзүүлэх үйлчилгээ гэсэн багц үйлчилгээнүүд болон үнэт цаас гаргагчдад үзүүлэх үйлчилгээ, агентын үйлчилгээг санал болгодог. Үүнд:

Хөрөнгө оруулагчид болон хөрөнгө оруулалтын сангуудад үнэт цаас худалдал, үнэт цаасны төлбөр тооцоо, компанийн үйл ажиллагаа, бэлэн мөнгөний удирдлага, тайлагнааг гэсэн үндсэн



2023 5 29





- Үйлчилгээг үзүүлдэг ба хөрөнгө оруулалтын сангуудад нэгж эрхийн бүртгэл, цэвэр хөрөнгийн үнэлгээний хяналт гэсэн нэмэлт үйлчилгээ үзүүлж байна.
- Үнэт цаас гаргагч компаниудад хадгаламжийн бичиг бүртгэх, үнэт цаасны бүртгэл (registrar), төлбөрийн агентын үйлчилгээ үзүүлдэг.
- Мөн эскроу агент, барьцаа хөрөнгийн агентын үйлчилгээг санал болгож байна.

ХААН Банк нь хөрөнгийн зах зээл дээр төлбөр гүйцэтгэгч банкны үүрэг гүйцэтгэдэг бөгөөд МҮЦКТ-ийн гишүүнчлэлийн төрлөөс хамааран клирингийн бус гишүүн ҮЦК, тэдгээрийн харилцагчдад МХБ дээрх үнэт цаасны арилжааны мөнгөн төлбөрийг гүйцэтгэх үйлчилгээ, клирингийн гишүүн ҮЦК-д зөвхөн номинал дансны үйлчилгээг тус тус үзүүлдэг.

Даатгалын зуучлал

ХААН Банк нь Банкны тухай хууль болон Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн хүрээнд СЗХ-ноос Даатгалын зуучлалын үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг 2012 оны 8 дугаар сард авснаар Монгол Улсад анх удаа банк, даатгалын цогц үйлчилгээг орон даяар байрлах бүх салбар, нэгжээрээ дамжуулан харилцагчдадаа хүргэн ажиллаж байна. Даатгалын бүтээгдэхүүнийг зуучилснаар харилцагчдад дараах давуу талуудыг бий болгож байна.


- Салбартаа тэргүүлэгч даатгалын компаниудын чанартай даатгалын бүтээгдэхүүнийг нэг дор харьцуулж, бага хураамжаар өндөр эрсдэлийн хамгаалалт авах;
- Өөрт ойр байрлах ХААН Банкны бүх салбар, нэгж болон цахим сувгаар даатгалын үйлчилгээг авах;
- Банкны үйлчилгээ авахдаа даатгалын үйлчилгээг авах боломжтой бөгөөд нэмэлт шимтгэл, хураамж төлөхгүй байх;
- Цахимаар даатгуулах боломжтой.

ХААН Банк нь үл хөдлөх хөрөнгийн даатгал, тээврийн хэрэгслийн даатгал, механизмын даатгал, хөдлөх хөрөнгийн даатгал, зээлийн даатгал, зээлдэгчийн амь насны даатгал, гэнэтийн ослын даатгал, хөдөлмөрийн чадвар түр алдалтын даатгал, эрүүл мэндийн даатгал, жолоочийн хариуцлагын албан журмын даатгал, малын индексжүүлсэн даатгал гэсэн даатгалын бүтээгдэхүүнүүдийг санал болгон ажилладаг.

Банк нь салбартаа тэргүүлэгч даатгалын компаниудтай хамтарч ажилладаг бөгөөд харилцагчид албан журмын болон сайн дурын даатгалаас сонгон даатгуулах боломжтой.

- "Агула даатгал" ХХК www.agula.mn
- "Амар даатгал" ХХК www.amardaatgal.mn
- "Ард даатгал" ХХК www.arddaatgal.mn
- "Бодь даатгал" ХК www.bodi-insurance.com
- "Мандал даатгал" ХК www.mandal.mn
- "Миг даатгал" ХХК www.mig.mn
- "Монгол даатгал" ХК www.mongoldaatgal.mn
- "Мөнх даатгал" ХХК www.munkhdaatgal.mn
- "Номин даатгал" ХХК www.insurance.nomin.net
- "Тэнгэр даатгал" ХХК www.tengerdaatgal.mn
- "Улаанбаатар хотын даатгал" ХХК www.ubci.mn
- "Хаан даатгал" ХХК www.khaandaatgal.com
- "Практикал даатгал" ХХК www.practical.mn
- "Үндэсний давхар даатгал" ХК www.mongolianre.com





Үйл ажиллагааны гол сегментүүд

ХААН Банк нь иргэд, жижиг дунд байгууллага, корпорейт байгууллагад зориулан банк санхүүгийн үйлчилгээг өргөн хүрээнд үзүүлэхээс гадна хөрөнгийн удирдлагын үйл ажиллагааг эрхэлдэг.

Нийт 2.8 сая харилцагчдаа уламжлалт банкны биет нэгж болон шинэ үеийн цахим нэгжээр үйлчилгээг хүргэж байна. Харилцагчид сүүлийн жилүүдэд цахимаар банкны үйлчилгээ авахыг илүүд үзэж цахим харилцагчдын тоо өсөж 2022 оны эцсээр ХААН Банкны интернэт банк, ухаалаг банк, мобайл банк, телефон банкны үйлчилгээг нийт 1.7 сая харилцагч авч байна.

Хүснэгт 7. Банкны сегментүүдийн орлогын хураангуй тайлан, 2022 он

Орлогын тайлан (хураангуй), сая төгрөгөөр	Иргэдийн банк	Жижиг дунд бизнесийн газар	Байгууллагын банк	Хөрөнгийн удирдлага	Бусад	Нийт
Хүүгийн орлого	719,962	133,477	152,246	271,304	90,376	1,367,365
Эзлэх хувь	53%	10%	11%	20%	7%	100%
Хүүгийн цэвэр орлого	442,144	48,995	52,855	116,114	226,173	886,281
Эзлэх хувь	50%	5%	6%	13%	26%	100%
Шимтгэл, хураамжийн цэвэр орлого	196,207	4,617	13,999	856	-	215,679
Эзлэх хувь	91%	2%	5%	0%	-	100%
Татварын өмнөх ашиг	424,597	8,607	36,836	132,765	(11,973)	590,833
Эзлэх хувь	72%	1%	6%	22%	-2%	100%

Хүснэгт 8. Банкны сегментүүдийн харилцагчийн депозит

Харилцагчийн депозит (сая төгрөгөөр)	2020		2021		2022	
	Дансны тоо	Дүн	Дансны тоо	Дүн	Дансны тоо	Дүн
Иргэдийн банк	4,143,504	7,986,136	4,428,365	9,000,649	4,629,435	9,078,204
Жижиг дунд бизнесийн газар	4,266	276,045	6,953	353,728	6,534	485,974
Байгууллагын банк	1,913	978,133	2,200	834,010	2,605	1,282,654
Төв банк	207,913	130,530	229,721	23,064	107,160	83,956
Нийт	4,357,596	9,370,844	4,667,239	10,211,451	4,745,734	10,930,788

Хүснэгт 9. Банкны сегментүүдийн зээлийн багц

Зээлийн багц (сая төгрөгөөр)	2020		2021		2022	
	Дансны тоо	Дүн	Дансны тоо	Дүн	Дансны тоо	Дүн
Иргэдийн банк	490,486	3,510,034	530,327	4,704,136	630,219	5,446,465
Жижиг дунд бизнесийн газар	1,414	662,670	2,327	1,103,312	1,987	1,067,949
Байгууллагын банк	178	938,454	244	1,021,233	254	1,262,707
Төв банк	8,889	178,865	9,160	188,955	7,888	200,648
Нийт	500,967	5,290,023	542,058	7,017,637	640,348	7,977,768

2023 5 29 1





Иргэдийн банкны үйл ажиллагаа

ХААН Банк иргэдийн банкны үйлчилгээг Улаанбаатар хотод 95, орон нутагт 449 салбар, нэгж болон гадаад дахь 1 төлөөлөгчийн газраар буюу нийт 545 (салбар 32, тооцооны төв-493, төлөөлөгчийн газар-1, тооцооны касс- 19) биет нэгжээр үзүүлж байна.

Банкны үйлчилгээнд харилцах данс, цахим банк, төлбөрийн карт, хэрэглээний болон олон төрлийн зээл, хадгаламж, даатгал, гадаад гуйвуулга гэх мэт үйлчилгээнээс гадна орчин үеийн төлбөр тооцооны шинэ хэрэгсэл болох Pass ухаалаг хэтэвч үйлчилгээ, шинэчлэгдсэн ХААН Банк аппликэйшн болох супер апп-ний платформ багтана.

Иргэдийн үйлчилгээнд халамж, тэтгэвэр олголтын үйлчилгээ багтах ба Засгийн газрын нийгэм рүү чиглэсэн халамжийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэж, нийгмийн зорилтот бүлэгт хүртээмжтэйгээр хүрч үйлчилж байна. Банкны хувьд орон даяар байршсан биет салбарын сүлжээ, өөрөө өөртөө үйлчлэх Экспресс банкны салбарууд, Киоскийн сүлжээгээр ердийн цагаас гадуур банкны үйлчилгээг хүргэдэг.

Иргэдийн банк нь ХААН Банкны үйл ажиллагааны хамгийн том хэсэг бөгөөд 2022 оны эцсийн байдлаар нийт 503 мянган зээлдэгчийн 3.0 их наяд төгрөгийн хэрэглээний зээлийн багц, 35.6 мянган зээлдэгчийн 1.7 их наяд төгрөгийн бизнесийн зээлийн багц, 91 мянган зээлдэгчийн 686 тэрбум төгрөгийн Хөдөө аж ахуйн зээлийн багц иргэдийн банканд байршиж байна. Бизнесийн зээлийн багцын 67.7%-ийг эргэлтийн хөрөнгийн зориулалтаар олгосон зээл эзэлж байгаа бол хэрэглээний зээлийн 44.0%-ийг цалингийн зээлийн багц бүрдүүлжээ.

Хүснэгт 10. Иргэдийн банкны сегментийн зээлийн мэдээлэл

Зээлийн багц (сая төгрөгөөр)	2020		2021		2022	
	Дүн	Зээлийн дансны тоо	Дүн	Зээлийн дансны тоо	Дүн	Зээлийн дансны тоо
Бизнесийн зээл	1,054,901	24,761	1,797,087	30,694	1,741,307	35,593
Бизнесийн зээл	560,879	15,767	1,286,067	23,952	1,180,719	29,547
Хөрөнгө оруулалтын зээл	393,185	3,899	457,850	3,775	529,469	4,347
Бичил бизнесийн зээл	100,837	5,095	53,169	2,967	31,120	1,699
Хэрэглээний зээл	2,046,213	395,467	2,325,007	424,633	3,019,303	503,591
Цалингийн зээл	1,260,111	226,234	1,179,226	201,738	1,323,109	206,793
Орон сууцны зээл	449,689	9,520	638,069	11,776	771,682	12,062
Бусад хэрэглээний зээл	336,412	159,713	507,712	211,119	924,513	284,736
Хөдөө аж ахуйн зээл	408,920	70,258	582,042	75,000	685,855	91,035
Малчны зээл	395,692	68,907	535,982	73,276	602,897	88,635
Хөдөө аж ахуйн зээл	13,227	1,351	46,060	1,724	82,958	2,400



Харилцагчаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн 83.1%-ийг иргэдийн банкны харилцагчид бүрдүүлж байгаа бөгөөд үүний 52% нь хугацаатай хадгаламж эзэлж байна.

Хүснэгт 11. Иргэдийн банкны харилцах, хадгаламжийн мэдээлэл

Харилцагчийн депозит (сая төгрөгөөр)	2020		2021		2022	
	Дансны тоо	Дүн	Дансны тоо	Дүн	Дансны тоо	Дүн
Нийт	4,143,504	7,986,136	4,428,365	9,000,649	4,629,435	9,078,204
Харилцах данс	2,822,062	1,243,745	3,111,991	2,264,294	3,385,291	3,156,176



2023 5 29



Хугацаагүй хадгаламж	840,619	2,276,536	828,865	1,757,118	704,467	1,151,153
Хугацаатай хадгаламж	480,331	4,447,732	487,426	4,961,138	539,579	4,755,362
Бусад эх үүсвэр	492	18,123	83	18,099	98	15,513

Хувийн банкны үйлчилгээ

Монгол Улсын эдийн засагт үнэмлэхүй хувь нэмэр оруулж буй үнэ цэнтэй, өндөр ашиг орлоготой, стратегийн ач холбогдол бүхий иргэдэд зориулан Приорити үйлчилгээг 2010 онд, салбартаа тэргүүлэгч, залуу манлайлагч, нийгмийн идэвхтэй иргэдэд зориулан Сигначер үйлчилгээг 2017 онд тус тус нэвтрүүлсэн. 2022 оны жилийн эцсийн байдлаар Монгол Улсын хэмжээнд Приорити болон Сигначер сегментийн нийт 50,000 орчим харилцагчтай болж, хувийн банкны тусгай бүтээгдэхүүн үйлчилгээг харилцагчдадаа санал болгон ажиллаж байна.

Сигначер үйлчилгээ

Сигначер харилцагчдын завгүй амьдралын хэв маягт тохирсон цахим банкны үйлчилгээ, санхүүгийн хэрэгцээг хангах тусгай нөхцөл бүхий Сигначер цалингийн зээл, Сигначер орон сууцны зээл, амины орон сууц худалдан авах, барихад зориулсан Сигначер зээлийн бүтээгдэхүүн, Сигначер дебит болон кредит карт, лоялти хөнгөлөлтүүд болон уулзалт товлох үйлчилгээнүүдийг хүргэн ажиллаж байна. Харилцагчдадаа Сигначер дебит болон кредит картаараа хамтран ажиллах гэрээтэй 100 гаруй үйлчилгээний байгууллагуудаас худалдан авалт бүрээс 3-20 хүртэл хувийн хэмнэлт хийх боломжийг олгодог. Мөн банкнаас зохион байгуулж буй уран зураг, соёл урлаг, боловсролын олон төрлийн арга хэмжээ, сургалт семинарт уригдан оролцож нийгэмд эзлэх байр сууриа нэмэгдүүлэхийн зэрэгцээ банкнаас хэрэгжүүлж буй сайн үйлсийн аянд нэгдэн нийгэмд тулгарч буй асуудлуудыг шийдвэрлэхэд оролцох боломжийг бүрдүүлэн ажиллаж байна. 2022 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Сигначер харилцагчдын банканд байршуулсан нийт эх үүсвэр 1.1 их наяд төгрөгт хүрч банкны харилцагчийн эх үүсвэрийн 10.1%-ийг бүрдүүлж байна.

Приорити хувийн банкны үйлчилгээ

ХААН Банк нь гадаад болон монгол Приорити харилцагчдадаа тусгайлан тохижуулсан тооцооны төвүүдэд тав тухтай орчинд ур чадвартай ажилтнууд болон зөвхөн танд үйлчлэх чадварлаг, мэргэшсэн хятад, солонгос, япон болон англи хэлтэй харилцааны менежерүүдээрээ дамжуулан хувийн банкны үйлчилгээг түргэн шуурхай хүргэн ажиллаж байна. Хувийн банкны үйлчилгээгээр харилцагчид өндөр зэрэглэлийн Приорити дебит карт, Платинум кредит карт, тусгай даатгалын бүтээгдэхүүн, зээлийн бүтээгдэхүүн, цахим банкны үйлчилгээ, лоялти хөнгөлөлтүүд, милл оноо хуримтлуулах хөтөлбөр, тусгай арга хэмжээг харилцагчийн сонирхол хэрэгцээ шаардлагад нийцүүлэн, сайжруулан хөгжүүлж хүргэсээр байна. Мөн 7533-1917 лавлах төвийн Приорити тусгай шугамаар дуудлага бүрийг алдалгүй 24/7 цагаар хүлээн авч харилцагчийн санал хүсэлтийг шийдвэрлэн, тухайлсан бүтээгдэхүүн үйлчилгээг зайнаас хүргэн ажилладаг. 2022 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Приорити харилцагчдын банканд байршуулсан нийт эх үүсвэр 2,296 тэрбум төгрөгт хүрч банкны харилцагчийн эх үүсвэрийн 21.0%- ийг бүрдүүлж байна.

Жижиг дунд бизнес эрхлэгчдэд зориулсан банкны үйлчилгээ

ХААН Банк нь байгууллагын зах зээлд жижиг, дунд бизнес эрхлэгчдэд зориулсан ХААН Бизнес үйлчилгээг 2017 оноос нэвтрүүлэн ажиллаж байгаа бөгөөд Улаанбаатар хотын төв цэгүүдэд байрших Бизнес төвүүдээрээ дамжуулан банк санхүүгийн үйлчилгээг нэг дороос авах боломжийг харилцагчдадаа олгодог. Жижиг дунд бизнес эрхлэгчдэд зориулж тэдний хэрэгцээ, шаардлагад нийцсэн "Нутгийн брэнд"-ийг дэмжих зээл, Өртгийн сүлжээний зээл, Экспортыг дэмжих зээл зэрэг төрөлжсөн зээлийг олгохоос гадна санхүүгийн бус үйлчилгээ үзүүлэх зорилгоор менежментийн зөвлөх үйлчилгээ, төрөл



2023 5 29

2023 оны 06 сар 09
 БУРГАА 302

бүрийн сургалт зохион байгуулдаг. Мөн Жижиг дунд бизнес эрхлэгчдийг дэмжих төвийг байгуулан харилцагчдынхаа шаардлагатай ур чадварыг хөгжүүлэх, бизнесийн үйл ажиллагааг нь чадаржуулах, цар Нс хүрээг нь өртөжүүлэх, хөгжлийн шинэ шатанд гарах боломжийг нэмэгдүүлэхэд чиглэн ажилладаг.

Жижиг дунд бизнесийн банкны бүтцийн харьяанд Жижиг дунд бизнесийн газар, Зээлийн судалгаа, шинжилгээний газар, Жижиг дунд бизнесийг дэмжих төв, Бизнес төвүүд ажиллаж байна. Энэхүү бүтэц шинээр байгуулагдсанаар бодлого, хөгжүүлэлт, борлуулалт, зээлийн судалгаа, шинжилгээний багуудын уялдаа сайжирч жижиг дунд бизнес эрхлэгчдэд үзүүлэх үйлчилгээ илүү ойртон, цар тахлын үед бизнес эрхлэгчдийг бодитоор дэмжиж ажиллах боломж бүрдсэн юм.

2022 оны эцсийн байдлаар Жижиг дунд бизнес эрхлэгчдэд зориулан олгосон зээлийн багц 1.0 их наяд төгрөг байгаа нь нийт зээлийн багцын 13.4%-ийг эзэлж байна.

Хүснэгт 12. Жижиг дунд бизнесийн банкны зээлийн мэдээлэл

Зээлийн багц (сая төгрөгөөр)	2020		2021		2022	
	Дүн	Зээлийн дансны тоо	Дүн	Зээлийн дансны тоо	Дүн	Зээлийн дансны тоо
Бизнесийн зээл	642,080	1,190	1,072,461	1,847	1,012,754	1,744
Бизнесийн зээл	307,990	639	673,912	1,333	601,690	1,235
Хөрөнгө оруулалтын зээл	333,865	546	398,431	511	411,019	507
Бичил бизнесийн зээл	226	5	118	3	45	2
Хэрэглээний зээл	16,212	217	21,353	458	38,856	213
Хөдөө аж ахуйн зээл	4,378	7	9,498	22	16,338	30

Жижиг дунд бизнес эрхлэгчдийн хувьд бизнесийн онцлогоос хамаарч тогтвортой хуримтлал үүсгэх нь бага, эх үүсвэрийн байнгын эргэлттэй байдаг. 2022 оны эцсийн байдлаар нийт татан төвлөрүүлсэн хөрөнгийн 4.4%-ийг энэхүү сегментийн харилцагчид эзэлж байгаа бөгөөд үүний 75.4% нь харилцах дансаар төвлөрч байна.

Хүснэгт 13. Жижиг дунд бизнесийн банкны харилцах, хадгаламжийн мэдээлэл

Харилцагчийн депозит (сая төгрөгөөр)	2020		2021		2022	
	Дансны тоо	Дүн	Дансны тоо	Дүн	Дансны тоо	Дүн
Нийт	4,266	276,045	6,953	353,728	6,534	485,974
Харилцах данс	4,036	192,648	5,848	280,905	5,962	366,469
Хугацаагүй хадгаламж	63	17,515	714	5,428	212	1,345
Хугацаатай хадгаламж	133	62,758	383	63,416	350	111,066
Бусад хадгаламж	34	3,124	8	3,978	10	7,095


Корпорейт банкны үйлчилгээ

ХААН Банк улс орны хөгжил, эдийн засгийн эргэлтэд гол хувь нэмэр оруулдаг том ААН-үүд, групп компаниудад зориулан корпорейт банкны үйлчилгээг байгууллагын банкны үйлчилгээ, кастодиан банкны үйлчилгээ, хөрөнгө удирдлага, худалдааны санхүүжилт зэрэг чиглэлээр үзүүлдэг. Барилга, уул уурхай, газар тариалан, хүнсний үйлдвэрлэл, бөөний болон жижиглэнгийн худалдаа, эрүүл мэндийн үйлчилгээ, шатахуун импорт, худалдааны салбарт үйл ажиллагаа явуулж буй томоохон байгууллага, групп компаниуд болон олон улсын байгууллага, төлөөлөгчийн газрууд, Элчин сайдын яамдуудад санхүүгийн дэвшилтэт, цогц үйлчилгээг хүргэж, тогтвортой, найдвартай харилцааг эрхэмлэн ажиллаж байна.

МОНГОЛЫН ХӨРӨН
 ХААН БАНК
 УКИ00009

МОНГОЛЫН ХӨРӨН
 ХААН БАНК
 БРОКЕР, ДИЛЖИГЧИЙН
 ҮЙЛ АЖИЛЛАГАА
 1115205417 2857082

2023 оны 06 сар 09



Байгууллагын банк нь иргэдийн зах зээл дээр голчлон ажилладаг жижиглэн болон бөөний худалдааны салбарт үйл ажиллагаа явуулж буй томоохон аж ахуйн нэгж байгууллагуудын зээлийн хэрэгцээг үйл ажиллагаатай нь уялдуулан хангахын сацуу, валютын арилжаа, ПОС машин, АТМ машин болон картын төрөл бүрийн үйлчилгээг үзүүлж хамтран ажилладаг. Түүнчлэн хүн амын эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдалд чухал нөлөө үзүүлж буй эмийн үйлдвэрлэл худалдаа эрхлэгч болон хүнсний үйлдвэрлэл эрхлэгч аж ахуйн нэгж байгууллагуудад санхүүгийн таатай бүтээгдэхүүнийг санал болгон дэмжин ажилладаг.

Байгууллагын банк нь Монгол Улсын стратегийн ач холбогдолтой томоохон уул уурхайн компаниуд тэдгээрийн ажилтан, албан хаагчдад мөн санхүүгийн тохирсон үйлчилгээг үзүүлэн хамтран ажилласаар ирсэн.

Байгууллагын банк нь олон улсын хөгжлийн банкуудтай хамтран ажиллаж, зарим томоохон төсөл хөтөлбөрүүдэд Европын сэргээн босголт хөгжлийн банкттай хамтарсан "Эрсдэл хуваалцах" зээлийг олгосноор банкны эрсдэлийг тодорхой түвшинд бууруулах, олон улсын шилдэг туршлагыг хэрэгжүүлэх, байгууллагын санхүүгийн сахилга батыг нэмэгдүүлэхэд чухал нөлөө үзүүлж байна.

Байгууллагын томоохон харилцагчдын хувьд зээлийн хүү, ханшийн өөрчлөлтөд мэдрэг ханддаг онцлогтой учраас ханшийн болон худалдааны санхүүжилтийн хэрэгсэл зэрэг бүтээгдэхүүнийг санал болгож ханшийн эрсдэл болон худалдааны эрсдэлийг бууруулж ажилладаг. Мөн зах зээлийн нөхцөл байдлаас шалтгаалан харилцагчдын санхүүгийн зардлыг бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.

Байгууллагын банкны зээлийн багцын төвлөрлийг бууруулах зорилгоор зээлийн багцын хольцыг илүүтэй анхаарч ажилласнаар 2022 оны эцсийн байдлаар нийт багцын 47.5%-ийг хөрөнгө оруулалтын, 52.5%-ийг бизнесийн эргэлтийн хөрөнгийн зээл бүрдүүлж байна. Мөн Байгууллагын банкны зээлийн багцын хольцыг сектороор авч үзвэл барилгын салбарын зээл 31%, уул уурхайн зээл 1%, бөөний болон жижиглэн худалдааны секторын зээл 46%, боловсруулах үйлдвэрийн зээл 9%, үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагааны зээл 5%-ийг тус тус эзэлж байна.


Байгууллагын банк нь цаашид дэлхийн уур амьсгалын өөрчлөлт болон хүлэмжийн хийг бууруулахад хувь нэмэр оруулах зорилгоор эрчим хүчний хэмнэлттэй төсөл хөтөлбөрүүдэд зориулсан ногоон зээл олгох, сэргээгдэх эрчим хүчний төсөл хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх чиглэлд идэвхтэй оролцохоор ажиллаж байна.

Хүснэгт 14. Байгууллагын банкны зээлийн мэдээлэл

Зээлийн багц (сая төгрөгөөр)	2020		2021		2022	
	Дүн	Зээлийн дансны тоо	Дүн	Зээлийн дансны тоо	Дүн	Зээлийн дансны тоо
Бизнесийн зээл	938,123	173	1,018,179	210	1,258,574	243
Бизнесийн зээл	678,079	119	599,987	151	661,021	169
Хөрөнгө оруулалтын зээл	260,044	54	418,192	59	597,554	74
Хэрэглээний зээл	331	5	806	30	359	9
Хөдөө аж ахуйн зээл	-	-	2,248	4	3,774	2



2023 5 29



Байгууллагаас татан төвлөрүүлсэн хөрөнгө

2022 оны эцсийн байдлаар Байгууллагын банкны харилцагчдаас татан төвлөрүүлсэн эх үүсвэр нийт депозитын 11.7%-ийг эзэлж байна. Бизнесийн секторын мөчлөг, макро эдийн засгийн нөхцөл байдалтай холбоотойгоор байгууллагын банкны харилцагчдын татан төвлөрүүлсэн эх үүсвэр тогтворгүй байдаг. Харилцах дансны үлдэгдэл 2021 оны жилийн эцсээс 116% өссөн бол хугацаатай хадгаламж 51% буурсан байна.

Хүснэгт 15. Байгууллагын банкны харилцах, хадгаламжийн мэдээлэл

Харилцагчийн депозит (сая төгрөгөөр)	2020		2021		2022	
	Дансны тоо	Дүн	Дансны тоо	Дүн	Дансны тоо	Дүн
Нийт	1,913	978,133	2,200	834,010	2,605	1,282,654
Харилцах данс	1,795	321,122	2,147	523,542	2,563	1,130,972
Хугацаагүй хадгаламж	35	45,476	1	25	1	25
Хугацаатай хадгаламж	66	608,011	47	305,863	37	148,845
Бусад хадгаламж	17	3,524	5	4,581	4	2,812

Гадаад гуйвуулга, корреспондент банкны харилцаа

Олон улсын SWIFT сүлжээгээр 13 төрлийн валютаар (USD, EUR, CNY, JPY, CHF, GBP, CAD, AUD, KRW, RUB, SGD, NZD, HKD) харилцагчдын гадаад төлбөр тооцоог шуурхай, найдвартай дамжуулдаг. ХААН Банк олон улсын 28 банкан дахь 49 ностро дансаар дамжуулан гадаад гуйвуулгын үйлчилгээг үзүүлж, жилд нийт 4.4 тэрбум ам.долларын нийт дүн бүхий 131 мянга гаруй гадаад гуйвуулгыг гүйцэтгэн ажиллаж байна.

2022 оны эцсийн байдлаар ХААН Банкны SWIFT сүлжээгээр хийгдсэн нийт гадаад гүйлгээний тоо өмнөх оны мөн үеэс 4%-иар буурч, харин нийт дүнгээр 29%-иар өссөн ба илгээсэн гуйвуулгын хувьд зах зээлд III, хүлээн авсан гуйвуулгын хувьд зах зээлд I байранд эрэмбэлэгдэж байна. Нийт гуйвуулгыг улс орноор нь ангилан үзвэл нийт илгээсэн болон хүлээн авсан гүйлгээний тоон үзүүлэлтээр БНСУ (40%) тэргүүлсэн бол БНХАУ (23%) болон Сингапур (17%) улсууд удаалж байна.

ХААН Банк нь SWIFT gpi үйлчилгээг Монгол Улсын зах зээлд анхлан 2019 онд нэвтрүүлсэн. Энэ үйлчилгээ нь харилцагчийн гадаад төлбөр тооцоог гүйлгээний байршил, гүйлгээг дамжуулахад оролцогч банкууд, тэдгээрийн тооцсон шимтгэл, дамжуулахад зарцуулсан хугацаа, гүйлгээ хүлээн авагчид очсон эсэхийг бодит цаг хугацааны горимд лавлах боломжийг бүрдүүлдэг.

1.6.2.3. Бүтэц зохион байгуулалт, банкны засаглал

Банкны бүтэц, зохион байгуулалт


Үнэт цаасны танилцуулга бэлтгэх үеийн байдлаар банк нь ТУЗ-ийн 2023 оны 04 сарын 12-ны өдрийн 11 тоот тогтоол, Гүйцэтгэх захирлын 2023 оны 05 сарын 01-ний өдрийн 01/136 тоот тушаалаар баталсан дараах бүтэц, зохион байгуулалттайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.

2023 5 29/1





Зураг 1. Банкны бүтэц, зохион байгуулалт



Хувьцаа эзэмшигчдийн хурал

ХААН Банкны дүрмийн 7.1-д заасны дагуу банкны эрх барих дээд байгууллага нь Хувьцаа эзэмшигчдийн хурал байна.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг санхүүгийн жил дууссанаас хойш 4 сарын дотор ТУЗ-ийн шийдвэрээр зарлан хуралдуулна.

Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчид нь Банкны тухай хуулийн 29 дүгээр зүйл болон Банкны дүрмийн 7.2-т зааснаар дараах асуудлуудыг хэлэлцэх, шийдвэрлэх бүрэн эрхтэй байна. Үүнд:

- Банкны дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу банкны дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах;
- Нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах буюу өөрчлөх замаар Банкныг өөрчлөн байгуулах;
- Банкны өрийг хувьцаагаар солих, хувьцаа нэмж гаргах, түүний тоог тогтоох;
- Банкны хэлбэрийг өөрчлөх;
- Банкныг татан буулгах болон татан буулгах комиссыг томилох;
- Банкны хувьцааг хуваах буюу нэгтгэх;
- Монголбанкны мэдэгдлийг хүлээн авсны үндсэн дээр ТУЗ-ийн гишүүнийг сонгох, бүрэн эрхийг нь хугацаанаас нь өмнө дуусгавар болгох;
- Компанийн тухай хуулийн 38 дугаар зүйлд заасны дагуу хувьцаа эзэмшигч нь хувьцаа, бусад үнэт цаасыг тэргүүн ээлжинд худалдан авах эрхээ хэрэгжүүлэх эсэх;
- Банкны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах;
- ТУЗ-өөс хуульд заасан журмын дагуу шийдвэрлэж чадаагүй тохиолдолд их хэмжээний хэлцлийг батлах;
- ТУЗ-өөс хуульд заасан журмын дагуу шийдвэрлэж чадаагүй тохиолдолд сонирхлын зөрчилтэй хэлцлийг батлах;
- Компанийн тухай хуульд заасны дагуу банк өөрийн хувьцаагаа эргүүлэн худалдаж авахыг зөвшөөрөх;
- ТУЗ-ийн дарга, гишүүний бүрэн эрхийг тогтоох, хариуцлага, цалин, урамшууллын хэмжээ, ТУЗ-ийн үйл ажиллагааны ерөнхий журмыг тогтоох;



2023 5 29



- Банкны тухайн жилийн үйл ажиллагаа, бүтэц, зохион байгуулалт, хөрөнгийн талаар ТУЗ-өөс бэлтгэсэн тайланг хэлэлцэж батлах;
- Хувь нийлүүлсэн хөрөнгийн бүтэц, хэмжээг өөрчлөх;
- ТУЗ-ийн шийдвэрээр хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэхээр оруулсан бусад асуудал;
- ТУЗ баталсны дараа хөндлөнгийн аудиторыг томилох;
- ТУЗ баталсны дараа ногдол ашиг хуваарилах;
- Хууль болон Банкны дүрмээр тогтоосон бусад асуудал.

Төлөөлөн удирдах зөвлөл

ХААН Банкны ТУЗ нь дотоодын болон дэлхийн санхүүгийн салбарт олон жилийн туршлагатай нийт 9 гишүүнээс бүрддэг бөгөөд Банкны дүрмийн 9.6-д заасны дагуу ердийн гишүүний бүрэн эрхийн хугацаа 1 жил, 9.9-д заасны дагуу хараат бус гишүүний бүрэн эрхийн хугацаа 2 жил байна.

ХААН Банкны ТУЗ нь Компанийн тухай хууль, Банкны тухай хууль, Монголбанкнаас баталсан журам, заавар, ХААН Банкны дүрэм, Компанийн засаглалын кодекс, ТУЗ-ийн үйл ажиллагааны журам болон бусад холбогдох эрх зүйн бичиг баримтыг мөрдөн банкны зохистой засаглалыг хэрэгжүүлэн үйл ажиллагаа явуулдаг.

Төлөөлөн удирдах зөвлөлийн чиг үүрэг

Банкны ТУЗ нь Банкны тухай хуулийн 31.3, Банкны дүрмийн 9.13 болон ТУЗ-ийн үйл ажиллагааны журам, Банкны зохистой засаглалын зарчмын хэрэгжилтийн хяналт шалгалтын журам, Компанийн засаглалын кодекст заасны дагуу дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Банкны стратегийг тодорхойлох, хянан үзэж түүнд нэмэлт өөрчлөлт оруулах, зохион байгуулалтын бүтэц, эрсдэлийн удирдлагын бодлого, жилийн төсөв, бизнес төлөвлөгөө, үйл ажиллагааны үр дүнгийн үзүүлэлтийг батлах;
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах;
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хуралдуулахгүйгээр хувьцаа эзэмшигчдээс эчнээ санал хураалт явуулах замаар асуудлыг шийдвэрлүүлэх;
- Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал, саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг гаргах бүртгэлийн өдөр болон хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулахтай холбогдох бусад асуудлыг шийдвэрлэх;
- Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хувьцаа эзэмшигчдийн баталсан хувьцааны төрөл болон тоонд багтаан хувьцаа гаргах;
- Банкны дүрэмд заасан хувьцаанд хамаарахаас бусад үнэт цаас гаргах;
- Компанийн тухай хуулийн 55 дугаар зүйлд заасны дагуу эд хөрөнгийн болон эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг тогтоох;
- Өөрийн гаргасан хувьцаа, бусад үнэт цаасыг худалдан авах буюу эргүүлэн авах тухай шийдвэр гаргах;
- Монголбанкны Ерөнхийлөгчтэй зөвшилцөн банкны гүйцэтгэх удирдлагыг томилох, түүний бүрэн эрхийг тогтоох;
- Гүйцэтгэх удирдлагын бүрэн эрх, хариуцлагыг тогтоох, үйл ажиллагаанд нь хяналт тавих, түүний цалин, урамшууллын хэмжээг тогтоох;
- Банкны дотоод аудитын нэгжийг гүйцэтгэх удирдлагаас хараат бусаар зохион байгуулж, түүний төсөв, орон тоог батлах, гүйцэтгэх удирдлага, ажилтныг томилох, үйл ажиллагааны журмыг тогтоох, цалин, урамшууллын хэмжээг тогтоох;
- Хөндлөнгийн аудитын байгууллагыг сонгож, түүнтэй байгуулах гэрээний нөхцөлийг тогтоох;
- Банкны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гаргаж түүнийг хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж батлуулах;
- Банкны дүрэмд өөрөөр заагаагүй бол ногдол ашгийн хэмжээ, түүнийг төлөх журмыг тодорхойлох;



2023 5 29/1



- Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны болон банкны зохистой засаглалын бодлого, журмыг тогтоож хэрэгжилтэд хяналт тавих;
- Банкны салбар болон төлөөлөгчийн газар байгуулах;
- Банк өөрчлөн байгуулах талаар хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийн төслийг бэлтгэх, гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх;
- Их хэмжээний хэлцэл хийх зөвшөөрөл олгох;
- Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох;
- Компанийн тухай хууль, Банкны тухай хууль болон компанийн дүрмээр тогтоосон бусад асуудал багтана.

Банкны ТУЗ-ийн гишүүн бүр Компанийн тухай хууль, Банкны тухай хуульд заасан үүргээс гадна дараах үүрэг хүлээнэ. Үүнд:

- Хууль, тогтоомж болон дүрмээр олгогдсон бүрэн эрхийн хүрээнд ажил, үүргээ хариуцлагатай биелүүлэх;
- Банкны эрх ашгийг хувийн болон өөрийг нь томилсон хувьцаа эзэмшигчдийн эрх ашгаас дээгүүр тавих;
- Нууцаар ашиг хүртэхгүй байх;
- Сонирхлын зөрчлөөс зайлсхийж, сонирхлын зөрчил үүссэн үед ТУЗ-д мэдээлдэг байх;
- Банкны өдөр тутмын үйл ажиллагаанд оролцохгүй байх;
- Банкны Гүйцэтгэх захиралд хяналт тавих, ажлын үр дүнгийн тайланг улиралд нэгээс доошгүй удаа авч хэлэлцэх, хувьцаа эзэмшигчдэд эрх тэгш хандах;
- Хувьцаа эзэмшигч, харилцагч болон хадгаламж эзэмшигчийн эрх ашгийг хамгаалах;
- Банкны бодлого, стратеги, эрсдэл даах сонирхлыг тодорхойлох, банканд үр ашигтай шийдвэр гаргах;
- Банкны нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлангийн тогтолцоо, хөндлөнгийн болон дотоод аудит, эрсдэлийн удирдлага, санхүүгийн болон үйл ажиллагааны хяналт, хууль тогтоомжийн хэрэгжилт, банкны бүтцийн өөрчлөлт зэрэг Гүйцэтгэх захирлын үйл ажиллагаанд хяналт тавих;
- ТУЗ-өөс Гүйцэтгэх захиралтай байгуулах гэрээнд эрх, үүрэг, хариуцлага, үйл ажиллагаанд хяналт тавих, тайлагнах тогтолцоог бүрэн тусгаж, гэрээний биелэлтийг улирал бүр дүгнэх;
- Банкны удирдлагыг сонгон шалгаруулах, тэдгээрийн залгамж халааг бэлтгэх төлөвлөгөөг батлах, төлөвлөгөөнд удирдах дээд албан тушаал бүрд тавигдах ажил мэргэжлийн шаардлага, чиг үүргээ үр дүнтэй гүйцэтгэхэд хангалттай түвшинд бэлтгэхийг тодорхой тусгасан байх;
- Гүйцэтгэх захирлын урамшууллын асуудлыг банкны эрхэм зорилго, урт хугацааны хэтийн зорилго, стратеги төлөвлөгөө, ёс зүйн хэм хэмжээ болон гэрээнд заасан үүргийн биелэлт зэрэгтэй уялдуулан шийдвэрлэх;
- Хууль тогтоомж болон Банкны дүрмээр олгогдсон бүрэн эрхийн хүрээнд ажил үүргээ хариуцлагатай, үнэнч шударгаар гүйцэтгэж, чандлан сахих;
- Ашиг сонирхлын зөрчлийн улмаас банкны өмнө хүлээсэн үүргээ зүй ёсоор хэрэгжүүлэхэд саад тотгор үзүүлэх үйлдэл, эс үйлдэл гаргахгүй байх;
- Монгол Улсын хууль тогтоомж болон олон улсын стандартад заасан шаардлагыг хангасан байгууллагыг сонгон шалгаруулж, хөндлөнгийн аудит хийлгэх;
- Банкны дотоод аудитын нэгжээс хийсэн шалгалтын акт материал, ажлын тайлан зэргийг цаг тухайд нь авч хэлэлцэн, зохистой засаглал болон дотоод хяналтын тогтолцоог сайжруулах талаар Гүйцэтгэх захиралд үүрэг өгөх, авсан арга хэмжээний үр дүнг тооцох;
- Өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ мэдлэг ур чадвараа дайчлан, хичээл зүтгэл гарган ажиллах.

Банкны ТУЗ-ийн хараат бус гишүүн нь Компанийн тухай хууль, Банкны тухай хуульд заасан үүргээс гадна дараах үүрэг хүлээнэ. Үүнд:

- ТУЗ, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаа, гаргасан шийдвэр нь тухайн банкны эрх ашигт сөргөөр нөлөөлөх эсэхэд хяналт тавих, хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэх;
- ТУЗ, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаа нь хууль тогтоомжид нийцсэн эсэхэд хяналт тавих;
- Банкны харилцагч, хадгаламж эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах;



2023 5 29



- Компанийн тухай хуульд заасан сонирхлын зөрчилтэй хэлцэл, холбогдох этгээдийн хэлцэл, их хэмжээний хэлцлийг хэлэлцэхэд заавал оролцож санал өгөх;
- ТУЗ болон гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаа, бодлого, шийдвэр нь банкны үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлсөн, хууль тогтоомжийг зөрчсөн тохиолдолд ТУЗ-ийн хараат бус гишүүн уг зөрчлийг арилгахыг холбогдох этгээдээс шаардах, шаардлагыг эс биелүүлэх тохиолдолд уг асуудлыг ТУЗ-д тавьж шийдвэрлүүлэх, улмаар хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулах шаардлагыг ТУЗ-д хүргүүлэх;
- Хувьцаа эзэмшигч, ТУЗ болон гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаа, бодлого, шийдвэр нь банкны эрх ашигт сөргөөр нөлөөлөх, хууль тогтоомжийг зөрчих тохиолдолд бүрт Монголбанканд мэдэгдэх, улмаар хүсэлт гарган банканд шалгалт хийлгэх;
- ТУЗ-ийн хараат бус гишүүн тус бүр нь өөрийн үндсэн үүргийн хэрэгжилт, ажлын тайлан зэргийг Монголбанканд болон хувьцаа эзэмшигчдийн хуралд жилд нэгээс доошгүй удаа тайлагнах;
- Аудитын болон Эрсдэлийн хорооны бүрэлдэхүүнд заавал орж ажиллах.

ТУЗ нь банкны үйл ажиллагаанд дараах байдлаар оролцохыг хориглоно:

- ТУЗ-ийн гишүүн болон түүний төлөөлж буй аж ахуйн нэгж, байгууллага нь банканд зээл, баталгаа, батлан даалтын гэрээгээр хүлээсэн аливаа үүрэг, төлбөр нь чанаргүй ангилалд орсон тохиолдолд тус гишүүнийг ТУЗ-ийн хуралд саналын эрхтэй оролцуулах;
- Гүйцэтгэх захирал нь ТУЗ-ийн гишүүнээр томилогдон ажиллах тохиолдолд ТУЗ-ийн үйл ажиллагаанд дараах байдлаар оролцохыг хориглоно:
- Аудитын хороо болон Эрсдэлийн хорооны бүрэлдэхүүнд саналын эрхтэйгээр орж ажиллах;
- Гүйцэтгэх захирлын бүрэн эрх, хариуцлагыг тогтоох, үйл ажиллагаанд нь хяналт тавих, түүний цалин урамшууллын хэмжээг тогтоох;
- Гүйцэтгэх захирлын үйл ажиллагаанд үнэлгээ, дүгнэлт өгөх.

Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн

Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн удирдах зөвлөл нь дараах бүрэлдэхүүнтэй байна.

Хүснэгт 16. ТУЗ-ийн гишүүдийн мэдээлэл



Т.Дарьбум

ТУЗ-ийн хараат бус гишүүн
ТУЗ-ийн дарга

| Компанийн засаглалын хорооны дарга, Хүний нөөцийн хорооны гишүүн |

Т.Дарьбум нь 2020 оны 8 дугаар сараас ХААН Банкны ТУЗ-ийн хараат бус гишүүнээр томилогдон ажиллаж байгаа бөгөөд тэрбээр банк санхүүгийн салбарт эрсдэлийн удирдлага, дүн шинжилгээ, нягтлан бодох бүртгэл, эрсдэлт хөрөнгө, үнэт цаас, бондын чиглэлээр олон улсын банк, санхүүгийн салбарт мэргэшсэн арвин туршлагатай. Канад улсын Торонто хотод төвтэй TD Bank Group (Канад улсын 2 дахь, Хойд Америкийн 6 дахь том банк)-д 13 жил гаруй ажилласан туршлагатай. Тэрбээр ОХУ-ын Москва хотын Санхүүгийн Их сургуулийн олон улсын эдийн засгийн бакалавр, АНУ-ын Сиаттлийн их сургуульд санхүүгийн шинжлэх ухааны магистрын зэрэг хамгаалсан бөгөөд Канад улсын Онтарио мужийн Мэргэшсэн нягтлан бодогчдын институцийн CPA, CMA зэрэгтэй.



Д.Хулан

ТУЗ-ийн гишүүн
ТУЗ-ийн орлогч дарга

| Хүний нөөцийн хорооны дарга, Аудитын болон Компанийн засаглалын хорооны гишүүн |

Д.Хулан нь ХААН Банкны бие даасан хувьцаа эзэмшигч юм. Д.Хулан нь тус банкны ТУЗ-ийн гишүүнээр 2003 оны 3 дугаар сараас эхлэн ажиллаж байна. Тэрбээр "Таван Богд Трейд" ХХК-ийг үүсгэн байгуулагчийн нэг бөгөөд өдгөө Таван Богд Группийн Тэргүүн дэд ерөнхийлөгчийн албан тушаалыг хашдаг. Хатагтай Д.Хулан нь ОХУ-ын Москва хотын Санхүүгийн олон улсын эдийн засгийн бакалавр, МУИС-ийн Бизнесийн удирдлагын магистр зэрэгтэй, Япон улсад мэргэжил дээшлүүлсэн. Мөн тэрбээр Монгол Улсын Сангийн яам, Худалдаа хөгжлийн банк зэрэг байгууллагад ажиллаж байсан банк санхүүгийн салбарын арвин мэдлэг, туршлагатай нэгэн.



2023 5 29



Харада Ясунари
 ТУЗ-ийн гишүүн

| Хүний нөөцийн, Эрсдэлийн болон Компанийн засаглалын хорооны гишүүн |

Эйч Эс Интернэйшл (Ази) Лимитед ХХК-ийг төлөөлсөн ТУЗ-ийн ердийн гишүүн бөгөөд Эйч Эс Холдингс ХК-ийн Ерөнхийлөгч, Төлөөлөгч Захирлын албан тушаалыг хашдаг. Тэрбээр Япон улсын Кьюшү Их сургуулийг Эрхзүйн бакалавр зэрэгтэй төгссөн.

Их сургуулиа төгсмөгц тэрээр Япон улсын Аж Үйлдвэрийн Банканд ажлын гараагаа эхлүүлсэн. Мөн тэрээр тус Банкнаас гадна хөрөнгө оруулалтын банкны салбар болох Morgan Stanley, BNP Paribas and Société Générale зэрэг банкуудад ажиллаж байсан туршлагатай болно.

| Аудитын хорооны гишүүн |



Иший Кисабүро
 ТУЗ-ийн гишүүн

Ноён Иший Кисабүро нь Эйч Эс Холдингс ХК-ыг төлөөлсөн ТУЗ-ийн ердийн гишүүн бөгөөд Эйч Эс Холдингс ХК-ын хараат бус захирлаар ажилладаг. Тэрээр Токиогийн их сургуульд эрх зүйн бакалаврын зэрэг хамгаалсан. Сургуулиа төгсмөгц ажлын гараагаа Барилгын яаманд (одоогийн Газар, дэд бүтэц, тээврийн яам) эхлүүлсэн. Тус яаманд Хотын захиргааны ерөнхий захирлаар ажиллаж байгаад Газар, дэд бүтэц, тээврийн яаманд дэд сайдын албан тушаал хашиж байгаад тэтгэвэрт гарсан. Одоогийн байдлаар тэрээр, Японоос Румынд суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар томилогдсон болно.

| Эрсдэлийн хорооны гишүүн |



Ц.Баатарсайхан
 ТУЗ-ийн гишүүн

Ц.Баатарсайхан нь "Таван Богд Трейд" ХХК-ийг төлөөлсөн ТУЗ-ийн гишүүн бөгөөд тус банкны ТУЗ-ийн гишүүнээр 2009 оны 3 дугаар сараас эхлэн ажиллаж байна. Ноён Ц.Баатарсайхан нь "Таван Богд Трейд" ХХК-ийг үүсгэн байгуулагчийн нэг, өдгөө Таван Богд Группийн Ерөнхийлөгчийн албан тушаалыг хашдаг. Ц.Баатарсайхан нь Монгол Улсын Политехникийн их сургууль болон Япон улсын Токио хотын Цахилгаан холбооны их сургуулийг тус тус дүүргэсэн. Тэрбээр Монгол-Японы хамтарсан "Алтай" ХХК-ийн захирал болон МИАТ ХК-ийн дэд ерөнхийлөгчийн албыг тус тус хашиж байсан.

| Хүний нөөцийн болон Эрсдэлийн хорооны гишүүн |



Жон Ло
 ТУЗ-ийн гишүүн

Жон Ло нь байгууллагын банк болон хөрөнгө оруулалтын банкны чиглэлд 30 гаруй жил ажилласан арвин туршлагатай. ОУСК-ийн Олон улсын санхүүгийн зах зээлийн газарт банкны мэргэжилтнээр ажиллаж байсны дээр Сити банк болон Жи .Пи Морган зэрэг банкуудад Ази, номхон далайн бүс хариуцан удирдах түвшний албан тушаалууд хашиж байсан туршлагатай. Тэрбээр АНУ-ын Индиана мужийн Блүүминтон хотын Индианагийн их сургуульд бизнесийн удирдлагын чиглэлээр магистрын зэрэг хамгаалжээ.

| Аудитын хорооны дарга |



А.Тамир
 ТУЗ-ийн хараат бус гишүүн

Монголын мэргэшсэн татварын зөвлөх А.Тамир нь 2020 оны 7 дугаар сараас ХААН Банкны ТУЗ-ийн хараат бус гишүүнээр томилогдон ажиллаж байна. Тэрбээр дотоодын болон гадаад улсын компаниудад нягтлан бодох бүртгэл, татвар, санхүүгийн тайлан, бизнес төлөвлөлт зэрэг чиглэлээр зөвлөх үйлчилгээ үзүүлдэг "Интегрейтед Финаншиал Сервис" ХХК-ийн үүсгэн байгуулагч бөгөөд Ерөнхий захирлын үүргийг гүйцэтгэдэг. Төрийн болон хувийн байгууллага, олон улсын байгууллагад мэргэжлээрээ 26 жил гаруй ажилласан туршлагатай. Австралийн Үндэсний их сургуулийг хөгжлийн эдийн засгийн диплом, Москва хотын Эдийн засаг, статистик болон информатикийн их сургуульд эдийн засгийн магистрын зэрэг тус тус хамгаалсан.





СЭХ
өн 2023.06.09
БҮРТГЭВ
№ 1



Аарт Йонгеянс

ТУЗ-ийн хараат бус гишүүн

| Эрсдэлийн хорооны дарга, Аудитын хорооны гишүүн |

Аарт Йонгеянс нь 2020 оны 7 дугаар сараас ХААН Банкны ТУЗ-ийн хараат бус гишүүнээр томилогдон ажиллаж байна. Тэрбээр банк санхүүгийн салбарын эрсдэлийн удирдлагын чиглэлээр нийт 44 жил ажилласан туршлагатай. Ноён Аарт Йонгеянс нь Нидерландын Вант улсын Банк санхүүгийн институцийг 1975 онд амжилттай дүүргэж тус улсын Эй Би Эн АМРО (Нидерландын 3 дахь том банк) банк, Би Эн Пи Парибас банк, Саудын Холланди банк гэх зэрэг санхүүгийн байгууллагад удирдах албан тушаал хашиж байсан.



Б. Амарсанаа

ТУЗ-ийн гишүүн

| Компанийн засаглалын хорооны гишүүн |

Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн Сургуулийн захирал, Хууль зүйн ухааны доктор, профессор Батболдын Амарсанаа нь ХААН Банкны жижиг хувьцаа эзэмшигчдийн төлөөлсөн Банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүн юм. Тэрээр өмнө нь арбитрын шүүхийн арбитрч, шүүн таслах бүрэлдэхүүний даргаар ажиллаж байсан, Хонконгийн Олон Улсын Арбитрын Төв, Олон Улсын Худалдааны Танхимын арбитрын шүүх дээр тус тус ажиллаж байсан туршлагатай. Үүнээс гадна Хууль зүйн Зөвлөл (хуулийн төсөл бэлтгэх үүрэг бүхий засгийн газрын ажлын хэсэг)-ийн үндсэн гишүүний хувьд Монгол Улсын томоохон хуулиудын төслийг бэлтгэх чиглэлээр ажилласан өргөн туршлагатай хүн юм.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороод

ТУЗ нь Аудитын хороо, Эрсдэлийн хороо, Компанийн засаглалын хороо болон Хүний нөөцийн асуудал эрхэлсэн нийт 4 хороотой бөгөөд ТУЗ-өөс баталсан тус бүрийн нарийвчилсан дүрмээр зохицуулагддаг. Үүнд хорооны гишүүдийг сонгох болон чөлөөлөх тухай, хороодын бүрэн эрх, үүрэг хариуцлагыг тусгасан бөгөөд дүрэм нь Компанийн тухай хууль, Банкны тухай хууль, Монголбанкны болон холбогдох дүрэм, журамд нийцсэн байна.

Аудитын хороо

Аудитын хороо нь банкны санхүүгийн нөхцөл байдалд тогтмол хяналт тавьж, нягтлан бодох бүртгэл, комплаенс, хэрэгжилтийг хангах болон бусад хяналт механизмын үр дүнтэй, найдвартай байдал зэрэгт дүгнэлт зөвлөмж өгдөг. Мөн банкны хөндлөнгийн аудитор болон дотоод аудиторын хараат бус байдал, ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажилладаг.

Аудитын хороо нь дараах гишүүдээс бүрддэг.

Аудитын хороо	Дарга:	А.Тамир	ТУЗ-ийн хараат бус гишүүн
	Гишүүд:	Д.Хулан	ТУЗ-ийн орлогч дарга
		Аарт Йонгеянс	ТУЗ-ийн хараат бус гишүүн
		Иший Кисабүро	ТУЗ-ийн гишүүн

Эрсдэлийн хороо

Эрсдэлийн хороо нь банкны эрсдэлийг зохистой удирдах үүрэг хүлээн, банканд учирч болзошгүй эрсдэлийг илрүүлэх зорилгоор тухайн эрсдэлийн өсөлт, хязгаарын тоон үзүүлэлт дээр үндэслэн санал зөвлөмж гарган ажлаа ТУЗ-д шууд тайлагнадаг.

Эрсдэлийн хороо нь дараах гишүүдээс бүрддэг.

Эрсдэлийн удирдлагын хороо	Дарга:	Аарт Йонгеянс	ТУЗ-ийн хараат бус гишүүн
	Гишүүд:	Харада Ясүнари	ТУЗ-ийн гишүүн



2023 5 29



Ц.Баатарсайхан
Жон Ло

ТУЗ-ийн гишүүн
ТУЗ-ийн гишүүн

Компанийн засаглалын хороо нь засаглалын эрүүл соёлыг төлөвшүүлэхэд чиглэсэн компанийн засаглалын цогц зарчим, ёс зүйн дүрмийг боловсруулах, ТУЗ-д зөвлөмж өгөх, ТУЗ-ийн гишүүн болох шаардлага хангасан хүмүүсийг тодорхойлох, нэр дэвшүүлэх үүднээс ТУЗ-д санал болгох, банкны хувьцаа эзэмшигчид, бусад сонирхол бүхий этгээдүүд болон хувьцаа эзэмшигчидтэй үр дүнтэй, идэвх санаачилгатай, хариуцлагатай байдлаар харилцах нөхцөлийг хангах болон байгаль орчин болон нийгмийн асуудлаарх банкны компанийн засаглалын стратеги, гүйцэтгэл болон тайлагналд хяналт тавин ажилладаг.

Компанийн засаглалын хороо нь дараах гишүүдээс бүрддэг.

Компанийн засаглалын хороо	Дарга:	Т.Дарьбум	ТУЗ-ийн дарга
	Гишүүд:	Д.Хулан	ТУЗ-ийн орлогч дарга
		Харада Ясүнари	ТУЗ-ийн гишүүн
		Б. Амарсанаа	ТУЗ-ийн гишүүн

Хүний нөөцийн хороо

Хүний нөөцийн хороо нь ТУЗ-д банкны хүний нөөц болон талант менежментийн бодлого, банкны зохистой соёлыг чиглүүлэх, удирдах үүргийг хэрэгжүүлэхэд туслах, улмаар банкны бизнесийн зорилтдоо хүрэх, бизнесээ тогтвортой хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх үүрэгтэй.

Хүний нөөцийн хороо нь дараах гишүүдээс бүрддэг.

Хүний нөөцийн хороо	Дарга:	Д. Хулан	ТУЗ-ийн орлогч дарга
	Гишүүд:	Т.Дарьбум	ТУЗ-ийн дарга
		Харада Ясүнари	ТУЗ-ийн гишүүн
		Жон Ло	ТУЗ-ийн гишүүн

Удирдлагын баг

ХААН Банкны Гүйцэтгэх захирал нь Төлөөлөн удирдах зөвлөлөөс тогтоосон эрх хэмжээний хүрээнд банкны өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, хяналт тавьж ажиллана. Гүйцэтгэх захирал нь хувьцаа эзэмшигчдийн болон Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан шийдвэр, тогтоолын зохих хэрэгжилтийг хангана. Гүйцэтгэх захирлын өдөр тутмын болон шуурхай үйл ажиллагаанд туслах үүрэгтэй Удирдлагын хороо ажилладаг.



2023 5 29

Хүснэгт 17: Удирдлагын хорооны гишүүдийн танилцуулга



Р.Мөнхтуяа
Гүйцэтгэх захирал

Р.Мөнхтуяа нь 2020 оны 12 сарын 28-ны өдрөөс ХААН Банкны Гүйцэтгэх захирлын албан тушаалд томилогдон ажиллаж байна. Банк санхүүгийн салбарт 26 жил тогтвортой ажиллаж буй тэрбээр 1994-2000 онд Монгол даатгал банк, Сэргээн босголт банканд нягтлан бодогчоор ажлын гараагаа эхэлсэн. Р.Мөнхтуяа нь 2000-2005 онд ХААН Банканд ерөнхий нягтлан бодогч, 2005-2008 онд Санхүү хариуцсан дэд захирал, 2008-2010 онд ХААН Банкны Гүйцэтгэх захирлын орлогч, 2010-2012 онд Байгууллагын банк хариуцсан дэд захирал, 2012-2020 он хүртэл Гүйцэтгэх захирлын тэргүүн орлогч, Гүйцэтгэх захирлын орлогчоор тус тус ажилласан мэргэжлийн туршлагатай банкир юм.

Тэрбээр СЭЗИС-ийг нягтлан бодох бүртгэлийн мэргэжлээр бакалавр зэрэг, МУИС-ийг Эдийн засаг, банкны чиглэлээр, 2012 онд БНСУ-ын "Хандонг глобал" их сургуульд Бизнесийн удирдлагын магистрын зэрэг тус тус хамгаалсан.



Б.Эрдэнэдэлгэр
Гүйцэтгэх захирлын тэргүүн орлогч

Б.Эрдэнэдэлгэр нь 2023 оны 05 дугаар сарын 1-ний өдрөөс Гүйцэтгэх захирлын тэргүүн орлогчийн албан тушаалд томилогдон ажиллаж байна. 1994 онд Монголбанкны эдийн засагчаас ажлын гараагаа эхэлсэн тэрээр 2010 оноос ХААН Банкны Хөрөнгө зохицуулалтын газрын захирал, 2012 оноос Хөрөнгө зохицуулалт хариуцсан захирал, улмаар 2018 оноос 2021 он хүртэл ХААН Банкны Байгууллагын банк хариуцсан дэд захирлаар тус тус ажиллаж Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй томоохон ААН, байгууллагуудад банк санхүүгийн иж бүрэн үйлчилгээ үзүүлэх, богино болон урт хугацаат санхүүжилт олгох зэргээр байгууллагын банкны үйл ажиллагааг амжилттай удирдаж ирсэн.

Б.Эрдэнэдэлгэр нь СЭЗИС-д банк, санхүүгийн бакалавр, МУИС-д эдийн засгийн магистр, 2003 онд АНУ-ын Индианагийн их сургуульд төрийн удирдлагын магистрын зэрэг хамгаалсан.



Сачин Наир
Гүйцэтгэх захирлын орлогч

Сачин Наир нь Бүгд Найрамдах Энэтхэг Улсын иргэн бөгөөд ХААН Банкны Мэдээлэл технологи хариуцсан дэд захирлаар 2019 оны 08 сарын 26-ны өдрөөс ажиллаж байгаад 2023 оны 5 сараас Гүйцэтгэх захирлын орлогчийн албан тушаалд томилогдон ажиллаж байна. Сачин Наир нь дэлхийн хэмжээний JP Morgan Chase, Omnitech Services Ltd зэрэг банк, санхүү болон технологийн байгууллагын Япон, Хонконг дахь салбаруудад 25 жил ажилласан туршлагатай. Үүний дараа Arges Global Limited хэмээх технологийн шинэчлэл, процесс автоматжуулалт, мэдээллийн аюулгүй байдлын чиглэлээр банк, санхүүгийн болон банк санхүүгийн бус байгууллагуудад үйлчилгээ зөвлөгөө үзүүлдэг, 8 улс оронд салбартай компанийг хамтран үүсгэн байгуулж, амжилттай удирдаж байсан туршлагатай нэгэн юм.

Тэрбээр Энэтхэгийн Пүнэ их сургуулийг компьютерийн инженерийн мэргэжлээр төгсчээ.

2023 5 29





Д.Энхбаатар
Эрсдэл хариуцсан дэд захирал

Д.Энхбаатар нь 2020 оны 9 дүгээр сараас Эрсдэл хариуцсан дэд захирлын албан тушаалд томилогдон ажиллаж байна.

Тэрбээр 1999 оноос хойш ХААН Банкны Зээлийн газар мэргэжилтэн, Орон нутгийн үйл ажиллагааны газар ахлах мэргэжилтэн, Чингэлтэй салбарын захирал, Улаанбаатарын зээлийн газрын захирал, Зээл, эрсдэл хариуцсан дэд захирал, том ААН, байгууллагын банк хариуцсан дэд захирлаар ажиллаж байгаад 2010 онд Аудит хариуцсан захирал, 2018 онд Ерөнхий аудитороор тус тус томилогдон ажиллаж байсан.

Д.Энхбаатар нь СЭЗИС-ийг Банкны удирдлагын мэргэжлээр бакалавр зэрэгтэй, БНСУ-ын Хандонг глобал их сургуулийг Бизнесийн удирдлага чиглэлээр магистрын зэрэгтэй тус тус дүүргэсэн байна.



Б.Ариунболд
Мэдээллийн технологи хариуцсан дэд захирал

Б.Ариунболд нь 2023 оны 05 дугаар сараас Мэдээллийн технологи хариуцсан дэд захирлын албан тушаалд томилогдон ажиллаж байна. Б.Ариунболд нь Мэдээллийн технологийн үйл ажиллагааны газар, Мэдээллийн технологийн дэд бүтцийн хэлтэс, Мэдээллийн технологийн Энтерпрайз платформ удирдлагын газарт тус тус захирлын албан тушаалд томилогдон ажиллаж байв.

Тэрээр Болгар улсын Софийн их сургуулийг программ хангамжийн инженер мэргэжлээр бакалаврын зэрэг, тус сургуулийг компьютерийн шинжлэх ухааны магистер зэрэгтэйгээр тус тус дүүргэсэн.



Г.Мөнхбаяр
Үйл ажиллагаа хариуцсан дэд захирал

Г.Мөнхбаяр нь 2007 оноос ХААН Банканд Санхүүгийн удирдлагын газрын захирлаар ажиллаж эхэлсэн бөгөөд Санхүү хариуцсан дэд захирал, 2010 оны 11 дүгээр сараас Санхүү хариуцсан захирлаар ажиллаж байгаад 2018 оны 02 дугаар сараас эхлэн Үйл ажиллагаа хариуцсан дэд захирлаар томилогдон ажиллаж байна. Г.Мөнхбаяр нь СЭЗДС-ийг Банкны удирдлага, МУИС-ийг англи хэлний чиглэлээр тус тус бакалаврын зэрэгтэй төгссөн байна.



Ш.Өлзий-Аюуш
Санхүү, захиргаа хариуцсан дэд захирал

Ш.Өлзий-Аюуш нь 2021 оны 02 сарын 01-ний өдрөөс ХААН Банкны Санхүү, захиргаа хариуцсан дэд захирлын албан тушаалд томилогдон ажиллаж байна. Тэрээр 2001 онд ХААН Банканд Үндсэн хөрөнгийн нягтлан бодогчоор ажлын гараагаа эхэлсэн ба 2003 онд Санхүүгийн удирдлагын газарт ахлах эдийн засагч, 2004 онд Санхүүгийн шинжилгээний хэлтсийн захирал, 2006 онд Санхүүгийн удирдлагын газрын захирлын албан тушаалд тус тус томилогдон ажиллаж байв.

Ш.Өлзий-Аюуш нь МУИС-ийг 2000 онд Банкны удирдлага мэргэжлээр бакалавр, 2007 онд Бизнесийн удирдлага чиглэлээр магистрын зэрэгтэй тус тус дүүргэсэн байна.





Д.Ариунбат

Иргэдийн банк хариуцсан дэд захирал

Д.Ариунбат нь 2020 оны 04 сарын 02-ны өдрөөс эхлэн ХААН Банкны Иргэдийн банк хариуцсан дэд захирлын албан тушаалд томилогдон ажиллаж байна. Тэрбээр ХААН Банканд 2003 онд анх ажилд орсноос хойш Улаанбаатар хотын тооцооны төвд теллер, эдийн засагч, тооцооны төвийн захирал, салбарын захирлаар тус тус дэвшин томилогдож, 2013 онд Төв банкны Байгууллагын харилцааны хэлтсийн дарга, 2014 онд Улаанбаатарын иргэдийн банкны захирал, 2019 онд Стратегийн төслийн удирдагчаар ажиллаж байв. Д.Ариунбат захирал нь Худалдаа үйлдвэрлэлийн дээд сургуулийг 2003 онд эдийн засаг, статистикч мэргэжлээр бакалаврын зэрэгтэй, АНУ-ын Purdue их сургуулийг 2019 онд Бизнесийн удирдлагын магистрын зэрэгтэй тус тус дүүргэсэн байна.



Т.Ууганбаяр

Байгууллагын банк хариуцсан дэд захирал

Т.Ууганбаяр нь 2021 оны 02 сарын 01-ний өдрөөс ХААН Банкны Байгууллагын банк хариуцсан дэд захирлын албан тушаалд томилогдон ажиллаж байна. Тэрээр 2004 онд ХААН Банкны Нөөцийн газар мэдээлэл судалгааны ажилтнаар ажлын гараагаа эхэлсэн бөгөөд 2008 онд Хөрөнгө зохицуулалтын газрын дилер, 2012 онд Хөрөнгийн удирдлагын газрын захирал, 2020 онд Байгууллагын банкны газрын захирлын албан тушаалд тус тус томилогдон ажиллаж байв. Т.Ууганбаяр нь МУИС-ийг 2004 онд Банкны удирдлага мэргэжлээр бакалаврын зэрэгтэй, Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын Лондон хотын Queen Mary их сургуулийг 2020 онд Банк санхүүгийн чиглэлээр магистрын зэрэгтэй тус тус дүүргэсэн байна.



Д.Дугарбаатар

Ерөнхий аудитор

Д.Дугарбаатар нь 2020 оны 9 дүгээр сараас Ерөнхий аудиторын албан тушаалд томилогдон ажиллаж байна. Тэрбээр 2007 оноос хойш ХААН Банкны Дотоод хяналтын газрын хянан шалгагч, Эрсдэлийн удирдлагын газрын мэргэжилтэн, ахлах мэргэжилтэн, Дотоод хяналтын газрын ахлах хянан шалгагч, дарга, 2018 онд Өмчийн харилцааны газрын захирал, 2019 онд Байгууллагын банкны газрын захирлын албан тушаалд тус тус томилогдон ажиллаж байв. Д.Дугарбаатар нь Эдийн засаг, бизнесийн дээд сургуулийг бакалавр, МУИС-ийг Санхүүгийн менежментийн магистрын зэрэгтэйгээр тус тус дүүргэсэн байна.



Ш.Ганбямба

Хүний нөөц хариуцсан дэд захирал

Ш.Ганбямба нь ХААН Банкны Хүний нөөцийн хөгжлийн хэлтсийн захирлаар 2007 оноос ажиллаж эхэлсэн бөгөөд 2016 оноос Хүний нөөц хариуцсан захирал, 2018 оны 2 дугаар сараас Хүний нөөц хариуцсан дэд захирлаар томилогдон ажиллаж байна. Тэрбээр 1993 онд Гадаад хэлний дээд сургуулийг орос, англи хэлний багш мэргэжлээр бакалавр, 1996 онд Гадаад хэлний дээд сургуулийг магистрын зэрэгтэй төгссөн.



Б.Баянбат

Бизнес хөгжил хариуцсан дэд захирал

Б.Баянбат нь 2021 оны 04 дүгээр сарын 12-ны өдрөөс ХААН Банкны Бизнес хөгжил хариуцсан дэд захирлын албан тушаалд томилогдон ажиллаж байна. Тэрбээр 2011 онд ХААН Банканд Мэдээлэл технологийн аудиторор ажилд орсон бөгөөд 2014 онд Мэдээлэл технологийн ахлах аудитор, 2018 онд Мэдээлэл технологийн аудитын газрын захирал зэрэг албан тушаалд тус тус томилогдон дэвшин ажилласан. Б.Баянбат нь Шинжлэх ухаан технологийн их сургуулийг 2009 онд Мэдээлэл технологийн инженер мэргэжлээр бакалаврын зэрэгтэй дүүргэсэн.





О.Ариунтулга

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

О.Ариунтулга нь 2019 оны 9 дүгээр сараас Компанийн засаглал, Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргаар ажиллаж байна. О.Ариунтулга нь Москвагийн олон улсын харилцааны их сургуулийг (МГИМО (У) МИД РФ) олон улсын эрх зүйч мэргэжлээр бакалаврын зэрэг, МУИС-ийн Хууль зүйн сургуулийг хууль зүйн ухааны магистрын зэрэгтэйгээр тус тус дүүргэсэн.

Тэрбээр Гадаад хэргийн яамны Олон улсын гэрээ эрх зүйн газар, Өмгөөллийн "Монгол өмгөөлөгч" ХХН, Улсын Их Хурлын тамгын газар, УИХ-ын гишүүний туслах, хуулийн зөвлөхөөр ажиллаж байгаад 2018 оноос ХААН Банкны Хууль эрх зүйн газарт хуулийн зөвлөхөөр ажиллаж эхэлсэн.

Эрх бүхий албан тушаалтны эзэмшиж буй хувьцааны тоо

Хүснэгт 18. Эрх бүхий албан тушаалтны эзэмшиж буй хувьцааны талаарх мэдээлэл

Эрх бүхий албан тушаалтан	Албан тушаал	Эзэмшиж буй хувьцааны тоо
Д.Хулан	ТУЗ-ийн орлогч дарга	252,738,000
Р.Мөнхтуяа	Гүйцэтгэх захирал	1,672,056
Б.Эрдэнэдэлгэр	Гүйцэтгэх захирлын тэргүүн орлогч	1,400,000
Сачин Наир	Гүйцэтгэх захирлын орлогч	90,000
Г.Мөнхбаяр	Үйл ажиллагаа хариуцсан дэд захирал	741,400
Д.Ариунбат	Иргэдийн банк хариуцсан дэд захирал	582,129
Д.Энхбаатар	Эрсдэл хариуцсан дэд захирал	448,370
Ш.Ганбямба	Хүний нөөц хариуцсан дэд захирал	362,426
Ш.Өлзий-Аюуш	Санхүү, захиргаа хариуцсан дэд захирал	193,305
Д.Дугарбаатар	Ерөнхий аудитор	177,529
Т.Ууганбаяр	Байгууллагын банк хариуцсан дэд захирал	102,723
Б.Баянбат	Бизнес хөгжил хариуцсан дэд захирал	81,562
Б. Ариунболд	Мэдээлэл технологи хариуцсан дэд захирал	133,171
О.Ариунтулга	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга	22,937


Банкны зохистой засаглал

ХААН Банк нь Банкны тухай хууль, Монголбанкны "Банкны зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэх журам"-д заасны дагуу өөрийн зохистой засаглалын үнэлгээг жил бүр хийж, Монголбанкаар хянан баталгаажуулдаг. Сүүлийн 5 жилийн байдлаарх зохистой засаглалын үнэлгээний товч мэдээлэл:

- ✓ Монголбанкнаас 2016 оны 04 сарын 30-ны өдрийн байдлаар банкны Зохистой засаглалыг "Сайн" буюу 91.5 оноогоор үнэлсэн.
- ✓ Монголбанкнаас 2017 оны 04 сарын 30-ны өдрийн байдлаар банкны Зохистой засаглалыг "Сайн" буюу 94 оноогоор үнэлсэн.
- ✓ Монголбанкнаас 2018 оны 04 сарын 30-ны өдрийн байдлаар банкны зохистой засаглалыг үнэлж "Сайн" буюу 95 оноогоор үнэлсэн.
- ✓ Монголбанкнаас 2019 оны 04 сарын 30-ны өдрийн байдлаар банкны зохистой засаглалыг үнэлээгүй бөгөөд ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг яаралтай томилж, Банкны дүрмийг шинэчлэхийг шаардсан болно.
- ✓ Монголбанкнаас 2020 оны 04 сарын 30-ны өдрийн байдлаар банкны зохистой засаглалыг "Дунд" буюу 65.0 оноогоор үнэлсэн. Тус үнэлгээний дагуу ХААН Банк нь Монголбанкнаас өгсөн чиглэлийн дагуу зохих арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэн 2020-2021 оны банкны зохистой



2023 5 29



засаглалын үнэлгээг хийн 2021 оны 04 сарын 30-ны өдөр хүргүүлж, Монголбанкнаас "Сайн" буюу 82.5 оноогоор үнэлсэн болно.
Монголбанкнаас 2021 оны 04 сарын 30-ны өдрийн байдлаар банкны зохистой засаглалыг үнэлж "Сайн" буюу 86.5 оноо авч "Удирдлагын үйл ажиллагаа нь хэвийн банк" гэж үнэлсэн.
Монголбанкнаас 2022 оны 04 сарын 30-ны өдрийн байдлаар банкны зохистой засаглалыг үнэлж "Сайн" буюу 86.5 оноо авч "Удирдлагын үйл ажиллагаа нь хэвийн банк" гэж үнэлсэн.

1.6.3. Ногоон үйл ажиллагаа

1.6.3.1. Тогтвортой хөгжлийн түүхэн замнал

2000 он хүртэл	Монгол Улсад Компанийн нийгмийн хариуцлагын талаарх ойлголт анх нэвтэрсэн үе бөгөөд банк нь энэ чиглэлээр дотоод руу чиглэсэн ажлуудыг үр дүнтэй хэрэгжүүлж эхэлсэн. Тухайлбал, ажилтнуудын нийгмийн асуудал, хуулийн хүрээнд шударга, ил тод үйл ажиллагаа эрхлэх зэрэг хариуцлагатай бизнесийн зарчмуудыг мөрдөн хэрэгжүүлэв.
2007	ХААН Банк Санг үүсгэн байгуулж, компанийн нийгмийн хариуцлагын төсөл хөтөлбөрүүдийг системтэйгээр хэрэгжүүлж эхлэв.
2010	НҮБ-ын Даян дэлхийн гэрээнд нэгдэж, 4 бүлэг, 10 зарчмыг нь үйл ажиллагаандаа мөрдөж эхэлсэн.
2011	Байгаль орчин, нийгмийн бодлогыг зээлийн үйл ажиллагаандаа хэрэгжүүлж эхлэн, тасралтгүй сайжруулсаар байна. Монголын тогтвортой санхүүжилтийн хөтөлбөрт нэгдэж, ТоС-ийн ажлын хэсэг байгуулагдсан.
2018	Компанийн нийгмийн хариуцлагын үйл ажиллагаагаа өргөжүүлэн, НҮБ-аас тодорхойлсон Тогтвортой хөгжлийн 17 зорилгод хувь нэмрээ оруулж, банкны бүх түвшний үйл ажиллагаатай уялдуулахаар зорьж эхэлсэн. "Нэг бүс - Нэг зам" санаачилгын хүрээнд бий болсон Ногоон хөрөнгө оруулалтын зарчимд нэгдэж, 7 зарчмыг нь үйл ажиллагаандаа хэрэгжүүлж эхэлсэн.
2019	Банкны Тогтвортой хөгжлийн жилийн тайланг бэлтгэн нийтэд ил тод мэдээлж эхлэв. Банкны ТоС-ийн ажлын хэсгийг өргөжүүлэн Тогтвортой хөгжлийн ажлын хэсэг байгууллаа.
2020	ХААН Банкны дотооддоо дагаж мөрдөх анхны Тогтвортой хөгжлийн бодлого батлагдав.
2022	ХААН Банкны брэнд шинэчлэлийн төслөөр "Тогтвортой хөгжлөөр манлайлагч байна" гэж банкны дөрвөн үнэт зүйлсийн нэгээр тухайлан тодорхойлсон. ХААН Банк нь Монголын анхны Ногоон бондыг олон улсын зах зээлд гаргаж, 5 жилийн хугацаатай 60 сая ам.долларын эх үүсвэрийг татан төвлөрүүлээ.

1.6.3.2. Тогтвортой хөгжлийн бодлого

ХААН Банк 2018 оноос эхлэн Тогтвортой хөгжлийн зорилгуудыг дотоод үйл ажиллагааныхаа түвшин бүрт уялдуулахад анхаарч ажиллах том зорилт тавьсан. Энэ зорилтын хүрээнд 2020 онд Тогтвортой хөгжлийн бодлогоо батлан хэрэгжүүлж эхэлсэн билээ.

Уг бодлогын суурь ойлголт нь НҮБ-ын 2015 онд тодорхойлсон Тогтвортой хөгжлийн 17 зорилго, НҮБ-аас 2000 онд зарлан тунхагласан "Даян дэлхийн гэрээ"-ний 4 бүлэгт 10 зарчим болон Монгол Улсын "Тогтвортой санхүүжилт (ТоС) хөтөлбөр"-ийн 2013 онд тодорхойлсон 8 зарчимд тулгуурласан байдаг.



2023 5 29



Энэхүү бодлого нь урт хугацаанд амжилттай оршин тогтнох суурийг бэхжүүлэх үндсэн баримт бичиг байх бөгөөд Тогтвортой хөгжлийн зорилго, зарчмуудыг тодорхойлох, тэдгээрийг өдөр тутмын үйл ажиллагаанд хэрэгжүүлэх, банкны Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх удирдлага, нийт ажилтнууд оролцогч талууд, харилцагчдын өмнө хүлээх үүрэг хариуцлагын хэм хэмжээг тодорхойлоход оршино.

ХААН Банкны тогтвортой хөгжлийн бодлого нь үндсэн дөрвөн хэсгээс бүрдэнэ. Үүнд:



1.6.3.3. Тогтвортой санхүүжилт

ХААН Банк нь тогтвортой санхүүжилтийн хүрээнд олон улсын санхүүжүүлэгч байгууллага, зөвлөх компаниуд, яам, тамгын газар болон байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа явуулж буй байгууллагуудтай хамтран ажиллаж цар хүрээгээ тэлсээр байна.

Банк нь дараах зээлийн бүтээгдэхүүнийг амжилттай хэрэгжүүлж, шинээр нэвтрүүлэн ажиллаж байна.

- ЛИСА төслийн байгаль орчныг хамгаалахад зориулсан ногоон зээл;
- БОАЖЯ-тай хамтран хэрэгжүүлж байгаа Агаар орчны бохирдлыг бууруулах өрхийн болон бизнесийн ногоон зээл;
- Банкны өөрийн эх үүсвэрээр санхүүжүүлэх хэрэглээний болон бизнесийн ногоон зээлийн бүтээгдэхүүнийг зах зээлд шинээр нэвтрүүлсэн;
- Эрчим хүчний үр ашгийг нэмэгдүүлэх бизнесийн төсөл хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх зорилготой “Эрчим хүчний хэмнэлттэй бизнесийн зээл”;
- Гэр бүлийн ногоон зээл багтаж байна.

Ногоон эх үүсвэр

ХААН Банк нь 2015 оноос хойш нийт 180 сая орчим ам.долларын ногоон зээлийн эх үүсвэрийг олон улсын банк санхүүгийн байгууллагуудаас татан төвлөрүүлээд байна. 2021-2023 онуудад ногоон санхүүжилтын чиглэлээр татсан санхүүжилтүүдийг дурдвал:



2023 5 29

**Дэлхийн уур амьсгалын хамтын ажиллагааны сан (GCPF)-аас олгосон санхүүжилт**

ХААН Банк нь уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицоход чиглэсэн үйл ажиллагааг дэмжин, иргэд, аж ахуйн нэгжүүдийн ногоон үйлдвэрлэлд шилжих шилжилтийг ногоон санхүүжилтийн шийдлүүдээр дэмжих зорилгоор банкны урт хугацааны түнш байгууллага болох Швейцарийн "responsAbility Investments AG"-н удирдаж буй "Дэлхийн уур амьсгалын хамтын ажиллагааны сан (GCPF)"-тай хамтын ажиллагааг 2021 онд амжилттай эхлүүлж байсан билээ. 2021 онд GCPF сангаас хүлээж авсан 5 сая ам.долларын урт хугацаат эх үүсвэрийг ногоон зээл, төсөл хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх зорилгоор амжилттай бүрэн ашиглаж дууссаны үндсэнд, зээлийн 2 дахь хэсэг болох 8 сая ам.долларыг нэмэлтээр татан төвлөрүүллээ. GCPF сан нь ХААН Банкны ногоон зээл олгох чадавхийг сайжруулах, ногоон зээл олгоход мэргэжлийн туслалцаа үзүүлэх, үйл ажиллагааг сайжруулахад шаардлагатай техникийн туслалцааг үзүүлэн хамтран ажилласаар байна.

Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк (EBRD)-аас олгосон санхүүжилт

ЕСБХБ нь "Ногоон эдийн засгийг санхүүжүүлэх хөтөлбөр"-ийн хүрээнд НҮБ-ын дэргэдэх Уур амьсгалын ногоон сан (УАНС)-гаас 15 сая ам.доллар, өөрийн эх үүсвэрээс 45 сая ам.долларыг бүрдүүлж, нийт 60 сая ам.долларыг байгаль орчинд ээлтэй ногоон зээлийг санхүүжүүлэх гэрээг ХААН Банкттай 2022 оны 10 сарын 19-ний өдөр байгуулсан. Уг санхүүжилтийн эхний хэсэг болох 30 сая ам.долларыг 2022 оны 12 сард хүлээн авсан бол үлдсэн эх үүсвэрийг 2023 ондоо хүлээн авахаар төлөвлөөд байна. Энэ хүрээнд байгальд ээлтэй үйл ажиллагаа, эко бүтээгдэхүүнийг дэмжих уян хатан, таатай нөхцөл бүхий ногоон зээлийг харилцагчдадаа санал болгосноор уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг хамтдаа тэмцэж, эх дэлхийдээ хувь нэмэр оруулах боломж бүрдэх болно.

Нидерландын Хөгжлийн банк (FMO) болон европын хөгжлийн банкуудын хамтарсан санхүүжилт

ХААН Банк нь Нидерландын хөгжлийн банк, Францын хөгжлийн байгууллага, Германы хөгжлийн банк, Олон улсын хөрөнгө оруулалтын банк болон Швейцарын "Atlantic Forfaitierungs AG" байгууллагуудтай 120 сая ам.долларын урт хугацаат хамтарсан санхүүжилттэй зээлийн гэрээг 2021 оны 9 дүгээр сард байгуулсан. Энэхүү санхүүжилтийн 20 сая ам.долларыг иргэд болон бизнес эрхлэгч харилцагчдын ногоон эрчим хүчний хэмнэлттэй бүтээгдэхүүн, үйлчилгээг санхүүжүүлэх, сэргээгдэх эрчим хүч, ус болон байгалийн нөөцийн хэмнэлттэй, дахин боловсруулах үйлдвэрлэл, хог хаягдлын менежмент, ногоон тээвэр, ногоон барилга зэрэг олон төрлийн "ногоон" төсөл хөтөлбөрийг тусгайлан санхүүжүүлэхэд зарцуулж байна.



Олон улсын зах зээлд гаргасан Монгол улсын хамгийн анхны ногоон бондын санхүүжилт

Банк нь сэргээгдэх эрчим хүч болон байгальд ээлтэй ногоон төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх зорилготой Монголын анхны Ногоон бондыг олон улсын зах зээлд гаргах ажлыг зохион байгуулж, Олон улсын санхүүгийн корпораци 15 сая ам.долларын санхүүжилт, Нидерландын хөгжлийн банк 35 сая ам.доллар, АНУ-д төвтэй "MicroVest Capital Management" компани 10 сая ам.долларын санхүүжилтийг тус тус олгоод байна. Энэхүү хөрөнгө оруулалтаар Монгол Улсын сэргээгдэх эрчим хүч, эрчим хүчний хэмнэлт, ногоон барилга байгууламж, хүрээлэн буй орчинд ээлтэй хөдөө аж ахуйн төслүүдийг санхүүжүүлснээр ХААН Банкны ногоон зээлийн багцыг нэмэгдүүлээд зогсохгүй Монгол Улсын санхүүгийн зах зээлийн тогтвортой хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулах болно.

Монголын хөрөнгийн зах зээлээс татсан санхүүжилт

ХААН Банк нь 2023 оны 4 дүгээр сард олон нийтэд хувьцааныхаа 10%-ийг санал болгож, 183.4 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлсэн. Банк нийт татан төвлөрүүлсэн хөрөнгийн 34% буюу 62.4 тэрбум төгрөгийг ногоон төсөл, хөтөлбөрүүдийн санхүүжилтэнд тусгайлан зарцуулахаар төлөвлөсөн.





НОГООН БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ

ХААН Банк нь ногоон зээлийн бүтээгдэхүүний хувьд гадны хөрөнгө оруулагч байгууллагуудтай хамтран ногоон технологи, эрчим хүчний хэмнэлт, нүүрсхүчлийн хийн ялгарлыг бууруулах чиглэлээр харилцагчдад техникийн зөвлөх үйлчилгээ үзүүлэн, ногоон бизнесийг дэмжин ажилладаг. Цаашид ч байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл, уур амьсгалын өөрчлөлтийг бууруулахад чиглэсэн ногоон бизнес, ногоон хэрэглээг дэмжих зээл болон бүтээгдэхүүн, үйлчилгээг тогтвортой хөгжүүлж, зах зээлд таниулан ногоон санхүүжилтийн экосистемийг бүтээх, үр ашгийг хэмжих зохицуулалтын зөв механизмыг бий болгох, ногоон эдийн засагт оруулах хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэн манлайлан ажиллахыг зорьж байна.

Хүснэгт 19. ХААН Банкны ногоон зээлийн бүтээгдэхүүн


Зээлийн бүтээгдэхүүн	Хүү	Хугацаа	Зээлийн дээд хэмжээ	Шаардлага
БИЗНЕСИЙН НОГООН ЗЭЭЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮНҮҮД				
Ногоон эдийн засгийг дэмжих МОНГЕФФ зээл – Эргэлтийн хөрөнгө * – Хөрөнгө оруулалт *	14.4 – 15.0%	60 сар хүртэл	5.0 сая ам.доллартай тэнцэх төгрөг	Эрчим хүчний хэмнэлт >20% Хүлэмжийн хийг бууруулах >20% Усны хэмнэлт >20%
Ногоон эдийн засгийг дэмжих МОНГЕФФ зээл – Тоног төхөөрөмж *	14.4%	36 сар хүртэл	300.0 ам.доллартай тэнцэх төгрөг	Pre-investment assessment
Тогтвортой ноос ноолуурын нийлүүлэлтийг дэмжих ногоон зээл ***	12.0%	12 сар хүртэл	1 тэрбум төгрөг	SFA - Зохистой дадлын тохирлын гэрчилгээ бүхий хоршоод
Агаар, орчны бохирдлыг бууруулах бизнесийн ногоон зээл	8%	60 сар хүртэл	200 сая төгрөг	Зориулалтын дагуу
Ногоон бизнесийн зээлийн шугам	15%	24 сар хүртэл	200 сая төгрөг	Ногоон таксономи
Техникийн хөрөнгө оруулалтын ногоон зээл	15%	60 сар хүртэл /Урьдчилгаа 20%/	500 сая төгрөг	Тоног төхөөрөмжийн шинэчлэл /IE3/
Ногоон хөрөнгө оруулалтын зээл	15%	60 сар хүртэл	1 тэрбум төгрөг	Ногоон таксономи

ХЭРЭГЛЭЭНИЙ НОГООН ЗЭЭЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮНҮҮД

Агаар, орчны бохирдлыг бууруулах өрхийн ногоон зээл	2.0 – 3.0%	30 сар хүртэл	40 сая төгрөг	Агаар, хөрсний бохирдол бууруулах
Агаар, орчны бохирдлыг бууруулах тэтгэврийн ногоон зээл	2.0 – 3.0%	12 сар хүртэл	Тэтгэврийн хэмжээтэй уялдана.	
Ногоон хэрэглээний зээл	14.4%	30 сар хүртэл	20 сая төгрөг	Ногоон таксономи
Гэр бүлийн ногоон зээл*	12.0%	30 сар хүртэл	40 сая төгрөг	Эрчим хүчний хэмнэлт бүхий цахилгаан бараа



2023 5 29.1



Худалдан авч буй тээврийн хэрэгслийн үнийн дүнгээс хэтрэхгүй

Шинэ цахилгаан тээврийн хэрэгсэл

*- Харилцагчийн бизнес төслүүдэд хөндлөнгийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх байгууллагууд эрчим хүчний хэмнэлтийн үнэлгээ гаргана. Үнэлгээг зээлийн судалгааны шатанд ногоон шалгуур үзүүлэлтийг хангах боломжтой эсэх дээр, зээл батлагдаж олгогдсоны дараа анх төлөвлөж байсан эрчим хүчний хэмнэлтийн үр дүн гарсан эсэхийг баталгаажуулах үнэлгээ хийнэ. Тус үнэлгээг эх үүсвэр олгогч талаас дааж байгаа бөгөөд харилцагчийн төслийн онцлогоос хамаарч тухай бүр үнэлгээ хийх байгууллагыг сонгоно.

** - Харилцагч өөрийн хэрэгжүүлэх байгаль орчинд ээлтэй бизнесийн үйл ажиллагааны төслийг бичсэн байна.

*** - Тогтвортой ноос ноолуурын эвслээс хянаж, баталгаажуулан Зохистой дадлын тохирлын гэрчилгээ бүхий хоршоодуудад туршилтаар олгож байгаа зээлийн бүтээгдэхүүн юм.

ХААН Банкны санхүүжүүлсэн ногоон төсөл хөтөлбөрүүдийн жишээ



Улаанбаатар зочид буудлыг сэргээн засварлан, шинэчлэх төсөл

Улаанбаатар зочид буудлыг сэргээн засварлах, шинэчлэх төсөл нь эрчим хүчний үр ашгийг нэмэгдүүлэх бизнесийн ногоон зээлийг авсан томоохон төслүүдийн нэг юм. Энэхүү төсөл нь 1959 онд баригдсан хуучны барилгыг дахин сэргээн засварлаж, дулаан алдагдлыг бууруулж илүү эрчим хүч, усны хэмнэлттэйгээр шинэлэг өнгө төрхтэйгээр үйл ажиллагаагаа явуулах зорилгоор нийт 9.5 тэрбум төгрөгийн зээлийн санхүүжилт авсан. Зээлийн зориулалтын хүрээнд үнэлгээг хийхэд дараах дүгнэлт гарсан байна.

- Бүрэн хүчин чадлаар ажиллахад өдөрт 27,010 литр ус хэмнэнэ.
- 1,208,160.96 kWh эрчим хүчийг хэмнэж, хувиар тооцвол 23.8%-ийн эрчим хүчний хэмнэлтийг гаргана.
- Эрчим хүчний зардалд 126.9 сая төгрөгийг жилд хэмнэх боломжтой.
- 2.59 сая тонн нүүрсхүчлийн хий ялгарахаас сэргийлж байна.

Уг төсөл нь дулаан алдагдлыг бууруулахаас гадна Улаанбаатар хотын төвд байрлах түүхэн дурсгалт барилгын хуучны өнгө төрхийг алдагдалгүйгээр сэргээн засварлаж, эрчим хүчний хэмнэлт бүхий "ногоон" барилга болгож байгаагаараа онцлогтой.



Төгс Ургац ХХК Бүрэн автомат өвлийн хүлэмжийн төсөл

"Төгс ургац" ХХК-ийн орчин үеийн, дэвшилтэт, ухаалаг технологийн голланд загварын бүрэн автомат, дөрвөн улирлын хүлэмжийн төслийг санхүүжүүлсэн.

Нийт 10,400 кв талбай бүхий халаалт, усалгааны систем, агаарын чийгшлийн тохируулга зэрэг орчин үеийн хүлэмжийн шаардлагыг бүрэн хангасан, жилийн дөрвөн улирлын үйл ажиллагаатай энэхүү хүлэмжийн төсөл нь ижил төрлийн өвлийн хүлэмжүүдтэй харьцуулахад эрчим хүчний хэрэглээг 24 хувиар бага зарцуулах төдийгүй хүлэмжийн хийн ялгарлыг 50 хувиар бууруулах боломжтой юм.

- Усны хэрэглээ нь шинэ төслийг хэрэгжүүлснээр 66%-иар буурна.
- 3,931,000 kWh эрчим хүчийг хэмнэж, хувиар тооцвол 24%-ийн эрчим хүчний хэмнэлтийг бий болгоно.



Милко "Олон улсын жишиг экспортын

Монголын Улсын анхны олон төрөлт хүнсний үйлдвэр болох "Олон улсын жишиг экспортын үйлдвэрийн бүс" байгуулах, энэхүү төслийг ХААН Банк ногоон зээлээр санхүүжүүлсэн. Тус ногоон санхүүжилтийн



2023 5 29 7



үйлдвэрийн бүс”
байгуулах төсөл

хүрээнд хог хаягдлыг багасгах, эрчим хүчний хэрэглээг 50 гаруй хувиар, хүлэмжийн хийн ялгарлыг 8000 гаруй тонноор бууруулах шинэ тоног төхөөрөмжүүд худалдан авч, ингэснээр үйлдвэрийн хүчин чадлыг гурав дахин нэмэгдүүлэх боломж бүрдсэн юм. Өөрөөр хэлбэл, үйлдвэрийн тоног төхөөрөмжүүдийг шинэчилснээр цахилгааны ашиглалт буурч, үйлдвэрийн бүтээмж нэмэгдэхээс гадна нэгж бүтээгдэхүүний зардал багасах аж. Мөн үйлдвэрлэлийн хүчин чадлыг ийнхүү сайжруулснаар хүнсний экспортын хэмжээг өсгөж, валютын урсгалыг нэмэгдүүлэх чухал ач холбогдолтой.



“Go.to market” -
Үйлчилгээний төв
байгуулах төсөл

Айл өрхүүдийн өдөр тутмын хэрэгцээг цогцоор нь хангах зориулалттай, уламжлалт захын хямд үнэ, өргөн сонголтыг тав тухтай орчинд үзүүлэх олон улсын чиг хандлага бүхий орчин үеийн жишиг томоохон захыг энэхүү төслийн хүрээнд барьж байна. Тус барилга байгууламж нь саарал усны хэрэглээ, эрчим хүч, хог хаягдлын менежментийг цогцоор нь шийдсэн, ус, цахилгаан болон дулааныг 24-өөс дээш хувь хэмнэх төдийгүй хүн, байгальд ээлтэй материал ашиглан барьж буйгаараа ногоон зээлд тавигдах шалгууруудыг бүрэн хангаж байгаа юм. Хамгийн том давуу тал нь үр ашиггүй эрчим хүчний хэрэглээг багасгаж, эдийн засаг, нийгэмд эерэг нөлөө үзүүлэхээс гадна үйлчлүүлэгчид тав тухтай орчинд сэтгэл ханамжтай худалдан авалт хийх, шоппинг аялал хийх боломж бүрдүүлснээрээ онцлогтой.

- 1,381,000 kWh буюу 24%-ийн эрчим хүчний хэмнэлтийг бий болгоно.

1.6.3.4. Тогтвортой үйл ажиллагаа

Тогтвортой ажлын байр


ХААН Банк нь Тогтвортой хөгжлийн 8-р зорилго: “Эдийн засгийн өсөлт, баталгаат ажлын байрыг бий болгох”-ын хүрээнд хүний нөөцийн уян хатан, оновчтой стратеги, бодлогыг хэрэгжүүлж, байгууллагын соёлыг бэхжүүлэн, ажилтнууддаа зөв хандлага, эерэг зан төлөвийг хэвшүүлэх, тэдний оролцоог нэмэгдүүлэх, сэтгэл ханамжтай, өндөр гүйцэтгэлтэй, үр бүтээмжтэй ажиллах нөхцөл бүрдүүлэх замаар банкны урт хугацааны, тогтвортой өсөлт хөгжилд хувь нэмрээ оруулан ажиллаж байна.

Банк нь ажилтнуудын сургалт, хөгжилд чиглэсэн тэгш хүртээмжтэй, уян хатан, хэрэгцээнд нь суурилсан сургалтуудыг санал болгохоос гадна банкны ажилтнууд мэргэжлийн өндөр түвшинд ажилладаг, мэргэшсэн байх тал дээр онцгойлон анхаардаг. Иймд мэргэжлийн чиглэлээр болон банкны дунд, урт хугацааны стратегийн дагуу ажилтнуудын саналд үндэслэн сургалтын хэрэгцээг тодорхойлж, мэргэжлийн, хувь хүний хөгжлийн чиглэлээр сургалтуудыг тогтмол зохион байгуулдаг билээ.

Ажилтнуудынхаа сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх үүднээс буцалтгүй тусламж олгох, тэтгэврийн хуримтлалын санд хамруулах, өндөр настны нэмэгдэл тэтгэврийг ахмад ажилтнууддаа олгох, төрөл бүрийн хөнгөлөлт, хангамжийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх, эрүүл мэндийн даатгал, үзлэг шинжилгээнд хамруулах зэргээр нийгмийн асуудлыг нь шийдвэрлэхийг зорьдог.

Мөн ажилтнуудынхаа эрүүл, аюулгүй орчинд ажиллах эрхийг хангахаар Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хуулийг хэрэгжүүлэн шаардлагатай орчин нөхцөлийг бүрдүүлэх, ажлын байрны эрсдэлийн үнэлгээ хийх, эрсдэлтэй гэж үзсэн тохиолдолд ажилтны эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангахад чиглэсэн шаардлагатай арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлдэг.





Төвтөртой ажлын орчин

Ногоон оффис

ХААН Банк нь 2018 оноос эхлэн Тогтвортой хөгжлийн 17 зорилгыг бүх түвшний үйл ажиллагаандаа шингээхээр зорьж ажиллаж байна. Үүний хамгийн том жишээ нь орчин үеийн барилгын удирдлагын системтэй, газар хөдөлтийн 8 баллд тэсвэр бүхий ногоон оффис болох ХААН Банк цамхаг билээ. Энэ нь ажилтнуудыг эрүүл, аюулгүй орчинд ажиллах нөхцөл боломжоор хангахаас гадна ХААН Банк өөрийн өдөр тутмын үйл ажиллагаагаар байгаль орчинд үлдээх ул мөр багатай байхад чухал ач холбогдолтой. Ногоон оффисын санаачлагууд нь банкны төв оффист цогцоор хэрэгжихээс гадна салбар нэгжийн оффист шат дараатай нэвтрүүлэн хэрэгжүүлж эхлээд байна.

Ногоон оффисын хүрээнд хэрэгжүүлж буй ажлууд:

- BMS – Building Management System
- Гэрэлтүүлгийн удирдлагын систем
- Хөдөлгөөн мэдрэгч гэрэлтүүлэг
- Лифтний цагийн болон эрчим хүчний хэмнэлттэй тохиргоо
- Цэвэр усны зохисгүй хэрэглээг бууруулах тохиргоо
- Дулаан солилцуурын систем
- Халаалт, хөргөлт, агааржуулалтын системүүд бүгд автомат цагийн тохиргоо
- Цахилгааны бүх оролт гаралтуудад дижитал тоолуур
- Хог хаягдлын менежмент



2023 5 29А

Нөөцийн зохистой хэрэглээ


Оффисын эрчим хүч, ус, дулааны хэрэглээ

2021 онд “Ковид-19” цар тахлын хязгаарлалт, хөл хорионы үед төв оффисын ажилтнууд зайнаас тодорхой хугацаанд ажилласан нь ашиглалтын зардлыг багагүй хэмжээгээр бууруулсан төдийгүй шатахуун зарцуулалт болон хүлэмжийн хийн ялгарлыг ихээхэн бууруулж чадсан. 2022 оноос цар тахлыг нөхцөл байдал сайжирсантай холбоотой нөөцийн хэрэглээ өссөн боловч хэвийн үеийн өмнөх байдалтай харьцуулахад буурсан төдийгүй цаашид илүү хэмнэлттэй, зохистой хэрэглээг хэвшүүлэхээр хичээн ажиллаж байна.

Хүснэгт 20. Оффисын эрчим хүч, ус, дулааны хэрэглээ

	2020	2021	2022
Хэрэглээ (м3)	8,639	6,746	9,1829
Зардал (төгрөг)	22,287,787	17,405,252	38,040,036





Эрчим хүч	Хэрэглээ (жоуль)	12,545	12,091	12,175
	Зардал (төгрөг)	91,286,472	87,983,151	88,594,273
Шатахуун	Хэрэглээ (кВт)	2,844,057	2,421,001	2,972,547
	Зардал (төгрөг)	458,908,544	263,180,262.7	530,908,102
	Хэрэглээ (тн)	267	65	104
	Хэрэглээ (м3)	615,982,386.5	176,769,155.5	398,507,511

Цаасны хэрэглээ

Банк нь цахим шилжилтийг тасралтгүй хийж буйтай холбоотойгоор цаасны хэрэглээг багасгахад анхаарч ажилласаар байна.

Хүснэгт 21. Төв оффис ба салбар нэгжийн цаасны хэрэглээ

Цаасны хэрэглээ*	2020	2021	2022
Цаасны ширхэг	1.9 сая ширхэг	770 мянган ширхэг	885 мянган ширхэг
Цаасны зардал	1.5 тэрбум төгрөг	1 тэрбум төгрөг	1.4 тэрбум төгрөг

* А4, АТМ, ПОС, Дугаарлагч цаас, мөнгөний бүс цаас, баримтын хавтас цаас

1.6.3.5. Тогтвортой нийгмийн хөрөнгө оруулалт

ХААН Банк Сан

ХААН Банк Сан нь 2007 онд байгуулагдсан бөгөөд уг сангаар дамжуулан компанийн тогтвортой хөгжлийн бодлого, нийгмийн хариуцлагын ажлуудыг хэрэгжүүлдэг. 2022 оны эцсийн байдлаар хүмүүсийн амьдралыг бодитой өөрчилж, нийгмийн сайн сайханд хувь нэмрээ оруулах эрхэм зорилгын дор 500 төсөл, хөтөлбөрийг 9.4 тэрбум төгрөгөөр санхүүжүүлжээ.

Боловсрол

ХААН Банкны нэрэмжит шинэ оюутны тэтгэлэгт хөтөлбөр

2007-2022 оны хугацаанд ХААН Банк сан "ХААН Банкны нэрэмжит тэтгэлэгт хөтөлбөр"-ийн хүрээнд нийт 2,170 оюутан залууст сургалтын төлбөрийн тодорхой хувийн тэтгэлэг олгоод байна.

RISE шинэ оюутны хөгжлийн хөтөлбөрийг ХААН Банк сан 2018 оноос санаачлан хэрэгжүүлсэн бөгөөд шинээр оюутан болж буй залуусыг хичээлээс гадуур өөрийгөө хөгжүүлэх, хувийн санхүүгээ зөв удирдах болон их хотын соёлтой иргэн байхад чиглүүлэх, туслах зорилготой. Өнгөрсөн хугацаанд тус хөтөлбөрт нийт 4,000 гаруй шинэ оюутан хамрагдаж, биечилсэн болон цахимаар сургалт, хөгжлийн 10 гаруй арга хэмжээнд оролцсон.

Иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх сургалт

Санхүүгийн төлөвлөлт, сахилга батын тухай зорилтот бүлгүүдэд мэдлэг мэдээлэл олгох, санхүүгийн зөв бүтээгдэхүүн үйлчилгээг сонгох, цахим банкны аюулгүй байдал болон санхүүгийн эрсдэлийг олон нийт, харилцагчдад ойлгуулах, цаашлаад иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх зорилгоор ХААН Банк 2018 оноос санхүүгийн боловсрол олгох хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлж эхэлсэн. Нийт 4,000 гаруй хүүхэд, залуусыг санхүүгийн болон хувь хүний хөгжлийн сургалт зэрэг сонирхолтой олон арга хэмжээ, сургалтад хамруулаад байна.

2023 5 29





Код бичих охидын хөтөлбөр

"Код бичих охидын хөтөлбөр" нь харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын хүний нөөцийг бэлдэх, бус нутгийн тоон хуваагдлыг бууруулах, жендерийн тэгш бус байдлыг багасгах зорилготойгоор 2 дахь жилдээ зохион байгуулагдсан бөгөөд уг ажлын хүрээнд ХААН Банк Сан 4 оролцогчийн сургалтын зардлыг бүрэн санхүүжүүлж, тэтгэлэг олгосон. Тус хөтөлбөрт нийт 30 охин шалгарч, зуны турш вакумжуулсан сургалтад хамрагдсанаас гадна ХААН Банкны төв оффис болох ХААН Банк Цамхагт зочлон банкны үйл ажиллагаа, санхүүгийн салбарын мэдээллийн технологитой танилцаж, мэргэжлийн хүмүүстэй ярилцан мэдээлэл авах боломжийг бүрдүүлсэн.

Эрүүл мэнд

Хавдрын эсрэг үндэсний аян

2011 оноос эхлэн "Хавдрын эсрэг үндэсний аян"-ыг орон даяар хэрэгжүүлж байна. Өнгөрсөн 12 жилийн хугацаанд аяны баг бүрэлдэхүүн Монгол орныг гурван удаа бүтэн тойрч, 130 мянга гаруй иргэнийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, 10 мянга гаруй эмч мэргэжилтнийг мэргэшүүлж, 500 гаруй удаагийн яаралтай мэс засал хийж, хорт хавдрын 600 гаруй тохиолдлыг илрүүлсэн ба ХААН Банкны 2,700 гаруй ажилтан сайн дурын эрүүл мэндийн ажилтнаар бэлтгэгдсэн.

Цусны даралт ихсэлтийн эсрэг аян

ХААН Банк Сан 2017 оноос "Цусны даралт ихсэлтийн эсрэг аян"-ыг орон даяар эхлүүлж, Монгол орны 12 аймагт амжилттай хэрэгжүүлэн, үүнд 19 мянга гаруй иргэн хамрагдаж, үр шимийг нь хүртээд байна. Аяныг хэрэгжүүлэгч талууд жил бүрийн 09 сарын 29-ний өдөр Дэлхийн зүрхний өдрийг хамтран тэмдэглэж, олон нийтэд эрүүл мэндийн боловсрол олгох нөлөөллийн ажлыг тогтмол хийж ирсэн.

Эмэгтэйчүүдийг дэмжих хөгжлийн хөтөлбөр

ХААН Банк сангаас 2021 оноос "Эмэгтэйчүүдийг дэмжих хөгжлийн хөтөлбөр"-ийг анх удаа санаачлан, эрүүл мэндийн салбарын сувилагч, асрагч нарын дунд хэрэгжүүлж байна. Уг хөтөлбөр нь тэдний ажил эрхлэлт, хувь хүний болон мэргэжлийн хөгжлийг дэмжих, мөн албан тушаал, ажил үүрэг, мэргэжлийн онцлог, давуу талыг нийгэмд таниулах, эерэг хандлага бий болгох зорилготой бөгөөд одоогийн байдлаар хөтөлбөрт 360 оролцогч шалгарч, 2-6 төрлийн сургалтад үнэ төлбөргүй цахимаар хамрагдсан.

Байгаль орчин

"ХААН Банкны ой" мод тарих хөтөлбөр

ХААН Банк Сан 2007 оноос эхлэн байгаль орчны тэнцвэрт байдлыг хадгалах, уур амьсгалын өөрчлөлтөөс урьдчилан сэргийлэх зорилгын хүрээнд "ХААН Банкны ой" хөтөлбөрийг хэрэгжүүлж ирсэн бөгөөд өнгөрсөн хугацаанд 30 мянган ширхэг мод тариад байна. Уг хөтөлбөрийн цар хүрээг өргөжүүлэн Монгол Улсын ойн санг нэмэгдүүлэхэд хувь нэмрээ оруулах зорилгоор 108,000 шинэс модыг Сэлбэ



голын эх, Их баяны ам орчмын 40 га газар тарихаар төлөвлөн, мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллаж байна. Тус газар мод тарьснаар ойн экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалах, Сэлбэ голын эхийн ундарга сэргэх, улмаар Сэлбэ голын Туул голд цутгах урсац нэмэгдэх зэрэг олон талын ач холбогдолтой.

Нийгмийн эмзэг бүлэгт

ХААН Банк Сан нь нийгмийн эмзэг бүлэгт чиглэсэн 30 гаруй төсөл, хөтөлбөрийг төрийн болон ТББ-тай хамтран хэрэгжүүлж, 450 гаруй сая төгрөгөөр санхүүжүүлэн иргэд, бяцхан үрсийн амьдралд баяр баясгалан бэлэглэсэн байна.

"Лантуун дохио" ТББ-ын санаачилсан "Ид шидийн орон-2" төсөлд ХААН Банк хамт олноороо 100 хувь "Ид шидтэй ах, эгч" болж нийгэмд эерэг давалгаа үүсгэсэн төдийгүй харилцагчдаа болон бусад ААН байгууллагуудыг ч энэ аянд уриалсан юм. "Ид шидтэй ах, эгч" болсноор харилцагчид хуримтлалын үйлчилгээ ашиглан өөрийн сонгосон дүнгээр "Ид шидийн орон" хүүхэд хамгааллын төвийн багачуудад өдөр бүр хандив өргөх боломжийг бүрдүүлсэн юм.


Орон нутгийн хөгжлийг дэмжих

ХААН Банкны 3x3 сагсан бөмбөгийн талбай

2021 онд ХААН Банк үүсэн байгуулагдсан түүхт 30 жилийн ойгоо тохиолдуулан нийгмийн хариуцлагын хүрээнд 21 аймаг болон нийслэлийн 8 дүүрэгт нийт 33 байршилд 3x3 сагсан бөмбөгийн жишиг талбай байгуулж ашиглалтад оруулсан.



Дорноговь аймаг



Дархан-Уул аймаг

ХААН Банк компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд 2000-аад оноос Монголын соёл урлагийн салбарт олон шинэ санаачилга, төсөл хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлж ирсэн түүхтэй. 2007 оноос хойш дэргэдээ уран зургийн галерей нээсэн бөгөөд тус галерей нь 2017 оноос банкны төв оффис ХААН Банк цамхагийн 3-р давхарт байрлаж байна. ХААН галерей залуу уран бүтээлчдийн үзэсгэлэнг харилцагчид болон олон нийтэд сар бүр үнэ төлбөргүй хүргэдэг. Тус галерейн уран бүтээлийн сан хөмрөгт өдгөө 400 гаруй бүтээл бий.

Тогтвортой хөгжил

"2030" цахим товхимол

ХААН Банк Сангаас 2019 онд Тогтвортой хөгжил гэж юу болох, яагаад дэлхий нийтээрээ үүнд зайлшгүй анхаарах шаардлагатай тухай мэдлэг ойлголтыг олон нийтэд хүргэх, мэдээ мэдээлэл түгээх зорилгоор Upgrade вэбсайтаар хамтран тогтвортой хөгжлийн талаар онцолдог "2030" цахим товхимлыг бэлтгэн 14 хоног тутам уншигчдын хүртээл болгож эхэлсэн. Тус товхимол нь олон нийтэд хүрсэн цагаасаа хойш 4 жилийн хугацаанд нийт 7,500 гаруй тогтмол уншигчтай болоод байна.



162 5 2023



СЭХ
он 2023 сар 1 8
БҮРТГЭВ
№ 1



1.6.3.6. Тогтвортой хамтын ажиллагаа ба тайлагнал

Дотоодын хамтын ажиллагаа

ХААН Банк нь Тогтвортой хөгжлийн 17-р зорилго: “Хөгжлийн төлөөх түншлэл”-ийн хүрээнд тогтвортой хөгжилд манлайлж, уриалан хамтдаа өсөж дэвшихийг эрмэлзэхийн хэрээр олон байгууллага, нэгдлүүдтэй хамтран ажиллаж идэвхтэй гишүүн байж, бусдаас суралцаж, өөрийн сайн туршлагаа хуваалцан тогтвортой хөгжил, компанийн нийгмийн хариуцлагыг зохистой, зөв чиглэлд хөгжүүлэхэд үлгэрлэсээр ирсэн. Хамтын ажиллагааны хүрээнд дараах дотоодын байгууллагуудад идэвхтэй гишүүнчлэл, ил тод тайлагналтай хамтран ажиллаж байна. Үүнд:



Олон улсын хамтын ажиллагаа

ХААН Банк нь корреспондент банкны чиглэлээр олон улсын нэр хүнд бүхий 200 гаруй банк, хөрөнгө оруулалтын чиглэлээр олон улсын 20 гаруй банк санхүүгийн байгууллагуудтай байнгын хамтын ажиллагаатай ажилладаг.


Банк нь гадаадын 28 банкан дахь 49 ностро дансаар дамжуулан харилцагчдынхаа 13 төрлийн валютаар хийгдэх олон улсын төлбөр тооцоо, гадаад гүйлгээг найдвартай гүйцэтгэж байна. 2021 оноос ХААН Банк гадаад төлбөр тооцооны тасралтгүй ажиллагааг хангах зорилгоор олон улсын банкуудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлэн хөгжүүлэхийн сацуу технологийн бусад дэвшлийг ашиглан гадаад гүйлгээг түргэн шуурхай дамжуулах боломжийг судлан, нэвтрүүлэхээр ажиллалаа.

ХААН Банк нь олон улсын банк, санхүүгийн байгууллагуудтай нийт 200 сая гаруй ам.долларын худалдааны санхүүжилтийн эрхийн гэрээг гадаад худалдаа эрхлэгч аж ахуйн нэгж, харилцагчдынхаа гадаад худалдааны үйл ажиллагааг дэмжих зорилгоор байгуулсан. Ингэхдээ харилцагчдынхаа худалдааны онцлог, эргэлтэд тохирсон гадаад худалдаанд өргөнөөр ашиглагддаг төлбөр тооцооны хэрэгсэл, санхүүжилтийн үйлчилгээг Олон улсын худалдаа аж үйлдвэрийн танхимаас гаргасан UCP600, URDG, Incoterms 2020 зэрэг стандартын дагуу санал болгон хамтран ажиллаж байна. Харилцагчдын гадаад худалдааг санхүүжүүлэх, дэмжих хүрээнд олон улсын банк, санхүүгийн байгууллагууд, хөгжлийн төмөр олон улсын санхүүгийн корпораци (ОУСК), Азийн хөгжлийн банк (АХБ), Европын сэргээн босголт, хөгжлийн банк (ЕСБХБ) зэрэг байгууллагатай урт хугацаанд хамтран ажиллаж ирсэн. Уг хамтын ажиллагааны хүрээнд олон улсын шилдэг 800 гаруй банктai худалдааны санхүүжилтийн чиглэлээр хамтран ажиллах боломж бүрдэж буй. ХААН Банкны олон улсын мөргөшсөн

МОНГОЛ
ХААН БАНК
УК10009
P. Manzi

МОНГОЛЫН УЛАСЫН БАНК
MONGOLIAN STATE BANK
1115205447
20230482

2023 5 29/1



зэрэгтэй ажилтнууд болон банкны нийт ажилтнууд, гадаад худалдааны бизнес эрхлэгч харилцагчдаа худалдааны санхүүжилтийн мэргэжлийн зөвлөгөө, сургалтыг тогтмол зохион байгуулан ажиллаж байна.

Мөн тогтвортой хөгжлийн чиглэлд дараах олон улсын байгууллагуудтай идэвхтэй гишүүнчлэл, ил тод тайлагналтай хамтран ажиллаж байна. Үүнд:

- United Nations Global Compact
- Green Investment Principles

1.6.4. Үнэт цаас гаргагчийн хийсэн гэрээ хэлцлийн талаар

Өмгөөллийн “ХаанЛекс Партнерс ХХН” (цаашид “Хуулийн зөвлөх” гэх) нь 2023 оны 05 дугаар сарын 09-ний өдөр Банктай байгуулсан 820 тоот “Хууль зүйн зөвлөх үйлчилгээний гэрээ”-ний дагуу Банкны нийтэд нээлттэй ногоон бонд гаргахтай холбоотойгоор Банкны үйл ажиллагаанд хууль зүйн хувьд хөндлөнгийн дүн шинжилгээ хийж, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10.6-д заасны дагуу үнэт цаасны танилцуулгад тусгасан мэдээллийн үнэн зөв, хүчин төгөлдөр эсэх тухай хуулийн дүгнэлт бэлтгэсэн.

Өмгөөллийн “ХаанЛекс Партнерс ХХН” нь “Үнэт цаасны зах зээлийн тухай хууль”-ийн 10.5.7, СЗХ-ны “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 11.14.1 дахь заалтын дагуу өөрийн гаргасан хуулийн дүгнэлтийн 3.4 болон 3.5 дахь хэсэгт Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн гэрээ, хэлцэл болон сүүлийн 3 жилийн хугацаанд хийгдсэн их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй гэрээ, хэлцлийг хуульд заасан журмын дагуу байгуулагдсан эсэх талаар тус тус дүгнэсэн.

Хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн гэрээ, хэлцэл

Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн нь 8,604,891,000 төгрөг болно. Хуулийн дүгнэлт бэлтгэх өдрийн байдлаар хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий нийт 259 гэрээ Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд хүчин төгөлдөр үйлчилж байна. Банкны зээлийн гэрээ, барьцааны гэрээнүүд нь тодорхой батлагдсан загварын дагуу байгуулагддаг стандарт гэрээнүүд байх бөгөөд Банкны тухай хуулийн 7.2 дахь хэсэг болон Банкны Нууцын журмын дагуу Банк нь харилцагчдын мэдээллийн нууцлалыг хадгалах үүрэгтэй тул жишээ болгон ирүүлсэн Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий таван зээлийн гэрээг хянан үзвэл тэдгээр нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна. Тодруулбал:

- Банкны зүгээс өөрийн хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий дээрх зээлийн гэрээнүүдэд Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэгт заасан зээлийн гэрээнд заавал тусгах нөхцөлүүдийг бүрэн тусгасан ба хуульд заасан агуулгын болон хэлбэрийн шаардлагыг хангасан байна.
- Хуулийн зөвлөхийн зүгээс Үнэт цаас гаргагчийн ирүүлсэн зээлийн гэрээнүүд нь хууль тогтоомжид нийцсэн бөгөөд гэрээний аль нэг талын үүргийн зөрчил байхгүй тул гэрээний хэрэгжилт хэвийн, хууль тогтоомжид нийцсэн хэмээн дүгнэсэн.

Сонирхлын зөрчилтэй хэлцэл

Компанийн тухай хуулийн 89 дүгээр зүйлийн 89.1-д “Компанийн энгийн хувьцааны 20 буюу түүнээс дээш хувийг дангаараа, эсхүл түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа



2023 5 29



хувьцаа эзэмшигч, компанийн эрх бүхий албан тушаалтан, түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээд нь өөрийн ажиллаж байгаа болон хувьцааг нь эзэмшиж байгаа компанитай дор дурдсан харилцаанд орсон бол компанитай, эсхүл түүний хараат болон охин компанитай сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх этгээдэд тооцогдоно" гэж заасан. Банк нь сүүлийн 3 жилийн хугацаанд нийт 190 сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулсан.

Компанийн тухай хуулийн 89.3-т Компанийн тухай хуулийн 12 дугаар бүлэгт заасан сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулах журам үл хамаарах тодорхой нөхцөлүүдийг жагсаасан байдаг бөгөөд мөн хуулийн 89.4 дэх хэсэгт: "Хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувьцаа эзэмшигчдийн тоо нь 10-аас илүүгүй бол компанийн дүрэмд энэ хуулийн 89.3-т зааснаас бусад тохиолдлыг зааж болно." гэж заасан байдаг. Өөрөөр хэлбэл компани нь өөрийн үйл ажиллагааны онцлогоос хамааран сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулахдаа Компанийн тухай хуулийн 12 дугаар бүлэгт заасан журмыг баримтлахгүй байх тодорхой тохиолдлыг тусгайлан зааж болдог байна. Энэхүү хуулийн зохицуулалтын дагуу Банк нь дүрэмдээ сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулах журам үл хамаарах нэмэлт нөхцөлийг тусгасан байх ба дээрх сонирхлын зөрчилтэй гэрээ, хэлцлийг өөрийн дүрэмд заасан зохицуулалтын хүрээнд байгуулсан нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна гэж Хуулийн фирм дүгнэсэн.

Их хэмжээний хэлцэл

Компанийн тухай хуулийн 87 дугаар зүйлийн 87.1.1-д "Хэлцэл хийхийн өмнөх сүүлийн балансын активын нийт дүнгийн 25 хувиас дээш зах зээлийн үнэтэй эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг худалдах, худалдан авах, захиран зарцуулах болон барьцаалахтай холбогдсон хэлцэл, эсхүл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн хэлцэл /компанийн өдөр тутмын үндсэн үйл ажиллагаатай холбогдсон хэлцэл үүнд хамаарахгүй/", 87.1.2 дахь хэсэгт: "компанийн урьд гаргасан энгийн хувьцааны 25 хувиас дээш хэмжээний энгийн хувьцаа, энгийн хувьцаа авах эрхийн бичиг буюу энгийн хувьцаанд хөрвөх үнэт цаас гаргах, эсхүл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн гаргалтыг" их хэмжээний хэлцэлд тооцно гэж заасан.

Банк нь Хуулийн зөвлөхийн хууль зүйн дүгнэлт гаргах өдрийн байдлаар Компанийн тухай хуулийн 87 дугаар зүйлийн 87.1 дэх хэсэгт тодорхойлсон их хэмжээний хэлцлийг сүүлийн 3 жилийн хугацаанд байгуулаагүй байна.

Хавсралт №6. Дэлгэрэнгүйг хуулийн дүгнэлтээс үзнэ үү.

1.6.5. Үнэт цаас гаргагчийн бүртгэл, санхүүгийн тайлагнал, санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд, аудитын дүгнэлт

ХААН Банк нь нийт хөрөнгө, өөрийн хөрөнгө, зээлийн багцын хэмжээ, харилцагчаас татсан хадгаламжийн дүн, ашигт ажиллагаа зэрэг санхүүгийн үзүүлэлтээрээ салбартаа тэргүүлдэг.


Үүсэн байгуулагдсанаас хойш банкны санхүүгийн үзүүлэлтүүд тогтвортой өсөж ирсэн ба 2022 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар банкны нийт хөрөнгө 14.95 их наяд төгрөг, цэвэр зээлийн багц 7.41 их наяд төгрөг, нийт харилцагчдын харилцах, хадгаламж 10.93 их наяд төгрөг, өөрийн хөрөнгө хөрөнгө 1.52 их наяд төгрөг байна.

Жилийн эцсийн болон улирлын санхүүгийн тайлангаа Банк нь олон улсын нэр хүнд бүхий аудитын байгууллагаар баталгаажуулан санхүүгийн тайлангийн аудит хийлгэн ажиллаж байна.

Мөн Банкны тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1-д заасны дагуу хууль, журмын шаардлага хангасан улирлын санхүүгийн тайлан, аудитаар баталгаажуулсан жилийн эцсийн санхүүгийн тайланг хуулиар



2023 5 29



тодорхойлсон хугацаанд банкны вэбсайт дээр байршуулах болон өдөр тутмын сонин хэвлэлд нийтлүүлэн олон нийтэд мэдээлдэг.

Энэхүү үнэт цаасны танилцуулга болон хавсралтад 2020 оны 12 сарын 31-ний өдрөөр, 2021 оны 12 сарын 31-ний өдрөөр, 2022 оны 12 сарын 31-ний өдрөөр тус тус тасалбар болсон санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо болон бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайлангууд буюу сүүлийн 3 жилийн аудитлагдсан санхүүгийн мэдээллүүд багтсан.

1.6.5.1. Биет болон биет бус хөрөнгө, өөрийн хөрөнгө

Үндсэн хөрөнгө

Банкны үндсэн хөрөнгө 2022 оны байдлаар 455,494 сая төгрөг буюу нийт хөрөнгийн 3%-ийг эзэлж байна. (2021: 455,595 сая төгрөг буюу 3.4%, 2020: 465,928 сая төгрөг буюу 3.8%). Энэ нь Банкны тухай хуулийн 17-р зүйлд заасан зарим хязгаарлалт буюу Монгол банкнаас тогтоосон "Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлт тогтоох түүнд хяналт тавих журам"-д заасны дагуу Үндсэн хөрөнгийн хэмжээ нь нийт цэвэршүүлсэн активын 8%-иас хэтрэхгүй гэсэн шалгуур үзүүлэлтийг тогтмол ханган ажиллаж байна.

Банкны үндсэн хөрөнгөд барилга байгууламж, компьютер тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, тээврийн хэрэгсэл зэрэг багтдаг ба дийлэнх хэсгийг буюу нийт үндсэн хөрөнгийн 64% (2021: 62%, 2020: 59%)-ийг Банкны эзэмшиж буй барилга байгууламж эзэлж байна.

Сүүлийн 3 жилийн үндсэн хөрөнгөтэй холбоотой тоон мэдээллийг доорх хүснэгтэд харуулав.

Хүснэгт 22. Банкны эзэмшиж буй үндсэн хөрөнгө /үлдэгдэл өртгөөр/

	2022.12.31		2021.12.31		2020.12.31	
	Дүн	Эзлэх хувь %	Дүн	Эзлэх хувь %	Дүн	Эзлэх хувь %
Барилга байгууламж	289,811	63.7%	283,199	62.2%	273,611	58.7%
Компьютер, тоног төхөөрөмж	120,300	26.5%	120,338	26.4%	128,363	27.6%
Тавилга эд хогшил, тээврийн хэрэгсэл	38,145	8.3%	34,636	7.6%	35,912	7.7%
Дуусаагүй барилга	7,237	1.5%	17,422	3.8%	28,042	6.0%
Нийт	455,494	100%	455,595	100%	465,928	100%

Дэлхий нийтээр банк санхүүгийн байгууллага цахим буюу Дижитал шилжилт рүү шилжиж байгаа, мөн харилцагчдадаа банкны шинэ бүтээгдхүүн үйлчилгээг хүргэхтэй холбоотойгоор Банкны үндсэн хөрөнгөнд томоохон хэсгийг эзэлж буй компьютер, тоног төхөөрөмжийн хувьд сүүлийн жилүүдэд олон улсад стандартад нийцсэн, хүлээн зөвшөөрөгдсөн хөрөнгө оруулалтын шинэчлэлт өөрчлөлтийг тогтмол хийн сайжруулсаар байна.

Мөн оффисын барилгын хувьд Банк нь салбар нэгжүүдийн өнгө төрх, тохижилтыг сайжруулах, жигдрүүлэх болон ажилтнууд ба харилцагчдын тав тухтай байдлыг хангах зорилгын хүрээнд Банкны нэгжийн барилгын жишиг стандарт тогтоох төслийг 2017 оноос хэрэгжүүлсэн бөгөөд нэгжүүдийн барилгын стандарт тогтоож, шинээр баригдаж буй салбар нэгжийн барилгыг тухайн стандартын хүрээнд барьж байгуулах, хуучин барилга байгууламжид тогтоосон стандартын дагуу их засвар хийн, уг төслийг үе шатлалтайгаар хэрэгжүүлж байна.

2022 оны байдлаар Банкны хэмжээнд нийт 545 салбар, тооцооны төв үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд үүнээс дийлэнх нь буюу 398 нэгж нь өөрийн эзэмшлийн оффисын байранд, бусад нь түрээсийн байранд үйл ажиллагаагаа явуулж байна. Байршлын хувьд орон нутагт байрлалтай 103,579 сая



2023 5 29



төгрөгийн үлдэгдэл өртөг бүхий 375 барилга байгууламж, нийслэлд байрлалтай 185,642 сая төгрөгийн үлдэгдэл өртөг бүхий 23 барилга байгууламж буюу нийт 289,221 сая төгрөгийн үлдэгдэл өртөг бүхий 398 барилга байгууламж эзэмшиж байна. Үүнээс Төв банкны эзэмшилд 3 томоохон /ХААН Цамхаг, Сөүл оффис, Жуков оффис/ оффис байгаа бөгөөд эдгээр нь нийтдээ 161,893 сая төгрөгийн үлдэгдэл өртөгтэй байна.

Банк нь барилга байгууламжид таван жилд 1 удаа мэргэжлийн хөрөнгийн үнэлгээний байгууллагаар дахин үнэлгээ хийлгэдэг. Сүүлийн байдлаар 2020 онд Банкны нийт барилга байгууламжийг хөндлөнгийн үнэлгээний байгууллагаар дахин үнэлүүлж, үнэлгээг шинэчлэн тогтоосон байна.

Биет бус хөрөнгө

Банкны биет бус хөрөнгө 2022 оны байдлаар 46,286 сая төгрөг буюу нийт хөрөнгийн 0.31%-ийг эзэлж байна. (2021: 54,765 сая төгрөг буюу 0.41%, 2020: 50,719 сая төгрөг буюу 0.42%)

Сүүлийн 3 жилийн биет бус хөрөнгөтэй холбоотой тоон мэдээллийг доорх хүснэгтэд харуулав.

Хүснэгт 23. Банкны эзэмшиж буй биет бус хөрөнгө /үлдэгдэл өртгөөр/

	2022.12.31		2021.12.31		2020.12.31	
	Дүн	Эзлэх хувь %	Дүн	Эзлэх хувь %	Дүн	Эзлэх хувь %
Үндсэн систем	3,915	8%	3,606	6.6%	4,619	9.1%
Картын систем	3,883	8%	3,020	5.5%	3,373	6.6%
ОСН	8,509	18%	6,594	12.0%	7,715	15.2%
CRM	8,719	19%	9,068	16.6%	8,615	16.9%
Бусад	21,260	46%	32,477	59.3%	26,397	52.2%
Нийт	46,286	100%	54,765	100%	50,719	100%

Өөрийн хөрөнгө

Аудитын тайланд тусгаснаар 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Үнэт цаас гаргагчийн өөрийн хөрөнгө нь 1,515,366,066 мянган төгрөг байна. Үүнээс хувьцаат капитал 172,097,820 мянган төгрөг, бусад нөөц 74,511,460 мянган төгрөг, хуримтлагдсан ашиг 1,268,756,786 мянган төгрөг байна.

Сүүлийн 3 жилийн өөрийн хөрөнгөтэй холбоотой тоон мэдээллийг доорх хүснэгтэд харуулав.

Хүснэгт 24. Банкны өөрийн хөрөнгө /үлдэгдэл өртгөөр/

	2022.12.31		2021.12.31		2020.12.31	
	Дүн	Эзлэх хувь %	Дүн	Эзлэх хувь %	Дүн	Эзлэх хувь %
Энгийн хувьцаа	172,098	11.4%	172,098	13.4%	58,071	4.7%
Хуримтлагдсан ашиг	1,268,757	83.7%	1,018,134	79.3%	1,066,160	86.7%
Халаасны хувьцаа	-	-	-	-	(7,789)	-0.6%
Бусад нөөц	74,511	4.9%	94,279	7.3%	112,569	9.2%
Нийт	1,515,366	100%	1,284,510	100%	1,229,211	100%

1.6.5.2. Санхүүгийн байдлын тайлан

Хүснэгт 25. Санхүүгийн байдлын тайлан

2020.12.31





Хөрөнгө:

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	4,827,975,047	4,526,979,979	4,373,412,201
Монголбанканд заавал байлгах нөөц	743,335,598	809,081,732	969,104,827
Бусад банк ба санхүүгийн байгууллага дахь харилцах, хадгаламж	85,400,721	-	-
Өрийн хэлбэрээрх хөрөнгө оруулалт	843,275,948	909,001,481	1,474,096,564
Өмчийн хэлбэрээрх хөрөнгө оруулалт	3,148,784	3,157,209	4,267,181
Үүсмэл санхүүгийн хэрэглүүр	82,094,281	27,086,528	128,660,248
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	4,925,483,235	6,589,298,799	7,411,064,009
Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалт	301,888	301,888	283,589
Бусад хөрөнгө	76,142,085	78,094,830	76,361,443
Биет бус хөрөнгө	50,718,804	54,764,803	46,286,024
Ашиглах эрхтэй хөрөнгө	7,362,765	10,086,653	10,202,947
Үндсэн хөрөнгө	465,928,170	455,595,092	455,493,746
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө	-	-	3,480,567
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	12,111,167,326	13,463,448,994	14,952,713,346

Өр төлбөр:

Бусад банк, санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж	25,825,049	35,854,280	191,080,282
Репо хэлцэл	184,890,799	620,802,675	367,267,329
Харилцагчдын харилцах, хадгаламж	9,370,844,845	10,211,450,727	10,930,788,356
Үүсмэл санхүүгийн хэрэглүүр	206,964	319,756	4,896,897
Зээлээр авсан санхүүжилт	1,173,586,423	1,191,916,946	1,776,932,717
Орлогын татварын өр төлбөр	6,155,494	2,167,852	3,957,990
Хойшлогдсон татварын өр төлбөр	7,467,039	4,579,593	4,709,251
Түрээсийн өглөг	7,960,407	11,085,695	11,231,249
Бусад өр төлбөр	105,019,286	100,761,094	146,483,209
НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	10,881,956,306	12,178,938,618	13,437,347,280

Өөрийн хөрөнгө:

Энгийн хувьцаа	58,071,253	172,097,820	172,097,820
Халаасны хувьцаа	(7,589,226)	-	-
Хуримтлагдсан ашиг	1,066,159,570	1,018,133,731	1,268,756,786
Бусад нөөц	112,569,423	94,278,825	74,511,460
НИЙТ ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,229,211,020	1,284,510,376	1,515,366,066
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ӨӨРИЙН ХӨРӨНГӨ	12,111,167,326	13,463,448,994	14,952,713,346

1.6.5.3. Ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлан

Хүснэгт 26. Ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлан

	2020.12.31	2021.12.31	2022.12.31
Үр ашигт хүүгийн аргыг ашиглан тооцоолсон хүүгийн орлого	1,070,069,841	1,139,951,636	1,327,391,147
Бусад адилтгах хүүгийн орлого	18,944,624	38,817,302	39,974,535
Хүүгийн зардал	(652,572,667)	(548,305,638)	(475,870,927)




2023 5 29

Бусад адилтгах хүүгийн зардал	(3,980,834)	(1,886,344)	(5,213,387)
Хүүгийн цэвэр орлого	432,460,964	634,576,956	886,281,368
Зээлжих эрсдэлийн сангийн зардал	(65,171,210)	(87,813,455)	(143,514,238)
Зээлжих эрсдэлийн сангийн зардлын дараах хүүгийн цэвэр орлого	367,289,754	546,763,501	742,767,130
Хураамж, шимтгэлийн орлого	159,625,125	212,086,407	263,466,643
Хураамж, шимтгэлийн зардал	(26,985,959)	(35,934,290)	(47,787,841)
Хорогдуулсан өртгөөр хэмжигдэх бусад зээлийн эх үүсвэрийн өөрчлөлтөөс үүссэн олз	1,129,808	868,353	2,275,457
Үүсмэл санхүүгийн хэрэглүүрийн цэвэр олз/(гарз)	(4,224,878)	(202,377)	15,878,389
Гадаад валютын арилжааны олз	6,253,504	19,033,665	32,799,045
Гадаад валютын ханшийн өөрчлөлтийн цэвэр олз/(гарз)	12,172,561	(1,696,325)	6,574,939
Бусад дэлгэрэнгүй орлогоор бодит үнэ цэнийг хүлээн зөвшөөрөгдөх санхүүгийн хөрөнгийн борлуулалтаас үүссэн (гарз)/олз	7,607,050	2,252,900	(900,167)
Хорогдуулсан өртгөөр хэмжих санхүүгийн хөрөнгүүдийн өөрчлөлтөөс үүссэн гарз	-	-	(7,225,649)
Ашиг, алдагдлаар бодит үнэ цэнийг хэмжих санхүүгийн хөрөнгийн гарз	(7,200,519)	(8,771,737)	(9,019,495)
Үйл ажиллагааны бусад орлого	2,216,173	1,287,190	4,317,634
Үйл ажиллагааны бусад зардал	(303,443,469)	(348,177,182)	(412,043,205)
Бусад гарз, цэвэр дүнгээр	(3,299,867)	(951,022)	(269,656)
Татварын өмнөх ашиг	211,139,282	386,559,083	590,833,224
Орлогын албан татварын зардал	(49,920,000)	(95,030,000)	(142,061,025)
Тайлант жилийн ашиг	161,219,282	291,529,083	448,772,199
Бусад дэлгэрэнгүй орлого (татварын дараах):			
Ирээдүйд ашиг, алдагдалд дахин ангилагдах зүйлс:			
<i>Бусад дэлгэрэнгүй орлогоор бодит үнэ цэнийг хүлээн зөвшөөрөгдөх өрийн хэрэглүүр:</i>			
Дахин үнэлгээний гарз	2,783,720	(7,856,520)	(14,032,658)
Худалдан борлуулснаас ашиг, алдагдалд дахин ангилсан олз/(гарз)	(7,607,050)	(2,252,900)	900,167
Мөнгөн гүйлгээний хейджийн нөөц	9,766,765	(11,281,559)	(11,666,472)
Бусад дэлгэрэнгүй орлогод шууд бүртгэгдсэн орлогын татвар	(1,235,859)	5,347,744	6,199,740
<i>Ирээдүйд ашиг, алдагдалд дахин ангилагдахгүй зүйлс:</i>			
Бусад дэлгэрэнгүй орлогоор бодит үнэ цэнийг хүлээн зөвшөөрөх өмчийн хэрэглүүрийн дахин үнэлгээний олз	(10,531)	8,426	1,109,972
Бусад дэлгэрэнгүй орлогод шууд бүртгэгдсэн орлогын татвар	2,633	(2,106)	(277,492)
Барилгын дахин үнэлгээ	64,792,320		
Татварын дараах бусад дэлгэрэнгүй зардал	68,491,998	(16,036,915)	(17,766,743)
Тайлант жилийн татварын дараах нийт дэлгэрэнгүй орлого	229,711,280	275,492,168	431,005,456
Банкны эзэмшигчдэд хамаарах нэгж хувьцаанд ногдох суурь болон хорогдуулсан ашиг (төгрөгөөр илэрхийлсэн)	87		



2023 5 29

1.6.5.4. Мөнгөн гүйлгээний тайлан



	2020.12.31	2021.12.31	2022.12.31
(мянган төгрөг)			
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ			
Татварын өмнөх ашиг	211,139,282	386,559,083	590,833,224
Тохируулгууд:			
Үүсмэл санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн өөрчлөлт	4,224,878	202,377	(15,878,389)
Хүлээгдэж буй эрсдэлийн сангийн зардал	65,171,210	87,813,455	143,514,238
Өмчлөх бусад хөрөнгийн бодит үнэ цэнийн бууралтаас үүссэн (олз)/гарз	260,360	5,985	(78,812)
Үндсэн хөрөнгийн элэгдэл	52,901,548	54,368,851	54,489,263
Биет бус хөрөнгийн хорогдуулалт	10,897,441	17,703,043	20,643,564
Ашиглах эрхтэй хөрөнгийн элэгдэл	7,171,432	7,511,435	7,623,736
Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз	544,999	1,022,560	749,553
Биет бус хөрөнгө данснаас хассаны гарз	1,513	-	4,349,666
Үндсэн хөрөнгө борлуулсны (олз)/гарз	47,053	(10,038)	71,960
Барилгын дахин үнэлгээний цэвэр алдагдал	2,582,396	-	-
Бусад дэлгэрэнгүй орлогоор хэмжигдэх бодит үнэ цэнээр бүртгэгдэх санхүүгийн хөрөнгө борлуулсны гарз/(олз)	(7,607,050)	(2,252,900)	900,167
Хорогдуулсан өртгөөр хэмжигдэх санхүүгийн хөрөнгийн өөрчлөлтөөс үүссэн гарз	-	-	7,225,649
Ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр хэмжигдэх санхүүгийн хөрөнгөөс үүссэн гарз	7,200,519	8,771,737	9,019,495
Хорогдуулсан өртгөөр хэмжигдэх зээлийн эх үүсвэрийн өөрчлөлтөөс үүссэн олз	(1,129,808)	(868,353)	(2,275,457)
Гадаад валютын ханшийн өөрчлөлтийн (олз)/гарз	(12,172,561)	1,696,325	(6,574,939)
Хүүгийн орлого болон түүнтэй адилтгах орлого	(1,089,014,465)	(1,178,768,938)	(1,367,365,682)
Хүүгийн зардал болон түүнтэй адилтгах зардал	656,553,501	544,191,982	481,084,314
Үйл ажиллагааны хөрөнгө, өр төлбөрийн өөрчлөлтийн өмнөх үйл ажиллагаанд зарцуулсан мөнгөн гүйлгээ	(91,227,752)	(72,053,396)	(71,668,450)
Цэвэр өсөлт/бууралт:			
Монголбанканд байршуулсан заавал байлгах нөөц	2,383,836	(29,513,402)	(161,373,304)
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	(1,172,652,358)	(1,743,406,168)	(1,398,527,921)
Бусад банканд байршуулсан харилцах, хадгаламж	33,806,740	78,426,073	-
Бусад хөрөнгө	(36,921,583)	(17,272,770)	(4,430,702)
Ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрөгдөх өрийн хэлбэрээрх үнэт цаас	52,282,300	41,054,900	121,988,100
Цэвэр өсөлт/бууралт:			
Бусад банк, санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж	(56,299,183)	4,844,957	155,142,345
Харилцагчдын харилцах, хадгаламж	2,135,861,287	842,931,467	757,138,330
Бусад өр төлбөр	22,439,529	(45,352,148)	45,389,272

2023 5 29





Татвар болон хүүгийн зардлын өмнөх үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	889,672,816	(940,340,487)	(556,342,330)
Хүлээн авсан хүү	1,808,070,795	1,060,326,443	1,383,136,022
Төлсөн хүү	(683,444,792)	(577,579,548)	(482,696,702)
Орлогын албан татварын төлөлт	(53,290,039)	(96,559,450)	(134,218,981)
Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	1,961,008,780	(554,153,042)	209,878,009

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ГҮЙЛГЭЭ

Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалтыг борлуулсны орлого	-	-	18,299
Бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрөгдөх өрийн хэлбэрээрх үнэт цаасны худалдан авалт	(594,282,000)	(156,535,570)	(56,035,308)
Бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрөгдөх өрийн хэлбэрээрх үнэт цаас борлуулсны орлого	680,637,121	162,040,999	92,355,896
Хорогдуулсан өртгөөр хэмжигдэх өрийн хэлбэрээрх үнэт цаасны худалдан авалт	(553,364,959)	(329,784,384)	(467,570,524)
Хорогдуулсан өртгөөр хэмжигдэх өрийн хэлбэрээрх үнэт цаас борлуулсны орлого	399,286,356	316,125,709	281,893,933
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	310,906	693,349	1,717,306
Үндсэн хөрөнгийн худалдан авалт	(51,719,561)	(45,741,583)	(56,926,734)
Биет бус хөрөнгийн худалдан авалт	(20,346,106)	(21,749,042)	(16,514,451)

Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(139,478,243)	(74,950,522)	(221,061,583)
--	----------------------	---------------------	----------------------

САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ

Репо хэлцлээс орж ирсэн орлого	1,739,512,680	1,793,870,044	3,801,304,742
Репо хэлцлийн эргэн төлөлт	(1,751,978,104)	(1,330,383,814)	(4,071,420,232)
Бусад зээлийн эх үүсвэрээс орж ирсэн орлого	299,473,116	715,271,479	959,412,011
Бусад зээлийн эх үүсвэрийн эргэн төлөлт	(469,563,774)	(688,946,113)	(560,785,101)
Хоёрдогч өглөгийн эргэн төлөлт	(55,339,500)	-	-
Түрээсийн үндсэн өр төлбөрийн эргэн төлөлт	(6,944,925)	(7,110,035)	(7,633,424)
Төлсөн ногдол ашиг	-	(200,000,000)	(200,149,766)
Буцаан худалдан авсан хувьцаа	(193,996,404)	-	-

Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(438,836,911)	282,701,561	(79,271,770)
--	----------------------	--------------------	---------------------

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн ханшийн өөрчлөлтийн нөлөө	83,863,330	45,520,893	(62,181,031)
---	------------	------------	--------------

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн зээлжих эрсдэлийн сангийн зардал	201,921	(113,958)	(931,403)
--	---------	-----------	-----------

Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр бууралт/өсөлт	1,466,758,877	(300,995,068)	(153,567,778)
--	----------------------	----------------------	----------------------

Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	3,361,216,170	4,827,975,047	4,526,979,979
--	---------------	---------------	---------------

Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	4,827,975,047	4,526,979,979	4,373,412,201
--	----------------------	----------------------	----------------------

1.6.5.5. Өмчийн өөрчлөлтийн тайлан

Хувиар 28. Өмчийн өөрчлөлтийн тайлан



2023 5 29 1

	Энгийн хувьцаа	Халаасны хувьцаа	БДОБҮЦ-ээр хэмжигдэх үнэт цаасны дахин үнэлгээний нөөц	Мөнгөн гүйлгээний хейджийн нөөц	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан ашиг	Нийт
2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар	52,792,048	(2,183,728)	16,765,409	(534,066)	28,727,381	1,097,929,100	1,193,496,14
Тайлант жилийн ашиг	-	-	-	-	-	161,219,282	161,219,28
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	(3,625,397)	7,325,074	64,792,320	-	68,491,95
Нийт дэлгэрэнгүй орлого	-	-	(3,625,397)	7,325,074	64,792,320	161,219,282	229,711,27
Өмчид гарсан өөрчлөлт	5,279,205	(5,405,498)	-	-	-	(193,870,110)	(193,996,40
Хэрэгжсэн дахин үнэлгээний нөөц	-	-	-	-	(881,298)	881,298	
2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар	58,071,253	(7,589,226)	13,140,012	6,791,008	92,638,403	1,066,159,570	1,229,211,02
2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар	58,071,253	(7,589,226)	13,140,012	6,791,008	92,638,403	1,066,159,570	1,229,211,02
Тайлант жилийн ашиг	-	-	-	-	-	291,529,083	291,529,08
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	(7,575,746)	(8,461,169)	-	-	(16,036,91
Нийт дэлгэрэнгүй орлого	-	-	(7,575,746)	(8,461,169)	-	291,529,083	275,492,16
Халаасны хувьцааны цуцлалт	(7,589,226)	7,589,226	-	-	-	-	
Нэрлэсэн үнийн өсөлт	121,615,793	-	-	-	-	(141,808,605)	(20,192,81
Ногдол ашиг	-	-	-	-	-	(200,000,000)	(200,000,00
Хэрэгжсэн дахин үнэлгээний нөөц	-	-	-	-	(2,253,683)	2,253,683	
2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар	172,097,820	-	5,564,266	(1,670,161)	90,384,720	1,018,133,731	1,284,510,37
2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар	172,097,820	-	5,564,266	(1,670,161)	90,384,720	1,018,133,731	1,284,510,37
Тайлант жилийн ашиг	-	-	-	-	-	448,772,199	448,772,19
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	(9,016,889)	(8,749,854)	-	-	(17,766,74
Нийт дэлгэрэнгүй орлого	-	-	(9,016,889)	(8,749,854)	-	448,772,199	431,005,45
Ногдол ашиг	-	-	-	-	-	(200,149,766)	(200,149,76
Хэрэгжсэн дахин үнэлгээний нөөц	-	-	-	-	(2,000,622)	2,000,622	
2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар	172,097,820	-	(3,452,623)	(10,420,015)	88,384,098	1,268,756,786	1,515,366,06


1.6.5.6. Аудитын дүгнэлт

ХААН Банк нь 2000 оноос хойш жилийн эцсийн болон улирлын санхүүгийн тайлангаа олон улсын нэр хүнд бүхий аудитын байгууллагаар баталгаажуулан санхүүгийн тайлангийн аудит хийлгэн ажиллаж байна.

Дээрх 22 жилийн хугацаанд санхүүгийн тайланд томоохон залруулгагүй бөгөөд хөндлөнгийн аудитын байгууллагаас "Зөрчилгүй" цэвэр дүгнэлт авч ажилласан.



МЭГ С 29М
2023 06 09



Монгол Улсын Аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д "Аль нэг аудитын хуулийн этгээд нь нэг ААН, байгууллагад дараалсан таван жилээс илүү хугацаанд энэ хуулийн 9.1.1, 9.1.2, 9.1.3-т заасан аудитын үйлчилгээ үзүүлэхийг хориглоно" гэж заасны дагуу:

- 2011, 2012, 2013 онуудад 3 жилийн гэрээ "ПрайсуотерхаусКуперс Аудит" ХХК, МУ
- 2014, 2015, 2016 онуудад 3 жилийн гэрээ "АО ПрайсуотерхаусКуперс Аудит", ОХУ болон Мэдээлэл Аудит ХХК-ийн хамтарсан консорциум
- 2017, 2018, 2019 онуудад 3 жилийн болон 2020-2021 онуудад 2 жилийн нийт 5 жилийн аудит хийлгэх гэрээг "Эрнст энд Янг Монголия Аудит" ХХК
- 2022 онд 1 жилийн гэрээ "ПрайсуотерхаусКуперс Аудит" ХХК, МУ компаниудтай байгуулан, хамтран ажилласан.

Энэхүү үнэт цаасны танилцуулга болон хавсралтад тусгагдсан 2020-2022 оны санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо болон бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайланд "Эрнст энд Янг Монголия аудит" ХХК болон "ПрайсуотерхаусКуперс Аудит" ХХК нь аудит хийж гүйцэтгэсэн ба банкны санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт ("СТОУС")-ын дагуу материаллаг алдаагүй, бодитой толилуулсан байна гэж дүгнэсэн байна.

2021 оны 04 сарын 23-ны өдөр банктай байгуулсан EYMA/LOE-21/AC/MB/UA/KB/24 тоот аудитын үйлчилгээ үзүүлэх гэрээний хүрээнд ХААН Банкны 2021 оны 12 сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж, дүгнэлт гаргасан.

2022 оны 04 сарын 07-ны өдөр банктай байгуулсан Баталгаажуулалт-48030043-A027-2021 тоот аудитын үйлчилгээ үзүүлэх гэрээний хүрээнд ХААН Банкны 2022 оны 12 сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж, дүгнэлт гаргасан.

Хавсралт №3. Аудитын тайлан

1.6.5.7. Санхүүгийн шинжилгээ болон санхүүгийн харьцаа үзүүлэлтүүд

Хүснэгт 29. Сүүлийн 3 жилийн санхүүгийн харьцаа үзүүлэлтүүд

	2020	2021	2022
Активын өгөөж (1)	1.4%	2.3%	3.2%
Өөрийн хөрөнгийн өгөөж (2)	13.3%	23.2%	32.1%
Нийт ӨХ-ийн хүрэлцээ (3)	18.8%	15.6%	16.7%
1-р зэрэглэлийн ӨХ-ийн хүрэлцээ (4)	18.1%	15.6%	16.7%
Зээл/Депозит харьцаа (5)	49.2%	58.2%	60.1%
Хөрвөх чадварын харьцаа (6)	58.0%	47.4%	49.4%
Зардал орлогын харьцаа (7)	51.2%	41.5%	35.9%
Цэвэр хүүгийн орлогын маржин (8)	4.1%	5.2%	6.5%
Хүүгийн бус орлогын маржин (9)	12.1%	13.8%	16.0%
Чанаргүй зээл/Нийт зээл (10)	7.0%	5.7%	5.5%
Зээлийн эрсдэлийн сан/Нийт зээл (11)	7.1%	6.6%	7.5%
Зээлийн эрсдэлийн сан/Чанаргүй зээл (12)	101.9%	115.7%	134.7%



(1) Татварын дараах цэвэр ашгийг сүүлийн 2 жилийн эцсийн дундаж активын дүнд харьцуулан тооцсон.
 (2) Татварын дараах цэвэр ашиг/сүүлийн 2 жилийн эцсийн дундаж өөрийн хөрөнгийн дүн.



2023 5 29

- (3) Нийт өөрийн хөрөнгө/Эрсдэлээр жигнэсэн активын дүн.
Нийт өөрийн хөрөнгөд энгийн хувьцаа, нэмж төлөгдсөн капитал, хуримтлагдсан ашиг, нөвцийн сан болон бусад тохируулгууд.
- (4) Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө/Эрсдэлээр жигнэсэн активын дүн.
Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгөнд энгийн хувьцаа, нэмж төлөгдсөн капитал, хуримтлагдсан ашиг, Нөвцийн сан болон бусад тохируулгуудын нийлбэрээр тооцсон.
- (5) Нийт зээлийн багц/Нийт татан төвлөрүүлсэн хөрөнгө
Нийт ТТХ-д харилцагчдын харилцах, хадгаламж, зээлээр авсан санхүүжилт, бусад банк санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж, репо хэлцлүүд орсон.
- (6) Түргэн борлогдох активын дүн/Цэвэр өр төлбөрийн дүнд (Нийт ТТХ, бусад өр төлбөр болон тохируулга)
- (7) Тайлант хугацааны нийт үйл ажиллагааны зардлыг нийт үйл ажиллагааны орлогод хуваан тооцов. Нийт үйл ажиллагааны орлогыг цэвэр хүүгийн орлого болон хүүгийн бус орлогыг оруулан тооцсон.
- (8) Цэвэр хүүгийн орлого/Орлого олдог активын сүүлийн 2 жилийн эцсийн дундаж үлдэгдэл.
Орлого олдог активт харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа, мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө, бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэх өрийн хэрэглүүр, бусад банк санхүүгийн байгууллага дахь харилцах хадгаламж, ипотекийн зээлээр баталгаажсан бонд оруулж тооцсон.
- (9) Хүүгийн бус орлогын дүнг нийт орлогод харьцуулж тооцсон. Нийт орлогыг нийт хүүгийн орлого болон хүүгийн бус орлогыг оруулан тооцсон.
- (10) СТОУСтандартын чанарын ангиллын дагуу ангилагдсан Чанаргүй зээлийн багцыг Хорогдуулсан өртгөөр хэмжигдэх харилцагчдад олгосон зээл ба урьдчилсан нийт дансны дүнд харьцуулсан харьцаа.
- (11) Зээлийн эрсдэлийн санг Хорогдуулсан өртгөөр хэмжигдэх харилцагчдад олгосон зээл ба урьдчилгааны нийт дүнд харьцуулсан харьцаа.
- (12) Зээлийн эрсдэлийн санг СТОУСтандартын чанарын ангиллын дагуу ангилагдсан Чанаргүй зээлийн багцад харьцуулсан хувь.

Ашигт ажиллагаа

ХААН Банкны цэвэр ашиг сүүлийн 3 жилийн нийлмэл дунджаар 33%-иар өссөн үзүүлэлттэй байгаа бөгөөд 2020 онд 161.2 тэрбум төгрөг (-15.8%), 2021 онд 291.5 тэрбум төгрөг (+80.8%), 2022 онд 448.8 тэрбум төгрөг (+53.9%)-ийн тус тус ашигтай ажилласан.

Өөрийн хөрөнгийн өгөөж сүүлийн 3 жилд дунджаар 22.9%, активын өгөөж дунджаар 2.3% байсан бөгөөд 2022 оны эцсийн байдлаар өөрийн хөрөнгийн өгөөжийн үзүүлэлтээр системийн нөлөө бүхий банкуудаа тэргүүлж байна.

Хүснэгт 30. Сүүлийн 3 жилийн ашигт ажиллагааны үзүүлэлт

(сая төгрөг)



	2020		2021		2022	
	Дүн	Өсөлт	Дүн	Өсөлт	Дүн	Өсөлт
Хүүгийн цэвэр орлого	432,461.0	-2.0%	634,577.0	46.7%	886,281.4	39.7%
Шимтгэл хураамжийн цэвэр орлого	132,304.3	10.3%	176,152.1	33.1%	215,678.8	22.4%
Тайлант жилийн татварын дараах ашиг	161,219.3	-15.8%	291,529.1	80.8%	448,772.1	53.9%

2023 5 29





Зурдг 2. Ашигт ажиллагааны харьцаа үзүүлэлтүүд



Өсөлтийн үзүүлэлтүүд

ХААН Банкны актив хөрөнгө, зээл, татан төвлөрүүлсэн хөрөнгийн өсөлт тогтвортой, тасралтгүй өссөн үзүүлэлттэй байгаа бөгөөд сүүлийн 3 жилд ХААН Банкны актив жилд нийлмэл дунджаар³ 15.4% өсөн 2022 оны жилийн эцсийн байдлаар нийт актив 14.95 их наяд төгрөгт хүрсэн байна.

Нийт зээлийн үлдэгдэл энэ хугацаанд жилд нийлмэл дунджаар 17.3% өсөж, 8 их наяд төгрөгт хүрсэн бөгөөд түүхэн хугацаанд зээлийн багц нь хэрэглээний зээл дээр төвлөрөн өсөж байсан бол 2020, 2021 онуудад бизнесийн зээлийн өсөлт 46%-иас дээш байв.

Хүснэгт 31. Нийт зээлийн багцын мэдээлэл

(сая төгрөг)

Харилцагчийн сегмент	Жилийн эцсээр			2021/2020 Өөрчлөлт		2022/2021 Өөрчлөлт	
	2020	2021	2022	%	Дүн	%	Дүн
Бизнесийн зээл	2,725,301	3,978,648	4,111,717	46.0%	1,253,347	3.3%	298,124
Хэрэглээний зээл	2,151,282	2,445,045	3,159,939	13.7%	293,763	29.2%	549,839
Бусад зээл	413,440	593,944	706,112	43.7%	180,504	18.9%	112,168
Нийт	5,290,023	7,017,637	7,977,768	32.7%	1,727,613	13.7%	960,132

Нийт татан төвлөрүүлсэн хөрөнгө 2020-2022 онуудад жилд дунджаар 14.5% өссөн. Нийт ТТХ-ийн 82.4%-ийг харилцагчийн харилцах хадгаламж, 17.6%-ийг банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр, зээллэг тус тус бүрдүүлж байна.



Жилийн дундаж өсөлтийн хувийг нийлмэл дундаж буюу CAGR-р тооцсон.



2023 5 29/1




Харилцагчийн харилцах хадгаламж 2020 онд 29.8%, 2021 онд 9.0%, 2022 онд 7.0%-иар тус тус өссөн үзүүлэлттэй.

Хүснэгц 32. Нийт депозитын мэдээлэл

	Жилийн эцсээр			(сая төгрөг)	
	2020	2021	2022	2021/2020	2022/2021
				Өөрчлөлт	Өөрчлөлт
				%	%
Бусад банк, санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж	25,825	35,854	191,080	38.8%	432.9%
Репо хэлцэл	184,891	620,803	367,267	235.8%	-40.8%
Харилцагчдын харилцах, хадгаламж	9,370,845	10,211,451	10,930,788	9.0%	7.0%
Зээлээр авсан санхүүжилт	1,173,586	1,191,917	1,776,933	1.6%	49.1%
Нийт депозит	10,755,147	12,060,025	13,266,068	12.1%	10.0%

Зураг 3. Өсөлтийн динамик



1.6.6. Монголбанкны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг биелүүлж байгаа талаарх үзүүлэлтүүд

Арилжааны банк нь Банкны тухай хуульд заасан шалгуур үзүүлэлт хязгаарлалт мөн Монголбанкнаас баталж гаргасан зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн талаарх журмыг хангаж, үйл ажиллагаандаа мөрдөн биелүүлж ажиллах үүрэгтэй байдаг. Тухайлбал:

- Банкны тухай хуулийн 16 болон 17-р зүйлүүд;
- Монголбанкны Ерөнхийлөгчийн 2019 оны 02 сарын 12-ны өдрийн А-36 тоот тушаалаар батлагдсан "Банкны үйл ажиллагаанд хийх хязгаарлалтыг тооцох хангах, тайлагнах, хяналт тавих журам";



2023 5 29 1



• Монголбанкны Ерөнхийлөгчийн 2019 оны 05 сарын 23-ны өдрийн А-138 тоот тушаалаар батлагдсан "Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам";

• Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайдын хамтарсан 2019 оны 06 сарын 10-ны өдрийн А-155/134 тоот тушаалаар батлагдсан "Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам".

ХААН Банк нь дээрх хууль журамд заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийг тогтмол ханган ажиллаж байгаа ба сүүлийн 3 жилийн байдлаарх зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн биелэлт дараах байдалтай байна.

Хүснэгт 33. Өөрийн хөрөнгийн хүрэлцээний харьцаа үзүүлэлтүүд

№	Шалгуур үзүүлэлтүүд	Банкны ҮА-ны З/Х-ны журмын зүйл заалт	Шаардлага	2020 оны биелэлт	2021 оны биелэлт	2022 оны биелэлт
1	Хөшүүргийн харьцаа	2.5	>4%	8.96%	8.53%	9.32%
2	Өөрийн хөрөнгө болон эрсдэлээр жигнэсэн активын харьцаа	2.5	>12.0%	18.91%	15.60%	16.71%
3	Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө болон эрсдэлээр жигнэсэн активын зохистой харьцаа	2.5	>9.0%+4.0%	18.16%	15.60%	16.71%

Хүснэгт 34. Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцаа үзүүлэлт

№	Шалгуур үзүүлэлтүүд	Банкны ҮА-ны З/Х-ны журмын зүйл заалт	Шаардлага	2020 оны биелэлт	2021 оны биелэлт	2022 оны биелэлт
1	Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцаа	3.2	>25%	57.21%	46.87%	45.96%
2	Заавал байлгах нөөцийн хувь	ЗБНЖ; БТХ 16.1	>18.0% валютаар, >6.5% тегерегээр	11.63%	8.39%	11.68%

Хүснэгт 35. Гадаад валютын ханшийн эрсдэлийн зохистой харьцаа үзүүлэлтүүд


№	Шалгуур үзүүлэлтүүд	Банкны ҮА-ны З/Х-ны журмын зүйл заалт	Шаардлага	2020 оны биелэлт	2021 оны биелэлт	2022 оны биелэлт
1	Гадаад валютын нээлттэй позици болон өөрийн хөрөнгийн харьцаа (нэгж валютаар)	4.2	±15%>	-5.05%	-1.87%	2.82%
2	Гадаад валютын нээлттэй позици болон өөрийн хөрөнгийн харьцаа (нийт)	4.3	±30%>	-5.05%	-2.16%	2.95%

Хүснэгт 36. Төвлөрлийн эрсдэлийн харьцаа үзүүлэлтүүд

№	Шалгуур үзүүлэлтүүд	Банкны ҮА-ны З/Х-ны журмын зүйл заалт	Шаардлага	2020 оны биелэлт	2021 оны биелэлт	2022 оны биелэлт



2023 5 29



1	Хамгийн том 10 харилцах, хадгаламжийн нийлбэр нь нийт активын 25 хувиас хэтрэхгүй	5.3	<25%	7.40%	4.38%	8.87%
2	Томоохон зээлдэгч (ӨХ-ийн 5%-иас дээш)-дэд олгосон нийт активын нийлбэр/өөрийн хөрөнгөд эзлэх хувь	5.1	<300%	55.86%	25.88%	33.46%
3	Банкны үндсэн хөрөнгө нь нийт активын 8 хувиас хэтрэхгүй	5.2	<8%	3.83%	3.36%	3.09%
4	Банкнаас аливаа этгээд, түүнтэй холбогдох этгээд, харилцан хамаарал бүхий этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох актив хөрөнгө, баталгаа, батлан даалт, бусад хэлцлийн нийлбэр дүн нь өөрийн хөрөнгийн 20 хувиас хэтрэхгүй	5.6; БТХ 17.1	<20%	18.03%	8.00%	7.75%
5	Банкнаас гаргах баталгаа, батлан даалтын нийлбэр дүн нь тухайн банкны өөрийн хөрөнгийн хэмжээнээс илүүгүй байна	5.6; БТХ 17.2	-	12.84%	8.90%	5.59%
6	Банкны нэг холбогдох этгээдэд олгосон зээл/өөрийн хөрөнгөд эзлэх хувь	5.6; БТХ 17.3	<5%	3.92%	0.75%	3.32%
7	Банкны нийт холбогдох этгээдэд олгосон нийт зээл/өөрийн хөрөнгөд эзлэх хувь	5.6; БТХ 17.3	<20%	4.05%	0.88%	12.98%
8	БТХ-ийн 17.5-д зааснаас бусад тохиолдолд банкны худалдан авах үнэт цаасны нийт дүн нь банкны өөрийн хөрөнгийн 20 хувиас хэтэрч болохгүй	5.6; БТХ 17.4	<20%	2.62%	3.15%	11.79%
9	БТХ-ийн 17.5-д зааснаас бусад тохиолдолд банкны худалдан авах хувьцаа нь нэг компанийн гаргасан хувьцааны 10 хувиас дээшгүй байна	5.6; БТХ 17.4	<10%	10.00%	2.05%	2.05%
10	Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас худалдан авах нийт дүн банкны өөрийн хөрөнгийн 50 хувиас хэтэрч болохгүй	5.6; БТХ 17.5	<50%	8.53%	10.18%	18.39%

1.7. Ногоон бонд

1.7.1. Ногоон бондын тухай

Ногоон бонд нь цэвэр бохирдолгүй эдийн засгийг дэмжих, байгаль орчны хамгаалах, байгаль орчинд ээлтэй, тогтвортой төслүүдийг санхүүжүүлэхэд дэмжих зорилготой тогтмол орлоготой өөрийн хэрэгсэл билээ.

Тухайлбал, уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах, дасан зохицох, байгалийн нөөцийг хамгаалах, биологийн олон янз байдал, төрөл зүйлийг хамгаалах, бохирдлоос урьдчилан сэргийлэх, хянах зэрэг байгаль орчны зорилтуудад хувь нэмэр оруулахуйц төсөл, хөтөлбөрүүд ногоон бонд гаргах байдлаар шаардлагатай санхүүжилтийг татан төвлөрүүлэх боломжтой.



2023 5 29



Сааруулах үйл ажиллагаа



Дасан зохицох үйл ажиллагаа

Олон улсын зах зээлд ногоон бонд нь байгаль орчин, нийгмийн томоохон асуудлыг шийдвэрлэхэд хувь нэмэр оруулдаг тул хөрөнгө оруулалтын бусад хэрэгслүүдтэй харьцуулахад татвараас чөлөөлөх, хөнгөлөх зэрэг байдлаар хөрөнгө оруулагчдад хөрөнгө оруулах таатай нөхцөлийг бүрдүүлдэг. Дэлхийн банк нь 2008 онд хамгийн анхны мэргэжлийн хөрөнгө оруулагчдад зориулсан ногоон бондыг гаргасан.

1.7.2. Байгаль орчинд үзүүлж буй нөлөө

Олон улсад ногоон бонд нь эрчим хүчний хэмнэлттэй төслүүдийг санхүүжүүлэх үндсэн эх үүсвэр болж байна. 2022 оны 12 дугаар сард хэвлэгдсэн Economic Analysis and Policy номын “Enhancing green economic recovery through green bonds financing and energy efficiency investments” судалгаанд дурдсанаар ногоон бонд нь дэлхийн эдийн засгийн өсөлтийг 4.9 хувиар нэмэгдүүлсэн үзүүлэлттэй байгаа ба дэлхийн ирээдүйн эрчим хүчний хэрэгцээг хангахын тулд Зүүн өмнөд Азийн эрчим хүчний хэрэглээ нэмэгдэж буй асуудлыг шийдвэрлэх шаардлагатай гэж үзсэн. Үүнтэй холбоотойгоор Азийн улс орнууд ногоон бондыг эрх зүйн, зохицуулалтын орчныг бүрдүүлж, шинэчлэх, буцалтгүй тусламжийн хөтөлбөр хэрэгжүүлэх үйл явц эрчимжиж байна. Нөгөөтээгүүр, Европ тивийн ногоон бонд гаргагч улсууд болох Герман, Бельги, Их Британийн эрчим хүчний хэрэглээ 20 хувиар буурчээ.

Дэлхийн Банкнаас гаргасан 2021 оны нөлөөллийн тайланд дурдсанаар тогтвортой хөгжлийн зорилгод тулгуурласан нийт 723 төслийг хэрэгжүүлснээр 2.20×10^7 MWh / 7.92×10^{10} MJ эрчим хүч хэмнэж, жилд 5,464 ГВт.ц сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэл өргөжин тэлж, 3.5 сая т CO₂ экв. хүлэмжийн хийн ялгарлыг бууруулж, 450,000 хүн болон 10,000 бизнес эрхлэгчид санхүүгийн үйлчилгээгээр дамжуулан ашиг хүртэж, 3.4 сая хүний амьжиргааны түвшин сайжирсан үзүүлэлттэй байна.

2021 онд Ногоон бонд гаргасан улс орнуудын үр дүнгээс дурдвал, Перу улсад 31,674 газар тариаланч үйл ажиллагаандаа шинэ технологийг нэвтрүүлж, Хятад улс 102,497 га талбайд шинэ ус зарцуулж

2023 5 29М





байгууламжийг барьж, Молдав улсад 95,063 иргэн эрчим хүчний хэмнэлттэйгээр хоол хийх боломж бүрдүүлснээр жилд 195,697 М.ГВ эрчим хүч хэмнэх, Колумб улсад жилийн нарийн тоосонцор ялгаруулалтын хэмжээг 7.64 тн хэмжээгээр бууруулж чаджээ.

1.7.3. Олон улсын тогтвортой хөгжлийн чиг хандлага

1.7.3.1. НҮБ-аас авч хэрэгжүүлж буй бодлого, баримтлал

Нэгдсэн Үндэсний Байгууллага (НҮБ)-аас 2015 онд байгаль орчны тогтвортой байдал, нийгмийн оролцоог хангахад чиглэсэн тогтвортой хөгжлийн зорилгуудыг баталсан. Тухайлбал, 2030 он гэхэд ядуурлыг арилгах, өлсгөлөнг зогсоох, эрүүл мэнд болон чанартай боловсролыг дэмжих, хүйсийн эрх тэгш байдлыг хангах, баталгаат ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангах, сэргээгдэх эрчим хүчийг нэвтрүүлэх, эдийн засгийн өсөлт, баталгаат хөдөлмөрийн зах зээлийг бий болгох, инноваци болон дэд бүтцийг нэмэгдүүлэх, тэгш бус байдлыг бууруулах, ээлтэй хот, иргэдийн оролцоог дэмжих, уур амьсгалын өөрчлөлтийн үр нөлөөг багасгах, далай тэнгисийн нөөц болон хуурай газрын эко системийг хамгаалах, энх тайван, шударга ёсыг бий болгох, хөгжлийн төлөөх түншлэлийг бэхжүүлэх зэрэг тогтвортой хөгжлийн зорилгуудыг тавин ажиллаж байна.

НҮБ-д нэгдсэн улс орнууд хөгжлийнхөө явцад "тогтвортой хөгжил"-ийг баримталж, дэлхийн агаарын дундаж температурын хувьд аж үйлдвэрийн хувьсал бий болсон XIX зууны дунд үед байсан түвшнээс нэмэгдэх дулааны хэмжээг цельсийн 2 хэмээс давахгүй байх зорилготойгоор 2015 онд Парист цугларсан 196 улс гүрний төлөөлөгчид хэлэлцэн, уг Парисын хэлэлцээр дэмжигдсэн.

2015 оны талуудын 21 дүгээр бага хурлын өмнө энэхүү хэлэлцээрт нэгдэх сонирхол бүхий улс орнууд уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах зорилготой үндэсний зорилтот хувь нэмэр буюу Intended Nationally Determined Contributions бичиг баримтыг боловсруулж, НҮБ-ын Конвенцийн нарийн бичгийн дарга нарын газарт хүргүүлснээр улс орон бүр баримт бичигт тусгагдсан зорилтуудад хүрэхээр ажиллаж байна.

1.7.3.2. Олон улсын банк санхүүгийн байгууллагуудын оролцоо

Ногоон бонд гаргаж буй үнэт цаас гаргагчдыг байгууллагын төрлөөр харгалзан үзэхэд 2022 оны жилийн эцсийн байдлаар дийлэнх буюу 28.69 хувийг санхүүгийн байгууллага, 25.26 хувь нь санхүүгийн бус байгууллага, 18.64 хувь нь засгийн газрын дэмжлэгтэй байгууллага, 16.57 хувь нь бүрэн эрхт байгууллага, 8.98 хувь нь хөгжлийн банк, 1.84 хувийг орон нутгийн захиргаа байна.


График 2. Ногоон бонд гаргасан байгууллагуудын төрөл /тэрбум ам.доллар/



Эх сурвалж: Sustainable Debt Global State of the Market 2022, Climate Bonds Initiative

2023 5 29.1





Ази, Номхон далайн бүс дэх ногоон бонд гаргагчдын тоо өсөх төлөвтэй байна. 2022 оны жилийн эцсийн байдлаар Хятад улс 332 хэлцлийн хүрээнд 85.4 тэрбум ам. доллар, Япон улс 69 хэлцлийн хүрээнд 12.6 тэрбум ам. доллар, Өмнөд Солонгос 30 хэлцлийн хүрээнд 7.9 тэрбум ам.долларын санхүүжилтийг тус тус татан төвлөрүүлжээ. Хятад улсын хувьд нийт татан төвлөрүүлсэн хөрөнгийн 15 хувь буюу 12.8 тэрбум ам.доллар бүхий 10 хэлцлийг Хятадын банк (Bank of China), 9.13 хувь буюу 7.8 тэрбум ам.доллар бүхий 6 хэлцлийг Хятадын хөгжлийн банк (China Development Bank)-тай хийсэн үзүүлэлттэй байна. Мөн China Three Gorges Corporation нь 6.67 хувь буюу 5.1 тэрбум ам.долларын 14 хэлцлийг тус тус гүйцэтгэжээ.

2022 онд хувийн хэвшлийн компаниуд ногоон зах зээлийг их дэмжсэн бөгөөд санхүүгийн байгууллагууд хамгийн их хувь нэмэр оруулсныг 2022 оны дэлхийн тогтвортой зээлийн судалгаанд дурдсан байна.

Европ тивийн хувьд 2022 оны чухал нөлөө бүхий ногоон бондын хэлцэл болох 5.2 тэрбум ам.доллар бүхий 45 хэлцлийг Германы арилжааны Хелеба банк (German commercial bank Heleba), 4 тэрбум ам.доллар бүхий 6 хэлцлийг Данийн үндэстэн дамнасан эрчим хүчний Orsted компани (Danish multinational power compnay Orsted)-тай тус тус хийжээ.

Хүснэгт 37. 2022 оны дэлхийн зах зээлд гаргасан топ 10 ногоон бондын үнэт цаас гаргагч /хувийн хэвшил/

Үнэт цаас гаргагч	2022	
	Татан төвлөрүүлсэн дүн (тэрбум ам.доллар)	Хэлцлийн тоо
China Three Gorges Corporation	5.1	14
Orsted	4	6
Iberdrola	3.1	4
Honda Motor Company	2.8	3
Volkswagen	2.6	3
E.ON	2.6	3
EDP	2.4	3
General Motors	2.3	2
RWE	2.1	1
Huaneng Lancang River Hydropower	2	16

Эх сурвалж: Sustainable Debt Global State of the Market 2022, Climate Bonds Initiative

Дэлхий дахинд тулгарч буй байгаль орчин, нийгмийн сорилтуудыг шийдвэрлэж, 2030 онд тогтвортой хөгжлийн зорилтуудад хүрэхэд жилд 5-7 их наяд ам. долларын санхүүжилт шаардлагатай гэж НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс (United Nations Development Programme) үзсэн. Одоогийн олон улсын хөрөнгө оруулалтын боломжит хэмжээ нь 200 их наяд ам.долларт хүрсэн гэх урьдчилсан тооцоолол гарсан хэдий ч Парисын хэлэлцээрийн хүрээнд дэх уур амьсгалын болон тогтвортой хөгжлийн зорилгуудад хүрч чадахааргүй нөхцөл байдалтай байна. Иймд олон улсын байгууллагуудын оролцоо, санхүүжилтийн хэрэгцээ ихээхэн шаардлагатай.

Байгаль орчны тогтвортой байдал, нийгмийн оролцоог хангахад чиглэсэн тогтвортой хөгжлийн зорилгуудыг хэрэгжүүлэхэд хувь нэмрээ оруулж буй дараах олон улсын сан, хөтөлбөрүүд байна. Үүнд:

- Good Fashion Fund (GFF) – Нидерландын засгийн газар, Ази тивийн текстиль болон бэлэн хувцасны салбарт өөрчлөлтийг бий болгох, байгальд ээлтэй технологи, тоног-технооромжийг худалдан авах;



Ширхэгээр хийсэн материал
УКН0009



2023 5 29 17

- Adaptation fund (AF) буюу Дасан зохицох сан – НҮБ-ийн суурь конвенц, Уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөнд өртөмтгий улс орнуудад дасан зохицох үйл ажиллагааг дэмжих;
- Agri-Business Capital (ABC fund) – Хөдөө аж ахуйн хөгжлийн сан (IFAD), Жижиг дунд үйлдвэрлэлийн хөдөө аж ахуй болон бичил фермүүдийг дэмжих;
- Ази тивийн хувийн хэвшлийг дэмжих Канадын уур амьсгалын II сан – Канадын засгийн газар, Ази, Номхон далайн жижиг арлын хөгжиж буй орнуудын уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах болон дасан зохицох үйл ажиллагаа явуулахад хувийн хэвшлийн компанийг оролцуулах;
- Уур амьсгал ба хөгжлийн төлөөх Нидерландын сан (DFCD) – Нидерландын засгийн газар, Хөгжиж буй орнуудын уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах болон дасан зохицох чиглэлийн төслүүдийг санхүүжүүлэх;
- Хөдөө аж ахуйн хөгжлийн олон улсын сан (IFAD) – НҮБ-ын хүнс, хөдөө аж ахуйн төв бөгөөд олон улсын санхүүгийн байгууллага, Хөдөө орон нутагт хүнсний аюулгүй байдлыг сайжруулах, хүнсний тэжээллэг байдлыг нэмэгдүүлэх;
- Дэлхийн байгаль орчны сан (GEF) - Байгаль орчинд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх;
- Үндэсний онцлог тохирсон сааруулах арга хэмжээний сан (NAMA FACILITY) - Германы байгаль орчны хамгаалал, цөмийн аюулгүй байдлын яам (BMU), Их Британийн Бизнес, эрчим хүч, аж үйлдвэрийн стратегийн газар (BEIS), Нөгжиж буй орнуудын богино болон дунд хугацааны уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэхэд нь санхүүгийн дэмжлэг үзүүлэх;
- Switch-Asia хөтөлбөр - Тогтвортой хэрэглээ, үйлдвэрлэлийг (SCP) дэмжих зорилт;
- Азийн хөгжлийн банкны хувийн хэвшлийн санхүүжилт (ADB private sector financing) – Азийн хөгжлийн банк, Байгаль орчинд ээлтэй, хүртээмжтэй эдийн засгийн өсөлтийг дэмжих, санхүүгийн таатай өгөөжийг бий болгох.

Эх сурвалж: Монголын ногоон санхүүжилтийн эх үүсвэрийн судалгаа, ТоС (2022)

1.7.4. Ногоон бондын зах зээлийн орчин

Олон улсад уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг буюу нүүрстөрөгч бага, хүлэмжийн хий ялгаруулалтыг бууруулах, уур амьсгалд тэсвэртэй төслүүдийн шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлэхэд хөрөнгө оруулагчид дэмжиж, хамтран ажиллаж байна.

Climate Bonds Initiative-с гаргасан 2022 оны дэлхийн тогтвортой зээлийн судалгаанд дурдсанаар дэлхий даяар нийт 3.7 их наяд ам.долларын green, social, transition, SLB and sustainability бондууд бүртгэгдсэн байна. Үүнээс 2.2 их наяд ам.доллар бүхий нийт 85 улсын 2,457 үнэт цаас гаргагчийн ногоон бонд бүртгэгджээ.

2021 оны нийт ногоон бонд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 92 хувиар өсжээ. Тухайлбал, Ковид-19 цар тахлын дараах эдийн засгийн хямралыг нөхөн сэргээх, эдийн засгийн өсөлтийг дэмжих, санхүүжилтийг нэмэгдүүлэх зорилготойгоор ногоон бонд гаргах тоо нэмэгдсэн.

2022 онд Орос-Украины зөрчилдөөнөөс шалтгаалан эрчим хүчний үнэ болон инфляцийн өсөлт нь хүүгийн түвшинг нэмэгдүүлэх томоохон хүчин зүйл болсон. Иймд 2022 оны бондын үзүүлэлт 2021 оны мөн үетэй харьцуулахад харьцангуй бага байна. Тухайлбал, Ногоон бондын хувьд 2021 онд 62 улсын 976 үнэт цаас гаргагчийн 582.4 тэрбум ам.доллар бүхий бонд бүртгэгдсэн бол 2022 онд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 16.36 хувийн бууралттай буюу 51 улсын 741 үнэт цаас гаргагчийн 487.1 тэрбум ам.долларын бонд бүртгэгджээ.





График 3. Ногоон бонд гаргалт бүс нутгаар /тэрбум ам.доллар/




Эх сурвалж: Sustainable Debt Global State of the Market 2022, Climate Bonds Initiative

Ногоон бондын эрэлт ба зарцуулалт

2022 оны дэлхийн тогтвортой зээлийн судалгаанд дурдсанаар ногоон бондын эрэлт нийлүүлэлтээсээ давсан үзүүлэлттэй байна. Энэ нь хөрөнгө оруулагчид нийгмийн хариуцлагынхаа хүрээнд ногоон болон бусад social, sustainability, transation, SLB бондуудад хөрөнгө оруулах хандлага нэмэгдэж буйг илтгэнэ.

Дэлхийн томоохон улс орнууд ногоон бонд гаргах замаар уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг сэргээгдэх эрчим хүч, ногоон устөрөгч бүхий технологийг нэмэгдүүлэхэд ихээхэн хөрөнгө зарцуулж байна.

График 4. Хөрөнгийн зарцуулж буй салбарууд



Эх сурвалж: Sustainable Debt Global State of the Market 2022, Climate Bonds Initiative



2023 5 29.1

1.7.5. Монгол улсын эдийн засгийн орчин, тогтвортой хөгжил


1.7.5.1. Макро эдийн засгийн орчин

Дотоодын нийт бүтээгдэхүүн

Монгол улсын бодит ДНБ 2009-2019 оны хооронд 10 жил тасралтгүй өссөн бөгөөд 2019 онд 37.8 их наяд төгрөгт хүрсэн. Гэвч 2020 онд Ковид-19 цар тахлын нөлөөгөөр дэлхий дахинд түүхий эдийн эрэлт эрс буурч үнэ нь огцом унасан, улс орны хэмжээнд тогтоосон хөл хорио, ялангуяа БНХАУ-тай хилээ хаасан нь Монгол Улсын эдийн засгийн өсөлт удаашрах гол шалтгаан болов.

2022 онд Азийн хөгжлийн банк, ОУВС, Дэлхийн банк зэрэг олон улсын байгууллагуудаас Монгол улсын эдийн засгийн өсөлтийг дунджаар 5.9 хувьтай байхаар таамагласан бөгөөд 2022 оны жилийн эцсийн байдлаар бодит ДНБ 52.9 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 4.8 хувиар өсжээ.

График 5. Дотоодын нийт бүтээгдэхүүн /их наяд төгрөг/



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Хүснэгт 38. Монгол Улсын эдийн засгийн өсөлтийн төлөв

Байгууллага	Шинэчилсэн огноо	2023Т	2024Т	2025Т	2026Т
Дэлхийн банк	2023.01	5.3%	6.4%		
ОУВС	2022.10	5.0%	7.0%	6%	5.5%
АХБ	2022.09	4.9%			
Дундаж		5.0%	6.7%		

Олон улсын шинжээчдийн таамаглалаар 2023 онд Монгол Улсын эдийн засаг дунджаар 5.0 хувиар өсөх хүлээлттэй байна.



2023 5 29

Гадаад сектор

График 6. Гадаад худалдааны тэнцэл /ам.доллар/
 2023.05.13 өдөр
 БҮРТГЭВ
 № 11
 12,000



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

2022 оны гүйцэтгэлээр гадаад худалдааны нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 3,220.6 сая ам.доллар буюу 24.9 хувиар өссөн.⁵ Үүнд экспорт 1,670.79 сая ам.доллараар буюу 22.0 хувиар, импорт 1,549.69 сая ам.доллараар буюу 29.0 хувиар өссөн үзүүлэлт нөлөөлжээ.

Улсын төсөв

Улсын төсөв сүүлийн 10 жилийн хугацаанд алдагдалтай ажилласнаас шалтгаалан өр хуримтлагдаж улмаар уул уурхай олборлох салбарын хөрөнгийн урсгалаас Монгол улсын эдийн засаг ихээхэн хамааралтай болсон. Мөн сүүлийн жилүүдийн төсвийн зардлын дийлэнх хэсгийг урсгал зардал эзэлж байна.

Улсын нэгдсэн төсвийн нийт орлого, тусламжийн хэмжээ 2022 оны урьдчилсан гүйцэтгэлээр 18.59 их наяд төгрөг болж, өмнөх оноос 4.3 их наяд төгрөг буюу 30.7 хувиар, тэнцвэржүүлсэн орлого тусламжийн хэмжээ 17.2 их наяд төгрөг болж, өмнөх оноос 4.5 их наяд төгрөгөөр буюу 35.5 хувиар тус тус өсжээ.

Хүснэгт 39. Улсын төсвийн гүйцэтгэл болон батлагдсан төсөв

Үзүүлэлт, (тэрбум төгрөгөөр)	2022		2021		2020
	Гүйцэтгэл	Батлагдсан	Гүйцэтгэл	Батлагдсан	Гүйцэтгэл
Нийт орлого	18,593.14	16,706.22	14,255.20	13,731.70	10,402.00
Ирээдүйн өв сан	0	0	937.9		914.1
Тогтворжуулалтын сан	1,394.62	751.71	627.9		66.2
Тэнцвэржүүлсэн орлого	17,198.51	15,954.50	12,689.40	12,056.50	9,421.60
Татварын орлого	15,568.31	13,857.59	11,262.80		8,501.80
Татварын бус орлого	1,630.21	2,096.91	1,426.60		919.9
Нийт зардал	18,177.80	18,833.83	15,598.10	15,748.30	13,960.80
Урсгал зардал	14,212.17	14,822.99	12,754.40		10,871.60

УЛААНБААТ 8,501.80
 МХБ-ийн гишүүн
 Б. Дорнод
 Брокер, дилерийн
 "БИДИ" ХХК
 1115012440082

www.1212.mn
 БОНДЫН ТАНИЛЦУУЛГА
 БАНК

2023 5 29

Хөрөнгийн зардал	3,813.13	4,258.88	3,047.00		
Цэвэр зээл	152.51	-248.04		-351.1	37.6
Тэнцвэржүүлсэн тэнцэл	-979.29	-2,879.32	-3,691.80	-2,908.80	-4,539.10

2023-06-09
БҮРТГЭВ
№

Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлогын хэмжээг 19.49 их наяд төгрөг буюу ДНБ-ий 34.9 хувь, нийт зарлагын хэмжээг 20.5 их наяд төгрөг буюу 37.6 хувь, төсвийн алдагдлыг 1.43 их наяд төгрөг буюу ДНБ-ийн 2.6 хувьтай тэнцүү байхаар төлөвлөжээ.

Хөрөнгийн зах зээлийн үнэлгээ ба хөрвөх чадвар

График 7. Зах зээлийн үнэлгээ /их наяд төгрөг/ ба ТОП 20



2021 онд хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 6.0 их наяд төгрөгт хүрч, 2020 оны жилийн эцсийн үзүүлэлтээс 97.5 хувиар өссөн. Энэхүү өсөлтөд ТОП-20 индекс 2021 оны эхэн үеэс эхлэн хурдацтай өссөөр 2021 оны 9 сард түүхэн дээд дүн болох 49,252 нэгжид хүрсэн нь голчлон нөлөөлсөн.

2022 оны жилийн эцсийн байдлаар ТОП-20 индекс 37,565.55 болж өмнөх оны мөн үеэс 15.4 хувиар буурсан. Хөрөнгийн зах зээлийн үнэлгээ өмнөх оноос 15.2 хувиар өсөж 6.9 их наяд төгрөгт хүрсэн ба Банкны реформын хүрээнд Голомт банк ХК, Төрийн банк ХК болон төрийн өмчит компаниудын хувьчлалын хүрээнд Монголын Хөрөнгийн бирж зэрэг томоохон компаниуд хувьцаагаа нийтэд санал болгосон нь зах зээлийн үнэлгээ нэмэгдэхэд голчлон нөлөөлжээ.

Хөрөнгийн зах зээлийн арилжаа

График 8. Хөрөнгийн зах зээлийн арилжаа /тэрбум төгрөг/



МОНГОЛ УЛС
ХААН БАНК ХХК
УКИ0003

УЛААНБААТАР ХОТ
МХБ-ийн Гашуун
Андерраптер
Брокер дилерийн
"БНДСЕК"
ҮЙС ХК
ХБУЦ
11152-347

2023 5 29 17

2022 оны нийт арилжааны 22.5 хувийг компанийн бонд, 2.3 хувийг хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх, 17.5 хувийг хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, 57.7 хувийг хувьцааны арилжаа тус тус эзэлж байна⁶.

1.7.5.2. Ногоон бондын хэрэгцээ, шаардлага

Уур амьсгалын өөрчлөлт

Сүүлийн 80 гаруй жилийн хугацаанд Монгол Улсын агаарын дундаж температур 2.25 цельсээр нэмэгдсэн нь дэлхийн дундаж өөрчлөлттэй харьцуулахад өндөр үзүүлэлт бөгөөд дулааны улиралд орох хур тунадасны хэмжээ буурч хуурайших хандлагатай байна. Энэ нь уур амьсгалын өөрчлөлттэй холбоотойгоор байгалийн гамшигт үзэгдлүүдийн давтамжийг нэмэгдүүлэх нөхцөл бүрдэж, эдийн засаг, санхүүгийн системд эрсдэл үүсгэж болзошгүй байна.

Монгол Улсын хүлэмжийн хийн ялгарлын хэмжээ дэлхийн нийт хүлэмжийн хийд 0.09 хувийг эзлэх хэдий ч нэг хүнд ноогдох хүлэмжийн хийн ялгарал нь дэлхийн дундаж хэмжээнээс 2.7 дахин их байна.

Үндэсний хөгжлийн явцтай уялдуулан хүлэмжийн хийн ялгарлыг 2010-2030 оны байдлаарх урьдчилсан тооцоололд 2010 онд хүлэмжийн хийн ялгарал 25.8 сая т CO₂-эquiv-аас 2030 онд 74.2 сая т CO₂-эquiv болж 2.76 дахин өсөх төлөвтэй. Энэхүү өсөлтөд хөдөө аж ахуй, эрчим хүчний салбарын ялгарал нөлөөлөх ба аж үйлдвэрийн салбарын эзлэх хувийн жин 4.1 хувиас 16.6 хувь хүртэл болж өсөхөөр байна.

График 9. Монгол Улсын нүүрсхүчлil болон хүлэмжийн хий ялгаруулалт



Эх сурвалж: Дэлхийн агаар мандлын судалгааны ялгарлын мэдээллийн сан

Олон улсын валютын сангийн удирдах зөвлөлийн 21/251 дугаар бүхий Монгол улсад зориулсан тайлан, үнэлгээнд дурдсанаар Монгол улсыг тогтвортой, хүртээмжтэй, ногоон хөгжилд суурилсан урт хугацааны хөгжлийн төлөвлөгөөг боловсруулах шаардлагатай гэж үзсэн. Тухайлбал, тайлангийн эрсдэлийн үнэлгээний матрицад цаг уурын ноцтой үзэгдлүүдийг санхүүгийн системд дунд зэргийн эрсдэлтэй хэмээн авч үзсэн бөгөөд цаг уурын тодорхойгүй байдал, температурын өсөлт, байгалийн гамшигт үзэгдэл зэрэг нь газрын доройтлыг бий болгож, мал аж ахуйн салбарт ноцтой эрсдэлүүд үүсэж, нийгэм эдийн засгийн зардал өсөх, тогтвортой хөгжлийн үйл явц удаашрах эрсдэлтэй болохыг дурдсан байна. Иймд хөдөө аж ахуйн салбарыг бүтээмжтэй, уур амьсгалын өөрчлөлт болон өндөр температурт тэсвэртэй болгох, малын тоо толгойг бэлчээрийн даацад тохируулах шаардлагатай.



СЗХ Санхүүгийн салбарын тойм, 2022

БОНДЫН ТАНИЛЦУУЛГА



2023 5 29 1

1.7.5.3. Тогтвортой хөгжлийн санхүүжилтийн хэрэгцээ

НҮБ-аас гаргасан тогтвортой хөгжлийн зорилгуудыг Монгол Улс 2021-2030 оны хооронд биелүүлэхийн тулд 280 их наяд төгрөг, мөн тогтвортой хөгжлийг хадгалах, нэмэгдүүлэхэд 2030 оноос хойш жил тутам 28 их наяд төгрөгийн санхүүжилт шаардлагатай гэсэн урьдчилсан тооцоолол гарсан.⁷

Монгол Улс Парисын хэлэлцээрт нэгдэн орсноор дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, түүний нөлөөлөл, эрсдэлээс хүн төрөлхтнийг хамгаалахад хувь нэмрээ оруулах, хамтран ажиллах үүрэг хүлээхийн зэрэгцээ уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой тулгамдсан асуудлуудыг олон улсын байгууллагууд болон өндөр хөгжилтэй орнуудын тусламжтайгаар шийдвэрлэх боломж бүрдсэн.

Парисын хэлэлцээрт нэгдэн орсноор Монгол Улс хүлэмжийн хийн ялгаралыг 2010 оны суурь нөхцөлтэй харьцуулахад 22.7 хувиар бууруулах амлалт өгсөн бөгөөд үүний хүрээнд үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийн зорилтын баримт бичгийг боловсруулсан.

Үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийн зорилтыг биелүүлэхэд нийт 11.5 тэрбум ам.доллар, үүнээс уур амьсгалын өөрчлөлтийг сааруулахад 6.3 тэрбум ам.доллар, дасан зохицох ажиллагаанд 5.2 тэрбум ам.долларын санхүүжилт шаардлагатай. Тогтвортой хөгжлийн зорилтуудыг биелүүлэхэд 2030 он хүртэл нэмэлтээр 43 тэрбум ам.долларын санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлэх шаардлагатай⁸.

Үндэсний зорилтот хувь нэмэр болон Засгийн газрын хүлээсэн бусад үүрэг амлалт, зорилтуудыг оролцуулан Нэгдсэн Үндэсний байгууллагын Байгаль орчны хөтөлбөрийн тооцоолсноор Монгол Улсын ногоон хөрөнгө оруулалтын жилийн хэрэгцээ 690 сая ам.доллараас 1.03 тэрбум ам.долларын хооронд хэмжигдэж байна. Энэхүү тооцоолол нь улсын төсвийн хөрөнгө оруулалт хангалтгүй бөгөөд хувийн хэвшил, олон улсын байгууллагуудын оролцоо, хөрөнгө оруулалтын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх шаардлагатайг илтгэнэ.

1.7.5.4. Монгол Улсын Засгийн Газраас авч хэрэгжүүлж буй бодлого

Монгол Улсын зах зээлд уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг тэмцэх хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, Монгол Улсын "Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх үндэсний хувь нэмрийн зорилтууд"-ыг хэрэгжүүлэх хүрээнд Засгийн газар болон Зохицуулагч байгууллагуудаас байгаль орчин нийгэмд эерэг нөлөө үзүүлэх хөрөнгө оруулалтуудыг дэмжих үйл ажиллагаа, хууль эрх зүй, журмын зохицуулалтуудыг бий болгож байна.

"АЛСЫН ХАРАА-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай

2020 оны 05 сарын 13-ны өдөр "Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030"-ын үр дүнг илэрхийлэхүйц Монгол Улсын тогтвортой хөгжлийн зорилгуудыг "Алсын хараа-2050" бодлогын баримт бичигт тусган баталж, 2020 оны 05 сарын 25-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөж эхэлсэн.

"Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 6 дугаар зорилгод ногоон хөгжил буюу байгаль орчинд ээлтэй ногоон хөгжлийг эрхэмлэн экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалах, байгаль орчны тогтвортой байдлыг ханган үр өгөөжийг нь одоо болон ирээдүйн хойч үе хүртэх нөхцөлийг бүрдүүлэх, хүний амьдралын чанарыг сайжруулахыг тусгасан. Тухайлбал, Ногоон хөгжлийн хүрээнд дараах 4 чиглэл тус бүрд 3 үе шат бүхий зорилтуудыг тусган, хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

⁷ Монголын ногоон санхүүжилтийн эх үүсвэрийн судалгаа

⁸ Үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийн зорилт болон Тогтвортой санхүүгийн үндэсний замын зураг

Зураг 4. "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Ногоон хөгжил



Эх сурвалж: Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийн зорилт

Парисын хэлэлцээрт нэгдэн орсноор Монгол Улс хүлэмжийн хийн ялгаралыг 2010 оны суурь нөхцөлтэй харьцуулахад 22.7 хувиар бууруулах амлалт өгсөн бөгөөд үүний хүрээнд үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийн зорилтын баримт бичгийг боловсруулсан.

Үндэсний зорилтот хувь нэмрийн бичиг баримтад эрчим хүч, хөдөө аж ахуй, аж үйлдвэр, газар ашиглалтын өөрчлөлт, ойн салбар, хог хаягдлын хүрээнд хүлэмжийн хийн ялгарлын тооцоо болон хүлэмжийн хийн шингээлтийг тусгасан.

Монгол улсад хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, шингээлтийг нэмэгдүүлэх арга хэмжээ

Монгол Улсад ялгарч буй хүлэмжийн хийн 50 орчим хувийг эрчим хүчний салбар эзэлж байна. Улсын эрчим хүчний салбар нь эрчим хүчний системийн таван сүлжээ болох Баруун бүс, Зүүн бүс, Төв, Алтай-Улиастайн, Өмнөд бүс, мөн бусад дизелийн цахилгаан станцууд болон сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрүүдээс бүрддэг.

Монгол Улс "Ногоон хөгжлийн бодлого", "Алсын хараа-2050", "Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлого" зэрэг бодлогын баримт бичгүүдэд эрчим хүчний үйлдвэрлэлд зориулсан уур амьсгалын өөрчлөлтийг сааруулахад чиглэсэн бодлого, хөтөлбөр, арга хэмжээнүүд тусгасан.

Эрчим хүчний үйлдвэрлэлийн салбарын хэмнэлт

2015 онд Монгол Улсын Их Хурал нь эрчим хүчийг хэмнэх, үр ашигтай хэрэглэхтэй холбоотойгоор "Эрчим хүчний хэмнэлтийн тухай хууль"-ийг баталсан. Энэхүү хууль батлагдсанаар Монгол Улсын Засгийн Газраас эрчим хүчний хэмнэлтийн арга хэмжээг хэрэгжүүлэх эрх зүй, зохицуулалттай холбоотой дараах журам, хөтөлбөр батлагдсан. Үүнд:

- "Эрчим хүчний аудитын байгууллага болон эрчим хүчний мэргэжлийн байгууллагад тавих шаардлага, тэдгээрийг магадлан итгэмжлэх журам"
- "Эрчим хүчний аудит хийх журам"
- "Эрчим хүчний аудитор, эрчим хүчний хэмнэлтийн менежер бэлтгэх сургалтыг зохион байгуулах, гэрчилгээ олгох, хүчингүй болгох журам"
- "Үүрэг хүлээсэн хэрэглэгчийг тодорхойлох, үүрэг хүлээсэн хэрэглэгчийн эрчим хүч хэмнэх хөтөлбөр, төлөвлөгөө, тэдгээрийг боловсруулах аргачлал, хэрэгжилтийг тайлагнах журам"
- "Үүрэг хүлээсэн хэрэглэгчийн эрчим хүчний жилийн хэрэглээний босго хэмжээ"

"Эрчим хүч хэмнэх үндэсний хөтөлбөр (2018-2022)"



Монгол Улсын Засгийн Газраас 2017 онд “Эрчим хүч хэмнэх үндэсний хөтөлбөр”-ийг баталсан. Уг хөтөлбөр нь эрчим хүчний хэрэглээг 10 болон түүнээс дээш хувиар хэмнэх, хуучин орон сууц, барилгын дулаан тусгаарлалтыг сайжруулснаар дулаан алдагдлыг 20 хувиар бууруулах, дулааны цахилгаан станцуудын дотоод хэрэгцээнд зарцуулж буй цахилгаан эрчим хүчний хэмжээг бууруулж, цахилгаан дулааныг дамжуулах, түгээх арга хэмжээг хэрэгжүүлэх, мөн эрчим хүчний хэрэглээг хэмнэх төсөлд зээл санхүүжилтийн механизмыг бүрдүүлэх, сан бий болгох, хувийн хэвшлийн компаниудын эрчим хүчний хэмнэлтийн үйл ажиллагааг дэмжих зорилготой.

Хүснэгт 40. Эрчим хүчний үйлдвэрлэлийн салбараас ялгарах хүлэмжийн хийг бууруулах бодлого, хэрэгжилт

Бодлого	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилт
Монгол Улсын ногоон хөгжлийн бодлого (УИХ-ын тогтоол №43, 2014)	<ul style="list-style-type: none"> - Эрчим хүчний үйлдвэрлэлд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувийг 2020 он гэхэд 20%, 2030 он гэхэд 30%-д хүргэж, тус салбарт ногдох хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах; - Сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэл, хэрэглээг дэмжих эрх зүй, эдийн засгийн хөшүүргийн таатай орчин бүрдүүлж хэрэгжүүлэх. 	<p>Нийт цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэлд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувь:</p> <ul style="list-style-type: none"> • 2014 - 3.57% • 2015 - 3.77% • 2016 - 4.18% • 2017 - 4.25% • 2018 - 7.08% • 2019 - 10.00% • 2020 - 10.08% • 2021 - 11.2% • 2022 - 10.00%
Төрөөс Эрчим хүчний талаар баримтлах бодлого (УИХ-ын тогтоол №63, 2015)	<ul style="list-style-type: none"> - Сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, уламжлалт эрчим хүчний байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах; - Дотоодын хэрэгцээний нийт суурилагдсан хүчин чадалд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хэмжээ: • 2014 он (суурь он) - 7.62% • 2023 оны түвшинд - 20% • 2030 оны түвшинд - 30% 	<p>Нийт цахилгаан эрчим хүчний суурилагдсан хүчин чадалд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувь:</p> <ul style="list-style-type: none"> • 2014 - 8.2% • 2015 - 6.9% • 2016 - 6.9% • 2017 - 11.8%

Эх сурвалж: Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийн зорилт, Эрчим хүчний зохицуулах хороо

Эрчим хүчний үйлдвэрлэл болон хэрэглээний салбарт хүлэмжийн хийн ялгарлыг 2030 он гэхэд 29 хувиар бууруулах үндсэн зорилт тавьсан. Тухайлбал, эрчим хүчний үйлдвэрлэлийн хүлэмжийн хийн ялгарлыг суурь сценаритай харьцуулахад 2020 онд 2.91 сая т CO₂ -эquiv. буюу 11.6 хувиар, 2025 онд 6.58 сая т CO₂ -эquiv. буюу 20.6 хувиар, 2030 онд 11.26 сая т CO₂ -эquiv. буюу 29.0 хувиар тус тус бууруулах боломжтой гэж үзсэн.

Хүснэгт 41. Эрчим хүчний үйлдвэрлэлийн салбарын хүлэмжийн хийн ялгарлын бууралт (мянст CO₂ -эquiv.)

	2010	2015	2020	2025	2030
1. Суурь сценари	14,031.9	18,301.1	24,998.5	32,018.3	38,837.3
2. Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах таамаглал			22,089.9	25,433.61	27,572.7



2023 5 29



3. Хүлэмжийн хийн ялгарлын нийт бууралт	2,908.6	6,584.7	11,264.6
3.1. Эрчим хүчний хэрэглээний нийт бууралт	978.1	2,261.1	2,924.1
• Барилга	603.3	699.9	830.1
• Аж үйлдвэр	306	782.1	1,045.2
• Тээвэр	68.8	779.1	1,048.8
3.2. Эрчим хүчний үйлдвэрлэлийн нийт бууралт	1,930.5	4,323.6	8,340.5
• Сэргээгдэх эрчим хүч ашиглах	221.3	1,055.0	2,968.7
• Эрчим хүчний хангамжийн үр ашгийг сайжруулах	1,709.2	3,268.6	5,371.8
4. Хүлэмжийн хийн ялгарлын нийт бууралт	11.6%	20.6%	29%

Эх сурвалж: Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийн зорилт

Монгол Улсын ногоон таксономи

2019 оны 12 сарын 17-ны өдрийн А-302/601/264/62 тоот Монголбанкны ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Сангийн сайд, Хадгаламжийн даатгалын корпорацийн гүйцэтгэх захирлын хамтын тушаалаар олон улсад мөрдөгдөж буй Ногоон эдийн засгийн нийтлэг зарчим, шалгуур үзүүлэлтийг нэвтрүүлж буй Монгол улсын "Ногоон таксономи"-ийг баталсан.

Ногоон таксономи нь байгаль орчинд ээлтэй үйл ажиллагааны ангилал, тодорхойлолт, шалгуур үзүүлэлт бөгөөд банк, санхүүгийн байгууллагууд болон хөрөнгө оруулагчид энэхүү таксономийг ногоон зээл, ногоон хөрөнгө оруулалтын төсөл, хөтөлбөрүүдийг тодорхойлоход ашиглана.

Тухайлбал, ногоон таксономийг тодорхойлж, ашиглах нь уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, сөрөг нөлөөг бууруулах, бохирдлоос хамгаалах, байгалийн нөөцийн зүй зохистой ашиглалтыг дэмжих, иргэдийн амьжиргааг дээшлүүлэх зэрэгт чиглэсэн нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн ногоон санхүүжилтийн үйл ажиллагааны тодорхойлолт, жагсаалтыг гаргаж, суурь шаардлага тавих зорилготой.

Хүснэгт 42. Ногоон таксономийг ашиглах зах зээлийн оролцогчид болон зорилтууд

Зах зээл дээрх оролцогчид	Ашиглах зорилтууд
Санхүүгийн байгууллагууд	<ul style="list-style-type: none"> Ногоон санхүүжилтийн стратеги, бодлого боловсруулах; Ногоон санхүүжилт хийх эсвэл татах боломжит төслүүд, бизнесийн үйл ажиллагааг тодорхойлж, судлах; Ногоон санхүүжилтийн бүтээгдэхүүний шалгуурыг боловсруулах; Зээлийн багц дах ногоон санхүүжилтийн урсгалыг хэмжих, тайлагнах; Харилцагч, гол оролцогч талуудын мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх; Ногоон бондоор санхүүжүүлэх төсөл, бизнесийн үйл ажиллагааны холбогдох шалгуурыг боловсруулах; Бонд гарган бүрдүүлсэн хөрөнгөөр санхүүжүүлэх төслүүдийг тодорхойлох, үнэлэх; Бондын үр дүнд бий болсон хөрөнгийн ашиглалтыг хянах;

Бонд гаргагч байгууллагууд





Баталгаажуулалтын байгууллагууд

- Хөрөнгийн хуваарилалтыг тайлагнах;
- Байгууллага, компанийн үйл ажиллагааны стратегид "ногоон" элементийг оруулах;
- Ногоон технологитой холбоотой сонголтуудыг үнэлэх, харьцуулах, шийдвэр гаргах;
- Ногоон төслүүд, бүтээгдэхүүнийг хөгжүүлэх;
- Ногоон санхүүжилтийн төслүүдийн техникийн болон үр дүнгийн шаардлагуудыг ойлгох;
- Ногоон бонд гаргахын өмнөх болон гаргасны дараах үйл ажиллагаа, үр дүнг үнэлэх, суурь үзүүлэлтүүдийг тодорхойлох;
- Ногоон төслүүдийг гэрчилгээжүүлэх;
- Ногоон шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварыг тодорхойлж патент олгох;
- Хөрөнгийн ашиглалтыг хянах;

Бодлого боловсруулагчид

Ногоон таксономийн холбогдох стандарт, шалгуур үзүүлэлт болон ногоон санхүүжилтийг нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлогыг боловсруулж, хөгжүүлэх.

Эх сурвалж: Монгол улсын ногоон таксономи

Ногоон таксономийн дагуу 8 ангиллын хүрээнд дараах ажлууд хийгдэх хүлээлтэй байна.

Хүснэгт 43. Монгол Улсын ногоон таксономи 8 чиглэл ба холбогдох зохицуулалт

№	Ангилал	Холбогдох бодлого, зохицуулалтууд
1	Сэргээгдэх эрчим хүч	<ul style="list-style-type: none"> • Эрчим хүчний салбар дахь хүлэмжийн хийн ялгаруулалтыг 2030 он гэхэд 20 хувиар бууруулах; • Нийт эрчим хүч үйлдвэрлэлд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувь 2014 онд 7.62 хувь байсныг 2020 онд 20 хувь, 2030 он гэхэд 30 хувьд тус тус хүргэх; • Дулааны цахилгаан станцын үйлдвэрийн дотоодын цахилгааны хэрэглээг (үйлдвэрийн цахилгаан хэмнэлт) 2014 онд 14.4 хувь байсныг 2020 онд 11.2 хувь, 2030 он гэхэд 9.14 хувьд тус тус хүргэх;
2	Бохирдол багатай эрчим хүч	<ul style="list-style-type: none"> • Цахилгаан дамжуулах шугам сүлжээний цахилгаан алдагдлыг 2014 онд 13.7 хувь байсныг 2020 онд 10.8 хувь, 2030 он гэхэд 7.8 хувьд тус тус хүргэх;
3	Эрчим хүчний хэмнэлт	<ul style="list-style-type: none"> • Зорилтот аж ахуйн нэгжүүдийн эрчим хүчний хэмнэлтийг 15 хувиар сайжруулах
4	Ногоон барилга	<ul style="list-style-type: none"> • Барилгын дулаан алдагдлыг 2014 оны түвшинтэй харьцуулахад 2020 онд 20 хувь, 2030 он гэхэд 40 хувьд хүртэл тус тус бууруулах; • Улаанбаатар хотын орон сууцны угсармал 18,184 айл өрхийн байрны дулаалгыг сайжруулах; • Хотын нийт барилга байгууламжид ногоон байгууламж, цэцэрлэгт хүрээлэнгийн эзлэх хувийг 25 хувьд хүргэх. • Бохирдол: Агаар бохирдуулагч эх үүсвэрүүдийг 80 хувиар бууруулах, боловсруулаагүй түүхий нүүрсний хэрэглээг цахилгаан станцад хэрэглэхээс бусад зориулалтаар ашиглахыг хориглох, агаарын болон байгаль орчны бохирдлыг 2025 он гэхэд багадаа 50 хувиар бууруулах;

Бохирдлоос сэргийлэх, бууруулах үйл ажиллагаа



2023 5 29.1



6 Тогтвортой ус, хаягдлын хэрэглээ

- Хог хаягдал: Газарт булагдаж буй хатуу хог хаягдлын хэмжээг 2020 онд 20 хувь, 2030 он гэхэд 40 хувьд хүртэл бууруулж, хог хаягдлыг дахин боловсруулах үйл ажиллагааны менежментийг сайжруулан, дахин боловсруулах үйл ажиллагааг нэмэгдүүлэх, мөн нэмүү өртөг шингэсэн бараа бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих. Нийт хог хаягдал дотор дахин боловсруулсан хаягдлын хэмжээг 30 хувь хүртэл өсгөх.
- Хүн амын 90-ээс доошгүй хувьд нь ундны цэвэр ус хэрэглэх боломжийг бий болгох;
- Гадаргын усны нөөц болон гол мөрний ай сав газруудын байгалийн унаган эко системийг хамгаалах замаар усны нөөцийг хадгалах;
- Усны нөөц, гол мөрөн болон усны эх үүсвэрүүдийн 50-иас доошгүй хувийг тусгай хамгаалалтад авч, Улаанбаатар хот болон аж үйлдвэрүүд, мөн говийн бүсэд усны тогтвортой нийлүүлэлтийг бий болгох шийдлийг боловсруулах.

7 Тогтвортой хөдөө аж ахуй, газар ашиглалт, ой болон эко аялал жуулчлал

- Бэлчээр: Бэлчээрийн даац, хүчин чадалд тохирсон хэмжээнд мал сүргийн тоо толгойг хадгалан, бэлчээрийн тогтвортой менежментийн арга туршлагыг нэвтрүүлэх;
- Малчид, малчдын бүлэг, мөн жижиг дунд фермерүүдийн бизнесийн үйл ажиллагааг дэмжих;
- Хөдөө аж ахуй: Тогтвортой хөдөө аж ахуй, ногоон технологид суурилсан экспортыг нэмэгдүүлэх зорилгоор боловсруулах аж үйлдвэрийг хөгжүүлэх, улмаар арьс шир, ноос ноолуур зэрэг түүхий эд материалын ногоон технологид суурилсан боловсруулалтыг 2020 онд 60 хувь, 2030 он гэхэд 80 хувь хүртэл тус тус нэмэгдүүлэх;
- Газар тариалангаас үүдэлтэй хөрсний доройтлыг бууруулах, хөрсний үржил шимийг нэмэгдүүлэх, хөрс арчлах агро техник болон усжуулах дэвшилтэт технологийг ашиглан, ойн бүсийг бий болгох замаар дотоодын буудай, төмс, хүнсний ногооны нийлүүлэлтийг нэмэгдүүлэх;
- Ойг устгах үйл ажиллагаанаас үүдэлтэй хүлэмжийн хийн ялгаралтыг 2020 онд 2 хувь, 2030 он гэхэд 5 хувь хүртэл тус тус бууруулах;
- Бэлчээрийн менежмент: Хөрсний доройтолд орсон газар нутгийн 70 хувийг сэргээхэд чиглэсэн үйл ажиллагааг дэмжих, нийт газар нутгийн 30 хувийг 2030 он гэхэд төрийн хамгаалалтад авах;
- Эко-аялал жуулчлал: Эко-аялал жуулчлалын бүсүүд, бүтээгдэхүүн үйлчилгээг бий болгон хөгжүүлэх, Монголын нүүдэлчин соёл зан заншлыг олон улсад сурталчлах, аялал жуулчлалаас орох орлогыг нэмэгдүүлэх, жилдээ гадаадын 2.0 сая жуулчин хүлээн авдаг болох.

2023 5 29





8 Карбон бага тээвэр

- Хосолсон хөдөлгүүртэй тээврийн хэрэгсэл 2014 онд 6.5 хувь байсныг 2030 он гэхэд 13 хувьд хүргэж нэмэгдүүлэх;
- Холбогдох татвар, байгаль орчны төлбөрийн хэмжээг нэмэгдүүлэх замаар Улаанбаатар хот болон аймгийн төвүүдэд зорчих тээврийн хэрэгслийн түлшийг шингэн түлшнээс байгалийн хий рүү шилжүүлэх;
- Байгаль орчинд ээлтэй олон нийтийн тээврийн хэрэгслийг нэвтрүүлэх;
- Байгаль орчин, хүний эрүүл мэнд, биологийн төрөл зүйлд ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй тээврийн сүлжээ болон дэд бүтцийг хөгжүүлэх.

Монгол Улсын тогтвортой санхүүжилтийн үндэсний замын зураг

2022 оны 03 сарын 29-ний өдөр Монголбанкны ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Сангийн сайд, Хадгаламжийн даатгалын корпорацийн гүйцэтгэх захирлын хамтарсан А-82/157/68/А26 тоот тушаалаар Монгол Улсын тогтвортой санхүүжилтийн үндэсний замыг зургийг баталсан.

Үндэсний тогтвортой санхүүгийн замын зураг нь Монгол Улсын тогтвортой хөгжил, уур амьсгалын зорилтуудтай уялдаа бүхий нэгдмэл, олон талт хамтын ажиллагааг хангасан тогтвортой санхүүгийн системийг 2030 он хүртэл хөгжүүлэх, бүс нутагтаа тогтвортой санхүүгийн мэдлэг, манлайлын төв болоход шаардлагатай стратегийн чиглэл, арга хэмжээг тодорхойлох зорилготой.

Энэхүү зургийг баталсанаар банк болон банк бус санхүүгийн байгууллагуудын нийт зээлд эзлэх ногоон зээлийн хэмжээг 2030 он гэхэд 10 болон 5 хувьд тус тус хүргэх, улмаар Монгол улсыг Ази тивийн бүс нутаг дахь тогтвортой санхүүжилтийн төв болон үлгэрлэн манлайлагч болгох зорилтыг дэвшүүлж байгаа юм.

Санхүүгийн зохицуулах хорооны "Компанийн өрийн хэрэгслийн бүртгэлийн журам"

Санхүүгийн зохицуулах хорооны 2021 онд батлагдсан "Компанийн өрийн хэрэгслийн бүртгэлийн журам"-д "ногоон бонд" гаргах үйл ажиллагааны нэмэлт зохицуулалтыг тусгасан. Энэ нь хувийн хэвшлийн компаниуд гадаад болон дотоодын хөрөнгө оруулагчдаас "ногоон" зориулалтаар тусгайлан хөрөнгө татан төвлөрүүлэх боломж бүрдээд байгаа юм.

167 5 297
2023 5 2023


1.7.6. Монгол Улсын банкны салбарын төлөв байдал

1.7.6.1. Банкны систем

Монгол Улсын банкны системд нийт 12 арилжааны банк үйл ажиллагаа явуулж байна. 2022 оны жилийн эцсийн байдлаар арилжааны банкуудын нийт активын хэмжээ өмнөх оны мөн үеэс 12%-иар өсөж, 45,951.5 тэрбум төгрөгт хүрсэн.

Банкны системийн нийт зээл 2022 оны эцэст 21,876.1 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оноос 1,014.4 тэрбум төгрөг буюу 4.9%-иар өссөн байна. Чанаргүй зээлийн багц 1,699.4 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 38.1 тэрбум төгрөг буюу 2.2%-иар буурсан. Чанаргүй зээлийн хувь 2020 оны эцэст хамгийн өндөр түвшинд хүрсэн буюу 9.6% байсан бол 2022 оны эцсийн байдлаар 7.8% болж буурсан нь сүүлийн 5 жилийн байдлаарх хамгийн бага түвшинд байна.

Банкны системийн нийт пассив 2022 онд 4,042.3 тэрбум төгрөг буюу 10.9%-иар өсөж, 40,965.2 тэрбум төгрөгт хүрсэн. Харилцагчдаас татсан харилцах хадгаламж 2,180.8 тэрбум төгрөг буюу 7.8%-иар өсөж, 30,918.9 тэрбум төгрөгт хүрсэн. Харилцах, хадгаламж нь банкны системийн хувьд тогтвортой эх үүсвэрт тооцогддог бөгөөд түүний өсөлт нь салбарын төлбөр түргэн гүйцэтгэх чадвар болон томоохон төсөл, хөтөлбөр санхүүжүүлэх чадварыг сайжруулж байдаг. 2022 онд банкны салбарын нийт эх үүсвэрийн бүтцийн 74 хувийг харилцах, хадгаламж бүрдүүлсэн байна.


Банкны системийн нийт өөрийн хөрөнгө өмнөх оны мөн үеэс 973.6 тэрбум төгрөг буюу 24%-иар нэмэгдэж, 4,986.3 тэрбум төгрөгт хүрсэн. Хуримтлагдсан ашгийн цэвэр өсөлт 653.7 тэрбум төгрөг буюу 31%-иар нэмэгдэж, 2,747.2 тэрбум төгрөгт хүрсэн. Мөн 2022 онд системийн нөлөө бүхий 2 арилжааны банк хувьцаагаа олон нийтэд анх удаа санал болгон амжилттай арилжсаны үр дүнд банкны системийн хувьцаат капиталын хэмжээ 352.3 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн.

1.7.6.2. Системийн нөлөө бүхий банкуудын харьцуулалт

Монголбанкнаас тогтоосон шалгуурын дагуу системийн нөлөө бүхий банканд ХААН Банк, Худалдаа хөгжлийн банк, Голомт банк, Төрийн банк, Хас банк тооцогддог бөгөөд 2022 оны байдлаар банкны системийн нийт активын 90.6%-ийг бүрдүүлжээ. Системийн 5 банкны зах зээл эзлэлтийг харьцуулахад ХААН Банкны зах зээл эзлэлт 2022 оны эцсийн байдлаар өрсөлдөгч банкуудаас өндөр өсөлттэй байснаар тэргүүлэх байр сууриа хадгалсан хэвээр байна.

Хүснэгт 44. Системийн нөлөө бүхий банканд тооцогддог 5 банкны зах зээл эзлэлтийн харьцуулалт

Голлох үзүүлэлтүүд (тэрбум төгрөгөөр)	Өсөлт 2022/2021	2020 он		2021 он		2022 он	
		Дүн	*Эзлэх %	Дүн	*Эзлэх %	Дүн	*Эзлэх %
Нийт актив	ХААН банк	12,111	33.2%	13,463	33.2%	14,953	32.8%
	ХХБанк	8,117	22.3%	9,576	23.4%	9,569	20.8%
	Голомт банк	7,278	19.7%	7,901	19.3%	8,925	19.4%
	Төрийн банк	3,482	9.5%	3,799	9.3%	4,163	9.1%
	Хас банк	3,244	8.8%	3,475	8.5%	3,921	8.5%
Нийт зээл	ХААН банк	5,270	30.8%	7,017	33.6%	7,960	36.4%
	ХХБанк	4,171	24.4%	4,660	22.3%	4,065	18.6%
	Голомт банк	3,085	18.0%	3,421	16.4%	3,849	17.6%
	Төрийн банк	1,886	11.0%	2,420	11.6%	2,036	9.3%
	Хас банк	1,385	8.1%	1,844	8.8%	2,053	9.4%
Харилцагчаас ТТХ	ХААН банк	9,124	35.6%	10,028	35.8%	10,712	35.5%
	ХХБанк	4,993	19.5%	5,634	20.1%	6,034	20.0%



	Голомт банк	5.34%	5,060	19.7%	5,335	19.0%	5,620	18.6%
	Төрийн банк	-3.66%	2,668	10.4%	2,846	10.2%	2,742	9.1%
	Хас банк	8.29%	2,026	7.9%	2,252	8.0%	2,439	8.1%
	ХААН банк	17.85%	1,229	33.3%	1,284	35.1%	1,515	32.9%
	ХХБанк	7.80%	1,018	27.6%	1,069	26.7%	1,152	23.1%
Өөрийн хөрөнгө	Голомт банк	41.57%	632	17.1%	596	14.9%	844	16.9%
	Төрийн банк	25.70%	304	8.2%	393	9.8%	494	9.9%
	Хас банк	28.26%	277	7.5%	368	9.2%	472	9.5%

Эх сурвалж: Банкуудын улирлын санхүүгийн тайлан

*Зах зээлд эзлэх хувийг тооцохдоо банкуудын аудитлагдаагүй санхүүгийн үр дүнг Монголбанкны нийт системийн тайлантай харьцуулан тооцсон болно.

Хүснэгт 45. 2022.12.31-ны байдлаар системийн нөлөө бүхий ТОП 5 банкны санхүү байдлын тайлан (тэрбум төгрөг)

Санхүү байдлын тайлан	ХААН Банк	ХХБанк	Голомт банк	Төрийн банк	Хас банк
Актив					
Мөнгө ба түүнтэй адилгах хөрөнгө	5,161	3,327	3,677	1,409	969
Хөрөнгө оруулалт	1,660	862	699	713	685
Цэвэр зээл	7,454	3,796	3,608	1,869	1,995
Зээлийн эрсдэлийн сан	(567)	(466)	(255)	(191)	(83)
Үндсэн хөрөнгө (цэвэр)	512	587	414	126	87
Дериватив санхүүгийн хөрөнгө	129	274	426	15	108
Бусад хөрөнгө	37	723	101	31	77
Нийт актив	14,953	9,569	8,925	4,163	3,921
Өр төлбөр					
Харилцагчдаас татсан харилцах, хадгаламж Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр	10,712	6,034	5,620	2,742	2,439
Бусад эх үүсвэр	1,977	1,658	1,999	435	771
Бусад өр төлбөр	543	443	306	456	137
Нийт өр төлбөр	205	281	156	36	103
Нийт өр төлбөр	13,437	8,417	8,082	3,669	3,449
Нийт өөрийн хөрөнгө					
Хувь нийлүүлсэн хөрөнгө	172	324	202	189	100
Нэмж төлөгдсөн капитал	-	0	301	15	2
Халаасны хувьцаа	-	-	-	-	-
Хуримтлагдсан ашиг	1,269	684	308	263	283
Дахин үнэлгээний нэмэгдэл	88	146	7	23	19
Бусад нөөц	(14)	(1)	25	5	69
Нийт өөрийн хөрөнгө	1,515	1,152	844	494	472
Нийт өр төлбөр ба Өөрийн хөрөнгө	14,953	9,569	8,925	4,163	3,921


Эх сурвалж: Банкуудын улирлын санхүүгийн тайлан

ХААН Банкны хувьд зээлийн хүүгийн орлого, хөрөнгө оруулалтын орлогын үзүүлэлтээр банкны системийг тэргүүлж байгаа бөгөөд хүүгийн бус орлого нь нийт орлогын 20.0%-ийг бүрдүүлж буй нь бусад банкуудтай харьцуулахад харьцангуй тогтвортой орлогын эх үүсвэртэй болохыг илтгэж байна.



2023 5 29


Хүснэгт 46. Системийн нөлөө бүхий ТОП 5 банкны орлогын тайлан, 2022 оны жилийн эцсийн байдлаар (тэрбум төгрөг)



Орлогын тайлан	ХААН Банк	ХХБанк	Голомт банк	Төрийн банк	Хас банк
Хүүгийн орлого	1,396.5	643.8	669.5	404.9	375.6
Зээлийн хүүгийн орлого	1,069.0	457.1	437.2	298.1	290.5
Хөрөнгө оруулалтын орлого	327.5	186.7	232.3	106.9	85.1
Хүүгийн зардал	535.5	350.3	307.9	182.9	160.7
Хүүгийн цэвэр орлого	861.0	293.5	361.6	222.1	214.9
Сангийн зардал	143.2	87.6	192.6	4.8	18.8
Эрсдэлийн сангийн дараах цэвэр орлого	717.8	205.9	169.1	217.3	196.1
Хүүгийн бус орлого	349.5	217.1	206.0	53.6	61.0
Нийт цэвэр орлого	1,067.3	423.0	375.0	270.9	257.1
Үйл ажиллагааны зардал	476.5	188.5	221.0	147.4	116.4
Татварын өмнөх ашиг, алдагдал	590.8	234.5	154.0	123.5	140.7
Орлогын татварын зардал	142.1	6.5	53.5	27.3	38.5
Татварын дараах ашиг, алдагдал	448.8	228.0	100.5	96.2	102.2

Эх сурвалж: Банкуудын улирлын санхүүгийн тайлан

Хүснэгт 47. Системийн нөлөө бүхий ТОП 5 банкны гол шалгуур үзүүлэлтүүд – 2022.12.31



Эх сурвалж: Банкуудын улирлын санхүүгийн тайлан





1.7.7. Үнэт цаас гаргагчийн нөхцөл байдлын шинжилгээ

1.7.7.1. Банкны зах зээлийн эзлэлт

ХААН Банк болон нийт банкны секторын сүүлийн таван жилийн дундаж өсөлтийг харьцуулан доор харуулав. Сүүлийн 5 жилийн хугацаанд ХААН Банкны голлох үзүүлэлтүүд банкны системтэй харьцуулахад хурдтай нэмэгдсэн байна.

Хүснэгт 48. Банкны зах зээлийн эзлэлт

		ЖНӨХ%	2022	2017
		(2017-2022)	(сая төгрөг)	(сая төгрөг)
Нийт актив	ХААН Банк	15.50%	14,952,713	7,274,991
	Банкны систем	9.82%	45,951,504	28,769,815
Нийт зээл	ХААН Банк	17.35%	7,959,644	3,576,804
	Банкны систем	10.19%	21,876,050	13,463,927
Харилцагчаас ТТХ	ХААН Банк	19.22%	10,711,725	4,447,397
	Банкны систем	13.37%	30,198,882	16,125,449
Өөрийн хөрөнгө (хоёрдогч өглөг оруулснаар)	ХААН Банк	12.67%	1,514,366	833,865
	Банкны систем	11.53%	4,986,287	2,889,549

Нийт актив

Банкны салбарын нийт актив тогтвортой нэмэгдэж, сүүлийн 5 жилийн дунджаар 10%-иар нэмэгдсэн бол ХААН Банкны хувьд дунджаар 15.7%-иар өсөж зах зээл эзлэлт 2018 оны эхнээс 6.7 пунктээр тэлэн 32.8% болсон байна.


График 10. ХААН Банкны нийт активын зах зээл эзлэлт (сая төгрөг, %)



Эх сурвалж: ХААН Банкны тайлан, Монголбанкны нэгдсэн тайлан

2023 5 29 1





Зээлийн бүтээгдэхүүн

Банкны салбарын нийт зээлийн сүүлийн 5 жилийн дунджаар багц 10.2%-иар нэмэгдсэн бол ХААН Банкны хувьд 17.3%-иар өсөж, зах зээл эзлэлт 2017 оноос 9.8 пунктээр тэлж, 36.4%-ийг эзэлж байна.

График 11. ХААН Банкны нийт зээлийн зах зээл эзлэлт (сая төгрөг, %)



Эх сурвалж: ХААН Банкны тайлан, Монголбанкны нэгдсэн тайлан

Бүтээгдэхүүний төрлөөр авч үзэхэд ХААН Банк хэрэглээний зээлийн зах зээлийн 40.0%-ийг эзэлж байгаа бол бизнесийн зээлээрээ сүүлийн 3 жил зах зээлээ нэмэгдүүлсээр 33%-д хүрсэн байна. Монголбанкны макро орчны зохистой бодлогын хүрээнд 2018 оноос эхлэн иргэдийн өрийн дарамтыг бууруулах зорилгоор хэрэглээний зээлийн өсөлтийг хязгаарласан. Мөн 2019 оны эцэст төрөөс нэг удаа тэтгэврийн зээлийг тэглэх арга хэмжээ авсан нь ХААН Банкны болон системийн хувьд хэрэглээний зээлийн хэмжээ буурахад нөлөөлсөн.

2020 оноос эхлэн хэрэглээний зээлийн шийдвэр гаргалтад зээлдэгчийн зан төлөвийн үнэлгээг нэвтрүүлэн судалгаа, шийдвэр гаргалтын төвлөрсөн бүтцийг өөрчлөн салбар, нэгжийн эрхийн хэмжээнд үе шаттайгаар шилжүүлсэн. Мөн зээл шийдвэрлэх хугацааг богиносгох зорилгоор процессд оролцогчдын тоо, ач холбогдол багатай хяналтуудыг цөөлөх сайжруулалт хийгдсэн болон зээлийн нөхцөл болон шалгуур үзүүлэлтүүдийг сулруулах чиглэл баримталж ажиллаж байгаа нь зээл олголтыг нэмэгдүүлсэн.


Бизнесийн зээлийн өсөлтийг дагаад ЖДҮ болон корпорейт нэгжүүдийн зах зээлд эзлэх хувь мөн нэмэгдсэн байна.

2023 5 29А






Зураг 5. Нийт зээлийн зах зээл эзлэлт (бүтээгдэхүүн)



Зураг 6. Нийт зээлийн зах зээл эзлэлт (бизнес нэгж)




Эх сурвалж: ХААН Банкны тайлан, Монголбанкны нэгдсэн тайлан

Зээлийн эдийн засгийн сектор

2022 оны эцсийн байдлаар ХААН Банкны хувьд эдийн засгийн голлох секторууд болох бөөний болон жижиглэн, үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа, боловсруулах үйлдвэр, барилгын салбаруудад тус бүр 25-с дээш хувийн зах зээлийг эзэлж байна. Уул уурхайн салбарын хувьд харьцангуй бага буюу 11.7% байна.

График 12. Нийт зээлийн зах зээл эзлэлт (сектороор)



Эх сурвалж: ХААН Банкны тайлан, Монголбанкны нэгдсэн тайлан

Зээлийн чанар


ХААН Банкны чанаргүй зээлийн хувь 2018 онд 5.6% байсан бол 2022 онд 5.3% болж буурсан. Энэ нь банкны системийн чанаргүй зээлийн хувиас тогтмол бага байсан байна.



2023 5 29



График 13. Нийт зээлийн чанар (тэрбум төгрөг, %)



Эх сурвалж: ХААН Банкны тайлан, Монголбанкны нэгдсэн тайлан

Татан төвлөрүүлсэн хөрөнгө

ХААН Банк сүүлийн 5 жилийн хугацаанд харилцагчаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн хэмжээгээр зах зээлийг тогтмол тэргүүлсэн байна. 2022 оны 12 дугаар сарын байдлаар 10,711 тэрбум төгрөгийг харилцагчдаас татан төвлөрүүлсэн ба өмнөх оноос 683.6 тэрбум төгрөгөөр (+6.8%) өсөж, банкны секторын 35.5%-ийг эзэлж байна.

График 14. ХААН Банкны харилцагчдын харилцах, хадгаламжийн зах зээл эзлэлт (сая төгрөг, %)



Эх сурвалж: ХААН Банкны тайлан, Монголбанкны нэгдсэн тайлан


Сүүлийн гурван жилийн хугацаанд ХААН Банкны харилцагчдын депозитыг бүтээгдэхүүнээр харгалзан үзэхэд харилцах дансны зах зээлд эзлэх хувь хурдтай нэмэгдсэн бол хугацаагүй болон хугацаатай хадгаламж тогтвортой зах зээлээ хадгалж байна. Мөн түүнчлэн банк иргэдийн хадгаламжид илүү их хувийг эзэлж байна.

Зураг 7. Харилцагчдын депозитын зах зээл эзлэлт (бүтээгдэхүүнээр)

Зураг 8. Харилцагчдын депозитын зах зээл эзлэлт (сегментээр)



2023 5 29.1




Эх сурвалж: ХААН Банкны тайлан, Монголбанкны нээгдсэн тайлан

Ногоон зах зээл

Монгол улсын Санхүүгийн Тогтвортой байдлын зөвлөлөөс 2019 оны 12 дугаар сард Ногоон таксономи буюу Ногоон ангиллын бичиг баримтыг батласан бөгөөд тус ангиллын дагуу 2020 оноос эхлэн арилжааны банкууд Монголбанкруу ногоон зээлийн мэдээллээ тайлагнаж эхэлсэн.

ХААН Банкны хувьд 2020 оны I улиралд нийт арилжааны банкуудын ногоон зээлийн багцын 15 хувийг эзлэж байсан бол 2022 оны эцсийн байдлаар ХААН Банкны ногоон зээлийн багц зах зээлийн 33 хувийг дангаар бүрдүүлж байна.

График 15. ХААН Банкны ногоон зээлийн багц, зах зээл эзлэлт



Эх сурвалж: Банкуудын улирлын ногоон зээлийн тайлан, ХААН Банк

ХААН Банкны ногоон зээлийн багц нь 2022 оны жилийн эцсийн байдлаар Ногоон таксономи дахь ангилалын дагуу эрчим хүчний хэмнэлт, ногоон барилга болон тогтвортой хөдөө аж ахуйн салбарт ниглэсэн зээл голлох хувийг эзэлж байна.





График 16. ХААН Банкны ногоон зээлийн ангилал



1.7.7.2. Өрсөлдөөний орчны шинжилгээ

Банкны салбарын өрсөлдөөний нөхцөл байдал

Банкны салбарын нийт активын хэмжээ 2022 оны IV улиралд 45,956 тэрбум төгрөгт хүрсэн ба 2017-2022 он хүртэлх жилийн нийлмэл дундаж өсөлт (CAGR) 9.8 хувьтай байна. 2022 оны жилийн эцсийн байдлаар системийн нөлөө бүхий арилжааны 5 банк нь салбарын нийт активын 90.8 хувийг бүрдүүлжээ.

ХААН Банк нь салбарын нийт активын хамгийн өндөр буюу 32.8 хувийг бүрдүүлж, нийт активын жилийн нийлмэл өсөлт нь бусад банкуудтай харьцуулахад хамгийн өндөр буюу 15.7 хувьтай байна.

Банкны салбарын системийн нөлөө бүхий арилжааны топ 5 банк болон бусад банкны санхүүгийн үзүүлэлтүүдийн зах зээл эзлэлт дараах графикт харуулав.

График 17. Банкуудын зах зээл эзлэлт 2022 оны IV улирлаар




Эх сурвалж: Банкуудын улирлын санхүүгийн тайлан, Монголбанк

Банкны салбарын цахим шилжилтийн үеийн өрсөлдөөн

Дэлхийн банкуудын хөгжлийн тэргүүн чиглэлүүдийн нэгэн адил Монголын банкуудын голлох өрсөлдөөн цахим шилжилтийн хүрээнд явагдаж, харилцагчийн туулах замыг хялбаршуулах, цахим төлбөр тооцоог нэмэгдүүлэх, дата аналитик тооцоолол ашиглах, хиймэл оюун ухаанд суурилан харилцагчийн үйлчилгээг шинэ түвшинд гарган сайжруулах, арын үйл ажиллагааг автоматжуулах, метаверс орчин болон блокчейн



2023-5-29



технологийг ашиглан үйлчилгээ, төлбөр тооцооны шинэ шийдлүүдийг нэвтрүүлэх зэргээр цахим хөгжлийн трендийг дагаж байна.

Банкуудын авч хэрэгжүүлж буй цахим стратегийн шинжтэй арга хэмжээнүүдээс дурдвал дижитал банк болох, цахим салбаруудыг байгуулах, шинэ төлбөрийн шийдлүүдийг нэвтрүүлэх, "Open banking" концепци буюу финтек болон технологийн компаниудтай хамтран ажиллах, төрийн цахим шилжилттэй холбогдоход түүчээлэх, хиймэл оюун ухаан суурьтай чатбот үйлчилгээг хөгжүүлэх, үйл ажиллагааны автоматжуулалт болон үндсэн системүүдийн шинэчлэлт зэрэг ажлууд хийгдэж байна. Эдгээр шилжилтүүдийн салшгүй нэг хэсэг нь ажилтнуудын цахим ур чадвар ба үүнтэй холбоотойгоор хүний нөөцийн шинэчлэлт тасралтгүй хөндөгдөх төлөвтэй.

Банкууд нь цахим бүтээгдэхүүн, үйлчилгээний хүрээнд боломжит бүтээгдэхүүн үйлчилгээг зайны сувагт шилжүүлэх, шинэ цахим сувгуудыг хөгжүүлэх сайжруулах, төлбөр тооцооны цахим хэтэвч нэвтрүүлэх, онлайн депозит, зээлийн үйлчилгээг шинээр нэвтрүүлэх сайжруулах, харилцагчийн амьдралын хэв маягт тохирсон шинэлэг үйлчилгээнүүдийг туршин харилцагчийн туулах замыг хялбаршуулж, сэтгэл ханамжийг сайжруулахад голлон анхаарч байна.

Хүснэгт 49. Банкуудын аппликейшн санал болгож буй бүтээгдэхүүн, үйлчилгээ

Апп нэр	Татан авалтын тоо	Үйлчилгээнүүд				
		Онлайн зээл	Банкны карт холбох	Онлайн купон	Депозит	Даатгал
1 ХААН	1,000,000 +	+	+		+	+
2 Төрийн	1,000,000 +	+	+		+	
3 Голомт	500,000 +	+	+	+	+	
4 ХХБ	100,000+	+	+		+	
5 Хас	100,000 +	+	+		+	+
6 М банк	100,000 +	+	+		+	

ХААН Банкны хувьд цахим шилжилтийг нэн тэргүүнд тавьж буй бөгөөд цахим стратегийн хүрээндээ банкны үйлчилгээнээс давсан буюу амьдралын хэв маягт тохирсон үйлчилгээг харилцагчдадаа үзүүлэн дижитал банк болох зорилгыг дэвшүүлэн ажилладаг. Байгууллагын цахим хөгжлийн хувьд ажилтнуудын зайнаас ажиллах боломж, мэдээлэл технологийн төслүүдийг agile арга барилаар чанартай, хурдан нэвтрүүлэх, ажилтнуудын цахим сэтгэлгээ, цахим ур чадварыг хөгжүүлэх ажлын байрны бодлого баримталдаг. Цахим бүтээгдэхүүн үйлчилгээний хувьд харилцагчийг зайнаас таних баталгаажуулалт хийснээр туулах замыг хялбаршуулах, зайнаас бүх төрлийн бүтээгдэхүүн үйлчилгээг авах боломжийг олгож байгаа ба шинэ омни сувгийн платформ нэвтрүүлэх, онлайн зээл, зорилтот хадгаламж, хувийн санхүүгийн удирдлага, шинэ "CRM" платформ нэвтрүүлж, зайны бүтээгдэхүүн үйлчилгээг тасралтгүй сайжруулахад анхаарч байна.

Банкны салбарын шинэ оролцогчдын өрсөлдөөн

2000 оноос банкны хувьчлалын хөтөлбөр эрчимтэй хэрэгжиж эхэлснээр салбарт шинэ тоглогчид цөөнгүй нэмэгдсэн. 2001 онд Хас банк, Чингис Хаан банк, 2006 онд Үндэсний хөрөнгө оруулалтын банк, 2009 онд Төрийн банк, 2014 онд Богд банк, 2022 оны 05 сард М банк тус тус шинээр байгуулагдсан. Банкны салбарын зохицуулалт өндөр, эдийн засгийн хямралын үеийн нөлөө байгаа хэдий ч шинэ оролцогчид цахим бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэх, дижитал шилжилтэд ниглэсэн хөгжүүлэлтийг хийх хэлбэрээр өрсөлдөж байгаа бол арилжааны ууган банкуудын өрсөлдөөн илүү өндөр хэвээр байна. Харин банк бус санхүүгийн байгууллагын салбарын хувьд 2016 оноос эхлэн шинэ тоглогчид олноор нэмэгдэж, финтек хэлбэрийн ББСБ-уудын өрсөлдөөн эрчимтэй нэмэгдсэн. СЗХ-ны тайлангаас авч үзвэл 2022 оны эцсийн байдлаар нийт 37 финтек компани бүртгэлтэйгээр үйл ажиллагаа эрхэлж байна.



2023 5 29



Банкны бус салбарын оролцогчдын өрсөлдөөн

Банкны бүтээгдэхүүн, үйлчилгээг орлуулах боломжит санхүүгийн салбарын банк бус санхүүгийн байгууллага, финтек компаниудын өрсөлдөөн сүүлийн жилүүдэд өндөр нөлөөтэй байна. 2022 оны эцсийн байдлаар 513 ББСБ үйл ажиллагаа эрхэлж байгаа бөгөөд банкнаас бусад санхүүгийн салбар нийт хөрөнгийн хэмжээгээр санхүүгийн зах зээлийн 19.5 хувийг бүрдүүлжээ. Банк бус санхүүгийн байгууллагын хувьд санхүүгийн зах зээл дэх нийт хөрөнгийн хэмжээний 6.2 хувийг эзэлж байгаа хэдий ч арилжааны банкуудын цэвэр ашгийн 30 хувьтай тэнцэх ашгийг 2022 онд хуримтлуулсан байна. Финтек компаниудын хувьд 2022 оны эцсийн байдлаар зөвхөн аппликэйшнээр 936 мянган зээлдэгчийн 461.0 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна. Нэг зээлдэгчид дунджаар 492.6 мянган төгрөгийн зээл олгосон үзүүлэлттэй. Финтек компаниудын санал болгож буй бүтээгдэхүүн, үйлчилгээг дараах хүснэгтэд харьцуулан харуулав.

Хүснэгт 50. Финтек компаниудын санал болгож буй бүтээгдэхүүн, үйлчилгээ

Апп нэр	Татан авалтын тоо	Үйлчилгээнүүд					Хувьцаа, крипто, бонд
		Онлайн зээл	Банкны карт холбох	Онлайн купон	Депозит	Даатгал	
1 Monpay	1,000,000 +	+	+	+		+	
2 Lend.mn	1,000,000 +	+		+	+	+	
3 Ard app	1,000,000 +	+		+	+	+	+
4 Pocket	500,000 +	+		+	+		
5 Sono Mongolia	500,000 +	+	+				
6 Toki	500,000 +	+	+	+			
7 Storepay	100,000 +	+					
8 Numur	100,000+	+					
9 Hi pay	100,000+	+	+			+	
10 Zeely	100,000 +	+					

1.7.8. Үнэт цаас гаргагчийн дунд хугацааны бизнес төлөвлөгөөний тойм

1.7.8.1. Бизнес зорилтууд

Банк нь харилцагчийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх, түргэн шуурхай үйлчилгээ үзүүлэх, зайнаас хүргэх үйлчилгээнийхээ нэр төрлийг өсгөх зорилгоор цахим шилжилтийн зорилтууддаа онцгойлон анхаарсан төдийгүй түүнтэй холбоотой байгууллагын хэмжээний эрсдэлийн удирдлагын тогтолцоог бий болгохоор зорилтуудаа дараах байдлаар тодорхойлоод байна.Үүнд:

Харилцагч төвт байдал


- Харилцагчийн үйлчилгээнд өгөгдлийн шинжилгээ, хиймэл оюун ухаанд суурилсан хэрэглэгч бүрийн тухайлсан хэрэгцээнд нийцсэн бүтээгдэхүүн үйлчилгээ нэвтрүүлэх замаар харилцагчийн сэтгэл ханамжийг өндөрт хадгалж, хүлээлтээс давсан стандартаар үйлчилгээ үзүүлж, харилцагчаа тэргүүнд тавих соёлыг бэхжүүлнэ;
- Хамгийн өндөр чанартай харилцагчийн үйлчилгээтэй, дэлхийн стандартын Харилцагчийн мэдээллийн төвөөр харилцагчийг дэмжиж үнэнч харилцагчийн баазыг бэхжүүлнэ.

Бизнесийн өсөлт, эрсдэлийн удирдлага, хяналт

Иргэдийн болон ЖДБ-ийн зах зээл дээр байр сууриа тэлнэ.

- Ногоон санхүүжилтийн хүрээнд ХААН Банк 2025 он гэхэд нийт зээлийн багцад эзлэх ногоон зээлийн хэмжээг 10%-д хүргэнэ.





Бүх төрлийн бүтээгдэхүүн үйлчилгээг цахим суваг руу үе шаттайгаар шилжүүлэх замаар голлох бизнесүүдийн өсөлтийг хангана. Бизнес зорилтын хүрээнд хувийн банкны бизнест зорилтот харилцагчийн эрэлт хэрэгцээнд нийцсэн шинэлэг бүтээгдэхүүн үйлчилгээг санал болгох.

- Дэлхий нийтэд шинээр тулгарч буй Технологийн, Кибер, Стратегийн, Гуравдагч талын, Загварын эрсдэлүүдийг бууруулах, нөөцийг зөв зохистой хуваарилах замаар эрсдэлийг эрт илрүүлж үр дүнтэй удирдах (Risk and Control Self Assessment, Key Risk Indicator гэх мэт) арга аргачлалуудыг бүрэн хэрэгжүүлэх, банкны хэмжээнд эрсдэлийн удирдлагын талаарх мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, байгууллагын нэгдсэн эрсдэлийн удирдлага (Enterprise Risk Management)-ын тогтолцоог бүрдүүлнэ.

Цахим банкны алсын хараа, стратеги

ХААН Банк нь гадна орчны хувьсал өөрчлөлтөд дасан зохицох, шинэчлэн сайжрах замаар урт хугацаанд өөрийн өрсөлдөх чадварыг хадгална. Бид харилцагчийн хүсэл зорилгыг таньж, түүнд нь тохирсон бүтээгдэхүүн, үйлчилгээг санал болгож, амьдралын хэв маягт нийцсэн, хэрэглэхэд хялбар түргэн шуурхай үйлчилгээг үзүүлнэ. Уг зорилгын хүрээнд:

1. Гуравдагч талуудтай хамтран харилцагчийн өдөр тутмын амьдралын хэв маягт тохирсон экосистемийг бий болгож, харилцагчийн сонголтод тэргүүлэгч байр суурийг эзэлнэ;
2. Өгөгдөл болон хиймэл оюун ухаанд суурилсан харилцагчийн тухайлсан хэрэгцээнд нийцсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг санал болгоно;
3. Харилцагчийн туулах замыг хялбаршуулах чиглэлээр зохион бүтээх сэтгэлгээг (design thinking) бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн процессод ашиглахаас гадна роботжуулсан процессийн автоматжуулалтыг бүтээгдэхүүн, үйлчилгээнд нэвтрүүлнэ;

Байгууллагын хөгжил

- Цахим банк болох зорилтыг биелүүлэхэд шаардагдах ажилтны ур чадварыг тодорхойлох, илрүүлэх, татах, бэхжүүлэхэд чиглэн ажиллах;
- Инноваци, нэвтрүүлэлтийн хурд, энгийн хялбар шийдэл болон үр дүнг гаргах Agile арга барилыг нэвтрүүлнэ;
- Байгууллагын засаглалын зарчмуудаа бэхжүүлж, оролцогч талууд хоорондын хамтын ажиллагааг дэмжин ил тод зарчмыг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллана. Мөн тогтвортой хөгжлийн бодлогоо бэхжүүлж, тогтвортой хөгжлийн зарчмуудыг үйл ажиллагаандаа нэвтрүүлнэ.

1.7.8.2. Санхүүгийн төсөөллүүд

Энэхүү үнэт цаасны танилцуулгад тусгагдсан ирээдүйн төсөөллүүд нь таамаглал, үнэлгээнд суурилсан бөгөөд хөрөнгө оруулагч нь тухайн төсөөллийн биелэлтэд өөрийн үнэлгээг хийж шийдвэрээ гаргана. Банкны 2022 оны 12-р сарын 31-ээрх СТОУС-ын дагуу тайлагнасан санхүүгийн тайланд Прайсотерхаускуперс Аудит ХХК аудит хийж гүйцэтгэсэн бөгөөд ирээдүйн төсөөлөл, таамаглалуудтай холбоотойгоор ямар нэгэн аудит, нягтлах ажил болон аливаа ажилбар хийж гүйцэтгээгүй. Тиймээс энэхүү танилцуулгад багтсан санхүүгийн ирээдүйн төсөөлөл, таамаглалуудтай холбоотойгоор ямар нэг дүгнэлт гаргаагүй болно.


Хүснэгт 51. ХААН Банкны санхүүгийн байдлын тайлангийн төсөөлөл

сая.төгрөг

	2022Г	2023Т	2024Т	2025Т	2026Т
Хөрөнгө					
Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө	3,424,972	3,140,645	4,036,596	4,888,165	5,706,141
Монголбанкны үнэт цаас	2,232,940	1,558,905	3,334,169	3,249,014	3,196,444



2023-05-29



Засгийн газрын үнэт цаас	812,136	880,778	859,660	884,916	910,918
ИЗББонд, бусад хөрөнгө оруулалт	379,824	591,753	340,730	377,610	414,490
Нийт зээл	7,959,644	8,922,186	9,631,923	10,884,073	12,299,002
ХААН Банкны үндсэн зээлүүд	7,125,537	8,609,218	9,348,271	10,858,915	12,273,845
Засгийн газрын хөтөлбөрийн зээлүүд	834,107	312,968	283,651	25,157	25,157
Хасах нь: Зээлийн эрсдэлийн сан	(566,704)	(630,673)	(562,013)	(647,013)	(742,013)
Бусад цэвэр хөрөнгө	709,901	779,755	737,386	769,876	777,185
Нийт хөрөнгө	14,952,713	15,243,349	18,378,452	20,406,641	22,562,167
Өр төлбөр ба өөрийн хөрөнгө					
Харилцах данс	4,348,009	3,734,662	3,755,557	4,197,567	4,691,031
Хугацаагүй хадгаламж	1,155,772	1,275,915	2,824,891	3,181,360	3,580,732
Хугацаатай хадгаламж	5,099,586	5,420,578	7,752,721	8,672,209	9,699,146
ЗГ харилцах хадгаламж	346,223	366,120	125,339	141,759	160,188
ОУСБ-аас авсан зээллэг	1,306,252	1,964,943	1,114,537	1,131,193	1,051,261
Бусад эх үүсвэр	450,928	210,028	296,349	308,829	321,309
Худалдааны санхүүжилтийн эх үүсвэр	16,989	25,100	31,341	32,263	33,212
Нийт ТТХ	12,723,759	12,997,347	15,900,735	17,665,180	19,536,879
Монголбанкны зээл, эх үүсвэр	367,410	35,266	163	167	172
Бусад өр төлбөр	346,178	292,039	317,863	317,863	317,863
Нийт өр төлбөр	13,437,347	13,324,652	16,218,760	17,983,210	19,854,914
Өөрийн хөрөнгө	1,515,366	1,918,696	2,159,691	2,423,431	2,707,253
Нийт өр төлбөр ба өөрийн хөрөнгө	14,952,713	15,243,349	18,378,452	20,406,641	22,562,167


Хүснэгт 52. ХААН Банкны орлогын тайлангийн төсөөлөл

	сая.төгрөг				
	2022Г	2023Т	2024Т	2025Т	2026Т
Нийт хүүгийн орлого	1,402,966	1,775,555	1,486,050	1,617,683	1,769,082
Зээлийн хүүгийн орлого	1,075,481	1,247,049	1,143,561	1,281,046	1,430,455
Хөрөнгө оруулалтын орлого	327,485	528,507	342,489	336,638	338,627
Хүүгийн зардал	535,259	893,859	637,050	698,222	766,347
Хүүгийн цэвэр орлого	867,708	881,696	849,000	919,462	1,002,736
Хүүгийн бус орлого	323,050	292,555	266,419	280,014	288,917
Банкны үйлчилгээний шимтгэл хураамж	264,145	265,437	236,500	248,325	260,741
Валют болон Үнэт цаас арилжаа, ханшийн тэгшитгэлийн цэвэр орлого	38,474	30,000	23,153	24,310	25,526
Свопын ашиг, алдагдал	15,878	(3,902)	5,574	6,124	1,329
Бусад орлого	4,552	1,020	1,192	1,254	1,322
Хүү болон шимтгэлийн цэвэр орлого	1,190,757	1,174,251	1,115,419	1,199,475	1,291,652
Зээлийн эрсдэлийн сан	138,534	72,000	75,000	85,000	95,000
Бусад хөрөнгийн эрсдэлийн сан	4,901	5,439	10,000	7,000	5,000
Үйл ажиллагааны зардлын өмнөх орлого	1,047,322	1,096,811	1,030,419	1,107,475	1,191,652

Боловсон хүчний зардал	155,624	188,590	173,546	190,901	209,991
Нийт үйл ажиллагааны зардал	293,295	378,473	341,876	366,198	391,015
Захиргааны зардал	199,968	273,254	223,606	239,259	256,007



2023 5 29



Элэгдлийн зардал	75,133	75,724	84,515	89,138	92,680
Хадгаламжийн даатгалын хураамжийн зардал	22,363	29,495	33,756	37,801	42,328
Татварын өмнөх цэвэр ашиг	594,233	529,748	514,996	550,377	590,647
Татварын зардал	34,921	126,515	120,529	128,637	137,825
Татварын дараах цэвэр ашиг	448,772	403,233	394,467	421,740	452,822

1.7.9. Зээлжих зэрэглэл

1.7.9.1. Монгол улсын зээлжих зэрэглэл

Олон улсын зээлжих зэрэглэлийн үнэлгээг тогтоогч топ гурван байгууллага болох "Мүүдис" агентлаг (Moody's Investor Service), "Фитч" агентлаг (FitchRatings), болон "Эс энд Пи" (S&P Global Ratings) агентлагууд Монгол Улсын зээлжих зэрэглэлийн үнэлгээг тогтоодог.

Мүүдис агентлаг нь 2023 оны 02 сарын 14-нд буюу хамгийн сүүлд Монгол Улсын зээлжих зэрэглэлийн "В3/тогтвортой" үнэлгээг хэвээр үлдээсэн бол Фитч агентлагийн хувьд 2022 оны 05 сарын 18-нд, "Эс энд Пи" агентлаг 2022 оны 07 сарын 21-нд Монгол Улсын зээлжих зэрэглэлийн "В/тогтвортой" үнэлгээг хэвээр үлдээж байгааг баталгаажуулсан байна.

Хүснэгт 53. Монгол Улсын зээлжих зэрэглэлийн үнэлгээ

Үнэлгээний байгууллага	Moody's	Fitch	S&P
Зээлжих зэрэглэлийн үнэлгээ*	B3	B	B
Үнэлгээний төлөв	тогтвортой	тогтвортой	Тогтвортой

Эх сурвалж: www.moody's.com, www.fitchratings.com, S&P report

* "Фитч" болон "Эс энд Пи"-ийн "В" үнэлгээ нь "Мүүдис"-ийн B3 үнэлгээтэй харьцуулахад нэг түвшин өндөр байдаг.

"Мүүдис" агентлагаас 2023 оны 02 сарын 16-ны өдөр гаргасан тайланд Монгол Улсын эдийн засаг нь цөөн хэдэн салбараас хамааралтай хэдий ч ашигт малтмалын асар их нөөцтэй ба түүний экспортын орлого нь дунд хугацаанд эдийн засгийг сайжруулах бололцоо өндөр, мөн Засгийн газрын өрийн удирдлага сайжирч өмнөх үетэй харьцуулахад тогтвортой түвшинд хүрсэн зэргийг харгалзан үзэж, үнэлгээг "В3, тогтвортой" хэвээр үлдээжээ.

"Фитч" агентлагын 2023 оны 05-р сарын 15-нд гаргасан тайланд Монгол Улсын засаглалын үзүүлэлтүүд нэг хүнд ногдох орлого "В" үнэлгээтэй бусад оронтой харьцуулахад сайн байгаа хэдий ч гадаад өрийн түвшин өндөр, гадаад валютын нөөц бага байгаа энэ үед гадаад санхүүжилт, БНХАУ-д нийлүүлэх түүхий эдийн экспортоос ихээхэн хамааралтай байгаа зэргийг харгалзан үзээд зээлжих зэрэглэлийн үнэлгээг "В", төлөвийг "тогтвортой" хэвээр үлдээж байгааг баталгаажуулсан байна. Фитч агентлаг уул уурхайн салбарын сэргэлт, дотоод эрэлтээс шалтгаалан 2023 онд Монгол Улсын бодит ДНБ-ий өсөлт 5 хувьд хүрч, 2024 онд эрчимжихээр таамаглаж байна. БНХАУ Ковидын эсрэг бодлогоо сулруулснаар нүүрсний экспорт хурдацтайгаар сэргэж байгаагийн зэрэгцээ ирэх 1-2 жилийн хугацаанд хил дээрх төмөр замыг бүрэн ашиглаж эхэлснээр экспортын хүчин чадал нэмэгдэнэ гэж төсөөлжээ. Мөн 2023 оны 03 дугаар сард Оюутолгой гүний уурхайн үйл ажиллагаа нээлтээ хийсэн бөгөөд аажмаар үйлдвэрлэл нь нэмэгдэж байгаа, бусад уул уурхай, дэд бүтцийн төслүүд дунд хугацааны өсөлтийг дэмжих боломжтой талаар дурдсан байна.

"Эс энд Пи" агентлагийн хувьд 2022 оны 07 сарын 21-ний өдөр гаргасан тайландаа түүхий эдийн экспортоос хамааралтай Монгол Улсын эдийн засаг 2022 онд 2.5 хувиар өсөх ба цаашид 2025 он хүртэл ДНБ-ий бодит өсөлтийг жилд дунджаар 6.4% болно гэж таамаглав. Энэхүү эдийн засгийн өсөлтийн төлөв нь Тавантолгой, Оюутолгой зэрэг уул уурхайн салбар дахь төслүүдэд гадаадын шууд хөрөнгө



2023 5 29

СЭХ
он 2023 сар 08
БҮРТГЭВ
№ 11

оруулалт тогтвортой хийгдэхтэй холбоотойгоор эерэг үргэлжилнэ гэж үзжээ. Цаашид зээлжих зэрэглэл "Тогтвортой" төлөвтэй байх нь эдийн засгийн сэргэлт хэвийн үргэлжилнэ гэсэн хүлээлтээс шалтгаална. Мөн 2020 оны 08-р сард БНХАУ-ын Ардын банктай байгуулсан 15 тэрбум юанийн своп хэлцэл 2023 оныг дуустал сунгасан, гадаад өр төлбөртэй холбоотой эрсдэлүүд нь олон улсын донор байгууллагуудын зээлийн дэмжлэгээр буурч байгаа зэрэгтэй холбоотойгоор Монгол Улсын төсөв, өр, гадаад секторын нөхцөл байдал ирээдүйд сайжирна гэдгийг онцолжээ.

1.7.9.2. Монголын банкуудын зээлжих зэрэглэл

2022 оны байдлаар Монгол Улсад үйл ажиллагаа явуулж арилжааны банкууд болон Монгол Улсын Хөгжлийн банк нь Мүүдис, Фитч, Эс энд Пи зэрэг агентлагаар зээлжих зэрэглэлийн үнэлгээгээ тогтоолгож байна.

Банкны салбарын үнэлгээг гаргахдаа тухай банкны үйл ажиллагаанд үнэлгээ өгөхөөс гадна үйл ажиллагаа явуулж буй Монгол Улсын макро эдийн засаг, хууль эрх зүйн орчин зэрэг хүчин зүйлсийг харгалзан үздэг.

2023 оны 05 дугаар сарын байдлаар банкнуудын зээлжих зэрэглэлийн үнэлгээ нь Монгол Улсын зээлжих зэрэглэлийн үнэлгээтэй адил түвшинд байгааг доорх хүснэгтээс харна уу.

Хүснэгт 54. Зээлжих зэрэглэлийн үнэлгээ

Нэр	"Мүүдис"	"Фитч"*	"Эс энд Пи"**
Монгол Улсын Засгийн газар	} В3/тогтвортой	} В/тогтвортой	} В/тогтвортой
Монгол Улсын Хөгжлийн банк			
Төрийн банк			
ХААН Банк	} В3/тогтвортой	} В/тогтвортой	} В/тогтвортой
ХасБанк			
Голомт банк			
Худалдаа Хөгжлийн Банк			
Капитрон банк			
Богд банк			
Тээвэр хөгжлийн банк			

Эх сурвалж: www.moody's.com, www.fitchratings.com, S&P report

* "Фитч" болон "Эс энд Пи"-ийн "В" үнэлгээ нь "Moody's"-ийн "В3" үнэлгээнээс нэг түвшин өндөр байдаг.

1.7.7.3. ХААН Банкны зээлжих зэрэглэл

ХААН Банк 2007 оноос эхлэн олон улсын зээлжих зэрэглэлийн үнэлгээ тогтоогч "Fitch Ratings" (Фитч), 2008 оноос эхлэн "Moody's Investors Service" (Мүүдис) үнэлгээний байгууллагаар тус тус зээлжих зэрэглэлийн үнэлгээ хийлгэж байна.

"Мүүдис" байгууллагаас гаргасан ХААН Банкны зээлжих чадварын үнэлгээ

2018 оны 01 дүгээр сард "Мүүдис" агентлагаас Монгол Улсын эдийн засгийн сэргэлт болон Засгийн газрын үнэлгээг сайжруулсантай холбоотойгоор ХААН Банкны зээлжих зэрэглэлийн үнэлгээг "САА1"-ээс "В3" болгон сайжруулсан бол 2021 оны 03 дугаар сард банкны зээлжих зэрэглэлийн үнэлгээний төлөвийг Монгол Улсын эдийн засаг эргэн сэргэж байгаатай холбоотойгоор банкны үйл ажиллагаа явуулах орчин таатай болж, банкны ашигт ажиллагаа болон активын чанарын үзүүлэлт тогтвортой байна гэсэн хүлээлттэйгээр ирэх 12-18 сарын үнэлгээний төлөвийг "сөрөг" байсныг "тогтвортой" болгон сайжруулсан.

"Мүүдис"-ээс хамгийн сүүлд буюу 2022 оны 10 дугаар сард ХААН Банкны "В3, тогтвортой" үнэлгээг дахин баталгаажуулж үнэлгээг хэвээр үлдээсэн тухай мэдэгдлийг гаргасан.

МОНГОЛЫН ХӨГЖЛИЙН ХААН БАНК
УКИ0009

УЛААНБААТАР ХОТ
ХААН БАНКНЫ
АНДЕРРАЙТЕР
А. АНДЕРРАЙТЕР
1115205447

2023 5 29



Хүснэгт 55. ХААН Банкны зээлжих зэрэглэлийн үнэлгээ /Moody's/

Үзүүлэлт

2022 оны 10 сар


Үнэлгээний төлөв/ outlook	Тогтвортой
Төгрөгөөр татан төвлөрүүлсэн хөрөнгийн үнэлгээ	B2/NP
Гадаад валютаар татан төвлөрүүлсэн хөрөнгийн үнэлгээ	B3/NP
Банкны хадгаламж	B3/NP
Зээлжих чадварын бие даасан үнэлгээ	b3
Үнэт цаас гаргагчийн үнэлгээ/ Issuer Rating	B3
Гэрээгээр хүлээсэн үүргийн эрсдэлийн үнэлгээ	B2(cr)/NP(cr)

Уг үнэлгээний дэлгэрэнгүй тайланд банкны үйл ажиллагааны талаар дараах дүгнэлтүүдийг оруулсан байна.

- ХААН Банк нь Монгол улсдаа хамгийн том банкны хувьд өргөн, хүчирхэг сүлжээтэй, Банкны өөрийн хөрөнгийн хүрэлцээ хангалттай түвшинд байгаа, татан төвлөрүүлэх хөрөнгө болон хөрвөх чадварын үзүүлэлт сайн, ашигт ажиллагаа өндөр байгаа зэрэг нь энэ үнэлгээнд нөлөөлсөн.
- Банкны зээлийн багц нь иргэдийн болон ЖДБ-т олгосон зээлийн багцаас бүрддэг нь Банкны активын чанарын үзүүлэлт тогтвортой байхад эерэгээр нөлөөлдөг.
- Монгол Улсын эдийн засагт чухал ач холбогдолтой, нөлөө бүхий байгууллага учраас аливаа нөхцөлд Засгийн газраас банканд дэмжлэг үзүүлэх магадлал өндөр ч энэ нь банкны урт хугацаат зээлжих зэрэглэлийн үнэлгээг дээшлүүлэхэд нөлөөгүй.
- Банк 2023 оны 6 сард багтаан нийтэд хувьцаагаа анх удаа санал болгох үйл ажиллагаа (IPO) нь өөрийн хөрөнгийн хүрэлцээг тогтвортой түвшинд хадгалах, 2023 оны онлайн зээлийн 2 оронтой тоонд хүргэх зорилгод дэмжлэг үзүүлэх зэргийг үндэслэн "B3" үнэлгээг өгсөн.
- Банкны ашигт ажиллагаа бусад банкнудаас өндөр байгаа нь банкны салбар нэгжийн өргөн сүлжээгээр дамжуулан татан төвлөрүүлж буй хөрөнгийн зардал бага, кредит карт болон дижитал банкны үйлчилгээний шимтгэлийн орлого өндөр байгаа нь нөлөөлж байгааг харгалзан "B1" үнэлгээг өгсөн.
- Салбар нэгжийн өргөн сүлжээгээр дамжуулан иргэд болон ЖДБ эрхлэгч харилцагчидтай удаан хугацаанд хамтран ажилласаар ирсэн нь зардал багатай эх үүсвэр татах боломж олгодог. Мөн олон улсын банк, санхүүгийн байгууллагуудаас урт хугацаат, тогтвортой эх үүсвэр татах боломжтой зэрэг нь татан төвлөрүүлсэн хөрөнгө болон төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлтүүдийг хангалттай сайн түвшинд хадгалахад дэмжлэг болж байгааг үндэслэн "B1" үнэлгээг өгсөн. Түүнчлэн ХААН Банкны эх үүсвэр болон төлбөр гүйцэтгэх чадварыг ирээдүйн 12-18 сарын хугацаанд тогтвортой хэмжээнд хадгалагдана хэмээн дүгнэжээ.
- ХААН Банкны зээлийн багцын 43.3%-ийг иргэдийн зээлийн багц бүрдүүлж байгаа нь бусад арилжааны банкнуудтай харьцуулахад зээлийн багцын чанарын үзүүлэлт сайн байхад нөлөөлж байна.
- ХААН Банкны "B3" бие даасан үнэлгээ нь Монгол Улсын макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтээр хязгаарлагдаж байна.
- "Мүүдис"-ээс Байгаль орчин, нийгэм, засаглалын (БОНЗ) үнэлгээг зээлжих зэрэглэлийн үнэлгээний тайланд оруулдаг болсон ба ХААН Банкны үнэлгээ зохистой буюу "CIS-2" түвшинд байна. Монгол Улсын Засгийн газраас ХААН Банканд үзүүлэх дэмжлэг сайн байх тул БОНЗ-ийн эрсдэлүүдийг хааж, зээлжих зэрэглэлийн үнэлгээнд материаллаг нөлөө үзүүлэхгүй гэж дүгнэжээ.

2023 5 29





• ХААН Банкны ашигт ажиллагаа, тогтвортой эх үүсвэрийн бүтэц болон хөрвөх чадвар бүхий хөрөнгийн хэмжээ зэрэг үзүүлэлтүүд нь бусад арилжааны банкнуудтай харьцуулахад 1-4 үнэлгээгээр өндөр үнэлэгдсэн байна.

“Фитч” үнэлгээний байгууллагаас ХААН Банканд өгсөн үнэлгээ

2023 оны 03 дугаар сард “Фитч” агентлагаас ХААН Банкны зээлжих зэрэглэлийн үнэлгээг МУ-ын эдийн засгийн сэргэлт эрчимжиж буй үед ашигт ажиллагаагаар бусад банкаа тэргүүлж байгаа, өөрийн хөрөнгийн хэмжээгээ нэмэгдүүлсэн зэрэг нь зээлжих чадварын “В, тогтвортой” үзүүлэлтээ тогтвортой хадгална гэж дүгнэжээ.

ХААН Банкны зээлжих зэрэглэлийн үнэлгээний үзүүлэлтүүд нь Монгол Улсын зээлжих зэрэглэлийн үнэлгээний үзүүлэлтүүдтэй ижил түвшинд байна. МУ-ын гадаад худалдааны саад тогторууд аажимдаа буурч, Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлж буй хил дамнансан дэд бүтцийн төслүүд хэрэгжиж эхэлснээр дунд хугацаанд эдийн засгийн төлөв, үзүүлэлтүүд сайжирвал банкнуудын үйл ажиллагаанд эергээр нөлөөлөх хандлагатай байна. Системийн нөлөө бүхий банкнуудын нийтэд хувьцаагаа анх удаа санал болгох үйл ажиллагаа (IPO)-ны сүүлийн хугацааг сунгасан нь эрх бүхий байгууллагууд банкны салбарын тогтвортой байдлыг хангахад чухал ач холбогдол өгч байгааг харуулжээ.


“Фитч”-ээс ХААН Банкны бизнесийн үнэлгээг үйл ажиллагааны орчны үнэлгээнээс нэг түвшин өндөр үнэлсэн бөгөөд үүнд банкны салбарын нийт активын үзүүлэлтээр зах зээлийн 33 хувийг дангаар эзэлж байгаа, бизнесийн өргөн цар хүрээ зэргийг харгалзан үзсэн гэж дурджээ. ХААН Банкны ашигт ажиллагааны түвшин, хүчирхэг санхүүгийн үзүүлэлтүүд нь эдийн засаг, хууль эрхзүйн орчин болон засгийн газрын бодлого зэрэг банкны бизнест нөлөө үзүүлэх үйл ажиллагааны орчинд үүсэх эрсдэлүүдийг бууруулахад давуу талтай гэж онцолсон байна.

Хүснэгт 56. ХААН Банкны зээлжих зэрэглэлийн үнэлгээ /Fitch/


Үзүүлэлт	2023 оны 03 сар
Төлөв / Outlook	Тогтвортой
Урт болон богино хугацаат гадаад валютаар хүлээсэн үүргийг биелүүлэх үнэлгээ	B
Урт хугацаат төгрөгөөр хүлээсэн үүргийг биелүүлэх үнэлгээ	B
Зээлжих чадварын үнэлгээ	b
Засгийн газрын дэмжлэг авах боломж	b

Үнэлгээний тайланд Банкны үйл ажиллагааны талаар дараах дүгнэлтүүдийг оруулсан байна. Үүнд:

- Хэдийгээр дэлхийн эдийн засгийн тодорхойгүй байдал, инфляцын дарамт, мөнгөний хумих бодлого зэргээс үүдэн ойрын хугацаанд банкны зээлийн өсөлт удаашрах, чанаргүй зээлийн багц өсөх эрсдэлтэй байгаа хэдий ч ХААН Банкны чанаргүй зээлийн харьцаа болон эрсдэлийн сангийн үзүүлэлт банкны салбарын дунджаас харьцангуй сайн байгаа нь активын чанарыг удирдах боломжтойг илтгэж байна. 2022 оны байдлаар Банкны чанаргүй зээлийн харьцаа үзүүлэлт 5.3% байсан нь МУ-ын банкны салбарын дундаж үзүүлэлт 9.2%-тай харьцуулахад сайн үзүүлэлт юм.
- Банкны ашигт ажиллагаа, орлого өндөр бөгөөд тогтвортой хадгалагдахаар байна. Бодлогын хүү өссөн нь Банкны цэвэр хүүгийн маржинд богино хугацаанд эергээр нөлөөлөхөөр байгаа бөгөөд дунд хугацаандаа эдийн засаг сэргэвэл Банкны ашиг орлогод мөн эергээр нөлөөлөх хандлагатай.
- Банкны 1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгийн харьцаа 2022 онд урьдчилсан байдлаар 16.7%-д хүрсэн (2021 онд 15.8%) бөгөөд зохицуулагч байгууллагаас тавьсан зохистой харьцааны шаардлага болох 13%-ийг бүрэн хангаж байна. Цаашид банкны өөрийн хөрөнгийн хэмжээ ашигт ажиллагааг дагаад өсөх хандлагатай байна. Тус харьцаа үзүүлэлт нь банк өөрийн



2023 5 29



хөрөнгийн хэмжээгээ огцом бууруулахуйц өндөр ногдол ашиг тараах тохиолдолд буурах эрсдэлтэй боловч банкны ирээдүйд хийхээр төлөвлөөд байгаа хувьцаагаа олон нийтэд санал болгох үйл ажиллагааны (IPO) хүрээнд босгох нэмэлт хөрөнгө нь тус харьцаа үзүүлэлтийг өсөхөд эергээр нөлөөлнө гэж харж байна.

- ХААН Банкны дотоодын зах зээлд томоохон байр суурь эзэлж байгаа, нийт банкны салбарын депозитийн 35%-ийг бүрдүүлж байгаа зэргийг харгалзан Банк хөрөнгийн эх үүсвэр, төлбөр түргэн гүйцэтгэх чадвараа хангалттай түвшинд хадгална гэж харж байна. Мөн олон улсын санхүүгийн байгууллагуудаас татаж буй урт хугацаат эх үүсвэрүүд нь банкны нийт эх үүсвэрийн 7.2%-ийг эзэлж байна.

Хавсралт №5. Зээлжих зэрэглэл тогтоосон үнэлгээний баримт бичиг

1.8 Эрсдэлийн хүчин зүйлс ба удирдлага

ХААН Банк нь эрсдэлийн удирдлагын тогтолцоог үр дүнтэй хэрэгжүүлж, тайлагнах, хяналт тавих зорилгоор ТУЗ, ТУЗ-ийн дэргэдэх эрсдэлийн хороо, ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороо, дотоод аудит, эрсдэлийн удирдлагын хороо, актив пассивын удирдлагын хороо, зээлийн эрсдэлийн хороо, комплаенсийн хороодоор дамжуулан эрсдэлийн удирдлагын засаглалыг хэрэгжүүлдэг. Түүнчлэн мэдээллийн аюулгүй байдлын хүрээнд "ISO27001:2013 – Мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны стандарт", "PCI DSS – Төлбөрийн картын аюулгүй байдлын стандарт", "ISO27701:2019 Privacy Information Management болон GDPR (General Data Protection Regulation)" зэрэг болон бусад Олон улсын стандарт шаардлагуудыг үйл ажиллагаандаа мөрдөн тогтмол сайжруулан ажиллаж байна.

ХААН Банкны хөрөнгө оруулагчдад учирч болзошгүй дараах эрсдэлүүдийг тодорхойлж байна. Хөрөнгө оруулагч нь ХААН Банканд хөрөнгө оруулалт хийхээсээ өмнө доор дурдсан эрсдэл, тодорхойгүй нөхцөл байдал болон бусад гол мэдээлэлтэй сайн танилцах нь зүйтэй.

1.8.1 Эрсдэлийн хүчин зүйлс

Банкны бизнестэй холбоотой эрсдэл

Банк нь өөрийн хөрөнгийн хүрэлцээний шаардлагуудыг хангахгүй тохиолдолд Банкны санхүүгийн нөхцөл байдалд сөргөөр нөлөөлөх магадлалтай.


Өөрийн хөрөнгийн хүрэлцээний харьцаа зөрчигдөхөд нөлөөлөх үндсэн 2 хүчин зүйл.

- *Эрсдэлээр жигнэсэн активын зохистой хэмжээ алдагдах:* Макро эдийн засгийн үзүүлэлтүүд, зах зээлийн нөхцөл байдлаас хамаарч зээлдэгчдийн санхүүгийн байдал хүндэрч, улмаар банкны зээлийн чанар муудах, банк, санхүүгийн байгууллага, үнэт цаас гаргагчийн зээлжих зэрэглэлийн үнэлгээ муудах, ханшийн эрсдэлтэй этгээдэд гадаад валютын зээл ихээр олгох, гадаад валютаарх позицын харьцаа үзүүлэлтээ хангахгүй байх, актив, пассивын оновчгүй удирдлага зэрэг хүчин зүйлүүд нь өөрийн хөрөнгийн хүрэлцээний харьцаанд сөрөг нөлөөлөл үзүүлдэг.
- *Өөрийн хөрөнгийн хэмжээ төлөвлөсөн хэмжээнээс буурах:* Төлөвлөөгүй томоохон үйл ажиллагааны зардал гарах, активын чанар муудснаар их хэмжээний эрсдэлийн сан байгуулах зэргээр ашигт ажиллагаа буурах.

Банк нь өөрийн хөрөнгийн хүрэлцээний харьцаа үзүүлэлтийг Монголбанк болон олон улсын санхүүгийн байгууллагуудаас тавьсан зохицуулалтын хүрээнд ханган ажиллахын зэрэгцээ стратеги зорилт ба болзошгүй нийт эрсдэлтэй нийцүүлэн удирддаг. Энэ зорилтын хүрээнд Банк хүлээн зөвшөөрөх эрсдэлийн түвшинг ТУЗ-өөр, дотооддоо мөрдөх хувь хэмжээ болон арга хэмжээний төлөвлөгөөг Актив пассивын удирдлагын хороогоор батлуулан, сар бүр тогтмол хяналт тавин ажиллаж байна.



2023 5 29.1



Иргэдийн зээлтэй холбоотой эрсдэл

Банк нь иргэдэд орон сууц, бизнес, кредит карт болон олон төрлийн хэрэглээний зээлийг санал болгодог. 2022 оны эцсийн байдлаар иргэдийн зээлийн багц нийт зээлийн багцын 47%-ийг эзэлж байна.

Иргэдийн зээлтэй холбоотой дараах эрсдэлүүд учирч болзошгүй. Үүнд:

- Иргэдийн зээлийн эрсдэлийг үнэлэхэд шаардлагатай мэдээллийг цаг хугацаанд нь бүрэн гүйцэд авч чадахгүй байх магадлалтай. Энэ нь Монгол Улсын зээлийн мэдээллийн сангийн системийн хөгжил сул, харилцагчдын зарим төрлийн орлогын талаарх мэдээллийг нэгдсэн мэдээллийн сангаас авах боломжгүй байгаа зэрэг нөхцөл байдалтай холбоотой.
- Бусад төрлийн харилцагчтай харьцуулахад иргэдийн санхүүгийн нөхцөл байдал нь илүү эмзэг байдаг. Тухайлбал, тэдний орлого буурах, ажилгүй болох, хувийн бизнес нь алдагдал хүлээх, эрүүл мэндийн шалтгаан үүсэх, нас барах зэрэг эрсдэл тулгарахад санхүүгийн хүндрэл үүсэж, зээл төлөгдөхгүй болох нөхцөл байдал үүсдэг.
- Иргэдийн бага дүнтэй, олон тооны зээлийг эргүүлэн төлүүлэхэд хүний нөөц харьцангуй их шаардлагатай байдаг ба чанаргүй зээлийг төлүүлэхэд бусад төрлийн зээлээс илүү урт хугацаа шаарддаг.
- Монгол орон нь жилийн 4 улиралтай, бэлчээрийн мал аж ахуй зонхилдог, зөвхөн дулаан улиралд газар тариалан эрхлэх боломжтой байдгаараа онцлогтой. Үүнээс шалтгаалан өвөл нь зуд, зун нь ган болох зэрэг байгалийн давагдашгүй хүчин зүйлс тохиолдвол малчны зээлийн болон газар тариалангийн зээлийн багцын эрсдэл нэмэгдэж болзошгүй байдаг. Мөн түүнчлэн малын гоц халдварт өвчин өргөн хүрээг хамарч тархсан тохиолдолд малчны зээлийн багцын эрсдэл өсдөг.

Дээр дурдсан болзошгүй эрсдэлүүд болон бусад байдлаар учирч болох эрсдэлүүдийг бууруулахад чиглэсэн төрөл бүрийн арга хэмжээг авдаг хэдий ч тэдгээр арга хэмжээ нь бүрэн, үр дүнтэй хэрэгжих баталгаа байхгүй юм. Эдгээр нөхцөл байдлаас шалтгаалан иргэдийн чанаргүй зээл их хэмжээгээр өссөн тохиолдолд Банкны бизнес, санхүүгийн нөхцөл байдал, үйл ажиллагаанд материаллаг сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлтэй.

Байгууллагын болон жижиг дунд бизнесийн зээлийн чанар муудах эрсдэл

Орос-Украин, Хятад-Тайвань улсуудын хоорондын зөрчилдөөн, АНУ, Европын холбооны хориг арга хэмжээ зэрэг томоохон улсуудын геополитикийн асуудлаас шалтгаалсан эдийн засгийн тодорхойгүй нөхцөл байдал нь банкны бизнесийн зээлийн багц, тэр дундаа гадаад худалдааны салбарт олгосон зээлийн багцад сөрөг нөлөө үзүүлэх эрсдэл байна.

Хөрөнгө оруулалт болон хөрөнгийн удирдлагын үйл ажиллагаанаас хүлээж болзошгүй алдагдал

Банк нь хөрвөх чадвараа хангаж ажиллах, валютын болон биет алтны арилжаа, мөнгөний болон хөрөнгийн захын үнэт цаасанд хөрөнгө оруулах зэрэг хөрөнгө зохицуулалтын үйл ажиллагаанаас ашигт ажиллагаагаа нэмэгдүүлэн ажилладаг.

Гадаад валютын ханш нь валютын захын эрэлт, нийлүүлэлт, улс төр, нийгэм эдийн засгийн орчин болон бусад гадаад хүчин зүйлсээс хамааран хэлбэлздэг. Энэхүү ханшийн хэлбэлзэл нь банкны гадаад валютаар эзэмшиж буй хөрөнгө өр төлбөрийн позицын байдлаас шалтгаалан ашигт ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлтэй.

Дотоод эдийн засгийн хүчин зүйлс сайжирсантай холбоотойгоор 2023 онд дотоодын валютын захын нөхцөл байдал тогтвортой байхаар хүлээгдэж буй хэдий ч гадаад орчноос хамааралтай тодорхой бус байдал өндөр хэвээр байна. Тодруулбал, ОХУ болон Украин улсын зөрчилдөөн даамжрах, цаашлаад олон улсын бүс нутгийг хамарсан эдийн засгийн хориг чангарах, гадаад зах зээлийн инфляци өсөх, АНУ-н Холбооны нөөцийн сан бодлогын хүүгээ огцом өсгөж, ам.долларын санхүүжилтийн өртгийг улам

2023 5 29

нэмэгдүүлэх зэрэг эрсдэлт хүчин зүйлс тохиолдох магадлал өндөр байна. Гадаад валютын эрэлт нийлүүлэлтэд нөлөөлөх эдгээр хүчин зүйлс нь валютын ханшийн гэнэтийн хэлбэлзэл бий болгосон тохиолдолд банкны гадаад валютын позицын удирдлага алдагдах, валют арилжааны алдагдал хүлээх нэрсдэлтэй.

Харилцагчаас худалдан авч буй биет алтны арилжаа нь олон улсын зах зээл дэх алтны ханшаас шууд хамааралтай байдаг ба харилцагчаас худалдан авсан биет алтыг хейдж хийгээгүй тохиолдолд арилжааны ашигт сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй.

АНУ-ын Холбооны нөөцийн банкны зүгээс мөнгөний хатуу бодлогоо хадгалсан хэвээр байгаа ба 2022 оноос хойш ам.долларын хүүгийн муруйнд өөрчлөлт орж, муруй бүхэлдээ өссөн нь гадаад валютын бондын өгөөжийг нэмэгдүүлж, үнэ унах эрсдэлийг нэмэгдүүлэв. Хэдийгээр Монгол Улсын Засгийн газрын зээлжих зэрэглэл В-тогтвортой ангилалд хэвээр байхаар хүлээгдэж буй ч Банкны эзэмшиж буй Монгол Улсын Засгийн газрын гаргасан эсвэл түүний баталгаатай, бодит үнэ цэнэ нь дэлгэрэнгүй орлогод бүртгэгдэх евро бондын багцын үнэлгээ буурч, алдагдал хүлээж болзошгүй.

Гадаад валютын ханшийн эрсдэл

Гадаад валютын ханшийн хэлбэлзэл нь Банкны бизнес, санхүүгийн нөхцөл байдал ба үйл ажиллагааны үр дүнд сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлтэй.

Банк нь нягтлан бодох бүртгэлийн зарчмын дагуу гадаад валютаар илэрхийлэгдсэн хөрөнгө, өр төлбөр болон балансын гадуурх үзүүлэлтийг үндэсний мөнгөн тэмдэгт (төгрөг, мөнгө)-ээр хөрвүүлэн хөтөлж тайлагнадаг тул гадаад валютын ханшийн өөрчлөлтөөс шалтгаалан нээлттэй позицоос гадаад валютын ханшийн эрсдэлд өртдөг. Түүнчлэн гадаад валютын ханшийн өөрчлөлт нь Банкны зээлдэгчдэд сөргөөр нөлөөлөх, цаашлаад активын чанарт давхар эрсдэл учруулж болзошгүй.

Банк жил тутам өөрийн хүлээн зөвшөөрөх эрсдэлийн мэдэгдэлд нийт зээлийн багцад эзлэх ханшийн эрсдэлээс хамгаалагдаагүй гадаад валютын зээлийн багцын дээд хязгаарлалтыг тогтоож, гадаад валютын зээлийн бодлого болон үйл ажиллагаандаа баримтлан ажилладаг тул Банкны зээлийн багцын бага хувийг гадаад валютаар олгосон зээл эзэлж байна.

Банк нь харилцагчдын харилцах, хадгаламжаас гадна хөрөнгө, өр төлбөрийн хугацааны зөрүүг удирдах, эх үүсвэрийн бүтцийг төрөлжүүлэх зорилгоор бусад гадаадын банк санхүүгийн байгууллагаас урт хугацаатай ам.долларын зээл авдаг. Валютын ханшийн хэлбэлзлийн улмаас урт хугацаатай валютын зээлийн эх үүсвэрийн мөнгөн гүйлгээ өөрчлөгдөж, банкны ашиг/алдагдалд нөлөөлөх эрсдэлээс хамгаалах зорилгоор Банк Монголбанктай урт хугацаат ам.долларын своп хэлцэл хийж байна.

Хэрэв Банк нь гадаад валютын нээлттэй позиц өндөртэй үед төгрөгийн ханш их хэмжээгээр хэлбэлзвэл алдагдал хүлээх, өөрийн хөрөнгийн хүрэлцээ буурч нэмэлт өөрийн хөрөнгө шаардагдах, Монголбанкнаас тогтоосон зохистой харьцаа зөрчигдөж болзошгүй байдал үүснэ.

Хүүгийн түвшний эрсдэл

Банкны цэвэр хүүгийн орлого үйл ажиллагааны үр дүнд шууд хамааралтай. Банк хүүгийн эрсдэлийг бууруулахын тулд хүүгийн түвшний хэлбэлзэл болон хөрөнгө, өр төлбөрийн хугацааны зөрүүг хянадаг хэдий ч дотоодын эсхүл олон улсын зах зээл дээрх хүүгийн түвшний мэдэгдэхүйц огцом өөрчлөлт нь банкны цэвэр хүүгийн орлого эсвэл санхүүгийн хэрэгслийн үнэ цэнийг бууруулах замаар банкны бизнес, үйл ажиллагааны үр дүнд ноцтой сөрөг нөлөө үзүүлж болзошгүй. Жишээлбэл, хүүгийн түвшин буурах нь хүүгийн орлого буурах, хүүгийн түвшин өсөх нь ерөнхийдөө банкны тогтмол хүүтэй актив хөрөнгийн үнэ цэнийг бууруулах, мөн санхүүжилтийн зардлыг нэмэгдүүлж болзошгүй. Үүнээс гадна хүүгийн түвшний өсөлт нь зээлийн нийт эрэлтийг бууруулж, улмаар зээл олголтыг хязгаарлаж, харилцагч төлбөрийн чадваргүй болох эрсдэлийг нэмэгдүүлж болзошгүй.

2023 5 29





2018 онд Монголбанкнаас Сангийн яам, СЗХ, Хадгаламжийн даатгалын корпорацитай хамтран “Зээлийн хүүг бууруулах стратеги 2018-2023” гаргасан. Монгол Улсын эдийн засаг болон институцийн чадавх сул тул энэхүү стратегийн хүрээнд макро эдийн засгийн тогтвортой орчинг бүрдүүлэх, ялангуяа инфляцыг тогтвортой нам түвшинд байлгах инфляцын зорилтот түвшинг хангах нь нэн чухал юм. Инфляцын эрсдэлээс шалтгаалан Банкны харилцагчид хадгаламж болон орлогын урсгалын бодит үнэ цэнэ буурах эрсдэлийн эсрэг бусад санхүүгийн хөрөнгө оруулалтын сонголт руу шилжих, банкны хүүгийн мэдрэмжтэй хөрөнгө болон өр төлбөрийн хоорондын зөрүү нэмэгдэх, түүнийг тохируулах нэмэлт зардал шаардах, мөн санхүүгийн хөрөнгийн үнэ цэнэ буурах нь банкны санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүнд эрсдэл үүсгэж болзошгүй.

Санхүүгийн үүсмэл хэрэгслийн гүйлгээтэй холбоотой эрсдэл

Банк нь гадаад валютын үүсмэл хэрэглүүрийг голчлон эрсдэлээс хамгаалах зорилгоор бага хэмжээгээр харилцагчдынхаа өмнөөс хийдэг. Банкны санхүүгийн үүсмэл хэрэглүүрийн бүтцийг гадаадын банк, санхүүгийн байгууллагуудаас авсан урт хугацаатай ам.долларын зээлийн санхүүжилтээс хүлээж болзошгүй мөнгөн гүйлгээний эрсдэлийг хейдж хийх зорилгоор Монголбанкт хийсэн ам.долларын своп хэлцлүүд бүрдүүлдэг. Банк нь эдгээр гүйлгээтэй холбоотой зах зээлийн, зээлийн болон үйл ажиллагааны эрсдэлд өртдөг.

Одоогийн байдлаар санхүүгийн үүсмэл хэрэглүүрийн зах зээлийн туршлага, зохицуулалтын баримт бичиг, хейджийн бүртгэл хийж байгаа талуудын хувьд дагалдах олон улсын бүртгэлийн стандарт ба шаардлагууд Монгол Улсад төдийлөн сайн хөгжөөгүй тул шүүхийн байгууллагууд эдгээр санхүүгийн гүйлгээтэй холбоотой аливаа асуудал, маргааныг шийдвэрлэх туршлага дутмаг байна. Энэ нь эдгээр гүйлгээтэй холбоотой эрсдэлийг улам нэмэгдүүлэх магадлалтай.

Энэхүү санхүүгийн үүсмэл хэрэглүүрийн бодит үнэ цэнэ нь түүний үнэлгээнд нөлөөлөх зах зээлийн хүчин хүчин зүйлсийн өөрчлөлтөөс хамааран тайлангийн хугацааны хооронд ихээхэн хэлбэлзэх боломжтой учраас Банкны ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайланд материаллаг нөлөө үзүүлж болно.

Гадаад орчноос хамаарсан стратеги төлөвлөгөөг биелүүлэхэд гарах эрсдэл

Геополитикийн тогтворгүй байдал, макро эдийн засгийн шок, зохицуулагч байгууллагын шаардлага зэргээс хамааран Банкны стратеги төлөвлөгөөнд нөлөөлөл учирч болно.

Мөн өрсөлдөгчийн авч буй арга хэмжээнээс хамаарч төлөвлөгөөний биелэлтэд хүндрэл учрах боломжтой. ХААН Банк харилцагчийн үйлчилгээний туршлагыг сайжруулах буюу хамгийн сайн үйлчилгээ үзүүлэх замаар өрсөлдөнө.

Аливаа бизнесийн салбарт бүтээгдэхүүн үйлчилгээний шинэлэг байдал, тухайлсан нөхцөл, үнийн бодлого зэрэгт өрсөлдөөн ширүүсэх, гадаад орчны нөхцөл тааварлашгүйгээр өөрчлөгдөх нь байгууллагын төлөвлөгөөнд өндөр нөлөөтэй тул Банк баримталж буй чиглэлээ тухай бүр магадлах, шаардлагатай үед өөрчлөх замаар тус эрсдлийг удирдана.

Технологийн хурдтай өөрчлөлтүүдтэй зэрэгцэн шинэ төрлийн бүтээгдэхүүн хурдацтай хөгжүүлж зах зээлд нэвтрүүлэхгүй байх эрсдэл

Жил ирэх тусам технологийн дэвшилтэт шийдлүүдийн зардал буурч, олон нийтэд хүртээмжтэй шийдлүүд олширч харилцагчийн амьдралын бүх түвшинд нэвтэрч байна. Тухайлбал, хэрэглээний цахилгаан хэрэгсэл, тоног төхөөрөмжүүд ухаалаг шинж чанаруудтай болж, хэрэглэгч тэдгээрийг гар утаснаасаа удирдах боломжтой болоод байна.

Үүнийг дагаад, ухаалаг цахилгаан хэрэгслийн санхүүжилтийг хүүгүйгээр, хувааж төлөх зарчмыг харилцагчид хүсэх болсон. Мөн гадаадын мерчантаас шууд худалдан авах, гадны төлбөрийн системтэй хил заагүй холбогдох эрэлт зах зээл дээр ажиглагдаж эхэлсэн.



2023 5 29



Эрэлт бөгөөд трендийг дэмжих үүднээс Банк технологийн хөрөнгө оруулалтанд их ач холбогдол өгч, дэд бүтцийн шинэчлэл өргөн хүрээнд хийж байна. Цаашид аль төрлийн бүтээгдэхүүний цахимжуулалтыг хурдавчлах нь нөөц хуваарьлалтын асуудал тул хэрэгжүүлэх төслүүдээ зөв эрэмбэлж, зах зээлд нэвтрүүлэх цагаа зөв тодорхойлохыг зорьно.

Цахим бүтээгдэхүүн дэх эрсдэлүүд

Банк санхүүгийн зуучлал үйлчилгээнээс гадна төлбөр тооцооны хэрэгсэл, карт гаргах, карт хүлээн авах төхөөрөмжөөр үйлчлэх, цахим банкны үйлчилгээ үзүүлэх, дансны хуулга гаргах, орлого зарлагын мэдээлэл хүргэх, тодорхойлолт гаргах, даатгалын зуучлалын үйлчилгээ үзүүлэх зэрэг бусад үйлчилгээг хүргэж шимтгэл, хураамжийн орлого олдог.

Эдгээр нь Банкны харилцагчдын гол авдаг үйлчилгээ бөгөөд өрсөлдөгч их болсноор зохицуулагч байгууллагын шийдвэрээр үйлчилгээний хураамж буурах хандлагатай. Иймд цаашид цахим банкны үйлчилгээ хэрэглэгчдээс бус хамтран үйлчилгээ үзүүлж буй түншүүдийн орлогоос бүрдэх төлөв ажиглагдаж байна.

Банкны гүйцэтгэх удирдлага болон шийдвэр гаргах гол албан тушаалтнуудын тогтвортой байдал алдагдах

2020, 2021 онуудад хэрэгжүүлсэн Талент удирдлагын бодлого болон залгамж халаа тодорхойлох, бэлтгэх хөгжүүлэх ажлыг тасралтгүй хийж хэрэгжүүлж байна. Нийт ажилтнуудыг сэтгэл ханамжтай, тогтвортой ажиллуулах бодлогын хүрээнд 2022 оны эхнээс шинэ аргачлалын дагуу ажлын байрны үнэлгээг хийж ажилтнуудын цалин хөлсний систем, сургалт хөгжил, карьерын оновчтой тогтолцоо, тогтвортой ажиллуулах, түлхүүр ажлын байруудыг дахин тодорхойлох, бодлогыг бүрдүүлэх чиглэлээр үргэлжлүүлэн ажиллалаа.

Дижитал стратегийг хэрэгжүүлэхэд гол үүрэгтэй оролцох Мэдээллийн технологийн ажилтнуудын шилжилт хөдөлгөөн 2022 онд 7.8 хувь болж буурсан байна.

Гүйцэтгэх удирдлагын болон шийдвэр гаргах албан тушаалтнуудын хувьд 2022 онд ажлын байр сул байсан, бизнесийн тасалдал үүсгэсэн нөхцөл байдал гараагүй бөгөөд тогтвортой байдлаа ханган ажилласан байна. ХААН Банкны хэмжээнд дундаж ажилласан жил 8 жил.

Байгалийн гамшиг, осол аваараас хамааран Банкны үйл ажиллагаанд тасалдал үүсч болзошгүй нөхцөлүүд

ХААН Банк нь ISO 22301:2019 олон улсын стандартын баримт бичгийн хүрээнд ХААН Банкны бизнесийн тасралтгүй байдлын бодлого боловсруулан ажилладаг. Тус бодлогын дагуу Төв банк, салбар нэгжүүд нь тусдаа бизнесийн тасралтгүй байдлын төлөвлөгөөг боловсруулдаг. Энэхүү бодлогын хүрээнд Байгалийн гамшиг /цаг агаарын аюулт үзэгдэл, геологийн гаралтай аюул, биологийн гаралтай аюул/, Осол аваар /технологийн гаралтай, нийгмийн гаралтай/-ын үед хурдан хугацаанд хариу арга хэмжээ авах талаар зохицуулалтыг тодорхой болгохыг зорин ажилладаг боловч Монгол улс нь цаг уурын онцлогоос хамааран байгалийн гамшигийн үед бодит эрсдэлийг бууруулж ажиллах нь хүндрэлтэй юм. Хүйтний улиралд цасан шуурга, зуд тохиолдох нь элбэг. Сүүлийн жилүүдэд шороон шуурга, ган цөлжилт нь улс орны төдийгүй бүс нутгийн хэмжээнд анхаарал хандуулах асуудал болж байна. Байгалийн давагдашгүй хүчин зүйл нь Монгол орны 21 аймаг, сум сууринд салбар тооцооны төвтэй банкны хувьд банкны аль нэг эсвэл хэсэг бүлэг нэгжүүд ажиллах боломжгүй болох эрсдэлийг дагуулах боломжтой. Улс орны хэмжээнд хүчтэй цасан болон шороон шуурга 2019 онд 56, 2020 онд 38, 2021 онд 91 удаа тохиолдсон байна. Монгол орны нутаг дэвсгэрт 2011-2022 онд 327,576 удаагийн газар хөдлөлт болсноос 6-6,9 магнитудын газар хөдлөлт гурван удаа, 5-5,9 магнитудынх 18 удаа, 4-4,9 магнитуд хүчтэй 238 удаа болсон. Нийслэл хот орчмын газар хөдлөлтийн 6 хагаралд 6.6-7.6 магнитудын хүчтэй газар хөдлөлт болоход хамгийн багадаа барилга байгууламжийн 47.8 хувь нурж 40.000-60.000 хүн өртөх эрсдэлтэй



гэсэн судалгаа гарсан байгаа нь ХААН Банкны төв оффисын 3 барилга нэгэн зэрэг газар хөдлөлтийн эрсдэлд өртөж, хохирол үүсгэх магадлалтайг харуулж байна.

Биологийн гаралтай аюул буюу хүний гоц халдварт өвчин, мал амьтны гоц халдварт өвчин тархсан үед хөл хорио тогтоох, засгийн газрын шийдвэрээр Банкны салбар нэгжийг албадан түр хугацаанд хаах зэрэг нь Банк бие даан шийдвэр гаргах боломжгүй асуудал үүсч болзошгүй. Иргэдийн банкны харъяа салбар нэгжүүдийн хувьд малын гоц халдварт өвчин гарсны улмаас тухайн сум сууринд хэсэгчилсэн хөл хорио тогтоосонтой холбоотой тогтмол цагийн хуваарийн дагуу ажиллах боломжгүй эрсдэл үүсэх боломжтой. Хүний гоц халдварт өвчин /цар тахал/-ий үед хүний нөөцийн хомсдолд орсноор бизнесийн тасалдал банкны аль нэг нэгжид үүсэх эрсдэлтэй.

Нийгмийн гаралтай аюул осол буюу нийтийг хамарсан эмх замбараагүй байдал, террорист халдлага, дайн, цахим халдлагыг онцгой нөхцөл байдалд авч үзэхээр баримт бичигт тусгасан боловч Монгол Улсад 2 шатлалт банкны тогтолцоо бий болсон цагаас хойш ХААН Банкны төдийгүй бусад арилжааны банкуудын үйл ажиллагаанд томоохон нөлөө үзүүлэхүйц үйл явдал болж байгаагүй. Иймд системийн хэмжээнд туршлагагүй, бодит байдалд түргэн шуурхай арга хэмжээ авч чадахгүй байх магадлалтай.

Ажилтнууд болон гуравдагч этгээдийн залилан мэхлэх болон бусад зүй бус үйлдлүүдийг бүрэн илрүүлж, урьдчилан сэргийлэх боломжгүй бөгөөд үйл ажиллагааны бусад эрсдэл

Банк нь өөрсдийн ажилтнууд эсвэл гуравдагч этгээдийн залилан мэхлэлт, бусад зүй бус үйлдэлд өртөж, санхүүгийн хохирол, гуравдагч этгээдийн нэхэмжлэл, зохицуулагч байгууллагын акт торгуульд орох зэргээс үүдэн үйл ажиллагаа эсвэл нэр хүндэд хохирол учруулж болзошгүй. Банкны бүх чиглэлийн дотоод бодлого, журам нь залилан мэхлэх, зүй бус үйлдлийн бүх тохиолдлоос урьдчилан сэргийлэх, эсхүл бүрэн илрүүлэх, таслан зогсооход үр дүнтэй эсвэл хангалттай гэдэгт банк бүрэн итгэлтэй байж чадахгүй юм. Залилан мэхлэх, хууль бус үйл ажиллагаа явуулах зорилгоор хэрэглэгчийн мэдээллийг хулгайлах, дээрэмдэх, гэмт халдлага үйлдэх гэх зэрэг гуравдагч этгээдийн зүгээс Банкны эсрэг гаргах зохисгүй үйлдэл нь тодорхой эрсдэлд оруулж болзошгүй бөгөөд үүнээс үүдэн Банкны бизнес, санхүүгийн байдал эсвэл үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж болзошгүй.

Сошиал орчин, хэвлэл мэдээллийн хэрэгслээр ташаа мэдээ мэдээлэл гарснаас үүдэн Банкны нэр хүнд унах

Банкны бизнесийн үйл ажиллагаа харилцагчдын итгэл дээр оршин тогтнодог бөгөөд олон нийтийн мэдээллийн хэрэгсэл болон сошиал орчинд Банктай холбоотой нотлогдоогүй, эх сурвалж тодорхойгүй, ташаа мэдээлэл нийтлэгдэх нь нэр хүндэд сөрөг нөлөөтэй. Нэр хүндийн эрсдэлийн улмаас иргэд харилцагчдын итгэл суларч, хадгаламжаа татах, банкны үйлчилгээнээс татгалзах нөхцөл байдал үүсэж, улмаар Банкны санхүүгийн чадамж, хэвийн үйл ажиллагаанд шууд болон дам байдлаар сөрөг нөлөө үзүүлж болзошгүй.

Банк болон банкны ажилтан хууль зөрчсөн тухай, банкны өмчлөл, ТУЗ-тэй холбоотой мэдээ, мэдээлэл, банкны санхүүгийн чадавх, зохистой харьцааны үзүүлэлтийн талаар ташаа, үнэнд нийцэхгүй мэдээлэл олон нийтийн мэдээллийн хэрэгслээр гарсны улмаас Банкны нэр хүнд, хэвийн үйл ажиллагаанд нөлөөлж болзошгүй.

Мэдээллийн аюулгүй байдлын зөрчил гарах

Мэдээлэл технологи, бизнес болон банк санхүүгийн томоохон байгууллагуудын үйл ажиллагаа, цар хүрээ тэлэхийн хэрээр тэдгээр байгууллагуудын вэбсайт, дэд бүтэц, мэдээлэл технологид учирч болзошгүй сайтар бэлтгэж төлөвлөсөн зорилтот кибер халдлагын эрсдэл нэмэгддэг. Мэдээлэл технологийн хурдацтай хөгжил, дэвшил нь өмнө ашиглагдаж байгаа технологиудад сул тал бий болгодог ба энэ нь мэдээллийн системд хандах эрхийг зөвшөөрөлгүй, хууль бусаар олж авах нөхцөлийг бүрдүүлдэг байдаг. Иймээс мэдээллийн аюулгүй байдлын ирээдүйд учирч болзошгүй сул талуудыг илрүүлэх нь





тухай бүрийн хөгжил шинэчлэлттэй хамт хийгддэг, байнгын сайжруулалт хийх шаардлагуудыг бий

болгодог.

2023 оны 05 сар 13 өдөр

БҮРТГЭВ

№ хэрэглэгчийн нэвтрэх эрх болон банкны нууцлалтай мэдээллийг олж авах зорилготойгоор банкны

ажилтнууд, харилцагчид болон гуравдагч талуудын оролцоотойгоор мэдээллийн систем, сүлжээ болон мэдээлэлд нэвтрэх оролдлогыг кибер халдлага болон залилангийн аргаар (фишинг) хийж гүйцэтгэх боломжтой.

ХААН Банкны мэдээллийн систем рүү чиглэсэн кибер халдлага хийх оролдлогуудыг илрүүлэн, таслан зогсоож байсан ба цаашид гарч болзошгүй кибер халдлага болон хувь хүний алдаа, системийн эмзэг байдал, доголдол болон бусад мэдээллийн аюулгүй байдлын зөрчлүүдтэй тулгарч болзошгүй. Гэсэн хэдий ч ХААН Банкны мэдээлэл технологийн систем, тоног төхөөрөмж болон мэдээллийн аюулгүй байдлын үйл ажиллагаа нь кибер халдлага болон мэдээллийн аюулгүй байдлын зөрчил гарахаас урьдчилан сэргийлэхэд чиглэгддэг. Энэхүү авч хэрэгжүүлж буй хяналтууд нь ирээдүйд учирч болзошгүй аюул заналаас бүрэн сэргийлэх боломжгүй байх магадлалтай.

Бодитоор учирч болзошгүй мэдээллийн аюулгүй байдлын зөрчил нь үйл ажиллагааны тасалдалд оруулж болох ба систем, үйлчилгээний хүртээмжтэй бус байдал, мэдээлэл алдагдах зэрэг үр дагаврууд нь банкны нэр хүнд, брэндинг болон хууль, зохицуулагч байгууллагын зөрчил цаашлаад санхүүгийн хохирол учруулах боломжтой.

Банк нь өөрийн байгууллагын ажилтнууд, хамтран ажилладаг гуравдагч тал эсвэл харилцагчдын санаатай болон санамсаргүй үйлдлүүд болох хүнээс шалтгаалсан мэдээлэл алдагдах тохиолдлуудыг илрүүлэх эсвэл таслан зогсоох боломжгүй байх

Банк нь хувь хүний мэдээллийн нууцлал, бизнесийн болон үйл ажиллагааны зэрэг маш чухал мэдээллүүдийн нууцлалыг хангах, хамгаалахын тулд хувь хүний мэдээллийн аюулгүй байдлыг хамгаалах олон улсын стандарт шаардлагуудыг хэрэгжүүлэн, хөдөлмөрийн гэрээ, нууц хадгалах гэрээг ажилтнуудтай байгуулан ажилладаг. Мөн ажилтнаас шалтгаалсан мэдээлэл алдагдах, санхүүгийн болон нэр хүндийн хохирол хүлээх эсвэл банканд зохицуулагч байгууллагаас арга хэмжээ авах зэрэг эрсдэлүүдийг бууруулах зорилгоор дотоод бодлого журмууд болон сургалт зөвлөмжөөрөө дамжуулан ажилтнууддаа мэдлэг, мэдээллийг тогтмол хүргүүлж ажилладаг.

Банк нь хүний санаатай болон санамсаргүй үйлдлээс үүдэн фишинг буюу хуурамч и-мэйлийн халдлагад өртөх, цахим шуудан болон интернэт орчны хортой кодын уршгаар банкны мэдээлэл болон файлууд алдагдах, санаатайгаар банкны мэдээллийг задруулах зэрэг тохиолдлуудыг банк бүрэн хянах, илрүүлэх эсвэл бүрэн таслан зогсоох боломжгүй байх магадлалтай.

Банк нь ажилтантай хөдөлмөрийн гэрээ болон нууц хадгалах гэрээ байгуулан Банкны мэдээллийн нууцлалыг хангуулдаг бол эсрэгээр нь харилцагчийн санамсаргүй байдлаас шалтгаалан харилцагч цахим залиланд өртөх, түүнээс үүдэн банкны нэр хүнд унах зэрэг эрсдэлийг банкны зүгээс хянах, илрүүлэх зэрэг арга хэмжээ авах боломжгүй байх эрсдэлийг хөрөнгө оруулагчийн зүгээс тооцоолон авч үзэхийг зөвлөж байна.

Гуравдагч талаас шалтгаалсан мэдээллийн нууцлал алдагдах

ХААН Банк нь мэдээллийн технологи, программ хангамж хөгжүүлэлт, бүтээгдэхүүн нийлүүлэлт, гадны аудит, санхүүгийн байгууллагууд зэрэг үйл ажиллагааны хүрээнд олон төрлийн гуравдагч талтай хамтран ажилладаг. Сүүлийн жилүүдэд гуравдагч талаас шалтгаалсан эрсдэл үүсэж, байгууллагын нууцлалтай мэдээллийг хамтран ажилладаг гуравдагч тал нь санаатай болон санамсаргүй байдлаар задруулах тохиолдол нэмэгдэх чиг хандлагатай байна. Гуравдагч талын дотоод үйл ажиллагааны мэдээллийн аюулгүй байдлын хяналт, үйл ажиллагааны хангалтгүй байдлаас шалтгаалсан мэдээлэл алдагдах эрсдэл

2023 5 29.1



үүсэж болзошгүй. Энэхүү эрсдэлийн хүрээнд Банк нь гэрээний хүрээнд хамтран ажиллаж буй гуравдагч талуудад Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн асуулгыг шалгах хуудсаар дамжуулан зайнаас хийж гүйцэтгэдэг. Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээний хүрээнд гуравдагч талын гэрээний хяналтыг Гуравдагч талд, нарийвчилсан үнэлгээг үйл ажиллагааны чиглэлд тулгуурлан нэгтгэсэн байдлаар хийж гүйцэтгэдэг. Үр дүнг мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн дэд хорооны гуравдагч талын эрсдэлийн самбарт бүртгэн эрсдэлд авах арга хэмжээний төрлийг сонгон хэрэгжүүлэн ажилладаг.

Үүлэн технологид суурилсан үйлчилгээний мэдээллийн аюулгүй байдал алдагдах

Монгол Улсын хууль, тогтоомж болон зохицуулагч байгууллагын хүрээнд Үүлэн технологид суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээнд тавигдах нэгдсэн зохицуулалт, шаардлага хангалтгүй байх нь Банк үүлэн технологид суурилсан бүтээгдэхүүн үйлчилгээг үзүүлэхэд мэдээллийн аюулгүй байдлын шаардлага бүрэн хангагдахгүй байх эрсдэлийг нэмэгдүүлж болзошгүй.

Мэдээлэл технологийн тасралтгүй бөгөөд тогтвортой байдлаас хамаарах эрсдэл

Банкны бизнесийн өсөлтийг бий болгох, бизнес стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх, бизнесийн тасралтгүй бөгөөд тогтвортой үйл ажиллагааг хангах нэг хөшүүрэг нь мэдээлэл технологийн үйл ажиллагаа байдаг ч мэдээлэл технологийн үйл ажиллагаанд тохиолдож буй томоохон гэмтэл саатал, доголдол, асуудлууд нь бизнесийн тасралтгүй ажиллагаа, банкны нэр хүнд, банкны бусад зорилго зорилгод сөрөг нөлөө үзүүлэх магадлалтай.

Банкны бизнесийн тасралтгүй ажиллагаанд нөлөө үзүүлэх магадлалтай дотоод болон гадаад хүчин зүйлүүд байдаг. Дотоод хүчин зүйлүүдэд мэдээлэл технологийн үйл ажиллагааны дутмаг байдал, бүтэц зохион байгуулалтын өөрчлөлт, ажилтны ур чадвар, ажилтны алдаа дутагдал, бодлого журмын хангалтгүй байдал зэрэг багтдаг. Гадаад хүчин зүйлүүдэд хуулийн болон зохицуулагч байгууллагуудын шаардлагууд, гуравдагч талын буюу мэдээлэл технологийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагаа доголдох зэрэг багтдаг.

Тодруулбал, Засгийн газраас гаргасан гэнэтийн шийдвэр нь (иргэдэд тэтгэмж олгох) Банкны интернэт банк болон картын гүйлгээнд ачаалал үүсгэн системийн тасралтгүй байдалд нөлөөлөх тохиолдол бий. Мөн Банк нь мэдээлэл технологийн үйлчилгээ үзүүлэгч гуравдагч талуудтай (ПОС, сүлжээ г.м) хамтран ажилладаг ба эдгээр гуравдагч талуудаас шалтгаалсан гэмтэл саатал нь банкны системүүдийн найдвартай, тасралтгүй үйл ажиллагаанд сөрөг нөлөөлөл үзүүлэх тохиолдлууд гардаг.

Банкны үйл ажиллагаатай холбоотой хууль зүйн эрсдэл

Банк нь ААН-ийн тусгай зөвшөөрлийн тухай хууль, Банкны тухай хуульд заасны дагуу Монголбанк, СЗХ-ноос олгосон тусгай зөвшөөрлийн хүрээнд мөнгөн хадгаламж, төлбөр тооцооны үйлчилгээ, зээлийн үйлчилгээ, үнэт зүйл хадгалах, гадаад төлбөр тооцоо, даатгалын зуучлагч, кастодианы үйл ажиллагаа зэрэг банкны үйл ажиллагаа эрхэлдэг.

ХААН Банк нь Монгол Улсад үйл ажиллагаагаа явуулдаг ААН-ийн хувьд Монгол Улсын хууль, тогтоомжийг дагаж мөрдөх үүрэгтэй. Гэвч банк санхүүгийн салбарын онцлог болон Монгол Улсын хууль эрх зүйн орчинтой холбоотой бусад нөхцөл байдлаас үүдэн банкны үйл ажиллагаанд хууль зүйн эрсдэл үүсэх тохиолдол гардаг.

Мөн түүнчлэн Банкны тухай хууль, зохицуулагч байгууллагуудын дүрэм, журам, гарын авлага, заавар зэрэг эрх зүйн баримт, бичгийг дагаж мөрдөөгүй тохиолдолд хуульд заасан шийтгэл хүлээх, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох зэрэг нөхцөл байдал үүсэх боломжтой.



**Монгол Улсын банкны салбартай холбоотой эрсдэл**

Банкны салбарын гол бизнес болох зээлийн үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэл, эрсдэлд нөлөөлөгч хүчин зүйлс, цаашдын тодорхой бус байдлыг дараах байдлаар тодорхойлон авч үзсэн.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн шаардлагын талаарх харилцагчдын мэдлэг хомс байгаагаас банкнаас тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлэхгүй байх эрсдэл

Банк нь Монгол Улсын Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх (МУТСТ) тухай хуулийн дагуу харилцагчаа таньж мэдэх, харилцагчийн хийж буй гүйлгээнд тусгайлан хяналт тавих, хууль бус сэжигтэй гүйлгээг илрүүлж, эрх бүхий зохицуулагч байгууллагад мэдээлэх үүрэг хүлээсэн байдаг. Улсын хэмжээнд энэхүү үйл ажиллагааг банк санхүүгийн салбарт нэвтрүүлж эхлээд удаагүй тул нийт харилцагчдын ойлголт мэдлэг хомс байдаг.

Хуулиар хүлээсэн үүргийн дагуу харилцагч тус бүрийг таньж мэдэх, бүртгэхтэй холбоотой бичиг баримт, мэдээллийг гаргуулан авах, мөн харилцагчийн хийж буй гүйлгээтэй холбоотой нотлох баримт, материалыг шаарддаг боловч эдгээр шаардлагыг харилцагч биелүүлэхээс татгалзах, хуурамч мэдээлэл өгөх, банкны зүгээс тавьсан хууль ёсны шаардлагын эсрэг олон нийтийн цахим сүлжээ ашиглан банкны нэр хүндэд халдах тохиолдол багагүй гарч, банкны үйл ажиллагаанд хүндрэл учруулдаг.

Улмаар харилцагч нь банкны бүтээгдэхүүн үйлчилгээг ашиглан гэмт хэргийн замаар олсон, хууль бус хөрөнгө мөнгийг "угаах", төлбөр тооцооны системээр хууль бус хөрөнгө мөнгө дамжуулах оролдлого хийх, банкны хяналтаас зайлсхийх зэрэг эрсдэлүүдтэй өдөр тутам нүүр тулдаг. Эдгээр эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх зорилгоор зарим тохиолдолд банк харилцагчийн дансыг хааж, бизнесийн харилцаагаа цуцлах, үйлчилгээг хязгаарлах, зогсоох арга хэмжээ авдаг бөгөөд энэ нь бизнесийн үр ашигт сөргөөр нөлөөлөх тохиолдол гардаг.

Банк нь МУТСТ хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүйгээс үүдэн эрх бүхий байгууллагаас өндөр дүнтэй торгууль хүлээх, нэр хүндээ алдах, улмаар үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлөө хураалгах хүртэл эрсдэлтэй байдаг тул банкны зүгээс тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлээгүй харилцагчид дээр дурдсан хатуу арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь зүй ёсны бөгөөд банкны урт хугацааны, тогтвортой үйл ажиллагаанд чухал ач холбогдолтой юм.

Улс оронтой холбоотой эрсдэл**Эдийн засгийн гол салбаруудын уналт нь зээлийн багцын чанарт сөргөөр нөлөөлнө**

Монгол улсын эдийн засаг нь бүхэлдээ гол цөөн салбаруудын үйл ажиллагаанаас өндөр хамаарах бөгөөд ялангуяа уул уурхайн салбарын гүйцэтгэл эдийн засагт өндөр нөлөөтэй байдаг. Тухайлбал, Монгол улсын экспортын гол түүхий эд болох нүүрс, зэсийн үнэ буурах, Оюу толгой, Таван толгойн уурхайн орд зэрэг гол төслүүдийн үйл ажиллагаа удаашрах зэрэг нь шууд болон дам байдлаар бүхий л салбаруудад хүчтэй нөлөө үзүүлнэ. Банкны хувьд хэдийгээр уул уурхайн салбарын зээлийн багцыг нийт зээлийн багцын 10%-иас хэтрэхгүй байх лимитийг мөрдөн хянадаг боловч үүнээс үл хамааран бусад салбаруудад шууд бус сөрөг нөлөө үзүүлснээр нийт зээлийн багцад сөргөөр нөлөөлөх эрсдэл байна.

Экспортын гол бараа болох түүхий эдийн үнэ унах эрсдэл

Монгол улсын эдийн засаг уул уурхайн экспортоос тэр дундаа нүүрсний экспортоос өндөр хамааралтай явсаар ирсэн. 2022 оны хоёрдугаар хагасаас эхлэн Хятадын хилийн хязгаарлалт суларч, Таван толгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр зам болон Таван толгой-Ханги боомт ашиглалтад өрснөөр нүүрсний экспортын биет хэмжээ сайжирч оны эцэст 31.7 сая тон хүрсэн. Мөн Ковид-19 цар тахлын хязгаарлалтууд суларсантай холбоотойгоор хөдөө аж ахуй болон үйлчилгээний салбарын идэвхжил ажиллагдсанаар 2022 онд Монгол улсын ДНБ 4.7 хувьд хүрэв.

2023 5 29.1



2023 оны Улсын нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүнг 19.1 их наяд төгрөг хүрэхээр тусгасан байгаа бөгөөд үүнд түүхий эдийн үнийн таамаглалыг дараах байдлаар тусгасан байна. Тухайлбал, эс 8,400 ам.доллар, алт 1,830 ам.доллар, нүүрс 220 орчим ам.доллар, газрын тос 95 ам.доллар тус тус байхаар тусгагдсан байна.

Түүхий эдийн ханш нь дэлхийн хоёр дахь том эдийн засаг болох Хятад улсын хэрэглээнээс ихээхэн хамаардаг бөгөөд хилийн хязгаарлалт суларсантай холбоотойгоор түүхий эдийн эрэлт болон ханшид эергээр нөлөөлөхөөр байна.

Түүнчлэн Монгол улсын засгийн газар 2024-2025 онд нийт нүүрсний экспортыг онлайн дуудлага худалдаа явуулах замаар нүүрсний экспортын ил тод, үр ашигтай байдлыг нэмэгдүүлэхээр төлөвлөж байна. 2023 оны 07-р сар гэхэд 12 сая тонн нүүрсийг дуудлага худалдаагаар худалдах зорилт тавиад байгаа бөгөөд 2023.04.26-ны байдлаар 1.17 сая тонныг оны эхнээс худалдаалсан байна.

Цаашид хил гаалийн нөхцөл байдал сайжирсан болон Таван толгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр зам болон Таван толгой-Ханги боомт ашиглалтад орсонтой холбоотойгоор нүүрсний экспортын биет хэмжээ өсөх төлөвтэй байна.

Улмаар нүүрсний экспортын хэмжээ төсөөллөөс өндөр гарснаар экспортын орлого, улмаар төсвийн орлого "Монгол Улсын нэгдсэн төсөв"-т тусгагдсан дүнгээс хэтрэх боломжтой байна.


Нөгөө талаар "Хятад-Тайван" улсын хоорондын зөрчилдөөн ширүүссэн тохиолдолд хил гаалийн нөхцөл байдал муудсанаар Монгол улсын экспортын хэмжээ болон түүхий эдийн ханш буурах эрсдэлтэй байна.

ГВАН буурах, улсын гадаад өрийн дарамт нэмэгдэх зэргээс шалтгаалан төгрөгийн ханшид шок бий болох эрсдэл

2023 оны 4 дүгээр сарын эцэст Төв банкны Гадаад валютын албан нөөц (ГВАН) 3.7 тэрбум ам.доллар буюу 5 орчим сарын импортын хэрэгцээг хангах түвшинд очсон. Монгол Улсын засгийн газраас эдийн засгийн харьяатын олон улсын зах зээл дээр гаргасан 2023 болон 2024 онд төлөгдөх евро бондуудыг 4 жилийн хугацаатай, 650 сая ам.долларын бондоор дахин санхүүжүүлснээр гадаад валютын ханшинд ирэх дарамтыг бууруулсан. Тухайлбал, 2023 онд 1.3 тэрбум ам.доллар, 2024 онд 850 сая ам.долларын бондын эргэн төлөлтийг тус тус 533 сая ам.доллар болон 600 сая ам.доллар болгон бууруулсан. Гэсэн хэдий ч Монгол улсын хөгжлийн банк болон хувийн компаниудын бондын эргэн төлөлтүүд 2023 болон 2024 онуудад байгаа нь ГВАН буурах, гадаад өрөө эргэн төлөх чадварт сөргөөр нөлөөлөх ба бондуудыг дахин санхүүжүүлэх, шинэ хөрөнгө оруулалт татахад сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байна. Гадаад валютын нөөц буурч улмаар хомсдолд орсон тохиолдолд ханшийн савлагаа нэмэгдэх, төгрөгийн ханш эрчтэй суларч болзошгүй. Түүнчлэн арилжааны банкууд гадны хөрөнгө оруулагч байгууллагуудаас ам.доллороор дунд болон урт хугацааны санхүүжилт татдаг бөгөөд уг санхүүжилтээрээ Монголбанктай урт хугацаат своп хэлцэл хийж төгрөгийн эх үүсвэр болгон ашигладаг. Урт хугацаат своп хэлцлийн 2 дугаар гүйлгээ нь бодит болон бодит бус гэсэн хэлбэртэй байдаг. Хэрэв Монголбанкны ГВАН буурч, Монголбанк эдгээр хэлцлийн дагуу төлбөрийн үүргээ биелүүлэх боломжгүй болох мөн дуудлага худалдаагаар валют нийлүүлэх боломжгүй болох тохиолдолд арилжааны банкуудын олон улсын санхүүгийн байгууллага, хөрөнгө оруулагчдын өмнө хүлээсэн эргэн төлөлтийн үүргээ биелүүлэхэд хүндрэл үүсэх эрсдэлтэй.

Монгол Улсын хууль эрх зүйн орчны тодорхойгүй байдлаас банканд үүсэх эрсдэл

Монгол Улсын хууль зүйн систем нь хөгжлийн үе шатандаа явж байгаа энэ үед Монгол Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомж болон төрийн эрх бүхий байгууллагаас батлан гаргасан эрх зүйн актын зохицуулалт нь нэг утгаар ойлгож хэрэглэх боломжгүй буюу олон салаа утгатай байх, тухайн зүйл заалтыг хэрхэн ойлгож, хэрэглэх талаар албан ёсны тайлбаргүй байх зэрэг тохиолдол цөөнгүй гардаг. Зарим тохиолдолд хууль, эрх зүйн актын тухайн зүйл, заалтыг шүүгч, төрийн байгууллагын эрх бүхий албан



тушаалтнууд өөр өөрөөр тайлбарлаж, хэрэгжүүлдэг нь банкны хувьд тодорхой хууль зүйн эрсдэл үүсгэдэг. Түүнчлэн, банк санхүүгийн салбар хурдацтай хөгжихийн хэрээр цахим платформд суурилсан санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ шинээр бий болж байгаа бөгөөд тухайн харилцааг зохицуулсан хууль тогтоомж, эрх зүйн актын зохицуулалт нь хангалттай үндэслэл, судалгаа хийгдээгүй байх, аливаа зүйлийг хэт хориглосон, хязгаарласан шинжтэй байх эсхүл зарим харилцааг зохицуулалтгүй үлдээж байгаа нь банкны үйл ажиллагаанд хууль зүйн эрсдэл үүсгэж болзошгүй.

Улс төрийн нөхцөл байдлаас хамаарч банканд үүсэх хууль зүйн эрсдэл

Банкны хууль эрх зүйн орчин нь мөн улс төрийн нөхцөл байдлаас өндөр хамааралтай байгаа нь хууль зүйн эрсдэл үүсэх шалтгаануудын нэг болж байгааг дурдах нь зүйтэй. Улс төрийн шинжтэй шийдвэрийг биелүүлэх зорилгоор банкны үйл ажиллагаанд хамааралтай хууль тогтоомжийн төсөлд банк, санхүүгийн байгууллагын саналыг авч тусгалгүйгээр батлах, тухайн хууль тогтоомжийн дагуу авч хэрэгжүүлэх арга хэмжээний хугацаа бодитой биш байх зэргээр гэнэтийн өөрчлөлтийг богино хугацаанд хэрэгжүүлэх шаардлага үүсгэдэг нь банкны үйл ажиллагаанд хууль зүйн эрсдэл үүсгэж болзошгүй.

Корреспондент банкны харилцаа цуцлагдах, гадаад төлбөр тооцооны гүйлгээ саатах эрсдэл тулгарч болзошгүй

Банк нь харилцагчийн гадаад гүйлгээг түргэн шуурхай дамжуулах, бүтээгдэхүүн үйлчилгээгээ олон улсын жишигт нийцүүлэн хүргэхийн тулд гадаадын банк санхүүгийн байгууллагатай хамтарч ажиллах, гадаадын корреспондент банкны үйлчилгээг авах шаардлагатай байдаг. Гэтэл санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-аас Монгол Улсыг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн дутагдалтай орнуудын жагсаалт буюу "Саарал жагсаалт"-д оруулсны улмаас гадаадын банк санхүүгийн байгууллагуудын хяналт чангарч, тавьж буй шаардлага ихсэхийн сацуу гадаад гүйлгээ саатах, шимтгэл хураамж өсөхөд хүрсэн. Хэдийгээр ФАТФ-ын зүгээс 2020 оны 10 сарын 23-ны өдөр Монгол Улсыг "Саарал жагсаалт"-аас гаргахаар шийдвэрлэсэн хэдий ч тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлэх төлөвлөгөөт үүрэг даалгавар өгсөн.

Ийнхүү ФАТФ-аас өгсөн үүргийн биелэлтийг Монгол Улсын хэмжээнд бүрэн биелүүлж чадахгүй байх тохиолдолд дахин "Саарал жагсаалт"-д оруулах эрсдэлтэй бөгөөд энэ нь зөвхөн банкны үйл ажиллагаа, гадаад төлбөр тооцоо саатахад нөлөөлөөд зогсохгүй улс орны гадаад харилцаа, эдийн засаг, олон улсын худалдаа, хөрөнгө оруулалтад сөргөөр нөлөөлөх өндөр эрсдэлийг дагуулна.

1.8.2 Эрсдэлийн удирдлага, хамгаалалтын 3 шугам

ХААН Банк нь Эрсдэлийн удирдлагын ерөнхий бодлого болон Хүлээн зөвшөөрөх эрсдэлийн тогтолцооны бодлогын хүрээнд Зээлийн эрсдэл, Хөрвөх чадварын эрсдэл, Зах зээлийн эрсдэл, Үйл ажиллагааны эрсдэл, Хууль, Комплаенсийн эрсдэл, Мэдээллийн аюулгүй байдал болон Мэдээлэл технологийн эрсдэлүүдийг тодорхойлж, хянаж, удирдаж ажилладаг.


Эдгээр эрсдэлүүдийг ТУЗ-өөс баталсан Эрсдэлийн удирдлагын ерөнхий бодлого болон Хүлээн зөвшөөрөх эрсдэлийн тогтолцооны бодлогын хүрээнд дараах бодлого, журмын дагуу удирдаж, хянадаг.

- Зээлийн эрсдэлийн удирдлагын бодлого, журам;
- Санхүүгийн бус эрсдэлийн удирдлагын бодлого;
- Хаан банкны дотоод хяналтын бодлого, журам;
- ХААН Банкны Стресс тестийн бодлого, журам;
- Комплаенсийн бодлого;
- Мөнгө угаах санхүүгийн гэмт хэргийн эсрэг баримтлах бодлого;
- Мэдээллийн аюулгүй байдлын бодлого;
- Гадаад валютын ханшийн эрсдэлийг хэмжих, удирдах журам;



Handwritten signature and initials over the stamp.

2023 5 7



- ХААН Банкны хүүгийн эрсдэлийг хэмжих, удирдах журам;
- ХААН Банкны хөрвөх чадварын эрсдэлийн удирдлагын журам;
- Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн удирдлагын журам;
- Мэдээлэл технологийн эрсдэлийн удирдлагын журам.

Эрсдэлийг удирдах үйл явцыг тасралтгүй, үр дүнтэй хэрэгжүүлэх үүднээс үүрэг хариуцлагуудыг оновчтой хуваарилж, эрсдэлийн удирдлагын бодлого, журмуудад тусгасан байдаг бөгөөд банкны ажилтан бүр өөрийн үүрэг хариуцлагын хүрээнд үүсэж болзошгүй эрсдэлийг мэдээлэх, удирдаж, хянах үүрэг хүлээдэг. ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагын үүрэг оролцоог Эрсдэлийн удирдлагын ерөнхий бодлогоор тодорхойлсон байдаг.

Банк эрсдэлийн удирдлагадаа дараах үндсэн зарчмуудыг баримталдаг.

- Эрсдэлийн удирдлагын үйл явцыг хэрэгжүүлэхэд хамаарал бүхий оролцогч талуудын оролцоо чухал бөгөөд оролцогчдыг нь эрсдэлийн мэдээллээр тогтмол хангадаг байна.
- Эрсдэлийн удирдлага нь бодит мэдээлэл дээр суурилсан байх бөгөөд шийдвэр гаргах үйл явцын нэг хэсэг байна.
- Эрсдэлийн удирдлага нь зохион байгуулалттай, цаг үетэйгээ нийцсэн, өөрчлөлтөд уян хатан байж банкны стратеги болон зорилтуудын биелэлтэнд хувь нэмэр оруулдаг байна.
- Эрсдэлийн удирдлагын үйл явцад дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.
- Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэхдээ хүрээлэн буй орчин болон нийгэмд нөлөөлж болзошгүй сөрөг үр дагавруудыг авч үзэж бууруулдаг байна.

Эрсдэлийн удирдлагын тайлагнал нь доороос дээш чиглэсэн байдаг бөгөөд хяналт, хариуцлага нь дээрээс доош чиглэсэн байдлаар хэрэгждэг. Эрсдэлийн удирдлагын нэгжүүд эрсдэлийн тайлан мэдээг боловсруулж, Эрсдэл хариуцсан дэд захирал болон холбогдох шатны хороодод тайлагнадаг. Эрсдэл хариуцсан дэд захирал нь ТУЗ болон түүний харъяа эрсдэлийн хороонд банкны эрсдэлийн удирдлагын тайлан болон бусад голлох эрсдэлүүд, асуудлын талаар тогтмол тайлагнадаг.

Хүлээн зөвшөөрөх эрсдэл



Хүлээн зөвшөөрөх эрсдэл (Risk appetite) гэдэг нь Банкны нийт харилцагч, хувь нийлүүлэгчид болон ажилтнуудынхаа эрх ашгийг хамгаалах, түүнчлэн зорилтууддаа хүрэхийн тулд ТУЗ-өөс хүлээн зөвшөөрч буй эрсдэлийн төрлүүд болон тэдгээрийн хэмжээг хэлдэг. ТУЗ-өөс Банкны хүлээн зөвшөөрөх эрсдэлийн мэдэгдэл (Цаашид "ХЗЭМ" гэх)-ийг жил бүр хянаж, баталдаг. Банк ХЗЭМ-ийг хэрэгжүүлэх хүрээнд хүлээн зөвшөөрөх эрсдэлийн тогтолцоонд баримтлах зарчим, хүлээн зөвшөөрөх эрсдэлийн мэдэгдэл, мэдэгдлийн шаардлагууд болон оролцогчдын үүрэг хариуцлагыг тодорхойлж, ТУЗ-өөр батлуулсан байдаг.

Хүлээн зөвшөөрөх эрсдэлийн бодлогын хүрээнд Банк дараах зарчмуудыг баримталдаг.

- Хүлээн зөвшөөрөх эрсдэлийн талаар банкны хэмжээнд хэвтээ болон босоо шугамын дагуу харилцан мэдээлэх боломж бүхий харилцаа холбоотой байна;
- Хүлээн зөвшөөрөх эрсдэлийн банкны эрсдэлийн соёлын салшгүй нэг хэсэг болгон хэвшүүлсэн байна;
- Банкны гадаад /улс төр, эдийн засаг, хууль, нийгэм, технологи/ болон дотоод нөхцөл байдлын өөрчлөлтөөс банкны стратеги болон бизнес зорилтуудад нөлөө үзүүлэхэд банкны Хүлээн зөвшөөрөх эрсдэл нь уян хатан байдлаар өөрчлөгддөг байна;
- Хүлээн зөвшөөрөх эрсдэл нь Банкны үйл ажиллагаанд гадаад болон дотоод нөлөөгөөр учирч болзошгүй бүхий л төрлийн эрсдэлийг хамарсан байна;
- Банкны шат шатны удирдлагууд ХЗЭМ-ийн хэрэгжилтийн талаар зохих хэмжээний мэдээлэл, тайлангаар тогтмол хангагддаг байна;



2023 5 29



Хүлээн зөвшөөрөх эрсдэлийн мэдэгдлийн хэрэгжүүлэлтийг гүйцэтгэх удирдлага хариуцах бөгөөд холбогдох нийт нэгжүүдэд ХЗЭМ-ийг мөрдөж, ажиллах чиглэлийг өгдөг. Эрсдэл хариуцсан дэд захирал нь ХЗЭМ-ийн тайланг сар бүр ТУЗЭХ, ТУЗ-д тайлагнадаг.

ХААН Банк "Хамгаалалтын гурван шугам" загварыг ашиглан эрсдэлийг удирдах үүрэг хариуцлагуудыг тохиромжтой байдлаар хуваарилан эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлдэг.

Хамгаалалтын 1-р шугам: Бизнесийн чиглэлүүд болон тэдгээрийн дэмжих функцүүд

Эрсдэл хариуцагч: Өөрсдийн бизнес, үйл ажиллагаанд үүсэж болзошгүй эрсдэлүүдийг хариуцаж, тасралтгүй үр дүнтэй удирдана. Үүнд: Банкны нийт салбар, тооцооны төв, Төв банкны бизнесийн үйл ажиллагаа хариуцсан нийт газар, алба, дэмжлэг үзүүлэгч бусад газар, алба болон холбогдох үйл ажиллагааны чиглэлийн хороод багтана.

Хамгаалалтын 2-р шугам: Эрсдэлийн функц болон эрсдэлийн удирдлагад дэмжлэг үзүүлэгч функцүүд

Эрсдэлийн чиглүүлэгч: Хамгаалалтын 1-р шугамын эрсдэлийн удирдлагыг чиглүүлнэ. Эдгээр функцууд нь бодлого, журмаар хүлээсэн үүрэг хариуцлагын хүрээнд хамгаалалтын 1-р шугамын газар, нэгжүүдийн эрсдэлийн удирдлагын үйл явцуудад хяналт шалгалт, сорилт хийх эрхтэй байна. Үүнд: Эрсдэлийн удирдлага хариуцсан нэгжүүд, Төв банкны холбогдох газар, алба болон эрсдэлийн хороод багтана.

Хамгаалалтын 3-р шугам: Дотоод аудитын функц

Хараат бус баталгаажуулагч: Банкны эрсдэлийн удирдлагын тогтолцоо, эрсдэлийн засаглал, дотоод хяналтад хараат бусаар шалгалт хийж, үр дүнтэй байдлыг баталгаажуулна. Дотоод аудитын функц нь Хамгаалалтын 1 ба 2-р шугамаас хараат бусаар үүрэг хариуцлагуудаа хэрэгжүүлж, ТУЗ-д тайлагнаж ажилладаг.

Зээлийн эрсдэлийн удирдлага

Банк зээлийн эрсдэлийг "Зээлдэгч эсвэл гэрээлэгч тал нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйгээс үүсэж болзошгүй алдагдал" гэж тодорхойлон. ХААН Банк нь зээлийн эрсдэлийн удирдлагыг Эрсдэлийн удирдлагын ерөнхий бодлого, Зээлийн эрсдэлийн удирдлагын бодлого болон бусад холбогдох үйл ажиллагааны журмуудын хүрээнд хэрэгжүүлдэг. Зээлийн эрсдэлийн удирдлагын хүрээнд тухайлсан нэгж зээлийн эрсдэл болон зээлийн багцын зээлийн эрсдэлийг авч үздэг.

ТУЗ нь жил бүр зээлийн эрсдэлийн удирдлагын стратеги болон тухайн жилийн зорилго, зорилтыг агуулсан хүлээн зөвшөөрөх эрсдэлийн мэдэгдлийг баталдаг. Тус хүлээн зөвшөөрөх эрсдэлийн мэдэгдлийн хүрээнд банк дотоод лимит, хязгаарлалтуудыг тогтоож, зээлийн эрсдэлийг илрүүлэх, үнэлэх, удирдах, хянах бие даасан хараат бус тогтолцоог бүрдүүлэн ажилладаг ба Гүйцэтгэх удирдлага болон ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн хороонд гүйцэтгэлийг тайлагнан ажилладаг.

Зээлийн хороод

Банкны зээлийн хороодын бүтэц нь зээлийн багцын чанар, харилцагчийн сегмент, зээлийн хэмжээ, төрөл зэрэгт нийцүүлэн зохион байгуулагдсан байдаг. Банк зээлийг шийдвэрлэх, хяналт тавих зорилгоор дараах төрлийн зээлийн хороодыг зохион байгуулсан байдаг.

Төв банкны зээлийн хороо (ТБЗХ) нь 3 тэрбум төгрөгөөс дээш, зээлдэгчийн эрсдэлийн ангиллаас хамааран банкны өөрийн хөрөнгийн 5% хүртэлх хэмжээтэй зээл, түүнтэй адилгах саналыг хэлэлцэн шийдвэрлэнэ. Зээлдэгчдийн эрсдэлийн ангилал болон зээлийн хэмжээнээс хамааран ТУЗ-өөс хяналт тавихаар зохицуулагдсан байдаг. ТБЗХ нь доод шатны зээлийн хороодын эрхийн хэмжээг тогтоож, баталдаг.



2023 5 29



- Төв банкны зээлийн дэд хороо (ТБЗДХ) нь доод шатны зээлийн хороодын эрхийн түвшнээс давсан 3 тэрбум төгрөг хүртэлх зээлийн саналыг хэлэлцэн шийдвэрлэдэг;
- Ипотекийн орон сууцны зээлийн хороо нь нийт зээлийн саналын хэмжээ нь 500 сая төгрөг хүртэл дүнтэй ипотекийн орон сууцны зээлийн саналыг шийдвэрлэнэ;
- Улаанбаатарын салбарын зээлийн хороо нь Улаанбаатарын иргэдийн банкны харьяа салбар, нэгжүүдийн нийт зээлийн саналын хэмжээ нь 500 сая төгрөг хүртэл дүнтэй ипотекийн орон сууцны зээлээс бусад зээлийн саналыг шийдвэрлэнэ;
- Орон нутгийн салбарын зээлийн хорооны эрх нь нийт зээлийн саналын хэмжээ нь 500 сая төгрөг хүртэл дүнтэй зээлийн саналыг шийдвэрлэнэ.

Зээлийн эрсдэл хариуцсан нэгжүүд

Зээлийн эрсдэлийн удирдлага, бодлого зохицуулалт, оновчтой стратегийг хэрэгжүүлэх зорилгоор Эрсдэл хариуцсан дэд захирлын харьяанд дараах нэгжүүдийг зохион байгуулсан байдаг. Үүнд:

- Бизнесийн зээлийн эрсдэлийн газар;
- Хэрэглээний зээлийн эрсдэлийн газар;
- Зээлийн бодлого зохицуулалтын газар.

Зээлийн эрсдэлийн газруудын гол чиг үүрэг нь зээлийн эрсдэлийн бодлого, журмыг боловсруулах, эрсдэлийн мэдэгдэлд тодорхойлсон лимитүүдэд мониторинг хийх, зээлийн эрсдэлийн шинжилгээ, судалгаа хийх, тухайлсан зээлийн саналд хараат бус эрсдэлийн үнэлгээ, дүгнэлт өгөх, бизнес нэгжүүдэд эрсдэлийн удирдлагын заавар, зөвлөмж өгөх, холбогдох сургалтыг зохион байгуулах юм.

Бизнесийн зээлийн эрсдэлийн газар:

- Томоохон (материаллаг) хэмжээтэй тухайлсан зээлийн эрсдэлийг үнэлэх, тодорхойлох, шийдвэр гаргалтанд оролцох;
- Хүлээн зөвшөөрөх эрсдэлийн мэдэгдлийн хүрээнд эрсдэл бүхий зээлийн үйл ажиллагаа болон бизнесийн зээлийн багцад тогтмол хяналт тавих, Гүйцэтгэх удирдлага болон Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх эрсдэлийн хороо (ТУЗЭХ)-нд тогтмол тайлагнах;
- Эрт илрүүлэлтийн системийг хэрэгжүүлэн "Анхаарах" зээлийг тодорхойлж, арга хэмжээ төлөвлөх, "Анхаарах" зээлийн багцад тогтмол хяналт тавих;
- Байгууллагын банкны болон өндөр дүнтэй жижиг дунд бизнесийн зээлүүдийн хувьд олголтын өмнөх хяналтыг хэрэгжүүлэх;
- Зээлийн эрсдэлийн үнэлгээний системийн хөгжүүлэлт, сайжруулалтыг хийх, хяналт тавих;
- Чанаргүй зээлийг бууруулах стратеги боловсруулах холбогдох арга хэмжээнүүдийг авч ажиллах;
- Зээлийн эрсдэлийн санг Монголбанкны "Активын ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам" болон СТОУС 9-н дагуу тооцоолж байгуулах;
- Олон улсын зээлдүүлэгч байгууллагуудаас тавигдсан зээлийн багцын чанартай холбоотой харьцаа үзүүлэлтэд хяналт тавих, тайлагнах;
- Барьцаа хөрөнгийн болон барилгын төслийн үнэлгээг хийх, хяналт тавих, үл хөдлөх хөрөнгө, орон сууц, хашаа байшингийн жишиг үнэлгээг тогтоох, тогтмол шинэчлэх;
- Бизнесийн нэгжүүдэд бизнесийн зээлийн эрсдэлийн удирдлагын чиглэлээр сургалт, зөвлөгөө өгөх, эрсдэлийн соёлыг төлөвшүүлэх;

Хэрэглээний зээлийн эрсдэлийн газар:

- Иргэдийн зээлийн багцын чанарт нөлөөлөгч хүчин зүйлсийг тодорхойлж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, багцын эрсдэлийг хүлээн зөвшөөрөх түвшинд барьж ажиллахад дэмжлэг үзүүлэх;
- Иргэдийн зээлийн багцын зээлийн хяналт болон төлүүлэх үйл ажиллагааны стратеги чиглэлд баримтлах зарчмуудыг тодорхойлох, тэдгээрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дэмжиж ажиллах;





- Иргэдийн зээлийн багц, түүний эрсдэлтэй холбоотой үйл ажиллагааг сайжруулах, шаардлагатай заавар, зөвлөмжөөр хангах, холбогдох нэгжүүдтэй хамтран ажиллах;
- Тухайлсан бүтээгдэхүүн, үйл ажиллагааны журмын хүрээнд зээлийн шийдвэр гаргалт болон хяналтын үйл явцад оролцох;
- Иргэдийн зээлийн багцын чанар, эрсдэл, скоринг, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, чанарыг сайжруулах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ боловсруулах;
- Хэрэглээний зээлийн эрсдэлийн удирдлагад шаардлагатай өгөгдлийг олборлох, мэдээ тайлан бэлтгэх, Behavioral Scoring болон Application Scoring үнэлгээ, бусад шаардлагатай үнэлгээ загварчлалыг боловсруулах, сайжруулах, тэдгээртэй холбоотой зохицуулалт хийх;

Зээлийн бодлого зохицуулалтын газар:

- Зээлийн бодлого, зээлийн бүтээгдэхүүний журам болон үйл ажиллагааны журмыг боловсруулах, хөгжүүлэх;
- Гуравдагч этгээдтэй төслийн болон ногоон зээлийн бүтээгдэхүүнээр хамтран ажиллах, үйл ажиллагааг зохицуулах;
- Зээлийн процессийн автоматжуулалтын төслүүд, зээлийн программын хөгжүүлэлт, сайжруулалтыг хариуцан ажиллах;
- Лизингийн бүтээгдэхүүнтэй холбоотой үйл ажиллагаа, харилцааг зохицуулах;
- Зээлээр баталгаажсан бондын хоёрдогч шинжилгээ хийх болон багц худалдах, худалдсан багцад үйлчилгээ үзүүлэх, холбогдох нэгж газартай хамтран ажиллах;
- Зах зээл, өрсөлдөөний судалгаа хийх, зээлийн бүтээгдэхүүний үнэ болон бусад нөхцөлийг хариуцан ажиллах;

Зээлийн эрсдэлийн удирдлагын арга хэрэгсэл

Банк нь зээлийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэхдээ иргэдийн хэрэглээний зээл болон бизнесийн зээл гэсэн бүтээгдэхүүний төрөл, зориулалтад суурилсан арга хэрэгслийг ашигладаг.

Иргэдийн зээлд бүх төрлийн хэрэглээний зээл, орон сууцны зээл, малчдын зээл, хөдөө аж ахуйн зээл болон бага дүнтэй бизнесийн зээлийг багтаан авч үздэг.

- Банк нь иргэдийн зээлийн шийдвэр гаргалт болон багцын эрсдэлийн удирдлага, хяналтад Application scoring (2015 оноос хойш), Behavioral Scoring (2020 оноос хойш), Зээлийн түүхийн үнэлгээ (2012 оноос хойш), Flow rate (2018 оноос хойш), New volume quality (2018 оноос хойш) зэрэг үнэлгээний загвар, аргачлалуудыг ашиглаж байна.
- Иргэдийн зээлийн багцын хувьд бүтээгдэхүүн тус бүрээр чанарын үзүүлэлтүүдийг тогтмол хянаж, анхааруулах дохио үзүүлэлт илэрсэн тохиолдол тухай бүрт үнэлэлт дүгнэлт гарган шаардлагатай арга хэмжээг авах байдлаар зээлийн багцын эрсдэлийг удирдан ажиллаж байна.
- Банк “Зан төлөвийн үнэлгээ” /“Behavioral scoring”/-г шинээр хөгжүүлэн, 2020 оны 8 дугаар сараас эхлэн хэрэглээний зээл болон бага дүнтэй бизнесийн зээлийн шийдвэр гаргалт, багцын чанарын удирдлагад ашиглаж эхэлсэн. Behavioral scoring /“BS”/ нь банкны бүх харилцагч иргэдийн санхүүгийн зан төлөвийн үнэлгээг бүрэн автоматжуулсан байдлаар тогтмол шинэчилдгээрээ гол онцлог, давуу тал бүхий эрсдэлийн үнэлгээний загвар юм. Энэхүү загварыг машин сургалт ашиглан тогтмол сайжруулан ажиллаж байна.
- Иргэдийн зээлийн шийдвэр гаргалтыг AS үнэлгээ, BS үнэлгээ болон Зээлийн түүхийн үнэлгээг ашиглан автоматаар, эсвэл зээлийн хороогоор хэлэлцэх замаар тухайн зээлдэгчийн эрсдэлийн үнэлгээний оноонууд, орлогын төрөл, бүтээгдэхүүний онцлогоос хамааруулан шийдвэрлэж, тэдгээрт тохирсон үнийн бодлого, эрсдэлийн бодлогыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлтэй ажиллах, салбар болон газар, нэгжүүдийг нэгдсэн мэдээллээр хангах зорилгоор “Debt collection” программ, цэсийг банк дотоодын эрсдэлийн удирдлагын системдээ ашиглаж байна.



2023 5 29



- Бизнесийн зээлд иргэдийн бага дүнтэй бизнесийн зээлээс бусад бүх төрлийн бизнесийн зээлийн бүтээгдэхүүнийг авч үздэг.
- Бизнесийн зээлийн шийдвэр гаргалт болон зээлийн эрсдэлийн удирдлагад Risk rating үнэлгээний загварыг 2008 оноос эхлэн хэрэгжүүлж байгаа бөгөөд Frankfurt school-ээс авсан зөвлөх үйлчилгээний хүрээнд тус үнэлгээний загварыг 2020 онд сайжруулан ашиглаж байна. Загвар нь зээлдэгчийн болон тухайлсан зээлийн үнэлгээг тодорхойлон ажилладаг.
- Бизнесийн зээлийн багцын хувьд онцгой, эрсдэл өндөртэй бизнес сектор тус бүрээр багцын лимитүүдийг тогтоон хянаж, багцын төвлөрлийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлж байна.

Зээлийн эрсдэлийг хянах болон тайлагнах систем

ТУЗЭХ болон ТБЗЭХ-нд сар бүр банкны зээлийн эрсдэлийн лимитүүдийн гүйцэтгэл, хяналтуудыг агуулсан иж бүрэн тайланг бэлтгэн хүргүүлдэг ба шаардлагатай тохиолдолд холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлдэг.

ХААН Банк нь зээл олгосны дараах процесст зээлийн чанар муудах, үүсч болзошгүй зээлийн эрсдэлийг эрт илрүүлэх, эрсдэлээс урьдчилан сэрэмжлүүлэх арга хэмжээ авах, хянах үйл ажиллагааг доорх 2 системийн хүрээнд хийж байна.

- Эрт илрүүлэх систем. 500 сая төгрөгөөс дээш бизнесийн зээлийн үлдэгдэлтэй харилцагчийн бизнесийн үйл ажиллагаанд илрэх эрсдэлийн дохио үзүүлэлтийг нэгж зээлийн болон багцын түвшинд тодорхойлж, асуудалтай болон асуудал үүсч болзошгүй зээлийг "Анхаарах" жагсаалтад бүртгэдэг. Бизнесийн зээлийн эрсдэлийн газраас энэхүү жагсаалтад хяналт тавьж, холбогдох арга хэмжээг төлөвлөх, гүйцэтгэлийг хянах замаар эрсдэлийг бууруулан ажилладаг. Эрт илрүүлэлтийн системийн үйл ажиллагааны тайланг сар бүр ТБЗЭХ-нд тайлагнадаг.
- Зээлийн давтамжит хяналтын систем. Байгууллага болон иргэнд олгосон 500 сая төгрөгөөс дээш бүх төрлийн бизнесийн зээлийн үлдэгдэлтэй харилцагчдад санхүүгийн болон санхүүгийн бус хяналтыг хариуцсан нэгж жилд хамгийн багадаа нэг удаа хийж холбогдох эрсдэлийн хороонд танилцуулж "Анхаарах" зээлүүдийг тодорхойлох, арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах, давтамжит хяналтын нэгдсэн үр дүнг хагас жил тутам ТУЗДЭХ-нд тайлагнана.

Зээлийн төвлөрлийн эрсдэл, хяналт

Ижил төрлийн газар зүйн бүс болон эдийн засгийн нэг салбарт бизнес эрхэлдэг харилцагчдын үйл ажиллагаанд улс төр, эдийн засаг болон бусад аливаа өөрчлөлт гарахад тэдгээрт ижил маягаар нөлөөлөхөөр байвал төвлөрлийн эрсдэлийг авч үздэг.

Зээлийн эрсдэлийн хэт төвлөрлөөс зайлсхийх үүднээс Банк өөрийн бодлого болон журмаараа зээлийн багцад эрсдэлийг тараан байршуулдаг. Банк нь зээлийн өргөдлийг нарийн судлах, эрсдэлийн түвшинд суурилсан хүүгийн хувь хэмжээг тогтоох, төвлөрлийн эрсдэлийг удирдах үүднээс нэг зээлдэгч, эдийн засгийн салбар зэрэг үзүүлэлтээр зээлийн багцад лимит тогтоох, түүнд хяналт тавих зэргээр зээлийн багцын эрсдэлийг хянаж удирддаг. Банкны тухай хуульд заасны дагуу Банк дараах хязгаарлалтыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах үүрэг хүлээдэг. Үүнд:

- Нэг зээлдэгч, түүнд холбогдох этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад активын нийт өөрийн хөрөнгөнд эзлэх хувь $\leq 20\%$;
- Банк холбогдох этгээдэд олгосон зээлийн хэмжээ болон зээлтэй адилтгах бусад хөрөнгийн дүн нь Банкны өөрийн хөрөнгийн 5%-иас, тэдгээрийн нийлбэр дүн нь өөрийн хөрөнгийн 20%-иас тус тус хэтрэхгүй;
- Нийт томоохон зээлдэгчдэд олгох активын нийлбэр нь банкны өөрийн хөрөнгийн 300%-иас тус тус хэтрэхгүй байхаар зохицуулсан байдаг.

Мөн банк нь банкны тухай хуульд заасан дээрх хязгаарлалтуудаас гадна эдийн засгийн салбарын төвлөрөлтэй холбоотой дараах дотоод хязгаарлалтуудын тогтоон мөрдөн ажиллаж байна. Үүнд:



2023 5 29

- Нийт өөрийн хөрөнгөтэй харьцуулсан банкны нэг зээлдэгчид олгох зээлийн дээд хэмжээг 10%-иас хэтрүүлэхгүй байх;
- Уул уурхайн салбарт олгосон зээлийн багцыг банкны нийт зээлийн багцын 10%-иас хэтрүүлэхгүй байх;
- Барилгын салбарт олгосон зээлийн багцыг банкны нийт зээлийн багцын 10%-иас хэтрүүлэхгүй байх;
- Газар тариалангийн салбарт олгосон зээлийн багцыг банкны нийт зээлийн багцын 5%-иас хэтрүүлэхгүй байх;
- Ханшийн эрсдэлээс хамгаалагдаагүй гадаад валютын зээлийн багцыг банкны нийт зээлийн багцын 5%-иас хэтрүүлэхгүй байх;
- Шатахууны импорт, худалдааны салбарт олгосон зээлийн багцыг банкны нийт зээлийн багцын 7.5%-иас хэтрүүлэхгүй байх.

Стресс тест

Банк нь зээлийн багцын түүхэн мэдээллийн сан дээр үндэслэн эконометрикийн арга хэрэгсэл ашиглах замаар зээлийн эрсдэлийн стресс тестийг тогтмол хийж гүйцэтгэдэг. Үүнд голлох макро индикаторууд, мөн эдийн засгийн салбар тус бүрийн зээлийн багцын үл төлөгдөх магадлалын тоон мэдээллүүдийг ашигладаг.

Аргачлалын хувьд зээлийн багцын чанарыг илэрхийлэх гол үзүүлэлтүүдийг макро эдийн засгийн тайлбарлагч хувьсагчуудаас хамааруулан корреляцын коэффициентийг тооцож, өндөр хувьтай нөлөөлж буй хувьсагчуудыг тайлбарлагч хувьсагчаар сонгодог. Макро эдийн засгийн тайлбарлагч хувьсагчуудыг ашиглан макро эдийн засгийн орчныг илэрхийлэх индикатор боловсруулсан бөгөөд түүхэн хугацааны тархалтын мэдээллийг ашиглан стресс нөхцөлийн шалгуур үзүүлэлтийг тодорхойлон авч үздэг. Макро индикаторын ирээдүйн сценари хувилбаруудад зээлийн багцын үл төлөгдөх магадлал ямар түвшинд байхыг түүхэн хугацааны цувааны регрессийн загварт үндэслэн гаргадаг.

Хөрвөх чадварын эрсдэлийн удирдлага

ХААН Банк нь хөрвөх чадварын эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны хүрээнд Монголбанк болон олон улсын санхүүгийн байгууллагуудын зүгээс тавьсан шалгуур үзүүлэлтүүдийг ханган ажиллахын зэрэгцээ нэгдсэн эрсдэлийн удирдлагын тогтолцоог мөрдлөг болгон ажиллаж байна. Энэхүү тогтолцооны дагуу тус эрсдэлийг Актив пассивын удирдлагын хороо хариуцдаг ба тухайн жил мөрдөгдөх хүлээн зөвшөөрөх эрсдэлийн мэдэгдэл, стратеги болон бодлогын баримт бичгийг баталснаар холбогдох газар нэгжүүд хамтран хяналт, удирдлагыг өдөр тутамдаа хэрэгжүүлж ажилладаг. Хөрвөх чадварын эрсдэлийн удирдлагыг сайжруулах, үр нөлөөг нэмэгдүүлэхийн тулд мөнгөний захын хэрэгслүүдийн арилжааны лимитүүдийг 6 сар тутам шинэчлэн баталдаг. Мөн онцгой нөхцөл байдлын үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, стресс тест болон мэдрэмжийн шинжилгээг тодорхой хугацааны давтамжтайгаар тайлагнадаг. Түүнчлэн Актив пассивын удирдлагын хороо нь долоо хоног тутам хуралдаж хяналтыг хэрэгжүүлдэг.

Хөрвөх чадварын болзошгүй эрсдэлд бэлэн байхын тулд хөрвөх чадварын харьцааны түвшнүүдийг тодорхойлж, нөөц хэмжээг бий болгон тухай бүр авч хэрэгжүүлэх арга хэмжээг баталсан байдаг. Үүнээс гадна эрсдэлийг цогцоор нь цаг тухайд нь үнэн зөв хэмжих тайлагналын системийг бий болгож тогтмол мэдээлдэг.

Эрсдэлийн хяналтын хувьд зохицуулагч байгууллага болох Монголбанкаас шаарддаг зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийн нэг болох Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа (ТТГЧХ) болон харилцагч олон улсын байгууллагуудаас шаарддаг Базел III стандартын хөрвөх чадвартай холбоотой гол харьцаа үзүүлэлтүүд болох Хөрвөх чадварыг хангах харьцаа (LCR) болон Цэвэр галтвортой санхүүжилтийн харьцаа (NSFR) зохистой түвшинд ханган ажилладаг.



Зах зээлийн эрсдэлийн удирдлага

Зах зээлийн эрсдэл гэдэг нь хүү, гадаад валютын ханш болон үнийн өөрчлөлт зэрэг зах зээлийн хувьсагчдын өөрчлөлтөөс шалтгаалан банкны эзэмшиж буй санхүүгийн хэрэглүүрүүдийн бодит үнэ цэнэ эсвэл ирээдүйн мөнгөн урсгал хэлбэлзэх эрсдэлийг хэлнэ. Банк нь бизнес төлөвлөгөө ба стратеги зорилгын хүрээнд жил тутам хүлээн зөвшөөрөх эрсдэлийн мэдэгдлийг ТУЗ-өөр хянан батлуулж, түүний хүрээнд зах зээлийн эрсдэлийн дотоод хязгаарлалтуудыг тогтоож, хэмжиж, хяналт тавьж удирддаг.

Гадаад валютын эрсдэлийн тоон ба чанарын шинжилгээ

Банк нь гадаад валютын ханшийн хэлбэлзлээс үүсэж болзошгүй алдагдлыг банкны эрсдэл даах чадвартай нь уялдуулах зорилгоор тухайн нэг болон нийт гадаад валютын позицид тогтоосон Монголбанкны хязгаарлалтуудыг мөрдөж ажиллахын зэрэгцээ "Хамгийн их эрсдэлийн арга-ХИЭА", мэдрэмтгий байдлын шинжилгээ, стресс тестийн шинжилгээ зэрэг дотоод үнэлгээний аргачлалуудыг ашиглан эрсдэлээ хэмжиж, удирддаг. ХИЭ аргачлал нь Базелийн хорооноос тодорхойлсон загварын үнэлгээнд тавигдах шаардлагуудын дагуу ханшийн хэлбэлзлийн үнэлгээний загварууд, тэдгээрийн үнэлгээний чанарыг бодит мэдээлэлтэй харьцуулах замаар тодорхойлдог буцаан шалгалтын аргачлалуудад суурилдаг.

Банкны өөрийн хөгжүүлсэн "VaR" программ хангамж нь өдөр тутмын ханшийн хэлбэлзлийг вариаци-ковариаци, түүхэн эх үүсвэр болон хүлээгдэж буй алдагдлын загваруудаар үнэлэх, мөн багцын ХИЭ-ийн хэрэгслүүдийг тооцох, дотоод лимитийн хэрэгжилтийг өдөр тутам хянах боломжийг олгодог. Банк нь гадаад валютын эрсдэлийг тооцох дотоод программ хангамжид эрсдэлийн үнэлгээний найдвартай, үнэн зөв байдлын хүрээнд загварууд болон буцаан шалгах аргачлалуудыг өргөтгөх, удирдлагын мэдээллийн системийн чанарыг сайжруулах зэргээр тасралтгүй хөгжүүлэлтийг хийдэг.

Түүнчлэн гадаад валютын захад тогтворгүй байдал үүссэн үед банкны авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулахын зэрэгцээ гадаад валютын ханшийн эрсдэлийн стресс тестийг улирал тутам хийж банкны санхүүгийн байдалд үзүүлэх материаллаг сөрөг нөлөөллийг тодорхойлж байна. Гадаад валютын ханшийн эрсдэлийн стресс тестийн сценарийг сонгохдоо макро эдийн засгийн эрсдэлийн үүсэж болзошгүй үйл явдлын итгэлцүүрээс хамааруулан доорх 3 төрлийн аргачлалаас сценари сонголтыг хийдэг. Үүнд:

- Түүхэн үйл явдалд суурилсан;
- Стресс бүхий ХИЭ арга;
- Экстрем утгын онол.

Тоон шинжилгээний аргачлалуудаас гадна банкны үйл ажиллагаанд тавигдах хуулийн хязгаарлалтын хүрээнд банк нь гадаад валютын активын чанарт төвлөрч харилцагч талуудын зээлийн эрсдэлийн түвшингээс хамааруулан дотоод лимитийг тогтоосноор валют арилжааны үйл ажиллагаанд үүсэж болзошгүй төлбөр тооцооны эрсдэл болон харилцагч талын зээлийн эрсдэлийг бууруулах арга хэмжээг авдаг. Харилцагч банкны зээлийн эрсдэлийн үнэлгээний аргачлал нь олон улсын үнэлгээний байгууллагаас гаргасан зээлжих зэрэглэлийн үнэлгээний загвар, шилдэг туршлагад суурилан тухайн банкны үйл ажиллагаа явуулж буй улсын макро орчны шинжилгээ, санхүүгийн шинжилгээ, чанарын тохируулга зэргийг авч үздэг.

Хүүгийн эрсдэлийн тоон ба чанарын шинжилгээ

Банк нь үр ашигтай хүүгийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх зорилгын хүрээнд Базелийн хорооноос гаргасан хүүгийн эрсдэлийг хэмжих зөвлөмжүүдийг баримталдаг. Банкны бүртгэл дэх хүүгийн эрсдэлийг хэмжихдээ статик дахин үнэлгээний зөрүүний аргачлалын дагуу хүүгийн мэдрэмжтэй хөрөнгө, өр төлбөр болон балансын гадуурх үзүүлэлтүүдийг тогтмол хүүтэй бол эргэн төлөгдөх хугацааны дагуу хувьсах хүүтэй бол дараагийн дахин үнэлгээний хугацааны дагуу тогтоосон хугацааны ангиллуудад хуваарилан глобал хүүгийн шокийн сценариудын үр дүнд банкны төлөвлөсөн цэвэр хүүгийн орлого болон өөрийн

хөрөнгийн эдийн засгийн үнэ цэнд үзүүлэх нөлөөг тооцдог. Гэхдээ доорх нуугдмал сонголттой хөрөнгө, өр төлбөр болон балансын гадуурх үзүүлэлтүүдийн онцлог шинж, бүтээгдэхүүний нөхцөл, түүхэн мэдээлэлд тулгуурлан стандарт аргачлал ба тогтоосон стандарт параметруудийг ашиглан мөнгөн урсгалыг загварчлан хүүгийн түвшний өөрчлөлтөд үзүүлэх нөлөөллийг тооцдог. Үүнд:

- Урт хугацаатай, тогтмол хүүтэй урьдчилгаа төлөлтийн эрсдэл өндөртэй зээлийн багц;
- Кредит карт ба бусад зээлийн шугамын ашиглалт;
- Харилцах болон хугацаагүй хадгаламжийн тогтвортой ба тогтворгүй хэсэг;

Түүнчлэн хүүгийн түвшний өөрчлөлтөөс шалтгаалан арилжааны зорилгоор эзэмшиж буй хөрөнгийн зах зээлийн үнэлгээ буурснаас үүсэх үнийн эрсдэлийг арилжааны бүртгэл дэх хүүгийн эрсдэлийн хүрээнд хэмжиж, удирдаж байна. Тухайн эрсдэлийг Базелийн хорооны арилжааны бүртгэлийн стандарт үнэлгээний аргачлалын дагуу ерөнхий хүүгийн эрсдэл болон credit spread-ийн эрсдэлийн үзүүлэлтүүдээс хамааруулан тооцоолдог. Банк нь олон улсын санхүүгийн зээлдүүлэгч байгууллагуудтай байгуулсан хоёр талын гэрээнд тусгагдсан санхүүгийн эрсдэлийн харьцаа үзүүлэлтийн шаардлагуудын хүрээнд дахин үнэлгээний зөрүүний харьцаа үзүүлэлтийн хязгаарлалтыг мөн хангаж ажиллаж байна. Түүнчлэн банк нь өөрийн эрсдэл даах чадварыг үнэлэх, цаашлаад том хэмжээний гэнэтийн өөрчлөлтөөс учирч болзошгүй алдагдлыг тэсвэрлэх, хангалттай хэмжээний өөрийн хөрөнгө ба төлбөрийн чадвартай эсэхийг тодорхойлох, хүндрэлийг даван туулах шаардлагатай нөөцийг бүрдүүлэх, онцгой нөхцөл байдлын үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний үр ашигтай байдлыг нэмэгдүүлэх зорилгоор Монголбанкны зохицуулалтын шаардлагад авч үздэггүй материаллаг гэж үзсэн зах зээлийн эрсдэлүүдийг хэмжиж, тогтмол хяналт тавьж ажилладаг.

Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлага

Банк нь Үйл ажиллагааны эрсдэлийг Банкны дотоод үйл ажиллагааны тохиромжгүй, доголдолтой байдал, хувь хүн болон гадаад хүчин зүйлсийн улмаас банкны стратеги болон зорилтод нөлөө үзүүлэх үйл явдал гэж тодорхойлдог. Үйл ажиллагааны эрсдэлд дараах дэд ангиллууд багтдаг:

- Дотоод залилан;
- Гадаад залилан;
- Хөдөлмөрийн харилцаа болон ажлын байрны аюулгүй байдал;
- Бүтээгдэхүүн үйлчилгээ болон бизнесийн үйл ажиллагааны алдаа дутагдал;
- Биет эд хөрөнгийн эвдрэл гэмтэл;
- Бизнесийн тасалдал;
- Гүйцэтгэл, нэвтрүүлэлт болон процессын удирдлагын алдаа дутагдал.

ТУЗ банкны үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагыг ерөнхий байдлаар хариуцдаг бол Эрсдэл хариуцсан дэд захирал өдөр тутмын банкны үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагыг удирдан чиглүүлдэг.

ХААН Банк Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагыг үр дүнтэй хэрэгжүүлэх үүднээс үйл ажиллагааны эрсдэлийг удирдах бодлого, журам, арга хэрэгслүүдийг олон улсын стандарт, жишигт нийцүүлж батлуулан банкны өдөр тутмын үйл ажиллагаа болон шийдвэр гаргалтад хэрэгжүүлэн ажилладаг. Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагад GRC систем дэмжлэг үзүүлдэг бөгөөд энэ нь эрсдэлийн мэдээллийн ил тод байдлыг хангаж тухай бүр тайлагнах боломжийг олгодог. Үйл ажиллагааны эрсдэлийн аргачлалд Нэгжийн эрсдэлийн самбар (unit risk dashboard), Эрсдэл ба хяналтын бие даасан үнэлгээ (RCSA), Алдагдлын мэдээллийн сан (Loss database) болон Асуудлын удирдлага (Issue management) зэрэг багтдаг.

Дотоод хяналтын тогтолцоо

Банк олон улсын сайн туршлагад суурилан Дотоод хяналтын бодлогыг баталж, банкны бүх түвшинд хэрэгжүүлдэг. Дотоод хяналтын бодлогын зорилго нь дотоод хяналтын тогтолцооны бүрэлдэхүүн хэсгүүд тэдгээрт баримтлах зарчим, оролцогч талуудын үүрэг хариуцлагыг тодорхойлж, үр дүнтэй хяналтын



тогтолцоог бүрдүүлэн, банкны үйл ажиллагааны, нийцлийн, комплаесын зорилтуудыг үр дүнтэй биелүүлэх юм. Дотоод хяналтын бодлого нь дараах бүрэлдэхүүн хэсгээс бүрдэнэ.

- Өдөр Хяналтын орчин
- Эрсдэлийн үнэлгээ
- Хяналтын үйл ажиллагаа
- Мониторинг
- Мэдээлэл харилцаа холбоо

Дээрх 5 бүрэлдэхүүн хэсэг 17 зарчмын хүрээнд банкны бүх түвшинд дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэн ажилладаг.

Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн удирдлага

ХААН Банк нь бизнесийн үйл ажиллагаа болон мэдээллийн технологид нөлөө үзүүлж буй мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийг хамгийн бага түвшинд удирдаж ажилладаг. Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийг системтэйгээр тодорхойлох, дүн шинжилгээ хийх, үнэлэх, арга хэмжээ авах болон эрсдэлийг тайлагнах зорилгоор банк нь ISO 31000 (Эрсдэлийн удирдлагын зарчмууд ба зааварчилгаа) болон ISO 27005 (Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн удирдлага) зэрэг стандартуудын дагуу олон улсад шалгарсан онол, арга барилыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлдэг.

Банк нь мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог ISO 27001:2013 стандартын дагуу үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажилладаг бөгөөд тус стандарт нь мэдээллийн хөрөнгийн аюулгүй байдлыг хангаж ажиллахад чиглэгдсэн, эрсдэлд суурилсан олон улсын мэдээллийн аюулгүй байдлын стандарт юм. Банк нь мэдээллийн хөрөнгийн сул талыг ашиглан түүний нууцлал, бүрэн бүтэн, хүртээмжтэй байдал алдагдсанаар хохирол хүлээх эрсдэлийг үр дүнтэй удирдахаар Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн дэд хороог тогтмол зохион байгуулж ажилладаг. Цахим аюулгүй байдлын газар нь Төв банкны газар, албадуудад, Улаанбаатар болон орон нутгийн салбар, тооцооны төвүүдэд үйл ажиллагааны хүрээнд гарч болзошгүй Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийг тодорхойлох, үнэлэх ажлыг гүйцэтгэдэг ба Мэдээллийн аюулгүй байдлын дэд хорооны самбарт бүртгэгддэг.

Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн дэд хороо нь ХААН Банкны Эрсдэлийн удирдлагын ерөнхий бодлого, Санхүүгийн бус эрсдэлийн удирдлагын бодлогын дагуу банкны Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн удирдлагын тогтолцоо болон эрсдэлийн удирдлагын үйл явцад тогтмол хяналт тавьж ажилладаг бөгөөд Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлүүдийг тодорхойлох, үнэлэх, үр дүнтэй удирдах байдлаар авах арга хэмжээ, стратегийг хэлэлцэж шийдвэрлэх зорилготой. Банк нь Мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны, Төлбөрийн картын аюулгүй байдлын олон улсын стандартуудын шаардлага болон мэдээллийн аюулгүй байдлын бодлого, журмын дагуу дотоод хэрэгжилтийн шалгалтыг тогтмол хийж гүйцэтгэдэг.

Хууль, Комплаенсийн эрсдэлийн удирдлага

Хуулийн эрсдэлийн удирдлага

Банкны хуулийн эрсдэл гэдэгт Монгол Улсын хууль тогтоомж, төрийн эрх бүхий байгууллагын баталсан дүрэм, журам, заавар, стандартыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллаагүй, банкны хэмжээнд хүчин төгөлдөр гэрээнүүдэд шинээр батлагдсан хууль тогтоомж болон хуульд нэмэлт өөрчлөлт орсон даруйд холбогдох өөрчлөлтүүдийг оруулаагүй, мөн түүнчлэн банк аливаа маргааныг шүүхээр хянан шийдвэрлүүлэх нөхцөл үүсэх явдлыг ойлгоно.

Хууль, эрх зүйн эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, арга хэмжээ авах, хянах, тайлагнах үйл явцыг Санхүүгийн бус эрсдэлийн удирдлагын бодлогын дагуу хэрэгжүүлдэг. Хууль, эрх зүйн эрсдэлийг ач холбогдлын түвшнээр нь эрэмбэлж, өндөр түвшний болон хүлээн зөвшөөрөх лимит зөрчилдсэн эрсдэлийг талаарх мэдээллийг эрх бүхий хороодод танилцуулж, холбогдох шийдвэрүүдийг гаргуулдаг. Хууль, эрх зүйн



2023 5 29



эрсдэлтэй холбоотой тайлан, мэдээг Үйл ажиллагааны эрсдэлийн дэд хороо, Эрсдэлийн удирдлагын хороонд тайлагнадаг.

Банкны хувьд хууль зүйн эрсдэл үүсэхээс урьдчилан сэргийлэх, бууруулах зорилгоор дараах эрсдэлийн удирдлагыг өдөр тутамдаа хэрэгжүүлэн ажиллаж байна:

- Гэрээ болон бодлого, журмын хяналт - хууль тогтоомжийн өөрчлөлт шинэчлэлт, банкны эрх бүхий этгээдийн шийдвэртэй уялдуулан банкны стандарт болон стандарт бус гэрээ, бодлого, журам, бусад эрх зүйн актыг хянаж хуульд нийцүүлэх;
- Хууль, тогтоомжийн шинэчлэл, нэмэлт өөрчлөлтийн талаарх мэдээллийг тухай бүр авах, банкны эрх ашгийг хөндсөн, банкны үйл ажиллагаанд хамааралтай хууль, тогтоомжийн төсөлд санал өгч тусгуулах, тухайн нэмэлт өөрчлөлтийн талаар судалгаа хийж, банкны үйл ажиллагааг түүнд нийцүүлэх талаар бэлтгэл хангах;
- Шүүхийн болон шүүхийн бус журмаар банкны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалж, хэрэг маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох ба ямар шалтгаан нөхцөлөөс үүдэн маргаан үүсч байгаа талаар судалгаа хийж, тухайн төрлийн маргаан дахин үүсэхээс урьдчилан сэргийлэх талаар шаардлагатай арга хэмжээг тухай бүр авч хэрэгжүүлэх.

Комплаенсийн эрсдэлийн удирдлага

Комплаенсийн эрсдэл гэж Банкны хэмжээнд Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх (МУТСТ)-тэй холбоотой хууль тогтоомж, дүрэм, журам болон банкны дотоод ёс зүйн дүрмийг дагаж мөрдөөгүйн улмаас хуулийн дагуу эрх бүхий зохицуулагч байгууллагаас өндөр дүнтэй торгууль ногдуулах, их хэмжээний санхүүгийн алдагдалд орох, банкны нэр хүнд унах зэргийг комплаенсийн эрсдэл гэж ойлгоно. ХААН Банкны комплаенсийн эрсдэлийн удирдлагын зорилго нь комплаенсийн эрсдэлийн удирдлагын үр дүнтэй механизмыг бий болгох замаар эрсдэлийг үр дүнтэй тодорхойлох, үнэлэх, урьдчилан сэргийлэх, шийдвэрлэх арга хэмжээ авах, улмаар банкны хэмжээнд холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулахад оршдог бөгөөд ингэхдээ ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагын эрх, үүрэг, хариуцлагыг оновчтой тодорхойлон, комплаенсийн эрсдэлийг өндөр түвшинд үр дүнтэй удирдаж, хяналт тавьдаг.

ХААН Банкны ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагын зүгээс банкны хэмжээнд дагаж мөрдөх комплаенсийн дотоод хяналтын хөтөлбөр, холбогдох бодлого, журмыг хянаж, баталдаг. Төлөөлөн удирдах зөвлөлөөс комплаенсийн эрсдэлийн удирдлагын өдөр тутмын хяналтыг хэрэгжүүлэх эрхийг Гүйцэтгэх удирдлагад олгох бөгөөд гүйцэтгэх удирдлагын зүгээс комплаенсийн эрсдэлтэй холбоотой үүссэн асуудал, тайлантай танилцаж, аливаа зөрчил дутагдлыг нэн даруй арилгах үүрэг даалгавар, чиглэлийг өгч, хяналт тавин ажилладаг. Банкны газар нэгжийн захирал, ахлах ажилтнууд нь комплаенсийн бодлого, журмыг нийт ажилтнуудад түгээн, хэрэгжилтэд хяналт тавих үүрэгтэй.

ХААН Банкны Гүйцэтгэх захирал нь комплаенс хариуцсан захирлыг томилж, Комплаенсийн газрын чиг үүрэг, зохион байгуулалтын бүтцийг тодорхойлж, чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөц, технологи, программ хангамж, нөхцөл боломжийг бүрдүүлж, комплаенсийн ажилтнуудын хараат бус байдлыг ханган ажилладаг.

Мөнгө угаахтай тэмцэх үйл ажиллагаа

Монгол Улс нь Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (FATF)-ын Ази Номхон далайн бүс нутаг хариуцсан бүлэг (APG)-ийн гишүүн бөгөөд Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үндэсний хууль тогтоомжийн зохицуулалт бүхий тогтолцоотой юм. Монголбанкны дэргэдэх Санхүүгийн мэдээллийн алба нь Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан стандарт, дүрэм, журмын хэрэгжилтэд хяналт тавин ажилладаг.

2023 5 29 I

ХААН Банк нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх (МУТСТ) олон улсын тэргүүн туршлага, стандартыг үйл ажиллагаандаа нэвтрүүлж, санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр дотооддоо түүнээс манлайлж ажилладаг бөгөөд банкны нийт удирдлага, ажилтнууд нь харилцагчаа төдийгүй санхүүгийн тогтолцооны бүрэн бүтэн байдлыг хамгаалах үүргээ ухамсарласан байдаг.

ХААН Банк нь МУТСТ стандарт шаардлага, хууль тогтоомжид нийцүүлэн дотоод бодлого, журмаа боловсруулан баталж, мөрдлөг болгон ажилладаг. МУТС эрсдэлийг удирдах, хяналтыг хэрэгжүүлэхтэй холбоотой банкны дотоод бодлого, журмуудаас дурдвал "Мөнгө угаах болон санхүүгийн гэмт хэргийн эсрэг баримтлах бодлого", "Авлига, хээл хахуулийн эсрэг бодлого", "Хориг арга хэмжээний бодлого", "Улс төрд нөлөө бүхий этгээдийн талаар баримтлах бодлого", "Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх журам", "Харилцагчийг таньж мэдэх, бүртгэх үйл ажиллагааны журам", "Хоригтой тулгах үйл ажиллагааны журам", "Банкнаас харилцагчийн бизнес харилцааг цуцлах, банкны үйлчилгээг зогсоох, хязгаарлах журам", "Гүйлгээнд хяналт тавих журам", "Сэжигтэй гүйлгээ, үйлдлийг мэдээлэх журам" зэрэг болно. Банкны дотоод баримт бичгийн удирдлагын журмын дагуу жил бүр дээрх бодлого, журмын хэрэгжилт, үр дүнтэй байдалд хяналт тавьж, шинэчлэн сайжруулах арга хэмжээг авч хэрэгжүүлдэг.

Комплаенсийн газар нь МУТСТ-тэй холбоотой бодлого, журмын хэрэгжилтэд нэгдсэн байдлаар хяналт тавих, үүссэн зөрчил дутагдал, асуудалд холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэн, удирдлагад тайлагнах чиг үүргийг хэрэгжүүлдгээс гадна бөгөөд дор дурдсан ерөнхий чиг үүрэгтэй. Үүнд:

- Ерөнхий комплаенс / банкны харилцагч таньж мэдэх ажиллагааны хяналт;
- Гүйлгээний тусгай хяналт;
- Хориг арга хэмжээний хяналт;
- Санхүүгийн гэмт хэргийн эрсдэлийн удирдлага;
- Комплаенсийн сургалт, хөгжил.

ХААН Банк нь Монгол Улсад мөрдөгдөж буй хууль тогтоомж болон хамтран ажиллагч талуудтай байгуулсан гэрээгээр хүлээсэн аливаа хориг арга хэмжээний шаардлагыг дагаж мөрддөг ба эдгээрийн заримаас дурдвал НҮБ-ын Аюулгүйн зөвлөл болон Европын холбоо, Их Британи, АНУ зэрэг олон улсын байгууллага, улс орнуудын тавьсан хориг арга хэмжээг дагаж мөрддөг. Үүний тулд ХААН Банкны хориг арга хэмжээний хяналтын тусгай хөтөлбөрийг боловсруулж, Гүйцэтгэх удирдлагаар батлуулсан бөгөөд тогтмол сайжруулан шинэчилж, банкны хэмжээнд дагаж мөрдөх, хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлдэг.

Комплаенсийн эрсдэлийн удирдлагын хүрээнд Банкны ажилтнуудад зориулсан МУТСТ чиглэлийн бүх төрлийн сургалтыг системтэйгээр цахимаар, танхимаар, мөн газар дээрх сургалтуудыг тогтмол зохион байгуулдаг. Түүнчлэн банкны дотоод сүлжээгээр дамжуулан мэдлэг олгох гарын авлага, материалыг түгээн бичил сургалтаар тогтмол хангаж ажилладаг. Мөн ХААН Банкны үнэт зүйлүүдийн нэг болох ёс зүйн дүрмийг мөрдлөг болгон бүх ажилтнуудад таниулах, үүн дотроо ажилтнууддаа авлига, хээл хахуулиас ангид байхыг шаардаж Ёс зүйн дүрэмд "Хариуцлагатай, ёс зүйтэй" байх нийтлэг тодорхойлолтыг тусган ажилтан бүр хүлээн зөвшөөрч, баталгаажуулдаг. ХААН Банкны Авлига, хээл хахуультай тэмцэх бодлогыг олон улсын жишиг, дотоодын хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулсан бөгөөд уг баримт бичгийг үйл ажиллагааны бүх түвшинд чанд мөрдөн ажиллаж байна.

Мэдээлэл технологийн эрсдэлийн удирдлага

Мэдээлэл технологийн эрсдэлийг бүхэлд нь Мэдээлэл технологи хариуцсан дэд захирал удирдаж, хянадаг бөгөөд түүний харъяа Мэдээлэл технологийн бизнес засаглалын газар нь Мэдээлэл технологийн эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, арга хэмжээ авах, хянах, тайлагнах үйл явцыг хариуцан чиглүүлдэг. Банкны мэдээлэл технологийн удирдлага, үйлчилгээний тогтолцооны сайжруулалт, нэвтрүүлэлтийн үйл ажиллагаа нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн COBIT, ITIL тогтолцоонд суурилсан байдаг. COBIT тогтолцоонд суурилсан ИТ-ийн аудитын шалгалтыг хоёр жил тутамд хөндлөнгийн аудитын

2023 5 29

байгууллагаар хийлгэдэг төдийгүй уг үнэлгээгээр эрсдэлийн удирдлагын чадавхийн түвшинг үнэмлэхүй сайжруулснаа баталгаажуулсан.

ХААН Банк нь мэдээлэл технологийг ашиглах, нэвтрүүлэх, удирдах, мэдээлэл технологийн үйлчилгээ болон бизнесийн тасралтгүй ажиллагааг хангахтай холбоотой мэдээлэл технологийн эрсдэлийг Мэдээлэл технологийн эрсдэлийн удирдлагын журам, Мэдээлэл технологийн эрсдэлийн дэд хорооны журмын дагуу удирдаж, хянадаг. Банк нь мэдээлэл технологийн эрсдэлүүдийг Мэдээлэл технологийн эрсдэлийн дэд хороогоор тогтмол хянаж, холбогдох шийдвэрүүдийг гаргадаг. Мөн түүнчлэн мэдээлэл технологитой холбоотой аудитын шалгалтаар илэрсэн асуудлууд, зөвлөмжүүд, тэдгээрийн хэрэгжилтийн явц, мэдээлэл технологитой холбоотой бодлого, журмуудыг хэлэлцэж, хянадаг.

Банкны бизнесийн стратеги болон зорилтуудтай уялдуулсан мэдээлэл технологийн процесс болон харилцагчийн үйлчилгээнд нөлөөтэй чухал системүүдэд сэдэвчилсэн эрсдэлийн үнэлгээг тогтмол хийдэг. Мэдээлэл технологийн эрсдэлийн үнэлгээгээр илэрсэн эрсдэлүүдийг мэдээлэл технологийн эрсдэлийн дэд хорооны самбарт бүртгэж, арга хэмжээ авч ажилладаг. Өдөр тутмын үйл ажиллагаанд тулгарч болзошгүй эрсдэлийг таних, илрүүлэхийг дэмжсэн хөтөлбөрийг мэдээлэл технологийн ажилтнуудад тогтмол зохион байгуулдаг.

2. ҮНЭТ ЦААСНЫ ТУХАЙ

2.1. Үнэт цаас гаргах тухай эрх бүхий этгээдийн шийдвэр

Бонд гаргагч нь 2023 оны 5 дугаар сарын 24-ны өдрийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 18 тоот тогтоолоор нийт 30 сая ам.доллар хүртэлх үнийн дүн бүхий "Ногоон бонд гаргах хөтөлбөр" (Бондын хөтөлбөр) хэрэгжүүлж, Бондын хөтөлбөрийн хүрээнд гаргах 170,000 ширхэг хүртэлх төгрөгийн бондын нэрлэсэн үнэ 100,000 төгрөг, 250,000 хүртэлх ширхэг ам.долларын бондын нэгжийн үнэ 100 ам.доллар байх ба тус бондуудыг хэсэгчлэн Монголын хөрөнгийн биржээр дамжуулан нийтэд болон стратегийн хөрөнгө оруулагчдад санал болгохоор шийдвэрлэсэн.

Хавсралт №1. Үнэт цаас гаргах эрх бүхий этгээдийн шийдвэр

2.2. Ногоон бонд гаргах үндэслэл

ХААН Банк харилцагчдынхаа санхүүгийн хэрэгцээ шаардлагыг хангах бүтээгдэхүүн, үйлчилгээг хамгийн найдвартай, шуурхай хүргээд зогсохгүй, бизнесээ нийгэм, байгаль орчинд ээлтэйгээр явуулж, Монгол Улсын эдийн засаг, нийгмийн хөгжилд бодитой хувь нэмэр оруулахын төлөө ажилладаг.

Энэхүү зорилгын хүрээнд Банк нь эрчим хүчний хэмнэлтийг нэмэгдүүлэх, ногоон барилга, ногоон тээвэр, тогтвортой хөдөө аж ахуйн орчин үеийн шийдлүүдийг нэвтрүүлэх, хог хаягдлын асуудлыг шийдвэрлэх, уур амьсгалын өөрчлөлтийг багасгах замаар сөрөг нөлөөг бууруулах байгаль орчинд ээлтэй үйл ажиллагааг санхүүжүүлэх ногоон санхүүжилтийн багцаа эрчимтэй нэмэгдүүлэх дунд хугацааны томоохон зорилтыг хэрэгжүүлж байна.

Уг зорилтын хүрээнд тус үйл ажиллагааг дэмжих урт хугацаат эх үүсвэрийг гадаад болон дотоодын хөрөнгө оруулагчдаас татан төвлөрүүлэх үүднээс олон улсын зах зээлд анхны "Ногоон бонд" гаргасан. Ногоон бонд гаргасны дараа бусад олон улсын санхүүгийн байгууллага, хамтран ажиллагч хөрөнгө оруулагчдаас байгаль орчин, нийгэмд эерэг нөлөө үзүүлэх тогтвортой хариуцлагатай хөрөнгө оруулалтыг дэмжих өндөр сонирхолтой байгаагаа илэрхийлсэн.

Иймд банк нь олон улсад ногоон бонд гаргасан туршлагад үндэслэн Монголын хөрөнгийн зах зээлд дотоодын анхны ногоон бондыг гаргаж байна. Ингэснээр хөрөнгийн зах зээлд Ногоон бүтээгдэхүүн



нэмэгдэж, хөрөнгийн зах зээлийг тэлэх, дотоодын болон гадаадын хөрөнгө оруулагчид, олон улсын санхүүгийн байгууллагуудад хөрөнгө оруулалтын шинэ боломжийг бүрдүүлэх өндөр ач холбогдолтой.

2.3. Өрийн хэрэгслийн хүү тогтоосон үндэслэл

ХААН Банк нь бондын хөтөлбөрийн хүрээнд гаргах бондуудын купон хүүгийн түвшинг тогтоохдоо макро эдийн засгийн төлөв байдал, зах зээлийн хүү, зах зээл дэх ижил төстэй өрийн хэрэгслүүдийн купон хүүгийн түвшин болон банкны ижил төстэй эх үүсвэрүүдийн зардлуудыг харьцуулсан. Мөн хөрөнгө оруулагчдын сонирхол, шаардлага, банкны зээлжих зэрэглэлийн үнэлгээ зэрэгт үндэслэн хөтөлбөрийн хүрээнд гаргах бондуудын хүүгийн төрөл, хүүгийн хязгаарыг тодорхойлсон.

Хүснэгт 57. Бондын санал болгож буй хүү

	Ам Долларын Бонд (3-5 жил хүртэл)	Төгрөгийн Бонд (3 хүртэл жил)
Купон хүүгийн төрөл	Хөвөгч хүү	Тогтмол хүү
Купон хүүгийн хувь	Ам.долларын 6 сарын Compounded SOFR хүү ⁹ + [3.40% - 3.85%]	Жилийн [14.8% - 16.0%]

Монголбанкнаас бодлогын хүүг 2023 оны 03 сарын 15-ны өдрийн Мөнгөний бодлогын хорооны хурлын шийдвэрээр 13.0 хувьд хэвээр үлдээсэн. Статистикийн үндэсний хорооноос 2023 оны 03 дугаар сарын инфляцийн жилийн түвшинг Монгол улсын хэмжээнд 12.2 хувьтай гарсныг мэдэгдсэн.

График 18. Инфляци, бодлогын хүү болон хадгаламжийн ЖДХ



Банкуудын депозитуудын жигнэсэн дундаж хүү 2023 оны 03 сарын 31-ны байдлаар 10.5%-тай байгаа бол банкуудын 2 жилийн хугацаатай депозитын нийтэд зарласан дундаж хүү 12.8-13.0 хувийн хооронд байна.

⁹ "SOFR" хүү нь Нью-Йоркийн Холбооны нөөцийн сангаас тогтоосон овернайт хүү юм.
<https://www.newyorkfed.org/markets/referencerates/sofr>


"Compounded SOFR" means a compounded average of daily SOFR calculated over a Corresponding Period or Interpolated Period, as applicable, that ends on the second New York business day preceding the [first][last] A day of the applicable interest period, according to the provisions describing the methodology for compounding set forth under "USD-SOFR-COMPOUND" of the International Swaps and Derivatives Association Definitions.



2023 11 02



Хүснэгт 58. Системийн нөлөө бүхий 5 арилжааны банкуудын депозитийн хүүгийн харьцуулалт /2023.03.31-ний байдлаар/



Валют	Хугацаа	ХААН Банк	ХХБанк	Голомт Банк	Хас Банк	Төрийн Банк	
Иргэд							
Энгийн хугацаатай хадгаламж	MNT	1 сар	8.0%	8.2%	8.0%	-	8.0%
	3 сар	9.5%	9.7%	9.5%	9.38%	9.1%	
	6 сар	10.5%	10.7%	10.5%	10.03%	10.6%	
	9 сар	11.0%	11.2%	11.0%	10.69%	11.5%	
	12 сар	12.3%	12.5%	12.4%	11.57%	12.3%	
	24 сар	12.8%	13.0%	12.8%	12.68%	12.8%	
	36 сар	-	13.2%-13.5%	-	-	12.8%	
Байгууллага							
Байгууллагын хугацаатай хадгаламж	MNT	1 сар	8.0%	8.2%	8.0%	-	8.0%
	3 сар	9.5%	9.7%	9.5%	9.38%	9.1%	
	6 сар	10.5%	10.7%	10.5%	10.03%	10.6%	
	9 сар	-	11.2%	11.0%	10.69%	-	
	12 сар	12.3%	12.5%	12.4%	11.57%	12.3%	
	24 сар	-	12.7%	-	12.68%	12.8%	

Эх сурвалж: Банкуудын вэбсайт

2023 оны 03 сарын 31-ний өдрийн байдлаар Монголын Хөрөнгийн Бирж дээр нийт 16 нээлттэй бонд арилжаалагдаж байгаа бөгөөд төгрөгийн бондуудын хугацаа 12-36 сар, жилийн купон хүү 10-19.2 хувьтай байна.

Хүснэгт 59. Монголын Хөрөнгийн Бирж дээр нээлттэй арилжаалагдаж буй бондуудын жагсаалт

Үнэт цаас гаргагч	Гаргасан огноо	Дуусах огноо	Хугацаа	Бондын купон хүү (жилийн)	Валют	Бондын нэгжийн үнэ	Бондын нийт дүн	Купон төлөх давтамж
1 "Инвекор ББСБ" ХК	2021.06.21	2023.06.21	24	13%	MNT	100,000	8,000,000,000	6 сар
2 "Эрдэнэс таван толгой" Хаалтай ХК	2021.03.26	2023.03.26	24	10%	MNT	100,000	236,551,700,000	6 сар
3 "Эрдэнэс таван толгой" Хаалтай ХК	2021.03.26	2023.03.26	24	6.8%	USD	100	39,012,200	6 сар
4 "ЛэндМН ББСБ" ХК	2021.07.02	2023.07.02	24	14%	MNT	100,000	5,000,000,000	6 сар
5 "Инвекор ББСБ" ХК	2021.08.17	2023.08.17	24	13%	MNT	100,000	6,000,000,000	6 сар
6 "Эрдэнэс таван толгой" Хаалтай ХК	2021.08.25	2024.08.26	36	13%	MNT	100,000	164,471,100,000	6 сар
7 "Эрдэнэс таван толгой" Хаалтай ХК	2021.08.25	2023.08.25	24	5.8%	USD	100	13,319,900	6 сар
8 "Инвекор ББСБ" ХК	2021.09.17	2023.09.15	24	13%	MNT	100,000	6,000,000,000	6 сар
9 "Мобифинанс ББСБ" ХХК	-	2022.11.08	12	14%	MNT	100,000	1,000,000,000	Хугацааны эцэст
10 "Эрдэнэс таван толгой" Хаалтай ХК	2021.11.16	2024.11.11	36	10%	MNT	100,000	142,404,600,000	6 сар





11	"ЛэндМН ББСБ" ХК	2021.12.02	2023.11.30	24	14%	MNT	100,000	2,500,000,000	6 сар
12	"ЛэндМН ББСБ" ХК	2022.04.05	2024.04.03	24	15%	MNT	100,000	3,100,000,000	6 сар
13	"Эрдэнэс таван толгой" Хаалттай ХК	2022.05.13	2025.05.08	36	МБ-ны бодлогын хүү+4%	MNT	100,000	76,618,200,000	6 сар
14	"Инвекор ББСБ" ХК	2022.12.20	2023.12.19	12	18%	MNT	100,000	10,000,000,000	3 сар
15	"Инвекор ББСБ" ХК	2022.12.22	2023.12.22	12	18%	MNT	100,000	10,000,000,000	3 сар
16	"Сэндли ББСБ" ХК	2023.01.30	2024.07.30	18	19.2%	MNT	100,000	8,500,000,000	3 сар

2.4. Бондын барьцаа

СЗХ-ны "Компанийн өрийн хэрэгслийн бүртгэлийн журам"-ын 2.8-д заасны дагуу Бонд гаргагч нь дотоодын эсхүл олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн эрх бүхий байгууллагаар санхүүжих чадварын зэрэглэл тогтоолгосон бол үүргийн гүйцэтгэлийг хангах баталгаа болгож эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийг барьцаалахгүй байж болно.

ХААН Банк нь 2007 оноос эхлэн олон улсын зээлжих зэрэглэлийн үнэлгээ тогтоогч "Fitch Ratings" (Фитч), 2008 оноос эхлэн "Moody's Investors Service" (Мүүдис) үнэлгээний байгууллагаар тус тус зээлжих зэрэглэлийн үнэлгээ хийлгэж байна.

"Мүүдис"-ээс 2022 оны 10 дугаар сард ХААН Банкны зээлжих зэрэглэлийн үнэлгээг "В3, тогтвортой" гэж үнэлсэн ба "Фитч" үнэлгээний байгууллагаас 2023 оны 03 дугаар сард "В, тогтвортой" гэж үнэлсэн.

Дэлгэрэнгүйг бондын танилцуулгын 1.7.9-өөс харна уу.

2.5. Нийтэд санал болгох үнэт цаасны төрөл тоо, хэлбэр, нэрлэсэн үнэ, хугацаа, үндсэн төлбөр, хүү төлөх нөхцөл

Хүснэгт 60. Санал болгож буй үнэт цаасны мэдээлэл

Үнэт цаас гаргагч	ХААН Банк ХХК	
Бондын төрөл	Ногоон бондын хөтөлбөр	
Бондын арилжаа	Олон нийтэд нээлттэй	
Татан төвлөрүүлэх дүн	Нийт 30 сая ам доллар хүртэлх. Үүнээс, <ul style="list-style-type: none"> Олон нийтэд санал болгох 17 тэрбум хүртэлх төгрөгийн (5 сая ам доллар хүртэлх дүнтэй тэнцэх) бонд Стратегийн хөрөнгө оруулагчдад санал болгох 25 сая ам доллар хүртэлх дүн бүхий ам.долларын бонд 	
Бондын нэрлэсэн үнэ	Төгрөгийн бонд 100,000₮	Ам.долларын бонд 100\$
Нийт тоо, ширхэг	170,000 ширхэг хүртэл	250,000 ширхэг хүртэл
Бондын хугацаа	3 хүртэл жил Тогтмол хүү	3-5 хүртэл жил Хөвөгч хүү
Бондын хүү (жилийн)	14.8%-16.0%	Ам.долларын 6 сарын Compounded SOFR хүү

"SOFR" хүү нь Нью-Йоркийн Холбооний нөөцийн сангаас тогтоосон овернайт хүү юм.
<https://www.newyorkfed.org/markets/referencerates/sofr>

БОНДЫН ТАНИЛЦУУЛГА

2023 11 02





Бондын хөтөлбөрийн хүрээнд гаргах бондуудыг хэсэгчлэн гаргах тухай бүр энэхүү хязгаарт багтаан бондын хүүгийн нөхцөлийг тодорхойлно.

+ [3.40% - 3.85%]

Бондын хүү төлөх нөхцөл	Хагас жил тутам
Бондын үндсэн төлбөр төлөх нөхцөл	Төгрөгийн бонд: Хугацааны эцэст Ам долларын бонд: Бондыг санал болгох тухай бүр тогтооно
Бондын зарцуулалт	Банкны одоо хэрэгжиж буй "Ногоон Бондын Санхүүжилтийн Хүрээ" -нд тодорхойлсон төсөл хөтөлбөр, үйл ажиллагаануудыг ("Шаардлага хангасан ногоон зээлүүд") бүхэлд нь эсхүл хэсэгчлэн санхүүжүүлэх болон дахин санхүүжүүлэхэд зарцуулна.
Бондын барьцаа / баталгаа, эргэн төлөлт	Барьцаагүй ¹¹
Анхдагч зах зээлд хэсэгчлэн гаргаж арилжаалах хуваарь	Ногоон бондын хөтөлбөрийн хүрээнд хэсэгчлэн гаргах бондуудын хүү, хугацаа, санал болгох хугацаа болон бусад нөхцөлийг тухай бүрд нь Банкны Гүйцэтгэх захирал шийдвэрлэнэ.
Хөтөлбөрийн хугацаа	24 сар

2.6. Нийтэд санал болгох, арилжих арга, нөхцөл

Үнэт цаас гаргагч нь нийтэд санал болгож буй бондыг бүртгүүлэх хүсэлтийг МХБ болон СЗХ-нд нэгэн зэрэг гарган, зохицуулах байгууллагуудын үнэт цаасыг бүртгэх зөвшөөрөл олгогдсоны дараа нийтэд санал болгоно.

Ногоон бонд гаргах хөтөлбөрийг энэхүү Бондын танилцуулгын 2.7-д заасны дагуу хэрэгжүүлнэ.

Үнэт цаас гаргагч нь ногоон бондын анхдагч зах зээлийн арилжааг СЗХ-ны "Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам"-ын 6.13 болон МХБ-ийн "Анхдагч зах зээлийн арилжааны журам"-ын 4 дүгээр бүлэгт тусгасны дагуу бондыг "Тогтоосон үнийн арга"-аар хөрөнгө оруулагчдад санал болгоно.

Андеррайтер нь СЗХ-ны "Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам"-ын 6.3 дугаар зүйлд зааснаар бондын танилцуулгад тусгасан нөхцөл, журамд заасан арга хэлбэрээр анхдагч зах зээлд санал болгож, худалдана.

Анхдагч зах зээлийн арилжаа

Андеррайтер болон үнэт цаас гаргагч нь анхдагч зах зээлийн арилжааг дараах байдлаар зохион байгуулна.

2023 11 02

"Compounded SOFR" means a compounded average of daily SOFR calculated over a Corresponding Period or Interpolated Period, as applicable, that ends on the second New York business day preceding the [first][last] A day of the applicable interest period, compounded according to the provisions describing the methodology for compounding set forth under "USD-SOFR-COMPOUND" of the International Swaps and Derivatives Association Definitions.

СЗХ-ны Компанийн өрийн хэрэгслийн бүртгэлийн журам"-ын 2.8-д тусгаснаар дотоодын эсхүл олон улсад хүрээнд зөвшөөрөгдсөн эрх бүхий байгууллагаар санхүүжих чадавхын зэрэглэл тогтоолгосон бол үүргийн гүйцэтгэлийг хангах баталгаа болгож эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийг барьцаалахгүй байж болно.





Зураг 9. Анхдагч зах зээлийн арилжааны ерөнхий схем



Төлөвлөгөө

Анхдагч зах зээлийн арилжааны төлөвлөгөөг СЗХ, МХБ - д хүргүүлнэ.

Танилцуулга

Олон нийтэд мэдээлэл өгөх, танилцуулах

Захиалга

Анхдагч зах зээлийн захиалга авах, захиалгын сан бүрдүүлэх

Арилжаа

Анхдагч зах зээлийн арилжаа дуусгавар болсноор ирүүлсэн захиалгын дагуу хуваарилалтыг гүйцэтгэнэ.

1. Анхдагч зах зээлийн арилжааны төлөвлөгөө

Зохицуулагч байгууллагууд үнэт цаасыг бүртгэснээр андеррайтер болон үнэт цаас гаргагч нь нийтэд танилцуулах, сурталчлах болон анхдагч зах зээлийг эхлүүлэх хугацаа, хуваарь зэрэг мэдээллийг тусгасан анхдагч зах зээлийн арилжааны төлөвлөгөөг уг ажиллагаа эхлэхээс ажлын 5-аас доошгүй өдрийн өмнө СЗХ болон МХБ-д мэдэгдэнэ.

2. Үнэт цаасыг олон нийтэд танилцуулах

Анхдагч зах зээлийн арилжааны төлөвлөгөөнд заасан хугацаанд үнэт цаасыг нийтэд танилцуулах ажиллагааг дараах байдлаар зохион байгуулна.

- Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр үнэт цаасны мэдээллийг хүргэх;
- Нийтэд зориулсан танилцуулга уулзалт зохион байгуулах;
- Үнэт цаасны танилцуулга, хураангуй танилцуулгыг боломжит хөрөнгө оруулагчдад түгээх;
- Олон улсын хөрөнгө оруулагчдад танилцуулах, сурталчлах;
- СЗХ-ны "Компанийн өрийн хэрэгслийн бүртгэлийн журам"-ын 6.4-т заасны дагуу олон нийтэд танилцуулах, анхдагч зах зээлд санал болгож, худалдах ажиллагааг хэрэгжүүлэхээс өмнөх стратегийн болон мэргэжлийн хөрөнгө оруулагчдад бондын талаар танилцуулж, санал болгох;
- Үнэт цаасыг танилцуулах маркетингийн төлөвлөгөөний дагуу бусад арга хэлбэрээр танилцуулна.

Үнэт цаас гаргагч нь ногоон бондын хөтөлбөрийн хүрээнд бондыг анхдагч зах зээлд нийлүүлэх тухай бүрд анхдагч зах зээлд санал болгож, захиалгыг эхлүүлэх тухай мэдэгдлийг уг ажиллагааг эхлүүлэхээс ажлын 5-аас доошгүй өдрийн өмнө СЗХ-нд хүргүүлнэ.

3. Үнэт цаасны анхдагч зах зээлийн захиалга

Хөрөнгө оруулагч нь дараах зааврын дагуу үнэт цаас гаргагчийн анхдагч зах зээлийн арилжаанд оролцоно.

Үнэт цаасны дансгүй бол МХБ-д бүртгэлтэй ҮЦК-д данс нээлгэх

02

Үнэт цаасны компаниар дамжуулан ногоон бонд авах захиалга өгөх


04



2023.05.29



Үнэт цаасны данс нээлгэх



Үнэт цаасны анхдагч зах зээлд оролцох гэж буй этгээд нь үнэт цаасны данстай бол өөрийн харилцдаг үнэт цаасны компаниар дамжуулан үнэт цаас гаргагчийн бондыг худалдан авна.

Хэрэв үнэт цаасны анхдагч зах зээлд оролцох гэж буй этгээд нь үнэт цаасны дансгүй бол МХБ-д бүртгэлтэй үнэт цаасны компаниар дамжуулан цахимаар болон биечлэн үнэт цаасны данс нээх боломжтой. Уг данс нь ажлын 1-2 хоногийн дотор нээгдэнэ.

Мөнгө байршуулах

Хөрөнгө оруулагч нь МХБ-д бүртгэлтэй үнэт цаасны компанид үнэт цаасны данс нээлгэж, өөрийн үнэт цаасны дансанд зааврын дагуу бонд худалдан авах мөнгийг байршуулна.

Хүснэгт 61. Мөнгө байршуулах заавар

Гүйлгээний заавар	
Хүлээн авагч банк:	Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв
Хүлээн авах данс:	____ (ҮЦК-ийн код) _____ (Харилцагчийн үнэт цаасны дансны дугаар)
Хүлээн авагч:	Харилцагчийн нэр
Шилжүүлэх дүн	Худалдан авах үнийн дүн + Арилжааны шимтгэл
Утга:	Овог нэр, регистрийн дугаар

Үнэт цаасны анхдагч зах зээлд оролцох гэж буй этгээд нь гүйлгээний үнийн дүнгийн тодорхой хувиар тооцсон үйлчилгээний шимтгэлийг төлөх ба уг шимтгэлд зохицуулагч байгууллагуудын шимтгэлийн дүн багтсан байдаг. Үнэт цаасны компаниудын шимтгэлийн хувь нь харилцан адилгүй бөгөөд уг хувиар бонд худалдан авах үнийн дүнд нэмж байршуулахыг анхаарна уу.

Захиалга өгөх

Хөрөнгө оруулагч нь өөрийн үнэт цаасны бүртгэлтэй компаниар дамжуулан ногоон бонд худалдан авах захиалгыг биеэр болон цахимаар өгөх боломжтой. Үнэт цаасны компаниуд нь хөрөнгө оруулагчдаас хүлээн авсан бонд худалдан авах захиалгыг IPO системд шивснээр захиалга баталгаажна. Анхдагч зах зээлийн захиалгыг IPO системд бүртгэх хугацаа СЗХ-ны "Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам"-ын 6.7-д заасны дагуу ажлын 5 өдрөөс илүүгүй байна.

Захиалга биелэгдэх

Санал болгосон бондын татан төвлөрүүлэх дүн бүрдсэн тохиолдолд захиалгыг цаг хугацааны дарааллаар бүртгэн анхдагч зах зээлийн захиалга хүлээн авах хугацааг дуусгавар болгон, нийлүүлэлтийг гүйцэтгэнэ.

Албан татвар

Хувь хүний болон аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай хуулиар Монгол Улсад байрладаг албан татвар төлөгчийн гадаад, дотоодын үнэт цаасны анхдагч болон хоёрдогч зах зээлд нээлттэй арилжаалах өрийн хэрэгсэл, хувьцаа, нэгж эрх худалдан авсан албан татвар төлөгчийн хүүгийн болон ногдол ашгийн орлогод 5 хувиар тооцон албан татвар төлнө.

Монгол улсад байрладаггүй иргэн, аж ахуй нэгжийн хувьд орлогын албан татварын тухай хуулийн дагуу татвар төлөх үүрэгтэй ба Монгол улсын нэгдэн орсон олон улсын гэрээ хэлцэл, Монгол улстай давхар татварын гэрээ байгуулсан улсын иргэн, аж ахуй нэгж нь тус гэрээний нөхцөлийг дагаж мөрдөнө.



2023 5 29

4. Үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлэх

Андеррайтер нь бондыг анхдагч зах зээлд санал болгож, хуваарилалтыг хийн захиалга авч дууссанаас хойш ажлын 3 өдрийн дотор анхдагч зах зээлд санал болгосон тухай тайланг МХБ-ийн дүгнэлтийн хамт СЗХ-нд хүргүүлнэ.

СЗХ нь бонд гаргагчийн арилжааны тайланг ажлын 3 өдөрт багтаан хянан бондыг анхдагч зах зээлд санал болгон худалдах ажиллагааг амжилттай болсон тухай мэдэгдлийг Андеррайтерт, өмчлөх эрхийн бүртгэлийг баталгаажуулах мэдэгдлийг ҮЦТХТ-д, бондын хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлэх мэдэгдлийг МХБ-д хүргүүлэх бөгөөд татан төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгийг бонд гаргагчийн холбогдох дансанд тусгаарлан байршуулна.

Үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлснээр бондыг анхдагч зах зээлээс худалдан авсан хөрөнгө оруулагчид бондоо МХБ дээр чөлөөтэй арилжаалах, нэмж худалдан авах боломж нээгдэнэ.

2.7. Ногоон бонд гаргах хөтөлбөр

ХААН Банк нь Ногоон бондыг СЗХ-ны "Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам"-ын 4 дүгээр зүйлд заасны дагуу хэсэгчлэн гаргах бөгөөд Бондын хөтөлбөрийн хүрээнд гаргах бондуудын хүү, хугацаа, анхдагч зах зээлд санал болгох хугацаа болон бусад нөхцөлүүдийг ТУЗ-өөс өгсөн эрхийн дагуу тухай бүр Банкны Гүйцэтгэх захирал тогтооно.

Хөтөлбөрийн дагуу эхний транчийн хүрээнд СЗХ-д бүртгүүлснээс хойш зургаан сарын дотор анхдагч зах зээлийн арилжааг зохион байгуулах ба хэсэгчлэн гаргах бусад транчийг Хороонд бүртгүүлснээс хойш 24 сарын дотор нийтэд санал болгоно.

2.8. Татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалтын төлөвлөгөө

Бонд гаргагч нь нийт ногоон зээлийн багцыг 2023 онд өмнөх оноос 4 дахин өсгөх зорилтыг дэвшүүлсэн бөгөөд өөрийн зээлийн багцын 5 орчим хувийг 2023 онд ногоон зээл болгох төлөвлөгөөтэй. Арилжааны банкууд өөрийн нийт зээлийн багц дахь ногоон зээлийн хувь хэмжээг 2030 онд 10%-д хүргэх томоохон үүрэг амлалт авсан бөгөөд ХААН Банкны хувьд тус зорилгод 2025 онд хүрсэн байхаар төлөвлөж байна.

Энэхүү бондын хүрээнд нийт 30 хүртэлх сая ам.доллартай тэнцэх хэмжээний төгрөгийн эх үүсвэрээр ХААН Банкны "Ногоон бондын санхүүжилтийн хүрээ"-нд тусгагдсан шаардлага хангаж буй ногоон төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэхэд зарцуулна.

"Ногоон бондын санхүүжилтийн хүрээ"-нд тусгаснаар Бонд гаргагч нь үндсэн 7 чиглэлийн хүрээнд ногоон төсөл хөтөлбөрүүдийг санхүүжүүлэхээр тодорхойлсон. Үүнд

- Сэргээгдэх эрчим хүчний төслүүд;
- Эрчим хүчний хэмнэлтийг үүсгэх бүтээгдэхүүн, үйлчилгээ, төслүүд;
- Ногоон барилгын шийдлүүд;
- Бохирдлоос урьдчилан сэргийлэх, бууруулах үйл ажиллагаа;
- Усны менежмент, усны хэмнэлттэй технологи;
- Тогтвортой хөдөө аж ахуй, мал аж ахуй;
- Ногоон тээврийн шийдлүүд зэрэг үйл ажиллагаанууд багтаж байна.

2.9. Бондын гэрээний үндсэн нөхцөл

Бонд гаргагч болон хөрөнгө оруулагчдыг төлөөлж Андеррайтер нь 2023 оны 05 сарын 26-ны өдөр 948 тоот Бондын гэрээг СЗХ-ны "Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам"-ын 3.6-д заасны дагуу байгуулсан билээ.



БОНДЫН ТАНИЛЦУУЛГА



Талууд тус гэрээнд бондын нөхцөлүүд болох нэрлэсэн үнэ, тоо, хугацаа, төрөл, хүүгийн төрөл, түвшин, үндсэн болон хүүгийн төлбөр тооцон олгох аргачлалын талаар оруулсан байх ба мөн төлбөрийн тасалдал болон үнэт цаас гаргагчийг төлбөрийн чадваргүйд тооцох нөхцөл, талуудын эрх, үүрэг, хариуцлага зэргийг тусгасан.

Хүү тооцох аргачлал:

Төгрөгийн бондын хувьд:

- Жилийн хүүг 365 хоногоор тооцох ба хүү хуваарилан олгох өдөр амралтын өдөр таарсан тохиолдолд тухайн өдрөөр тасалбар болгон хүүг тооцож, дараагийн ажлын өдөр төлнө.
- Хугацааны эцэст үндсэн болон хүүгийн төлбөр хуваарилан олгогдох өдөр амралтын өдөр таарсан тохиолдолд өмнөх ажлын өдрөөр тасалбар болгон эзэмшсэн хугацааны хүүг тооцож, тус өдрөөр үндсэн болон хүүгийн төлбөрийг төлнө.

Ам.долларын бондын хувьд:

- Стратегийн хөрөнгө оруулагчдад санал болгох тухай бүр Банкны Гүйцэтгэх захирал урьдчилан тохиролцсон хэлэлцээрээр тогтоон, Санхүүгийн зохицуулах хорооны "Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам"-ын 6.5-д заасан мэдэгдэлд тусгана.

Төлбөрийн тасалдал үүсэхэд авах арга, хэмжээ

Төлбөрийн тасалдал үүсэх нөхцөл:

- Үнэт цаас гаргагч нь бондын хүү болон үндсэн төлбөрийг 30 хүртэл хоногоор төлөөгүй нөхцөл;
- Хуульд заасан бусад нөхцөл.

Төлбөрийн тасалдал үүсэх нөхцөлд авах арга хэмжээ:

1. Хөрөнгө оруулагчидтай бондын төлбөрийн нөхцлийг өөрчлөх санал хүргүүлэн хэлцэл хийх;
2. Шаардлагатай тохиолдолд компанийн хөрвөх чадвартай хөрөнгийг зарж, борлуулах.

Үнэт цаас гаргагчийн эрх үүрэг:

1. Мэдээллийн ил тод байдлыг тогтмол хангах буюу үйл ажиллагаа, санхүү, санхүүжих чадавхын зэрэглэл болон бусад бодит байдлын талаарх мэдээллийг үнэн зөв, агууллагын хувьд хоёрдмол утгагүй, бүрэн гүйцэд мэдээлж хөрөнгө оруулагчийн өмнө хүлээсэн үүргээ хэрэгжүүлж ажиллана.
2. Эргэн төлөлтийн хуваарийн дагуу бондын үндсэн болон хүүгийн төлбөрийг бонд эзэмшигчдэд төлөх үүрэгтэй.
3. Төлбөрийн тасалдал үүссэн нөхцөлд энэхүү гэрээний 3.2-т тусгасан арга хэмжээг авах байдлаар Бонд эзэмшигчийн хүү болон үндсэн төлбөрийг барагдуулах үүрэгтэй.
4. Бонд эзэмшигчийн хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахтай холбоотой хуулиар хориглосноос бусад бүхий л мэдээллийг Андеррайтер шаардсан тохиолдолд холбогдох мэдээллийг гаргаж өгөх үүрэгтэй.
5. Үнэт цаасны танилцуулгад тусгасан зориулалтын дагуу татан төвлөрүүлсэн хөрөнгийг зарцуулна.
6. Тухайн гаргасан бондыг бүртгүүлэхтэй холбоотойгоор СЗХ-нд хүргүүлсэн баримт бичиг, түүнд хавсаргасан холбогдох дүгнэлт зэрэг бусад баримт бичгийг бондын хугацаа дуусаж, үндсэн болон хүүгийн төлбөрийг бүрэн төлж дуусах хүртэлх хугацаанд компани дээрээ хадгална.
7. Гэрээнд тусгагдсан үүргээ зохих ёсоор биелүүлээгүйн улмаас Бонд эзэмшигчдэд учруулсан аливаа хохирлыг төлж барагдуулах үүрэгтэй.
8. СЗХ-ны "Компанийн өрийн хэрэгслийн бүртгэлийн журам"-ын 8.6, 8.7 болон 8.8-д заасны дагуу өөрийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг дараах хугацаанд СЗХ болон МХБ-д хүргүүлж нийтэд мэдээлнэ.
 - i. Улирлын тайланг дараа сарын 10-ны өдрийн дотор, хоёрдугаар улирлын тайланг дараа сарын 20-ны өдрийн дотор, жилийн тайлан болон Бондын тайланг 02 дугаар сарын 10-ны дотор, аудитын тайланг дараа оны 03 дугаар сарын 10-ны дотор;
 - ii. Бондын танилцуулгад заасан үйл ажиллагааны чиглэл, төсөл болон төслийн хэрэгжилтийн явцад өөрчлөлт орсон, бусад санхүүгийн байгууллага, хөрөнгө оруулагчид эзэл авсан, тэдний өмнө хүлээсэн нэмэлт үүрэг үүссэн, хяналтын багц бүхий хувьцаа эзэмшигч

2023 5 29





Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын бүтцэд өөрчлөлт орсон, эрх бүхий байгууллагын шийдвэрээр үнэт цаас гаргагчийн хөрөнгийг битүүмжилсэн, эсхүл хураасан, тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхлэх болсон, хугацааг сунгуулсан, эсхүл түүнийг тудгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон, гуравдагч этгээдийн өмнөөс баталгаа, батлан даалт гаргасан, хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр гарсан бол тухайн үйл явдал болсноос ажлын 3 өдрийн дотор;

iii. Бондын үнэ ханшид нөлөөлж болохуйц аливаа үйл явдлын мэдээллийг нэн даруй буюу 24 цагийн дотор.

9. Хууль, тогтоомжид заасан бусад эрх үүрэг.

Андеррайтерийн эрх, үүрэг:

1. Хөрөнгө оруулагчийн шийдвэр гаргахад шаардлагатай үнэт цаас гаргагчийн талаарх хуулиар хориглосноос бусад бүхий л мэдээллийг үнэт цаас гаргагчаас гаргуулан авах эрхтэй.
2. Бондын танилцуулгыг бэлтгэх, төгрөгийн бондын анхдагч зах зээлийн захиалгыг авах, хуваарилах болон байршуулах ажиллагааг удирдан зохион байгуулна.
3. Үнэт цаас гаргагчийн бондын хүү болон үндсэн төлбөрийн эргэн төлөлтөд хяналт тавьж, үүргээ биелүүлэхийг Үнэт цаас гаргагчаас шаардах эрхтэй.
4. Мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх явцад олж авсан хувь хүний болон байгууллагын нууцтай холбоотой мэдээ, мэдээлэл, баримт бичгийг гуравдагч этгээдэд задруулахгүй байх үүрэгтэй.
5. Үнэт цаас гаргагч нь төлбөрийн чадваргүй болж, хүүгийн болон үндсэн төлбөрөө төлөөгүй бол энэхүү гэрээний 3.2-т заасан арга хэмжээг авах бөгөөд үүргээ биелүүлж чадахааргүй нөхцөлд хүрвэл Андеррайтер нь үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргаж болно.
6. Бонд эзэмшигчээс ирүүлсэн санал, хүсэлтэд холбогдох тайлбар мэдээллийг өгөх бөгөөд шаардлагатай тохиолдолд Үнэт цаас гаргагч руу хандана.
7. Хууль, тогтоомжид заасан бусад эрх, үүрэг.

Бонд эзэмшигчийн эрх, үүрэг:

1. Үнэт цаас гаргагчийн нууцад хамаарахгүй компанийн үйл ажиллагааны мэдээлэлтэй танилцах, уг мэдээллээр хангахыг шаардах эрхтэй.
2. Анхдагч зах зээлээс худалдан авсан бондоо хоёрдогч зах зээл дээр чөлөөтэй худалдах эрхтэй.
3. Бондын үндсэн болон хүүгийн төлбөрийг заасан хуваарийн дагуу бүрэн төлөхийг Үнэт цаас гаргагчаас шаардах эрхтэй бөгөөд тус эрхээ өөрөө эсхүл төлөөлөгч, өмгөөлөгчөөр дамжуулан эдэлнэ.
4. Бондтой холбоотой аливаа санал, гомдлыг Андеррайтерт мэдэгдэнэ.
5. Төгрөгийн бонд эзэмшигч нь хуулиар хүлээсэн татвар, арилжааны шимтгэл болон бусад гарах зардлыг өөрөө хариуцна.
6. Бонд эзэмшигчийн бондын захиалгын төлбөрт төлсөн мөнгөн хөрөнгө нь түүний хууль ёсны үйл ажиллагаанаас олсон орлого бөгөөд "Мөнгө угаах, терроризмтой тэмцэх тухай хууль"-ийн дагуу холбогдох шалгуурыг хангасан, эрх зүйн аливаа доголдолгүй, маргаангүй байна.
7. Бондын үндсэн нөхцөлүүдийг бүрэн хүлээн зөвшөөрч, үнэт цаасны танилцуулга болон бусад холбогдох мэдээлэлд танилцсаны үндсэн дээр хөрөнгө оруулалтын шийдвэрийг гаргана.
8. Стратегийн хөрөнгө оруулагчдын хувьд бондын хөтөлбөрийн дагуу хэсэгчилсэн бонд гаргах тухай бүр бондын эзэмшигчийн эрх үүргийг стратегийн хөрөнгө оруулагчидтай урьдчилсан хэлэлцээрээр тохиролцоно.
9. Хууль, тогтоомжид заасан бусад эрх, үүрэг.

2.10. Үнэт цаасаар гэрчлэгдэх эрх, үүрэг

Бонд эзэмшигчийн эрх, үүрэг

- Бонд эзэмшигч нь бонд гаргагчийн талаарх хуулиар хориглосноос бусад бүхий л мэдээллийг бонд гаргагчаас гаргуулан авах эрхтэй.



2023 5 29



- Бонд эзэмшигч нь анхдагч зах зээлээс худалдан авсан бондоо хоёрдогч зах зээл дээр чөлөөтэй худалдах эрхтэй.
- Бонд эзэмшигч нь бондын үндсэн болон хүүгийн төлбөрийг заасан хуваарийн дагуу бүрэн төлөхийг Үнэт цаас гаргагчаас шаардах эрхтэй бөгөөд тус эрхээ өөрөө эсхүл хуульд заасны дагуу төлөөлөгчөөрөө дамжуулан эдэлнэ.
- Бонд эзэмшигч нь бондтой холбоотой аливаа санал, гомдлыг Андеррайтерт мэдэгдэнэ.
- Бонд эзэмшигч нь хуулиар хүлээсэн татвар, арилжааны шимтгэл болон бусад гарах зардлыг өөрөө хариуцна.
- Бонд эзэмшигчийн бондын захиалгын төлбөрт төлсөн мөнгөн хөрөнгө нь түүний хууль ёсны үйл ажиллагаанаас олсон орлого бөгөөд "Мөнгө угаах, терроризмтой тэмцэх тухай хууль"-ийн дагуу холбогдох шалгуурыг хангасан, эрх зүйн аливаа доголдолгүй, маргаангүй байна.
- Бонд эзэмшигч нь бондын үндсэн нөхцөлүүдийг бүрэн хүлээн зөвшөөрч, үнэт цаасны танилцуулга болон бусад холбогдох мэдээлэлд танилцсаны үндсэн дээр хөрөнгө оруулалтын шийдвэрийг гаргана.
- Стратегийн хөрөнгө оруулагчдын хувьд бондын хөтөлбөрийн дагуу хэсэгчилсэн бонд гаргах тухай бүр бондын эзэмшигчийн эрх үүргийг стратегийн хөрөнгө оруулагчидтай урьдчилсан хэлэлцээрээр тохиролцоно.
- Хууль, тогтоомжид заасан бусад эрх, үүрэг.

Үнэт цаас гаргагчийн эрх, үүрэг

- Үнэт цаас гаргагч нь мэдээллийн ил тод байдлыг тогтмол хангах буюу үйл ажиллагаа, санхүү, санхүүжих чадавхын зэрэглэл болон бусад бодит байдлын талаарх мэдээллийг үнэн зөв, агууллагын хувьд хоёрдмол утгагүй, бүрэн гүйцэд мэдээлж хөрөнгө оруулагчийн өмнө хүлээсэн үүргээ хэрэгжүүлж ажиллана.
- Үнэт цаас гаргагч нь эргэн төлөлтийн хуваарийн дагуу бондын үндсэн болон хүүгийн төлбөрийг бонд эзэмшигчдэд төлөх үүрэгтэй.
- Үнэт цаас гаргагч нь төлбөрийн тасалдал /дефолт/ үүссэн нөхцөлд хөрөнгө оруулагчдын өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх зорилгоор Бондын гэрээнд заасан санхүүгийн чадавхыг сайжруулах холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
- Үнэт цаас гаргагч нь Бонд эзэмшигчийн хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахтай холбоотой хуулиар хориглосноос бусад бүхий л мэдээллийг Андеррайтер шаардсан тохиолдолд холбогдох мэдээллийг гаргаж өгөх үүрэгтэй.
- Үнэт цаас гаргагч нь үнэт цаасны танилцуулгад тусгасан зориулалтын дагуу татан төвлөрүүлсэн хөрөнгийг зарцуулна.
- Үнэт цаас гаргагч нь тухайн гаргасан бондыг бүртгүүлэхтэй холбоотойгоор СЗХ-нд хүргүүлсэн баримт бичиг, түүнд хавсаргасан холбогдох дүгнэлт зэрэг бусад баримт бичгийг бондын хугацаа дуусаж, үндсэн болон хүүгийн төлбөрийг бүрэн төлж дуусах хүртэлх хугацаанд компани дээрээ хадгална.
- Үнэт цаас гаргагч нь гэрээнд тусгагдсан үүргээ зохих ёсоор биелүүлээгүйн улмаас Бонд эзэмшигчдэд учруулсан аливаа хохирлыг төлж барагдуулах үүрэгтэй.
- СЗХ-ны "Компанийн өрийн хэрэгслийн бүртгэлийн журам"-ын 8.6, 8.7 болон 8.8-д заасны дагуу өөрийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг холбогдох хугацаанд СЗХ болон МХБ-д хүргүүлж нийтэд мэдээлнэ.
- Хууль, тогтоомжид заасан бусад эрх үүрэг.





3. ҮНЭТ ЦААС ГАРГАХ АЖИЛЛАГААНД ХАМТРАН АЖИЛЛАСАН БАЙГУУЛЛАГУУДЫН ТУХАЙ

Сонирхлын зөрчлөөс сэргийлсэн тухай мэдэгдэл

СЗХ-ны "Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам"-ын 3.4.3-д заасны дагуу Бонд гаргагч болон мэргэжлийн үйлчилгээ үзүүлсэн андеррайтерийн компани болох "БиДиСЕК ҮЦК" ХК, хуулийн зөвлөх компани болох Өмгөөллийн "ХаанЛекс Партнерс" ХХН, аудитын компани болох "Прайсуотерхаускуперс Аудит" ХХК, хараат бус үнэлгээний компани болох "Эвиденсе Аудит" ХХК, тэдгээрийн эрх бүхий албан тушаалтан, холбоотой этгээдүүд нь аливаа байдлаар ашиг сонирхлын хувьд зөрчилгүй бөгөөд сонирхлын зөрчил үүсэхээс сэргийлж ажиллах тухай мэдэгдсэн.

3.1. Андеррайтер компанийн танилцуулга

	Регистрийн дугаар:	2052482
	Улсын бүртгэлийн дугаар:	9010001030
	Хаяг:	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Залуучуудын өргөн чөлөө 27/1, 8-р хороо, БиДиСЕК ҮЦК ХК-ийн байр
	Утас:	7555-1919
	И-мэйл:	info@bdsec.mn
	Вебсайт:	www.bdsec.mn

"БиДиСЕК ҮЦК" ХК нь Монгол Улсад өмч хувьчлал явагдаж Хөрөнгийн зах зээлийн харилцаа бий болсон цагаас үүсгэн байгуулагдаж өнөөг хүртэл 31 жилийн турш тасралтгүй үйл ажиллагаа явуулж буй, салбартаа тэргүүлэгч үнэт цаасны компани юм.

Компани нь 2006 онд Монголын Хөрөнгийн Бирж дээр IPO хийснээр нийтэд үнэт цаасаа нээлттэй санал болгосон хамгийн анхны үнэт цаасны компани болсон.

"БиДиСЕК ҮЦК" ХК нь СЗХ-ны 2007 оны 08 сарын 17-ны өдрийн 113 тоот тогтоолоор брокер, дилер, хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээ үзүүлэх эрх, 2008 оны 06 сарын 12-ны өдрийн 136 тоот тогтоолоор андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл болон 2017 оны 03 сарын 22-ны өдрийн 163 тоот тогтоолоор гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрлийг тус тус авснаар үнэт цаасны зах зээлийн цогц үйлчилгээг харилцагчдадаа санал болгон ажиллаж байна.

Одоогийн байдлаар компани нь Улаанбаатар хот болон 8 аймагт хөрөнгийн зах зээлийн үйлчилгээ үзүүлэх зөвшөөрөлтэй ба дотоод, гадаадын нийт 344 орчим мянган харилцагчдад үйлчилдэг Монгол Улсын хамгийн өргөн брокерийн сүлжээг бий болгоод байна.

Сүүлийн 10 жилийн хугацаанд МХБ-ийн үнэт цаасны арилжаанд өндөр идэвхтэй оролцож ирсэн бөгөөд 2012 онд хамгийн өндөр буюу нийт үнэт цаасны арилжааны 91%-ийг гүйцэтгэсэн.





Мөн МХБ-д шинээр хувьцаа гарган санхүүжилт татан төвлөрүүлэх ажиллагааны 17.2%-д, нэмэлт хувьцаа гаргах ажиллагааны 87.3%-д, нээлттэй компанийн бондын 93.4%-д нь андеррайтерийн үйлчилгээ үзүүлж ажилласан туршлагатай.

3.1.1. Андеррайтерийн тусгай зөвшөөрөл

БИДИСЕК-УЦК ХК нь СЗХ-ны 2008 оны 06 сарын 12-ны өдрийн 136 тоот тогтоолоор андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг авсан бөгөөд уг тусгай зөвшөөрлийн хүрээнд 14 жил тасралтгүй үйл ажиллагаа явуулж байна.

3.1.2. Андеррайтертай байгуулсан гэрээний тухай

Андеррайтер нь Үнэт цаас гаргагч ХААН Банкны ногоон бонд санал болгон гаргах ажиллагаанд 2023 оны 5 дугаар сарын 09-ний өдөр андеррайтерийн гэрээ байгуулсан. ХААН Банкны ногоон бонд санал болгон гаргах ажиллагаанд дараах эрх үүрэгтэйгээр оролцож байна. Үүнд:

Андеррайтерийн компанийн эрх, үүрэг:

- Андеррайтер нь Гэрээний 3.1-т заасан болон энэхүү гэрээнд заасан бусад ажил үйлчилгээг Монгол улсын хууль тогтоомжид нийцүүлэн мэргэжлийн өндөр түвшинд, хугацаанд нь чанартай, шударга, амжилттай хийж гүйцэтгэн, хамтран ажиллах үүрэг хүлээнэ.
- Андеррайтер нь Үнэт цаас гаргагчийн бондыг нийтэд санал болгон худалдахад шаардлагатай бүх хүчин чармайлт гаргах буюу Андеррайтерийн Best effort хэлбэрээр ажиллана.
- Андеррайтер нь Үнэт цаас гаргагчийг энэ гэрээнд заасан ажил үйлчилгээ болон хөрөнгийн зах зээлтэй холбоотой боломжит бүхий л мэдээллээр хангаж, зөвлөгөө өгч ажиллах үүрэгтэй.
- Бондын анхдагч зах зээлийн арилжааны нийлүүлэлт болон арилжааг гүйцэтгэх үүрэгтэй.
- Гэрээнд заасан ажил үйлчилгээг гүйцэтгэхтэй холбоотой аливаа асуудлаар Үнэт цаас гаргагчид зөвлөгөө өгч буй аудит, үнэлгээ, хуулийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх этгээдтэй хамтран ажиллаж, шаардлагатай арга хэмжээг шуурхай шийдвэрлэх үүрэгтэй.
- Гэрээт ажлын хүрээнд үнэт цаас гаргагчид дотоод аудитын хяналт шалгалт хийгдэх тохиолдолд тухайн ажилтай холбоотой шаардлагатай баримт, материал гаргаж өгөх, баримт бичигт чөлөөтэй хандах эрх олгох зэргээр хамтран ажиллах үүрэгтэй.
- Андеррайтер нь томоохон харилцагч, хөрөнгө оруулагч болон стратегийн томоохон хөрөнгө оруулагчдад бондын мэдээллийг өгч үнэт цаас гаргагчтай тохиролцсон нөхцөлөөр тодорхой санал гаргаж, идэвхтэй ажиллах үүрэгтэй.
- Андеррайтер нь ногоон бондыг бүртгүүлэхэд үнэт цаасны танилцуулга бэлтгэх, үнэлгээ, хууль, аудитын үйлчилгээ үзүүлэгчийн дүгнэлт болон бусад шаардагдах бичиг баримтын бүрдлийг шалгана.
- Маркетингийн уулзалт, хурлуудад зориулсан танилцуулга, материалуудыг бэлтгэхэд хамтарч ажиллах үүрэгтэй.
- Үнэт цаас гаргагчтай хамтран ажиллахдаа хөрөнгө оруулагчдын хууль ёсны эрх ашгийг чухалчлан үзнэ.
- Андеррайтер нь ногоон бондын үнэт цаасны танилцуулгыг бэлтгэх, анхдагч зах зээлийн захиалгыг авах, хуваарилах, худалдах болон байршуулах ажиллагааг удирдан зохион байгуулна.
- Үнэт цаас гаргагчийн санал болгож буй ногоон бонд эзэмшигчдэд үнэт цаасны данс нээх, бондыг байршуулах ажлыг зохион байгуулах зэргээр брокерийн үйлчилгээ үзүүлэх үүрэгтэй.
- Андеррайтер нь анхдагч зах зээлийн захиалга авах явцад харилцагчийг таньж мэдэх, аливаа сэтгэлгээний гялзүүн, Андеррайтер Брокер, Алтанги "БИДИСЕК-УЦК" ХХК-ийн үйлчилгээг үзүүлэх үүрэгтэй.

Р.Монгол

- Андеррайтер нь мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх явцад олж авсан хувь хүний болон байгууллагын нууцтай холбоотой мэдээ, мэдээлэл, баримт бичгийг гуравдагч этгээдэд задруулахгүй байх үүрэгтэй.
- Андеррайтер нь үнэт цаас гаргагчийн бондын хүүгийн болон үндсэн төлбөрийн эргэн төлөлтөд хяналт тавих үүрэгтэй.
- Үнэт цаас гаргагч нь төлбөрийн чадваргүй болж, хүүгийн болон үндсэн төлбөрөө төлөөгүй бол үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргаж болно.
- Андеррайтер нь хөрөнгө оруулагчийн шийдвэр гаргахад шаардлагатай үнэт цаас гаргагчийн талаарх хуулиар хориглосноос бусад бүхий л мэдээллийг үнэт цаас гаргагчаас гаргуулан авах боломжтой.
- Андеррайтер нь анхдагч зах зээлд стратегийн болон мэргэжлийн хөрөнгө оруулагчийн үйл ажиллагаа эрхлэгчид санал болгоно.
- Андеррайтер нь үнэт цаас гаргагчийн хөрөнгө оруулагчийн өмнө хүлээсэн бондын төлбөрийн үүргийн талаарх мэдээллийг СЗХ-ны шийдвэрийг үндэслэн тухай бүр Монголбанкны Зээлийн мэдээллийн санд нийтлэх үүрэгтэй.
- Андеррайтер нь СЗХ-нд бүртгүүлсэн бондын танилцуулгыг нийтэд үнэ төлбөргүй хүргэх, сонирхсон бүх этгээдийг танилцах боломжоор хангах үүрэгтэй.
- Андеррайтер нь дотоод мэдээлэл эзэмшигч тул үнэт цаас гаргагчаас энэхүү гэрээний дагуу олж мэдсэн нийтэд ил тод болж тараагдаагүй бүх төрлийн мэдээлэл, баримт бичгийг бусдад задруулахгүй байх, задруулж болох нөхцөлийг бүрдүүлэхгүй үүрэгтэй.
- Хууль, дүрэм журамд заасан бусад эрх, үүрэг.

Үнэт цаас гаргагчийн эрх үүрэг:

- Үнэт цаас гаргагч нь энэхүү гэрээнд заасан мэргэжлийн үйлчилгээг авахтай холбоотой хуулиар хориглоогүй өөрийн үйл ажиллагаа, үйлчилгээ, санхүүгийн нөхцөл байдал, бусадтай байгуулсан гэрээ хэлцэл болон бусад бодит байдлын талаар Андеррайтерт үнэн зөв мэдээлэх үүрэг хүлээнэ.
- Үнэт цаас гаргагч нь бэлтгэн өгч буй мэдээллийн үнэн зөвийг хариуцах ба уг үүргээ биелүүлээгүйгээс үүдсэн аливаа хохирлыг хариуцна.
- Андеррайтерийн ажлын хөлсийг Гэрээнд заасан хугацаанд төлөх үүрэгтэй.
- Үнэт цаас гаргахтай холбоотой хууль, журамд заасан шаардлагыг хангах, арга хэмжээг авч хэрэгжүүлэх үүрэгтэй.
- Гэрээт ажлын хүрээнд дотоод аудитын хяналт шалгалтыг явуулах эрхтэй.
- Андеррайтераас Гэрээний дагуу хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах эрхтэй.
- Андеррайтертай хамтран ажиллахдаа хөрөнгө оруулагчдын хууль ёсны эрх ашгийг чухалчлан үзнэ.
- Үнэт цаас гаргагч нь андеррайтераас гаргасан нарийвчилсан шинжилгээ, судалгаа, дүгнэлтэд үндэслэн нийтэд санал болгох бондын үнэ, хүүгийн түвшинг тогтоох эрхтэй.
- Үнэт цаас гаргагч нь компанийн санхүүжих чадавхийн зэрэглэл тогтоох эрх бүхий байгууллагаар зэрэглэл тогтоолгох эрхтэй.
- Үнэт цаас гаргагч нь санхүүжих чадавхын зэрэглэл тогтоох эрх бүхий байгууллагаар зэрэглэл тогтоолгох бол зэрэглэл тогтооход шаардлагатай үнэн зөв, бүрэн мэдээллийг тухайн байгууллагад гарган өгнө.
- Үнэт цаас гаргагч нь зэрэглэл тогтоолгосон бол хагас жил, бүтэн жил тутам зэрэглэлийг шинэчилнэ.
- Үнэт цаас гаргагч нь мэдээллийн ил тод байдлыг тогтмол хангах, хөрөнгө оруулагчийн өмнө хүлээсэн үүргээ хэрэгжүүлж ажиллана.
- Үнэт цаас гаргагч нь Андеррайтерийг үнэт цаас гаргагчийн хөрөнгө оруулагчийн өмнө хүлээсэн бондын төлбөрийн үүргийн талаарх мэдээллийг Монголбанкны Зээлийн мэдээллийн санд нийлүүлэхийг зөвшөөрч байна.
- Үнэт цаас гаргагч нь татан төвлөрүүлсэн хөрөнгийг зориулалтын дагуу зардуулах үүрэгтэй.
- Хууль, дүрэм журамд заасан бусад эрх үүрэг.



3.2. Аудитын компанийн танилцуулга

**PWC**

Регистрийн дугаар:	5357128
Улсын бүртгэлийн дугаар:	9019050116
Хаяг:	Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Централ Тауэр, 6 давхарт, 601 тоот
Утас:	+976-7000 9089, +976-11-322-068
Вебсайт:	www.pwc.com

"Прайсуотерхаускуперс Аудит" ХХК нь 2010 оны 4-р сард Монгол Улсад үүсгэн байгуулагдаж үйл ажиллагаагаа эхлүүлсэн. Аудитын багийн гишүүдэд "ACCA" (Олон улсын Мэргэшсэн нягтлан бодогчдын холбоо) жинхэнэ гишүүн, оюутан болон Олон улсын Мэргэшсэн нягтлан бодогч "CPA" болон "CISA" Кибер аюулгүй байдал, дэд бүтцийн аюулгүй байдлын газрын баталгаажуулалт, Монголын мэргэшсэн нягтлан бодогчийн цолтой, аудит болон баталгаажуулах үйлчилгээг үзүүлэх эрхийн батламжтай ажилтнууд багтана.

3.2.1. Аудитын компанийн тусгай зөвшөөрөл

"Прайсуотерхаускуперс Аудит" ХХК нь СЗХ-ны 2012 оны 08 сарын 08-ний өдрийн 259 дүгээр тогтоолын дагуу үнэт цаасны зах зээлд оролцогчид аудитын үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдээр бүртгүүлсэн.

3.2.2. Аудитын компанитай байгуулсан гэрээний тухай

Аудитын компани нь 2022 оны 04 сарын 07-ны өдөр банктай байгуулсан Баталгаажуулалт-48030043-A027-2021 тоот аудитын үйлчилгээ үзүүлэх гэрээний хүрээнд ХААН Банкны 2022 оны 12 сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж, дүгнэлт гаргасан.


Гэрээний хүрээнд "Прайсуотерхаускуперс Аудит" ХХК нь Үнэт цаас гаргагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг СТОУС-ын дагуу бүх материаллаг зүйлсийн үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхэд аудит хийж, аудиторын тайлан гаргах ажиллагаанд үйлчилгээ үзүүлж ажилласан.

Аудитын компанийн эрх, үүрэг:


- Аудитын байгууллага нь үйлчилгээ үзүүлэхдээ Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан аудитын олон улсын стандартын дагуу үйлчилгээ үзүүлэх ба үүний хүрээнд үнэт цаас гаргагчаас хараат бус байдлаар, мэргэжлийн, ёс зүйтэй үйлчилгээ үзүүлэх үүрэгтэй.
- Банкны удирдлагын хувьд банкны Нягтлан бодох бүртгэлийг СТОУС-ын дагуу хөтөлж, санхүүгийн тайлангийн бүртгэл, банкны ажил гүйлгээтэй холбоотой бүртгэл хөтөлтийн үнэн зөв байдалд хариуцлага хүлээх үүрэгтэй бөгөөд санхүүгийн нөхцөл байдлын болон үр дүн, мөнгөн гүйлгээний үзүүлэлтүүдийг үнэн зөвөөр мэдээлэх шаардлагатай.
- Мөн банкны удирдлага нь аудитын зүгээс үйлчилгээг зохих ёсоор үзүүлэхэд шаардлагатай гэж үзсэн нягтлан бодох бүртгэлийн болон бусад бүхий л мэдээллийг тухай бүр бэлтгэн гаргаж өгөх бөгөөд Аудитаас шаардсан тохиолдолд нэмэлт мэдээлэл, нотлох баримт бичгийг тухай бүр бэлтгэн гаргаж өгөх үүрэгтэй. Түүнчлэн холбогдох бичиг баримт нь алдаатай эсхүл бүрдэл дутуун



2023 5 29



шаардлага хангаагүй нөхцөлд аудитын байгууллагын тавьсан шаардлагын дагуу баримт бичгийг бүрдүүлэх, бодитой мэдээллээр хангах, шаардлагатай бичиг баримтыг эрх бүхий байгууллагаар баталгаажуулах үүрэг хүлээсэн байна.



Үнэлгээний компанийн танилцуулга

Регистрийн дугаар: 5211875

Улсын бүртгэлийн дугаар: 9018001052

"Эвиденсе Аудит" ХХК



Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, СБД, 9-р хороо, 7-р хороолол, Алтанй гудамж 281, Хийморь оффис -502 тоот.

Утас: +976-7000 7121

И-мэйл: Info@evidenceaudit.mn

Вебсайт: www.evidenceaudit.mn

3.3.1. Үнэлгээний компанийн тусгай зөвшөөрөл

"Эвиденсе Аудит" ХХК нь СЗХ-ны 2012 оны 08 сарын 08-ний өдрийн 261 дүгээр тогтоолын дагуу үнэт цаасны зах зээлд оролцогчид аудит, үл хөдлөх хөрөнгийн үнэлгээ хийх үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдээр бүртгүүлсэн.

3.3.2. Үнэлгээний компанитай байгуулсан гэрээний тухай

ХААН Банк нь 2023 оны 05 дугаар сарын 09-ны өдөр "Эвиденсе аудит" ХХК-тай хөрөнгийн үнэлгээ хийх үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулсан.

Гэрээний хүрээнд ногоон бондыг санал болгон гаргахтай холбоотойгоор "ХААН Банк" ХК-ийн хөрөнгийн үнэлгээг олон улсын үнэлгээний стандартад нийцүүлэн Монгол улсын холбогдох хууль, тогтоомж, журам, аргачлалын дагуу хөрөнгийн үнэлгээний тайланг бэлтгэж, ногоон бонд санал болгохтой холбоотой Санхүүгийн зохицуулах хорооноос зөвшөөрөл авах, Монголын хөрөнгийн биржид бүртгүүлэх зэрэг ажиллагааг гүйцэтгэхэд хөрөнгийн үнэлгээний тайлан гаргах мэргэжлийн үйлчилгээ үзүүлж ажилласан.

Үнэлгээний байгууллага нь үйлчилгээ үзүүлэхдээ Монгол улсын хууль тогтоомжид нийцүүлэн мэргэжлийн өндөр түвшинд, хугацаанд нь, чанартай, шударгаар, амжилттай хийж гүйцэтгэн, хамтран ажиллах үүрэгтэй. Түүнчлэн үнэлгээний байгууллага нь дотоод мэдээлэл эзэмшигч тул үйлчилгээ үзүүлж буй байгууллагаас олж мэдсэн нийтэд ил тод болж тараагдаагүй бүх төрлийн мэдээлэл, баримт бичгийг бусдад задруулахгүй байх, задруулж болох нөхцөлийг бүрдүүлэхгүй байх, мэдээллийг үндэслэн үнэт цаасны арилжаанд оролцохгүй байх, бусад этгээдийг арилжаанд оролцохыг санал болгох, ятгахгүй байх үүрэгтэй.

Банкны удирдлага нь үнэлгээний мэргэжлийн үйлчилгээг авахтай холбоотой хуулиар хориглоогүй мэдээлэл, баримт бичгийн талаар Үнэлгээний байгууллагад үнэн зөв мэдээлэх шаардлагатай.



БОНДЫН ТАНИЛЦУУЛГА



2023 5 29

**3.4. Хөрөнгийн үнэлгээний тайлангийн хураангуй**

Хараат бус үнэлгээний байгууллага "Эвиденсе Аудит" ХХК-ийн ХААН Банк ХХК-д гүйцэтгэсэн хөрөнгийн үнэлгээний үр дүнд үнэт цаас гаргагчийн хөрөнгийн үнэлгээ дараах байдалтай байна. Үүнд:

- Эргэлтийн хөрөнгө: ХААН банк ХК-ийн эзэмшиж буй эргэлтийн хөрөнгө нь үнэлгээний өдрийн байдлаар 14,360,888,619.0 мянган төгрөгийн бодит үнэ цэнэтэй байна.
- Эргэлтийн бус хөрөнгө: Үнэлгээний байгууллага нь ХААН Банк ХХК-ийн эзэмшиж буй үндсэн хөрөнгийн барилга, байгууламжийн ангийн хөрөнгүүдэд холбогдох шинжилгээ хийсний үндсэн дээр өртгийн хандлагаас нэгж хүчин чадлын жишиг үнэлгээний нөхөн орлуулах өртгийн арга, зах зээлийн хандлагаас жишиг арилжааны харьцуулалтын аргыг сонгон ашигласан байна. ХААН Банк ХХК-ийн эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө нь үнэлгээний өдрийн байдлаар 592,595,651.9 мянган төгрөгийн бодит үнэ цэнэтэй байх үндэслэлтэй хэмээн дүгнэсэн байна.

3.5. Хуулийн нөхөрлөлийн танилцуулга

Үнэт цаас гаргагч нь хувьцаагаа нийтэд санал болгох ажиллагаанд Өмгөөллийн "ХаанЛекс Партнерс" ХХН фирмтэй "Хуулийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээ" байгуулан хамтран ажиллаж байна.



Өмгөөллийн "ХаанЛекс
Партнерс" ХХН

Регистрийн дугаар: 6351034

Улсын бүртгэлийн дугаар: 9022003026

Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Олимпын гудамж 5, Аюуд тауэр, 14 давхар 1404 тоот

Утас: 7747-1122

И-мэйл: info@khanlex.mn

Вебсайт: www.khanlex.mn

Өмгөөллийн "ХаанЛекс Партнерс" ХХН нь банк санхүү, үнэт цаас, дэд бүтэц, эрчим хүч, шүүхийн маргаан, бизнесийн болон компанийн эрх зүйн салбарт голчлон хууль зүйн мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлдэг Монголын тэргүүлэх хуулийн фирмүүдийн нэг юм. Өнгөрсөн арав гаруй жилийн хугацаанд өөрсдийн үйлчилгээ, мэдлэг, туршлагаа олон улсын зах зээлийн томоохон оролцогч нарт хүргэж ирсэн ба эдгээрт олон улсын хөгжлийн банк, санхүүгийн байгууллагууд, гадаадын төрийн өмчит болон хувийн салбарын тэргүүлэгч компаниуд багтдаг.

Хуулийн фирм нь Монгол Улсад хийгдсэн олон улсын шинжтэй томоохон гэрээ, хэлцлүүдэд эрх зүйн зөвлөгөө өгч, амжилттай ажилласан ба тэдгээрийн зарим нь олон улсын хэмжээнд танигдаж, хүлээн зөвшөөрөгдсөн байдаг. Түүнчлэн, хууль зүйн зөвлөгөө өгч ажилладаг үндсэн эрх зүйн салбарууд (банк санхүү, дэд бүтэц, бизнесийн эрх зүй, шүүхийн маргаан зэрэг)-аас гадна хурдтай хөгжиж буй "ногоон санхүүжилт"-ийн эрх зүйн чиглэлээр ажилласан байдал, туршлагаараа Монгол Улсын хуулийн фирмүүдийн дунд тэргүүлэх байр суурь эзэлж байна.

3.5.1. Хуулийн нөхөрлөлийн тусгай зөвшөөрөл

Өмгөөллийн "ХаанЛекс Партнерс" ХХН нь 2018 оны 09 сарын 02-ны өдөр Улсын бүртгэлд бүртгүүлсэн ба нөхөрлөл нь 2020 оны 6 сарын 10-ны өдрийн 338 дугаар тогтоолоор үнэт цаасны зах зээлд оролцогчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэх зөвшөөрлийг Санхүүгийн зохицуулах хорооноос авсан.

**3.5.2. Хуулийн нөхөрлөлтэй байгуулсан гэрээний тухай**

Хуулийн зөвлөх нь Үнэт цаас гаргагч ХААН Банкны ногоон бонд санал болгон гаргах ажиллагаанд 2023 оны 5 дугаар сарын 09-ний өдөр хуулийн зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулсан.

ХААН Банкны ногоон бонд санал болгон гаргах ажиллагаанд дараах эрх үүрэгтэйгээр оролцож байна. Үүнд:

Хуулийн зөвлөхийн эрх, үүрэг:

- Хуулийн зөвлөх нь гэрээний 3.1-д заасан болон гэрээнд заасан бусад ажил үйлчилгээг Монгол улсын хууль тогтоомжийн дагуу нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн мэргэжлийн болон бодит жишигт нийцүүлэн, хугацаанд нь чанартай, шударгаар хийж гүйцэтгэн, гэрээ болон үйлчилгээтэй холбоотой ямарваа нэгэн асуудлаар ямагт Банкны зөвлөхийн хувиар ажиллаж, Үнэт цаас гаргагчийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах үүрэг хүлээнэ;
- Хуулийн зөвлөх нь гэрээний хугацаанд бусад арилжааны банкуудад гэрээний 3.1-д заасан ажил үйлчилгээг үзүүлэхгүй буюу Бонд гаргах ажиллагаанд хамтран ажиллахгүй байх үүрэг хүлээнэ;
- Тус гэрээнд заасан дүгнэлтийн агуулгатай холбоотойгоор Банкнаас нэмэлт тодруулга хүссэн тохиолдолд дэлгэрэнгүй тайлбар, тодруулга өгөх үүрэгтэй;
- Гэрээний явцад Үнэт цаас гаргагчид гаргаж өгсөн мэдээлэл, зөвлөгөө, дүгнэлт, холбогдох баримт бичгийн үнэн зөв, бүрэн гүйцэд, бодит байдлыг хариуцах үүрэгтэй;
- Хуулийн зөвлөх нь Үнэт цаас гаргагчийг гэрээнд заасан ажил үйлчилгээтэй холбоотой үнэн бодит мэдээллээр тухай бүр хангаж, зөвлөгөө өгч ажиллах үүрэгтэй;
- Гэрээнд заасан ажил үйлчилгээг гүйцэтгэхтэй холбоотой аливаа асуудлаар Үнэт цаас гаргагчтай хамтран ажиллах андеррайтер, аудит, үнэлгээний болон бусад хөндлөнгийн байгууллагатай хамтран ажиллаж, шаардлагатай арга хэмжээг шуурхай шийдвэрлэх үүрэгтэй;
- Гэрээт ажлын хүрээнд Үнэт цаас гаргагчид дотоод аудитын хяналт шалгалт хийгдэх тохиолдолд тухайн ажилтай холбоотой шаардлагатай баримт материал гаргаж өгөх, баримт бичигт чөлөөтэй хандах эрх олгох зэргээр хамтран ажиллах үүрэгтэй;
- Хуулийн зөвлөх нь гэрээний 3.1-д заасан ажил үйлчилгээг гүйцэтгэхэд шаардлагатай хууль тогтоомжид заасан мэдээлэл, баримт бичгийн жагсаалт, түүнд тавих шаардлагын талаарх мэдээллийг энэхүү гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш ажлын 5 хоногийн дотор үнэт цаас гаргагчид гаргаж өгнө;
- Хуулийн зөвлөхөөр ажиллаж буй өмгөөллийн нөхөрлөлүүдийн хамтран ажиллах зохион байгуулалт, удирдлага, эрх, үүрэг, хариуцлагыг нөхөрлөлүүдийн хооронд байгуулсан хамтран ажиллах гэрээгээр зохицуулах ба тус гэрээг Банканд ирүүлнэ. Банк шаардлагатай гэж үзсэн тохиолдолд уг хамтран ажиллах гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулахыг Хуулийн зөвлөхүүдээс шаардах эрхтэй.

Үнэт цаас гаргагчийн эрх, үүрэг:

- Гэрээний 3.1-д заасан үйлчилгээг авахтай холбоотой хуулиар хориглоогүй өөрийн үйл ажиллагааны талаар Хуулийн зөвлөхөд үнэн зөв мэдээлэх үүрэгтэй;
- Хуулийн зөвлөхөөр гэрээнд зааснаас өөр нэмэлт ажил гүйцэтгүүлж болно;
- Хуулийн зөвлөх үйлчилгээтэй холбоотой үйл ажиллагааны талаар мэдээллийг тухай бүр шаардан авах эрхтэй;
- Гэрээний 3.1-д заасан үйлчилгээг гүйцэтгэхтэй холбоотой шаардлага, санал, хүсэлт гаргах, тэдгээрийг шийдвэрлүүлэх эрхтэй;
- Хуулийн зөвлөхөөс гэрээний дагуу хүлээсэн үүргээ биелүүлэх, зохих ёсоор биелүүлэхийг шаардах эрхтэй.





Хууль тогтоомжид заасан бусад эрх, үүрэг.

3.6. Мэргэжлийн баталгаажуулалтын байгууллагын танилцуулга

Sustainable Fitch нь Environmental, social and governance (ESG)-ийн үнэлгээний Fitch Group-ийн хамаарал бүхий компани. Sustainable Fitch нь дэлхийн улс орнууд болон компаниудын байгаль, орчин, нийгэм, засаглалын хөндлөнгийн шинжилгээ, дүгнэлт гаргах үйл ажиллагаа явуулдаг.

Fitch Group нь дэлхийн 30 гаруй улсад үйл ажиллагаа явуулдаг бөгөөд 1,700 орчим зээл, эрсдэлийн шинжээчид ажилладаг.

3.6.1. Мэргэжлийн баталгаажуулалтын байгууллагатай хийсэн гэрээний тухай

ХААН Банк ХХК нь Sustainable Fitch байгууллагатай 2022 оны 11 сарын 10-ны өдөр 00147148.0/1811 дугаартай ESG буюу ногоон, нийгмийн, тогтвортой (Green, Social, and Sustainability) бондуудын үйл явцын хүрээнд хөндлөнгийн үнэлгээ, дүгнэлт гаргах үйлчилгээ үзүүлэх гэрээг байгуулсан.

3.7. Мэргэжлийн баталгаажуулалтын байгууллагын дүгнэлт

Sustainable Fitch нь ХААН Банк ХХК-ийн гаргасан "Ногоон бондын санхүүжилтийн хүрээ" баримт бичигт туссан ногоон бондын зарцуулалт буюу ногоон төслүүд болон хяналт, тайлагналын үйл ажиллагааг Олон улсын хөрөнгийн зах зээлийн холбоо (ICMA)-оос гаргасан ногоон бондын зарчмуудтай (Green Bond Principles) нийцэж буй эсэхэд дүгнэлт гаргасан.

Монгол Улс нь 2015 онд "Парисын хэлэлцээр"-т оролцсоноор "Үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийн зорилт"-ын бичиг баримтыг боловсруулж, үүний хүрээнд хүлэмжийн хийн ялгарлыг 2010 оны суурь нөхцөлтэй харьцуулахад 2030 он гэхэд 22.7 хувиар бууруулах амлалт өгсөн байна..

Үнэлгээний байгууллагаас ХААН Банкны ногоон зээлийг сэргээгдэх эрчим хүч, эрчим хүчний хэмнэлт, ногоон барилга байгууламж, бохирдлоос урьдчилан сэргийлэх, түүнд хяналт тавих, усны менежмент, тогтвортой хөдөө аж ахуй, мал аж ахуй төслүүдийг санхүүжүүлэх байдлаар олгогдож байгаа гэж үзсэн. Энэ нь Монгол улсын үндэсний хэмжээнд тодорхойлсон байгаль орчны тодорхой бодлогын зорилтуудтай нийцэж байна гэж үзсэн.

Мөн Sustainable Fitch-ийн A Second party opinion буюу хөндлөнгийн баталгаажуулалтын тайланд дурдснаар ХААН Банкны бондын зарцуулалт болон санхүүжүүлж буй ногоон зээлийг ногоон бондын зарчмуудтай нийцэж байгаа бөгөөд "Сайн" үнэлгээтэй үнэлсэн байна.





Энэхүү Бондын танилцуулга нь Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Санхүүгийн Зохицуулах Хорооны "Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам", Монголын хөрөнгийн биржийн "Үнэт цаасны бүртгэлийн журам" болон бусад холбогдох дүрэм, журмын шаардлагад нийцүүлэн үнэн зөв боловсруулагдсан болохыг баталж байна.

Мөн Монголын хөрөнгийн бирж болон Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлсэн энэхүү бондын танилцуулга нь хоорондоо адил бөгөөд ямар нэг зөрүүтэй мэдээлэл тусгагдаагүй болно.

ҮНЭТ ЦААСНЫ ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГЫГ БАТАЛГААЖУУЛСАН

ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ:

АНДЕРРАЙТЕР:

"ХААН БАНК" ХХК

"БидиСЕК ҮЦК" ХК

ГҮЗ-ИЙН ДАРГА

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Б.ЛХАГВАДОРЖ

[Signature]

Р.МӨНХТУЯА

САНХҮҮ, ЗАХИРГАА ХАРИУЦСАН ДЭД
ЗАХИРАЛ

[Signature]

Ш.ӨЛЗИЙ-АЮУШ

2023.05.29

НОГООН БОНД | MSE:KHAN | БОНДЫН ТАНИЛЦУУЛГА



МОНГОЛЫН УЛААСНЫ ХУУЛЬ
MONGOLIAN STATE LAW

0000001

2023-06-09

Андеррайтер.

БҮРТГЭВ-02

БиДисЕК ХК
ҮНЭТ ЦААСНЫ КОМПАНИ



Үнэт цаас гаргагч:



ХААН БАНК

ХААН БАНК | НОГООН БОНД

ХАВСРАЛТ

67 с 5207



2023





ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГЫН ХАВСРАЛТЫН ЖАГСААЛТ

№	Хавсралт материалын жагсаалт
1	Үнэт цаас гаргагчийн эрх бүхий этгээдийн шийдвэр
2	Үнэт цаас гаргагчийн улсын бүртгэлийн гэрчилгээ болон тусгай зөвшөөрлийн хуулбар
3	Аудитын тайлан
4	Ногоон танилцуулга
5	Зээлжих зэрэглэл тогтоосон үнэлгээний баримт бичиг
6	Хууль зүйн дүгнэлт
7	Үнэт цаас гаргагчийн эрх бүхий этгээдийн шийдвэр /нэмэлт/

2023 11 02



СХ
2023.06.13
БҮРТГЭВ
N

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-06-09
0000003
БҮРТГЭВ-02

Хавсралт 1

/Үнэт цаас гаргагчийн эрх бүхий этгээдийн шийдвэр/

2023 5 29



УЛААНБААТАР ХОТ
МХБ-ийн гишүүн
Андеррайтер
Брокер, дилерийн
"БИДСЕК"
УЦК ХК
111205441-112052454



НУУЦЛАЛТАЙ

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 5 дугаар
сарын 24-ний өдөр

№ 18

Улаанбаатар хот

Монгол улсын Компанийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2, 42 дугаар зүйлийн 42.1, 76 дугаар зүйлийн 76.1.5, 80 дугаар зүйлийн 80.2, Санхүүгийн зохицуулах хорооны Өрийн хэрэгслийн бүртгэлийн журмын 4.1, ХААН Банк ХХК-ийн Дүрмийн 5.4 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн;

Монгол улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан, 2693321 регистрийн дугаартай, Монгол Улсын Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 15-р хороо, Стадион Оргил-1, Чингисийн Өргөн Чөлөө-6-д бүртгэлтэй ХААН Банк ХХК (“Банк”), Хязгаарлагдмал Хариуцлагатай Компанийн доор гарын үсэг зурсан Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүд нь дараах тогтоолыг үүгээр үйлдэж батлав. Үүнд:

ҮНДЭСЛЭЛ Банк нь нийт 30 сая ам.доллар хүртэлх үнийн дүн бүхий “Ногоон бонд гаргах хөтөлбөр” (Бондын Хөтөлбөр) хэрэгжүүлэх, үүнээс 25 сая хүртэлх ам.доллартай тэнцэхүйц дүнгийн бондыг ам.доллараар гаргаж стратегийн хөрөнгө оруулагчдад санал болгох (Ам.долларын бондын санал), харин 5 сая хүртэлх ам.доллартай тэнцэхүйц дүн буюу 17 тэрбум хүртэлх дүнгийн бондыг төгрөгөөр гаргаж олон нийтэд санал болгох (Төгрөгийн бондын санал)-ыг;

ҮНДЭСЛЭЛ Бондын Хөтөлбөрийн хүрээнд гаргах бондуудыг Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан нийтэд нээлттэй хэлбэрээр хэсэгчлэн санал болгон гаргахыг;

ҮНДЭСЛЭЛ Бондын Хөтөлбөрийн хүрээнд гаргах 170,000 хүртэлх тооны Төгрөгийн бондын нэгжийн нэрлэсэн үнэ 100,000 төгрөг, 250,000 хүртэлх тооны Ам.долларын бондын нэгжийн нэрлэсэн үнэ 100 ам.доллар байхыг;

ҮНДЭСЛЭЛ Бондын Хөтөлбөрийн хугацаа 24 сар хүртэл байхыг;

ҮНДЭСЛЭЛ Бондын Хөтөлбөрийн хүрээнд гарах Төгрөгийн бондын хугацаа 3 хүртэл жил, Ам.долларын бондын хувьд 3-5 хүртэл жил байхыг;

ҮНДЭСЛЭЛ Бондын хөтөлбөрийн хүрээнд гаргах бондуудыг хэсэгчлэн гаргах тухай бүр бондын хүүгийн нөхцөлийг тодорхойлох ба Ам.долларын бондын хувьд хөвөгч хүүтэй байх ба хүүгийн түвшин ам.долларын зах зээлийн 6 сарын “СМЕ Term SOFR” хүү дээр нэмэх нь жилийн 3.40-3.85% хязгаарт багтсан байх, харин Төгрөгийн бондын хувьд тогтмол хүүтэй байх ба хүүгийн түвшин жилийн 13.8-14.8% хязгаарт багтсан байхыг;

ҮНДЭСЛЭЛ Төгрөгийн бондын хувьд бондын үндсэн төлбөрийг бондын хугацааны эцэст бүтэн дүнгээр төлөх бол ам.долларын бондын үндсэн төлбөрийг төлөх хугацааг бондыг санал болгох тухай бүр тогтоохыг;

ҮНДЭСЛЭЛ Бондын хүүгийн төлбөрийг хагас жил тутамд төлөх нөхцөлтэй байхыг,

ҮНДЭСЛЭЛ Бондын хүрээнд татан төвлөрүүлсэн хөрөнгийг Банкны одоо хэрэгжиж буй “Ногоон Бондын Санхүүжилтийн Хүрээ”-нд тодорхойлсон төсөл хөтөлбөр, үйл ажиллагаануудыг (“Шаардлага хангасан ногоон зээлүүд”) бүхэлд нь эсхүл хэсэгчлэн санхүүжүүлэх болон дахин санхүүжүүлэхэд зарцуулахыг;

ҮНДЭСЛЭЛ Бондын Хөтөлбөрийн хүрээнд гаргах бондуудын хүү, хугацаа, гаргах хугацаа болон бусад нөхцөлүүдийг энэхүү тогтоолд нийцүүлэн тухай бүр Гүйцэтгэх Захирал тогтоож нийдвэрлэхийг;

Дээрх саналыг Төлөөлөн Удирдах Зөвлөл хүлээн зөвшөөрснийг ҮНДЭСЛЭН ТОГТООХ нь:



2023 5 29



НУУЦИАЛТАЙ

- ТОГТООХ НЬ:** Бондын хөтөлбөрийг дээрх нөхцлийн дагуу хэрэгжүүлэхийг хүлээн зөвшөөрч баталгаажуулсугай.
- ТОГТООХ НЬ:** Бондын танилцуулгыг дээр дурдсан нөхцөлүүд болон бусад шаардлагатай мэдээллийн хүрээнд боловсруулж, гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулах бүрэн эрхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга (эсхүл төлөөлөн удирдах зөвлөлийн орлогч дарга), Гүйцэтгэх захирал болон ерөнхий нягтлан бодогч буюу Санхүү, захиргаа хариуцсан дэд захирал нарт олгосугай.
- ТОГТООХ НЬ:** Монгол Улсын холбогдох хууль, хэм хэмжээ тогтоосон эрх зүйн актуудын хүрээнд төрийн эрх бүхий зохицуулагч байгууллагуудад Бондын хөтөлбөрийг бүртгүүлэх, хөтөлбөрийн хүрээн бонд гаргахад шаардлагатай зөвшөөрөл авах, анхдагч зах зээлийн арилжаа зохион байгуулж бондын санхүүжилтийг татан төвлөрүүлэх, шаардлагатай эсхүл зохистой гэж үзсэн холбогдох бүхий л баримт бичигт гарын үсэг зурах, баталгаажуулах, шаардлагатай бүх арга хэмжээг авч энэхүү тогтоолын гүйцэтгэлийг хангах бүрэн эрхийг Гүйцэтгэх захирал эсвэл түүний томилсон этгээдэд олгосугай.

БАТЛАВ



Д.Хулан

Ясунари Харада

Ц.Баатарсайхан

Иший Кисабуро

Жон Ло

А.Тамир

Ханс Аарт Йонгеянс

Б.Амарсанаа



2023 5 29



НУУЦЛАЛТАЙ

- ТОГТООХ НЬ:** Бондын хөтөлбөрийг дээрх нөхцлийн дагуу хэрэгжүүлэхийг хүлээн зөвшөөрч баталгаажуулсугай.
- ТОГТООХ НЬ:** Бондын танилцуулгыг дээр дурдсан нөхцөлүүд болон бусад шаардлагатай мэдээллийн хүрээнд боловсруулж, гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулах бүрэн эрхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга (эсхүл төлөөлөн удирдах зөвлөлийн орлогч дарга), Гүйцэтгэх захирал болон ерөнхий нягтлан бодогч буюу Санхүү, захиргаа хариуцсан дэд захирал нарт олгосугай.
- ТОГТООХ НЬ:** Монгол Улсын холбогдох хууль, хэм хэмжээ тогтоосон эрх зүйн актуудын хүрээнд төрийн эрх бүхий зохицуулагч байгууллагуудад Бондын хөтөлбөрийг бүртгүүлэх, хөтөлбөрийн хүрээн бонд гаргахад шаардлагатай зөвшөөрөл авах, анхдагч зах зээлийн арилжаа зохион байгуулж бондын санхүүжилтийг татан төвлөрүүлэх, шаардлагатай эсхүл зохистой гэж үзсэн холбогдох бүхий л баримт бичигт гарын үсэг зурах, баталгаажуулах, шаардлагатай бүх арга хэмжээг авч энэхүү тогтоолын гүйцэтгэлийг хангах бүрэн эрхийг Гүйцэтгэх захирал эсвэл түүний томилсон этгээдэд олгосугай.

БАТЛАВ

Т.Дарьбум

Д.Хулан

Ясунари Харала



А.Тамир

Ханс Аарт Йонгяанс

Б.Амарсанаа

2023 5 29





НУУЦЛАЛТАЙ

- ТОГТООХ НЬ:** Бондын хөтөлбөрийг дээрх нөхцлийн дагуу хэрэгжүүлэхийг хүлээн зөвшөөрч баталгаажуулсугай.
- ТОГТООХ НЬ:** Бондын танилцуулгыг дээр дурдсан нөхцөлүүд болон бусад шаардлагатай мэдээллийн хүрээнд боловсруулж, гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулах бүрэн эрхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга (эсхүл төлөөлөн удирдах зөвлөлийн орлогч дарга), Гүйцэтгэх захирал болон ерөнхий нягтлан бодогч буюу Санхүү, захиргаа хариуцсан дэд захирал нарт олгосугай.
- ТОГТООХ НЬ:** Монгол Улсын холбогдох хууль, хэм хэмжээ тогтоосон эрх зүйн актуудын хүрээнд төрийн эрх бүхий зохицуулагч байгууллагуудад Бондын хөтөлбөрийг бүртгүүлэх, хөтөлбөрийн хүрээнд гаргахад шаардлагатай зөвшөөрөл авах, анхдагч зах зээлийн арилжаа зохион байгуулж бондын санхүүжилтийг татан төвлөрүүлэх, шаардлагатай эсхүл зохистой гэж үзсэн холбогдох бүхий л баримт бичигт гарын үсэг зурах, баталгаажуулах, шаардлагатай бүх арга хэмжээг авч энэхүү тогтоолын гүйцэтгэлийг хангах бүрэн эрхийг Гүйцэтгэх захирал эсвэл түүний томилсон этгээдэд олгосугай.

БАТЛАВ

Т.Дарьбум



Ц.Баатарсайхан

Иший Кисабуро

Жон Ло

А.Тамир

Ханс Аарт Йонгеянс

Б.Амарсанаа



2023 5 29



ХААН БАНК



НУУЦЛАЛТАЙ

- ТОГТООХ НЬ:** Бондын хөтөлбөрийг дээрх нөхцлийн дагуу хэрэгжүүлэхийг хүлээн зөвшөөрч баталгаажуулсугай.
- ТОГТООХ НЬ:** Бондын танилцуулгыг дээр дурдсан нөхцөлүүд болон бусад шаардлагатай мэдээллийн хүрээнд боловсруулж, гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулах бүрэн эрхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга (эсхүл төлөөлөн удирдах зөвлөлийн орлогч дарга), Гүйцэтгэх захирал болон ерөнхий нягтлан бодогч буюу Санхүү, захиргаа хариуцсан дэд захирал нарт олгосугай.
- ТОГТООХ НЬ:** Монгол Улсын холбогдох хууль, хэм хэмжээ тогтоосон эрх зүйн актуудын хүрээнд төрийн эрх бүхий зохицуулагч байгууллагуудад Бондын хөтөлбөрийг бүртгүүлэх, хөтөлбөрийн хүрэн бонд гаргахад шаардлагатай зөвшөөрөл авах, анхдагч зах зээлийн арилжаа зохион байгуулж бондын санхүүжилтийг татан төвлөрүүлэх, шаардлагатай эсхүл зохистой гэж үзсэн холбогдох бүхий л баримт бичигт гарын үсэг зурах, баталгаажуулах, шаардлагатай бүх арга хэмжээг авч энэхүү тогтоолын гүйцэтгэлийг хангах бүрэн эрхийг Гүйцэтгэх захирал эсвэл түүний томилсон этгээдэд олгосугай.

БАТЛАВ



Т.Дарьбум

Д.Худан

Ясунари Харата

Ц.Баатарсайхан

Иший Кисабуро

Жон Ло


А.Тамир

Ханс Аарт Йонгеганс

Б.Амарсанаа



2023 5 29



- 1. ТОГТООХ НЬ:** Бондын хөтөлбөрийг дээрх нөхцлийн дагуу хэрэгжүүлэхийг хүлээн зөвшөөрч баталгаажуулсугай.
- 2. ТОГТООХ НЬ:** Бондын танилцуулгыг дээр дурдсан нөхцөлүүд болон бусад шаардлагатай мэдээллийн хүрээнд боловсруулж, гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулах бүрэн эрхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга (эсхүл төлөөлөн удирдах зөвлөлийн орлогч дарга), Гүйцэтгэх захирал болон ерөнхий нягтлан бодогч буюу Санхүү, захиргаа хариуцсан дэд захирал нарт олгосугай.
- 3. ТОГТООХ НЬ:** Монгол Улсын холбогдох хууль, хэм хэмжээ тогтоосон эрх зүйн актуудын хүрээнд төрийн эрх бүхий зохицуулагч байгууллагуудад Бондын хөтөлбөрийг бүртгүүлэх, хөтөлбөрийн хүрээн бонд гаргахад шаардлагатай зөвшөөрөл авах, анхдагч зах зээлийн арилжаа зохион байгуулж бондын санхүүжилтийг татан төвлөрүүлэх, шаардлагатай эсхүл зохистой гэж үзсэн холбогдох бүхий л баримт бичигт гарын үсэг зурах, баталгаажуулах, шаардлагатай бүх арга хэмжээг авч энэхүү тогтоолын гүйцэтгэлийг хангах бүрэн эрхийг Гүйцэтгэх захирал эсвэл түүний томилсон этгээдэд олгосугай.

БАТЛАВ

Т.Дарьбум

Д.Хулан



Иший Кисабуро

Жон Ло


А.Тамир

Ханс Аарт Йонгеянс

Б.Амарсанаа

2023 5 29





- ТОГТООХ НЬ:** Бондын хөтөлбөрийг дээрх нөхцлийн дагуу хэрэгжүүлэхийг хүлээн зөвшөөрч баталгаажуулсугай.
- ТОГТООХ НЬ:** Бондын танилцуулгыг дээр дурдсан нөхцөлүүд болон бусад шаардлагатай мэдээллийн хүрээнд боловсруулж, гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулах бүрэн эрхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга (эсхүл төлөөлөн удирдах зөвлөлийн орлогч дарга), Гүйцэтгэх захирал болон ерөнхий нягтлан бодогч буюу Санхүү, захиргаа хариуцсан дэд захирал нарт олгосугай.
- ТОГТООХ НЬ:** Монгол Улсын холбогдох хууль, хэм хэмжээ тогтоосон эрх зүйн актуудын хүрээнд төрийн эрх бүхий зохицуулагч байгууллагуудад Бондын хөтөлбөрийг бүртгүүлэх, хөтөлбөрийн хүрэн бонд гаргахад шаардлагатай зөвшөөрөл авах, анхдагч зах зээлийн арилжаа зохион байгуулж бондын санхүүжилтийг татан төвлөрүүлэх, шаардлагатай эсхүл зохистой гэж үзсэн холбогдох бүхий л баримт бичигт гарын үсэг зурах, баталгаажуулах, шаардлагатай бүх арга хэмжээг авч энэхүү тогтоолын гүйцэтгэлийг хангах бүрэн эрхийг Гүйцэтгэх захирал эсвэл түүний томилсон этгээдэд олгосугай.

БАТЛАВ

Т.Дарьбум

Д.Хулан

Ясунари Харада

Ц.Баатарсайхан

Иший Кисабуро

Жон Ло



Б.Амарсанаа



2023 5 29



1. **ТОГТООХ НЬ:** Бондын хөтөлбөрийг дээрх нөхцлийн дагуу хэрэгжүүлэхийг хүлээн зөвшөөрч баталгаажуулсугай.

2. **ТОГТООХ НЬ:** Бондын танилцуулгыг дээр дурдсан нөхцөлүүд болон бусад шаардлагатай мэдээллийн хүрээнд боловсруулж, гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулах бүрэн эрхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга (эсхүл төлөөлөн удирдах зөвлөлийн орлогч дарга), Гүйцэтгэх захирал болон ерөнхий нягтлан бодогч буюу Санхүү, захиргаа хариуцсан дэд захирал нарт олгосугай.

3. **ТОГТООХ НЬ:** Монгол Улсын холбогдох хууль, хэм хэмжээ тогтоосон эрх зүйн актуудын хүрээнд төрийн эрх бүхий зохицуулагч байгууллагуудад Бондын хөтөлбөрийг бүртгүүлэх, хөтөлбөрийн хүрэн бонд гаргахад шаардлагатай зөвшөөрөл авах, анхдагч зах зээлийн арилжаа зохион байгуулж бондын санхүүжилтийг татан төвлөрүүлэх, шаардлагатай эсхүл зохистой гэж үзсэн холбогдох бүхий л баримт бичигт гарын үсэг зурах, баталгаажуулах, шаардлагатай бүх арга хэмжээг авч энэхүү тогтоолын гүйцэтгэлийг хангах бүрэн эрхийг Гүйцэтгэх захирал эсвэл түүний томилсон этгээдэд олгосугай.

БАТЛАВ

Т.Дарьбум

Д.Хулан

Ясунари Харада

Ц.Баатарсайхан



А.Тамир

Ханс Аарт Йонгеянс

Б.Амарсанаа

2023 5 29



2023 06 13
ср өдөр
БҮРТГЭВ
№

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 06 13
БҮРТГЭВ-02

Хавсралт 2

/Үнэт цаас гаргагчийн улсын бүртгэлийн гэрчилгээ болон тусгай зөвшөөрлийн хуулбар/

2023 5 29



МХ
он 2023 сар 06, 1 өдөр

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN EXCHANGE

2023-06-09

БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ



МОНГОЛ УЛС
ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

000268227

2005.11.04

/ Бүртгэсэн он, сар, өдөр /

9016001011

/ Хувийн хэргийн дугаар /

2693321

/ Регистрийн дугаар /

ХААН Банк

Хязгаарлагдмал хариуцлагатай
КОМПАНИ

/ Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /

Дүрэм

/ Үүсгэн байгуулах баримт бичиг /

Шийдвэр

/ Шийдвэрийн нэр /

01

/ Дугаар /

2001.03.08

/ Он, сар, өдөр /

6499

Үнэт цаас гаргах, худалдах, худалдан авах

6492

Зээл, гадаад дотоод төлбөр тооцоо

6499

Үнэт зүйл хадгалэх, санхүүгийн түрээс

6419

Мөнгөн хадгаламж, гадаад валют худалдах, худалдан авах /1991.12.05-/

6520

Даатгалын зуучлагчийн үйлчилгээ

6619

Үнэт цаасны тухайлсан бүртгэлийн үйл ажиллагаа

66190

Факторингийн үйлчилгээ эрхлэх

/ Код /

/ Үйл ажиллагааны чиглэл /



Хугацаагүй

/ хугацаа /

4140

/ гишүүдийн тоо /

172,097,820.00

/ хөрөнгийн хэмжээ, мөнгөн төгрөгөөр /

Улаанбаатар, Хан-Уул, 15-р хороо, чингисийн өргөн чөлөө, -6, Стадион Оргил-1, Утас1:

11332333-3053, Утас2: 11332333-3056, Факс: 70117023

/ хуулийн этгээдийн албан ёсны хаяг /



УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР
ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГАЗАР

/ Бүртгэсэн байгууллагын нэр /

УЛСЫН БҮРТГЭГЧ

ГЭМДЭГ

С.МӨНХСАНЧИР

Гарын

Гэрчилгээ дахин олгосон 2023 он 03 сар 27 өдөр



670 2023



Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт өөрчлөлтийн бүртгэл

Д/д	Нэмэлт өөрчлөлтийн агуулга	Бүртгэсч	
		Огноо	Ажилтан тэмдэг
1	Рэнцэнбат овогтой Мөнхтуяа-г Гүйцэтгэх захирал-р сонгосон(томилсон)-ыг бүртгэв.	2020.12.30	С.Цолмон
2	Дөхин гэрчилгээ олгов.	2023.03.27	С.Мөнхөнчир
3	Дүрийн 3.1.14, 3.1.15-т оруулсан өөрчлөлтийг бүртгэв.	2023.04.07	Э.Мөнхзана

2023 о.г. сар 10 өдөр Бүртгэлийн № 645
 Нийслэлийн хууль ёсны газартай
 Хүний Дотоод Ажилбарын
 Үйлчилгээний газар
 Хэрэг дүн

2023 5 20



Энэхүү гэрчилгээг хуурамчаар үйлдсэн этгээдэд Монгол Улсын хуулийн дагуу хариуцахаг хүлээн энэ Улсын бүртгэлийн гэрчилгээ засвартай бол хүчингүй.



СЭХ
0ч 2023 оны 06. 13 өдөр
Б

МОНГОЛЫН АЖИРАХЧИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
0000015
2023-06-09

МОНГОЛ УЛС



МОНГОЛБАНК

БАНКНЫ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

2006 оны 11. -р сарын
22 -ны өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

Монгол улсын Банкны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2000 оны 375 тоот тушаалаар батлагдсан “Банк, түүний нэгж байгуулах зөвшөөрлийн журам”-ыг үндэслэн

Чүрлэн байгууламждаг
-д *"ХолдИн Банк"*

..... оноосон нэр бүхий банк байгуулах зөвшөөрөл
ОЛГОВ.

Монгол банкны бүртгэлийн дугаар 06
Монголбанкны 1991 оны 12 дугаар сарын 05
сарийн 06 тоот зөвшөөрлийг үндэслэн
шинэглэн олгов.

/Энэхүү Гэрчилгээ нь хавсралтын хамт хүчинтэй./

МОНГОЛ УЛС
ЕРӨНХИЙЛӨГЧ

[Signature]

А. БАТСҮХ

УЛААНБААТАР ХОТ
МХБ-ийн гишүүн
Андеррайтер
Брокер, Инверсийн
"БИНДСЕК"
ХТХ/Х

[Signature]

675 2023

2023 06 13

БҮРТГЭВ-02

2023.06.13 өдөр
БҮРТГЭВ

... 02 ... ТООТ

ГЭРЧИЛГЭЭНИЙ ХАВСРАЛТ

2023 06 13

Энэхүү хавсралт нь гэрчилгээгүй бол хүчингүй/
УХИ 014



СЭХ
2523.00р.13 өдөр
БҮРТГЭВ
N

ГЭРЧИЛГЭЭНИЙ ХАВСРАЛТ

Банкны нэр: "ХААН Банк"
 Банкны хаяг: Баянзүрх дүүрэг, 4-р хороо, 15-р хороолол, Энхтайвныг өргөн чөлөө-51 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, V хороо, Сөүлийн гудамж 25

Нэг: "ХААН Банк" банкны эрхлэх үйл ажиллагааны талаархи тэмдэглэл

1. Монголбанкны Ерөнхийлөгчийн ... оны ... сарын ... -ны өдрийн ... тоот тушаалаар
 банкнд Банкны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан
 Монгол хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг олгов.

2. Бусад: 1. Гадаад валют худалдах, хадгалах

2. Үнэт зүйл хадгалах

3. Хөрөнгө оруулалт, санхүүгийн гэгээлээр зөвшөөрөл нэгдэллээ өгөх

4. Үнэт цаас худалдах, худалдан авах

5. Гадаад төлбөр тооцоо эрхлэх зөвшөөрөл
 (МБ-ийн 1993 оны 9 дүгээр сарын 22-ны өдрийн 3/270 тоот тушаал)

6. Улсын нэршил өмчөөс гуравдагч эрхлэхэд баталгаа, батлан даалт гаргах
 (МБ-ийн Ерөнхийлөгчийн 2007.12.6-ны 575 тоот тушаал)

7. Гадаад төлбөр тооцоо эрхлэх нэмэлт зөвшөөрөл
 (МБ-ийн Ерөнхийлөгчийн 2009.05.09-ний өдрийн 164 тоот тушаал)

8. Санхүүгийн тэрээсийн үйл ажиллагаа эрхлэх
 МБ-ын Ерөнхийлөгчийн 2010 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн 269 дүгээр тушаал

9. Зээл болон санхүүгийн бусад тэрээсийн худалдах, худалдан авах үйл ажиллагааг зөвшөөрөл
 (Монгол банкны Ерөнхийлөгчийн 2010 оны 11 дүгээр сарын 30-ны 684 тушаал)



МХБ-ийн Ганшуун
 Андеррантер
 Брокер, дилерийн
 "БНДСБ"
 УЦК ХХ
 1115205447 / 11152452

2023 06 13

БҮРТГЭВ-02

СХК
2023.06.13 өдөр
БҮРТГЭВ
А.Н.

Хоёр: Банкны нэгж, түүний байршлын талаархи тэмдэглэл

д/д	Нэгжийн төрөл	Ямар шийдвэрийг үндэслэн бүртгэсэн	Дугаар	Нэгжийн байршил, Хаяг

2023.05.29



00000109

БҮРТГЭВ-02

2023.05.13 өдөр
БҮРТГЭВ
№

Гурав: Банк, түүний нэгж байгуулах, банкны үйл ажиллагаа
эрхлэх зөвшөөрлийг хязгаарласан болон хүчингүй болгосон тухай

Монголбанкны 2010 оны 11 дүрээр сарын 25-ны өдрийн 6/1967
тоотгоор Хаанбанкны дүрмийн сан Савада Холдинг Лимитэд
2,612,941 ширхэг хувьцаа буюу 40,22%, Энэ Зо. Ийнхүү ширхэг
(Ариа) 829,016 ширхэг хувьцаа буюу 12,76%, Маван Богд Трейдинг
ХХК - 1,452,177 ширхэг хувьцаа буюу 22,35% иргэн Д. Аюуан
842,460 ширхэг хувьцаа буюу 12,97% Алан улсын санхүүгийн
корпораци 589,446 ширхэг буюу 9,07%, Деволемент Альтернативд
Унк 116,217 ширхэг хувьцаа буюу 1,79%, Монголын Холдинг
Лимитэд Партнершид ХХК - 43,324 ширхэг хувьцаа буюу 0,67%
Морроу Рамми Ревокал Траст 11,425 ширхэг хувьцаа буюу 0,18%
болж өөргөлт оруулсаныг зөвшөөрсөн бөгөөд 2011.01.01.



2023 5 29



МОНГОЛЫН ХААНЫ БАНК
MONGOLIAN HAANY BANK
000000-0
БҮРГЭ



МОНГОЛ УЛСЫН
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

Дугаар ТЗ 210/16

2012 оны 08 сарын 08 өдөр

Монгол улсын “Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль”, “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль”, бусад холбогдох хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 08 сарын 08 өдрийн 234 дугаар тогтоолоор “ХААН БАНК” ХХК -д

Даатгалын зуучлагчийн

үйл ажиллагаа эрхлэхийг зөвшөөрч, энэхүү гэрчилгээг олгов.

ДАРГА
“тамга”

S. Davasuren
С.ДАВААСҮРЭН

С.ДАВААСҮРЭН

Энэхүү гэрчилгээ нь
хавсралтын хамт
хүчинтэй





МОНГОЛ УЛС
МОНГОЛБАНК

15160 Улаанбаатар хот Чингэлтэй дүүрэг
Бага тойруу 3 Утас: 31-03-92 Факс: (975-11) 31-14-71
http://www.mongolbank.mn

2024. 11. 27 № А-6/1244
танай 2024. 09. 05-ны № 0119055 -т



ХААН БАНКНЫ ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ Н.КАТО ТАНАА

Танай банкинд Үнэт металл, эрдэнийн чулуу худалдах, худалдан авах, хадгалах, хадгалуулах үйл ажиллагаа эрхлэх нэмэлт зөвшөөрөл олгосон тухай Монголбанкны Ерөнхийлөгчийн 2014 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн А187 дугаар тушаалыг хавсралтаар хүргүүлж байна.

Танай банк холбогдох шимтгэлийн хураамжийг төлж, банкны зөвшөөрлийн гэрчилгээнд ажлын 3 (гурв) хоногийн дотор тэмдэглэгээ хийлгэнэ үү.

Хавсралт 1 хуудастай.

Хүндэтгэсэн

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ



Д.ГАНБАТ

14 4328

A5-2014.doc

2023. 5. 29



Handwritten signature



Handwritten signature



МОНГОЛБАНКНЫ
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУШААЛ



2014 оны 11 сарын 25 өдөр

Дугаар А-187

Улаанбаатар хот

Үйл ажиллагааны нэмэлт
зөвшөөрөл олгох тухай

Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт, Банкны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1.6 дахь заалт, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2012 оны А-80 дугаар тушаалаар батлагдсан "Банкны зөвшөөрлийн журам"-ын 4 дэх заалт болон ХААН банкнаас ирүүлсэн хүсэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.ХААН банкинд үнэт металл, эрдэнийн чулуу худалдах, худалдан авах, хадгалах, хадгалуулах үйл ажиллагаа эрхлэх нэмэлт зөвшөөрөл олгосугай.

2.Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шалгалтын газар (Д.Ганбат)-т даалгасугай.

ЕРӨНХИЙЛӨГЧ



Н.ЗОЛЖАРГАЛ

2023 5 29



14 1656

Tushaal 2014.doc



МОНГОЛЫН 00000023
MONGOLIAN STOCK EXCHANGE

дөр
ЭБ



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

ТУСТАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

Дугаар 321/03

2015 оны 06 сарын 24 өдөр

Монгол улсын "Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль", "Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль", бусад хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 06 сарын 24 өдрийн 284 дугаар тогтоолоор "Хаан Банк" ХАК -д
Кастодианос

үйл ажиллагаа эрхлэхийг зөвшөөрч, энэхүү гэрчилгээг олгов.

ДАРГА
321/03
МОНГОЛЫН
САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО



УЛААНБААТАР ХОТ
МХБ-ийн гишүүн

Энэхүү гэрчилгээ нь
хавсралтын хамт
хүчинтэй

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
00000004
2023-06-09
БҮРТГЭВ-02

СХ
2023-06-12 өдөр
БҮРТГЭВ
№



МОНГОЛ УЛСЫН
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

321/03 ТООТ

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ ХАВСРАЛТ

2023.5.29

“Тэмдэг”
Унэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагад зориулсан
тэмдэглэлүүд
УХА0410 5043239

Унэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагад зориулсан
тэмдэглэлүүд



(Энэхүү хавсралт нь тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хамт хүчинтэй)

УЛААНБААТАР ХОТ
МХБ-ийн гишүүн
Аларрантес
Брокер, дилэрийн
БҮГДЭСЕК
1115205447 д. 2023.4.22

СЭХ
2023.06.13
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 1

Мэргэжлийн байгууллагын оноосон нэр: "Хаан Банк" ХХК

Д/д	Өөрчлөлтийн тэмдэглэл	Өөрчлөлтийг бүртгэсэн огноо, гарын үсэг
1.	<p>ҮНЭТ ЦААСНЫ ОМГОЛОХ ЭРХИЙН БҮРТГЭЛИЙН ҮНЭ АЖИЛАГААНЫ ТӨРӨЛ БОЛОХ ҮНЭТ ЦААСНЫ ТУХАЙЛСАН БҮРТГЭЛИЙН ҮНЭ АЖИЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ НЭМЖ ОЛГОВ.</p> <p>2017.12.15 - №237 ТОГТООЛ</p>	<p>СЭХ 2017.12.20 БҮРТГЭВ № 03</p>



2023 5 29

МОНГОЛЫН ХЭРЭНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 00000076
БҮРТГЭВ-02

2023 оны 06 сарын 13 өдөр
БҮРТГЭВ
№



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2023 оны 06 сарын 25 өдөр

Дугаар 34

Улаанбаатар хот

Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 6.2.1, 22 дугаар зүйлийн 22.1, Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.1, 5.2 дугаар зүйлийн 8, 5.3 дугаар зүйлийн 1, 8.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.11, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, Банкны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "ХААН банк" ХК-д банк бус санхүүгийн факторингийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгосугай.
2. Хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлж, зохих өөрчлөлтийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлж, холбогдох баримт бичгийг Санхүүгийн зохицуулах хороонд ажлын 15 хоногийн дотор ирүүлэхийг "ХААН банк" ХК (Р.Мөнхтуяа)-д үүрэг болгосугай.
3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба (Т.Жамбаажамц)-нд даалгасугай.

ДАРГА

Б.БАЯРСАЙХАН



1518000060

2023 5 29

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
0000007
2023-06-09
БҮРТГЭВ-02

СЭХ
2023.06.13 өдөр
БҮРТГЭВ

Хавсралт 3

/Аудитын тайлан/

2023 5 29





ХААН БАНК ХХК

Санхүүгийн тайлангууд болон
Хараат бус аудиторын тайлан

2022 оны 12 дугаар сарын 31

2023 5 29



АГУУЛГА

Хараат бус аудиторын тайлан
Ерөнхий мэдээлэл1
Товчилсон үгс2

Санхүүгийн тайлангууд

Санхүүгийн байдлын тайлан3
Орлого үр дүнгийн болон бусад дэлгэрэнгүй орлогын тайлан4
Өмчийн өөрчлөлтийн тайлан5
Мөнгөн гүйлгээний тайлан6

Санхүүгийн тайлангуудын тодруулгууд

1. Танилцуулга 8
2. Банкны үйл ажиллагааны орчин 8
3. Нягтлан бодох бүртгэлийн бодлого 9
4. Нягтлан бодох бүртгэлийн бодлогыг хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой тооцоолол, дүгнэлт 24
5. Шинэ буюу өөрчлөлт орсон стандартуудын тайлбар болон хэрэгжилт 28
6. Нягтлан бодох бүртгэлийн шинэ бодлогын мэдэгдэл 29
7. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө 30
8. Монголбанкн дахь заавал байлгах нөөц 31
9. Санхүүгийн Хөрөнгө оруулалт 32
10. Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалт 36
11. Үүсмэл санхүүгийн хэрэглүүр 36
12. Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа 38
13. Бусад хөрөнгө 50
14. Үндсэн хөрөнгө 52
15. Биет бус хөрөнгө 53
16. Ашиглах эрхтэй хөрөнгө ба түрээсийн өглөг 54
17. Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө 54
18. Бусад банк санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж 55
19. Репо хэлцэл 55
20. Харилцагчдын харилцах, хадгаламж 55
21. Зээлээр авсан санхүүжилт 56
22. Бусад өглөг 60
23. Хувьцаат капитал, бусад нөөц ба ногдол ашиг 60
24. Хүү болон түүнтэй адилтгах орлого 63
25. Хүү болон түүнтэй адилтгах зардал 63
26. Шимтгэл, хураамжийн цэвэр орлого 64
27. Үүсмэл санхүүгийн хэрэглүүрийн цэвэр олз / гарз) 64
28. Зээлжих эрсдэлийн сан 65
29. Бодит үнэ цэнээр ашиг, алдагдалд бүртгэгдэх санхүүгийн хөрөнгийн гарз 65
30. Үйл ажиллагааны зардал 66
31. Орлогын албан татвар 67
32. Нэгж хувьцаанд ногдох ашиг 68
33. Санхүүгийн үйл ажиллагаанаас үүссэн өр төлбөрийн тохируулга 69
34. Сегментийн шинжилгээ 70
35. Болзошгүй өр төлбөр ба үүрэг 74
36. Санхүүгийн эрсдэлийн удирдлага 81
37. Бодит үнэ цэнийн тодруулга 98
38. Холбоотой талын тодруулга 105
39. Хөрөнгө болон өр төлбөрийн дуусгавар болох хугацааны шинжилгээ 107
40. Өөрийн хөрөнгийн хүрэлцээ 109
41. Тайлангийн дараах үйл явдал 110
42. Монгол хэлний орчуулга 110

2023 5 29





Хараат бус Аудиторын Тайлан

Хаан банк ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдэд

Дүгнэлт

Бидний дүгнэлтээр, Хаан банк ХХК ("Банк" гэх)-ийн санхүүгийн тайлангууд нь 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал хийгээд мөн тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн санхүүгийн үр дүн болон мөнгөн гүйлгээг бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу бодитойгоор илэрхийлэгдсэн байна.

Бид юунд аудит хийсэн талаар

Дараах бүрэлдэхүүн бүхий Банкны санхүүгийн тайлангуудад бид аудитыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

- 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар санхүүгийн байдлын тайлан;
- тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн орлого үр дүнгийн болон бусад дэлгэрэнгүй орлогын тайлан;
- тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн өмчийн өөрчлөлтийн тайлан;
- тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн мөнгөн гүйлгээний тайлан; болон
- нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд болон бусад тайлбар мэдээллээс бүрдсэн санхүүгийн тайлангуудын тодруулгууд.

Дүгнэлтийн үндэслэл

Бид Аудитын олон улсын стандарт (АОУС)-ын дагуу аудитын ажлыг хийж гүйцэтгэсэн. Уг стандартын дагуу бидний хүлээх үүрэг хариуцлагын талаар тус тайлангийн Санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд аудиторын хүлээх үүрэг хариуцлага хэсэгт тусгасан.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой үндэслэл болсон гэдэгт бид итгэлтэй байна.

Хараат бус байдал

Нягтлан бодогчдын олон улсын ёс зүйн стандартын зөвлөл (НБОУЭСЗ)-өөс гаргасан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм (МНБЭСЗ)-ийн (Хараат бус байдлын олон улсын стандартыг оруулан) дагуу Банкнаас бид хараат бус болно. Бид НБОУЭСЗ-ийн МНБЭСЗ-ийн бусад ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Санхүүгийн тайлангуудтай холбоотойгоор засаглал хариуцсан эрх бүхий этгээд болон удирдлагын зүгээс хүлээх үүрэг хариуцлага

Санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу бэлтгэж, бодитойгоор тайлагнах болон залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг



ПрайвотерхаусКуперс Аудит ХХК, Сэнтрал Тауэр, 6 давхар, 601 тоот,
Сүхбаатарын талбай, Сүхбаатар дүүрэг 8-р хороо, Улаанбаатар хот 14200, Монгол Улс
Утас: +976 70009089, www.pwc.com/mn





Санхүүгийн тайлангуудтай холбоотойгоор засаглал хариуцсан эрх бүхий этгээд болон удирдлагын зүгээс хүлээх үүрэг хариуцлага (үргэлжлэл)

буруу илэрхийллээс ангид санхүүгийн тайлангууд бэлтгэхэд шаардлагатай гэж удирдлага тодорхойлсон дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх нь удирдлагын үүрэг хариуцлага байна.

Санхүүгийн тайлангуудыг бэлтгэх явцад удирдлага Банкны үйл ажиллагааг цаашид тасралтгүйгээр үргэлжлүүлэх чадамжийг үнэлэх, тухайн чадамжид нөлөөлөх нөхцөл байдлын талаар зохистой үед тодруулах болон Банкны үйл ажиллагааг татан буулгах, үйл ажиллагааг зогсоохоор төлөвлөж байгаа эсвэл зогсоохоос өөр сонголтгүй болсноос бусад тохиолдлуудад нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг баримтлах үүрэгтэй.


Банкны засаглал хариуцсан эрх бүхий этгээд нь санхүүгийн тайлагналын үйл явцыг хянах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд аудиторын хүлээх үүрэг хариуцлага

Бидний зорилго бол залилан эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлангууд нь бүхэлдээ материаллаг буруу илэрхийлэлгүй эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах мөн бидний дүгнэлтийг агуулсан аудиторын тайланг бэлтгэх явдал юм. Хэдийгээр үндэслэлтэй баталгаа нь өндөр түвшний баталгаа боловч, АОУС-ын дагуу гүйцэтгэсэн аудит нь материаллаг буруу илэрхийлэл байх тохиолдол бүрийг олж илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй. Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдааны улмаас үүсэх боломжтой ба энэ нь санхүүгийн тайланг хэрэглэгчдийн эдгээр тайланд үндэслэн гаргах эдийн засгийн шийдвэрт тус бүрдээ эсвэл нийт дүнгээрээ нөлөөлөхүйц байвал материаллаг буруу илэрхийлэл болно.

АОУС-ын дагуу бид аудитын туршид мэргэжлийн үл итгэх байр сууринаас хандах, мэргэжлийн холбогдох итгэл үнэмшил бүхий үнэлэлтүүдийг хийдэг. Мөн бид:

- Залилан болон алдааны улмаас санхүүгийн тайланд материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдэлийг илрүүлэн үнэлэх, тэдгээр эрсдэлүүдэд нийцсэн аудитын горимыг тодорхойлон гүйцэтгэх, аудитын дүгнэлт гаргахад үндэслэл болох хангалттай бөгөөд зохистой нотолгоог олж авдаг. Залилан нь нууцаар үгсэн тохирох, хуурамч бичиг баримт үйлдэх, санаатайгаар орхигдуулах, хуурамч батламж гаргах эсвэл эрх мэдлээ хэтрүүлэн дотоод хяналтыг зөрчих зэрэг үйлдлүүдтэй холбоотойгоор үүсдэг тул залилангаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийллийг олж илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас шалтгаалж үүсэх материаллаг буруу илэрхийллийг олж илрүүлэхгүй байх эрсдэлээс илүү өндөр байдаг.
- Банкны дотоод хяналтын үр дүнтэй байдлын талаар дүгнэлт өгөх зорилгоор бус харин тухайн нөхцөл байдалд тохирох аудитын горимыг тодорхойлох зорилгын хүрээнд дотоод хяналтын тогтолцооны ойлголтуудыг аудитын явцад олж авдаг.
- Удирдлагын зүгээс мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын зохистой байдал болон хийсэн тооцоолуудын үндэслэлтэй байдал, холбогдох тодруулгуудыг үнэлдэг.
- Банк үйл ажиллагаагаа тасралтгүйгээр үргэлжлүүлэх чадварт томоохон хэмжээний эргэлзээ үүсч болох нөхцөл байдал, тухайн үйл явдлуудтай холбоотойгоор материаллаг тодорхой бус байдал оршин байгаа эсэх болон удирдлага нь үйл ажиллагаагаа тасралтгүйгээр хангахад зөв зохистой нягтлан бодох бүртгэлийн суурийг сонгосон эсэхийг аудитын туршид бүрдүүлсэн нотолгоонд үндэслэн дүгнэдэг. Хэрэв үйл ажиллагаагаа тасралтгүйгээр үргэлжлүүлэх чадамжид материаллаг тодорхойгүй байдал оршин байгаа гэж үзсэн тохиолдолд санхүүгийн тайлангуудын холбогдох тодруулгыг аудиторын тайланд тусгах, анхааруулах мөн эдгээр тодруулгууд хангалтгүй гэж үзсэн тохиолдолд дүгнэлтээ өөрчилдөг. Бид дүгнэлтээ аудиторын



2023 5 29



Санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд аудиторын хүлээх үүрэг хариуцлага (үргэлжлэл)

тайланг гаргах өдрийг хүртэл олж авсан аудитын нотолгоонуудад үндэслэн гаргадаг боловч ирээдүйд болох үйл явдал, нөхцөл байдлуудаас шалтгаалан Банкны үйл ажиллагаа зогсох нөхцөл байдал үүсч болно.

- Тодруулгуудыг оролцуулан санхүүгийн тайлангийн ерөнхий агуулга болон бүтцийг бүхэлд нь үнэлдэг ба ач холбогдол бүхий ажил гүйлгээ, үйл явдлуудыг санхүүгийн тайланд үнэн зөв тодруулах шаардлагыг хангахуйц байдлаар илэрхийлсэн эсэхийг тодорхойлдог.

Бид засаглал хариуцсан эрх бүхий этгээдэд аудитын үйл ажиллагааны төлөвлөсөн цар хүрээ, аудит гүйцэтгэх цаг хугацаа болон аудитын явцад олж илрүүлсэн томоохон асуудлуудын талаар мэдээлдэг бөгөөд үүнд дотоод хяналтын дутагдалтай талууд багтдаг.

Гарын үсэг зурсан:



Дараагийн Баярмаа
Гүйцэтгэх захирал
ПрайсуотерхаусКуперс Аудит ХХК

Баталсан:

Шаукат Тапия
Партнер
ПрайсуотерхаусКуперс Аудит ХХК

Монгол Улс, Улаанбаатар хот
2023 оны 3 дугаар сарын 24-ний өдөр



2023 5 29



ТУЗ-ИЙН ГИШҮҮД

Т. Дарьбум
Д. Хулан
Кисабүрө Иший
Ц. Баатарсайхан
Харада Ясүнари
Жон Ло
Б. Амарсанаа
А. Тамир
Аарт Йонгеянс

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА:

О. Ариунтулга

АЛБАН ХАЯГ:

ХААН Банк Цамхаг
Чингисийн өргөн чөлөө 6,
Стадион Оргил-1, Хан-Уул дүүрэг,
Улаанбаатар хот- 17010,
Монгол Улс

АУДИТОРУУД:

ПрайсуотерхаусКуперс Аудит ХХК

167529202





ХААН Банк ХХК

Товчилсон үгс



Энэ Санхүүгийн тайланд товчилсон үгсийн дараах хэв маягийг ашигласан болно.

ХӨ	Хорогдуулсан өртөг
МБ	Монголбанк
ХБЭА	Хүлээгдэж буй эрсдэлийн алдагдал
ҮАХА	Үр ашигт хүүгийн аргачлал
ЧӨД	Чанаргүйдэлд өртөх магадлал
БДОБҮЦ	Бусад дэлгэрэнгүй орлогоор бүртгэгдэх бодит үнэ цэнэ
ААБҮЦ	Ашиг, алдагдлаар бүртгэгдэх бодит үнэ цэнэ
БҮЦ	Бодит үнэ цэнэ
СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
ЖЗХШ	Жишиг зээлийн хүүгийн шинэчлэл
АХЧ	Алдагдалд хүргэх чанаргүйдэл
НХХБЭА	Нийт хугацааны хүлээгдэж буй эрсдэлийн алдагдал
МИК	Монголын ипотекийн корпораци
ТӨГ	Монгол Төгрөг
БДО	Бусад дэлгэрэнгүй орлого
ЧМ	Чанаргүйдлийн магадлал
ХАҮҮЦБ	Худалдаж авсан болон үүссэн үнэ цэнийн бууралт
ЭХТ	Эрсдэлгүй хүүгийн түвшин
ИЗББ	Ипотекийн зээлээр баталгаажсан бонд
АЭХ	Ашиглах эрхтэй хөрөнгө
НХӨ	Нийт хөрөнгийн өгөөж
ӨХӨ	Өөрийн хөрөнгийн өгөөж
ЗЭМӨ	Зээлийн эрсдэлийн мэдэгдэхүйц өсөлт
ЗҮТХТ	Зөвхөн үндсэн төлбөр ба хүүгийн төлбөр
12 сарын ХБЭА	12 сарын хүлээгдэж буй эрсдэлийн алдагдал

2023.05.29



2023-06-09
0000075

БҮРТГЭВ-02

2023.06.13 өдөр
БҮРТГЭВ
№ ХААН БАНК ХХК
Санхүүгийн байдлын тайлан

Мянган төгрөгөөр	Тодруулга	2022 оны 12 дугаар сарын 31	2021 оны 12 дугаар сарын 31
ХӨРӨНГӨ			
	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	7 4,373,412,201	4,526,979,979
	Монголбанкинд байршуулсан заавал байлгах нөөц	8 969,104,827	809,081,732
	Өрийн хэлбэрээрх хөрөнгө оруулалт	9 1,474,096,564	909,001,481
	Өмчийн хэлбэрээрх хөрөнгө оруулалт	9 4,267,181	3,157,209
	Үүсмэл санхүүгийн хэрэглүүр	11 128,660,248	27,086,528
	Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	12 7,411,064,009	6,589,298,799
	Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалт	10 283,589	301,888
	Бусад хөрөнгө	13 76,361,443	78,094,830
	Биет бус хөрөнгө	15 46,286,024	54,764,803
	Ашиглах эрхтэй хөрөнгө	16 10,202,947	10,086,653
	Үндсэн хөрөнгө	14 455,493,746	455,595,092
	Борлуулах зорилгоор зэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө	17 3,480,567	-
	НИЙТ ХӨРӨНГӨ	14,952,713,346	13,463,448,994
ӨР ТӨЛБӨР			
	Бусад банк, санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж	18 191,080,282	35,854,280
	Репоз хэлцэл	19 367,267,329	620,802,675
	Харилцагчдын харилцах, хадгаламж	20 10,930,788,356	10,211,450,727
	Үүсмэл санхүүгийн хэрэглүүр	11 4,896,897	319,756
	Зээлээр авсан санхүүжилт	21 1,776,932,717	1,191,916,946
	Орлогын татварын өглөг	31 3,957,990	2,167,852
	Хойшлогдсон татварын өр төлбөр	31 4,709,251	4,579,593
	Түрээсийн өр төлбөр	16 11,231,249	11,085,695
	Бусад өглөг	22 146,483,209	100,761,094
	НИЙТ ӨР ТӨЛБӨР	13,437,347,280	12,178,938,618
ӨӨРИЙН ХӨРӨНГӨ			
	Энгийн хувьцаа	23 172,097,820	172,097,820
	Хуримтлагдсан ашиг	1,268,756,786	1,018,133,731
	Бусад нөөц	23 74,511,460	94,278,825
	НИЙТ ӨӨРИЙН ХӨРӨНГӨ	1,515,366,066	1,284,510,376
	НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ӨӨРИЙН ХӨРӨНГӨ	14,952,713,346	13,463,448,994

2023 оны 3 дугаар сарын 24-ний өдөр Банкны удирдлагыг төлөөлж энэхүү тайланг нийтлэхийг хүлээн зөвшөөрч гарын үсэг зурав


Т.ДАРЬБУМ
Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга



Р.МӨНХТУЯА
Гүйцэтгэх захирал


Ш.ӨЛЗИЙ-АЮУШ
Санхүү, Захиргаа хариуцсан дэд захирал


Н.БААСАНЦЭЭ
Санхүүгийн удирдлагын газрын захирал


Санхүүгийн тайлангийн 8-110 дугаар хуудсан дахь тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн дэлгэцгүй хэсэг болно

2023 5 29



ХААН БАНК ХХК
Орлого үр дүнгийн болон бусад дэлгэрэнгүй орлогын тайлан

Мянган төгрөгөөр	Тодруулга	2022	2021
Үр ашигт хүүгийн аргыг ашиглан тооцоолсон хүүгийн орлого	24	1,327,391,147	1,139,951,636
Бусад адилтгах хүүгийн орлого	24	39,974,535	38,817,302
Хүүгийн зардал	25	(475,870,927)	(542,305,638)
Бусад адилтгах хүүгийн зардал	25	(5,213,387)	(1,886,344)
Хүүгийн цэвэр орлого		886,281,368	634,576,956
Зээлжих эрсдэлийн сангийн зардал	28	(143,514,238)	(87,813,455)
Зээлжих эрсдэлийн сангийн зардлын дараах хүүгийн цэвэр орлого		742,767,130	546,763,501
Хураамж, шимтгэлийн орлого	26	263,466,643	212,086,407
Хураамж, шимтгэлийн зардал	26	(47,787,841)	(35,934,290)
Хорогдуулсан өртгөөр хэмжигдэх бусад зээлийн эх үүсвэрийн өөрчлөлтөөс үүссэн олз		2,275,457	868,353
Үүсмэл санхүүгийн хэрэглүүрийн цэвэр олз/(гарз)	27	15,878,389	(202,377)
Гадаад валютын арилжааны олз		32,799,045	19,033,665
Гадаад валютын ханшийн өөрчлөлтийн цэвэр олз/(гарз)		6,574,939	(1,696,325)
Бусад дэлгэрэнгүй орлогоор бодит үнэ цэнийг хүлээн зөвшөөрөгдөх санхүүгийн хөрөнгийн борлуулалтаас үүссэн (гарз)/олз		(900,167)	2,252,900
Хорогдуулсан өртгөөр хэмжих санхүүгийн хөрөнгүүдийн өөрчлөлтөөс үүссэн гарз		(7,225,649)	-
Ашиг, алдагдлаар бодит үнэ цэнийг хэмжих санхүүгийн хөрөнгийн гарз	29	(9,019,495)	(8,771,737)
Үйл ажиллагааны бусад орлого		4,317,634	1,287,190
Үйл ажиллагааны бусад зардал	30	(412,043,205)	(348,177,182)
Бусад гарз, цэвэр дүнгээр		(269,656)	(951,022)
Татварын өмнөх ашиг		590,833,224	386,559,083
Орлогын албан татварын зардал	31	(142,061,025)	(95,030,000)
Тайлант жилийн ашиг		448,772,199	291,529,083

Бусад дэлгэрэнгүй орлого:

Ирээдүйд ашиг, алдагдалд дахин ангилагдах зүйлс:

Бусад дэлгэрэнгүй орлогоор бодит үнэ цэнийг хүлээн зөвшөөрөгдөх өрийн хэрэглүүр:			
Дахин үнэлгээний гарз		(14,032,658)	(7,856,520)
Худалдан борлуулснаас ашиг, алдагдалд дахин ангилсан олз/(гарз)		900,167	(2,252,900)
Мөнгөн гүйлгээний хөйджийн нөөц		(11,666,472)	(11,281,559)
Бусад дэлгэрэнгүй орлогод шууд бүртгэгдсэн орлогын татвар		6,199,740	5,347,744
Ирээдүйд ашиг, алдагдалд дахин ангилагдахгүй зүйлс:			
Бусад дэлгэрэнгүй орлогоор бодит үнэ цэнийг хүлээн зөвшөөрөх өмчийн хэрэглүүрийн дахин үнэлгээний олз		1,109,972	8,426
Бусад дэлгэрэнгүй орлогод шууд бүртгэгдсэн орлогын татвар		(277,492)	(2,106)

Тайлант жилийн бусад дэлгэрэнгүй зардал (17,766,743) (16,036,915)

Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй орлого 431,005,456 275,492,168

Банкны эзэмшигчдэд хамаарах нэгж хувьцаанд ногдох суурь болон хорогдуулсан ашиг (төгрөгөөр илэрхийлсэн) 261 169



Санхүүгийн тайлангийн 8-110 дугаар хуудсан дахь тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.



ХААН БАНК ХХК
Өмчийн бөрчлөлийн тайлан

СЭХ
2023.06.13 өдөр
БҮРТГЭВ
№ 01
Нийт

Мянган төгрөгөөр	Энгийн хувьцаа	Халаасны хувьцаа	БДОБҮЦ-ээр хэмжигдэх үнэт цаасны дахин үнэлгээний нөөц	Мөнгөн гүйлгээний хөйджийн нөөц	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан ашиг	Нийт эзэмшигчдийн өмч
2021 оны 1 сарын 1-ний үлдэгдэл	58,071,253	(7,589,226)	13,140,012	6,791,008	92,638,403	1,066,159,570	1,229,211,020
Тайлант жилийн ашиг	-	-	-	-	-	291,529,083	291,529,083
Бусад дэлгэрэнгүй зардал	-	-	(7,575,746)	(8,461,169)	-	-	(16,036,915)
Нийт дэлгэрэнгүй орлого	-	-	(7,575,746)	(8,461,169)	-	291,529,083	275,492,168
Халаасны хувьцааны цуцлалт (Тодруулга 23)	(7,589,226)	7,589,226	-	-	-	-	-
Нэрлэсэн үнийн өсөлт (Тодруулга 23)	121,615,793	-	-	-	-	(141,808,605)	(20,192,812)
Ногдол ашиг (Тодруулга 23)	-	-	-	-	-	(200,000,000)	(200,000,000)
Хэрэгжсэн дахин үнэлээний нөөц	-	-	-	-	(2,253,683)	2,253,683	-
2021 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	172,097,820	-	5,564,266	(1,670,161)	90,384,720	1,018,133,731	1,284,510,376
2022 оны 1 сарын 1-ний үлдэгдэл	172,097,820	-	5,564,266	(1,670,161)	90,384,720	1,018,133,731	1,284,510,376
Тайлант жилийн ашиг	-	-	-	-	-	448,772,199	448,772,199
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	(9,016,889)	(8,749,854)	-	-	(17,766,743)
Нийт дэлгэрэнгүй орлого	-	-	(9,016,889)	(8,749,854)	-	448,772,199	431,005,456
Ногдол ашиг (Тодруулга 23)	-	-	-	-	-	(200,149,766)	(200,149,766)
Хэрэгжсэн дахин үнэлээний нөөц	-	-	-	-	(2,000,622)	2,000,622	-
2022 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	172,097,820	-	(3,452,623)	(10,420,015)	88,384,098	1,268,756,786	1,515,366,066

МХКН-ийн гүйцэтгэл
Броуэр
11520544 / 2052982
2023-06-09

0000027
2023-06-09
БҮРТГЭВ-02



Мянган төгрөгөөр	Тодруулга	2022	2021
Үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Татварын өмнөх ашиг		590,833,224	386,559,083
Татварын өмнөх ашгийн цэвэр мөнгөн урсгалд тохируулсан залруулгууд:			
	Үүсмэл санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн өөрчлөлт	(15,878,389)	202,377
28	Хүлээгдэж буй эрсдэлийн сангийн зардал	143,514,238	87,813,455
	Өмчлөх бусад хөрөнгийн бодит үнэ цэнийн бууралтаас үүссэн (олз)/гарз	(78,812)	5,985
28	Үндсэн хөрөнгийн элэгдэл	54,489,263	54,368,851
30	Биет бус хөрөнгийн хорогдуулалт	20,643,564	17,703,043
30	Ашиглах эрхтэй хөрөнгийн элэгдэл	7,623,736	7,511,435
	Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз	749,553	1,022,560
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны гарз	4,349,666	-
	Үндсэн хөрөнгө борлуулсны (олз)/гарз	71,960	(10,038)
	Бусад дэлгэрэнгүй орлогоор хэмжигдэх бодит үнэ цэнээр бүртгэгдэх санхүүгийн хөрөнгө борлуулсны гарз/(олз)	900,167	(2,252,900)
	Хорогдуулсан өртгөөр хэмжигдэх санхүүгийн хөрөнгийн өөрчлөлтөөс үүссэн гарз	7,225,649	-
	Ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр хэмжигдэх санхүүгийн хөрөнгөөс үүссэн гарз	9,019,495	8,771,737
	Хорогдуулсан өртгөөр хэмжигдэх зээлийн эх үүсвэрийн өөрчлөлтөөс үүссэн олз	(2,275,457)	(868,353)
	Гадаад валютын ханшийн өөрчлөлтийн (олз)/гарз	(6,574,939)	1,696,325
	Хүүгийн орлого болон түүнтэй адилтгах орлого	(1,367,365,682)	(1,178,768,938)
	Хүүгийн зардал болон түүнтэй адилтгах зардал	481,084,314	544,191,982
Үйл ажиллагааны хөрөнгө, өр төлбөрийн өөрчлөлтийн өмнөх үйл ажиллагаанд зарцуулсан мөнгөн гүйлгээ		(71,668,450)	(72,053,396)
Цэвэр (өсөлт)/бууралт:			
	- Монголбанкинд байршуулсан заавал байлгах нөөц	(161,373,304)	(29,513,402)
	- Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	(1,398,527,921)	(1,743,406,168)
	- Бусад банканд байршуулсан харилцах, хадгаламж	-	78,426,073
	- Бусад хөрөнгө	(4,430,702)	(17,272,770)
	- Ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрөгдөх өрийн хэлбэрээрх үнэт цаас	121,988,100	41,054,900
Цэвэр өсөлт/(бууралт):			
	- Бусад банк, санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж	155,142,345	4,844,957
	- Харилцагчдын харилцах, хадгаламж	757,138,330	842,931,467
	- Бусад өр төлбөр	45,389,272	(45,352,148)
Татвар болон хүүгийн зардлын өмнөх үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ		(556,342,330)	(940,340,487)
Хүлээн авсан хүү			
	Төлсөн хүү	1,383,136,022	1,060,326,443
	Орлогын албан татварын төлөлт	(482,696,702)	(577,579,548)
31.3		(134,218,981)	(96,559,450)
Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ		209,878,009	(554,153,042)

Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ

Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалтыг борлуулсны орлого

Санхүүгийн тайлангийн 8-110 дугаар хуудсан дахь тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.






ХААН БАНК ХХК
Мөнгөн гүйлгээний тайлан



Мянган төгрөгөөр	Тодруулга	2022	2021
Бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрөгдөх өрийн хэлбэрээрх үнэт цаасны худалдан авалт		(56,035,308)	(156,535,570)
Бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрөгдөх өрийн хэлбэрээрх үнэт цаас борлуулсны орлого		92,355,896	162,040,999
Хорогдуулсан өртгөөр хэмжигдэх өрийн хэлбэрээрх үнэт цаас борлуулсны орлого		281,893,933	316,125,709
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		1,717,306	693,349
Үндсэн хөрөнгийн худалдан авалт	14	(56,926,734)	(45,741,583)
Биет бус хөрөнгийн худалдан авалт	15	(16,514,451)	(21,749,042)
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ		(221,061,583)	(74,950,522)
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
РЕПО хэлцлээс орж ирсэн орлого	19	3,801,304,742	1,793,870,044
РЕПО хэлцлийн эргэн төлөлт	19	(4,071,420,232)	(1,330,383,814)
Бусад зээлийн эх үүсвэрээс орж ирсэн орлого	21	959,412,011	715,271,479
Бусад зээлийн эх үүсвэрийн эргэн төлөлт	21	(560,785,101)	(688,946,113)
Түрээсийн үндсэн өр төлбөрийн эргэн төлөлт	16	(7,633,424)	(7,110,035)
Төлсөн ногдол ашиг	23	(200,149,766)	(200,000,000)
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ		(79,271,770)	282,701,561
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн ханшийн өөрчлөлтийн нөлөө		(62,181,031)	45,520,893
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн зээлжих эрсдэлийн сангийн зардал	7	(931,403)	(113,958)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр бууралт		(153,567,778)	(300,995,068)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	7	4,526,979,979	4,827,975,047
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	7	4,373,412,201	4,526,979,979



Санхүүгийн тайлангийн 8-110 дугаар хуудсан дахь тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.



ХААН БАНК ХХК

Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2022 оны 12 сарын 31

1. Танилцуулга

ХААН Банк нь ("Банк") Монголбанкнаас ("МБ") олгосон 2 тоот зөвшөөрлийн дагуу Банк, санхүүгийн үндсэн үйлчилгээг 2006 оны 11 дүгээр сарын 22-ны өдрөөс хойш үзүүлж байна.

Банкны хүчин төгөлдөр дүрмийн дагуу Банкны үндсэн үйл ажиллагаа нь:

- Хадгаламж;
- Зээлийн үйлчилгээ;
- Картын үйлчилгээ;
- Баталгаа ба аккредитив;
- Мөнгөн шилжүүлэг;
- Гадаад валют худалдах, худалдан авах, хадгалах, болон арилжаалах;
- Үнэт металл худалдах, худалдан авах, хадгалах, болон арилжаалах;
- Гадаад төлбөр, тооцоо;
- Үнэт цаас гаргах, арилжаалах;;
- Санхүүгийн түрээсийн үйлчилгээ;
- Зээл болон бусад санхүүгийн хэрэглүүр худалдан авах, худалдах;
- Кастодиан банкны үйлчилгээ;
- Хууль эрх зүйн хүрээнд хязгаарлагдаагүй бусад санхүүгийн үйлчилгээ болон Монголбанк ба Засгийн Газрын бусад байгууллагуудын хүлээн зөвшөөрсөн бусад үйлчилгээг үзүүлнэ.

Банк нь Монгол Улсад бүртгэлтэй, тус улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулдаг хязгаарлагдмал хариуцлагатай компани юм. Банкны төв байрны албан ёсны хаяг нь ХААН Банк Цамхаг, Чингисийн өргөн чөлөө 6, Стадион, Оргил-1, Хан Уул дүүрэг, Улаанбаатар хот - 17010, Монгол Улс.

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Банкны толгой компани байсан Савада Холдинг ХК нь 2022 оны 2 дугаар сард Эйч Эс Холдинг ХК болгон өөрчилсөн. Тиймээс, Банкны толгой компани нь Эйч Эс Холдинг ХК бөгөөд 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Токиогийн Хөрөнгийн Бирж дээр бүртгэлтэй болно.

2. Банкны үйл ажиллагааны орчин


Монгол Улс хөгжиж буй зах зээлийн олон шинж чанарыг агуулдаг ба тэр дундаа өндөр инфляци зээлийн хүүгийн түвшинтэй. Уул уурхайн салбар дахь боловсруулах үйлдвэрлэлийн түвшин бага байгаагаас шалтгаалж нүүрс, зэс зэрэг ашигт малтмалын түүхий эдийн нөөцийн экспорт нь эдийн засгийн үндсэн орлогыг бүрдүүлдэг. 2017-2019 онуудад Монгол Улсын эдийн засаг жилд дунджаар 6 орчим хувиар өссөний дараа 2020 онд Ковид-19 цар тахлын улмаас эдийн засагт хүчтэй сөрөг нөлөө үзүүлж 4.6 хувиар буурсан ба 2021 онд бага зэргийн буцуу 1.6 хувийн өсөлт үзүүлсэн. Үндэсний статистикийн хорооны мэдээлснээр 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар ДНБ-ийн бодит өсөлт нь 4.8 хувь байна.

Монгол Улсын зээлжих зэрэглэлийн үнэлгээ Стандарт энд Пүүрсийн эрсдэлийн зэрэглэл тогтоох үнэлгээний байгууллагын 2022 оны 7 сарын 21-ны өдрийн үнэлгээгээр тогтвортой төлөвтэй "В" түвшинд байна. Мүүдис үнэлгээний агентлаг Монгол Улсын зээлжих зэрэглэлийг "В3" тогтвортой төлөвтэй хэвээр байна гэж үнэлсэн. Фитч'с үнэлгээний агентлаг Монгол Улсын зээлжих зэрэглэлийг "В" тогтвортой төлөвтэй гэж тайлагнасан.

Украины дайны улмаас 2022 онд Монгол Улс инфляцийн өндөр түвшинд хүрсэн ба ихэвчлэн хүнсний бүтээгдэхүүн болон шатахуунд хүчтэй нөлөөлсөн. Орос-Украины дайны улмаас учирч болзошгүй эрсдэлийг бууруулахын тулд Банк нь ОХУ-ын банкуудтай холбоотой бүх боломжит нээлттэй дансдыг хааж, үүсч болох эрсдэлийг бууруулсан. Түүнчлэн Хятад улсын "Тэг Ковид" бодлого болон эдийн засгийн идэвхгүй байдал мөн хил хаасны улмаас Монгол Улсын гол экспортын бүтээгдхүүнд хүндхэн цохилт өгч, нийлүүлэлтийн сүлжээ тасалдаж, түүхий эдийн эрэлт буурсан байна. 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгт болох монгол төгрөг ам.доллартай харьцах ханш 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн ханштай харьцуулахад 21 хувиар суларсан үзүүлэлттэй байна.

Үүний хариуд Төв банк мөнгөний бодлогоо эрс чангаруулж, 2022 оны 1 дүгээр сард 6 хувь байсан бодлогын хүүг шат шатаар нэмсээр 2022 оны 12 дугаар сарын байдлаар 13 хувьд хүргэсэн.

Монгол Улсын хүлээгдэж буй бодит ДНБ-ий өсөлт 2023 онд 5% хүртэл өснө гэсэн таамагтай байна. Гэвч Хятад улсын хилийн хориг, дэлхийн суларсан эдийн засгийн төлөв болон Украины дайны улмаас импортын барааны өндөр үнэ нь эдийн засгийн сэргэлтийг хязгаарлах төлөвтэй байна. Мөн, Хятад улс





ХААН БАНК ХХК

Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2022 оны 12 сарын 31



2. Банкны үйл ажиллагааны орчин (Үргэлжлэл)

2023 оны нэгдүгээр сарын эхээр хилээ нээж, Оюутолгойн далд уурхайн олборлолтыг 2023 оны эхний хагаст эхлүүлэхээр төлөвлөж байгаа нь 2023 он болон цаашдын эдийн засгийн төлөв байдалд эерэгээр нөлөөлж болзошгүй байна. Одоогийн эдийн засгийн нөхцөл байдлын урт хугацааны үр нөлөөг урьдчилан таамаглахад бэрхшээлтэй бөгөөд Банкны удирдлагын одоогийн хүлээлт, тооцоолол нь бодит үр дүнгээс өөр байж болно.

Хүлээгдэж буй эрсдэлийн алдагдал (ХБЭА)-ыг тооцоолоход Банк ирээдүйд чиглэсэн мэдээллийг ашигладаг ба үүнд макро эдийн засгийн хувьсах таамаглалыг багтаасан байдаг. Гэхдээ аливаа эдийн засгийн төсөөлөл, тэдгээрээс үүсэх магадлал нь тодорхойгүй байдлыг үүсгэдэг тул бодит үр дүн нь төлөвлөснөөс эрс ялгаатай байж болно. Тодруулга 4 болон 36-д Банк хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын загварт тооцооллыг хийхдээ хэрхэн ирээдүйд чиглэсэн мэдээллийг ашигласан талаар дэлгэрэнгүй толиллуулсан.

3. Нягтлан бодох бүртгэлийн бодлого


Тайлан бэлтгэх үндэслэл. Банкны эдгээр санхүүгийн тайлангууд нь Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ын дагуу түүхэн бодит өртөгт үндэслэн бэлтгэгдсэн бөгөөд үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл, ашиг алдагдлаарх бодит үнэ цэнэ (ААБҮЦ)-ээр бүртгэгдэх санхүүгийн хэрэглүүр болон бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнэ (БДОБҮЦ)-ээр бүртгэгдэх санхүүгийн хэрэглүүрүүдийн өөрчлөгдсөн анхдагч хүлээн зөвшөөрөлт нь бодит үнэ цэнэд суурилсан байдаг. Эдгээр санхүүгийн тайлангуудыг бэлтгэхэд ашигласан НББ-ийн үндсэн бодлогуудыг доор толиллуулав. Эдгээр нягтлан бодох бүртгэлийн бодлогууд нь өөрөөр зааснаас бусад тохиолдолд бүх тайлант жилүүдэд тасралтгүй мөрдөгдөж ирсэн.


Эдгээр санхүүгийн тайлангууд нь Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэг болох Монгол төгрөгөөр бэлтгэгдсэн бөгөөд энэ нь Банкны үйл ажиллагааны бүртгэлийн мөнгөн тэмдэгт байна. Эдгээр санхүүгийн тайлангуудад өөрөөр тусгайлан зааснаас бусад тохиолдолд бүх үзүүлэлтүүд мянганчлан илэрхийлэгдсэн.

Санхүүгийн хэрэглүүр – хэмжилтийн үндсэн нэр томъёо. Бодит үнэ цэнэ нь зах зээлд оролцогчдын хооронд хөрөнгө худалдах эсвэл өр төлбөр барагдуулах гүйлгээг хэмжилтийн өдөр зохион байгуулалттай явуулахад хүлээн авах эсвэл төлөх үнэ юм. Бодит үнэ цэнийн хамгийн тод жишээ бол идэвхтэй зах зээлд дээрх үнэ юм. Идэвхтэй зах зээл гэдэг нь хөрөнгө болон өр төлбөрийн хэлцлүүд нь үнийн мэдээллээр тогтмол хангахуйц түвшинд явагддаг зах зээлийг хэлнэ. Идэвхтэй зах зээлд арилжаалагдаж буй санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийг хэмжихдээ тухайн хөрөнгө болон өр төлбөрийн заасан үнэ болон тухай байгууллагын эзэмшиж буй хэмжээгээр тооцдог. Зах зээлийн ердийн өдөр тутмын арилжааны хэмжээ нь эзэмшиж буй дүнгийн түвшинд хүрэхгүй бөгөөд позицийг нэг арилжаагаар худалдан борлуулах захиалга өгснөөр заасан үнэнд нөлөөлж болох юм. Санхүүгийн хөрөнгийг үнэлэхэд ашигласан зах зээлийн үнэ нь одоогийн арилжаалах үнэ ба санхүүгийн өр төлбөрийн зах зээлийн үнэ нь санал болгосон үнэ юм.

Идэвхтэй зах зээлд арилжаалагддаггүй санхүүгийн үүсмэл хэрэглүүр болон бусад санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн багцыг хэмжихдээ бүлэг санхүүгийн хөрөнгө болон санхүүгийн өр төлбөрийн бодит үнэ цэнийг ашиглана. Ингэхдээ хэмжилтийн өдрийн байдлаар зах зээлд оролцогч нарын хооронд хийсэн захиалгын хэлцэлээр тухайлсан эрсдэлийн дүнгийн хувьд цэвэр урт позицийг өөрөөр хэлбэл хөрөнгө зарахад хүлээн авах үнэ эсвэл цэвэр богино позицийг өөрөөр хэлбэл хөрөнгө шилжүүлэхэд төлөх үнэнд суурилна. Энэ нь давтагдах байдлаар бодит үнэ цэнээр бүртгэгдсэн хөрөнгийн хувьд хамааралтай ба Банк (а) Санхүүгийн хөрөнгө эсвэл санхүүгийн өр төлбөрийг зах зээлийн тодорхой эрсдэлийн хувьд эсвэл байгууллагын баримтжуулсан эрсдэлийн удирдлага болон хөрөнгө оруулалтын стратегийн дагуу тухай харилцагч талын зээлийн эрсдэлийн хувьд удирддаг бол (б) Хөрөнгө болон өр төлбөрийн мэдээллийг эрх бүхий албан тушаалтнуудад мэдээлдэг бол (в) Зах зээлийн эрсдэл, тухайлбал, санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөрөөс үүсэх тухайн зах зээлийн эрсдэлд эсвэл эрсдэлүүдэд өртөх хугацаа нь үндсэндээ ижил байдаг.

Гадаад зах зээлийн мэдээлэл авах боломжгүй тохиолдолд санхүүгийн тодорхой хэрэглүүрийн бодит үнэ цэнийг тооцохдоо хорогдуулсан мөнгөн гүйлгээний загвар, сүүлийн үеийн сунгасан гарын зарчмын дагуу хийгдсэн хэлцэлд ашигласан загвар болон санхүүжигч талын санхүүгийн тайлан мэдээ зэрэг үнэлгээний аргачлалыг ашиглана. Бодит үнэ цэнийг бодит үнэ цэнийн ангилал тус бүрд үнэлэх ба эдгээр түвшин нь (i) ижил төрлийн хөрөнгө болон өр төлбөрийн идэвхтэй зах зээл дэх зарлагдсан тохируулга даагүй үнийг ашиглан 1-р түвшинд тодорхойлно, (ii) хөрөнгө болон өр төлбөрийн хувьд материаллаг боломжит өгөгдлийг ашиглан шууд (үнэ) болон шууд бусаар (үнээс гаралтай) үнэлгээний аргачлалыг 2-р түвшинд хэрэглүүрнэ. 3-р түвшинд зах зээлийн ашиглаж болох өгөгдөлд тулгуурлахгүйгээр (зах зээлээс шууд





ХААН БАНК ХХК

Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2022 оны 12 сарын 31



3. Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогууд (Үргэлжлэл)

ашиглах боломжгүй өгөгдөлийг шаарддаг) үнэлгээг тодорхойлно. Бодит үнэ цэнийн ангилал дахь түвшингүүдийн хоорондын шилжүүлгийг тайлант хугацааны эцэст хийгдсэн гэж үзнэ. Тодруулга 37-оос харна уу.

Гүйлгээний зардлууд нь санхүүгийн хэрэглүүрүүдийг худалдан авах, худалдах, шинээр гаргах эсвэл борлуулахтай шууд холбоотой нэмэлт зардлууд юм. Нэмэлт зардал нь гүйлгээг хийгээгүй тохиолдолд үүсэхгүй байх зардал юм. Гүйлгээний зардал агент (борлуулагч агентын үүрэг гүйцэтгэж буй ажиллагсад) зөвлөх, брокер, дилерүүдэд төлсөн хураамж шимтгэл, зохицуулах байгууллага болон хөрөнгийн зах зээлийн байгууллагуудад төлсөн төлбөрүүд, мөн шилжүүлгийн татвар хураамжууд багтана. Гүйлгээний зардалд өрийн шимтгэл буюу хөнгөлөлт, санхүүжилтийн зардлууд, захиргааны дотоод буюу хадгалалтын зардлууд орохгүй.

Хорогдуулсан өртөг (ХӨ) нь санхүүгийн хэрэглүүрүүдийг анх хүлээн зөвшөөрсөн дүнгээс аливаа үндсэн дүнгийн эргэн төлөлтийг хасч, хуримтлагдсан хүүг нэмж, санхүүгийн хөрөнгийн хувьд үнэ цэнийн бууралттай холбоотой аливаа хасагдуулгыг хассан дүн юм. Хуримтлагдсан хүүд анх хүлээн зөвшөөрөх үед хойшлогдсон гүйлгээний зардлын хорогдуулалт, мөн үнийн аливаа нэмэгдэл буюу хөнгөлөлтийн дүнгийн үр ашигт хүүгийн аргаар тооцсон хорогдуулалт орно. Хуримтлагдсан хүүгийн орлого, хуримтлагдсан хүүгийн зардал, мөн хуримтлагдсан купон болон үнийн дискаунтчилсан нэмэгдэл буюу хөнгөлөлтийг (мөн аливаа хойшлогдсон шимтгэлийн хамт) тусад нь толилуулаагүй ба тэдгээрийн санхүүгийн байдлын тайлан дахь тэнцэлд хамаарах хэсэгт дансны үнээр тусгасан болно.

Үр ашигт хүүгийн арга нь хүүгийн орлого болон эсвэл хүүгийн зардлыг хамаарах хугацааны туршид дансны үнээс тооцогдох хүүгийн хувийг тогтмол байлгахаар (үр ашигт хүүгийн хувь) хуваарилах арга юм.


Үр ашигт хүүгийн арга нь ирээдүйд орж ирэхээр тооцоолсон мөнгөн орлого, гарах зарлагыг (ирээдүйн эрсдэлийн алдагдлыг үл харгалзан) санхүүгийн хэрэглүүрийн хүлээгдэж буй хугацааны эсвэл зохистой бол түүнээс богино хугацааны туршид хямдруулж санхүүгийн хэрэглүүрийн нийт дансны үнээс тооцдог хүүгийн хувь юм.

Үр ашигт хүүгийн хувь нь хувьсах хүүтэй хэрэглүүрийн мөнгөн урсгалыг хүүг өөрчлөх дараагийн мөч хүртэл дискаунтчлах боловч хэрэглүүрт тусгагдсан хөвөх хүү дээр нэмэгдэх зээлийн хүүгийн зөрүүг илэрхийлсэн урамшуулал буюу хөнгөлөлтийг, мөн зах зээлийн түвшинд тохируулагддаггүй бусад хувьсах хүчин зүйлсэд үл хамаарна. Эдгээр урамшуулал, хөнгөлөлтийг хэрэглүүрийн хүлээгдэж буй нийт хугацааны туршид хорогдуулна. Өнөөгийн үнэ цэнийн тооцооллод гэрээний талуудын хооронд өгч авалцах бүх шимтгэл, хураамжийг оруулах бөгөөд тэдгээр нь үр ашигт хүүгийн бүрэлдэхүүн хэсэг болно. Худалдаж авахад эсвэл шинээр олгоход үнэ цэнийн бууралттай ("POCI") санхүүгийн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөх үед үр ашигт хүүний түвшинг зээлийн эрсдэлд тохируулахыг хэлнэ. Үүнд: анх хүлээн зөвшөөрөхдөө гэрээний төлбөрийн оронд хүлээгдэж буй мөнгөн гүйлгээнд үндэслэн тооцоолно.

Санхүүгийн хэрэглүүр – анхны хүлээн зөвшөөрөлт. Бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрөгдөх санхүүгийн хэрэглүүрийг анх бодит үнэ цэнээр нь бүртгэдэг. Бусад бүх санхүүгийн хэрэглүүрүүд нь анх гүйлгээний зардлыг тохируулсан бодит үнэ цэнээр бүртгэгддэг. Гүйлгээний үнэ нь анх хүлээн зөвшөөрөх үеийн бодит үнэ цэнийн хамгийн сайн нотолгоо болдог. Анх бүртгэх үед үүсэх олз эсвэл гарз нь бодит үнэ цэнэ болон гүйлгээний үнийн хооронд зөрүү гарсан тохиолдолд л бүртгэгдэх бөгөөд үүнийг зөвхөн ижил төрлийн хэрэглүүрийг сүүлийн үед арилжсан талаарх зах зээлийн нээлттэй мэдээллээр баталгаажуулсан эсвэл зөвхөн нээлттэй зах зээлээс авсан мэдээлэлд үндэслэж хийсэн үнэлгээний аргачлалаар тооцсон тохиолдлуудад бүртгэнэ. Анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа хорогдуулсан өртгөөр хэмжигдэх санхүүгийн хөрөнгүүд болон бодит үнэ цэнэ нь бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрөгдөх өрийн хэлбэрээрх хөрөнгө оруулалтын хувьд хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлыг хүлээн зөвшөөрч, үр дүнг шууд бүртгэлийн гарзаар бүртгэдэг.

Зохицуулалт эсвэл зах зээлийн жишгээр тогтоогдсон ("хэвийн" борлуулалт болон худалдан авалт) тодорхой хугацаанд багтаан нийлүүлэх шаардлагатай санхүүгийн хөрөнгийн бүхий л худалдан авалт болон борлуулалтыг арилжаа хийсэн өдөр буюу Банк тухайн санхүүгийн хөрөнгийг нийлүүлэх үүрэг хүлээсэн өдөр бүртгэнэ. Бусад бүх худалдан авалтыг Банк тухайн хэрэглүүрийн гэрээний тал болсон үед хүлээн зөвшөөрнө.

Банк идэвхтэй зах зээлд арилжаалагдаагүй урт хугацаат гадаад валют хоорондын хүүгийн СВОП хэлцлийн бодит үнэ цэнийг тодорхойлохдоо хямдруулсан мөнгөн урсгалын үнэлгээний аргачлалыг ашигладаг. Гүйлгээний үнэ гэж тооцогддог анхны хүлээн зөвшөөрөх үеийн бодит үнэ цэнэ болон 3-р үе шатны өгөгдөл бүхий үнэлгээний техникийг ашиглан анх хүлээн зөвшөөрөх үед тодорхойлсон дүнгийн





ХААН БАНК ХХК

Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2022 оны 12 сарын 31

3. Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогууд (Үргэлжлэл)

хооронд зөрүү үүсч болно. Загвар өгөгдлүүдийг тохируулсны дараа зөрүү хэвээр байвал эдгээр зөрүүг бусад хөрөнгө эсвэл бусад өр төлбөрт хүлээн зөвшөөрч, дараа нь валютын своп хэлцлийн хугацаанд шулуун шугамын аргаар хорогдуулна. Хэрэв үнэлгээний зөвхөн 1 эсвэл 2-р түвшний өгөгдлийг ашигладаг бол зөрүүг шууд ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.

Санхүүгийн хөрөнгө – ангилал ба дараагийн хэмжилт – хэмжилтийн ангилал. Банк санхүүгийн хөрөнгийг дараах хэмжилтийн ангиллаар ангилдаг: бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд бүртгэгдэх (ААБҮЦ), бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэх (БДОБҮЦ) болон хорогдуулсан өртгөөр (ХӨ) бүртгэгдэх. Санхүүгийн өрийн хэрэглүүрийн ангилал ба дараа үеийн хэмжилт нь дараах зүйлсээс хамаарна: (1) холбогдох хөрөнгүүдийн багцыг удирдах Банкны бизнес загвар ба (2) хөрөнгийн мөнгөн урсгалын онцлог шинж.

Санхүүгийн хөрөнгө – ангилал ба дараагийн хэмжилт – бизнесийн загвар. Банк мөнгөн урсгалыг бий болгохын тулд хөрөнгийг хэрхэн удирддаг болохыг бизнесийн загвар харуулдаг. Банкны зорилго нь: (i) зөвхөн хөрөнгийн гэрээнд заасан мөнгөн гүйлгээг цуглуулах ("гэрээнд заасан мөнгөн гүйлгээг цуглуулах зорилгоор эзэмших"), эсвэл (2) хөрөнгийг борлуулснаас үүсэх мөнгөн гүйлгээ ба гэрээнд заасан мөнгөн гүйлгээг цуглуулах ("гэрээнд заасан мөнгөн гүйлгээг цуглуулах болон худалдан борлуулах зорилгоор эзэмших") эсвэл хэрэв (1) ба (2) алинд ч хамаарахгүй бол санхүүгийн хөрөнгийг "бусад" бизнесийн загварт ангилж, ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрөгдөх бодит үнэ цэнээр хэмжинэ.

Бизнесийн загварыг үнэлгээний өдөр боломжит багцад зориулан тогтоосон зорилтондоо хүрэхийн тулд Банкны хэрэгжүүлж буй үйл ажиллагааны талаарх бүх нотолгоонд үндэслэн Банкны хөрөнгийг (багцын түвшинд) тодорхойлно. Бизнесийн загварыг тодорхойлоход Банкны авч үздэг хүчин зүйлс нь багцын зорилго ба бүрэлдэхүүн, тухайн хөрөнгийн мөнгөн гүйлгээг хэрхэн цуглуулсан, эрсдэлийг хэрхэн үнэлж, удирдаж байсан, хөрөнгийн гүйцэтгэлийг яаж үнэлсэн, цалин хөлс, урамшууллын системд хэрхэн тусгагдсан талаар өнгөрсөн туршлагад үндэслэдэг. Санхүүгийн хөрөнгийн бизнес загварыг тодорхойлоход Банкны гаргасан шийдвэрийг Тодруулга 4-өөс харна уу.

Санхүүгийн хөрөнгө – ангилал ба дараагийн хэмжилт – мөнгөн урсгалын шинж чанар. Бизнес загвар нь хөрөнгийн гэрээний мөнгөн урсгалыг цуглуулах зорилгоор эзэмших эсвэл хөрөнгийн гэрээний мөнгөн урсгалыг цуглуулах болон борлуулах зорилгоор хөрөнгийг эзэмших загвар бол Банк мөнгөн урсгал нь зөвхөн хүү болон үндсэн төлөлтөөс бүрдэж буй (ЗҮТХТ) эсэхэд үнэлгээ өгнө. Гэрээний мөнгөн урсгал нь ЗҮТХТ -ийн онцлогтой нийцсэн эсэхийг тодорхойлоход нуугдмал деривативыг агуулсан санхүүгийн хөрөнгийг бүхэлд нь авч үзнэ. Энэ үнэлгээг хийхдээ Банк гэрээний мөнгөн урсгал нь зээлийн гэрээний үндсэн тохиролцоонд нийцтэй эсэх, ялангуяа хүү нь зээлийн эрсдэл, мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ болон зээлийн бусад эрсдэл, ашгийн түвшинг багтаасан эсэхийг авч үздэг.

Гэрээний нөхцөлүүдэд эрсдэлтэй эсвэл зээлийн үндсэн нөхцөлтэй үл нийцэх өөрчлөлтийг тусгасан байвал санхүүгийн хөрөнгө нь ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр хэмжигдэж ангилагдана. ЗҮТХТ -ийн үнэлгээ нь хөрөнгийн анхны хүлээн зөвшөөрөлтийн үед хийгдэх бөгөөд дараа үед дахин хийгдэхгүй. Санхүүгийн хөрөнгийн хувьд ЗҮТХТ -ийн тестийг хийхэд Банкны гаргасан шийдвэрийг Тодруулга 4-өөс харна уу.

Санхүүгийн хөрөнгө – дахин ангилах. Тухайн багцыг удирдах бизнес загвар нь бүхэлдээ өөрчлөгдсөн тохиолдолд санхүүгийн хэрэглүүрийн дахин ангиллыг хийдэг. Дахин ангилал нь тухайн бизнес загвар өөрчлөгдсөнөөс хойш эхний санхүүгийн тайлангийн жилээс эхлэн хэрэгжинэ. Банк өмнөх болон тайлант хугацаанд бизнес загвараа өөрчлөөгүй бөгөөд ямар нэгэн дахин ангиллын залруулгыг хийгээгүй.

Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт – ХБЭА-ын сан. Банк хорогдуулсан өртөг болон бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр бүртгэгдэх санхүүгийн өрийн хэрэглүүр болон зээл, санхүүгийн баталгаатай холбоотой хүлээгдэж буй алдагдлыг ирээдүйн таамаглалын нөхцөл байдалд суурилан үнэлдэг. Банк нь хүлээгдэж буй эрсдэлийн алдагдал ("ХБЭА")-ыг хэмжиж, зээлжих эрсдэлийн хасагдуулгыг тайлант хугацаа бүрийн эцэст хүлээн зөвшөөрдөг. Хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын хэмжилт нь (1) олон янзын боломжит үр дүнг үнэлсний үр дүнд тодорхойлсон зохистой, магадлалаар жинлэсэн дүнг; (2) мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ; болон (3) тайлант хугацаа бүрийн эцэст өнгөрсөн үйл явдлууд, одоогийн нөхцөл байдал болон ирээдүйн нөхцөл байдлын таамаглалын талаар хэт их өртөг, хүчин чармайлтгүйгээр олдох боломжтой үндэслэл бүхий бэлэн мэдээлэлд үндэслэнэ.

Хорогдуулсан өртгөөрх өрийн хэрэглүүрийг санхүүгийн байдлын тайланд ХБЭА-ын санг хассан цэвэр дүнгээр тайлагнана. Зээл болон санхүүгийн баталгааны хувьд ХБЭА-ын санг санхүүгийн байдлын тайланд өр төлбөр гэж тусад нь хүлээн зөвшөөрдөг.





ХААН БАНК ХХК

Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2022 оны 12 сарын 31

3. Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогууд (Үргэлжлэл)

БДОБУЦ-ээрх өрийн хэрэглүүрийн хувьд ХБЭА-ын санг хассан хорогдуулсан өртгийн өөрчлөлтийн дүн нь ашиг алдагдалд хүлээн зөвшөөрөгдөх бөгөөд дансны үнийн бусад өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогод БДОБУЦ-ээрх өрийн хэрэглүүрийн гарзыг хассан дүнгээр олз гэж тайлагнагдана.

Банк анхны хүлээн зөвшөөрөлтийн дараах зээлийн чанарын өөрчлөлтөд үндэслэсэн үнэ цэнийн бууралтын "3 шатлал" бүхий дараах загварыг ашигладаг. Анхны хүлээн зөвшөөрөлтийн үед ямар нэг үнэ цэнийн бууралтгүй зээлүүд нь "1-р шатлал"-д ангилагдана. 1-р шатлалын зээлүүдийн ХБЭА нь ашиглалтын хугацаанд хүлээгдэж буй алдагдлын тайлант өдрөөс хойш 12 сарын дотор эсвэл хэрэв үүнээс богино бол гэрээний хугацаа дуусах хүртэл хэрэв үүнээс богино бол гэрээний хугацаа дуусах хүртэл (12 сарын ХБЭА) үүсч болох санхүүгийн хэрэглүүрийн дефолтоос үүдэн гарах хүлээгдэж буй алдагдлын хэсгийн хэмжээтэй ижил дүнгээр хэмжигдэнэ.

Хэрэв Банк анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш зээлийн эрсдэл нь мэдэгдэхүйц нэмэгдсэн гэдгийг тогтоовол хөрөнгийг "2-р шатлал"-д шилжүүлэн ангилах бөгөөд ХБЭА нь ашиглалтын хугацаанд хүлээгдэж буй алдагдалд үндэслэн хэмжигдэх ба энэ нь гэрээ дуусах хүртэл боловч хэрэв байгаа бол хүлээгдэж буй эргэн төлөлтүүдийг авч үзнэ (Ашиглалтын хугацааны ХБЭА). Тодруулга 36-аас Банк зээлийн эрсдэлийн мэдэгдэхүйц өсөлтийг хэрхэн тодорхойлсныг харна уу. Хэрэв Банк санхүүгийн хөрөнгийн зээлийн үнэ цэнэ буурсан гэж тодорхойлсон бол хөрөнгийг "3-р шатлал" руу шилжүүлэн ангилах ба ХБЭА нь ашиглалтын хугацааны турш дахь хүлээгдэж буй эрсдэлийн алдагдалд үндэслэн хэмжигдэнэ. Банкны эрсдэлийн үнэ цэнийн бууралттай хөрөнгө болон төлбөр төлөгдөхгүй болох тухайн тодорхойлолтыг Тодруулга 36-д тайлбарласан болно.

Худалдан авсан, шинээр гаргасан үнэ цэнийн бууралттай санхүүгийн хөрөнгийн хувьд ХБЭА нь үргэлж хөрөнгийн ашиглалтын хугацааны турш дахь ХБЭА-тай ижил хэмжигдэнэ. ХБЭА-ын загварыг хэмжихэд ашиглагдсан мэдээлэл, таамаглал, тооцооллын аргууд болон ХБЭА-ын загварт ирээдүйд чиглэсэн мэдээллийг Банк хэрхэн ашигласан талаарх тайлбарыг Тодруулга 36-аас харна уу.

Үүнээс гадна зээл болон ашиглагдаагүй байгаа зээлийн шугамыг хоёуланг нь багтаасан зээлийн карт гэх мэт санхүүгийн зарим хэрэглүүрүүдийн хувьд Банк хугацааны туршид хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлыг тухайн хугацаа нь хамгийн ихдээ гэрээний хугацаатай адилхан болсон ч гэсэн зээлийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлснээр энэхүү алдагдлыг багасгах хүртэл тооцоолдог. Зээлийн эргэн төлөлтийг шаардах болон ашиглагдаагүй байгаа шугамын гэрээг цуцлах гэрээгээр эрх нь гэрээний дагуу шаардах хугацаанд эрсдэлийн алдагдлын дүнд хязгаарлалт тавьдаггүйтэй холбоотой.

Санхүүгийн хөрөнгө – данснаас хасах. Банк элэгдэж дууссан, дахин ашиглах боломжгүй гэж дүгнэсэн тохиолдолд санхүүгийн хөрөнгийг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн данснаас хасдаг. Бүртгэлээс хасах нь данснаас хасагдсан үйл явдлыг илэрхийлнэ. Зээлдэгчийн дампуурал, шүүхийн шийдвэрээс үл хамааран ашиглах боломжгүй гэсэн үндэслэлүүд орно. Банк гэрээгээр хүлээгдэж буй төлбөрийг нөхөн төлөхийг оролдох үед хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах үйл ажиллагаа хэвээр байгаа санхүүгийн хөрөнгийг данснаас хасах боломжтой боловч эргэн төлөгдөх үндэслэл болохгүй.

Санхүүгийн хөрөнгө – бүртгэлээс хасах. Банк санхүүгийн хөрөнгийг дараах тохиолдолд үл хүлээн зөвшөөрнө: (а) хөрөнгийн төлбөрийг авсан эсвэл хөрөнгөтэй холбоотой мөнгөн урсгалыг хүлээн авах эрх дуусгавар болсон, (б) хөрөнгөтэй холбоотой мөнгөн урсгалыг хүлээн авах эрхээ бусдад шилжүүлэн өгсөн эсвэл хүлээн зөвшөөрөгдсөн дамжуулан өгөх хэлцэлд оролцсон (1) хөрөнгийг эзэмшихтэй холбоотой бүхий л эрсдэл болон өгөөжийг бүхэлд нь бусдад шилжүүлсэн, эсвэл (2) хөрөнгийг эзэмшихтэй холбоотой бүхий л эрсдэл болон өгөөжийг бүхэлд нь бусдад шилжүүлээгүй ч, өөртөө авч үлдээгүй буюу хяналтын эрхийг хадгалж үлдээгүй. Холбогдох тал хөрөнгийн борлуулалтад нэмэлт хязгаарлалт хийхгүйгээр холбоогүй гуравдагч этгээдэд бүхэлд нь худалдах боломжгүй тохиолдолд хяналтын эрхийг хадгалж үлдсэн гэж үзнэ.

Санхүүгийн хөрөнгө – өөрчлөлт. Банк зарим тохиолдолд санхүүгийн хөрөнгийн гэрээний нөхцөлийг өөрчлөх буюу дахин тохиролцдог. Банк нь гэрээний мөнгөн урсгалын өөрчлөлт нь мэдэгдэхүйц эсэхийг дараах зүйлсийг харгалзан үзэж үнэлнэ: хөрөнгийн эрсдэлийн үнэлгээнд мэдэгдэхүйц нөлөө үзүүлэхээр гэрээний шинэ зүйл заалт байгаа эсэх (ялангуяа ашгийн хуваарилалт эсвэл өөрийн хөрөнгийн өгөөж), хүүний өөрчлөлт, нэрлэсэн валютын өөрчлөлт, шинэ барьцаа эсвэл хөрөнгөтэй холбоотой зээлийн эрсдэлд мэдэгдэхүйц нөлөөлөх зээлийн өсөлт, мөн зээлдэгчийн санхүүгийн хүндрэлд ороогүй байх үеийн зээлийн сунгалт гэх мэт.



629
529
2023

ХААН БАНК ХХК
2023.06.13 өдөр
БҮРТГЭВ
№

Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2022 оны 12 сарын 31

3. Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогууд (Үргэлжлэл)

Хэрэв өөрчлөгдсөн нөхцөлүүд нь анхны нөхцөлөөс мэдэгдэхүйц зөрүүтэй бол анхны хөрөнгийн мөнгөн урсгалыг хүчингүй болгож, Банк өмнөх хөрөнгийг үл хүлээн зөвшөөрч бодит үнэ цэнээр нь шинэ хөрөнгийг хүлээн зөвшөөрнө. Дахин тохиролцоо хийсэн өдрийг дараа үеийн үнэ цэнийн бууралтыг тооцоолох зорилгоор анхны хүлээн зөвшөөрөлтийн өдөр байна гэж үздэг. Мөн зээлийн эрсдэлд мэдэгдэхүйц өсөлт байгаа эсэхийг тодорхойлж харгалзан үздэг. Банк шинэ зээл буюу өрийн хэрэглүүр нь үндсэн төлбөр болон хүүний төлбөр (ЗҮТХТ)-ийн шалгуурт нийцэж байгаа эсэхийг үнэлдэг.

Үл хүлээн зөвшөөрөгдсөн анхны хөрөнгийн дансны үнэ болон мэдэгдэхүйц өөрчлөлт орсон шинэ хөрөнгийн бодит үнэ цэнийн зөрүү нь өмчлөгчидтэй хийсэн капитал хөрөнгийн гүйлгээтэй холбоотойгоос бусад тохиолдолд ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.

Дахин тохиролцоо нь холбогдох нөгөө талын санхүүгийн хүндрэлтэй байдал болон анхны тохиролцсон төлбөрөө төлөх боломжгүй болсон үед хийгдэж байгаа нөхцөлд Банк хөрөнгийн одоогийн шинэчлэгдсэн мөнгөн гүйлгээ болон анхны мөнгөн гүйлгээг харьцуулж гэрээний өөрчлөлтөөс үүдэлтэй мэдэгдэхүйц өөрчлөгдсөн хөрөнгөд эрсдэл болон өгөөж байгаа эсэхийг үнэлнэ. Хэрэв эрсдэл болон өгөөж өөрчлөгдөөгүй бол өөрчилсөн хөрөнгө нь анхны хөрөнгөөс мэдэгдэхүйц өөрчлөлтгүй гэх ба өөрчлөлтөөс үүдэн үл хүлээн зөвшөөрөлт гарахгүй. Банк анхны үр ашигт хүүгийн түвшин (эсвэл худалдан авсан, шинээр гаргасан үнэ цэнийн бууралттай санхүүгийн хөрөнгийн хувьд зээлийн тохируулгатай үр ашигт хүүгийн түвшин)-г ашиглан өөрчлөгдсөн гэрээний мөнгөн урсгалыг хорогдуулах замаар нийт дансны үнийг дахин тооцоолж, өөрчлөлтийн олз, гарзыг ашиг алдагдалд хүлээн зөвшөөрнө.

Засгийн газраас авч хэрэгжүүлж буй арга хэмжээний хүрээнд КОВИД-19 цар тахлын эсрэг Банкнаас олгосон зээлийн төлбөрийн хугацааг хойшлуулсан нь тухайн зээл ба урьдчилгаа төлбөрийн гэрээний өөрчлөлт гэж үзнэ. Дансны нийт дүнд үзүүлэх нөлөөлөл (өөрчлөлтийн гарз) нь ашиг алдагдлын тайланд "Санхүүгийн хөрөнгийн өөрчлөлтөөс үүсэх гарз" гэсэн хэсэгт тусгагдсан болно.

Санхүүгийн өр талбөр – хэмжилтийн төрөл. Санхүүгийн өр төлбөрийг дараах нөхцөлөөс бусад үед хорогдуулсан өртгөөр ангилна. (1) Бодит үнэ цэнэ нь ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрөгдөх (ААБҮЦ) санхүүгийн өр төлбөр: энэ ангилалд дериватив, борлуулах зорилгоор эзэмшиж буй санхүүгийн өр төлбөр (үнэт цаасны богино позиц), бизнесийн нэгдлийн үед худалдан авагчийн хүлээн зөвшөөрсөн болзошгүй өр төлбөр болон анхны хүлээн зөвшөөрөлтөөр тодорхойлсон бусад санхүүгийн өр төлбөрүүд болон (2) санхүүгийн баталгааны гэрээ болон зээлд хамаарах үүрэг батгана.


Санхүүгийн өр төлбөр – үл хүлээн зөвшөөрөх. Санхүүгийн өр төлбөрийг хүчингүй болсон үед нь (гэрээнд заасан үүргээс чөлөөлөх, цуцалсан эсвэл хугацаа нь дууссан үед) үл хүлээн зөвшөөрнө.

Банк болон анхны зээлдүүлэгчийн мэдэгдэхүйц өөр нөхцөл хугацаа бүхий өрийн хэрэглүүр болон одоо буй санхүүгийн өр төлбөрийн нөхцөл, хугацааны мэдэгдэхүйц өөрчлөлт нь анхны санхүүгийн өр төлбөрийг хүчингүй болгож, шинэ санхүүгийн өр төлбөрийг бий болгосонд тооцно. Шинэ нөхцөлөөрх мөнгөн гүйлгээний аливаа төлсөн төлбөр хураамж болон хүлээн авсан төлбөр хураамжийн цэвэр дүнг багтаасан хорогдуулсан өнөөгийн үнэ цэнэ нь анхны санхүүгийн өр төлбөрийн үлдэх хугацааны мөнгөн урсгалын хорогдуулсан өнөөгийн үнэ цэнээс хамгийн багадаа 10% зөрүүтэй бол мэдэгдэхүйц өөр нөхцөлтэй гэж үзнэ. Хэрэв өрийн хэрэглүүрийг солих буюу заалтын өөрчлөлтийг хүчингүй болсон гэж тооцвол гарсан аливаа зардал эсвэл төлбөрийг хүчингүй болгохтой холбоотой олз, гарзын нэг хэсэг байдлаар хүлээн зөвшөөрнө. Харин өрийн хэрэглүүрийг солих буюу заалтын өөрчлөлтийг хүчингүй болсон гэж бүртгээгүй бол гарсан аливаа төлбөр, хураамжаар өр төлбөрийн дансны үнийг тохируулах ба өөрчлөгдсөн өр төлбөрийг үлдсэн хугацааны турш хорогдуулна.

Дансны өртгийн зөрүүгийн эдийн засгийн шинж чанар нь эзэмшигчидтэй хийсэн хөрөнгийн гүйлгээний шинжтэй болсноос бусад тохиолдолд өрийн хэрэглүүр үл хүлээн зөвшөөрнө гэж үзээгүй, өрийн өөрчлөлтийн ашиг алдагдалд хүлээн зөвшөөрсөн аливаа олз, гарзыг хуримтлагдсан өөрчлөлтийн аргыг ашиглан тооцооллын өөрчлөлт гэж бүртгэнэ.

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөд тодорхой хэмжээний мөнгө рүү түргэн хөрвөх боломжтой үнэ цэнээ алдах эрсдэл багатай зүйлс хамаарна. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөд бусад банкуудад 3 сараас доош анхны хугацаатай байршуулсан репо, урвуу репо хэлцлүүд, банк хооронд байршуулсан бүх мөнгөн хөрөнгө орно. Санхүүгийн байдлын тайланд болон мөнгөн гүйлгээний тайлангийн зорилгоор анх 3 сараас дээш хугацаатайгаар байршуулсан хөрөнгийг мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөд оруулж бүртгэхгүй. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийг хорогдуулсан өртгөөр бүртгэх ба энэ нь: (1) гэрээнд заасан мөнгөн гүйлгээг цуглуулах зорилгоор эзэмшдэг бөгөөд эдгээр мөнгөн





ХААН БАНК ХХК

Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2022 оны 12 сарын 31



3. Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогууд (Үргэлжлэл)

гүйлгээ нь ЗҮТХТ-ийн дагуу байх, (2) ашиг, алдагдалд бодит үнэ цэнийг нь хүлээн зөвшөөрөхгүй үед бүртгэдэг.

Мөнгөн гүйлгээний тайланд тусгагдсан төлбөр болон орлого нь Банкны мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн шилжүүлгийг илэрхийлдэг. Банкны харилцагч талуудын харилцах дансанд бүртгэсэн дүнг оролцуулан, зээлийн хүүгийн авлага, харилцагчдын харилцах данснаас суутгасан үндсэн төлбөр, харилцагчдад олгосон зээл ба зээлийн хүүгийн төлөлт зэргийг оролцуулах ба эдгээр төлөлтүүд нь харилцагчдын мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө болно.

Монголбанкинд байршуулсан заавал байлгах нөөцийн үлдэгдэл. Монголбанкинд байршуулсан, заавал байлгах нөөцийн үлдэгдлийг хорогдуулсан өртгөөр бүртгэх бөгөөд Банкны өдөр тутмын үйл ажиллагааг санхүүжүүлэхэд ашиглах боломжгүй заавал байлгах нөөцийн хүүгүй хадгаламж тул үүнийг мөнгөн гүйлгээний тайлан дахь мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөд оруулахгүй.

Бусад банк санхүүгийн байгууллага дахь харилцах, хадгаламж. Банк харилцагч банкуудад мөнгө байршуулсан үед нь бүртгэнэ. Бусад банк, санхүүгийн байгууллага дахь харилцах, хадгаламжийг дараах үед хорогдуулсан өртгөөр бүртгэнэ: (1) гэрээнд заасан мөнгө гүйлгээг цуглуулах зорилгоор эзэмшдэг бөгөөд эдгээр мөнгөн гүйлгээ нь ЗҮТХТ-ийн дагуу байх, (2) ашиг, алдагдалд бодит үнэ цэнийг (ААБҮЦ) нь хүлээн зөвшөөрөхгүй үед.

Өрийн хэлбэрээрх хөрөнгө оруулалт. Өрийн хэлбэрээрх хөрөнгө оруулалтыг бизнес загвар болон мөнгөн урсгалын шинж чанарт нь үндэслэн дараахын аль нэгээр нь ангилна: (1) Хорогдуулсан өртгөөр бүртгэгдэх (ХӨ), (2) Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэх (БДОБҮЦ), эсвэл (3) Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд бүртгэгдэх (ААБҮЦ). Өрийн үнэт цаасыг ЗҮТХТ-ийн дагуу гэрээнд заасан мөнгөн төлбөрийг цуглуулах зорилгоор эзэмшиж байгаа үед хорогдуулсан өртгөөр бүртгэх ба нягтлан бодох бүртгэлийн зөрүүг бууруулах зорилгоор бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд бүртгэгдээгүй үед хорогдуулсан өртгөөр бүртгэнэ.


Өрийн үнэт цаасыг ЗҮТХТ-ийн дагуу гэрээнд заасан мөнгөн төлбөрийг цуглуулах зорилгоор болон худалдан борлуулах зорилгоор эзэмшиж байгаа үед бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын (БДОБҮЦ) тайланд бүртгэгдэнэ. Эдгээр хөрөнгүүдийн хүүний орлогыг үр ашигт хүүний аргаар тодорхойлох ба ашиг алдагдалд бүртгэнэ. Үнэ цэнийн бууралтын санг хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын загварыг ашиглан тооцоолох ба тухайн тайлант жилийн ашиг алдагдалд бүртгэдэг. Бусад бүх дансны үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрнө. Хэрэв бусад дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрөгдөхгүй үед өмнө нь хуримтлагдан бүртгэгдсэн байсан ашиг алдагдлыг бусад дэлгэрэнгүй орлогын тайлангаас ашиг алдагдлын тайлан руу дахин ангилна.

Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг алдагдлын тайланд бүртгэгдэх (ААБҮЦ) өрийн хэлбэрээрх хөрөнгө оруулалтын хувьд хорогдуулсан өртгөөр (ХӨ) бүртгэгдэх болон бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд (БДОБҮЦ) бүртгэгдэх шалгуурыг хангаагүй өрийн хэрэглүүрүүд байна. Банк нягтлан бодох бүртгэлийн олон янзын сууриар хүлээн зөвшөөрөгдсөн буюу хэмжигдсэн санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрийн хоорондын нягтлан бодох бүртгэлийн зөрүүг мэдэгдэхүйц хэмжээгээр бууруулах сонголтыг ашиглаж байгаа тохиолдолд анхны хүлээн зөвшөөрөлтөөр нь бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг алдагдлын тайланд бүртгэгдэх өрийн үнэт цаасны хөрөнгө оруулалтыг дахин тодорхойлж болно.

Өмчийн хэлбэрээрх хөрөнгө оруулалт. Үнэт цаас гаргагчийн хэтийн төлөвт өмчийн тодорхойлолтыг хангасан санхүүгийн хөрөнгө (мөнгөөр төлөх гэрээний үүргийг агуулаагүй санхүүгийн хэрэглүүр ба гаргагчийн цэвэр хөрөнгөд үлдэх хувь оролцоог нотлох баримт) нь Банкны өмчийн хэлбэрээрх хөрөнгө оруулалтыг илтгэнэ. Өмчийн хэлбэрээрх хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнийг бусад дэлгэрэнгүй орлогод (БДОБҮЦ) анх хүлээн зөвшөөрөхөөс бусад тохиолдолд бодит үнэ цэнийг нь ашиг, алдагдлаар (ААБҮЦ) хэмжинэ. Банкны бодлогод хөрөнгө оруулалтыг зөвхөн өгөөж бий болгохоос бусад стратегийн зорилгоор тэдгээр хөрөнгө оруулалтыг эзэмшдэг бол өмчийн хэлбэрээрх хөрөнгө оруулалтыг бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнэ (БДОБҮЦ)-ээр тодорхойлно гэж заасан байдаг. Бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнэ (БДОБҮЦ)-ийг хүлээн зөвшөөрөх сонголтын үед бодит үнэ цэнийн олз гарзыг бусад дэлгэрэнгүй орлогод хүлээн зөвшөөрч, түүнийг борлуулахтай холбоотой ашиг алдагдалд дахин ангилж болохгүй. Хэрэв үнэ цэнийн бууралтын гарз ба тэдгээрийн буцаалт байгаа тохиолдолд бодит үнэ цэнийн бусад өөрчлөлтөөс тусад нь хэмжихгүй. Банкны төлбөр хүлээн авах эрх нь хөрөнгө оруулалтын өгөөж гэхээсээ илүү хөрөнгө оруулалтын нөхөн төлбөрийг илэрхийлэхээс бусад тохиолдолд ногдол ашгийг ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө.



625 3202



ХААН БАНК ХХК

Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2022 оны 12 сарын 31

3. Нягтлан бодох бүртгэлийн бодлого (Үргэлжлэл)

Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа. Банк харилцагчаас авах өрийг худалдан авах эсвэл шинээр зээл олгож мөнгө шилжүүлсэн тохиолдолд харилцагчдад олгосон зээл ба урьдчилгааг бүртгэнэ. Бизнес загвар болон мөнгөн урсгалын шинж чанарт үндэслэн дараах хэмжилтийн аль нэгээр нь ангилна: (1) хорогдуулсан өртгөөр (ХӨ) : гэрээнд заасан мөнгөн урсгалыг цуглуулах зорилгоор олгосон зээл бөгөөд эдгээр мөнгөн урсгал нь ЗҮТХТ-ийн дагуу байх, (2) бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлаар (ААБҮЦ) хүлээн зөвшөөрөгдөх: ЗҮТХТ болон хорогдуулсан өртөг, бодит үнэ цэнэ нь бусад дэлгэрэнгүй орлогоор (БДОБҮЦ) хүлээн зөвшөөрөгдөх шалгуурыг хангаагүй тохиолдолд бодит үнэ цэнийг ашиг алдагдалд хүлээн зөвшөөрнө.

Үнэ цэнийн бууралтын санг ирээдүйд чиглэсэн хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын загварт үндэслэн тогтоодог. Тодруулга 36-д хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын хэмжилтэд ашигласан өгөгдөл, таамаглал, тооцооллын аргачлал болон Банк хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын загварт ирээдүйд чиглэсэн мэдээллийг хэрхэн тодруулсан тайлбарыг тусгасан.

Хураан авсан барьцаа хөрөнгө. Хураан авсан барьцаа хөрөнгө нь хугацаа хэтэрсэн зээлийн төлбөрийг барагдуулах зорилгоор зээлдэгчээс хураан авсан санхүүгийн болон санхүүгийн бус хөрөнгийг илэрхийлнэ. Тухайн хөрөнгийг өртгөөр (санхүүгийн бус хөрөнгө) эсвэл бодит үнээр (санхүүгийн хөрөнгө) бүртгэж, Банкны зорилго болон мөн чанараас нь хамааран хөрөнгүүдийг тоног төхөөрөмж, бусад санхүүгийн хөрөнгө, хөрөнгө оруулалтын үл хөдлөх хөрөнгө зэргээр ангилах ба түүний дараа эдгээр хөрөнгүүдийг нягтлан бодох бүртгэлийн бодлогын дагуу дахин үнэлнэ.

Банк борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын дагуу тайлант хугацааны эцэст ийм ангиллын холбогдох нөхцөл хангагдсан тохиолдолд өмчлөх бусад хөрөнгөд бүртгэдэг.


Зээлд хамаарах үүрэг. Банк зээл олгох үүрэг хүлээдэг ба эдгээр үүрэг нь материаллаг сөрөг өөрчлөлтөөс хамааран буцалтгүй болон буцаагдах нөхцөлтэй байна. Зээл олгох үүрэг нь анх бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрөгддөг бөгөөд хүлээн авсан хураамжийн дүнгээр нотлогддог. Энэ дүнг хүлээсэн үүргийн хүчинтэй байх хугацааны туршид шулуун шугамын аргаар хорогдуулан бүртгэдэг. Энэ арга нь Банк зээл олгох үүрэг хүлээж, уг үүргийнхээ дагуу тодорхой зээлийн хэлцэлд оролцох нь магадлалтай бөгөөд тухайн зээлээ олгосны дараа богино хугацаанд бусад борлуулах төлөвлөгөөгүй тохиолдолд үйлчлэхгүй. Энэ тохиолдолд зээлийн үүргийн хураамжийг хойшлуулж, олгосон зээлийн анхны хүлээн зөвшөөрөх дүнд оруулан тооцно. Тайлант үе бүрийн эцэст үүргүүдийг (1) анх хүлээн зөвшөөрсөн тухайн өдрөөрх хорогдуулаагүй дүнгийн үлдэгдэл болон (2) зах зээлийн хүүний түвшнээс доогуур хүүтэй зээл олгох үүргээс бусад тохиолдолд хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын загварын дагуу тодорхойлогдсон алдагдлын дүнгийн аль ихээр нь хэмжиж бүртгэнэ. Зээлд хамаарах үүргийн дансны үнэ нь өр төлбөрийг илэрхийлнэ. Зээл болон ашиглаагүй үүргийг багтаасан гэрээний хувьд, Банк нь зээлийн бүрэлдэхүүнээс ашиглагдаагүй үүргийн хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлыг тусад нь ялгаж чадахгүй тохиолдолд уг алдагдлыг зээлийн алдагдлын хасагдуулгын хамт хүлээн зөвшөөрнө. Нийт хүлээгдэж буй эрсдэлийн алдагдал нь зээлийн нийт дансны үнээс илүү гарсан тохиолдолд өр төлбөрөөр хүлээн зөвшөөрнө.

Тодруулга 36-д ХБЭА-ыг хэмжихэд ашигласан өгөгдөл, таамаглал, тооцооллын аргачлал болон Банк нь ХБЭА-ын загварт ирээдүйд чиглэсэн мэдээллийг хэрхэн тодруулсан талаарх тайлбарыг оруулсан.

Санхүүгийн баталгаа. Санхүүгийн баталгаа нь өрийн хэрэглүүрийн анхны эсвэл өөрчлөгдсөн нөхцөлийн дагуу тогтоосон хугацаанд төлбөрөө төлөөгүйгээс болж баталгаа эзэмшигчид учирсан хохирлыг барагдуулахын тулд банкнаас тодорхой төлбөр хийхийг шаарддаг. Санхүүгийн баталгааг ихэвчлэн бодит үнэ цэнээр нь хүлээн зөвшөөрдөг бөгөөд энэ нь ихэвчлэн хүлээн авсан шимтгэлийн дүнгээр нотлогддог. Энэ дүнг баталгааны хугацаанд шулуун шугамын аргаар хорогдуулдаг. Тайлант үе бүрийн эцэст баталгааг (1) ХБЭА-ын загварт үндэслэн тодорхойлсон баталгаат эрсдэлийн алдагдлын сангийн хэмжээ (2) анх хүлээн зөвшөөрөх үеийн үнийн дүнгийн хорогдуулаагүй үлдэгдлийн аль ихээр нь хэмждэг. Түүнчлэн санхүүгийн байдлын тайланд хөрөнгө болгон хүлээн зөвшөөрсөн төлбөрийн авлагад ХБЭА-ын санг тооцож хүлээн зөвшөөрдөг. Тодруулга 36-д ХБЭА-ыг хэмжихэд ашигласан өгөгдөл, таамаглал, тооцооллын аргачлалын талаарх мэдээлэл, тухайлбал банк нь ХБЭА-ын загварт ирээдүйд харсан мэдээллийг хэрхэн тусгадаг тухай тайлбарыг оруулсан болно.

Гүйцэтгэлийн баталгаа. Гүйцэтгэлийн баталгаа нь гэрээ эсвэл хууль ёсны үүргээ биелүүлээгүй тохиолдолд нөгөө талаас нөхөн төлбөр олгодог гэрээ юм. Гүйцэтгэлийн баталгаа нь банкинд хүсэлт гаргагчаас баталгаа эзэмшигчид төлсөн төлбөрийг нөхөн төлөх гэрээгээр нөхөн олговор олгох эрхтэй бол тухайн эрх нь барьцаа хөрөнгөөр хангагдах тохиолдолд, банк баталгааны гэрээгээр банкинд алдагдал





ХААН БАНК ХХК

Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2022 оны 12 сарын 31

3. Нягтлан бодох бүртгэлийн бодлого (Үргэлжлэл)

хүлээхэд хүргэж болзошгүй арилжааны шинж чанартай үйл явдал байхгүй гэж дүгнэвэл эдгээрийг олгосон зээлийн үүрэг гэж үзнэ. Гүйцэтгэлийн баталгааг хүлээн зөвшөөрөхдөө хүлээн авсан шимтгэлийн хураамжийн үнэ буюу бодит үнэ цэнээр нь бүртгэдэг. Энэхүү дүнд шулуун шугамын аргаар гэрээний хугацааны турш хорогдуулалт тооцдог. Тайлант үе бүрийн эцэст гүйцэтгэлийн баталгааны гэрээг дараах дүнгүүдийн аль ихээр нь хэмжинэ. Үүнд (1) анх хүлээн зөвшөөрөх үеийн үнийн хорогдуулалт хийгээгүй дүн, (2) ХБЭА-ын загварт үндэслэн тодорхойлогдсон алдагдлын дүн.

Гүйцэтгэлийн баталгаа нь талуудын хооронд ямар нэгэн өрийн хэрэглүүр байхгүй бөгөөд баталгааны төлбөр нь зөвхөн зээлдэгч төлбөрөө төлөөгүй байхаас хамаарахгүй тохиолдолд СТОУС 9-д заасан санхүүгийн баталгааны тодорхойлолтыг хангахгүй. Ийм гүйцэтгэлийн баталгааны хувьд Банк одоогоор СТОУС 17-ын дагуу нөлөөллийг үнэлж байна.

Худалдах, буцаан худалдан авах хэлцэл, үнэт цаасыг зээлдүүлэх. Зээлдүүлэгч нь эсрэг талдаа өгөөжийг үр дүнтэйгээр хангадаг худалдах, буцаан худалдан авах хэлцлийг (“репо хэлцэл”) баталгаатай санхүүжилтийн ажил гүйлгээ гэж үзнэ. Ийм худалдах, буцаан худалдан авах хэлцлийн дагуу борлуулсан үнэт цаасыг үл хүлээн зөвшөөрөхгүй. Үнэт цаасыг худалдан авагч нь гэрээ болон заншлаар үнэт цаасыг худалдах, дахин барьцаалах эрхтэй бол санхүүгийн байдлын тайланд дахин худалдан авах авлага гэж ангилна. Харгалзах өр төлбөрийг бусад банкинд төлөх эсвэл зээлээр авсан санхүүжилт хэсэгт тусгана.

Зээлдүүлэгчийн өгөөжийг банкинд үр дүнтэй өгдөг буцаан худалдах гэрээний дагуу худалдаж авсан үнэт цаасыг (“урвуу репо хэлцэл”) бусад банкнаас авах, эсвэл харилцагчид олгосон зээл, урьдчилгаа төлбөр гэж бүртгэнэ. Худалдах болон буцаан худалдан авах үнийн зөрүүг эсрэг талын цуглуулсан хүү, ногдол ашгийн орлогод тооцож, үр ашигт хүүгийн аргыг ашиглан репо хэлцлийн хугацаанд хуримтлуулна.

Тогтмол шимтгэлтэй харилцагч талуудад зээлсэн үнэт цаасыг санхүүгийн тайланд буюу санхүүгийн байдлын тайлангийн анхны ангилалд үлдээн бүртгэдэг. Харилцагч тал нь гэрээ, захиалгаар үнэт цаасыг худалдах, дахин барьцаалах эрхгүй бол тэдгээрийг дахин ангилж, тусад нь толиллуулна. Тогтмол шимтгэлтэйгээр зээлсэн үнэт цаасыг гуравдагч этгээдэд худалдахаас бусад тохиолдолд санхүүгийн тайланд бүртгэхгүй бөгөөд энэ тохиолдолд худалдан авалт, борлуулалтыг үнэт цаасны арилжаанаас үүссэн алдагдлыг хассан орлогод багтаан тухайн жилийн ашиг, алдагдалд бүртгэнэ. Үнэт цаасыг буцааж өгөх үүргийг зээлээр авсан санхүүжилт хэсэгт бодит үнэ цэнээр нь бүртгэнэ.


Худалдах, буцаан худалдан авах хэлцлийн дагуу худалдсан үнэт цаасны ангилалд үндэслэн Банк буцаан худалдан авах авлагыг хорогдуулсан өртөг (ХӨ), бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэх (БДОБҮЦ), бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг алдагдлын тайланд бүртгэгдэх (ААБҮЦ) хэмжилтийн ангиллын аль нэгэнд ангилдаг.

Худалдаж авсан өрийн бичиг. Худалдан авсан өрийн бичиг нь шинж чанараасаа хамааран бусад банкинд байршуулсан харилцах, хадгаламж, эсвэл харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа хэсэгт тусгагдах бөгөөд НББ-ийн хөрөнгийн ангиллын дагуу дараа нь дахин хэмжиж бүртгэнэ.

Худалдаж авсан санхүүгийн баталгаа. Худалдан авсан санхүүгийн баталгааны НББ-ийн хувьд, Банк өрийн хэрэглүүрт учирсан эрсдэлийн гарзыг нөхөн төлөх эсэх нь тухайн баталгаа нь (1) баталгаат зээлийн нөхцөлтэй салшгүй холбоотой эсэх, (2) тусад нь хүлээн зөвшөөрөхгүй зэргээс хамаарна.

Хэрэв санхүүгийн баталгаа нь баталгаат зээлийн салшгүй хэсэг эсвэл тусад нь хүлээн зөвшөөрөгдөөгүй гэсэн хоёрын аль алиныг нь хангаж байвал бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд бүртгэгдэх (ААБҮЦ) зээлээс бусад тохиолдолд баталгаанд төлсөн шимтгэл нь гүйлгээний зардлын адил зээлийн үр ашигт хүүгийн салшгүй хэсэг болно. Хэрэв баталгаат зээлийг хорогдуулсан өртгөөр (ХӨ) нь хэмжсэн бол зээлийн эрсдэл мэдэгдэхүйц нэмэгдсэн эсэхийг үнэлэхдээ санхүүгийн баталгаанаас мөнгөн гүйлгээг нөхөх чадварыг тооцохгүй боловч санхүүгийн баталгаанаас хүлээгдэж буй мөнгөн гүйлгээг баталгаатай зээлийн ХБЭА-ын хэмжилтэнд оруулна.

Санхүүгийн баталгаа нь аливаа зээл, зээлийн бүлэгт хамаарах нөхцөл, нөхцөлтэй салшгүй холбоотой бол тусдаа хөрөнгө гэж хүлээн зөвшөөрнө. Санхүүгийн баталгааг тусад нь хүлээн зөвшөөрдөг тул баталгаатай зээл, зээлийн ХБЭА-ын хэмжилтэнд оруулахгүй. Банк санхүүгийн баталгаанд хүлээн зөвшөөрөгдсөн хөрөнгийг (1) холбогдох зээлийн ХБЭА-ын сан ба (2) батлан даалтын зардлыг: (а) баталгааны хугацаа ба (б) баталгаатай зээл эсвэл зээлийн хүлээгдэж буй хугацаанаас богино хугацаанд хуваарилах зорилгоор хүлээн зөвшөөрөгдсөн хуримтлагдсан хорогдлыг хассан өртгийн аль ихээр хэмждэг. Зээлдэгч төлбөрөө төлөөгүй тохиолдолд энэхүү баталгаа нь тухайн байгууллагад учирсан





ХААН БАНК ХХК
Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2022 оны 12 сарын 31

3. Нягтлан бодох бүртгэлийн бодлого (Үргэлжлэл)

хохирлыг нөхөн төлөх нь бараг тодорхой бол уг хөрөнгийг хүлээн зөвшөөрдөг.

Барилга, тоног төхөөрөмж. Барилгыг дор дурдсанчлан дахин үнэлэгдсэн өртгөөс хуримтлагдсан элэгдлийг, мөн шаардлагатай бол үнэ цэнийн бууралтын гарзыг хассан дүнгээр тусгадаг.

Банкны эзэмшиж буй барилгыг анх өртгөөр нь хэмжиж бүртгэнэ. Үл хөдлөх хөрөнгийн дансны үнэ нь бодит үнээс материаллаг зөрүүтэй эсэхийг тайлант хугацаа бүрийн эцэст дахин үнэлнэ. Дахин үнэлгээнээс нэмэгдсэн дансны үнээр бусад дэлгэрэнгүй орлогыг кредитлэн, өөрийн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансыг нэмэгдүүлнэ. Ижил хөрөнгийн өмнө нь үүссэн нэмэгдлийг хааж буй дахин үнэлгээний бууралтыг бусад дэлгэрэнгүй орлогод хүлээн зөвшөөрч, өөрийн хөрөнгөнд өмнө нь хүлээн зөвшөөрсөн дахин үнэлгээний нэмэгдлийг бууруулах ба бусад бүх бууралтыг тухайн жилийн ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө. Хөрөнгийг борлуулах болон данснаас хасахад гарсан нэмэгдэл эсвэл хөрөнгийг Банк ашиглаж буй тохиолдолд өөрийн хөрөнгөнд бүртгэсэн барилга, тоног төхөөрөмжийн дахин үнэлгээний нөөцийг хуримтлагдсан алдагдал буюу хуримтлагдсан ашигт шууд хааж бүртгэдэг. Сүүлийн тохиолдолд бодит зөрүүгийн хэрэгжсэн өсөлт нь хөрөнгийн дахин үнэлсэн дансны үнээс тооцсон элэгдэл болон хөрөнгийн анхны өртгөөс тооцсон элэгдлийн зөрүүтэй тэнцэнэ.

Бодит үнэ цэнийн зах зээлд суурилсан нотлох баримт байхгүй бол орлогын хандлагын аргыг ашиглан бодит үнэ цэнийг тооцоолно. Удирдлага зах зээлд суурилсан нотолгоог ашиглан тайлант хугацааны эцэст дахин үнэлгээний загварын дагуу хэмжсэн барилгуудын дансны үнийг үнэлсэн бөгөөд бодит үнэ цэнэд мэдэгдэхүйц өөрчлөлт ороогүйг батлах бодит үнэ цэнийн зах зээлд суурилсан хангалттай нотолгоо байгаа гэдгийг хүлээн зөвшөөрнө.

Банкны үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээний дүн нь адил төрлийн үл хөдлөх хөрөнгийг үнэлж байсан туршлагатай, холбогдох мэргэжлийн мэргэшлийг эзэмшсэн, хараат бус үнэлгээчдийн хийсэн үнэлгээнд тулгуурладаг.

Банкны эзэмшиж буй тоног төхөөрөмжийг үнэ цэнэ бууралтын гарз болон элэгдлийг хассан дүнгээр бүртгэнэ.

Бага хэмжээний, өдөр тутмын засвар үйлчилгээний өртгийг гарсан даруйд нь зардалд бүртгэдэг. Барилга тоног төхөөрөмжийн томоохон хэсгийг шинэчлэхтэй холбоотой гарсан зардлыг капиталжуулж сольсон хэсгийг ашиглалтаас хасна.

Түрээсийн сайжруулалт нь Банкнаас түрээсийн зориулалттай үл хөдлөх хөрөнгийг бизнесийн тодорхой хэрэгцээ сонирхолд нийцүүлэн өөрчлөх явдал юм. Банкнаас үл хөдлөх хөрөнгийг зориулалтын дагуу ашиглахын тулд хийгдэх аливаа сайжруулалтыг нягтлан бодох бүртгэлийн зорилгоор өөрийн хөрөнгө гэж бүртгэдэг.


НББОУС 16 "Үндсэн хөрөнгө"-ийн дагуу дахин үнэлсэн хөрөнгийн бодит үнэ цэнэ нь дансны үнээс мэдэгдэхүйц ялгаагүй тохиолдолд 3-5 жилийн хугацаанд тухайн хөрөнгийг дахин үнэлж болно. Үндсэн хөрөнгийн үнэ цэнэ буурсан шинж тэмдэг илэрсэн тохиолдолд удирдлага хөрөнгийн бодит үнэ цэнээс борлуулах өртгийг хассан дүн болон түүний ашиглалтын үнэ цэнийн аль ихээр нь нөхөгдөх өртгийг тооцдог. Дансны үнийг нөхөгдөх өртөг хүртэл бууруулж, үнэ цэнийн бууралтын гарзыг өөрийн хөрөнгөд өмнө бүртгэгдсэн дахин үнэлгээний нэмэгдлээс давсан дүнгээр тухайн жилийн ашиг, алдагдалд бүртгэнэ. Хөрөнгийн ашиглалтын үнэ цэнэ болон бодит үнэ цэнээс борлуулахтай холбоотой зардлыг хассан дүнг тооцолход өөрчлөлт орсон бол өмнөх жилүүдэд хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтыг гарзыг шаардлагатай бол буцаан залруулж бүртгэнэ.

Хөрөнгө борлуулсны олз, гарзыг тодорхойлохдоо борлуултаас олсон орлогыг бүртгэлийн дүнтэй харьцуулж тооцох бөгөөд олз гарзыг тухайн жилийн ашиг, алдагдалд бүртгэнэ (үйл ажиллагааны бусад орлого зардлын хэсэгт).

Үндсэн хөрөнгийн элэгдэл. Дуусагүй барилгыг элэгдүүлдэггүй. Бусад үндсэн хөрөнгүүдийн элэгдлийг өртөг эсвэл дахин үнэлсэн дүнг доорх ашиглах хугацааны туршид шулуун шугамын аргыг ашиглан үлдэх өртөг хүртэл нь хуваарилж тооцно:



2023 5 29



ХААН БАНК ХХК

Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2022 оны 12 сарын 31

3. Нягтлан бодох бүртгэлийн бодлого (Үргэлжлэл)



Ашиглалтын хугацаа (жилээр)

Барилга	30-67
Компьютер	3-10
Оффисын тавилга, тоног төхөөрөмж	10
Тээврийн хэрэгсэл	10
Ашиглах эрхтэй хөрөнгө	3-5

Банкны тухайн хөрөнгийн хүлээгдэж буй ашиглалтын хугацааны эцэст хэрэв уг хөрөнгө аль хэдийн ашиглагдаж дууссан бол хөрөнгийн борлуулах үнээс холбогдох тооцолсон зардлуудыг хасч тооцсон дүнг хөрөнгийн үлдэх өртөг гэдэг. Тайлант хугацаа бүрийн эцэст хөрөнгийн үлдэх өртөг болон ашиглалтын хугацааг хянаж үзэх ба шаардлагатай бол залруулдаг.

Хүлээгдэж буй ашиглалтын хугацааны өөрчлөлтийг элэгдлийн хугацаа болон аргачлалыг зохих хэмжээнд өөрчилснөөр нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт гэж тодорхойлно. Ашиглах эрхтэй хөрөнгийг санхүүгийн байдлын тайланд үндсэн хөрөнгөөс тусад нь толиллуулна. Ашиглах эрхтэй хөрөнгийг түрээсийн хугацаанд шулуун шугамын аргаар элэгдүүлнэ.

Биет бус хөрөнгө. Банкны биет бус хөрөнгө нь компьютерийн программ хангамж болон лицензүүд байна. Худалдан авсан компьютерийн программ хангамжийн лицензүүдийг тэдгээрийг худалдан авах үед үүсэх зардал болон ашиглахад бэлэн болгоход гарсан зардлыг үндэслэн капиталжуулдаг. Хэрэв хөрөнгийн зардлаасаа давсан өсөн нэмэгдэх эдийн засгийн өгөөж орж ирэх магадлалтай бол Банкны эзэмшлийн бүх төрлийн программ хангамжийг хөгжүүлсэнтэй холбоотой зардлыг биет бус хөрөнгө гэж бүртгэнэ. Хязгаарлагдмал хугацаатай биет бус хөрөнгийн эдийн засгийн ашиглалтын хугацааны турш шулуун шугамын аргаар хорогдуулах ба биет бус хөрөнгийн үнэ цэнийн бууралтын шинж тэмдэг илэрсэн үед тухайн хөрөнгийн үнэ цэнэ бууралтыг үнэлнэ. Хорогдуулалтын хугацаа болон аргачлалыг хамгийн багадаа жил бүрийн тайлант хугацааны эцэст хянаж үздэг. Биет бус хөрөнгийн тооцолсон ашиглалтын хугацааг дараах байдлаар тогтоосон: Программ хангамжийн лицензүүд 1- 5 жил байна.

Банк түрээслэгчийн хувьд түрээсийн нягтлан бодох бүртгэл. Банк нь оффисын байр түрээслэдэг. Банк ашиглах эрхтэй хөрөнгө болон түүнтэй холбоотой өр төлбөрийг тухайн түрээслэж буй хөрөнгийг ашиглах эрх нь бий болсон өдрөөр хүлээн зөвшөөрнө. Түрээсийн төлбөр бүрийг өр төлбөр ба санхүүгийн зардлын хооронд хуваарилдаг. Санхүүгийн зардлыг түрээсийн хугацааны туршид ашиг алдагдалд хүлээн зөвшөөрдөг бөгөөд ингэснээр хугацаа тус бүрийн өр төлбөрийн үлдэгдэлд хүүгийн хугацааны туршид тогтмол хувийг ашиглан тооцоолдог. Ашиглах эрхтэй хөрөнгийг өртгөөр хүлээн зөвшөөрөх ба хөрөнгийн ашиглалтын хугацаа болон түрээсийн хугацааны аль багаар нь шулуун шугамын аргаар элэгдэл тооцдог.

Түрээсийн төлбөрийн өнөөгийн үнэ цэнээр нь анхлан хэмжинэ. Түрээсийн өр төлбөр нь дараах түрээсийн төлбөрийн өнөөгийн цэвэр үнэ цэнийг агуулна:

- тогтмол төлбөрүүд (уг чанар нь тогтмол төлбөрүүд орно) хасах нь аливаа түрээсийн урамшууллын авлага;
- индекс эсвэл хувь хэмжээнд үндэслэсэн түрээсийн хувьсах төлбөрүүд;
- баталгаат үлдэх өртгийн дагуу Банкны төлөхөөр тооцоолж буй дүн;
- худалдан авах сонголтын хэрэгжих үнэ (хэрэв түрээслэгч тухайн сонголтыг хийх нь тодорхой үндэслэлтэй бол); болон
- Түрээсийн гэрээг цуцлахтай холбоотой торгуулийн төлбөрүүд (хэрэв түрээсийн нөхцөлд түрээсийг цуцлах сонголтыг хэрэгжүүлэхээр түрээслэгч тусгасан бол)


Түрээсийн төлбөрүүдийг нуугдмал хүүний түвшингээр хорогдуулах ба хэрвээ тодорхойлох боломжгүй бол түрээслэгчийн зээлийн өсөн нэмэгдэх хүүний түвшинг ашиглана. Энэ нь Банк эдийн засгийн ижил төстэй нөхцөл байдалд ижил үнэ цэнэтэй хөрөнгийг худалдан авахад шаардлагатай санхүүжилтийг ижил төстэй нөхцөлөөр зээлэх үед төлөх зээлийн хүүгийн түвшинг хэлнэ.

Ашиглах эрхтэй хөрөнгийг дараах өртгөөр хэмжинэ:

- Түрээсийн өр төлбөрийн анхны хэмжилтийн дүн;
- түрээсийн гэрээ хүчин төгөлдөр хэрэгжиж эхлэх өдөр болон түүнээс өмнө төлсөн түрээсийн төлбөрүүд, холбоотой аливаа хүлээн авсан урамшууллыг хассан дүнгээр;
- анхдагч шууд зардал;
- нөхөн сэргээгдэх зардал;



2023 5 29



ХААН БАНК ХХК

Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2022 оны 12 сарын 31

№ 3.1 Нягтлан бодох бүртгэлийн бодлого (Үргэлжлэл)

Дээр дурдсанаас үл хамааран Банк богино хугацаатай түрээс болон бага үнэ цэнэтэй түрээсийн хөрөнгийн төлбөрийг шулуун шугамын аргаар хуваарилан үйл ажиллагааны зардалд бүртгэдэг.

Банк түрээсийн хугацааг тодорхойлохдоо түрээсийн гэрээг эдийн засгийн өгөөжтэй байх эсэхэд үндэслэн сунгах эсвэл цуцлах эсэхийг холбогдох баримт болон нөхцөл байдлыг харгалзан үздэг. Сунгах болон цуцлах хугацааны сонголтыг зөвхөн тодорхой үндэслэлтэйгээр хэрэгжүүлнэ гэсэн тохиолдолд түрээсийн нөхцөлд оруулдаг.

Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө. Эргэлтийн бус хөрөнгө эсвэл борлуулах бүлэг хөрөнгөнд эргэлтийн болон эргэлтийн бус хөрөнгүүд багтах ба хэрэв тайлант хугацаанаас хойш 12 сарын дотор дансны үнэ нь борлуулалтын ажил гүйлгээний үр дүнд нөхөгдөх, эсвэл тухайн хөрөнгийг эзэмшиж байгаа охин компанийн хяналтыг алдахаар байх үед эдгээр хөрөнгийг санхүүгийн байдлын тайланд "Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө" гэж ангилна. Дараах нөхцөлүүд хангагдсан үед хөрөнгийг дахин ангилна. Үүнд: (а) хөрөнгө нь одоогийн нөхцөл байдалд нэн даруй борлогдох боломжтой; (б) Банкны удирдлага худалдан авагчийг олох төлөвлөгөөг батлан, үйл ажиллагааны идэвхтэй хөтөлбөрийг эхлүүлсэн; (в) хөрөнгийг зах зээлийн үнэтэй ойролцоо үнээр худалдахаар идэвхтэй ажиллаж буй; (г) хөрөнгийг нэг жилийн хугацаанд худалдан борлуулах магадлалтай; (д) хөрөнгийг худалдах төлөвлөгөөнд өөрчлөлт орох эсвэл төлөвлөгөөг цуцлах магадлал тун бага. Тайлант хугацааны санхүүгийн байдлын тайланд борлуулах зорилгоор эзэмшиж байгаа хөрөнгөөр тусгагдсан эргэлтийн бус хөрөнгө эсвэл борлуулах бүлэг хөрөнгө нь харьцуулсан санхүүгийн байдлын тайланд дахин ангилагдаагүй, мөн дахин толиллуулагдаагүй.

Бусад банкуудын байршуулсан хөрөнгө. Бусад банкуудын байршуулсан хөрөнгийг харилцагч банкууд Банкинд мөнгө буюу бусад төрлийн хөрөнгө шилжүүлсэн үед хүлээн зөвшөөрнө. Дериватив бус өр төлбөрийг хорогдуулсан өртгөөр (ХӨ) бүртгэнэ. Хэрэв Банк өөрийн өрийг худалдан авсан тохиолдолд өр төлбөрийг санхүүгийн байдлын тайлангаас хасч, өр төлбөрийн дансны үнэ болон төлсөн төлбөрийн зөрүүг болон өрийн эргэн төлөлтөөс үүссэн төлбөрийг ашиг алдагдалд бүртгэдэг.

Харилцагчдын харилцах, хадгаламж. Харилцагчдын харилцах, хадгаламж нь хувь хүмүүс, улсын болон хувийн эзэмшлийн аж ахуйн нэгж, байгууллагад төлөх дериватив бус өр төлбөр бөгөөд хорогдуулсан өртгөөр (ХӨ) бүртгэнэ.


Бодит үнэ цэнэ нь ашиг алдагдлаар (ААБҮЦ) хэмжигдэх санхүүгийн өр төлбөр. Банк зарим санхүүгийн өр төлбөрийг анхны хүлээн зөвшөөрөлтөөр бодит үнэ цэнэ нь ашиг алдагдлаар хэмжигдэх (ААБҮЦ) өр төлбөрт ангилдаг. Ийм өр төлбөрийн олз гарзыг ашиг алдагдлын тайланд тусгадаг ба тухайн өр төлбөрийн зээлийн эрсдэлийн бодит үнэ цэнийн өөрчлөлтөөс үүссэн дүнг бусад дэлгэрэнгүй орлогод (БДО) тусгадаг ба ирээдүйд ашиг алдагдлын тайланд дахин ангилагдаагүй. Хэрвээ энэхүү бүртгэл нь нягтлан бодох бүртгэлийн зөрүү үүсгэсэн байвал өр төлбөрийн зээлийн эрсдэлийн өөрчлөлтөөс үүссэн олз/гарзын дүнг ашиг алдагдлын тайланд бүртгэнэ.

Банкнаас гаргасан өрийн үнэт цаасууд. Банкнаас гаргасан өрийн үнэт цаасуудад өрийн бичгүүд, бондууд, хадгаламжийн болон өрийн бичгийн гэрчилгээнүүд багтсан бөгөөд хорогдуулсан өртгөөр (ХӨ) хэмжигдэнэ. Хэрэв Банк өөрийн гаргасан өрийн үнэт цаасаа худалдан авсан тохиолдолд тэдгээр үнэт цаасуудын санхүүгийн байдлын тайлангаас хасч, дансны үнэ болон төлсөн төлбөрийн зөрүүг болон өрийн эргэн төлөлтөөс үүссэн төлбөрийг ашиг алдагдалд бүртгэдэг.

Бусад зээлээр авсан санхүүжилт. Олон улсын санхүүгийн байгууллага болон Монгол улсын төрийн байгууллагуудаас авсан зээлүүд нь зээлээр авсан санхүүжилтэнд багтана. Анхны хэмжилтийн дараа гаргасан өр болон бусад зээлсэн хөрөнгийг үр ашигт хүүгийн аргачлалыг ашиглан тооцож хорогдуулсан өртгөөр (ХӨ) хэмжинэ. Хорогдуулсан өртгийг тооцоходоо гаргасан хөрөнгийн хөнгөлөлт, урамшуулал, мөн үр ашигт хүүгийн салшгүй хэсэг болох зардлыг харгалзан тооцдог.

Үүсмэл санхүүгийн хэрэглүүр. Үүсмэл санхүүгийн хэрэглүүр нь бодит үнэ цэнээр бүртгэгдэх валютын своп байна.

Үүсмэл санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнэ эерэг бол хөрөнгө, бодит үнэ цэнэ нь сөрөг бол өр төлбөр гэж бүртгэдэг. Үүсмэл санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийг тухайн жилийн ашиг, алдагдалд бүртгэдэг (үүсмэл санхүүгийн хэрэглүүрээс үүссэн олзоос гарзыг хассан дүнгээр).



3. Нягтлан бодох бүртгэлийн бодлого (Үргэлжлэл)

Хейджийн бүртгэл. Банк нь тодорхой деривативуудыг (валют хоорондын своп) хейджийн хэрэглүүр гэж тодорхойлдог бөгөөд тэдгээр нь гадаадын банк, санхүүгийн байгууллагаас авсан ам.доллараар илэрхийлэгдсэн урт хугацааны зээлийн мөнгөн гүйлгээний хэлбэлзлийн эрсдэлээс хамгаалах зорилготой юм.

Банк хейджийн зүйлийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийг тооцоолохдоо таамаглалын деривативийн аргыг ашигладаг. Таамаглалын дериватив арга нь хейджийн эрсдэлд өртөхөд хамгийн тохиромжтой хейджийн хэрэглүүр болох нэрлэсэн деривативыг бий болгох явдал юм (хүүгийн своп эсвэл форвард хэлцэл нь энгийн нөхцөлгүйгээр байх мөн хейджийн харилцааг эхлүүлэх үед бодит үнэ цэнэ тэг байна). Таамаглалын деривативын бодит үнэ цэнийг эрсдэлээс хамгаалсан ирээдүйн мөнгөн гүйлгээний цэвэр өнөөгийн үнэ цэнийг төлөөлөх хэрэглүүр болгон ашигладаг бөгөөд үүний эсрэг бодит хейджийн хэрэглүүрийн үнэ цэнийн өөрчлөлтийг Тодруулга 11-д, үр ашиггүй байдлын хэмжилтийг Тодруулга 27-д тусган харуулсан.

Орлогын албан татвар. Орлогын албан татварыг тайлант үеийн эцэст бүхэлдээ буюу үндсэндээ батлагдсан хууль тогтоомжийн дагуу санхүүгийн тайлангуудад хүлээн зөвшөөрнө. Орлогын албан татварын зардал нь тухайн тайлант хугацааны болон хойшлогдсон татвараас бүрдэх бөгөөд уг зардлуудтай холбоотой ажил гүйлгээ нь тухайн буюу өөр тайлант хугацаанд бусад дэлгэрэнгүй орлогод бүртгэгдсэнээс бусад тохиолдолд тухайн жилийн ашиг алдагдалд хүлээн зөвшөөрөгдөнө.

Тайлант хугацааны орлогын албан татвар нь тухайн болон өмнөх хугацаанд үүссэн татвар ногдуулах ашиг, алдагдалтай холбоотой татварын байгууллагад төлөх эсвэл түүнээс нөхөн авах дүн болно. Санхүүгийн тайланг холбогдох татварын албанд тушаахаас өмнө баталж амжаагүй тохиолдолд татвар ногдуулах ашиг, алдагдлыг урьдчилан тооцоолдог. Орлогын албан татвараас бусад татваруудыг удирдлагын болон үйл ажиллагааны бусад зардалд бүртгэдэг.

Хойшлогдсон орлогын албан татварыг тооцоохдоо татварын алдагдлыг ирээдүйд шилжүүлэх балансын өглөгийн аргыг ашигладаг ба санхүүгийн тайлангийн өдрийн байдлаарх хөрөнгө, өр төлбөрийн татварын суурь болон санхүүгийн тайлан дахь бүртгэлийн дүнгийн хооронд үүсэх түр зөрүүнд үндэслэж тооцдог.

Анхны хүлээн зөвшөөрөлийн чөлөөлөлтийн дагуу татвар ногдуулах ашиг болон бүртгэлийн ашгийн алинд ч нөлөөлдөггүй, мөн бизнесийн нэгдлээс бусад ажил гүйлгээнд хөрөнгө ба өр төлбөрийг анхлан хүлээн зөвшөөрөх үед үүссэн түр зөрүүгийн хувьд хойшлогдсон татвар бүртгэхгүй. Хойшлогдсон татварын үлдэгдлийг тайлант хугацааны эцэст бүхэлдээ буюу үндсэндээ батлагдсан байсан татварын хувь хэмжээгээр тооцож байгаа бөгөөд түр зөрүү гарах хугацаанд буцаах эсвэл татварын алдагдлыг ирээдүйд ашиглагдах үед тооцохоор хүлээгдэж байдаг.

Хасагдах түр зөрүү болон татварын алдагдал шилжүүлснээс үүссэн хойшлогдсон татварын хөрөнгийг ирээдүйд түр зөрүү буцаах магадлалтай үед бүртгэх бөгөөд эдгээр түр зөрүүг ирээдүйд олох татварын ашгаас хасч ашиглаж болохуйц хэмжээгээр хүлээн зөвшөөрнө.


Татварын тодорхой бус байдал. Банкны тодорхой бус байр суурийг удирдлага тайлант үеийн эцэс бүрд дахин үнэлдэг. Банкны орлогын татварын байр суурийг татварын байгууллага хүлээн зөвшөөрөхгүй байж болохоос үүдэн нэмэлт татвар ногдуулах нь ногдуулахгүй байхаас илүү магадлалтай гэж удирдлага үзсэн тохиолдолд өр төлбөрийг хүлээн зөвшөөрнө. Санхүүгийн тайлангийн эцсийн өдрийн байдлаар бүхэлдээ буюу үндсэндээ батлагдсан байсан хууль тогтоомжийн тайлбар, мөн ижил асуудлыг шүүх байгууллагын шийдвэрлэсэн байдалд үндэслэн үнэлгээ хийдэг. Торгууль, алданги болон орлогын бус татвартай холбоотой өглөгийн хувьд тайлант хугацааны эцэс дэх өр төлбөрийг барагдуулахад шаардагдах зардлыг удирдлага хамгийн боломжит аргаар тодорхойлсноор хүлээн зөвшөөрнө.

Өр төлбөрийн эрсдэлийн сан. Өр төлбөрийн эрсдэлийн сан нь тодорхойгүй хугацаатай болон дүн бүхий санхүүгийн бус өр төлбөр бөгөөд Банк өнгөрсөн үйл явдлын үр дүнд өнөөгийн эрх зүйн хувьд эсвэл бодит үндэслэлтэй үүрэг хүлээх энэхүү үүргээ биелүүлэхэд шаардагдах эдийн засгийн өгөөж бүхий эх үүсвэрийг төлөх магадлалтай ба уг үүргийн дүнг баталгаатайгаар тооцоолох боломжгүй үед эдгээр санг хуримтлуулан бүртгэдэг.

Дансны болон бусад өглөг. Дансны өглөгийг эсрэг тал гэрээгээр хүлээсэн үргээ биелүүлэх үед хуримтлуулж, хорогдуулсан өртгөөр (ХӨ) бүртгэнэ.



67
5
29
2023



ХААН БАНК ХХК

Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2022 оны 12 сарын 31



3. Нягтлан бодох бүртгэлийн бодлого (Үргэлжлэл)

Хувьцаат капитал. Энгийн хувьцааг эздийн өмчид ангилан бүртгэдэг. Хүлээн авсан төлбөрийн бодит үнэ цэнэ нь гаргасан хувьцааны нэрлэсэн үнээс хэтэрсэн үед эздийн өмчид хувьцааны урамшуулал буюу нэмж төлөгдсөн дансанд бүртгэдэг.

Ногдол ашиг. Ногдол ашиг зарласан хугацаанд нь эзэмшигчдийн хөрөнгөд бүртгэнэ. Тайлант хугацааны дараа болон санхүүгийн тайлан гаргах зөвшөөрөл олгохоос өмнө зарласан аливаа ногдол ашигийг тайлангийн дараагийн үйл явдлын тодруулгад толиллуулна. Банкны хуульд нийцүүлэн гаргасан нягтлан бодох бүртгэлийн тайлан нь ашгийн хуваарилалт болон бусад хуваарилалтын суурь үндэслэл болно. Монгол Улсын хууль тогтоомжид хуваарилалтын суурийг тухайн жилийн цэвэр ашиг гэж тодорхойлсон байдаг.

Хүүгийн орлого болон зардлын хүлээн зөвшөөрөлт. Хүүгийн орлого, зардлыг ашиг алдагдлаарх бодит үнэ цэнээр (ААБҮЦ) хүлээн зөвшөөрөхөөс бусад тохиолдолд бүх өрийн хэрэглүүр бүрийн хувьд аккруэл суурьт үндэслэн үр ашигт хүүгийн аргаар тооцоолон бүртгэнэ. Энэ аргын дагуу гэрээний талуудын хооронд төлөгдсөн эсвэл хүлээн авсан бүх хураамж, гүйлгээний зардал болон бүх үнийн нэмэгдэл буюу хөнгөлөлтийг үр ашигт хүүнд оруулан тооцож, цаг хугацааны хувьд хойшлуулан хүүгийн орлого эсвэл зардалд бүртгэнэ. Бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөгдөх (ААБҮЦ) өрийн хэрэглүүрийн хүүгийн орлогыг нэрлэсэн хүүгээр тооцож орлого үр дүнгийн тайлангийн "бусад адилтгах орлого" мөрөнд толиллуулсан.

Үр ашигт хүүгийн бүрэлдэхүүн болох хураамжид санхүүгийн хөрөнгийг худалдан авах эсвэл санхүүгийн өр төлбөрийг үүсгэхэд шууд холбоотойгоор нэмэгдэн гардаг, жишээлбэл төлбөрийн чадварыг үнэлэх, зээлийн баталгаа эсвэл барьцааг үнэлэх болон бүртгэх, хэрэглүүрийн нөхцөлүүдийг хэлэлцэх болон холбогдох баримт бичиг боловсруулах зэрэг гэрээ байгуулахтай холбоотой аливаа хураамжууд орно. Банк нь харилцагчид зээл олгосны дараах богино хугацаанд тухайн зээлийг тусгайлсан хэлцэл байгуулах худалдах төлөвлөгөөгүй тохиолдолд тухайн зээлийг зах зээлийн хүүгээр олгохтой холбоотой хураамж, шимтгэлийг үр ашигт хүүгийн бүрэлдэхүүн хэсэг болгон тооцно. Зээл олгохоор хүлээсэн үүргийг Банк ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр (ААБҮЦ) хэмжигдсэн санхүүгийн өр төлбөр гэж ангилдаггүй.


Үүссэн болон худалдан авсан үнэ цэнийн бууралттай санхүүгийн хөрөнгийн хувьд үр ашигт хүүгийн түвшин нь хүлээгдэж буй мөнгөн гүйлгээг (анхны хүлээгдэж буй эрсдэлийн алдагдал) анх бодит үнэ цэнээр (худалдан авах үнээр илэрхийлэгддэг) хүлээн зөвшөөрөхдөө бүртгэх хямдруулах хүү юм. Үр дүнд нь үр ашигт хүүгийн түвшин нь зээлийн тохируулгатай байдаг.

Дараах нөхцөлөөс бусад үед санхүүгийн хөрөнгийн нийт дансны үнэд үр ашигт хүүгийн түвшинг ашиглан хүүгийн орлогыг тооцоолно. (1) зээлийн үнэ цэнийн бууралтад орсон санхүүгийн хөрөнгүүд (3-р үе шат), хүүгийн орлогын үр ашигт хүүний түвшинг ашиглан хорогдуулсан өртгөөр тооцож, хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын санг хассан дүнгээр, (2) үүссэн болон худалдан авсан үнэ цэнийн бууралттай санхүүгийн хөрөнгийн хувьд анхны зээлийн тохируулгатай үр ашигт хүүгийн түвшинг ашиглан хорогдуулсан өртгийг тооцох үед.

Хэрэв 3-р үе шат -д ангилсан санхүүгийн хөрөнгийн зээлийн эрсдэл дараа нь сайжирч, хөрөнгө нь цаашид зээлийн үнэ цэнийн бууралтгүй болсон мөн энэ сайжирсан байдал нь хөрөнгийг зээлийн үнэ цэнийн бууралттай гэж тогтоосны дараа үүсэх үйл явдалтай бодитойгоор холбоотой байгаа тохиолдолд хөрөнгийг 3-р үе шатаас гаргаж, хүүгийн орлогын дансны нийт дүнгээс үр ашигт хүүгийн аргаар тооцож бүртгэнэ. Өмнө нь хөрөнгө 3-р үе шат-д байсны улмаас ашиг алдагдалд хүлээн зөвшөөрөгдөөгүй байсан нэмэлт хүүгийн орлого нь ангилал сайжирснаар үнэ цэнийн бууралтын буцаалт гэж хүлээн зөвшөөрөгдөнө.

Шимтгэл хураамжийн орлого. Шимтгэл, хураамжийн орлогыг харилцагч Банкны үйл ажиллагааны үр дүнд бий болсон үр өгөөжийг нэгэн зэрэг хүлээн авч, ашигладаг учраас үйлчилгээг үзүүлсэн үед нь шулуун шугамын аргаар хугацааны туршид хүлээн зөвшөөрдөг. Шимтгэл хураамжийн орлогод дансны бүртгэл, дансны үйлчилгээний хураамж, данс хөтөлсний хураамж, тусгай үйлчилгээний багцын хураамж болон бусад үйлчилгээний хураамж, эсвэл гуравдагч этгээдийн нэрийн өмнөөс төлсөн зээлийн үйлчилгээний хураамж зэрэг багтана. Хувьсах хураамжийг томоохон хэмжээний буцаалт байхгүй гэдгийг өндөр магадлалтайгаар удирдлага тодорхойлсон үед л хүлээн зөвшөөрнө.





ХААН БАНК ХХК

Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2022 оны 12 сарын 31



3. Нягтлан бодох бүртгэлийн бодлого (Үргэлжлэл)

Бусад хураамж, шимтгэлийн орлого нь ихэвчлэн үндсэн ажил гүйлгээ гарсны дараа тодорхой хугацаанд буюу Банк гүйцэтгэлийн үүргээ хангасан үед хүлээн зөвшөөрнө. Хүлээн авсан хураамж, шимтгэл болон авлагын дүн нь гүйцэтгэлийн ялгаатай үүргүүд гэж тодорхойлсон үйлчилгээний хувьд гүйлгээний үнийг илэрхийлнэ. Иймд орлогод харилцагчийн нэрийн өмнөөс гадаад валют худалдах, худалдан авахад зориулсан хураамж, төлбөрийн гүйлгээ хийх үйлчилгээний хураамж, бэлэн мөнгөний төлбөр тооцоо, цуглуулах, зарцуулах хураамж зэрэг багтана.

Гадаад валют худалдах, худалдан авах, валют хөрвүүлэх. Банк нь касс болон банкны дансаар дамжуулан гадаад валют худалдах, худалдан авах, мөн гадаад валют солилцох үйл ажиллагаа явуулдаг. Гүйлгээ нь тухайн өдрийн албан ханшаас ялгаатай ба банкнаас тогтоосон ханшаар хийгддэг. Албан ханш болон банкны тогтоосон ханшийн зөрүүг гүйцэтгэлийн тодорхой үүрэг биелсэн үед гадаад валют арилжааны алдагдлыг хассан дүнгээр ашиг гэж хүлээн зөвшөөрнө.

Гадаад валютын хөрвүүлэлт. Банкны үйл ажиллагааны бүртгэлийн мөнгөн тэмдэгт нь Монгол төгрөг (Төг) байна. Гадаад валютаар хийгдсэн гүйлгээг анх гүйлгээ хийгдсэн өдрийн албан ханшаар үйл ажиллагааны валютаар бүртгэнэ. Гадаад валютаар бүртгэгдсэн мөнгөн хөрөнгө, төлбөрүүдийг санхүүгийн байдлын тайлангийн өдрийн ханшаар дахин хөрвүүлдэг. Мөнгөн зүйлсийн төлөгдсөн буюу хүлээн авсан эсвэл хөрвүүлснээс үүссэн бүх зөрүүг ашиг, алдагдлын тайланд бүртгэнэ. Өөрийн өртөг нь гадаад валютаар хэмжигдэх мөнгөн бус зүйлсийг анхны гүйлгээний өдрийн ханшаар хөрвүүлнэ. 2022 оны 12 дугаар сарын 31-ний болон 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар төгрөгийн нэгж ам.доллартай харьцах ханш 3,444.60 төгрөг болон 2,848.80 төгрөг байна.

Цэвэршүүлэх. Ирээдүйн үйл явдлаас хамааралгүйгээр хүлээн зөвшөөрөгдсөн дүнгүүдийг цэвэршүүлэх хуулиар олгогдсон эрхтэй ба доорх бүх нөхцөлд цэвэр дүнгээр нь барагдуулах хандлагатай байгаа үед санхүүгийн хөрөнгө, санхүүгийн өр төлбөрүүдийг хооронд нь цэвэршүүлж, цэвэр дүнг санхүүгийн байдлын тайланд толиллуулна. Үүнд: (а) ирээдүйн үйл явдлаас шалтгаалахгүй байх (б) дараах бүх нөхцөл байдалд хууль ёсны дагуу хэрэгжих ёстой: (1) бизнесийн хэвийн үйл ажиллагааны үед, (2) чанаргүйдэл гарсан үед (3) төлбөрийн чадваргүй болсон эсвэл дампуурсан үед.


Нэгж хувьцаанд ногдох ашиг. Нэгж хувьцаанд ногдох ашгийг банкны хувьцаа эзэмшигчдэд ногдох ашиг, алдагдлыг тайлант жилийн эргэлтэд байгаа хувьцааны жинлэсэн дундаж тоонд хуваах замаар тодорхойлно.

Ажилтны зардал ба түүнтэй холбоотой тэтгэмж. Банкны ажилчдын цалин, нийгмийн даатгалын шимтгэл, жилийн цалинтай чөлөө, ХЧТАТэтгэмж, урамшуулал, мөнгөн бус тэтгэмжийг ажилтны холбогдох үйлчилгээ үзүүлсэн тайлант жилд тайлагнана. Банк хуулиар тогтоосон шимтгэлийн тогтолцооны төлбөрөөс гадна тэтгэвэр болон түүнтэй адилтгах тэтгэмжийн төлбөрийг хийх хууль ёсны болон бодит үүрэг хүлээхгүй.

Сегментийн тайлан. Сегментүүдийг дотоод тайлагналын дагуу тайлагнадаг. Орлого, үр дүн эсвэл хөрөнгө нь бүх сегментийн 10 ба түүнээс дээш хувьтай тэнцүү байгаа сегментүүдийг тусад нь тайлагнадаг.

Санхүүгийн тайланг гаргасны дараа нэмэлт өөрчлөлт оруулах. Банкны хувьцаа эзэмшигчид болон удирдлага санхүүгийн тайланг гаргасны дараа нэмэлт, өөрчлөлт оруулах эрхтэй:





ХААН БАНК ХХК

Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2022 оны 12 сарын 31

3. Нягтлан бодох бүртгэлийн бодлого (Үргэлжлэл)

Шаардлагатай тоон мэдээллийг тухайн тайлант жилийн дүнгийн танилцуулгад нийцүүлэн зассан. 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн тоон мэдээллийг дараах байдлаар дахин ангилсан байдлаар доор харуулав:

	Анх толилуулагдсан	Дахин ангилагдсан	2021 оны 12 дугаар сарын 31-нээр дахин ангилагдсан
<i>Мянган төгрөгөөр</i>			
Хүүгийн зардал [1]	1,886,344	(1,886,344)	-
Бусад түүнтэй адилтгах зардал [1]	-	1,886,344	1,886,344
Шимтгэл хураамжийн зардал [2]	-	18,456,766	18,456,766
Удирдлага болон бусад үйл ажиллагааны зардал [2]	18,456,766	(18,456,766)	-
Бусад үйл ажиллагааны зардал [3]	7,903,384	(7,903,384)	-
Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд бүртгэгдэх санхүүгийн хөрөнгийн гарз [3]	-	(8,771,737)	(8,771,737)
Хорогдуулсан өртгөөр тооцсон зээлээр авсан санхүүжилтийн өөрчлөлтийн олз [3]	-	868,353	868,353
Гадаад валют арилжааны гарзыг хассан олз [4]	2,252,900	(2,252,900)	-
БДОБҮЦ-ээр бүртгэгдэх санхүүгийн хөрөнгийг борлуулсны гарзыг хассан олз [4]	-	2,252,900	2,252,900
Удирдлага болон бусад үйл ажиллагааны зардал [5]	951,022	(951,022)	-
Бусад цэвэр олз [5]	-	951,022	951,022

Ил тод, хамааралтай байдлыг хангах үүднээс 2022 оноос эхлэн орлогын тайланд дараах зүйлсийг тусад нь толилуулсан. Харьцуулсан дүнг өөрчлөлттэй уялдуулан дахин ангилсан.

- [1] Түрээсийн өглөг болон хейдж хангаагүй свопын хүүгийн зардлыг хүүгийн зардалд оруулалгүй бусад түүнтэй адилтгах зардал хэсэгт тусгасан.
- [2] Мессежийн хураамжийн зардлыг удирдлага болон бусад үйл ажиллагааны зардлаас хураамж, шимтгэлийн зардал болгон дахин ангилсан.
- [3] Санхүүгийн хөрөнгийн өөрчлөлтөөс үүссэн гарзыг бусад үйл ажиллагааны зардлаас тусад нь толилуулсан.
- [4] Санхүүгийн хөрөнгийг борлуулсаны олзыг хассан гарзыг гадаад валют арилжааны гарзыг хассан олзоос тусад нь тусгасан.
- [5] Хөрөнгийн гарзыг хассан олзыг тусад нь тусгасан.

Удирдлагын зүгээс ингэж толилуулах нь илүү ач холбогдолтой гэж үзсэн тул 2022 оноос эхлэн Мөнгөн гүйлгээний тайланд өөрчлөлт оруулсан. Өөрчлөлттэй уялдуулан харьцуулсан дүнг дахин ангилсан бөгөөд үүнд голчлон:

	Анх толилуулагдсан	Дахин ангилагдсан	2021 оны 12 дугаар сарын 31-нээр дахин ангилагдсан
<i>Мянган төгрөгөөр</i>			
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	26,818,301	(580,971,343)	(554,153,042)
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд зарцуулсан цэвэр мөнгөн гүйлгээ	(146,914,742)	71,964,220	(74,950,522)
Санхүүгийн үйл ажиллагаанд зарцуулсан цэвэр мөнгөн гүйлгээ	(180,784,669)	463,486,230	282,701,561
Валютын ханшийн өөрчлөлтийн мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөд үзүүлэх нөлөө	-	45,520,893	45,520,893
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн тайлант жилийн эрсдэлийн сангийн зардал	-	(113,958)	(113,958)



2023 5 29



ХААН БАНК ХХК

Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2022 оны 12 сарын 31

3. Нягтлан бодох бүртгэлийн бодлого (Үргэлжлэл)

- Репо хэлцлийн санхүүжилт болон эргэн төлөлтийн цэвэршүүлсэн 463,486,230 мянган төгрөгийг өмнө нь “үндсэн үйл ажиллагаа” гэж ангилж байсныг “санхүүгийн үйл ажиллагаа” гэж дахин ангилсан.
Банкны дотоод зээлжих зэрэглэлийн систем, жилийн эцсийн Үе шатны ангилалд үндэслэн зээлийн чанар болон зээлийн эрсдэлд өртөх дээд хэмжээг Тодруулга 7, 8, 9, 12-аас харна уу.

Хүлээгдэж буй эрсдэлийн алдагдал (ХБЭА)-ын хэмжилт: ХБЭА нь ирээдүйд хүлээж болзошгүй алдагдлын өнөөгийн үнэ цэнэ (өөрөөр хэлбэл: зээлийн үргэлжлэх хугацаанд зээл дефолт болоход жигнэсэн дундаж алдагдал) юм. ХБЭА нь нэг хүчин зүйлээс шууд хамааралтай бус хэд хэдэн боломжит хувилбаруудаас хамаарч тооцоологддог. Банкны ХБЭА-ын тооцоолол дөрвөн бүрэлдэхүүн хэсгээс бүрдэнэ. Үүнд: Чанаргүйдлийн магадлал ("ЧМ"), Чанаргүйдэлд өртөх дүн ("ЧӨД"), Алдагдал хүргэх чанаргүйдэл ("АХЧ") болон Хөнгөлөлтийн хувь.

ЧӨД гэдэг нь зээл дефолт болох үеийн үлдэгдэл бөгөөд тайлант хугацаанаас хойших зээлийн үлдэгдлийг таамаглахдаа зээлийн эргэн төлөлт буюу үндсэн зээлийн болон хүүгийн төлөлт, нэмж олгож болзошгүй зээлийн дүнг харгалзан авч үздэг. Хүлээж болзошгүй үүргийн дефолт болох үеийн зээлийн үлдэгдлийг тооцоолохдоо зээл хөрвүүлэлтийн коэффициент ("ЗХК") ашигладаг. ЗХК нь хүлээж болзошгүй үүрэг зээл хөрвүүлэлтийн магадлалын коэффициент юм. Банк хүлээж болзошгүй үүрэг 12 сарын дотор зээлрүү хөрвөх болон нийт хугацааны турш зээлрүү хөрвөх магадлалуудыг адил гэж үздэг.

ЧМ нь өгөгдсөн хугацааны туршид дефолт болох магадлалын тооцоолол юм. АХЧ нь зээл дефолт болсон тохиолдолд түүнээс хүлээж болзошгүй алдагдлын тооцоолол юм. АХЧ нь гэрээний дагуух төлөх ёстой мөнгөн дүн болон зээлдүүлэгч тухайн зээлээс төлүүлж чадах мөнгөн дүн хоёрын зөрүү юм. Харилцагчаас төлүүлж чадах мөнгөн дүнд барьцаа хөрөнгө орно. АХЧ нь ихэвчлэн ЧӨД-д эзлэх хувиар илэрхийлэгддэг. Хүлээгдэж буй алдагдлыг тайлант хугацааны эцэст өнөөгийн үнэ цэнээр хорогдуулна. Хөнгөлөлтийн хувь нь санхүүгийн хэрэглүүрийн үр ашигт хүүгийн түвшин ("ҮАХТ") юм.



2023 5 29



№: Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2022 оны 12 дугаар сарын 31

36. Санхүүгийн эрсдэлийн удирдлага (Үргэлжлэл)

36.2 Зээлийн эрсдэл (Үргэлжлэл)

Хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын тооцооллыг зээлийн *нийт хугацааны туршид* загварчилсан. *Нийт хугацааны туршид* гэдэг нь өрийн хэрэглүүрийн гэрээний үлдсэн хугацаа ба гэрээнээсээ өмнө төлөгдөх магадлалыг тохируулдаг. Зээлийн үүрэг болон санхүүгийн баталгааны гэрээний хувьд тухайн аж ахуйн нэгж зээлийн хугацааг сунгах гэрээний үүрэгтэй гэрээт хугацаа юм. Нийт хугацааг гэрээний дагуу хүлээгдэж буй үлдэгдэл хугацаагаар тодорхойлдог бол хувь хүнд олгосон зээлийн картын хувьд нийт хугацаа нь гэрээний дагуу картын хугацаа бөгөөд энэ нь хамгийн ихдээ 2 хүртэлх жилтэй тэнцүү байна.

Нийт хугацааны ХБЭА нь зээлийн дуусах хугацааны турш болзошгүй бүх дефолт тохиолдлоос үүсэх алдагдал юм. *12 сарын ХБЭА* нь зээлийн дуусах хүртэлх хугацааны ХБЭА-ын нэг хэсэг бөгөөд тайлант

хугацаанаас хойших 12 сарын хугацаанд үүсэж болзошгүй зээлийн алдагдал юм. Хэрэв зээлийн дуусах хугацаа нь 12 сараас бага байвал хүлээж болзошгүй зээлийн алдагдлыг дуусах хугацаа хүртэл тооцоолно.

Санхүүгийн тайланд толиллуулсан ХБЭА-ын тооцоолол нь дотоодын зохицуулагч байгууллагад зориулсан урт хугацааны өгөгдлийг ашиглах бус сүүлийн үеийн өгөгдлийг ашигласан. Тооцоолол нь ирээдүйн таамаглалыг агуулсан буюу зээлийн эрсдэлд нөлөөлдөг гол макро хувьсагчуудын ирээдүйд болох таамаглал тусгагдсан.

Чанаргүйдлийн тодорхойлолт. ЧМ-ыг хэмжихийн тулд банк нь дараах шалгууруудын нэг буюу хэд хэдэн шалгуурыг хангасан нөхцөл байдлыг чанаргүйдэл гэж тодорхойлдог:


- Зээлдэгч гэрээний төлбөрөө төлөх хугацаа 90 хоногоос хэтэрсэн;
- Зээлдэгч бусад банкинд гэрээгээр төлөх хугацаа 90 хоногоос хэтэрсэн зээлтэй;
- Банк зээл муудсаны улмаас зээлдэгчийн өр эсвэл түүний хэсгийг алдагдалтай худалдсан;
- Олон улсын үнэлгээний байгууллагууд зээлдэгчийг чанаргүй зээлийн ангилалд оруулсан;
- Зээлдэгч нь доорх төлбөр төлөх боломжгүй гэсэн жагсаалтанд орсон:
 - Банк өрийн бүтцийн өөрчлөлт хийхээс өөр аргагүй болсон;
 - Зээлдэгч нас барсан;
 - Зээлдэгч төлбөрийн чадваргүй болсон;
 - Зээлийн хугацаан дахь барьцаа хөрөнгийн үнэгүйдэл;
 - Зээлдэгч нь санхүүгийн болон зээлийн гэрээнд дурдсан нөхцөл, бусад шаардлагыг зөрчсөн;
 - Зээлдэгчийн эргэлтийн хөрөнгийн бууралт эсвэл томоохон үйлчлүүлэгчээ алдах;
 - Зээлдэгч дампуурах магадлалтай болж байгаа;
 - Зээлийн алдагдлыг тусгасан ихээхэн хөнгөлөлттэй үнээр худалдаж авсан эсвэл олгосон зээл.

Тодруулгын зорилгоор, Банкны дефолтын тодорхойлолт болон зээлийн үнэ цэнэ бууралтын тодорхойлолт хооронд ямар нэгэн зөрүүгүй бөгөөд дээр дурдсан дефолт тодорхойлолт нь Банкны санхүүгийн бүх хөрөнгөнд мөрдөгдөнө.


Санхүүгийн хөрөнгө нь зургаан сарын дараалан дефолт тодорхойлолтонд заасан нөхцөлүүдийг хангаагүй тохиолдолд дефолтоос гарч болно. Зургаан сар гэдэг нь санхүүгийн хөрөнгийн дефолтоос гарсан хөрөнгө буцаж дефолт болсон хугацааны тооцоолол дээр үндэслэн гарсан болно.

Зээл анх олгогдсоноос хойш зээлийн эрсдэл мэдэгдэхүйц өссөн ("ЗЭМӨ") эсэх үнэлгээ нь зээл нэг бүрчлэн хийгддэг. Банкны зээлийн эрсдэлийн удирдлагын хэлтэс нь зээлийн эрсдэл мэдэгдэхүйц өссөн эсэх нөхцөлүүд нь тохиромжтой байдлыг тогтмол хугацаатай хянаж байдаг. Зээл анх олгогдсоноос хойш эрсдэл илэрхий өссөн эсэх шалгууруудыг нэг болох хугацаа хэтэрсэн хоног нь 30-аас дээш байх нөхцөл өөрчлөгдөөгүй болно.

Санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрөгдсөн хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын тооцоолол нь харилцагчийн зээлийн эрсдэл анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш мэдэгдэхүйц өссөн эсэхэд тулгуурладаг. Хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын тооцооллын загвар нь 3 үе шаттай байдаг. Санхүүгийн хэрэглүүр нь анхны хүлээн зөвшөөрөлтийн үед ямар нэг үнэ цэнийн бууралтгүй байдаг ба түүний зээлийн эрсдэл нь анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш их хэмжээгээр нэмэгдээгүй бөгөөд 12



2023 5 29



ХААН БАНК ХХК

Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2022 оны 12 дугаар сарын 31

36. Санхүүгийн эрсдэлийн удирдлага (Үргэлжлэл)

36.2 Зээлийн эрсдэл (Үргэлжлэл)

сарын ХБЭА (1-р үе шат)-д үндэслэн эрсдэлийн алдагдлын хасагдуулгыг тооцдог. Хэрвээ зээлийн эрсдэл мэдэгдэхүйц өссөн нь тогтоогдсон тохиолдолд 2-р үе шатанд орж, нийт хугацааны ХБЭА-д үндэслэн эрсдэлийн алдагдлыг тооцоолно. 2-р үе шатанд орсон зээлүүд нь үнэ цэнэ буураагүй зээлүүд болно. Санхүүгийн хөрөнгө нь үнэ цэнэ буурсан тохиолдолд 3-р үе шатанд хуваарилагдаж, дуусах хугацаа хүртэлх алдагдлыг тооцоолдог. 3-р үе шатанд орсон зээлүүдийн рүүгийн орлогыг зээлийн эрсдэлийн сангаас цэвэршүүлсэн дүнд тооцоолдог.

Хэрэв зээлийн эрсдэл мэдэгдэхүйц өссөн эсэхийг үнэлдэг шалгуурууд нь тухайн зээлд дахин илрээгүй бол 1-р үе шатруу шилжинэ. Банк чанарын үзүүлэлтээр 2-р үе шатруу шилжсэн зээлүүдийг тогтмол хянадаг.

Үнэ цэнэ буурсан зээл олгосон ба худалдан авсан зээлүүдийн хүлээгдэж буй эрсдэлийн алдагдал нь үргэлж нийт хугацааны турш тооцоологддог. Иймд Банк эдгээр зээлийн хувьд зөвхөн нийт хугацааны ХБЭА-ын зөрүүг бүртгэдэг.

ХБЭА-ын тооцоолол нь хоёр үнэлгээний аргаас бүрддэг. Үүнд: (1) тусгай үнэлгээ; (2) багцын үнэлгээ: зээлийн багцын нэг ижил төрлийн сегментүүдийн хувьд ХБЭА-ын тооцоололд ижил зээлийн эрсдэлийн параметр (жишээ нь: ЧМ, АХЧ)-ийг ашигладаг.

Банк дараах төрлийн зээлүүдийг тусгай үнэлгээний аргаар үнэлдэг. Үүнд: Зээлийн эрсдэлийн өвөрмөц шинж чанартай зээл эсвэл бүтцийн өөрчлөлттэй зээл, хяналтын жагсаалтад орсон зээл, өөрөөр хэлбэл 500,000 мянган төгрөгөөс дээш хувийн өртэй, 2,000,000 мянган төгрөгөөс дээш хугацаа хэтэрсэн зээл.

Зээлийн үнэ цэнэ бууралтын бодит нотлох баримт илэрсэн тохиолдолд ХБЭА-ыг тооцно. Зээлийн үнэ цэнэ бууралтын бодит нотолгоо нь санхүүгийн хүндрэл, гэрээний үүргээ биелүүлээгүй болон хугацаа хэтэрсэн, гэрээний бүтцийн өөрчлөлт, барьцаа хөрөнгийн үнэ цэнийн бууралт зэрэг юм.

Хүлээгдэж буй алдагдлын тооцоо, боломжит хувилбарыг тодорхой үнэлгээний аргаар үнэлж, хувилбар бүрийн магадлалыг харгалзан ХБЭА-ыг тооцно.

Банк дараах төрлийн зээлүүдэд багцын үнэлгээ хийдэг. Үүнд: Зээлдэгчийн мэдээлэл байхгүй үед хэрэглээний болон ЖДҮ-ийн зээл олгосон. Энэ арга нь зээлдэгчийн тусгайлсан мэдээлэл, тухайлбал, алдагдлын талаарх түүхэн мэдээлэл, байршил болон бусад урьдчилан таамаглах мэдээлэл зэрэгт үндэслэн зээлийн санг нэгэн төрлийн сегмент болгон ангилдаг. Банк нь мөн байгууллагын харилцагчдад олгосон зээл, банк хоорондын зээл, хэрэглээний зээл, ЖДҮ-д олгосон зээлийн үнэлгээг багцаар хийдэг.

Тусгайлсан ХБЭА-ын үнэлгээг үр дүн бүрийн магадлалын эсрэг олон төрлийн боломжит үр дүнгийн зээлийн алдагдлын тооцооллыг жинлэх замаар гүйцэтгэдэг. Банк үнэлгээнд хамрагдсан зээл бүрийн хувьд 2-3 боломжит үр дүнг тодорхойлдог бөгөөд тэдгээрийн нэг нь ийм хувилбарын магадлал маш бага байсан нь зээлийн алдагдалд хүргэдэг. Ганцаарчилсан үнэлгээ нь үндсэндээ Байгууллагын болон Хэрэглээний зээлийн эрсдэл, Тусгай активын хэлтсийн туршлагатай ажилтнууд, шинжээчдийн дүгнэлтэд суурилдаг. Тооцоолол болон бодит алдагдлын зөрүүг багасгахын тулд шинжээчдийн дүгнэлтийг тогтмол туршиж үздэг.

Багцын үнэлгээний аргаар багцын алдагдлын санг тооцоолохдоо зээл бүрийг үе шат бүрт хуваарилдаг. Банкны зээлийн эрсдэлийн нийтлэг шинж чанарт үндэслэн тодорхойлогдсон сегментүүдээр эрсдэлээ шинжилдэг. Банк зээлүүдийг ижил төрлийн эрсдэлийн шинж чанартайгаар нь ялган бүлэглэж тооцоолдог. Ижил төрлийн эрсдэлийн шинж чанартай зээл гэдэг нь харилцагчийн ангилал (бизнесийн, хэрэглээний болон хөдөө аж ахуйн гэх мэт) бүтээгдэхүүний төрөл, зээлийн эрсдэлийн зэрэглэл, анх хүлээн зөвшөөрөгдсөн огноо, дуусах хугацаа, барьцаа хөрөнгийн чанар, зээлийн үнэ (ЗҮ) харьцаа юм. Бүлэг болгон өөр өөр ЧМ болон АХЧ зэрэг эрсдэлийн параметруудтэй байна. Байгууллагын болон Хэрэглээний зээлийн эрсдэлийн удирдлагын газар зээлүүдийг бүлэглэх нь зохистой байгаа эсэхийг тогтмол хянаж байдаг.

ХБЭА нь ЧӨД, ЧМ, АХЧ зэрэг эрсдэлийн параметруудийн үржвэр бөгөөд тухайн санхүүгийн хөрөнгийн үр ашигт хүүгээр дискаунт хийж өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдэнэ. Эрсдэлийн параметр (ЧӨД, ЧМ, АХЧ)-ийг ирэх нэг жилийн таамаглалын тооцооллыг зээл нэг бүрийн эсвэл багцалсан зээлүүдийн





ХААН БАНК ХХК

Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2022 оны 12 дугаар сарын 31

36. Санхүүгийн эрсдэлийн удирдлага (Үргэлжлэл)

36.2 Зээлийн эрсдэл (Үргэлжлэл)

хувьд гаргаж тооцоолдог. Эдгээр гурван бүрэлдэхүүн хэсгийг хамтад нь үржүүлж, зээл төлөгдөх магадлалыг тохируулна (өөрөөр хэлбэл, чанаргүйдлийн өмнөх сард төлсөн эсвэл төлөгдөөгүй). ХБЭА нь зээл бүрийн ирээдүйн алдагдлыг тооцоолол ба тайлант огнооруу дискаунт хийсэн алдагдлуудын нийлбэр юм. ХБЭА-ын тооцоололд ашиглагдаж буй дискаунт хүү нь үр ашигт хүү эсвэл ойролцоо тооцоолсон хүү байна.

Зээлийн эрсдэлийн параметруудийг тооцоолох үндсэн зарчим. ЧӨД-үүд нь хүлээгдэж буй төлбөрийн хуваарьт тулгуурлан тодорхойлогддог бөгөөд энэ нь бүтээгдэхүүний төрлөөс хамаарна.

ЧӨД нь зээлдэгчийн хүлээсэн үүргийнхээ дагуу ирэх 12 сар эсвэл нийт хугацааны туршид төлөх ёстой зээлийн эргэн төлөлтөнд тулгуурладаг. Үүнийг мөн зээлдэгчийн төлөхөөр хүлээгдэж буй илүү төлбөрт тохируулдаг. Зээлдэгч нь зээлийн хуваарьт зааснаас өмнө зээлээ урьдчилан төлөх магадлалтай дүнгээр зээлийн эргэн төлөлтийн хуваарьт тохируулга хийдэг. Эргэн төлөлт, дахин санхүүжилтийн таамаглалыг мөн тооцоололд оруулдаг. Эргэлтийн бүтээгдэхүүнүүдийн хувьд ЧӨД нь одоогийн үлдэгдлийг авч, зээлийн хөрвүүлэлтийн коэффициент ашиглан үлдсэн хугацаан дахь хүлээгдэж буй зээл олголтыг нэмж тооцоолдог. Эдгээр таамаглалууд нь бүтээгдэхүүний төрөл, одоогийн зээлийн эрхийн хэрэглээ болон зээлдэгчийн онцлог зан төлөвөөс хамаарч ялгаатай байж болно.

ХБЭА-ыг тооцоход хоёр төрлийн ЧМ ашигладаг ба эдгээр нь 12 сар ба нийт хугацааны ЧМ юм. 12 сарын ЧМ-ын үнэлгээ нь хамгийн сүүлийн үеийн өгөгдөлд суурилсан. Нийт хугацааны ЧМ нь санхүүгийн хэрэглүүрийн үлдсэн хугацааны туршид дефолт болох магадлал ба энэ нь санхүүгийн хэрэглүүрийн 12 сар болон дефолт болох магадлалын нийлбэр байна. Банк шилжих хөдөлгөөнт матрицийн статистик аргагүйг ашиглан нийт хугацааны ЧМ-ыг харилцагчийн ангилал болон хугацаа хэтэрсэн хоногт тулгуурлан тооцоолдог. Тухайлбал, шилжих хөдөлгөөний матрицад суурилсан 12 сарын ЧМ-ыг экстраполяци хийж, түүхэн дефолт өгөгдөлд суурилсан нийт хугацааны ЧМ муруйг сайжруулах гэх мэт.


АХЧ нь төлөгдөөгүй эрсдэлээс үүдэн гарах алдагдлын хэмжээг букуу банкны хүлээлтийг илэрхийлнэ. АХЧ нь эсрэг талын төрөл, нэхэмжлэлийн төрөл, ахмад нас, барьцаа хөрөнгө болон бусад зээлийн дэмжлэг зэргээс хамаарч өөр өөр байдаг. 12 сар ба нийт хугацааны АХЧ нь зээл дефолт болсны дараа хүлээгдэж буй эргэн төлөлтөнд нөлөөлөх хүчин зүйлсийг авч үздэг. АХЧ хэмжилтийг гурван боломжит аргад хувааж болно:

- Барьцаа хөрөнгийн онцлог шинж чанарт үндэслэсэн АХЧ хэмжилт;
- Нөхөн сэргээлтийн статистик мэдээлэлд тулгуурсан багцад суурилсан АХЧ тооцоолол;
- Өөр өөр хүчин зүйлс, хувилбараас хамааран дангаар нь тодорхойлсон АХЧ.

Банк үл хөдлөх хөрөнгө, бэлэн мөнгө хөрвөх чадвартай үнэт цаасаар баталгаажсан зээлийн барьцаа хөрөнгийн төсөөлж буй үнэ, борлуулалтын түүхэн хөнгөлөлт болон бусад хүчин зүйл зэрэгт үндэслэн АХЧ-ийг тооцдог. АХЧ-ийг хамгийн сүүлийн үеийн эргэн төлөлтийн статистик мэдээлэлд үндэслэн байгууллагын болон хэрэглээний бүх зээлүүдэд багцын түвшинд тооцоолдог.

Санхүүгийн баталгаа болон зээлийн үүргийн ХБЭА-ын хэмжилт. Эдгээр хэрэглүүрийн ХБЭА-ын хэмжилт нь дээр дурдсантай ижил тооцоологдох боловч дефолт болох үеийн зээлийн үлдэгдэл АХЧ-ийн тооцооллын хувьд ялгаатай байна. АХЧ нь зээл хөрвүүлэлтийн коэффициент ("ЗХК") болон үүргийн дүнгээс хамаарна. Зээл хөрвүүлэлтийн коэффициент нь олгогдоогүй зээлийн үүрэг, зээлийн карт, санхүүгийн баталгааны түүхэн статистик тооцоололд тулгуурладаг. Овердрафтын зээл хөрвүүлэлтийн коэффициент нь 100% гэж тодорхойлогддог, учир нь харилцагч ямар ч үед дээд хэмжээгээр нь ашиглах боломжтой байдаг.

ХБЭА-ын тооцоололд орсон ирээдүйн мэдээлэл. Зээлийн эрсдэлийн мэдэгдэхүйц өсөлт болон ХБЭА-ыг тооцоолоход шударга болон дэмжигдэхүйц ирээдүйд үндэслэсэн мэдээллийг оролцуулдаг. Банк зээлийн эрсдэл болон ХБЭА-ыг боловсруулахад хамааралтай гол эдийн засгийн хувьсагч хэмжигдэхүүнүүдийг тодорхойлсон байдаг. Эдийн засгийн гол хувьсагч хэмжигдэхүүнүүдийг ("Эдийн засгийн суурь хувилбар") улирал тутам Банкны Хөрөнгийн Удирдлагын газраас гаргаж, таван жилд хүлээгдэж буй макро эдийн засгийн хөгжлийн хамгийн оновчтой тооцоог гаргаж өгдөг. Таван жилийн дараа "дундаж урвуу хандлагыг" ашигладаг бөгөөд энэ нь эдийн засгийн урт хугацааны дундаж түвшин (жишээ нь, ажилгүйдлийн түвшин) эсвэл урт хугацааны дундаж өсөлтийн хувь (жишээлбэл, ДНБ) руу





ХААН БАНК ХХК

Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2022 оны 12 дугаар сарын 31

36. Санхүүгийн эрсдэлийн удирдлага (Үргэлжлэл)

36.2 Зээлийн эрсдэл (Үргэлжлэл)

буцах хандлагатай байдаг. Чанаргүйдлийн магадлал (ЧМ), Чанаргүйдэлд өртөх дүн (ЧӨД) болон Алдагдалд хүргэх чанаргүйдэл (АХЧ)-д нөлөөлөх холбогдох эдийн засгийн хувьсагчдыг нөлөөг тодорхойлохын тулд статистик регрессийн шинжилгээ хийн эдгээр хувьсагчдын өөрчлөлт нь өмнө хэрхэн АХЧ болон ЧӨД-ийн бүрэлдэхүүд нөлөөлж байсныг тодорхойлно.

Эдийн засгийн суурь хувилбараас гадна Банкны Зээлийн Эрсдэлийн газар нь бусад боломжит хувилбаруудыг магадлалын хувь хэмжээтэй өгдөг. Бусад хувилбаруудын шугаман бус байдлыг харуулахын тулд үндсэн томоохон бүтээгдэхүүнүүдийн тус бүрийн шинжилгээнд үндэслэдэг. Хувилбаруудын хэмжээний хувьд тайлант жил бүр дахин үнэлэгддэг ба статистик шинжилгээ ба шинжээчдийн зээлийн дүгнэлтийг хослуулан тодорхойлдог ба ингэхдээ сонгогдсон хувилбар бүрийг илтгэх боломжит үр дүнг харгалзан үздэг. Зээлийн мэдэхүйц есөлтийн хэмжээг тооцоолохын тулд ЧМ-ын нийт хугацааг холбогдох хувилбарын хувь хэмжээнд үржүүлнэ, ингэхдээ чанар болон backstop индикаторуудыг оролцуулна. Энэ нь санхүүгийн хэрэглүүрийг бүхэлдээ 1-р үе шат, 2-р үе шат эсвэл 3-р үе шатанд орох эсэхийг тодорхойлж 12 сар эсвэл нийт хугацааны ЧМ бүртгэх эсэхийг тодорхойлно. Энэхүү үнэлгээний дараа Банк 12 сарын магадлалаар жинлэсэн ХБЭА-ыг бүртгэх (1-р үе шат) эсвэл магадлалаар жинлэгдсэн нийт хугацааны ХБЭА-ыг бүртгэнэ (2,3-р үе шат). Энэ магадлалаар жинлэсэн ХБЭА-ыг холбогдох ХБЭА-ын загвар хувилбар тус бүрээр гүйцэтгэж зохих хувилбарын жигнэгчээр үржүүлснээр тодорхойлогдоно.

Эдийн засгийн урьдчилсан таамаглалын хувьд тэдгээр тохиолдлын биелэх магадлал, төсөөлөл нь маш тодорхойгүй байдаг тул бодит үр дүн нь төлөвлөснөөс эрс ялгаатай байж болно. Банк эдгээр таамаглалуудыг боломжит үр дүнгийн хамгийн сайн тооцоолол гэж үзсэн ба өөр өөр багцуудын шугаман бус ба тэгш бус байдлын сонгогдсон хувилбарууд нь боломжит хувилбаруудыг хамгийн сайн боломжит байдлаар төлөөлдөг болохыг тогтоосон.

Банк эрсдэлийн тооцоолол болон бодит алдагдал хоёрын хоорондын зөрүүг бага байлгах үүднээс тооцооллын загварыг болон таамаглалыг тогтмол хугацаанд хянадаг.

Хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын тооцооллын загварын хяналтын үр дүнг банкны удирдлагуудад хүргүүлдэг ба хэлэлцүүлгээс гарсан үр дүнд үндэслэн загвар болон тооцоололд шаардлагатай шинэчлэлүүдийг хийдэг.

36.3 Зах зээлийн эрсдэл

Банк зах зээлийн эрсдэлд өртөх боломжтой. Зах зээлийн эрсдэлд а/ валютын ханш, б/ хүүний түвшин, в/ өмчийн үнэ цаасууд болон тухайн хөрөнгөд нөлөөлөх нийт болон тусгай зах зээлийн хөдөлгөөнөөс үүсдэг. Банкны удирдлага зах зээлийн эрсдэлийн гол хэмжигдэхүүний хязгаарыг тогтоож түүнийг өдөр тутамд хянах байдлаар зах зээлийг удирддаг.

Монгол Улс 2022 онд, БНХАУ-аас тогтоосон хилийн хязгаарлалт, ОХУ-ын Украинд хийсэн халдлага, мөн дэлхийн улс орнуудын мөнгөний бодлого чангарсны улмаас улсын макро эдийн засагт үзүүлэх дарамтыг нэмэгдүүлсэн боловч Банк алдагдлыг зах зээлийн эрсдэлийн удирдлагын хүрээнд зохих түвшинд үр дүнтэй удирдаж чадсан.

Банк хамгийн их эрсдэлийн арга (VaR), статик хугацааны зөрүүний шинжилгээ, мэдрэмтгий байдлын шинжилгээг ашиглан зах зээлийн эрсдэлээ хэмжин удирддаг бөгөөд түүнчлэн АПУХ-оос стоп лосс лимит, позицгийн лимит, мөнгөн гүйлгээний хейджийн зорилгоор хийх бодит бус нөхцөлтэй үүсмэл санхүүгийн хэрэглүүрийн мөнгөн урсгалын лимит, банкууд ба харилцагчидтай хийх арилжааны лимит болон нийт зээлээс бусад активын лимитийг тогтоон мөрдүүлж ажиллаж байна.

Түүнчлэн Банк өөрийн эрсдэл даах чадварыг үнэлэх, цаашлаад том хэмжээний гэнэтийн өөрчлөлтөөс учирч болзошгүй алдагдлыг тэсвэрлэх, хангалттай хэмжээний өөрийн хөрөнгө ба төлбөрийн чадвартай эсэхийг тодорхойлох, хүндрэлийг даван туулах шаардлагатай нөөцийг бүрдүүлэх, онцгой нөхцөл байдлын үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний үр ашигтай байдлыг нэмэгдүүлэх зорилгоор улирал тутам стресс тестийн шинжилгээг хийдэг. Банк олон улсад өргөн ашиглагддаг шилдэг туршлага, стандартад нийцүүлэн зах зээлийн эрсдэлийг хэмжих загвар, аргачлал, лимит тогтоох үйл явц болон эрсдэл бууруулах арга хэрэгслүүдийг тасралтгүй хөгжүүлж, хэрэгжүүлж ажилладаг.



СЭХ
2023.06.09
БҮРТГЭВ
№

ХААН БАНК ХХК

Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2022 оны 12 дугаар сарын 31

36. Санхүүгийн эрсдэлийн удирдлага (Үргэлжлэл)

36.4. Гадаад валютын ханшийн эрсдэл

Гадаад валютын ханшийн хэлбэлзлээс үүдэн санхүүгийн хэрэглүүрийн үнэ цэнэ өөрчлөгдөх эрсдэлийг гадаад валютын ханшийн эрсдэл гэнэ. Банк гадаад валютын ханшийн эрсдэлийн удирдлагын хүрээнд Монголбанкнаас банкуудад гадаад валютын ханшийн хэлбэлзлээс үүсч болзошгүй алдагдлыг тэдгээрийн эрсдэл даах чадвартай уялдуулах зорилгоор тогтоосон тухайн нэг болон нийт гадаад валютын нээлттэй позицитай хязгаарлалтуудыг хангаж ажиллаж байна. Түүнчлэн дотооддоо гадаад валютын нээлттэй позицоос тодорхой хугацааны дараа алдаж болох алдагдлын хэмжээг тодорхой магадлалтайгаар тодорхойлдог Хамгийн их эрсдэлийн аргаар ханшийн эрсдэлээ хэмжиж удирдаж ажилладаг. Банкны ашиглаж буй VaR аргачлал нь 99%-ийн итгэлцлийн түвшин ба хэрэв одоогийн зах зээлийн эрсдэлийн хэмжээ нэг өдөр өөрчлөгдөхгүй хэвээр байхад болзошгүй алдагдлын хэмжээ нь хэтэрч илүү гарахгүй байх 1 өдрийн хугацааг ашигладаг ба эдгээр хувьсагчуудыг зах зээлийн өгөгдлийн 250 өдрийн хөдөлгөөнийг ажигласны үндсэндэр тодорхойлдог. Эдгээр загварууд нь зах зээлийн хэвийн нөхцөлд эрсдэлийн хүчин зүйлсийн өөрчлөлтүүд нь хэвийн тархалттай байна гэж үздэг. Зах зээлд тогтворгүй байдал үүссэн тохиолдолд гадаад валютын эрсдэлийг илүү нарийвчлалтайгаар тооцох хэрэгцээ шаардлага өндөр байдаг. Иймд, тайлант жилд дотоод программ хангамжинд үнэлгээний загварууд болон буцаан шалгах аргачлалуудыг өргөтгөх, удирдлагын мэдээллийн системийн чанарыг сайжруулах зэрэг томоохон хөгжүүлэлтүүдийг хийсэн.

Банк нь уг хөгжүүлэлтүүдийг өдөр тутмын үйл ажиллагаандаа ашиглан ханшийн эрсдэлийн VaR тайланг бэлтгэж, АПУХ-оос тогтоосон лимитийн хэрэгжилтэд хяналт тавьж ажилладаг.

Банк нь мөн бизнесийн түншүүдтэй хийх арилжааны лимитийг тогтоож тогтмол хяналт тавин ажилладаг. Түүнчлэн гадаад валютын захын тогтворгүй үед банкны хүндрэлтэй үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулахын зэрэгцээ гадаад валютын ханшийн эрсдэлийн стресс тестийг улирал бүр хийж, үр дүнг АПУХ-д танилцуулан ажиллаж байна.

Тайлант хугацааны эцэст Банкны гадаад валютын ханшийн эрсдэлийн хураангуйг доорх хүснэгтээр харуулав

Мянган төг	2022 оны 12 дугаар сарын 31				2021 оны 12 дугаар сарын 31			
	Санхүүгийн мөнгөн хөрөнгө	Санхүүгийн мөнгөн өр төлбөр	Үүсмэл хэрэглүүр	Цэвэр позици	Санхүүгийн мөнгөн хөрөнгө	Санхүүгийн мөнгөн өр төлбөр	Үүсмэл хэрэглүүр	Цэвэр позици
Төгрөг	11,033,605,880	(9,041,716,734)	(1,177,315,414)	814,573,732	10,874,584,091	(9,646,374,772)	(485,885,071)	742,324,248
Ам.доллар	2,647,234,835	(3,857,780,654)	1,301,466,648	90,920,829	1,758,712,858	(2,309,751,630)	512,968,551	(38,070,221)
Евро	19,408,755	(19,577,161)	(33,162)	(201,568)	19,808,065	(15,864,611)	(18,329)	3,925,125
Юань	477,834,556	(469,266,033)	-	8,568,523	136,508,127	(144,086,326)	332	(7,577,867)
Бусад	52,296,621	(24,122,071)	(354,721)	27,819,829	69,401,047	(45,844,916)	(298,711)	23,257,420
Total	14,230,380,647	(13,412,462,653)	123,763,351	941,681,345	12,859,014,188	(12,161,922,255)	26,766,772	723,858,705

Бусад бүх хувьсах хүчин зүйлс тогтмол үед Банкны бүртгэлийн валюттай холбоотой тайлант хугацааны эцсийн ханшийн харьцангуй боломжит өөрчлөлтийн Банкны ашиг, алдагдал болон өөрийн хөрөнгөнд үзүүлэх мэдрэмтгий байдлыг доорх хүснэгтэнд тусгав:

Мянган төгрөгөөр	2022 оны 12 дугаар сарын 31	2021 оны 12 дугаар сарын 31
Ам.доллар 15%-аар чангарахад (2021: 15%-аар чангарахад)	13,638,124	(5,710,533)
Ам.доллар 15%-аар сулрахад (2021: 15%-аар сулрахад)	(13,638,124)	5,710,533
Евро 15%-аар чангарахад (2021: 15%-аар чангарахад)	(30,235)	588,769
Евро 15%-аар сулрахад (2021: 15%-аар сулрахад)	30,235	(588,769)
Юань 15%-аар чангарахад (2021: 15%-аар чангарахад)	1,285,279	(1,136,680)
Юань 15%-аар сулрахад (2021: 15%-аар сулрахад)	(1,285,279)	1,136,680
Бусад валют 15%-аар чангарахад (2021: 15%-аар чангарахад)	4,172,974	3,488,613
Бусад валют 15%-аар сулрахад (2021: 15%-аар сулрахад %)	(4,172,974)	(3,488,613)



2023 5 29

СЭХХААН БАНК ХХК

Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2022 оны 12 дугаар сарын 31

БҮРТГЭВ

№ 1 36. Санхүүгийн эрсдэлийн удирдлага (Үргэлжлэл)

36.5. Хүүний түвшний эрсдэл

Банкны санхүүгийн байдал, мөнгөн гүйлгээ нь зах зээлийн хүүний түвшний хэлбэлзлийн нөлөөнд өртдөг. Ийм хэлбэлзлийн үр дүнд хүүгийн ахиуц ашгийн хэмжээ нэмэгдэх магадлалтай боловч гэнэтийн өөрчлөлт үүсэх тохиолдолд алдагдал буурах эсвэл эсрэгээрээ нэмэгдэх ч боломжтой.

Банк нь Банкны арилжааны бүртгэл болон Банкны бүртгэлийн позицисоос хүлээж болзошгүй хүүгийн түвшний эрсдэлүүдийг хэмжиж удирддаг. Зах зээл дэх хүүний түвшний өөрчлөлт нь богино хугацаанд банкны цэвэр хүүгийн орлогод шууд нөлөөлдөг бол урт хугацаанд өөрийн хөрөнгийн эдийн засгийн үнэ цэнэд нөлөөлдөг. Банк нь хүүгийн эрсдэлийг хамгийн бага байлгах үүднээс Банкны хяналт шалгалтын Базелийн хорооноос боловсруулсан аргачлал, түүнд тодорхойлсон хүүний түвшний стандарт болон шокийн сценари хувилбаруудыг ашиглан эрсдэлээ хэмжиж, лимит тогтоох замаар сөрөг нөлөөллийг хязгаарладаг. Үүнд:


- Арилжааны бүртгэлийн хүүгийн түвшний эрсдэлийг удирдахын тулд хөрвөх чадвараар тохируулсан хамгийн их эрсдэлийн аргыг ашиглан позицисын ба стоп лосс зэрэг хязгаарлалтуудыг тавидаг.
- Банкны бүртгэлийн хүүгийн түвшний эрсдэлийг удирдахын тулд орлогын ба эдийн засгийн өртөгийн хандлагуудыг ашиглаж хүлээн зөвшөөрсөн хязгаарлалтын хүрээнд сар тутам хяналт тавьдаг.


Түүнчлэн Банк нь олон улсын санхүүгийн байгууллагаас тогтоосон хүүгийн эрсдэлийн дахин үнэлгээний зөрүүний харьцаа үзүүлэлтүүдийг хангаж ажиллахын зэрэгцээ хүүгийн стресс тестийг улирал бүр хийн үр дүнг шийдвэр гаргах зорилгоор АПУХороонд тайлагнадаг.

Доорх хүснэгтэд Банкны хүүгийн түвшний эрсдэлийн өртөх байдлыг хураангуйлан үзүүлэв. Энэхүү хүснэгтэд банкны хөрөнгө ба өр төлбөрийн дансны үнийн дүнг хүүнд өөрчлөлт орох хугацаа эсвэл дуусгавар болох хугацааны аль өмнөх хугацаагаар нь ангилан үзүүлэв:

Мянган төгрөгөөр	Хугацаагүй болон 1-с бага сар	1 - 6 сар	6 - 12 сар	1 жилээс их	Хүүгүй	Нийт
2022 оны 12 дугаар сарын 31						
Нийт санхүүгийн хөрөнгө	3,290,658,076	2,822,553,292	1,974,346,084	4,013,476,352	2,262,274,272	14,363,308,076
Нийт санхүүгийн өр төлбөр	1,672,207,654	2,673,907,298	2,691,632,922	1,528,757,814	4,850,853,862	13,417,359,550
2022 оны 12 дугаар сарын 31-р хүүгийн мэдрэмтгийн байдлын цэвэр зөрүү	1,618,450,422	148,645,994	(717,286,838)	2,484,718,538	(2,588,579,590)	945,948,526
2021 оны 12 дугаар сарын 31						
Нийт санхүүгийн хөрөнгө	3,752,686,452	1,352,061,532	1,578,528,066	4,216,552,946	1,989,428,929	12,889,257,925
Нийт санхүүгийн өр төлбөр	4,474,921,445	3,188,487,646	2,673,253,556	1,705,462,150	120,117,211	12,162,242,008
2021 оны 12 дугаар сарын 31-р хүүгийн мэдрэмтгийн байдлын цэвэр зөрүү	(722,234,993)	(1,836,426,114)	(1,094,725,490)	2,511,090,796	1,869,311,718	727,015,917

Бусад бүх хувьсагчийн тогтмол гэж үзээд 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр хүүгийн түвшин 100 суурь оноогоор бага байвал (2021: 100 суурь оноогоор бага) тухайн жилийн ашиг 15,890,847 мянган төгрөгөөр (2021: 23,039,837 төгрөгөөр их) бага байна, шалтгаан нь хувьсах хүүгийн өр төлбөрийн хүүгийн зардал өндөр байгаатай холбоотой. Өөрийн хөрөнгө нь 2,907,025 мянган төгрөгөөр (2021: 5,490,483 мянган төгрөгөөр) их байна, шалтгаан нь бодит үнэ цэнэ нь БДО-р хэмжигдэх санхүүгийн хөрөнгийн тогтмол ханшийн бодит үнэ цэнийн өсөлттэй холбоотой байна.





ХААН БАНК ХХК

Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2022 оны 12 дугаар сарын 31

36. Санхүүгийн эрсдэлийн удирдлага (Үргэлжлэл)

36.5. Хүүний түвшний эрсдэл (Үргэлжлэл)

Бусад бүх хувьсагчийн тогтмол гэж үзээд 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр хүүгийн түвшин 100 суурь оноогоор их байвал (2021: 100 суурь оноогоор их) тухайн жилийн ашиг 15,890,847 мянган төгрөгөөр (2021: 23,039,837 төгрөгөөр бага) их байна, шалтгаан нь хувьсах хүүгийн өр төлбөрийн хүүгийн зардал өндөр байгаатай холбоотой. Өөрийн хөрөнгө нь 787,938 мянган төгрөгөөр (2021: 3,694,922 мянган төгрөгөөр) бага байна, шалтгаан нь бодит үнэ цэнэ нь бусад дэлгэрэнгүй орлогод хэмжигдэх (БДОБҮЦ) санхүүгийн хөрөнгийн тогтмол ханшийн бодит үнэ цэнийн өсөлттэй холбоотой байна.

Банк нь өөрийн санхүүгийн хэрэглүүрийн хүүгийн түвшинд тогтмол хяналт тавьдаг. Доорх хүснэгтэнд эрх бүхий албан тушаалтнуудын хянасан тайлангуудад үндэслэн холбогдох тайлант хугацааны хүүгийн түвшнийг хураангуйлан үзүүлэв. Үнэт цаасны хувьд хүүгийн хувь нь тайлант хугацааны зах зээлийн үнэлгээнд үндэслэн гаргасан дуусгавар болох хугацаа хүртэлх өгөөжийн хувийг хэлнэ:


Хувиар	2022					2021				
	Төг	Ам.дол	Евро	Юань	Бусад	Төг	Ам.дол	Евро	Юань	Бусад
Хөрөнгө										
Бэлэн мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	8.49%	1.41%	0%	0%	0%	4.72%	0%	0%	0%	0%
Монголбанкны Заавал байлгах нөөц	5.50%	0%	-	-	-	2.50%	0%	-	-	-
Хорогдуулсан өртгөөр бүртгэх ерийн хэрэглүүр	12.09%	6.42%	-	-	-	10.46%	6.53%	-	-	-
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	13.34%	6.20%	7.35%	-	-	12.41%	6.34%	6.84%	-	-
Өр төлбөр										
Бусад банк, санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж	12.91%	0.69%	0%	0%	0%	0%	0%	0%	0%	9.97%
Репо хэлцэл	8.02%	-	-	-	-	6.56%	-	-	-	-
Харилцагчдын харилцах, хадгаламж										
- харилцах	0%	0%	0%	0%	0%	0%	0%	0%	0%	0%
- хадгаламж	9.72%	2.36%	-	1.46%	-	9.19%	1.83%	-	1.42%	-
Зээлээр авсан санхүүжилт	4.38%	7.12%	4.2%	-	-	4.09%	4.18%	3.01%	-	-
Түрээсийн өглөг	15.65%	-	-	-	-	15.98%	-	-	-	-

Дээрх хүснэгтийн "-" тэмдэг нь Банкинд холбогдох валютаар илэрхийлэгдсэн хөрөнгө эсвэл өр төлбөр байхгүйг илгэнэ.

36.6. Хөрвөх чадварын эрсдэл

Банкны хувьд хөрвөх чадварын эрсдэлийн удирдлага гэдэг нь өр төлбөртэй холбоотой үүргээ биелүүлэхэд шаардагдах хөрвөх чадвартай хөрөнгийн түвшинг хэлдэг ба олон төрлийн санхүүжилтийн эх үүсвэрийг татан төвлөрүүлэх боломж, санхүүжилтийн болзошгүй үүргийн удирдлага болон хөрвөх чадварын харьцааг холбогдох бодлого зохицуулалтын шаардлагын дагуу хянах зэрэг хяналтууд багтдаг байна. Харин Хөрвөх чадварын эрсдэл гэдэг нь санхүүгийн өр төлбөртэй холбоотой үүргээ хэвийн болон стресстэй нөхцөл байдалд биелүүлэхэд хүндрэл гарах үед үүсэх эрсдэлийг хэлнэ. Уг эрсдэлийг удирдахын тулд удирдлага нь ирээдүйн мөнгөн урсгалын үнэлнээ болон шаардлагатай үед нэмэлт санхүүжилт авах зорилгоор өндөр зэрэглэлийн барьцааны үнэлгээг оролцуулна.

Банк нь Монголбанкнаас шаарддаг түвшнээс илүү, хэмжээний хөрвөх чадвартай хөрөнгөтэй байдаг. Үүнээс гадна Банк нь нийт харилцагчаас татан төвлөрүүлсэн төгрөгийн харилцах, хадгаламжийн 8% (2022 оны 1 сарын 28-ны өдөр 6%-8% хүртэл өссөн) валютын 18%-тай (2021 оны 12 сарын 16-ны өдөр 15%-18% хүртэл өссөн) тэнцэх бэлэн мөнгийг Монголбанкнаас дахь дансанд заавал байлгах нөөцөнд байршуулж байх ёстой байдаг.



СЗХ
 2023 оны 06 сарын 15 өдөр
 БҮРТГЭВ
 № 31

МОНГОЛЫН ХЭВЭГНИЙН БИРЖ
 MONGOLIAN EXCHANGE
 0000124
 2023-06-09
 92

ХААН БАНК ХХК
 Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2022 оны 12 дугаар сарын 31

36. Санхүүгийн эрсдэлийн удирдлага (Үргэлжлэл)

36.б. Хөрвөх чадварын эрсдэл (Үргэлжлэл)

Дараах хүснэгтэд 2022 болон 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Банкны санхүүгийн өр төлбөр болон хөрөнгийн дуусгавар хугацааг тэдгээрийн аливаа нэг хөнгөлөлтгүйгээр, гэрээний дагуу эргэн төлөх үүрэг дээр үндэслэн харууллаа. Гэсэн хэдий ч, Банк харилцагчдын дийлэнх нь гэрээт хугацаанаасаа өмнө зарлагын гүйлгээ хийхгүй гэсэн хүлээлттэй байгаа ба хадгаламжийн татан авалтын түүхэн өгөгдөл дээр үндэслэн Банкны хүлээж буй мөнгөн урсгалыг хүснэгтэд тусгаагүй болно.

2022 оны 12 дугаар сарын 31 Мянган төгрөгөөр	Хугацаагүй	3-аас доош сар	3-6 сар	6 сараас 1 жил	1-5 жил	5-аас дээш жил	Нийт дүн
Хөрөнгө							
Мөнгө ба түүнтэй адилгах хөрөнгө	1,794,774,691	2,582,324,566	-	-	-	-	4,377,099,257
Монголбанкны Заавал байлгах нөөц	969,104,827	-	-	-	-	-	969,104,827
Своп ба форвард хэлцлийн нийт дүн:							
- Орох мөнгөн урсгал (авлага)	-	59,068,144	47,465,269	201,141,987	878,274,460	68,041,093	1,253,990,953
- Гарах мөнгөн урсгал (өглөг)	-	(45,150,343)	(40,200,785)	(170,593,113)	(805,649,362)	(63,737,102)	(1,125,330,705)
ХӨ-өөр бүртгэгдэх харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	-	1,371,927,992	1,258,812,911	2,123,716,563	3,215,348,535	709,056,930	8,678,862,931
ААБҮЦ-ээр бүртгэгдэх харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	-	17,951,542	25,144,181	56,198,387	150,943,158	329,661,364	579,898,632
Өрийн хэрэглүүрт оруулсан хөрөнгө оруулалт	-	61,184,691	621,856,577	120,782,772	618,328,015	615,974,229	2,038,126,284
Өмчийн хэрэглүүрт оруулсан хөрөнгө оруулалт	4,267,181	-	-	-	-	-	4,267,181
Бусад санхүүгийн хөрөнгө	-	2,703,046	-	-	-	-	2,703,046
Нийт санхүүгийн хөрөнгө	2,768,146,699	4,050,009,638	1,913,078,153	2,331,246,596	4,057,244,806	1,658,996,514	16,778,722,406
Өр төлбөр							
Бусад банк ба санхүүгийн байгууллага дахь харилцах хадгаламж	15,884,992	175,370,767	-	-	-	-	191,255,759
Рело хэлцэл	-	177,227,938	112,657,532	56,603,934	33,658,140	-	380,147,544
Харилцагчдын харилцах, хадгаламж	3,517,104,591	1,463,783,942	1,226,949,068	2,494,578,249	2,073,367,454	395,277,134	11,171,060,438
Үүсмэл санхүүгийн хэрэглүүр	-	505,456	1,106,782	1,401,821	1,882,838	-	4,896,897
Зээлээр авсан санхүүжилт	-	150,632,791	61,558,227	572,726,505	1,150,292,786	87,476,989	2,022,687,298
Бусад санхүүгийн өр төлбөр	-	135,162,720	-	-	-	-	135,162,720
Түрээсийн өглөг	-	2,593,267	2,462,448	4,534,349	5,927,116	-	15,517,180
Нийт санхүүгийн өр төлбөр	3,532,989,583	2,105,276,881	1,404,734,057	3,129,844,858	3,265,128,334	482,754,123	13,920,727,836
Ашиглагдаагүй зээлийн шугам	640,182,957	-	-	-	-	-	640,182,957
Олгосон банкны баталгаа	109,875,380	-	-	-	-	-	109,875,380
Аккредитив	24,667,537	-	-	-	-	-	24,667,537
Ашиглагдаагүй кредит карт	61,741,646	-	-	-	-	-	61,741,646
Нийт балансын гадуурх зүйлс	836,467,520	-	-	-	-	-	836,467,520
Нийт санхүүгийн өр төлбөр болон балансын гадуурх өр төлбөр	4,369,457,103	2,105,276,881	1,404,734,057	3,129,844,858	3,265,128,334	482,754,123	14,757,195,356
Цэвэр дүн	(1,601,310,404)	1,944,732,757	508,344,096	(798,598,262)	792,116,472	1,176,242,391	2,021,527,050

2023 5 29

ХААН БАНК ХХК
 УИМБОВЗ
 ХААН БАНК ХХК

МОНГОЛЫН ХЭВЭГНИЙН БИРЖ
 MONGOLIAN EXCHANGE
 0000124
 2023-06-09
 92

СЭХ
он 2023 сарын 1 өдөр
БҮРТГЭВ
N

МОНГОЛЫН ХААН БАНК ХХК
MONGOLIAN BANK
0000135
2023-06-09
ТГЭВ-02
93

2023 5 29

ХААН БАНК ХХК


Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2022 оны 12 дугаар сарын 31

36. Санхүүгийн эрсдэлийн удирдлага (Үргэлжлэл)

36.6 Хөрвөх чадварын эрсдэл (Үргэлжлэл)

2021 оны 12 дугаар сарын 31 Мянган төгрөгөөр	Хугацаагүй	3-аас доош сар	3-6 сар	6 сараас 1 жил	1-5 жил	5-аас дээш жил	Нийт дүн
Хөрөнгө							
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	1,155,695,000	3,380,294,431	-	-	-	-	4,535,989,431
Монголбанкны Заавал байлгах нөөц	809,081,732	-	-	-	-	-	809,081,732
Свал болон форвард хэлцлийн нийт дүн:							
- Орох мөнгөн урсгал (авлага)	-	95,770,717	8,587,669	117,611,915	291,001,298	-	512,971,599
- Гарах мөнгөн урсгал (өглөг)	-	(96,323,286)	(8,198,160)	(107,528,906)	(283,834,719)	-	(485,885,071)
Хорогдуулсан өртгөөр бүртгэгдэх харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	-	1,029,214,448	991,746,895	1,612,403,633	3,248,818,033	540,432,799	7,422,615,808
Бодит үнэ цэнээр ашиг, алдагдалд бүртгэгдэх харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	-	27,500,669	31,215,298	78,033,382	308,892,273	365,373,415	811,015,037
Өрийн хэрэглүүрт оруулсан хөрөнгө оруулалт	-	30,192,251	19,372,977	154,337,365	683,253,710	423,117,156	1,310,273,459
Бусад санхүүгийн хөрөнгө	-	24,652,197	-	-	-	-	24,652,197
Нийт санхүүгийн хөрөнгө	1,964,776,732	4,501,301,427	1,042,724,679	1,854,857,389	4,248,130,595	1,328,923,370	14,940,714,192
Өр төлбөр							
Бусад банк санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж	29,305,284	6,581,769	-	-	-	-	35,887,053
Репо хэлцэл	-	254,182,596	6,289,065	124,715,874	266,549,386	-	651,736,921
Харилцагчдын харилцах, хадгаламж	3,319,904,967	1,792,319,315	1,509,989,509	2,372,815,864	1,148,660,707	259,566,301	10,403,256,663
Үүсмэл санхүүгийн хэрэглүүр	-	319,756	-	-	-	-	319,756
Зөвлөөр авсан санхүүжилт	-	128,506,526	19,569,539	428,446,824	671,824,838	38,284,295	1,286,632,022
Бусад санхүүгийн өр төлбөр	-	90,811,930	-	-	-	-	90,811,930
Түрээсийн өглөг	-	1,052,469	1,078,634	2,188,835	6,765,757	-	11,085,695
Нийт санхүүгийн өр төлбөр	3,349,210,251	2,273,774,361	1,536,926,747	2,928,167,397	2,093,800,688	297,850,596	12,479,730,040
Ашиглагдаагүй зээлийн шугам	555,157,014	-	-	-	-	-	555,157,014
Олгосон банкны баталгаа	129,567,459	-	-	-	-	-	129,567,459
Аккредитив	26,247,091	-	-	-	-	-	26,247,091
Ашиглагдаагүй зээлийн карт	75,618,760	-	-	-	-	-	75,618,760
Нийт балансын гадуурх зүйлс	786,590,324	-	-	-	-	-	786,590,324
Нийт санхүүгийн өр төлбөр	4,135,800,575	2,273,774,361	1,536,926,747	2,928,167,397	2,093,800,688	297,850,596	13,266,320,364
Цэвэр дүн	(2,171,023,843)	2,227,527,066	(494,202,068)	(1,073,310,008)	2,154,329,907	1,031,072,774	1,674,393,828

УЛААНБААТАР ХОТ
ХБ-ийн гишүүн
Андеррайтер
Рокей диверсийн
"ДИСЕК"
ХХК
1547-2052482



ХААН БАНК ХХК

Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2022 оны 12 дугаар сарын 31

36. Санхүүгийн эрсдэлийн удирдлага (Үргэлжлэл)

36.6 Төлбөрийн чадварын эрсдэл (Үргэлжлэл)

Банк төлбөрийн чадвараа удирдахын тулд өр төлбөрийн гэрээний хорогдуулаагүй хугацаанд үндэслэж дээрх дуусгавар болох хугацааны шинжилгээг ашигладаггүй. Үүний оронд Банк хүлээгдэж буй дуусгавар болох хугацаа болон хүлээгдэж буй хугацаан дахь төлбөрийн чадварын зөрүүг дараах байдлаар хянадаг:

Мянган төгрөгөөр	Хугацаагүй болон 1 сараас доош	1-6 сар	6-12 сар	12 сараас 5 жил	5 жилээс дээш	Нийт дүн
2022 оны 12 дугаар сарын 31-нээр						
Санхүүгийн хөрөнгө	5,469,547,353	2,769,257,794	1,999,798,601	3,208,950,608	915,753,720	14,363,308,076
Санхүүгийн өр төлбөр	4,577,841,434	2,400,497,181	2,944,336,334	3,018,898,988	475,785,613	13,417,359,550
Хүлээгдэж буй хугацаан дахь төлбөрийн чадварын цэвэр зөрүү	891,705,919	368,760,613	(944,537,733)	190,051,620	439,968,107	945,948,526
2021 оны 12 дугаар сарын 31-нээр						
Санхүүгийн хөрөнгө	5,742,115,380	1,334,811,944	1,565,694,874	3,468,034,567	778,601,160	12,889,257,925
Санхүүгийн өр төлбөр	4,368,150,284	2,724,217,939	2,764,205,779	2,009,519,912	296,148,094	12,162,242,008
Хүлээгдэж буй хугацаан дахь төлбөрийн чадварын цэвэр зөрүү	1,373,965,096	(1,389,405,995)	(1,198,510,905)	1,458,514,655	482,453,066	727,015,917

Хөрөнгө өр төлбөрийн дуусгавар болох хугацаа болон хүүгийн түвшний нийцтэй байдал болон үл нийцэл нь Банкны удирдлагын үндсэн суурь болдог. Бизнесийн гүйлгээнүүд нь тодорхойгүй хугацаа болон олон төрөлтэй байдаг тул Банкны үргэлж нийцтэй байх явдал бага юм. Хөрөнгө өр төлбөрийн нийцээгүй позицтой байх нь ашигт ажиллагааг нэмэгдүүлэх ч эсрэгээрээ алдагдлын эрсдэлийг өсгөдөг. Банк хүү, валютын ханшийн өөрчлөлтөд өртөх эрсдэлийг бууруулах төлбөрийн чадварыг үнэлэхэд хөрөнгө, өр төлбөрийн дуусгавар болох хугацаа болон хүүтэй өр төлбөрийг хүлээн зөвшөөрөгдөх өртгөөр нөхөх чадвар чухал хүчин зүйлс болдог.

Харилцагчийн дансны эрэлт өндөр байгаа байдал, харилцах хадгаламжийн дансуудын тоо болон төрлийн төрөлжүүлэлт болон Банкны өнгөрсөн туршлагаас үзэхэд эдгээр харилцагчийн дансууд нь банкны урт хугацааны тогтвортой эх үүсвэр болж байгаа гэдэгт Банк итгэлтэй байна.

36.7 Жишиг зээлийн хүүгийн шинэчлэлийн нөлөө

Банк хоорондын санал болгож буй жишиг зээлийн хүү ('ЖЗХ')-г шинэчлэх, солих нь зохицуулагч байгууллагуудын нэн тэргүүний зорилт болоод байна. Ихэнх жишиг зээлийн хүүг 2021 оны 12 сарын 31-ний өдөр нийтэд ил болгохыг зогсоосон бол зарим ам.долларын ЛИБОР хүүг 2023 оны 6 сарын 30-ны өдөр гэхэд нийтэд зарлахаа шууд зогсоохоор болж байна.


Тайлант жилийн эцэст бүх урт хугацаат үүсмэл хэрэглүүрийн хүүг Баталгаажсан овернайт санхүүжилтийн хүү (БОСХ)-д үндэслэн тооцоолсон. Нийт 211,744 мянган ам.долларын нэрлэсэн үнэ бүхий урт хугацаат своп хэлцлийг ЛИБОР хүүнээс БОСХ-д шилжүүлсэн бол Монголбанкттай нийт 141,250 мянган ам.долларын урт хугацаат своп хэлцлийг шинээр байгуулсан.

Банк нь олон улсын санхүүгийн байгууллагууд гэх мэт өөрийн харилцагчид болон бусад хамтрагч байгууллагуудтай хамтран ЖЗХ-д суурилсан санхүүгийн хэрэглүүрийг өөр жишиг хүү рүү шилжүүлэхээр ажиллаж байна. Банк мөн ЖЗХ-ээс эрсдэлгүй хүүд жигд шилжихийг хангахын тулд дотоод үйл явцаа сайжруулж байна.

Дараах хүснэгтэнд жилийн эцсийн байдлаар ЖЗХ-ийн шинэчлэлт нөлөөлж эрсдэлгүй хүүд шилжих санхүүгийн хөрөнгө, өр төлбөрүүдийн дүнг харуулж байна. Банк хоорондын захын хүүг зогсоох хүртэл эдгээр дүн нь байх бөгөөд 2023 оны 6 сарын 30-ны өдрөөс өмнө шилжинэ.



2023 5 29



ХААН БАНК ХХК

Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2022 оны 12 дугаар сарын 31

36. Санхүүгийн эрсдэлийн удирдлага (Үргэлжлэл)

36.7 Жишиг зээлийн хүүгийн шинэчлэлийн нөлөө (Үргэлжлэл)

<i>Мянган төгрөгөөр</i>	Ам.долларын ЛИБОР хүү	Нийт дүн
2022 оны 12 дугаар сарын 31 <i>Үүсмэл бус санхүүгийн өр төлбөр</i> Зээлээр авсан санхүүжилт	411,568,000	411,568,000
2021 оны 12 дугаар сарын 31 <i>Үүсмэл бус санхүүгийн өр төлбөр</i> Зээлээр авсан санхүүжилт	535,923,441	535,923,441
<i>Үүсмэл санхүүгийн хэрэглүүр</i> Нийт валют хоорондын своп хэлцэл: нэрлэсэн үнэ	513,839,684	513,839,684

36.8. Үйл ажиллагааны эрсдэл

Банк нь үйл ажиллагааны эрсдэлийг Банкны дотоод үйл ажиллагааны тохиромжгүй, доголдолтой байдал, хувь хүн болон гадны хүчин зүйлсийн улмаас Банкны стратеги болон зорилтод нөлөө үзүүлэх үйл явдал гэж тодорхойлдог. Үйл ажиллагааны эрсдэлд дараах дэд ангиллууд багтдаг:

- Дотоод залилан
- Гадны залилан
- Эрүүл мэнд, амь насны аюул, хөдөлмөр эрхлэлтийн зөрчил
- Бүтээгдэхүүн, үйлчилгээний алдаа, дутагдал
- Биет эд хөрөнгийн эвдрэл гэмтэл
- Бизнесийн тасалдал
- Гүйцэтгэлийн алдаа ба дутагдал

Үйл ажиллагааны эрсдэлд хууль, комплаенсийн эрсдэл, мэдээллийн аюулгүй байдлын эрсдэл болон мэдээлэл технологийн эрсдэл хамаарахгүй бөгөөд эдгээр эрсдэлийг тусдаа эрсдэл болгон удирддаг.

Хамгаалалтын нэгдүгээр шугамын бүх газар, салбар нэгжүүд үйл ажиллагааны эрсдэлийг өдөр тутам удирдах үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Хамгаалалтын хоёрдугаар шугамд Үйл ажиллагааны эрсдэлийн газар нь үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын тогтолцоо болон холбогдох аргачлалыг боловсруулах үүргийг хүлээнэ. Мөн үйл ажиллагааны эрсдэлийн газар нь хамгаалалтын 1-р шугам дахь нэгжүүдэд эрсдэлээ тодорхойлох, эрсдэлийг үнэлэх, бууруулахад дэмжлэг үзүүлэн ажилладаг.

Мөн түүнчлэн, Үйл ажиллагааны эрсдэлийн газар нь улирал бүр санхүүгийн бус эрсдэлийн нэгдсэн тайланг бэлтгэж, Банкны Эрсдэлийн удирдлагын хороонд танилцуулдаг бөгөөд Эрсдэлийн удирдлагын хороо түүнийг хянан үзээд холбогдох шийдвэрүүдийг гаргадаг.

Эрсдэлийн удирдлагын хорооны харьяанд дараах дэд хороод Банкны үйл ажиллаганы хяналтын эрсдэлийг илүү их хянаж удирдан ажиллахын тулд Банкны бүх түвшинд ажиллаж байна:


- Үйл ажиллагааны эрсдэлийн дэд хороо
- Карт болон цахим банкны эрсдэлийн дэд хороо
- Салбарын эрсдэлийн хороо

Хамгаалалтын гуравдугаар шугамд хамаарах дотоод аудит нь хамгаалалтын 1 болон хамгаалалтын 2-р шугамын үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт тавьдаг.

Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагад GRC систем дэмжлэг үзүүлдэг бөгөөд энэ нь эрсдэлийн мэдээллийн ил тод байдлыг хангаж тухай бүр тайлагнах боломжийг олгодог. Үйл ажиллагааны эрсдэлийн аргачлалд Нэгжийн эрсдэлийн самбар (unit risk dashboard), Эрсдэл ба хяналтын бие даасан үнэлгээ (RCSA), Алдагдлын мэдээллийн сан (Loss database), Түлхүүр эрсдэлийн үзүүлэлтүүд (KRI) болон Асуудлын удирдлага (Issue management) зэрэг орно.



2023 5 29



ХААН БАНК ХХК

Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2022 оны 12 дугаар сарын 31

36. Санхүүгийн эрсдэлийн удирдлага (Үргэлжлэл)

36.8. Үйл ажиллагааны эрсдэл (Үргэлжлэл)

Иргэдийн банкны харьяа салбар нэгжүүд нь Нэгжийн эрсдэлийн самбар хөтлөх аргачлалын дагуу үйл ажиллагааны эрсдэлээ тодорхойлж бүртгэн, эрсдэлийг бууруулах зохих арга хэмжээг төлөвлөн, хэрэгжилтийг хангах байдлаар өдөр тутмын үйл ажиллагааны эрсдэлээ удирдан ажиллаж байна.

Банк бизнесийн үндсэн процесс болон дэд процессуудад төлөвлөгөө гаргаж, Үйл ажиллагааны эрсдэлийн газрын зөвлөмжийн дагуу газар нэгжийн ажилтанууд нь холбогдох оролцогч талуудтай хамтарч өөрсдийн хариуцсан процесст хамаарах эрсдэлийг тодорхойлж, үнэлэх, бууруулах зорилгоор RCSA-г хэрэгжүүлсэн. RCSA-ийн аргачлалыг тодорхойлсноор бүх тодорхойлогдсон эрсдэл, хяналт, зорилтыг GRC системд өөр хоорондын уялдаа холбоотой байдлаар нь бүртгэсэн болно. Асуудал болон алдагдлын үйл явдлыг тухай бүр холбогдох эрсдэл, хяналт, үйл явц, бүтээгдэхүүний хүрээнд бүртгэн дүн шинжилгээ хийхэд ашиглаж байгаа болно.

36.9. Хууль, комплаенсийн эрсдэл


Комплаенсийн эрсдэлийг банкны хэмжээнд үр дүнтэй удирдах тогтолцоог бий болгох, ялангуяа Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилтийг банкны хэмжээнд хангуулан ажиллахад банкны Төлөөлөн удирдах зөвлөл болон Гүйцэтгэх удирдлагын зүгээс ихээхэн анхаарч Банкны Мөнгө угаах, санхүүгийн гэмт хэргийн эсрэг баримтлах бодлого, Комплаенсийн дотоод хяналтын хөтөлбөр болон холбогдох бусад бодлого журмыг батлан гаргаж, банкны хэмжээнд мөрдлөг болгон ажиллаж байна. Хууль эрх зүйн эрсдэл нь Банк зохицуулагч байгууллагаас баталсан дүрэм, журам, стандартыг мөрдөөгүйгээс үүсэх эрсдэл; шинэ хууль санаачилж байгаа болон хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах үед хүчин төгөлдөр гэрээндээ холбогдох нэмэлт, өөрчлөлт оруулахгүй байх; эсвэл нэхэмжлэлийн шаардлагаас хуулийн хэрэг үүсэх эрсдэл байна.

Комплаенсийн газрын зүгээс дээр дурдсан бодлого журмын хэрэгжилтэд хяналт тавин, сар тутам тайланг бэлтгэж ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагад мэдээлэл хүргүүлэхийн зэрэгцээ банкны нийт ажилтан, эрх бүхий албан тушаалтнуудыг тогтмол сургалт мэдээллээр ханган ажиллаж байна.

Банкны хэмжээнд МУТСТ үр дүнтэй тогтолцоог бий болгох нь олон улсын санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллагууд, хөрөнгө оруулагчид болон корреспондент банкуудын зүгээс тавьж буй шаардлага, тэдгээрийн өсөн нэмэгдэж нэмэгдэж буй хүлээлтэд нийцүүлэн банкны тогтвортой байдал, харилцагчиддаа тасралтгүй найдвартай үйлчилгээ үзүүлэх чадварыг бий болгох зайлшгүй чухал хэсэг болоод байгаа юм.

Ийнхүү Комплаенсийн Дотоод хяналтын хөтөлбөрийн хүрээнд 2022 онд хийж гүйцэтгэсэн ажлуудаас дурдвал:

- ХААН Банкны Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээг харилцагчид, бүтээгдэхүүн үйлчилгээ болон газарзүйн байршлын чиглэлээр хийж, тодорхойлсон зөвлөмжийн дагуу системтэй үйл ажиллагаа явуулсан. Цаашлаад ХААН Банкны Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээний аргачлалыг олон улсын стандарт, орон нутгийн дүрэм журмын дагуу шинэчлэн боловсруулж, нэвтрүүлсэн.
- Комплаенсийн газрын зүгээс мөнгө угаах, санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх, харилцагчийг таньж мэдэх, гүйлгээний хяналт, хориг арга хэмжээг дагаж мөрдөх үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэх зорилготой 2023-2025 он хүртэлх Комплаенсийн хөтөлбөрийг дахин боловсруулсан.
- Нэгдсэн Үндэсний Байгууллагын Аюулгүйн Зөвлөлийн хориг арга хэмжээ болон дотоодын дүрэм журам зэрэг олон улсын гэрээнд заасан хориг арга хэмжээний үүргийг илүү сайн хэрэгжүүлэхийн тулд Банкны хориг арга хэмжээг шалгах хэрэгслийг сайжруулсан. Энэхүү сайжруулалтаар "Смарт скрининг"-ийг идэвхжүүлсэн бөгөөд энэ нь хуурамч эерэг/сөрөг болон "шаардлагатай ижил төстэй байдал"-ыг багасгаж, үүссэн сэрэмжлүүлгийг нэн тэргүүнд зохицуулах боломжийг олгодог ба 2022 онд 24.6%-аас 13.7% болж мэдэгдэхүйцээр буурсан.
- Банкны хэмжээнд Ёс зүйтэй банкир аяныг хоёр дахь жилдээ амжилттай зохион байгуулсан. Энэхүү ажил нь Удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага болон нийт ажилчдад цаг тухайд нь сургалт, мэдээлэл хүргэх замаар мөнгө угаалт болон санхүүгийн гэмт хэрэгт холбогдох эрсдэлээс зайлсхийхийн тулд дагаж мөрдөх ёс зүй, ёс зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилготой юм. Нэмж дурдахад, комплаенсийн мэргэжилтнүүд мэргэжил дээшлүүлэх зорилтын хүрээнд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн сургалтуудад хамрагдаж байна. 2022 оны байдлаар



675202



ХААН БАНК ХХК

Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2022 оны 12 дугаар сарын 31

36. Санхүүгийн эрсдлийн удирдлага (Үргэлжлэл)

36.9. Хууль комплаенсийн эрсдэл (Үргэлжлэл)

Комплаенсийн газраас давхардсан тоогоор 10,462 гаруй ажилтан, албан хаагчид ялангуяа мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр нийт 23 танхимын болон онлайн сургалтанд хамрагдсан байна.

- Гүйлгээний хяналтын систем, TCS Bancs Комплаенс-д тохируулсан хувилбар нь зохицуулалтын хүлээлт, олон улсын шилдэг туршлага, төрлүүдийн дагуу дахин тохируулагдсан. Өөрчлөлтүүдийн нэг нь төлөв байдлын хувилбарыг нэвтрүүлэх явдал бөгөөд үүнээс өмнө зөвхөн гүйлгээнд суурилсан хувилбарууд байдаг байсан.
- Сэжигтэй гүйлгээг салбараас Комплаенсийн ажилтанд шилжүүлдэг excel суурьтай емейлээр илгээдэг тайлангийн хуучин системийг сольж, сайжруулсан. Энэхүү сайжруулалт нь сэжигтэй гүйлгээний тайланг системтэйгээр бүртгэхийн зэрэгцээ салбарын ажилтнуудын зарцуулах цагийг багасгасан. Иймд салбарын ажилтнуудын гар ажиллагаа болон нэг хүн цагийн бууруулж, сэжигтэй гүйлгээг бүртгэх илүү хялбар болсон.

36.10. Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэл

Банк нь бизнесийн үйл ажиллагаа болон мэдээллийн технологид нөлөө үзүүлж буй мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийг бага түвшинд байлган удирдаж ажилладаг. Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийг системтэйгээр тодорхойлох, дүн шинжилгээ хийх, үнэлэх, арга хэмжээ авах болон эрсдэлийг тайлагнах зорилгоор Банк нь ISO31000 (Эрсдэлийн удирдлагын зарчмууд ба зааварчилгаа) болон ISO27005 (Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн удирдлага) зэрэг стандартуудын дагуу олон улсад шалгарсан онол, арга барилыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлдэг.

Банк нь мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог ISO27001:2013 стандартын дагуу үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажилладаг бөгөөд тус стандарт нь хөрөнгийн мэдээллийн аюулгүй байдлыг хангаж ажиллахад чиглэгдсэн, эрсдэлд суурилсан олон улсын мэдээллийн аюулгүй байдлын стандарт юм.

Хөрөнгийн мэдээллийн сул талыг ашиглан түүний нууцлал, бүрэн бүтэн, хүртээмжтэй байдал алдагдсанаар хохирол хүлээх, мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийг үр дүнтэй удирдахын тулд Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн дэд хороог тогтмол хянан хэлэлцдэг.

2022 онд Мэдээллийн аюулгүй байдлын газар нь Төв банкны 74 газар, нэгж болон Улаанбаатар, Орон нутгийн салбар, тооцооны төвүүдэд үйл ажиллагааны хүрээнд гарч болзошгүй мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийг тодорхойлох, үнэлэх ажлыг хийж гүйцэтгэсэн. Тодорхойлогдсон эрсдэлүүдийг Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн дэд хорооны самбарт бүртгэн эрсдэлд авах арга хэмжээний төрлийг сонгон хэрэгжүүлж, үр дүнтэй удирдан ажиллаж байна.

Банк нь гэрээний хүрээнд хамтран ажиллаж буй гуравдагч талуудад Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн асуулгыг шалгах хуудсаар дамжуулан зайнаас хийж гүйцэтгэсэн. Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээний хүрээнд гуравдагч талын гэрээний хяналтыг 969 гуравдагч талд, нарийвчилсан үнэлгээг үйл ажиллагааны чиглэлд тулгуурлан нэгтгэсэн байдлаар хийж гүйцэтгэсэн. Үнэлгээний үр дүнг Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн дэд хорооны гуравдагч талын эрсдэлийн самбарт бүртгэн эрсдэлд авах арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна.

2022 онд Мэдээллийн аюулгүй байдлын газар нь ISO27001:2013 & PCI DSS v3.2.1 болон мэдээллийн аюулгүй байдлын бодлого, журмын дагуу байнгын дотоод аудитыг амжилттай хийж дуусгасан. Шалгалтад Төв банкны 36 газар, Улаанбаатар болон Орон нутгийн иргэдийн банкны 214 салбар тооцооны төвүүд хамрагдсан байна.

Мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны ISO27001:2013 стандартын 2022 оны олон улсын аудитын хүрээнд Төв банкны газар нэгж, Дата төв, Улаанбаатар болон Орон нутгийн иргэдийн банкны салбар, тооцооны төвүүдэд Магадлан аудитыг хийж гүйцэтгэсэн ба аудитын үеэр аливаа том хэмжээний үл нийцэл ажиглагдаагүй.

Төлбөрийн картын мэдээллийн аюулгүй байдлын PCI DSS v3.2.1 стандартын хүрээнд олон улсын аудит хийгдсэн ба стандартын хяналтуудыг хэрэгжүүлсэн Сертификатыг дахин амжилттай баталгаажуулсан.



2023 5 29



ХААН БАНК ХХК

Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2022 оны 12 дугаар сарын 31

36. Санхүүгийн эрсдэлийн удирдлага (Үргэлжлэл)

Ерөнхий мэдээлэл хамгаалах журмын (GDPR) дагуу Банкны харилцагчийн хувийн мэдээлэлтэй ажилладаг 52 газар, хэлтсийн ажилтнуудын уулзалт болж, хамрах хүрээг тодорхойлсон. Бизнесийн системийн хэрэглэгчийн үнэлгээг нийт 30 систем дээр хийсэн. Мэдээллийн аюулгүй байдлын газрын удирддаг бүх системд улирал тутам хэрэглэгчийн үнэлгээг хийдэг.

Мэдээлэл технологийн эрсдэлийн удирдлага

Банк нь мэдээллийн технологийн эрсдэлийг үр дүнтэй удирдах Мэдээлэл технологийн эрсдэлийн дэд хороотой бөгөөд энэ хороо нь Банкны системүүд болон мэдээлэл технологийн үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлүүдийг тодорхойлон арга хэмжээ авч ажилладаг. Олон улсын жишиг болсон байгууллагын Мэдээллийн технологийн шалгуурын дагуу 2022 онд мэдээллийн технологийн үйл ажиллагааны эрсдэлийн үнэлгээг асуулга хэлбэрээр явуулсан.

Банкны бизнес стратеги зорилго, зорилтуудтай уялдуулах зорилгоор Банк программ хангамж хөгжүүлэлтийн процесс болон хэрэгслийн эрсдэлийн үнэлгээг хийж гүйцэтгэсэн.

Түүнчлэн мэдээллийн технологийн үйлчилгээний хүртээмж, бизнесийн үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах үүднээс үйл ажиллагаанд гарсан асуудал, зөрчлийн талаар тогтмол дүн шинжилгээ хийж, шаардлагатай бол цаг тухайд нь арга хэмжээ авч байна. Эрсдэлийн шинжилгээ, үнэлгээгээр илэрсэн эрсдэлүүдийг холбогдох арга хэмжээнүүдийн хамт мэдээллийн технологийн эрсдэлийн самбарт тусган удирдаж байна. Тайлант жилд мэдээлэл технологийн үйл ажиллагаатай холбоотой өндөр түвшний эрсдэлүүдэд гол анхаарлаа хандуулж, эрсдэлийг бууруулах хяналтын үр дүнтэй, өгөөжтэй байхад анхаарч ажилласан. Түүнчлэн Мэдээллийн технологийн эрсдэлийн баг 2022 онд олон улсын мэдээллийн технологийн эрсдэлийн удирдлагын мэргэжлийн сургалтад хамрагдаж, CRISC гэрчилгээ авсан.

37. Бодит үнэ цэнийн тодруулга

Бодит үнэ цэнийн хэмжилтийг бодит үнэ цэнийн шатлал тус бүрт үнэлэх ба эдгээр түвшин нь: (1) ижил төрлийн хөрөнгө болон өр төлбөрийн идэвхтэй зах зээл дэх зарласан (тохируулаагүй) үнийг ашиглан 1-р түвшинд тодорхойлно, (2) хөрөнгө болон өр төлбөрийн хувьд боломжит өгөгдлийг ашиглан шууд (үнэ) болон шууд бусаар (үнээс гаралтай) бодит үнэ цэнийн үнэлгээг тодорхойлох аргачлалыг 2-р түвшинд хэрэгжүүлнэ, (3) 3-р түвшинд зах зээлийн ашиглаж болох өгөгдөлд тулгуурлахгүйгээр (ашиглагдахгүй өгөгдөл) бодит үнэ цэнийн үнэлгээг тодорхойлно. Удирдлага санхүүгийн хэрэглүүрийг ангилахдаа бодит үнэ цэнийн түвшинг ангилдаг. Хэрэв бодит үнэ цэнийг тодорхойлоход шууд ашиглаж болох өгөгдөлд ихээхэн тодруулга хийгдсэний дараа ашиглаж байгаа бол тухайн хэмжилт нь 3-р түвшинд хийгдэж байна гэсэн үг. Үнэлгээний өгөгдлийн ач холбогдлыг бодит үнэ цэнийн тодорхойлолттой бүхэлд нь уялдуулан авч үзэн үнэлдэг.

2023 5 29





ХААН БАНК ХХК
Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2022 оны 12 сарын 31

37. Бодит үнэ цэнэ тодруулга (Үргэлжлэл)
(а) Бодит үнэ цэнийн давтагдах хэмжилт

Бодит үнэ цэнийн давтагдах хэмжилт нь нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу тайлангийн үе бүрийн эцэст санхүүгийн байдлын тайланд заасан эсвэл зөвшөөрөгдсөн хэмжилт юм. Бодит үнэ цэнийн давтагдах хэмжилтийг ангилсан бодит үнэ цэнийн шатлалын түвшин дараах байдалтай байна.

Үүнд:

Мянган төгрөгөөр	2022 оны 12 дугаар сарын 31			2021 оны 12 дугаар сарын 31				
	Түвшин 1	Түвшин 2	Түвшин 3	Нийт дүн	Түвшин 1	Түвшин 2	Түвшин 3	Нийт дүн
БОДИТ ҮНЭ ЦЭНЭЭР БҮРТГЭГДСЭН ХӨРӨНГӨ								
САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨ								
Эрийн үнэт цаасны хөрөнгө оруулалт								
- Бодит үнэ цэнээр үнэлэгдсэн үнэт цаас	186,302,687	-	-	186,302,687	206,007,659	-	-	206,007,659
- Давуу эрхтэй ИЗББ, бодит үнэ цэнээр	-	-	74,849,224	74,849,224	-	-	36,536,559	36,536,559
- Энгийн эрхтэй ИЗББ, ҮЦСК бодит үнэ цэнээр	-	-	174,218,961	174,218,961	-	-	113,368,465	113,368,465
Хувьцааны хөрөнгө оруулалт								
- Байгууллагын хувьцаа	4,267,181	-	-	4,267,181	3,157,209	-	-	3,157,209
Бодит үнэ цэнээр ашиг, алдагдалд бүртгэгдэх харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа								
Үүсмэл санхүүгийн хэрэглүүр	-	378,606,395	-	378,606,395	-	560,315,869	-	560,315,869
Бусад санхүүгийн хөрөнгө	-	128,660,248	-	128,660,248	-	27,086,528	-	27,086,528
					21,768,134	-	-	21,768,134
САНХҮҮГИЙН БУС ХӨРӨНГӨ								
Үндсэн хөрөнгө	-	-	289,810,778	289,810,778	-	-	283,199,116	283,199,116
БОДИТ ҮНЭ ЦЭНЭЭР БҮРТГЭГДСЭН ДАВТАГДАХ ХЭМЖИЛТЭЙ НИИТ ХӨРӨНГӨ	190,569,868	507,266,643	538,878,963	1,236,715,474	230,933,002	587,402,397	433,104,140	1,251,439,539

БОДИТ ҮНЭ ЦЭНЭЭР БҮРТГЭГДСЭН ДАВТАГДАХ ХЭМЖИЛТЭЙ НИИТ ХӨРӨНГӨ

БОДИТ ҮНЭ ЦЭНЭЭР БҮРТГЭГДСЭН ТӨЛБӨР
САНХҮҮГИЙН ӨР ТӨЛБӨР
Үүсмэл санхүүгийн хэрэглүүр

БОДИТ ҮНЭ ЦЭНЭЭР БҮРТГЭГДСЭН ДАВТАГДАХ ХЭМЖИЛТЭЙ НИИТ ӨР ТӨЛБӨР



1115205447



2023 5 29

99



ХААН БАНК ХХК

Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2022 оны 12 сарын 31

37. Бодит үнэ цэнэ тодруулга (үргэлжлэл)

2022 болон 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх 2 дугаар түвшний санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийг тооцсон аргачлал болон түүнд ашигласан мэдээлэл:

Мянган төгрөгөөр	2022	2021	Үнэлгээний аргачлал	Ашигласан мэдээлэл
БОДИТ ҮНЭ ЦЭНЭЭР БҮРТГЭГДСЭН ХӨРӨНГӨ				
САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨ				
Бодит үнэ цэнээр ашиг, алдагдалд бүртгэгдэх харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	378,606,395	560,315,869	Зах зээлийн харьцуулалтын арга	Зах зээлийн үнэ/өөрийн үнэ
Үүсмэл санхүүгийн хэрэглүүр	128,660,248	27,086,528	Хүүгийн түвшний парето шинжилгээ/ Засварлагдсан хорогдуулалтын муруй	Репо хүү, бодлогын хүү, 28 долоо хоногийн Монголбанкны үнэт цаасны хүү, Z-тархалт, ЛИБОР хүү, SOFR хүү, фьючерс болон своп хэлцлийн хүү, засварласан форвард хүү
БОДИТ ҮНЭ ЦЭНЭЭР БҮРТГЭГДСЭН ӨР ТӨЛБӨР				
САНХҮҮГИЙН ӨР ТӨЛБӨР				
Үүсмэл санхүүгийн хэрэглүүр	4,896,897	319,756	Хүүгийн түвшний парето шинжилгээ/ Засварлагдсан хорогдуулалтын муруй	Блүмбэрг үнэ Монголбанкны валютын ханш
2-р түвшин дэх давтагдах бодит үнэ цэнийн нийт дүн	502,369,746	587,082,641		

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болон тайлант жилд 2-р түвшин дэх давтагдах бодит үнэ цэнийг тооцох аргачлалд өөрчлөлт ороогүй. (2021: байхгүй)

3-р түвшин дэх бодит үнэ цэнийг хэмжихэд ашигласан мэдээлэл, үнэлгээний аргачлал болон боломжит өөрчлөлийг мэдрэх мэдрэмжийг 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар дараах байдлаар харуулав:

Мянган төгрөгөөр	Бодит үнэ цэнэ	Үнэлгээний аргачлал	Ашигласан мэдээлэл	Ашигласан өгөгдлийн хүрээ (жинлэсэн дундаж)	Боломжит өөрчлөлт	Бодит үнэ цэнийн хэмжилтийн мэдрэмтгий байдал
БОДИТ ҮНЭ ЦЭНЭЭР БҮРТГЭГДСЭН ХӨРӨНГӨ						
САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨ						
Өрийн хэрэглүүрт оруулсан хөрөнгө оруулалт						
- Давуу эрхтэй ИЗББ, бодит үнэ цэнээр	74,849,224	Зах зээлийн харьцуулалтын арга	Зах зээлийн үнэ	100	1%	+/-748,492
- Энгийн эрхтэй ИЗББ, бодит үнэ цэнээр	174,218,961	Зах зээлийн харьцуулалтын арга	Зах зээлийн үнэ	100	1%	+/-1,742,190
САНХҮҮГИЙН БУС ХӨРӨНГӨ						
Барилга болон тоног төхөөрөмж	289,810,778	Элэгдүүлсэн орлуулах өртгийн арга болон зах зээлийн харьцуулалтын арга	Тохиромжтой тохируулга-тай метр квадратын зах зээлийн үнэ	2,895-7,940		+/-28,981,077
3-р түвшин дэх давтагдах бодит үнэ цэнийн нийт дүн	538,878,963					



2023 5 29



ХААН БАНК ХХК

Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2022 оны 12 сарын 31



37. Бодит үнэ цэнэ тодруулга (үргэлжлэл)

3-р түвшин дэх бодит үнэ цэнийг хэмжихэд ашигласан мэдээлэл, үнэлгээний аргачлал болон боломжит өөрчлөлийг мэдрэх мэдрэмжийг 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар дараах байдлаар харуулав:

	Бодит үнэ цэнэ	Үнэлгээний аргачлал	Ашигласан мэдээлэл	Ашигласан өгөгдлийн хүрээ (жинлэсэн дундаж)	Боломжит өөрчлөлт	Бодит үнэ цэнийн хэмжилтийн мэдрэмтгий байдал
<i>Мянган төгрөгөөр</i>						
Бодит үнэ цэнээр бүртгэгдсэн хөрөнгө						
Санхүүгийн хөрөнгө						
Өрийн хэрэглүүрт оруулсан хөрөнгө оруулалт						
- Давуу эрхтэй ИЗББ, бодит үнэ цэнээр	36,536,559	Зах зээлийн харьцуулалтын арга	Бондын үнэ Тохиромжтой тохируулгатай	100	1%	+/-365,366
- Энгийн эрхтэй ИЗББ, бодит үнэ цэнээр	113,368,465	Зах зээлийн харьцуулалтын арга	Бондын үнэ Тохиромжтой тохируулгатай	100	1%	+/-1,133,685
Санхүүгийн бус хөрөнгө						
Барилга болон тоног төхөөрөмж	283,199,116	Элэгдүүлсэн орлуулах өртгийн арга, зах зээлийн харьцуулалтын арга	Тохиромжтой тохируулгатай метр квадратын зах зээлийн үнэ	2,118 – 11,732	10%	+/-28,319,912
3-р түвшин дэх давтагдах бодит үнэ цэнийн нийт дүн	433,104,140					


Дээрх хүснэгтэнд санхүүгийн хөрөнгө болон санхүүгийн өр төлбөрийн үнэлгээний өгөгдөлд хамаарах мэдрэмтгий байдлыг тусгасан бөгөөд хэрэв боломжит зохистой таамаглалыг тусгахын тулд зах зээлээс олж авах боломжгүй нэг буюу хэд хэдэн орц, өгөгдлийн өөрчлөлт нь бодит үнэ цэнэд томоохон өөрчлөлт ороход хүргэдэг. Иймд, ач холбогдлын үнэлгээг ашиг, алдагдал болон нийт хөрөнгө, өр төлбөрийн хувьд үнэлж хэрэв бодит үнэ цэнийн өөрчлөлт үүсвэл БДО-д болон өөрийн хөрөнгөд бүртгэнэ.

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилд 3-р түвшин дэх давтагдах бодит үнэ цэнийг тооцох аргачлалд өөрчлөлт ороогүй. (2021: байхгүй)

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн бодит үнэ цэнийн шатлалын дагуу 3-р түвшинд хамаарах хэрэглүүрийн өөрчлөлт, хөдөлгөөний тохируулгыг дараах байдлаар харуулав:

	Давуу эрхтэй ИЗББ	Энгийн эрхтэй ИЗББ, ҮЦСК	Барилга болон тоног төхөөрөмж
<i>Мянган төгрөгөөр</i>			
2022 оны 1-р сарын 1-нээрх бодит үнэ цэнэ			283,199,116
Ашиг алдагдалд бүртгэсэн элэгдлийн дүн	36,536,559	113,368,465	-
Худалдан авалт	156,306,800	51,379,800	6,902,804
Төлөлт	(121,988,100)	-	(282,822)
Хүүгийн авлага	4,259,661	13,080,278	-
Хүүгийн өглөг	(265,696)	(3,609,582)	-
Данснаас хассан	-	-	(8,320)
2022 оны 12 дугаар сарын 31-нээрх бодит үнэ цэнэ	74,849,224	174,218,961	289,810,778





ХААН БАНК ХХК

Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2022 оны 12 сарын 31



37. Бодит үнэ цэнэ тодруулга (үргэлжлэл)

Бодит үнэ цэнийн шатлалын дагуу 3-р түвшинд хамаарах хэрэглүүрийн өөрчлөлт, хөдөлгөөний тохируулгыг 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн байдлаар харуулав:

	Давуу эрхтэй ИЗББ	Энгийн эрхтэй ИЗББ	Байшин ба тоног төхөөрөмж	Хөрөнгийн биржид бүртгэлгүй хөрөнгө оруулалт	Хөрөнгийн биржид бүртгэлгүй бонд
<i>Мянган төгрөгөөр</i>					
2021 оны 1 сарын 1-нээрх бодит үнэ цэнэ	8,290,518	102,422,285	273,610,643	2,327,261	42,117,133
Ашиг алдагдалд бүртгэгдэх валютын ханшийн өөрчлөлт	-	-	-	(25)	-
Элэгдлийн зардал	-	-	(5,530,909)	-	-
Нэмэгдсэн	67,768,300	7,397,100	15,616,891	-	-
Борлуулсан	(41,054,900)	-	(491,893)	-	-
Хорогдуулаагүй хямдруулалт	-	-	-	-	10,664,867
Эргэн төлөлт	-	-	-	-	(52,782,000)
Хүүгийн авлага	1,532,641	10,948,750	-	-	-
Хүүгийн өглөг	-	(7,399,670)	-	-	-
Данснаас хассан	-	-	(5,616)	-	-
Бодит үнэ цэнийн өөрчлөлт	-	-	-	(2,327,236)	-
2021 оны 12 сарын 31-нээрх бодит үнэ цэнэ	36,536,559	113,368,465	283,199,116	-	-

(б) Давтагдахгүй бодит үнэ цэнийн хэмжилт

Банк борлуулах зорилгоор эзэмшиж байгаа эргэлтийн бус хөрөнгийг бодит үнэ цэнээс нь борлуулах зардлыг хассан дүнгээр бууруулан бүртгэсэн. Бодит үнэ цэнэ нь бодит үнэ цэнийн шатлалын дагуу 3-р түвшинд хамаарна. 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар бодит үнэ цэнийн үнэлгээнд ашиглагдсан үнэлгээний аргачлал болон мэдээлэл:

	Бодит үнэ цэнэ	Үнэлгээний аргачлал	Ашигласан мэдээлэл	Мэдээллийн хүрээ (Жинлэсэн дундаж)	
				2022 оны 12 дугаар сарын 31	2021 оны 12 дугаар сарын 31
<i>Мянган төгрөгөөр</i>					
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (эсвэл бүлэг борлуулалт)	3,480,567	Элэгдүүлсэн орлуулах өртгийн арга болон зах зээлийн харьцуулалтын арга	Тохиромжтой тохируулгатай метр квадратын зах зээлийн үнэ	2,895-7,940	-

(в) 3-р түвшний давтагдах болон давтагдахгүй бодит үнэ цэнийн хэмжилтийн үнэлгээний процесс

Бодит үнэ цэнийн 3-р түвшний үнэлгээг барилга байгууламжийн хувьд Хөрөнгийн удирдлагын газар, хөрөнгө оруулалтын үнэт цаасны хувьд Зах зээлийн эрсдэлийн газартай хамтран Банкны Санхүүгийн удирдлагын газар жил бүр хяналт тавьдаг. Банкны удирдлага үнэлгээний загварын орцуудын зохистой байдал, түүнчлэн санхүүгийн үйлчилгээний салбарт стандарт гэж хүлээн зөвшөөрөгдсөн үнэлгээний арга, техникийг ашиглан үнэлгээний үр дүнг авч үздэг. Үнэлгээний хамгийн тохиромжтой загварыг сонгохдоо хороо дахин шалгалт хийж, аль загварын үр дүн нь зах зээлийн бодит гүйлгээтэй түүхэндээ хамгийн ойр нийцэж байгааг нь авч үздэг.





Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2022 оны 12 сарын 31

37. Бодит үнэ цэнэ тодруулга (үргэлжлэл)


(а) • Бодит үнэ цэнээр хэмжигдээгүй боловч бодит үнэ цэнийг нь тодруулсан хөрөнгө, өр төлбөр

Бодит үнэ цэнээр хэмжигдээгүй хөрөнгийг бодит үнэ цэнийн шатлалын дагуу түвшин болон дансны үнээр нь доорх байдлаар харуулав.

Мянган төгрөгөөр	2022 оны 12 дугаар сарын 31				2021 оны 12 дугаар сарын 31			
	1-р түвшин	2-р түвшин	3-р түвшин	Дансны үнэ	1-р түвшин	2-р түвшин	3-р түвшин	Дансны үнэ
	Бодит үнэ цэнэ	Бодит үнэ цэнэ	Бодит үнэ цэнэ		Бодит үнэ цэнэ	Бодит үнэ цэнэ	Бодит үнэ цэнэ	
САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨ								
Мөнгө ба түүнтэй адилгах хөрөнгө	212,128,736	4,161,283,465	-	4,373,412,201	186,773,015	4,340,206,964	-	4,526,979,979
Монголбанкнд заавал байлгах нөөц	-	969,104,827	-	969,104,827	-	809,081,732	-	809,081,732
Өрийн хэлбэрээрх хөрөнгө оруулалт	910,520,709	16,206,688	71,111,287	997,838,684	538,121,547	16,185,153	-	554,306,700
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	-	-	6,721,694,050	6,721,694,050	-	-	5,953,560,548	6,028,982,930
Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалт	-	-	283,589	283,589	-	-	301,888	301,888
Бусад санхүүгийн хөрөнгө	-	-	2,703,046	2,703,046	-	-	2,884,063	2,884,063
НИЙТ ДҮН	1,122,649,445	5,146,594,980	6,795,791,972	13,065,036,397	724,894,562	5,165,473,849	5,956,746,499	11,921,319,390

2023 5 29 1





ХААН БАНК ХХК
Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2022 оны 12 сарын 31

37. Бодит үнэ цэнэ тодруулга (үргэлжлэл)

Бодит үнэ цэнээр хэмжигдээгүй өр төлбөрийг бодит үнэ цэнийн шатлалын дагуу түвшин болон дансны үнээр нь доорх байдлаар харуулав.

Мянган төгрөгөөр	2022 оны 12 дугаар сарын 31		2021 оны 12 дугаар сарын 31		Бодит үнэ цэнэ	Дансны үнэ	1-р түвшин Бодит үнэ цэнэ	2-р түвшин Бодит үнэ цэнэ	3-р түвшин Бодит үнэ цэнэ	Бодит үнэ цэнэ	Дансны үнэ	
	1-р түвшин Бодит үнэ цэнэ	2-р түвшин Бодит үнэ цэнэ	3-р түвшин Бодит үнэ цэнэ	1-р түвшин Бодит үнэ цэнэ								2-р түвшин Бодит үнэ цэнэ
САНХҮҮГИЙН ӨР ТӨЛБӨР												
Бусад банк, санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж	-	191,080,282	-	191,080,282	191,080,282	191,080,282	-	35,854,280	-	35,854,280	35,854,280	
Рело хэлцэл	-	367,267,329	-	367,267,329	367,267,329	367,267,329	-	620,802,675	-	620,802,675	620,802,675	
Харилцагчдын харилцах, хадгаламж	-	10,884,102,500	-	10,884,102,500	10,930,788,356	10,930,788,356	-	10,245,689,117	-	10,245,689,117	10,211,450,727	
Зээлээр авсан санхүүжилт	-	1,743,845,236	-	1,743,845,236	1,776,932,717	1,776,932,717	-	1,191,998,551	-	1,191,998,551	1,191,916,946	
Бусад санхүүгийн өр төлбөр	-	-	128,955,771	128,955,771	128,955,771	128,955,771	-	84,937,825	-	84,937,825	84,937,825	
Зээлтэй холбоотой амлалтын сан	-	-	6,206,949	6,206,949	6,206,949	6,206,949	-	5,874,105	-	5,874,105	5,874,105	
НИЙТ ДҮН	-	13,186,295,347	135,162,720	13,321,458,067	13,401,231,404	13,401,231,404	-	12,094,344,623	90,811,930	12,185,156,553	12,150,836,558	

Бодит үнэ цэнийн шатлалын 2 болон 3-р түвшний бодит үнэ цэнийг хямдруулсан мөнгөн урсгалын үнэлгээний аргачлалыг ашиглан тооцсон. Идэвхтэй зах зээлд арилжаалагддаггүй хөвөгч хүүтэй хэрэглүүрийн бодит үнэ цэнийг дансны үнэтэй нь тэнцүү байхаар тооцсон. Хөрөнгийн биржид бүртгэлгүй, тогтмол хүүтэй хэрэглүүрийн бодит үнэ цэнийг ижил зээлийн эрсдэл болон ижил үлдэх хугацаатай шинэ хэрэглүүрийн тухайн үеийн хүүгийн хувьд хямдруулж авахаар хүлээгдэж буй ирээдүйн мөнгөн урсгалд үндэслэн тооцоолсон.



2023 5 29



ХААН БАНК ХХК

Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2022 оны 12 сарын 31



38 Холбоотой талын тодруулга

Талууд нийтлэг хяналтанд байгаа, эсвэл нэг тал нь нөгөө талдаа хяналт тавих чадвартай, эсвэл санхүүгийн болон үйл ажиллагааны шийдвэр гаргахад нөгөө талдаа чухал нөлөө үзүүлж чаддаг бол талуудыг ихэвчлэн харилцан холбоотой гэж үздэг. Холбоотой талын боломжит харилцаа бүрийг авч үзэхдээ зөвхөн эрх зүйн хэлбэрт бус харилцааны мөн чанарт анхаарлаа хандуулдаг.

Бизнесийн хэвийн үйл ажиллагааны явцад Банк нь үндсэн хувьцаа эзэмшигчид, захирлууд болон бусад холбоотой талуудтай гүйлгээ хийдэг. Эдгээр гүйлгээнд төлбөр тооцоо, зээл олгох, хадгаламж татах, батлан даалт, бусдаас зээлсэн эх үүсвэр, аккредитив орно. Банкны бодлогын дагуу холбоотой талуудын гүйлгээний нөхцөл нь сунгасан гарын зарчмын дагуу харилцан тохиролцсон гүйлгээнд давамгайлсан нөхцөлтэй тэнцүү байна.

Холбоотой талын ангилал нь дараа байдалтай байна:

Эцсийн буюу шууд толгой компани:	Эйч Эс Холдингс Лимитед Компани нь банкны үндсэн хувьцаа эзэмшигч бөгөөд Тодруулга 1-ийг харна уу.
Бусад томоохон хувьцаа эзэмшигч:	Таван Богд Трейд Лимитед Компани нь банкны томоохон хувьцаа эзэмшигч юм.
Эрх бүхий албан тушаалтан:	Банкны гүйцэтгэх удирдлагууд болон ТУЗ.
Бусад холбоотой талууд:	Толгой болон томоохон хувьцаа эзэмшигчдийн хяналтанд байдаг аж ахуйн нэгж байгууллагууд.

2022 оны 12 дугаар сарын 31-ний болон 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Банкны шууд болон эцсийн толгой компани, эцсийн хяналт тавих толгой компанийн талаарх мэдээллийг Торуулга 1-ээс харна уу.

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар холбоотой талуудын үлдэгдэл дараах байдалтай байна:

	Толгой компани	Бусад томоохон хувьцаа эзэмшигч	Эрх бүхий албан тушаалтан	Бусад холбоотой талууд
<i>Мянган төгрөгөөр</i>				
Хувьцаа эзэмшигчдэд олгосон зээл ба урьдчилгаа (гэрээний хүү: 2.4% – 18%)	-	-	2,371,287	48,447,881
Авлага	-	86,632	-	-
Урт хугацаат своп хэлцэл (бодит үнэ цэнээр)	-	4,264,836	-	-
Хувьцаа эзэмшигчдийн харилцах, хадгаламж (гэрээний хүү: 0.0% – 13.3%)	172,729	37,857	6,775,216	27,950,906
Зээлээр санхүүжсэн эх үүсвэр (гэрээний хүү: 1.20% – 1.67%)	60,173,259	-	-	-
Ажилчдын эзэмшиж буй хувьцаа	-	-	608,838	-

2022 онд холбоотой талуудтай хийгдсэн орлого, зардлын гүйлгээний дүнг доор харуулав:

	Толгой компани	Бусад томоохон хувьцаа эзэмшигч	Эрх бүхий албан тушаалтан	Бусад холбоотой талууд
<i>Мянган төгрөгөөр</i>				
Хүүгийн орлого	-	112,475	168,953	1,718,270
Хүүгийн зардал	1,049,971	-	284,007	361,500
Үйл ажиллагааны зардал	-	624,054	-	42,984,649

Үйл ажиллагааны зардалд түрээс, АТМ, тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээ болон бусад үйлчилгээний зардал багтсан.

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар холбоотой талуудад хамарах бусад эрх, үүрэг дараах байдалтай байна:



1925202

ХААН БАНК ХХК

Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2022 оны 12 сарын 31

38. Холбоотой талуудын тодруулга (Үргэлжлэл)

	Толгой компани	Бусад томоохон хувьцаа эзэмшигч	Эрх бүхий албан тушаалтан	Бусад холбоотой талууд
<i>Мянган төгрөгөөр</i>				
Эргэж төлөгдөхгүй ашиглагдаагүй зээлийн шугам	-	-	289,527	134,212
Батлагдсан хэмжээ	-	8,345	-	-
Олгосон баталгаа батлан даалт	-	-	-	2,731,036
Аккредитив	-	-	-	1,288,310

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар холбоотой талуудын үлдэгдэл дараах байдалтай байна:

	Толгой компани	Бусад томоохон хувьцаа эзэмшигч	Эрх бүхий албан тушаалтан	Бусад холбоотой талууд
<i>Мянган төгрөгөөр</i>				
Хувьцаа эзэмшигчдэд олгосон зээл ба урьдчилгаа (гэрээний хүү: 2.4% – 24%)	-	-	1,713,723	3,616,616
Авлага	-	86,632	-	-
Хувьцаа эзэмшигчдийн харилцах, хадгаламж (гэрээний хүү: 0.0% – 13.3%)	8,329,057	7,763	18,186,903	92,006,565
Зээлээр санхүүжсэн эх үүсвэр (гэрээний хүү: 3.15% – 4.66%)	77,889,459	-	-	-

2021 онд холбоотой талуудтай хийгдсэн орлого, зардлын дүнг доор харуулав:

	Толгой компани	Бусад томоохон хувьцаа эзэмшигч	Эрх бүхий албан тушаалтан	Бусад холбоотой талууд
<i>Мянган төгрөгөөр</i>				
Хүүгийн орлого	-	377,462	116,245	2,138,641
Хүүгийн зардал	3,889,441	-	632,889	2,246,364
Үйл ажиллагааны зардал	-	608,236	-	39,605,842

2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар холбоотой талуудад хамаарах бусад эрх, үүрэг дараах байдалтай байна:

	Толгой компани	Бусад томоохон хувьцаа эзэмшигч	Эрх бүхий албан тушаалтан	Бусад холбоотой талууд
<i>Мянган төгрөгөөр</i>				
Эргэж төлөгдөхгүй ашиглагдаагүй зээлийн шугам	-	100	210,632	6,080
Батлагдсан хэмжээ	-	1,859,843	-	-
Олгосон баталгаа батлан даалт	-	245,421	-	352,461
Аккредитив	-	-	-	3,173,171

Эрх бүхий албан тушаалтнуудын нөхөн олговрыг доор харуулав:

<i>Мянган төгрөгөөр</i>	2022	2021
-------------------------	------	------

Богино хугацаат тэтгэмж:
- Цалин болон бусад олговор
- Богино хугацаат урамшуулал

9,902,471 6,386,103
1,237,809 747,916
11,140,280 7,134,019





Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2022 оны 12 сарын 31

39 Хөрөнгө болон өр төлбөрийн дуусгавар болох хугацааны шинжилгээ

Дараах хүснэгтэд Банкны хөрөнгө, өр төлбөрийг эргэн төлөгдөх, барагдуулах хугацаагаарх шинжилгээг харуулсан. Тодруулга 36-д тусгасан "Төлбөрийн чадварын эрсдэл ба эх үүсвэрийн удирдлага"-д Банкны санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийн эргэн төлөлтийн хорогдуулж тооцоогүй гэрээт үүргийн дүнг харна уу.

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр

Мянган төгрөгөөр	12 сар хүртэлх	12 сараас дээш	Нийт дүн
Санхүүгийн хөрөнгө			
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	4,373,412,201	–	4,373,412,201
Монгол банкны заавал байлгах нөөц	969,104,827	–	969,104,827
Үүсмэл санхүүгийн хэрэглүүр	51,731,160	76,929,088	128,660,248
Хорогдуулсан өртгөөр бүртгэгдэх харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	4,039,870,175	2,992,587,439	7,032,457,614
Бодит үнэ цэнээр ашиг, алдагдалд бүртгэгдэх харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	77,042,788	301,563,607	378,606,395
Өрийн хэрэглүүрт оруулсан хөрөнгө оруулалт	720,472,369	753,624,195	1,474,096,564
Өмчийн хэрэглүүрт оруулсан хөрөнгө оруулалт	4,267,181	–	4,267,181
Бусад санхүүгийн хөрөнгө	2,703,046	–	2,703,046
Нийт дүн	10,238,603,747	4,124,704,329	14,363,308,076
Санхүүгийн бус хөрөнгө			
Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалт	283,589	–	283,589
Бусад хөрөнгө	73,658,397	–	73,658,397
Үндсэн хөрөнгө	–	455,493,746	455,493,746
Биет бус хөрөнгө	–	46,286,024	46,286,024
Ашиглах эрхтэй хөрөнгө	6,450,464	3,752,483	10,202,947
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө	3,480,567	–	3,480,567
Нийт дүн	83,873,017	505,532,253	589,405,270
Нийт дүн	10,322,476,764	4,630,236,582	14,952,713,346
Санхүүгийн өр төлбөр			
Бусад банк, санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж	191,080,282	–	191,080,282
Репө хэлцэл	336,370,023	30,897,306	367,267,329
Харилцагчдын харилцах, хадгаламж	8,516,017,213	2,414,771,143	10,930,788,356
Үүсмэл санхүүгийн хэрэглүүр	3,014,059	1,882,838	4,896,897
Зээлээр авсан санхүүжилт	734,089,415	1,042,843,302	1,776,932,717
Бусад өр төлбөр	135,162,720	–	135,162,720
Түрээсийн өглөг	6,941,236	4,290,013	11,231,249
Нийт дүн	9,922,674,948	3,494,684,602	13,417,359,550
Санхүүгийн бус өр төлбөр			
Бусад өр төлбөр	11,320,489	–	11,320,489
Орлогын албан татварын өр төлбөр	3,957,990	–	3,957,990
Хойшлогдсон татварын өр төлбөр	–	4,709,251	4,709,251
Нийт дүн	15,278,479	4,709,251	19,987,730
Нийт дүн	9,937,953,427	3,499,393,853	13,437,347,280
Цэвэр дүн	384,523,337	1,130,842,729	1,515,366,066



2023-06-09



ХААН БАНК ХХК

№: Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2022 оны 12 сарын 31

39. Хөрөнгө болон өр төлбөрийн хугацааны шинжилгээ (Үргэлжлэл)

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр

<i>Мянган төгрөгөөр</i>	12 сар хүртэлх	12 сараас дээш	Нийт дүн
Санхүүгийн хөрөнгө			
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	4,526,979,979	–	4,526,979,979
Монгол банкны заавал байлгах нөөц	809,081,732	–	809,081,732
Үүсмэл санхүүгийн хэрэглүүр	19,919,948	7,166,580	27,086,528
Хорогдуулсан өртгөөр бүртгэгдэх харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	3,015,158,422	3,013,824,508	6,028,982,930
Бодит үнэ цэнээр ашиг, алдагдалд бүртгэгдэх харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	102,309,742	458,006,127	560,315,869
Өрийн хэрэглүүрт оруулсан хөрөнгө оруулалт	141,362,969	767,638,512	909,001,481
Өмчийн хэрэглүүрт оруулсан хөрөнгө оруулалт	3,157,209	–	3,157,209
Бусад санхүүгийн хөрөнгө	24,652,197	–	24,652,197
Нийт дүн	8,642,622,198	4,246,635,727	12,889,257,925
Санхүүгийн бус хөрөнгө			
Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалт	301,888	–	301,888
Бусад хөрөнгө	53,442,633	–	53,442,633
Үндсэн хөрөнгө	–	455,595,092	455,595,092
Биет бус хөрөнгө	–	54,764,803	54,764,803
Ашиглах эрхтэй хөрөнгө	4,523,515	5,563,138	10,086,653
Нийт дүн	58,268,036	515,923,033	574,191,069
Нийт дүн	8,700,890,234	4,762,558,760	13,463,448,994
Санхүүгийн өр төлбөр			
Бусад банк, санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж	35,854,280	–	35,854,280
Репо хэлцэл	360,476,946	260,325,729	620,802,675
Харилцагчдын харилцах, хадгаламж	8,813,782,247	1,397,668,480	10,211,450,727
Үүсмэл санхүүгийн хэрэглүүр	319,756	–	319,756
Зээлээр авсан санхүүжилт	551,008,907	640,908,039	1,191,916,946
Бусад өр төлбөр	90,811,930	–	90,811,930
Түрээсийн өглөг	4,319,937	6,765,758	11,085,695
Нийт дүн	9,856,574,003	2,305,668,006	12,162,242,009
Санхүүгийн бус өр төлбөр			
Бусад өр төлбөр	9,949,164	–	9,949,164
Орлогын албан татварын өр төлбөр	2,167,852	–	2,167,852
Хойшлогдсон татварын өр төлбөр	–	4,579,593	4,579,593
Нийт дүн	12,117,016	4,579,593	16,696,609
Нийт дүн	9,868,691,019	2,310,247,599	12,178,938,618
Цэвэр дүн	(1,167,800,785)	2,452,311,161	1,284,510,376

1082 С 5717



ХААН БАНК ХХК
2023
БҮРТГЭВ-02

Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2022 оны 12 сарын 31

40 Өөрийн хөрөнгийн хүрэлцээ

Банкны өөрийн хөрөнгийн хүрэлцээг Монголбанкнаас тогтоосон дүрэм, үзүүлэлтүүдийн харьцаагаар хянадаг. Банк 2022 болон 2021 онуудад зохицуулах байгууллагаас тогтоосон өөрийн хөрөнгийн шаардлагыг бүрэн хангасан.

Капиталын удирдлага

Банкны капиталын удирдлагын үндсэн зорилго нь хөндлөнгөөс тавигдсан зохистой харьцааны шалгууруудыг биелүүлэх ба сөрөг цочролыг дааж чадах өөрийн хөрөнгийн зохистой харьцааг хадгалахад оршдог.

Банк өөрийн хөрөнгийн бүтцийг удирдаж, эдийн засгийн нөхцөл байдал болон үйл ажиллагааных нь эрсдэлийн онцлог шинжид орсон өөрчлөлтүүдийг харгалзан капиталын бүтэцдээ залруулга хийдэг байна.

Зохицуулалттай капитал

Монголбанкнаас арилжааны банкуудын нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын зохистой харьцааг хамгийн багадаа 9% (2021: 9%), өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын харьцааг 13% (2021: 12%)-аас доошгүй байхаар тогтоосон байдаг бөгөөд эдгээр харьцаа нь эрсдэлийн энэхүү онцлог шинжээр тохируулагдсан нийт хөрөнгө болон нийт капиталд тулгуурлан тооцоологдсон байдаг.

Банк нь 2022 оны 12 дугаар сарын 31 болон 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар зохицуулагч байгууллагаас тогтоосон өөрийн хөрөнгийн бүх шаардлагыг хангаж биелүүлсэн бөгөөд банкны өөрийн хөрөнгийн зохистой харьцаа дараах байдалтай байна:

Мянган төгрөгөөр	2022 оны 12 дугаар сарын 31	2021 оны 12 дугаар сарын 31
Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын зохистой харьцаа	16.69%	15.58%
Өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын харьцаа	16.69%	15.58%

12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Банкны өөрийн хөрөнгийн хүрэлцээний харьцаа дараах байдалтай байна:

Мянган төгрөгөөр	2022 оны 12 дугаар сарын 31	2021 оны 12 дугаар сарын 31
Энгийн хувьцаа	172,097,820	172,097,820
Хуримтлагдсан ашиг	1,268,756,786	1,018,133,731
Нийт 1-р зэрэглэлийн хөрөнгийн дүн	1,440,854,606	1,190,231,551
Нийт капитал /капиталын суурь	1,440,854,606	1,190,231,551





Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2022 оны 12 сарын 31

41 Тайлангийн дараах үйл явдал

Банк одоогийн хувьцаа эзэмшигчдийнхээ эзэмшилд хувь тэнцүүлэн 180,703,711 мянгэн төгрөгийн ногдол ашиг хуваарилахаар 2023 оны 2 сарын 17-ны өдөр зарласан ба Монголбанкнаас 2023 оны 3 сарын 23-ны өдөр зөвшөөрөл авсан.

Банк нийт 60 сая ам.долларын (35 сая ам.долларыг Хөгжлийн Санхүүжилтийн Компани (ФМО), 15 сая ам.долларыг Ай Эф Си, 10 сая ам.долларыг МикроВестээс тус тус авсан) ногоон бонд гаргасан. Ногоон бонд нь 5 жилийн хугацаатай бөгөөд Монгол Улсын сэргээгдэх эрчим хүч, эрчим хүчний хэмнэлт, хөдөө аж ахуйн ухаалаг уур амьсгал зэрэг байгаль орчны төслүүдэд зээл олгоход зарцуулагдана.

2023 оны 3-р сард АНУ-ын Сигначур банк хаагдсаны дараа сандарсан харилцагчид Силикон Валлий Банк (СВБ)-аас хадгаламжаа татах давалгаа үүссэний улмаас АНУ-ын засгийн газрын Холбооны Хадгаламжийн Даатгалын Корпораци (ХХДК) нь СВБ-ыг хяналтандаа авсан. Хоёр банк хоёулаа бизнесээ санхүүжүүлэхийн тулд даатгуулаагүй халгаламжийн харьцаа ер бусын өндөр байсан. Хоёр банкны дампуурал нь дэлхийн бусад банк, ялангуяа Швейцарийн Крерит Свисс банкинд сөргөөр нөлөөлж байна. Банкинд санхүүгийн тайлангийн дараах эдгээр үйл явдлууд ямар нэгэн мэдэгдэхүйц нөлөө үзүүлээгүй. Гэсэн хэдий ч хувьсан өөрчлөгдөж буй нөхцөл байдал хэвээр байгаа бөгөөд удирдлагын зүгээс нөлөөллийг тасралтгүй хянаж, аливаа нөлөөллийг бууруулахын тулд боломжтой бүх арга хэмжээг авах болно.

Удирдлага тайлагналын эцсийн өдрөөс хойш эдгээр санхүүгийн тайлангуудад нөлөө үзүүлэх өөр бусад үйл явдал гараагүй гэж үзэж байна.

42 Монгол хэлний орчуулга

Эдгээр санхүүгийн тайлангуудыг мөн Англи хэл дээр бэлтгэсэн болно. Англи болон Монгол хувилбарын хооронд утга, агуулгын зөрүү гарсан тохиолдолд Англи хувилбарыг баримтална.





Хавсралт 4

/Ногоон танилцуулга/

2023 5 29.1





"Компанийн өрийн хэрэгслийн бүртгэлийн журам"-ын

Хавсралт 4

НОГООН ТАНИЛЦУУЛГА

/БОНД/

Огноо: 2023/05/29

Энэхүү танилцуулга нь нийтэд санал болгон ногоон бонд гаргах ХААН Банк ХХК-ийн үйл ажиллагааны ерөнхий стратеги, татан төвлөрүүлсэн хөрөнгөөр санхүүжүүлэх үйл ажиллагааны байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл, удирдлага, тайлагналын үйл явц, мөн төлөвлөсөн үйл ажиллагааны Монгол Улсын 'Ногоон таксономи' болон бусад олон улсын холбогдох ногоон бондын стандарт, шалгуурт нийцсэн байдлыг холбогдох талуудад тайлбарлах зорилготой бөгөөд Хорооны "Компанийн өрийн хэрэгслийн бүртгэлийн журам"-ын 3.4-т заасан Бондын танилцуулгын салшгүй хэсэг юм.


Бонд гаргагчийн нэр:	ХААН Банк
Бондын нэр:	Ногоон Бондын хөтөлбөр
Хөндлөнгийн мэргэжлийн баталгаажуулалтын байгууллагын нэр /дүгнэлт гаргуулсан бол/:	Sustainable Fitch Limited

1. СТРАТЕГИ БОЛОН ҮНДЭСЛЭЛ

1.1. Байгаль орчны зорилтууд, ногоон бонд гаргах болсон шалтгааны талаар болон компанийн ерөнхий стратеги, үйл ажиллагаатай хэрхэн уялдсан тухай

ХААН Банк харилцагчдынхаа санхүүгийн хэрэгцээ шаардлагыг хангах бүтээгдэхүүн, үйлчилгээг хамгийн найдвартай, шуурхай хүргээд зогсохгүй, бизнесээ нийгэм, хүн ард, байгаль орчинд ээлтэйгээр явуулж, Монгол Улсын эдийн засаг, нийгмийн хөгжилд бодитой хувь нэмэр оруулахын төлөө ажилладаг. Энэхүү эрхэм зорилгын хүрээнд Банк эрчим хүчний хэмнэлтийг нэмэгдүүлэх, ногоон барилга, ногоон тээвэр, тогтвортой хөдөө аж ахуйн орчин үеийн шийдлүүдийг нэвтрүүлэх, хог хаягдлын асуудлыг шийдвэрлэх, уур амьсгалын өөрчлөлтийг багасгах замаар сөрөг нөлөөг бууруулах байгаль орчинд ээлтэй үйл ажиллагааг санхүүжүүлэх ногоон санхүүжилтийн багцаа эрчимтэй нэмэгдүүлэх дунд хугацааны томоохон зорилтыг хэрэгжүүлж байна.

Энэ хүрээнд тус үйл ажиллагааг дэмжих урт хугацаат эх үүсвэрийг гадаад болон дотоодын хөрөнгө оруулагчдаас татан төвлөрүүлэх үүднээс Банк олон улсын зах зээлээс анхны "Ногоон бонд" гаргасан. Энэ Ногоон бондыг гаргасны дараа бусад олон улсын санхүүгийн байгууллага, хамтран ажиллагч хөрөнгө оруулагчдаас байгаль орчин, нийгэмд эерэг нөлөө үзүүлэх тогтвортой хариуцлагатай хөрөнгө оруулалтыг дэмжих өндөр сонирхолтой байгаагаа илэрхийлсэн. Иймд банк олон улсад ногоон бонд гаргасан туршлага дээрээ үндэслэн Монголын хөрөнгийн зах зээлд дотоодын анхны ногоон бондыг гаргах үйл ажиллагааг эхлүүлж байна. Ингэснээр хөрөнгийн зах зээлд энэ төрлийн шинэ бүтээгдэхүүн нэмэгдэж, хөрөнгийн зах





зээлийг тэлэх, дотоодын болон гадаадын хөрөнгө оруулагчид, олон улсын санхүүгийн байгууллагуудад хөрөнгө оруулалтын шинэ боломжийг бүрдүүлэх өндөр ач холбогдолтой юм.

Банкны үйл ажиллагаа болон стратегийн тухай товч мэдээлэл

ХААН Банк нь анх 1991 онд улс орон даяар 326 салбар нэгжтэйгээр, 2000 гаруй ажилтантай Монголын Хөдөө аж ахуйн хоршоологчдын банк нэртэй байгуулагдсан түүхтэй. Харин өнөөдөр ХААН Банк нь 6,500 гаруй ажилтантай, 2.7 сая гаруй харилцагчидтай, Монгол Улсын өнцөг булан бүрд байрлах 547 салбар, тооцооны төвөөрөө дамжуулан нийт айл өрхийн 80 гаруй хувьд цахим болон биет бүх сувгаараа 24 цагийн турш үйлчилгээгээ зогсолтгүй хүргэдэг банкны салбарын зах зээлийн гуравны нэгийг эзэлсэн тэргүүлэгч банк болсон байна.

ХААН Банк харилцагчидтайгаа хамт эгнэгт өсөж хөгждөг, итгэл төгөлдөр банк байгаад зогсохгүй нийгэм улс орныхоо хөгжилд хувь нэмрээ оруулж, цаашид олон олон жил оршин тогтнох бизнесийн байгууллага болохын хувьд тогтвортой хөгжлөөр манлайлагч байх зорилгыг цаашдын стратегидаа шингээгээд байна.

- Эрхэм зорилго** *Бид харилцагчдынхаа санхүүгийн аяллын алхам бүрд хамгийн шилдэг, шинэлэг бүтээгдэхүүн үйлчилгээг хүргэнэ.*
- Алсын хараа** *Харилцагчидтайгаа хамт эгнэгт өсөж хөгждөг, итгэл төгөлдөр банк байна.*
- Уриа үг** *Хамтын өсөлт төгөлдөр*
- Үнэт зүйл**
 - Хөгжил цэцэглэлтийн түүчээлэгч**
Бидний үүрэг банкны үйлчилгээ үзүүлэхийн зэрэгцээ харилцагчид, ажилтнууд, хувьцаа эзэмшигчдээ өсөлт хөгжлийн замд хөтлөхөд чиглэнэ.
 - Тогтвортой хөгжилд манлайлагч**
Бид нэг байрандаа зогсдоггүй. Тогтвортой бизнесийг бүтээхийн төлөө тасралтгүй суралцаж, дасан зохицож, улам сайжирдаг учраас харилцагчдаа зорьж буй ирээдүйд нь хүргэх ажлаа улам төгөлдөржүүлнэ.
 - Шилдэг цахим бүтээгдэхүүн үйлчилгээ үзүүлэгч**
Харилцагч бүр шилдгийг хүлээн авах учиртай. Тиймээс бид ирээдүйн сайн сайханд хөтлөх санхүүгийн ухаалаг арга хэрэгсэл, бүтээгдэхүүн үйлчилгээгээр түүчээлнэ.
 - Итгэлт зөвлөгч**
Харилцагчид маань хэдэн арваны турш санхүүгээ бидэнд даатгаж ирсэн билээ. Энэхүү хүндтэй үйлсийг бид бахархалтайгаар үргэлжлүүлж, найдвартай зөвлөх, итгэлтэй түнш байж, үргэлж сайны төлөө зүтгэх болно.

ХААН Банкны Тогтвортой Хөгжлийн Бодлого

Улс орныхоо эдийн засагт хувь нэмэр оруулдаг, ТОП аж ахуйн нэгжийн хувьд бид НҮБ-ын Даян дэлхийн гэрээнд заасан 10 зарчмыг баримтлахын зэрэгцээ нийгэм, эдийн засаг, байгаль орчны тогтвортой байдалд эерэг нөлөө үзүүлэхийг зорин ажиллаж байна. ХААН Банкны ажилчид төдийгүй харилцагчид маань эдгээр зарчмуудыг ажил амьдралдаа хэрэгжүүлснээр нийгэмдээ





хувь нэмрээ оруулсан иргэн болон төлөвшиж байна. Ёс зүйтэй, байгаль орчиндоо хайртай, нийгмийн хариуцлагатай ажилчдаа бид ямагт дэмжин банкны үйл ажиллагаагаа ил тод явуулдаг билээ.

ХААН Банк 2019 онд Тогтвортой хөгжлийн бодлогоо батлан хэрэгжүүлж эхэлсэн. ХААН Банкны Тогтвортой хөгжлийн бодлого нь үндсэн дөрвөн хэсгээс бүрдэнэ. Үүнд:

- Тогтвортой санхүүжилт
- Тогтвортой үйл ажиллагаа
- Тогтвортой нийгмийн хөрөнгө оруулалт
- Тогтвортой хамтын ажиллагаа, тайлагнал

Уг бодлогын суурь ойлголт нь НҮБ-ын 2015 онд тодорхойлсон Тогтвортой хөгжлийн 17 зорилго, мөн тус байгууллагаас 2000 онд зарлан тунхагласан Даян дэлхийн гэрээний 4 бүлэгт 10 зарчим болон Монгол Улсын Тогтвортой санхүүжилт (ТоС) хөтөлбөрийн 2013 онд тодорхойлсон 8 зарчимд тулгуурласан. ХААН Банк 2019 оноос хойш жил бүрийн бизнес төлөвлөгөөндөө тогтвортой хөгжлийн зорилтуудыг тусгаж ирсэн. Банкнаас жил бүр хэрэгжүүлж буй тогтвортой хөгжлийн санаачилгыг тодорхойлж хэрэгжүүлэх зорилгоор банкны холбогдох газар нэгжийн төлөөллийг багтаасан Тогтвортой хөгжлийн ажлын хэсгийг байгуулан ажилладаг.

Ногоон санхүүжилт ба БОНЗ эрсдэлийн удирдлагын тогтолцоо

ХААН Банк байгаль орчинд ээлтэй бизнесийг санхүүжүүлэх зорилгоор төрийн байгууллага, олон улсын санхүүгийн байгууллагуудтай хамтран “ногоон” төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлсээр ирсэн туршлагатай бөгөөд 2022 оны төгсгөлөөр арилжааны банкуудын нийт ногоон зээлийн багцын 33%-ийн ХААН Банк дангаараа бүрдүүлж байна.

Бид харилцагчидынхаа тогтвортой үйл ажиллагааг дэмжин уян хатан нөхцөл бүхий олон төрлийн бизнес болон хэрэглээний ногоон зээлүүдийг харилцагч нартаа санал болгож байгаа бөгөөд үүнээс дурдвал:

- Ногоон эдийн засгийг дэмжих бизнесийн зээл
- Ногоон хөрөнгө оруулалтын зээл
- Ногоон эргэлтийн хөрөнгийн зээл
- Ногоон зээлийн шугам
- Тогтвортой ноолуурын нийлүүлэлтийг дэмжих хоршоодод зориулсан ногоон зээл
- Агаар орчны бохирдлыг бууруулах ногоон зээлийн хөтөлбөр
- Гэр бүлийн ногоон зээл
- Хэрэглээний ногоон зээл
- Ногоон тээврийн хэрэгслийн зээл

ХААН Банк анх 2011 онд байгаль орчин нийгмийн талаар баримтлах бодлогоо баталснаас хойш, төслийн байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөөллийг хэмжих үнэлгээг зээлийн бодлого журамдаа тусган зээлийн үйл ажиллагааны салшгүй нэг хэсэг болгосон бөгөөд 100 сая төгрөгөөс дээш дүнтэй бизнесийн зээлийн хүсэлтүүдэд эдийн засгийн салбарын ангилалаас нь хамаарч “Байгаль орчин, нийгэм, засаглалын эрсдэлийн үнэлгээ”-г хийж гүйцэтгэсээр байна.

1.2. Санхүүжүүлэхээр төлөвлөж байгаа үйл ажиллагааны байгаль орчны зохицуулалтуудад оруулах хувь нэмрийг тэмдэглэнэ үү? /Монгол Улсын "Ногоон



2023 5 29



таксономи' болон бусад олон улсын холбогдох ногоон бондын стандарт, шалгууртай уялдсан байна/

- Уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөг бууруулах;
- Уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөнд дасан зохицох чадварыг нэмэгдүүлэх;
- Бохирдлоос сэргийлэх;
- Байгалийн нөөцийг хамгаалах, зөв зохистой ашиглах;
- Хүн амын амьжиргааг сайжруулах.

1.3. Удирдлагын систем, бүтцийн тухай

Ногоон Зээлийн бодлого, үйл ажиллагааны зохицуулалт, үнэлгээний процесс болон Байгаль орчин, Нийгэм, Засаглалын эрсдэлийн удирдлагыг банкны Зээлийн Эрсдэлийн Хорооны хяналтан дор ХААН Банкны Зээлийн Бодлого, Зохицуулалтын Газрын харьяа Ногоон Санхүүжилтийн Баг нь удирдан, зохион байгуулж ажиллана.

Ногоон зээлийн хүсэлт тус бүрийг Ногоон Бондын Санхүүжилтийн хамрах хүрээнд заагдсан үйл ажиллагаа эсэх болон тавигдах шаардлагыг хангасан эсэхийг эхэлж шалган баталгаажуулах бөгөөд зөвхөн ногоон санхүүжилтийн шаардлагыг хангаж буй зээлийн хүсэлтийг ногоон зээлийн бүтээгдэхүүнээр судлана. Ийнхүү ногоон зээлээр судлах боломжтой зээлийн хүсэлтүүдийг ХААН Банкны зээлийн бодлого, үйл ажиллагааны журмуудын дагуу хянан шалгаж, зээлийн судалгааг хийж гүйцэтгэн холбогдох дүгнэлтүүдийг журамд заасны дагуу гаргаж шат шатны зээлийн хороогоор хэлэлцүүлж шийдвэрлэнэ.

Экспертийн дүгнэлт	Тайлбар
Барилгын инженерийн дүгнэлт	Барилгын салбар дахь зээлийн хүсэлтийн хувьд барилгын инженерийн дүгнэлт шаардлагатай.
Хуулийн дүгнэлт	Төв Банкны Зээлийн хороо болон Төв Банкны Зээлийн Дэд хороогоор хэлэлцэгдэх бүх саналд Хуулийн болон Эрсдэлийн шинжээчийн дүгнэлтийг тус тус гаргана.
Эрсдэлийн шинжээчийн дүгнэлт	ТҮЗ-аар хэлэлцэгдэх бүх саналуудад Комплайнсын дүгнэлт ирүүлэх шаардлагатай.
Комплайнсын дүгнэлт	Байгаль орчин, нийгэм, засаглалын эрсдэлийн үнэлгээ нь 100 сая төгрөгөөс дээш дүн бүхий бизнесийн зээл болон Улаан, Шар ангилал бүхий бизнесийн үйл ажиллагаануудад шаардлагатай.
Байгаль орчин, нийгэм, засаглалын эрсдэлийн үнэлгээ	Хүрээлэн буй орчин, нийгэм, засаглалын шалгалт /due diligence/ нь Улаан болон Шар ангилалын үйл ажиллагааны чиглэлтэй 36 сараас урт хугацаатай, 5 сая ам.доллараас дээш үнийн дүн бүхий бизнесийн зээлүүдэд шаардлагатай.
Байгаль орчин, нийгэм, засаглалын эрсдэлийн дэлгэрэнгүй шинжилгээ /due diligence/	

1.4. Шаардлагатай бусад мэдээлэл





2. НОГООН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2.1. Үйл ажиллагааны ангилал /"Ногоон таксаноми"-д заасны дагуу/

Ногоон бондоор босгох эх үүсвэрийг зөвхөн байгаль орчинд эерэг нөлөө үзүүлэх зорилготой төсөл, үйл ажиллагааг (Ногоон зээлийн шаардлага хангасан) бүхэлд нь болон хэсэгчлэн санхүүжүүлэх, дахин санхүүжүүлэхэд зарцуулна.

Бондын хөрөнгөөр дахин санхүүжүүлэх шаардлага хангасан төсөл, арга хэмжээ нь нийт эх үүсвэрийн 20 хувиас хэтрэхгүй байх бөгөөд Ногоон бонд гаргах өдрөөс 180 хүртэл хоногийн өмнө олгосон зээлүүдийг дахин санхүүжүүлэх боломжтой байна.

Ногоон бондын хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл эсвэл арга хэмжээ нь доорх хүснэгтэд заасан шалгуурын дор хаяж нэгийг хангасан байх ёстой.

ШААРДЛАГА ХАНГАСАН НОГООН ҮЙЛ АЖИЛЛАГАА

СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧ

Дараах сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг барих, хөгжүүлэх, ашиглах, худалдан авах, засвар үйлчилгээ хийх, түгээх ажлыг санхүүжүүлэх.

- ☉ Салхины эрчим хүч
- ☉ Фото цахилгаан нарны энерги
- ☉ Нарны дулааны энерги
- ☉ Нарны төвлөрсөн эрчим хүч
- ☉ Газрын гүний дулааны эрчим хүч
- ☉ Жижиг хэмжээний (<20МВт) усан цахилгаан станц

ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТ

Эрчим хүчний хэрэглээг оновчтой болгож, эрчим хүчний хэмнэлтийг үүсгэх бүтээгдэхүүн, технологи, үйлчилгээг санхүүжүүлнэ.

Шаардлага хангасан Эрчим хүчний үр ашигтай төслүүд нь дор хаяж 20 хувийн эрчим хүчний/ CO₂ хэмнэлтийг бий болгох ёстой.

Brownfield investment - Одоо байгаа барилга, үйлдвэр, тоног төхөөрөмжүүдийг сайжруулах эсвэл сэргээн засварлахад чиглэсэн, эсвэл одоо ашиглагдаж буйг шууд орлох шинэ техник төхөөрөмж суурилуулах тохиолдолд боломжтой. Энэ төрлийн төслүүдийн үнэлгээний суурь үзүүлэлт нь одоогийн буюу түүхэн үзүүлэлт дээр тулгуурлана.

Greenfield investment - Үйлдвэр, тоног төхөөрөмжийн дийлэнх нь шинээр баригдах төслүүдийг хэлнэ. Одоо байгаа байгууламжийн төслүүдийн хувьд бүх чухал тоног төхөөрөмжийг ашиглалтаас хасдаг эсвэл үндсэндээ шинэ төхөөрөмж, тоног төхөөрөмж худалдан авах, байрлуулахтай холбоотой байна. Ногоон талбайн төслийн суурь үзүүлэлт



0000148



нь тухайн төрлийн технологи эсвэл процесст тодорхойлсон эрчим хүчний хэмнэлтийн хамгийн бага стандартууд юм.

Тоног төхөөрөмжийг илүү өндөр хүчин чадалтай тоног төхөөрөмжөөр солих үед шинэ хүчин чадал нь одоогийн хүчин чадлаас хоёр дахин ихгүй, эрчим хүчний хэрэглээ буюу хүлэмжийн хийн ялгаруулалтыг нэгж бүтээгдэхүүнд 20 ба түүнээс дээш хувиар бууруулсан тохиолдолд боломжтой.

- ☉ Дулаан сэргээн ашиглах (агааржуулагч эсвэл хөргөлтийн системээс)
- ☉ Уурын конденсат шүүгчийг засварлах / солих
- ☉ Уурын зуух шинэчлэх:
 - Дулааны бойлороос конденсатор бойлер руу шилжсэн орон сууц, албан байгууллага, аж ахуйн зориулалттай уурын зуухнууд
- ☉ Цахилгааны болон механик системийг автоматжуулах, хянах: гэрэлтүүлгийн хяналтын төхөөрөмжийг шинэчлэх (жишээ нь: мэдрэгч төхөөрөмжүүд); халаалтын удирдлагыг шинэчлэх (жишээ нь: цаг тохируулга), моторын хувьсах хурдны хөтчүүд; автомат унтраалга суурилуулах; индукцийн халаалт руу шилжих, дээр дурдсан аль нэгтэй холбоотой системийн чухал бүрэлдэхүүн хэсгүүд
- ☉ Гэрэлтүүлгийг улайсдаг гэрлээс CFL эсвэл LED болгон эсвэл флюоресцентээс LED эсвэл T8/T5 болгон сайжруулна.
- ☉ IE2 эсвэл IE3 мотор худалдаж авах эсвэл IE1-ийг IE2 эсвэл IE3-аар солих.

НОГООН БАРИЛГА

Олон улсын болон дотоодын ногоон барилгын гэрчилгээ авсан буюу шаардлага хангасан барилгын зураг төсөл бүхий шинэ барилгын төслийг санхүүжүүлэх бөгөөд дараах төрлийн олон улсын болон дотоодын барилгын гэрчилгээг хүлээн зөвшөөрнөб

- ☉ LEED “Мөнгөн”
- ☉ BREEAM “Сайн”
- ☉ EDGE “Стандарт”
- ☉ Монгол улсын ВNaC 25-01-20 “Барилгын дулааны үзүүлэлт”-ийн дагуу A++, A+, A, B зэрэглэл. Барилгын дулааны гүйцэтгэлийн харьцаа нь халаалт, агааржуулалтад шаардагдах эрчим хүчийг норматив стандартын дагуу тооцдог.

Эрчим хүчний тэмдэглэгээ	Барилгын эрчим хүчний ангилал	Гүйцэтгэлийн харьцаа
A++	Пассив барилга	<20%
A+	Бага эрчим хүч ашиглах барилга	20% to 40%
A	Эрчим хүчний хэмнэлт ихтэй барилга	40% to 65%
B	Эрчим хүчний хэмнэлттэй барилга	65% to 90%

Барилгын засварын ажил нь засварын өмнөх барилгын үндсэн гүйцэтгэлтэй харьцуулахад эрчим хүчний хэмнэлтийг дор хаяж 20% -иар нэмэгдүүлэх боломжтой байдаг тул одоо ашиглалтанд байгаа барилгын дулаан алдагдлыг бууруулах засвар үйлчилгээний зориулалтыг мөн санхүүжүүлэх боломжтой.

- ☉ хана, дээврийн дулаалга,



[Handwritten signature]



2023 5 29



- LED гэрэлтүүлэг,
- Бойлер солих,
- Эрчим хүчний удирдлагын системийг суурилуулах,
- Халаалт, агаар сэлгэлт, агааржуулалтын системийг солих.

БОХИРДЛООС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, БУУРУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Хог хаягдлын менежментийн үйл ажиллагааг хөгжүүлэх, үйлдвэрлэх, барих, ашиглах, засварлах ажлыг санхүүжүүлэх, үүнд:

- Хог хаягдлаас урьдчилан сэргийлэх, хог хаягдлыг бууруулах
- Төрөл бүрийн хог хаягдлыг цуглуулах, боловсруулах
- Материал, хог хаягдлыг шинэ бүтээгдэхүүний орц болгон эсвэл нөөц болгон сэргээж, дахин ашигладаг хог хаягдлыг дахин боловсруулах төслүүд
- Дахин ашиглах боломжтой материал, био хог хаягдлыг (ургамал, амьтан, мяндас) тусад нь цуглуулах хогийн сав, ачааны машин, зөвшөөрөгдсөн ялгаруулалтыг бууруулахад одоо байгаа моторт тээврийн хэрэгслийг шинэчлэх
- Био хог хаягдлыг бордоо болгох байгууламж

Хог хаягдалтай холбоотой санхүүжүүлэхийг хориглох үйл ажиллагаа:

- Аюултай хог хаягдалтай холбоотой бүх үйл ажиллагаа
- Эмнэлгийн болон био анагаахын (хүн, амьтны) хог хаягдалтай холбоотой бүх үйл ажиллагаа
- Хог хаягдлыг шатаах болон ижил төрлийн дулаан боловсруулалт

УСНЫ МЕНЕЖМЕНТ

Усны хэрэглээг бууруулах ба/эсвэл усны хэрэглээг сайжруулах боломжтой материал, тоног төхөөрөмж, цахилгаан хэрэгсэл, технологийг санхүүжүүлэх.

- Ус хэмнэх, хянах, хадгалах, түгээх технологи, системийг үйлдвэрлэх, худалдан авах, ашиглах.
- Ус дахин боловсруулах байгууламж
- Бохир ус цэвэрлэх байгууламж
- Борооны ус цуглуулах, хадгалах, түгээх

Хөрөнгө оруулалт дараах үр дүнг хангасан байна:

- "Эрчим хүчний суурь үзүүлэлт"-тэй харьцуулахад эрчим хүчний хэмнэлт дор хаяж 20%
- "Жишиг усны суурь"-тай харьцуулахад хамгийн багадаа 20%-иар усны хэмнэлт, эсвэл
- 100м3/жилтэй тэнцэх буюу түүнээс дээш хүчин чадалтай тогтвортой ус үйлдвэрлэх байгууламжууд.

ТОГТВОРТОЙ ХӨДӨӨ АЖ АХУЙ, МАЛ АЖ АХУЙ





Органик газар тариалан, мал аж ахуйн бүтээгдэхүүн, уур амьсгалд зохицсон ухаалаг хөдөө аж ахуй зэрэг байгалийн нөөц, газар ашиглалтын тогтвортой менежментэд хувь нэмэр оруулах хөрөнгө.

- ☉ Органик хөдөө аж ахуй, мал аж ахуйн бүтээгдэхүүн
- ☉ Уур амьсгалд зохицсон ухаалаг хөдөө аж ахуй
- ☉ Ойжуулалт, шинээр мод тарих
- ☉ Тогтвортой ойн менежмент

Зөвшөөрөгдсөн үйл ажиллагаа нь:

- ☉ Тогтвортой ноолуурын стандарт (SFA) нь малын тавлаг байдал, бэлчээр ашиглалт, ноолуур цэвэрлэх процесс зэрэгт тавигдах шаардлагыг хангасан малчдын байгууллага, боловсруулах үйлдвэрүүдийг баталгаажуулсан.
- ☉ Хариуцлагатай нүүдэлчид, ногоон алт эсвэл үндэсний хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн бусад стандартыг дагаж мөрдөх. Жишээлбэл: Улсын Стандарт, Хэмжил зүйн газраас 2020 оны 2 дугаар сард батлагдсан “Хариуцлагатай нүүдэлчдийн шалгуур үзүүлэлт-Мал аж ахуйн үйлдвэрлэлийн тогтвортой үйл ажиллагааны стандарт”-ын нийлбэр дүнгийн 60-с дээш хувьтай тэнцэх.

Хөдөө аж ахуйн сайн туршлага (GAP) гэрчилгээтэй фермерүүд

ЦЭВЭР ТЭЭВЭР

Цоо шинэ цахилгаан суудлын автомашинууд болон холбогдох дэд бүтцийг бий болгох, худалдан авах, өргөтгөх, шинэчлэх, засвар үйлчилгээ хийх, ажиллуулах санхүүжилт.

- ☉ Цахилгаан нийтийн тээврийн үйлдвэрлэл, түгээлтийг нэмэгдүүлэх төслүүд
- ☉ Цахилгаан машин цэнэглэх станц зэрэг эко тээврийн хэрэгслийг ашиглах боломжтой болгох төслүүд

2023 5.29

2.2. Байгаль орчны зорилтуудад оруулах хувь нэмэр

Ногоон бондоор босгох эх үүсвэрээр санхүүжүүлэх ногоон төслүүд нь уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах, Парисын хэлэлцээрийн хүрээнд Монгол Улсын Үндэсний тодорхойлсон хувь нэмэр, НҮБ-ын ТХЗ-уудын хэрэгжилттэй холбоотой дараах бодлогын зорилтуудад хувь нэмрээ оруулж байна.

ШААРДЛАГА ХАНГАСАН
НОГООН ҮЙЛ
АЖИЛЛАГАА

ТХЗ-Д НИЙЦСЭН
БАЙДАЛ



МОНГОЛ УЛСЫН
БОДЛОГЫН ҮНДСЭН
ЗОРИЛТТОЙ
НИЙЦСЭН БАЙДАЛ



СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ
ХҮЧ










- 2030 онд эрчим хүчний үр ашгийг 20 хувиар нэмэгдүүлж, нийт эрчим хүчний үйлдвэрлэлд ашигласан сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувийг 2020 он гэхэд 20 хувь, 2030 он гэхэд 30 хувьд хүргэх замаар эрчим хүчний салбарын хүлэмжийн хийн ялгарлыг бууруулна. Эрчим хүчний үйлдвэрлэл болон бусад аж



СЭХ
2023.06.13 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 0000152
БҮРТГЭВ-02

		<p>Үйлдвэрийн технологийг шинэчлэх, хэт их хэрэглээ, алдагдлыг бууруулах, үнийн бодлогыг оновчтой болгох замаар хүрэх болно.</p> <ul style="list-style-type: none"> Сэргээгдэх эрчим хүчний хүчин чадлын нийт цахилгаан үйлдвэрлэх хүчин чадалд эзлэх хувийг 2020 он гэхэд 20 хувь, 2030 он гэхэд 30 хувь болгон нэмэгдүүлнэ.
3.2. Банкны эрх бүхий албан тушаалтнууд нь холбогдох хууль тогтоомж, СЭХ-ноос баталсан “Тохиромжтой этгээдийг тодорхойлох журам”, “Компанийн засаглалын кодекс”-т заасан шаардлага хангаж байгаа эсэх тухай

Компанийн тухай хуулийн 84.2-т заасны дагуу Банк нь эрх бүхий албан тушаалтны жагсаалтыг дүрэмдээ тухайлан заах шаардлагатай байдаг бөгөөд энэхүү заалтын дагуу Банк нь дүрмийнхээ 14.1 дэх хэсэгт эрх бүхий албан тушаалтныг жагсаан тоочсон байна. Тус жагсаалтаар Банкны (i) ТУЗ-ийн гишүүд, (ii) гүйцэтгэх захирал, (iii) гүйцэтгэх захирлын орлогч, (iv) дотоод аудитын захирал буюу ерөнхий аудитор, (v) ТУЗ-ийн нарийн бичгийн дарга болон (vi) Удирдлагын хорооны гишүүдийг эрх бүхий албан тушаалтанд хамааруулан авч үзсэн байх бөгөөд энэ нь Компанийн тухай хуулийн 84.1-т заасан шаардлагад нийцэж байна.

Банкнаас 2023 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн 01/2606 тоот “Эрх бүхий албан тушаалтнуудын тухай мэдээлэл хүргүүлэх тухай” албан бичгээр Банкны эрх бүхий албан тушаалтнуудын жагсаалтыг бидэнд ирүүлсэн ба дараах нэр бүхий хүмүүсийг эрх бүхий албан тушаалтанд хамруулсан байна. Үүнд:

Хүснэгт №1. Банкны эрх бүхий албан тушаалтнуудын жагсаалт

№	Овог, Нэр	Албан тушаал	Сонгогдсон/томилогдсон огноо
1	Г.Дарьбум	ТУЗ-ийн хараат бус гишүүн, ТУЗ-ийн дарга	2022.06.15
2	Д. Хулан	ТУЗ-ийн орлогч дарга, ТУЗ-ийн гишүүн	2022.06.15
3	Харада Ясунари	ТУЗ-ийн гишүүн	2022.06.15
4	Иший Кисабүро	ТУЗ-ийн гишүүн	2022.06.15
5	Ц. Баатарсайхан	ТУЗ-ийн гишүүн	2022.06.15
6	Б. Амарсанаа	ТУЗ-ийн гишүүн	2022.06.15
7	Жон Ло	ТУЗ-ийн гишүүн	2022.06.15
8	А. Тамир	ТУЗ-ийн хараат бус гишүүн	2022.06.15
9	Ханс Аарт Йонгегянс	ТУЗ-ийн хараат бус гишүүн	2022.06.15
10	Р.Мөнхтуяа	Гүйцэтгэх захирал	2020.12.28
11	Б.Эрдэнэдэлгэр	Гүйцэтгэх захирлын тэргүүн орлогч	2023.05.01
12	Сачин Наир	Гүйцэтгэх захирлын орлогч	2023.05.01
13	Д.Ариунбат	Иргэдийн банк хариуцсан дэд захирал	2020.04.02
14	Ж.Товуудорж	Жижиг дунд бизнесийн банк хариуцсан дэд захирал	2022.10.26
15	Т.Ууганбаяр	Байгууллагын банк хариуцсан дэд захирал	2021.02.01





16	Б.Баянбат	Бизнес хөгжил хариуцсан дэд захирал	2021.04.12
17	Г.Мөнхбаяр	Үйл ажиллагаа хариуцсан дэд захирал	2018.02.20
18	Б.Ариунболд	Мэдээлэл технологи хариуцсан дэд захирал	2023.05.01
19	Д.Энхбаатар	Эрсдэл хариуцсан дэд захирал	2020.09.21
20	Ш.Ганбямба	Хүний нөөц хариуцсан дэд захирал	2018.02.20
21	Ш.Өлзий-Аюуш	Санхүү захиргаа хариуцсан дэд захирал	2021.02.01
22	О.Ариунтулга	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга	2019.09.30
23	Д.Дугарбаатар	Ерөнхий аудитор	2020.09.21

Банкны эрх бүхий албан тушаалтнууд нь Компанийн тухай хуулийн 84.3, СЗХ-ны 2020 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн 179 дүгээр тогтоолоор батлагдсан “Тохиромжтой этгээдийг тодорхойлох журам”-ын 2.1.2-т тус тус заасан шаардлагыг нэгэн зэрэг хангасан байх ёстой бөгөөд ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх захирал зэрэг тодорхой албан тушаалтнуудын хувьд эдгээр нийтлэг шаардлагаас гадна Компанийн тухай хууль, Банкны тухай хууль, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2019 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн А-82 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Банк байгуулах тусгай зөвшөөрлийн журам”, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2021 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн А-86 тоот тушаалын хавсралтаар батлагдсан “Банкны төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх журам”, Компанийн засаглалын кодекст заасан холбогдох шаардлагыг мөн хангасан байх ёстой.

Бид эрх бүхий албан тушаалтнууд нь хуульд заасан шаардлагыг хангаж байгаа эсэх, тэдгээрийн удирдах чадвар, дадлага туршлага нь хуульд нийцэж байгаа эсэх тухай дүгнэлтийг дээр заасан шалгууруудын дагуу нэг бүрчлэн шалгахад эрх бүхий албан тушаалтнууд, тэдгээрийн удирдах чадвар, дадлага туршлага нь хуульд заасан шаардлагыг хангаж байсан болно.

Банкны эрх бүхий албан тушаалтнууд нь хуульд заасан шалгуурыг хангаж байгаа эсэх тухай дүгнэлтийн дэлгэрэнгүйг Хавсралт № 1-с үзнэ үү.





3.3. Үнэт цаас гаргагчийн дотоод дүрэм, журмууд холбогдох хууль тогтоомж, СЗХ-ноос баталсан “Компанийн засаглалын кодекс”-т нийцэж буй эсэх тухай

Банкны зүгээс Хуулийн фирмд ирүүлсэн материалаас үзвэл нийт 297 журам Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд хүчин төгөлдөр мөрдөгдөн хэрэгжиж байх ба бөгөөд Хуулийн фирм нь тус жагсаалт дахь Үнэт цаас гаргагчийн засаглал, дотоод хяналттай холбоотой голлох ач холбогдол бүхий дотоод дүрэм, журмыг хянасан болно.


Компанийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3 дахь хэсэгт “Компанийг нэгтгэхээс бусад хэлбэрээр өөрчлөн байгуулж байгаа тохиолдолд шинээр бий болж байгаа компанийг улсын бүртгэлд бүртгэснээр компани өөрчлөн байгуулагдсанд тооцно.” гэж заасан байна. Дүгнэлт бэлтгэх өдрийн байдлаар Үнэт цаас гаргагчийн хувьцаа нь МХБ-д бүртгэгдэн нээлттэй арилжаалагдаж байх боловч Компанийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3 дахь хэсэгт заасны дагуу компанийн хэлбэрийг өөрчилсөн тухай бүртгэлийг хуулийн этгээдийн улсын бүртгэлд хийлгүүлээгүй буюу өөрчлөн байгуулагдах хуульд заасан процесс ажиллагаа явагдаж байх тул Хуулийн фирм нь Үнэт цаас гаргагчийн хэлбэр өөрчлөгдөн, хувьцаат компаниар бүртгэгдсэний дараагаар дагаж мөрдөгдөх холбогдох дүрэм, журмын төслийг хянан, дараах байдлаар хууль зүйн дүн шинжилгээ хийсэн болно. Үүнд:

3.3.1. Үнэт цаас гаргагчийн дүрэм

Үнэт цаас гаргагчийн дүрэм нь хувьцаа эзэмшигчдийн 2020 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн хурлын 5 тоот тогтоолын хавсралтаар батлагдсан байх бөгөөд хувьцаа эзэмшигчдийн хурлын дараах тогтоолуудын хавсралтын дагуу нийт 5 удаа нэмэлт, өөрчлөлт орсон байна. Үүнд:

1. Хувьцаа эзэмшигчдийн 2021 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн хурлын 6 тоот тогтоол;
2. Хувьцаа эзэмшигчдийн 2022 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн хурлын 2 тоот тогтоол;
3. Хувьцаа эзэмшигчдийн 2022 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн хурлын 3 тоот тогтоол;
4. Хувьцаа эзэмшигчдийн 2022 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн хурлын 11 тоот тогтоол;
5. Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2023 оны 2 дугаар сарын 24-ний өдрийн хурлын 2 тоот тогтоол.

Компанийн дүрмийг батлах, дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх бүрэн эрх нь Компанийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг, 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх хэсэг болон Банкны тухай хуулийн 29.2.1 дэх хэсэгт тус тус заасны дагуу хувьцаа эзэмшигчдийн хуралд хадгалагдаж байх тул дээрх тогтоолууд нь энэхүү шаардлагад нийцэж байна. Түүнчлэн Үнэт цаас гаргагчийн дүрэм нь ХЭУБГ-т 2023



2023 5 29



оны 4 дугаар сарын 7-ны өдөр бүртгэгдэн, УБЕГ-ын тамга, тэмдгээр баталгаажсан байх тул Компанийн тухай хуулийн 17.9-д заасны дагуу улсын бүртгэлд бүртгэгдсэн, хүчин төгөлдөр дүрэм байна.

Компанийн дүрэм нь агуулгын хувьд Компанийн тухай хуулийн 16.2 дахь хэсэг болон Банкны тухай хуулийн 21.1 дэх хэсэгт заасан шаардлагыг хангасан байх ёстой. Үнэт цаас гаргагчийн дүрэм нь агуулгын хувьд компанийн эрх, үүрэг, хариуцлага, үйл ажиллагааны чиглэл, хувьцаа эзэмшигчийн эрх, үүрэг, хувь нийлүүлсэн хөрөнгө, төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх захирлын бүрэн эрх, хариуцлага зэрэг харилцааг зохицуулсан нийт 20 зүйлээс бүрдэх бөгөөд Компанийн тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна.

3.3.2. Банкны Хувьцаат компанийн дүрмийн төсөл

Монгол Улсын хууль тогтоомжийн хүрээнд “ХХК” хэлбэртэй компани болон “ХК” хэлбэртэй компани нь харилцан адилгүй эрх зүйн зохицуулалттай байх тул Банк өөрчлөн байгуулагдан, хувьцаат компаниар ХЭУБГ-г бүртгүүлснээс хойш хэрэгжих Банкны дүрмийн төслийг Үнэт цаас гаргагчаас боловсруулан, Хуулийн фирмд ирүүлсэн байна.

Банкны дүрмийн төсөл нь нийт 20 зүйлтэй бөгөөд зүйл тус бүр нь дараах харилцааг зохицуулсан байна. Үүнд:

- (i) *Нэгдүгээр зүйл:* Дүрмийн зорилго, хүрээ, нэр томъёоны тайлбар;
- (ii) *Хоёрдугаар зүйл:* Банкны эрх зүйн байдал;
- (iii) *Гуравдугаар зүйл:* Банкны үйл ажиллагаа;
- (iv) *Дөрөвдүгээр зүйл:* Банкны хувь нийлүүлсэн хөрөнгө;
- (v) *Тавдугаар зүйл:* Банкны хувьцаа, бусад үнэт цаас;
- (vi) *Зургаадугаар зүйл:* Хувьцаа эзэмшигчдийн эрх, үүрэг;
- (vii) *Долдугаар зүйл:* Хувьцаа эзэмшигчдийн хурал, түүний бүрэн эрх;
- (viii) *Наймдугаар зүйл:* Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдах журам;
- (ix) *Есдүгээр зүйл:* Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрх;
- (x) *Аравдугаар зүйл:* Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргад тавигдах шаардлага, түүнийг томилох;
- (xi) *Арван нэгдүгээр зүйл:* Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороод;
- (xii) *Арван хоёрдугаар зүйл:* Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал;
- (xiii) *Арван гуравдугаар зүйл:* Гүйцэтгэх захиралд тавигдах шаардлага, түүнийг томилох;
- (xiv) *Арван дөрөвдүгээр зүйл:* Банкны эрх бүхий албан тушаалтан, түүний хүлээх хариуцлага;
- (xv) *Арван тавдугаар зүйл:* Их хэмжээний хэлцлийн ойлголт болон түүнийг батлах;
- (xvi) *Арван зургаадугаар зүйл:* Сонирхлын зөрчилтэй хэлцлийн ойлголт болон түүнийг батлах;
- (xvii) *Арван долдугаар зүйл:* Банкны санхүүгийн болон санхүүгийн бус тайлан ба аудит;
- (xviii) *Арван наймдугаар зүйл:* Банкийг өөрчлөн байгуулах болон татан буулгах;



2023 5 29



- (xix) Арван есдүгээр зүйл: Банкны бичиг баримтыг хадгалах;
- (xx) Хорьдугаар зүйл: Дүрмийг батлах хувь болон дүрмийн хүчин төгөлдөр болох үндэслэл, зохицуулах хууль.

СЗХ-ноос Компанийн засаглалын кодексийг шинэчлэн баталсан 2022 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн 145 дугаартай тогтоолд нээлттэй хувьцаат компанийг үйл ажиллагаандаа дагаж мөрдөхийг үүрэг болгосон байдаг учир энэхүү дүрмийн төсөл нь Компанийн засаглалын кодекст нийцсэн эсэхийг шалгаж дүгнэсэн болно.

Тодруулбал, ТУЗ-ийн даргыг ТУЗ-ийн хараат бус гишүүд дундаас сонгоно гэж тусгасан Компанийн засаглалын кодексийн 2.1 дэх хэсэгт нийцсэн, ТУЗ-ийн хороод нь үйл ажиллагааны журам, заавартай, чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар, ажлын туршлага бүхий гурваас доошгүй гишүүдтэй байна гэж заасан нь Компанийн засаглалын кодексийн 2.5 дахь хэсэгт нийцсэн, ТУЗ-ийн хороодын бүтэц, бүрэлдэхүүнд тавигдах шаардлага, эрх үүргийн зохицуулалт нь Компанийн засаглалын кодексийн хоёрдугаар зарчим, 5.2 дахь хэсэгт тус тус нийцэж байна. Түүнчлэн Банкны тайлагналтай холбоотой зохицуулалтыг санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал гэж ангилан зохицуулсан байгаа нь Компанийн засаглалын кодексийн 3.3 дахь хэсэгтэй нийцэж байна.

Иймд Бид уг дүрмийн төслийн заалтууд нь хөрөнгө оруулагч, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх зүйн байдлыг хуульд зааснаас дордуулсан эсэх болон хууль тогтоомжид заасан нийтлэг шалгуурыг хангаж байгаа эсэхийг нэг бүрчлэн шалгаад, холбогдох хууль тогтоомж, Компанийн засаглалын кодекст нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.3.3. ТУЗ-ийн үйл ажиллагааны журам

Энэхүү журам нь ТУЗ-ийн 2016 оны 2 дугаар сарын 8-ны өдөр 01 тоот тогтоолоор батлагдсан байх бөгөөд хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувьд Компанийн засаглалын кодексийг заавал дагаж мөрдөх үүрэггүй боловч Хуулийн фирм нь Компанийн засаглалын кодекс болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэхэд дүгнэлт хийсэн болно.

Энэхүү ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар ТУЗ-ийн гишүүдийн стратегийн хүрээнд хэрэгжүүлэх бүрэн эрх, Хувьцаа эзэмшигчдийн харилцаанд ТУЗ-ийн гүйцэтгэх бүрэн эрх, Эрсдэл удирдлага, дотоод аудит, дотоод хяналтын асуудалд ТУЗ-ийн хэрэгжүүлэх бүрэн эрх, Санхүүгийн хяналт шалгалт, хөндлөнгийн аудиторын харилцаанд хэрэгжүүлэх ТУЗ-ийн бүрэн эрх, Банкны актив хөрөнгө болон үнэт цаасны асуудалд ТУЗ-ийн хэрэгжүүлэх бүрэн эрх, ТУЗ-ийн гишүүд болон тэдний ажлын гүйцэтгэлд ТУЗ-ийн хэрэгжүүлэх бүрэн эрх, Банкин дахь Удирдлагын асуудалд ТУЗ-ийн хэрэгжүүлэх бүрэн эрхийг тус бүрт нь тухайлан зохицуулснаас гадна ТУЗ-ийн гишүүдийн ажил хэргийн хүрээнд баримтлах зан чанар, хандлага, хэмжээг зохицуулсан байгаа нь Банкны тухай хуулийн 31.4.2 заалттай нийцэж байна.





Журмаар ТУЗ-ийн дарга, ТУЗ-ийн нарийн бичгийн даргын чиг үүргийг нарийвчлан зохицуулж, ТУЗ-ийн ээлжит болон ээлжит бус хурал, Хуралд оролцох, хурлын ирцийг Компанийн тухай хуульд нийцүүлэн зохицуулсан байхаас гадна ТУЗ-ийн гишүүд сонгогдсоны дараа Банкны стратеги, ерөнхий санхүү, эрх зүйн харилцаа, Банкны санхүүгийн тайлагналын тогтолцоо, Банк болон бизнесийн үйл ажиллагаанд тулгардаг онцгой асуудлууд болон ТУЗ-ийн гишүүний үүрэг, хариуцлага зэргийг хамруулсан чиглүүлэх сургалтад хамрагдах талаар зохицуулсан байгаа нь ач холбогдол бүхий байх бөгөөд Компанийн засаглалын кодексийн 1.3 дахь хэсгийн Тайлбар 1-тай нийцэж байна.

Түүнчлэн, ТУЗ нь жилд нэгээс доошгүй удаа өөрсдийнхөө ур чадвар, бүтээмжит үйл ажиллагааг үнэлнэ гэж заасан нь Компанийн засаглалын кодексийн 1.5 дахь хэсэгтэй нийцсэн байна.

Иймд Бид энэхүү журмыг хянаад Компанийн тухай хуулийн 75 – 82 дугаар зүйл болон Компанийн засаглалын кодексст нийцэж байна гэж дүгнэлээ.

3.3.4. Банкны засаглалын кодекс

Банк нь Компанийн тухай хууль, Банкны тухай хууль, Компанийн засаглалын кодекс, Банкны зохистой засаглалын зарчмын хэрэгжилтийн хяналт шалгалтын журамд нийцүүлэн компанийн засаглалыг хэрэгжүүлэх шаардлагатай байх бөгөөд Хуулийн фирм нь энэ хүрээнд Банкны засаглалын кодексийг хянасан болно. Тус кодексст дурдсанчлан Банкны засаглалын кодексийг Банкны ТУЗ-өөр батлуулахаар заасан байх бөгөөд энэ нь Компанийн тухай хуулийн 76.1.13, Банкны тухай хуулийн 31.3.7 дахь хэсэгт тус тус нийцэж байна. Банкны засаглалын кодекс нь ТУЗ-ийн засаглал, хяналтын орчин, хувьцаа эзэмшигчийн эрх ба харилцаа, мэдээлэл толилуулах болон ил тод байдлыг хангах гэсэн үндсэн 4 хэсгээс бүрдэж байх бөгөөд дараах чиглэлд Банкны баримтлах компанийн засаглалын үндсэн бодлого, үйл ажиллагааг ерөнхийд нь тодорхойлжээ. Тодруулбал:

- ТУЗ-ийн засаглал;
- Хяналтын орчин;
- Хувьцаа эзэмшигчийн эрх ба оролцогч талуудын эрх ашиг;
- Эрсдэлийн хяналт;
- Ил тод байдал ба мэдээлэл.

Банкны засаглалын кодексоор ТУЗ, түүний гишүүд, ТУЗ-ийн дэргэдэх хороо, ТУЗ-ийн дарга, ТУЗ-ийн нарийн бичгийн даргын чиг үүргийг тодорхойлон заасан байх бөгөөд Банкны дүрэм, ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар нарийвчлан зохицуулахаар тогтоосон байх тул Компанийн засаглалын кодексийн 1.1 дэх хэсэгт нийцэж байна. ТУЗ-ийн гишүүний боловсрол, мэргэшил, ур чадвар, туршлагад тавигдах шаардлага болон хүйсийн тэнцвэр зэрэг асуудлыг ТУЗ-ийн бүтэц, бүрэлдэхүүний асуудлыг тухайлсан бодлого, журмаар нарийвчлан зохицуулахаар тогтоосон байх бөгөөд баримт бичигт туссан зорилтын биелэлтийг жил бүр дүгнэж, Банкны жилийн үйл ажиллагааны тайлан болон цахим





хуудсанд байршуулахаар заасан нь Компанийн засаглалын кодексийн нэгдүгээр зарчимд нийцэж байна. Түүнчлэн Банкны засаглалын кодексээр Банкны эрсдэлийн удирдлага, дотоод хяналт, комплаенс, хөндлөнгийн аудит, мэдээллийн аюулгүй байдал болон хувь хүний нууцлалтай мэдээллийн хамгаалалт зэрэг аудит, хяналтын тогтолцоотой холбоотой зохицуулалтууд, тайлагнал мэдээллийн ил тод байдал, хувьцаа эзэмшигч болон оролцогч талуудын эрх ашгийг хамгаалахтай холбоотой суурь зарчмууд, компанийн соёл болон цалин урамшууллын тогтолцоотой холбоотой Банкны баримтлах үндсэн чиглэлүүдийг тогтоож өгсөн байх бөгөөд эдгээр нь Компанийн засаглалын кодексст нийцсэн байна. Дүгнэн хэлбэл, тус журам нь холбогдох хууль тогтоомж, Компанийн засаглалын кодексст нийцсэн байна.

3.3.5. Дотоод хяналтын журмууд

Банкны тухай хууль болон Компанийн засаглалын кодексст тус тус заасны дагуу Банк нь дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэн, зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлдэг байх шаардлагатай. Энэхүү шаардлагын дагуу Банкны ТУЗ-өөс Банкны дотоод хяналтын бодлогыг баталсан байх бөгөөд уг бодлогын хэрэгжилтийг хангах үүднээс Банк нь дараах журмыг батлан, дотоод үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:

1. Банкны дотоод хяналтын бодлогыг хэрэгжүүлэх зааварчилгаа;
2. Шүгэл үлээх бодлого;
3. Дотоод аудитын дүрэм;
4. Банкны салбарын аудитын үйл ажиллагааны журам;
5. Банкны мэдээлэл технологийн аудитын газрын үйл ажиллагааны журам;
6. Банкны төв банкны аудитын газрын үйл ажиллагааны журам.

Компанийн засаглалын кодекс болон Банкны тухай хуульд заасны дагуу Банк нь дотоод аудитын нэгжтэй байх ёстой бөгөөд Банкны тухай хуулийн 31.3.6-т тус тус заасны дагуу дотоод аудитын нэгжийг Банк гүйцэтгэх удирдлагаас хараат бусаар зохион байгуулсан байх ёстой. Банкны гүйцэтгэх захирлын 2023 оны 5 дугаар сарын 1-ний өдрийн 01/136 тоот тушаалын хавсралтаар батлагдсан Банкны зохион байгуулалтын бүтэц, Банкны ТУЗ-ийн Аудитын хорооны 2021 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн шийдвэрээр батлагдсан Банкны дотоод аудитын дүрмийн 5.1 дэх хэсгээс үзэхэд Банк нь гүйцэтгэх захирлаас хараат бус ерөнхий аудитортой байх бөгөөд ерөнхий аудиторын доор тус тусын чиг үүрэг бүхий салбарын аудитын газар, төв банкны аудитын газар, мэдээлэл технологийн аудиторын газар харьяалагдан ажиллаж байх тул тус шаардлагыг хангасан байна.

Банкны дотоод аудитын дүрэмд дотоод аудитын зорилго, хэрэгжүүлэх стандарт, хараат бус байдал, эрх, үүрэг, хариуцлага, эрх бүхий албан тушаалтантай харилцах харилцаа зэрэг үйл ажиллагаандаа баримтлах суурь зарчмыг зааж өгсөн байх бөгөөд дотоод аудитын газруудын тухайлсан чиг, үүрэг, бүтэц зохион байгуулалттай холбоотой харилцааг Банкны Ерөнхий аудиторын баталсан “Банкны салбарын аудитын үйл ажиллагааны журам”, “Банкны мэдээлэл технологийн аудитын газрын үйл ажиллагааны журам”;





“Банкны төв банкны аудитын газрын үйл ажиллагааны журам” зэрэг нарийвчилсан журмуудаар зохицуулж байна.

Түүнчлэн, Банк нь дотоод хяналтыг сайжруулах үүднээс Банкны бүх шатны ажилтнууд болон эрх бүхий албан тушаалтнуудын үйлдсэн Банкны үйл ажиллагаатай холбоотой хууль бус үйлдэл, зөрчил зэргийг Банкны дотоод аудитын газарт мэдээлэх, мэдээлэл өгсөн ажилтны нууцыг хамгаалахтай холбоотой харилцааг зохицуулах Шүгэл үлээх бодлогыг үйл ажиллагаандаа батлан хэрэгжүүлдэг байна.

Дээр дурдсаныг нэгтгэн дүгнэвэл Банк нь Компанийн тухай хууль, Банкны тухай хууль, Компанийн засаглалын кодексийн 8 дугаар зарчим, Банкны зохистой засаглалын зарчмын 7 дугаар бүлэгт тус тус заасан дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлсэн бөгөөд Банкны дотоод хяналтын дүрэм, журмууд нь холбогдох хууль болон зохицуулагч байгууллагын журамд нийцсэн байна.

3.3.6. Банкны комплаенс, эрсдэлийн удирдлагын журмууд

Банкны үйл ажиллагаанд хэрэгжүүлэх эрсдэлийн удирдлагатай холбоотой суурь шаардлагыг Банкны зохистой засаглалын зарчмын хэрэгжилтийн хяналт шалгалтын журмын 6 дугаар зүйл болон Компанийн засаглалын кодексийн 5 дугаар хэсгээр тус тус зохицуулдаг бөгөөд эдгээр журмын хэрэгжилтийг хангах зорилгоор Банк нь доорх журмуудыг батлан, үйл ажиллагаандаа хэрэгжүүлж байна. Үүнд:

1. Комплаенсийн хорооны журам;
2. Комплаенсийн бодлого;
3. Банкны эрсдэлийн удирдлагын хорооны журам;
4. Банкны эрсдэлийн дэд хорооны журам;
5. Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн дэд хорооны журам;
6. Мэдээллийн технологийн эрсдэлийн дэд хорооны журам;
7. Карт болон Цахим банкны эрсдэлийн дэд хорооны журам;
8. Банкны эрсдэлийн удирдлагын ерөнхий бодлого;
9. Санхүүгийн бус эрсдэлийн удирдлагын журам;
10. Банкны хүлээн зөвшөөрөх эрсдэлийн бодлого;
11. Банкны бизнесийн тасралтгүй байдлын журам;
12. Хүлээн зөвшөөрөх эрсдэлийн мэдэгдлийг хэрэгжүүлэх журам;
13. Арга хэмжээний удирдлагын журам;
14. Хохирлын үйл явдлыг мэдээлэх, бүртгэх журам;
15. Стресс тестийн бодлого, журам;
16. Баримт тэмдэглэлийн хяналтын журам;
17. Банкны даатгалын журам;
18. Гадаад валютын ханшийн эрсдэлийг хэмжих, удирдах журам.

2023 5 29





Компанийн засаглалын кодексийн 5 дахь хэсэгт заасны дагуу ТУЗ нь эрсдэлийн удирдлага болон комплаенсын хяналтыг зохистой байдлаар, хараат бусаар зохион байгуулж, тэдгээрийн үр дүнтэй байдалд тогтмол хяналт тавих үүрэгтэй байх тул Банкны ТУЗ-өөс Эрсдэлийн удирдлагын ерөнхий бодлогыг баталсан байна. Эрсдэлийн удирдлагын ерөнхий бодлогод Банкны хүлээн зөвшөөрөгдөх эрсдэл болон Банкинд учирч болох аливаа эрсдэлүүдийг тодорхойлсон байх бөгөөд эрсдэлийг удирдах ерөнхий зарчим, эрсдэлд шинжилгээ хийх, дүгнэлт хийх, арга хэмжээ авах, тайлагнах, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэгч этгээдийн эрх хэмжээ зэрэг эрсдэлийн удирдлагатай холбоотой суурь харилцааг зохицуулсан байна.

Банк нь үйл ажиллагаандаа “Хамгаалалтын 3 шугам” загварыг ашиглан эрсдэлийн удирдлагад оролцогч талуудын хүлээх үүргийг хуваарилдаг бөгөөд нийт эрсдэлийг санхүүгийн болон санхүүгийн бус эрсдэл хэмээн хоёр хуваасан байна. Мөн эрсдэлийг түүний онцлогоос шалтгаалан тухайлсан эрсдэлийн удирдлагын хороо хянаж, удирддаг, эрсдэлийн удирдлагын хороо нь үйл ажиллагааныхаа хураангуй тайланг ТУЗ болон гүйцэтгэх удирдлагад тайлагнадаг, газар, хэлтэс нь хоорондоо мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлсэн байх тул Банкны зохистой засаглалын зарчмын хэрэгжилтийн хяналт шалгалтын журмын 6.1.9-д заасан мэдээллийн хэвтээ болон босоо бүтцийг бүрдүүлсэн байна гэж дүгнэлээ.

Түүнчлэн Банк нь мэргэжлийн үйл ажиллагааг тогтоосон хэм хэмжээнд нийцүүлэн хэрэгжүүлэх, хууль тогтоомж, зохицуулагчаас дагаж мөрдөхөөр заасан нийтлэг зарчим, хэм хэмжээ, удирдамжийг биелүүлээгүй буюу Банкны ажилтан нь ёс зүйн дүрэм, дотоод журмаа зөрчсөний улмаас Банкинд хуулийн дагуу, эсхүл эрх бүхий байгууллагын шийдвэрээр хүлээлгэх хариуцлага, санхүүгийн үлэмж хэмжээний алдагдал, нэр хүнд хөсөрдөх зэрэг учирч болзошгүй эрсдэлээс урьдчилсан сэргийлэх зорилго бүхий Комплаенсын бодлогыг хэрэгжүүлдэг байх бөгөөд тус бодлогыг Банкны ТУЗ-өөс батлан, мөрдүүлдэг байна. Тус бодлогоор Банкны комплаенсыг хэрэгжүүлэх үндэслэл, зарчим, ТУЗ болон Комплаенсын хорооны бүрэн эрх зэргийг зохицуулсан байх ба энэ нь Банкны тухай хууль, Банкны зохистой засаглалын зарчмын хэрэгжилтийн хяналт шалгалтын журамд тус тус нийцсэн байна.

Дээрхээс гадна Банк нь болзошгүй эрсдэлийг бууруулах, үйл ажиллагааны эрсдэлээ шилжүүлэх арга хэмжээний хүрээнд аливаа эрсдэлээс үүссэн хохирлыг даатгалын байгууллагаар нөхөн төлүүлэх зорилгоор хамтран ажиллах даатгалын байгууллага сонгон шалгаруулахаас эхлээд даатгалын нөхөн төлбөр авч, гэрээ дүгнэх хүртэлх бүхий л харилцааг зохицуулсан Даатгалын журамтай болохыг онцлох нь зүйтэй.

Нэгтгэн дүгнэвэл, Банкны комплаенс, эрсдэлийн удирдлагатай холбоотой дээр жагсаасан журмууд нь Банкны тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж болон зохицуулагч байгууллагын журмуудтай нийцсэн байна.



2023 5 29



3.4. Үнэт цаас гаргагчийн бусадтай байгуулсан худалдах болон худалдан авах, бэлтгэн нийлүүлэх, зээлийн гэрээ болон үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд чухал ач холбогдол үзүүлэх бусад гэрээ нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэх тухайд, мөн Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн гэрээ хэлцэл нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн, Компанийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх үр дагавар үүссэн эсэх тухай

3.4.1. Үнэт цаас гаргагчийн бусадтай байгуулсан худалдах болон худалдан авах, бэлтгэн нийлүүлэх, бусдаас эх үүсвэр татсан зээлийн гэрээ болон үйл ажиллагаанд чухал ач холбогдол үзүүлэх гэрээ

Хуулийн фирм нь энэхүү хэсгийн Дүгнэлтийг Үнэт цаас гаргагчийн сүүлийн 2 (хоёр) жилийн хугацаанд буюу 2021 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс 2023 оны 5 дугаар сарын 1-ний өдрийн хооронд (цаашид “Гэрээг тасалбар болгосон өдөр” гэх) байгуулсан гэрээ хэлцэлд үндэслэн бэлтгэсэн болно.

Үнэт цаас гаргагчаас Хуулийн фирмд ирүүлсэн мэдээллээс үзвэл Тасалбар болгох өдрийн байдлаар дээрх агуулгад хамаарах нийт 121 гэрээ Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд хүчин төгөлдөр үйлчилж байх ба эдгээр гэрээ нь дараах байдалтай байна. Тодруулбал:

Хүснэгт №2. Банкны байгуулсан гэрээний тоон үзүүлэлт

№	Гэрээний төрөл	Хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа гэрээний тоон мэдээлэл
1.	Худалдах худалдан авах, бэлтгэн нийлүүлэх гэрээ	59
2.	Бусдаас эх үүсвэр татсан зээлийн гэрээ	50
3.	Банкны үйл ажиллагаанд чухал ач холбогдол бүхий гэрээ	12

Хуулийн фирм нь гэрээний хүчин төгөлдөр байдал буюу хуульд заасан агуулга болон хэлбэрийн шаардлага хангасан эсэх тухай Дүгнэлтийг зөвхөн Монгол Улсын хууль тогтоомжийн хүрээнд бэлтгэсэн бөгөөд гэрээний хэрэгжилт, гүйцэтгэлд дүгнэлт өгөөгүй болно. Ийнхүү дүгнэхдээ Хуулийн фирм нь дээр заасан гэрээний төрөл тус бүрээс тодорхой тооны гэрээг түүврийн аргаар сонгон авч хянасан болно.

3.4.1.1. Үнэт цаас гаргагчийн бусадтай байгуулсан худалдах-худалдан авах гэрээ болон бэлтгэн нийлүүлэх гэрээ

Энэ хүрээнд Хуулийн фирм нь Үнэт цаас гаргагчийн бусадтай байгуулсан дараах 5 гэрээг сонгон авч хянасан болно. Үүнд:



2023 5 29



- i. 2023 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн *** тоот Худалдах, худалдан авах, ажил гүйцэтгэх гэрээ;
- ii. 2023 оны 4 дүгээр сарын 5-ны өдрийн *** тоот Худалдах, худалдан авах, ажил гүйцэтгэх гэрээ;
- iii. 2023 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн *** тоот Худалдах, худалдан авах гэрээ;
- iv. 2023 оны 4 дүгээр сарын 11-ний өдрийн *** тоот Худалдах, худалдан авах, ажил гүйцэтгэх гэрээ;
- v. 2023 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн *** тоот Лицензийн ашиглах эрх сунгах, засвар үйлчилгээ үзүүлэх гэрээ.

Дээрх гэрээнүүдийн тухайд нэг талаас худалдагч нь биет байдлын доголдолгүй, эрхийн зөрчилгүй, гэрээнд заасан нэр, төрөл, тоо хэмжээ, техникийн үзүүлэлтийг бүрэн хангасан тодорхой төрлийн хуулиар хориглоогүй барааг нийлүүлэх, гэрээнд заасан баталгаат хугацаанд засвар, үйлчилгээ үзүүлэх, нөгөө талаас Банк нь харилцан тохиролцсон хугацаанд барааны үнийг төлж хүлээн авахтай холбоотой харилцааг зохицуулсан байх тул Иргэний хуулийн 243.1 дэх хэсэгт заасан худалдах худалдан авах гэрээний харилцаа байна.

Эдгээр гэрээнд Иргэний хуулийн 243 дугаар зүйлд заасан худалдах, худалдан авах гэрээнд заавал тусгах нөхцөлүүдийг бүрэн тусгагдсан, талуудыг төлөөлөх эрх бүхий этгээд гарын үсэг зурж, тамга, тэмдгээр баталгаажсан байх тул хуульд заасан агуулгын болон хэлбэрийн шаардлагыг хангасан гэж үзлээ. Түүнчлэн, энэхүү Дүгнэлт гаргах өдрийн байдлаар Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн мэдээлэл болон гэрээний агуулгаас үзэхэд худалдах, худалдан авах гэрээ нь хууль тогтоомжид нийцсэн бөгөөд хэлцэл хүчин төгөлдөр бусад тооцогдох аливаа нөхцөл болон гэрээний аль нэг талын үүргийн зөрчил байхгүй, гэрээний хэрэгжилт хэвийн байх тул Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх үр дагавар бий болоогүй, хуульд нийцсэн гэж дүгнэлээ.

3.4.1.2. Бусдаас эх үүсвэр татсан зээлийн гэрээ

Үнэт цаас гаргагч нь гадаад эх үүсвэрээс санхүүжилт татах зорилгоор олон улсын санхүүгийн байгууллагуудтай дараах зээлийн гэрээг байгуулсан байна. Үүнд:

Хүснэгт №3. Бусдаас эх үүсвэр татсан гэрээний мэдээлэл

№	Зээлдүүлэгч байгууллага	Гэрээ байгуулсан огноо	Зээлийн хэмжээ	Хэрэгжиж буй эсэх	Зохицуулах хууль
1	***	2021.09.20	120,000,000 ам.доллар	Тийм	Англи улс
2	***	2022.07.25	20,000,000 ам.доллар	Тийм	Люксембург улс
3	***	2022.10.19	10,000,000 ам.доллар	Тийм	Англи улс





4	***	2022.11.22	6,000,000 ам.доллар	Тийм	Нидерланд улс
5	***	2023.04.21	10,000,000 ам.доллар	Тийм	Англи улс
6	***	2022.12.26	3,350,000,000 төгрөг	Тийм	Монгол улс

Дээрх хүснэгтийн 1-5 дахь хэсэгт заасан гадаад эх үүсвэрийн гэрээнүүд нь гадаад улсын хууль тогтоомжоор зохицуулагдаж байх тул Хуулийн фирмийн зүгээс аливаа үнэлэлт, дүн шинжилгээ өгөх эрх зүйн боломжгүй болно.

Иймд Бидний зүгээс дээрх хүснэгтийн 6 дахь хэсэгт заасан Монгол Улсын хуулиар зохицуулагдах эх үүсвэрийн гэрээг дараах байдлаар хянан шалгалаа. Тодруулбал:

- 2022 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн *** тоот Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн жижиг зээлийг Улаанбаатар хотод дамжуулан олгох банкттай байгуулах гэрээ

Энэхүү гэрээгээр хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажлын байр шинээр бий болгох, хадгалах, өргөтгөх зорилгоор хувиараа хөдөлмөр эрхлэгч, малчин, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэн, бичил үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгч болон гадаад улсад хөдөлмөр эрхэлж байгаад буцаж ирсэн иргэнд жижиг зээл олгох үйл ажиллагааг дамжуулан гүйцэтгүүлэхтэй холбоотойгоор Үнэт цаас гаргагч, зээлдүүлэгч болон зээлдэгч нарын хооронд үүссэн харилцааг зохицуулсан байна. Тус гэрээнд талуудын эрх үүрэг, эцсийн зээлдэгчид олгох зээлийн нөхцөл, эх үүсвэрийг буцаан төлөх, үүнтэй холбоотой хүү, хугацаа зэрэг гэрээнд заавал тусгавал гол нөхцөлүүдийг бүрэн тусгасан, талуудыг төлөөлөх эрх бүхий этгээд гарын үсэг зурж, тамга, тэмдгээр баталгаажсан байх тул хуульд заасан агуулгын болон хэлбэрийн шаардлагыг хангасан гэж үзлээ. Түүнчлэн, энэхүү Дүгнэлт гаргах өдрийн байдлаар Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн мэдээлэл болон гэрээний агуулгаас үзэхэд энэхүү гэрээ нь хууль тогтоомжид нийцсэн бөгөөд хэлцэл хүчин төгөлдөр бусад тооцогдох аливаа нөхцөл болон гэрээний аль нэг талын үүргийн зөрчил байхгүй, гэрээний хэрэгжилт хэвийн байх тул Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх үр дагавар бий болоогүй, хуульд нийцсэн гэж дүгнэлээ.

3.4.1.3. Банкны үйл ажиллагаанд чухал ач холбогдол бүхий гэрээ

Үнэт цаас гаргагч нь өөрийн үйл ажиллагаанд чухал ач холбогдол бүхий буюу тухайн гэрээнд заасан нөхцөл хэрэгжээгүйгээс Банкны санхүүгийн болон санхүүгийн бус үйл ажиллагааны хэвийн байдалд нөлөө үзүүлж болохуйц үр дагавар бүхий дараах гэрээг ирүүлсэн болно. Үүнд:




2023 о 29



Хүснэгт №4. Банкны үйл ажиллагаанд чухал ач холбогдол бүхий гэрээний мэдээлэл

№	Гэрээний нэр	Гэрээ байгуулсан огноо	Зээлийн хэмжээ	Хэрэгжиж буй эсэх	Зохицуулах хууль
1	Эх үүсвэр татах зээлийн гэрээ	2021.07.30	15,000,000,000 ам.доллар	Тийм	Англи улс
2	Эх үүсвэр татах зээлийн гэрээ	2021.09.20	120,000,000 ам.доллар	Тийм	Англи улс
3	Эх үүсвэр татах зээлийн гэрээ	2021.12.16	20,000,000 ам.доллар	Тийм	Англи улс
4	Эх үүсвэр татах зээлийн гэрээ	2022.07.25	20,000,000 ам.доллар	Тийм	Люксембург улс
5	Эх үүсвэр татах зээлийн гэрээ	2022.08.04	6,500,000 ам.доллар	Тийм	Люксембург улс
6	Эх үүсвэр татах зээлийн гэрээ	2022.10.19	60,000,000 ам.доллар	Тийм	Англи улс
7	Эх үүсвэр татах зээлийн гэрээ	2022.10.19	10,000,000 ам.доллар	Тийм	Англи улс
8	Эх үүсвэр татах нөхцөлт зээлийн гэрээ	2022.12.23	130,000,000 ам.доллар	Тийм	Англи улс
9	Эх үүсвэр татах нөхцөлт бондын гэрээ	2023.03.16	60,000,000 ам.доллар	Тийм	Англи улс
10	Ногоон бондын захиалгын гэрээ	2023.03.16	35,000,000 ам.доллар	Тийм	Англи улс
11	Ногоон бондын захиалгын гэрээ	2023.03.16	15,000,000 ам.доллар	Тийм	Англи улс
12	Ногоон бондын захиалгын гэрээ	2023.03.16	10,000,000 ам.доллар	Тийм	Англи улс

Дээрх хүснэгтэд дурдагдсан гэрээнүүд нь гадаад улсын хууль тогтоомжоор зохицуулагдаж байх тул Хуулийн фирмийн зүгээс эдгээр гэрээнүүдийг хуульд нийцсэн эсэх талаар аливаа үнэлэлт, дүн шинжилгээ өгөх эрх зүйн боломжгүй болно. Түүнчлэн, энэхүү Дүгнэлт бэлтгэх өдрийн байдлаар Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн мэдээллээс үзэхэд дээрх гэрээнүүдийн хэрэгжилт хэвийн байгаа бөгөөд гэрээний аль нэг талын үүргийн зөрчил, гэрээнээс татгалзах зэргээр Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх үр дагавар бий болоогүй байна.



2023 5 29



Дээрхийг нэгтгэн дүгнэвэл, Үнэт цаас гаргагчийн бусадтай байгуулсан худалдах болон худалдан авах, бэлтгэн нийлүүлэх, бусдаас эх үүсвэр татсан зээлийн гэрээ болон үйл ажиллагаанд чухал ач холбогдол үзүүлэх гэрээ, хэлцлүүд нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн бөгөөд Банкны үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх нөхцөл илрээгүй байна.

3.4.2. Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн гэрээ хэлцэл

Энэхүү Дүгнэлт бэлтгэх өдрийн байдлаар Банкны дүрэмд тусгагдсан хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь 172,097,820,000 (нэг зуун далан хоёр тэрбум ерэн долоон сая найман зуун хорин мянган) төгрөг байх бөгөөд Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн нь 8,604,891,000 (найман тэрбум зургаан зуун дөрвөн сая найман зуун ерэн нэгэн мянган) төгрөг ба түүнээс дээш мөнгөн дүн байна.

Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн мэдээллээс үзвэл Тасалбар болгох өдрийн байдлаар хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий нийт 259 гэрээ Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд хүчин төгөлдөр үйлчилж байна. Хуулийн фирм нь эдгээр гэрээнээс дараах гэрээг түүврийн аргаар сонгон авч дүгнэлээ. Үүнд:

Хүснэгт №5. Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн гэрээний мэдээлэл

№	Гэрээний нэр	Гэрээ байгуулсан огноо	Зээлийн хэмжээ	Гэрээний тал	Хэрэгжиж буй эсэх
1	Зээлийн шугамын гэрээ	2022.05.04	15,000,000,000 төгрөг	Монгол улсын хуулийн этгээд	Тийм
2	Зээлийн эрх нээх гэрээ	2022.12.23	15,000,000,000 төгрөг	Монгол улсын хуулийн этгээд	Тийм
3	Барилгын зээлийн гэрээ	2021.06.21	25,123,780,801.87 төгрөг	Монгол улсын хуулийн этгээд	Тийм
4	Газрын тосны бүтээгдэхүүний агуулахын хөрөнгө оруулалтын зориулалт бүхий зээлийн гэрээ	2022.06.08	15,000,000,000 төгрөг	Монгол улсын хуулийн этгээд	Тийм



2023.5.29



5	Програм хангамжийн лицензийн эзэмших ашиглах эрхийг сунгах болон нэмэлт програм хангамж худалдах, худалдан авах гэрээ	2021.12.08	11,776,211,036.7 төгрөг	Монгол улсын хуулийн этгээд	Тийм
---	---	------------	-------------------------	-----------------------------	------

■ **Хүснэгт № 5-ын 1-4 дэх хэсэгт тусгагдсан зээлийн гэрээнүүд:**


Банкны тухай хуулийн 7.2 дахь хэсэг болон Банкны Нууцын журмын дагуу Банк нь харилцагчдын мэдээллийн нууцлалыг хадгалах үүрэгтэй тул зээлдэгчийн нэрийг харуулахгүйгээр товч авч үзвэл:

Банк болон Банкны харилцагчид хооронд байгуулагдсан зээлийн гэрээгээр зээлийн хэмжээ, мөнгөн тэмдэгтийн төрөл, зээлийн дансны дугаар, зээлийн зориулалт, зээл олгох хэлбэр, зээлийн гэрээний хугацаа зэрэг Иргэний хуулийн 451.1 дэх хэсэг, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэгт тус тус заасан гэрээнд заавал тусгах нөхцөлүүдийг бүрэн тусгагдсан, талуудыг төлөөлөх эрх бүхий этгээд гарын үсэг зурж, тамга, тэмдгээр баталгаажин нотариатаар гэрчлэгдсэн байх тул хуульд заасан агуулгын болон хэлбэрийн шаардлагыг хангасан гэж үзлээ. Түүнчлэн, энэхүү Дүгнэлт гаргах өдрийн байдлаар Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн мэдээлэл болон гэрээний агуулгаас үзэхэд зээлийн гэрээнүүд нь хууль тогтоомжид нийцсэн бөгөөд хэлцэл хүчин төгөлдөр бусад тооцогдох аливаа нөхцөл болон гэрээний аль нэг талын үүргийн зөрчил байхгүй тул гэрээний хэрэгжилт хэвийн, хуульд нийцсэн гэж дүгнэлээ.

■ **Хүснэгт № 5-ын 5 дахь хэсэгт тусгагдсан 2021 оны 12 дугаар сарын 08-ны өдөр *** ХХК-тай байгуулсан *** тоот Програм хангамжийн лицензийн эзэмших ашиглах эрхийг сунгах болон нэмэлт програм хангамж худалдах, худалдан авах гэрээ**

2021 оны 12 дугаар сарын 08-ны өдөр Банк нь Microsoft Ireland Operations Limited компанийн үйлдвэрлэсэн программ хангамжийн лицензийн эзэмших, ашиглах эрхийг сунгах болон нэмэлт программ хангамж худалдан авахаар *** ХХК-тай Программ хангамжийн лицензийн эзэмших ашиглах эрхийг сунгах болон нэмэлт программ хангамж худалдах худалдан авах гэрээ байгуулсан байна.

Тус гэрээнд зааснаар Худалдагч *** ХХК нь Банкинд гэрээний хавсралтад заасан программ хангамжийн лиценз эзэмших ашиглах эрхийг шилжүүлэх, худалдан авагч Банк нь гэрээнд заасан нийт төлбөр болох 11,776,211,036.7 төгрөгийг гурван жилийн хугацаанд тэнцүү хуваан төлөхөөр тус тус тохиролцсон байх ба дээрх гэрээнд тусгагдсан зохицуулалтууд нь Иргэний хуулийн 189.1, 243-261 дүгээр зүйлд нийцсэн бөгөөд талуудын



2023 08 29



эрх бүхий төлөөлөгчид гарын үсэг зурсан байх тул хуульд заасан агуулгын болон хэлбэрийн шаардлагыг хангасан гэж үзлээ. Түүнчлэн, энэхүү Дүгнэлт гаргах өдрийн байдлаар Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн мэдээлэл болон гэрээний агуулгаас үзэхэд зээлийн гэрээнүүд нь хууль тогтоомжид нийцсэн бөгөөд хэлцэл хүчин төгөлдөр бусад тооцогдох аливаа нөхцөл болон гэрээний аль нэг талын үүргийн зөрчил байхгүй тул гэрээний хэрэгжилт хэвийн, хуульд нийцсэн гэж дүгнэлээ.

Дээрхийг нэгтгэн дүгнэвэл, Үнэт цаас гаргагчийн хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн гэрээнүүд нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн бөгөөд хэрэгжилт нь хэвийн байна.

2023 5 29





3.5. Үнэт цаас гаргагчийн сүүлийн 3 жилийн дотор хийгдсэн их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл нь холбогдох хууль, тогтоомжийн дагуу хийгдсэн эсэх тухай

3.5.1. Сонирхлын зөрчилтэй хэлцэл

Компанийн тухай хуулийн 89.1 дэх хэсэгт: “Компанийн энгийн хувьцааны 20 буюу түүнээс дээш хувийг дангаараа, эсхүл түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч, компанийн эрх бүхий албан тушаалтан, түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээд нь өөрийн ажиллаж байгаа болон хувьцааг нь эзэмшиж байгаа компанитай дор дурдсан харилцаанд орсон бол компанитай, эсхүл түүний хараат болон охин компанитай сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх этгээдэд тооцогдоно”, тус хуулийн 92.1 дэх хэсэгт “Энэ хуулийн 89.1-д заасан этгээдийн өөрийн ажиллаж байгаа болон хувьцааных нь хяналтын багцыг эзэмшиж байгаа компанитай хийж байгаа хэлцлийг сонирхлын зөрчилтэй хэлцэл гэнэ” гэж тус тус заасан байдаг.

Банкны хувьд 2020 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс 2023 оны 5 дугаар сарын 1-ний өдрийн хооронд буюу сүүлийн 3 жилийн хугацаанд нийт 190 сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулсан байна.

Банкнаас Бидэнд ирүүлсэн мэдээллээс үзвэл Банк нь дээрх сонирхлын зөрчилтэй хэлцлийг Компанийн тухай хуулийн 89.4 дэх хэсэгт заасны дагуу ТУЗ эсхүл Банкны хувьцаа эзэмшигч нараар батлуулаагүй бөгөөд Банкны сонирхлын зөрчилтэй хэлцэлтэй холбоотойгоор аливаа маргаан, зөрчлөөн үүсээгүй, Банкны үйл ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлэхүйц үр дагавар үүсээгүй байна.

Компанийн тухай хуулийн 89.3 дахь хэсэгт Компанийн тухай хуулийн 12 дугаар бүлэгт заасан сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулах журам үл хамаарах тодорхой нөхцөлүүдийг жагсаасан байдаг бөгөөд мөн хуулийн 89.4 дэх хэсэгт: “Хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувьцаа эзэмшигчдийн тоо нь 10-аас илүүгүй бол компанийн дүрэмд энэ хуулийн 89.3-т зааснаас бусад тохиолдлыг зааж болно.” гэж заасан байдаг. Өөрөөр хэлбэл, компани нь өөрийн үйл ажиллагааны онцлогоос хамааран сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулахдаа Компанийн тухай хуулийн 12 дугаар бүлэгт заасан журмыг баримтлахгүй байх тодорхой тохиолдлыг тусгайлан зааж болдог байна. Энэхүү хуулийн зохицуулалтын дагуу Банк нь дүрэмдээ сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулах журам үл хамаарах нэмэлт нөхцөлийг тусгасан байх ба дээрх сонирхлын зөрчилтэй гэрээ, хэлцлийг өөрийн дүрэмд заасан зохицуулалтын хүрээнд байгуулсан нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна гэж Хуулийн фирм дүгнэсэн.

3.5.2. Их хэмжээний хэлцэл



2023 5 29



Их хэмжээний хэлцлийг Компанийн тухай хуулийн 87 дугаар зүйлд зохицуулсан байдаг бөгөөд 87.1.1 дэх хэсэгт: “хэлцэл хийхийн өмнөх сүүлийн балансын активын нийт дүнгийн 25 хувиас дээш зах зээлийн үнэтэй эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг худалдах, худалдан авах, захиран зарцуулах болон барьцаалахтай холбогдсон хэлцэл, эсхүл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн хэлцэл /компанийн өдөр тутмын үндсэн үйл ажиллагаатай холбогдсон хэлцэл үүнд хамаарахгүй”, 87.1.2 дахь хэсэгт: “компанийн урьд гаргасан энгийн хувьцааны 25 хувиас дээш хэмжээний энгийн хувьцаа, энгийн хувьцаа авах эрхийн бичиг буюу энгийн хувьцаанд хөрвөх үнэт цаас гаргах, эсхүл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн гаргалтыг” - гэж тодорхойлсон байдаг.

Түүнчлэн, тус хуулийн 88.1 дэх хэсэгт их хэмжээний хэлцэл хийх шийдвэрийг ТУЗ /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/ санал нэгтгэйгээр гаргах бөгөөд 88.2 дахь хэсэгт заасны дагуу хэрэв ТУЗ их хэмжээний хэлцэл хийх тухай шийдвэрийг санал нэгтгэй гаргаж чадахгүй тохиолдолд асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулах бөгөөд уг асуудлыг хуралд оролцож байгаа хувьцаа эзэмшигчдийн саналын олонхоор шийдвэрлэхээр тусгасан байдаг.

Үнэт цаас гаргагчаас бидэнд ирүүлсэн мэдээллээс үзвэл Үнэт цаас гаргагчийн сүүлийн 3 жилийн балансын активын 25 хувийн тоон үзүүлэлт дараах байдалтай байна. Тухайлбал:

Хүснэгт №6. Банкны сүүлийн 3 жилийн балансын активын 25%-ын тоон үзүүлэлт.

№	Хугацаа	Тухайн улирлын балансын нийт актив (төгрөгөөр)	Тухайн улирлын балансын активын 25% (төгрөгөөр)
1	2020 оны 1 улирал	10,057,104,361,000	2,514,276,090,000
2	2020 оны 2 улирал	10,987,483,593,000	2,746,870,898,000
3	2020 оны 3 улирал	11,065,091,312,000	2,766,272,828,000
4	2020 оны 4 улирал	12,111,167,326,000	3,027,791,832,000
5	2021 оны 1 улирал	12,300,062,428,000	3,075,015,607,000
6	2021 оны 2 улирал	13,847,672,121,000	3,461,918,030,000
7	2021 оны 3 улирал	13,086,027,273,000	3,271,506,818,000
8	2021 оны 4 улирал	13,463,448,994,000	3,365,862,249,000
9	2022 оны 1 улирал	12,627,202,763,000	3,158,000,691,000





10	2022 оны 2 улирал	13,500,032,315,000	3,375,088,079,000
11	2022 оны 3 улирал	13,192,300,274,000	3,298,075,069,000
12	2022 оны 4 улирал	14,952,713,346,000	3,738,178,337,000
13	2023 оны 1 улирал	14,950,783,995,000	3,737,695,999,000

Банкнаас Хуулийн фирмд ирүүлсэн 2023 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн 01/2687 тоот Их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй гэрээ, хэлцлийн мэдээлэл хүргүүлэх тухай албан бичигт тусгагдсанаар дээрх тоон үзүүлэлтийн дагуу Хуулийн дүгнэлт гаргах өдрийн байдлаар Компанийн тухай хуулийн 87 дугаар зүйлийн 87.1 дэх хэсэгт тодорхойлсон их хэмжээний хэлцэл байгуулагдаагүй байна.

2023 5 29





3.6. Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл, лиценз, зохиогчийн эрх, патент, бараа, үйлчилгээний тэмдэг, газар эзэмших эрх нь хүчин төгөлдөр эсэх, тэдгээрийн хугацаа дуусах, цуцлагдах, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангуулах үүрэг хүлээсэн зэргээр үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд нь бодитой нөлөөлж болохуйц нөхцөл байгаа эсэх тухай

3.6.1. Үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл нь хүчин төгөлдөр эсэх, тэдгээрийн хугацаа дуусах, цуцлагдах, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангуулах үүрэг хүлээсэн зэргээр үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд нь бодитой нөлөөлж болохуйц нөхцөл байгаа эсэх

Үнэт цаас гаргагч нь Зөвшөөрлийн тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Банкны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.2 дахь хэсэгт зааснаар Монголбанк, СЗХ-ноос олгосон дараах тусгай зөвшөөрлийн үндсэн дээр банк, санхүүгийн үйл ажиллагааг хугацаагүйгээр эрхэлж байна. Үүнд:

Хүснэгт №7. Банкны тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхэлж буй үйл ажиллагааны мэдээлэл

№	Тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхлэх үйл ажиллагааны нэр	Тусгай зөвшөөрөл олгосон шийдвэр/тогтоолын огноо, дугаар	Гэрчилгээний дугаар	Хугацаа
1	Мөнгөн хадгаламж	Монголбанкны 1991 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 06 тоот зөвшөөрлийн гэрчилгээ	02	Хугацаагүй
2	Зээл			
3	Төлбөр, тооцооны үйлчилгээ			
4	Гадаад валют худалдах, худалдан авах, хадгалах, хадгалуулах			
5	Үнэт зүйл хадгалах			
6	Гадаад төлбөр тооцоо хийх	Монголбанкны Ерөнхийлөгчийн 2009 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн 264 дүгээр тушаал	02	
7	Үнэт метал, эрдэнийн чулуу худалдах, худалдан авах, хадгалах, хадгалуулах	Монголбанкны Ерөнхийлөгчийн 2014.11.25-ны өдрийн А187 дугаар тушаал	02	
8	Өөрийн нэрийн өмнөөс гуравдагч этгээдэд баталгаа, батлан даалт гаргах	Монголбанкны Ерөнхийлөгчийн 2007 оны 12 дугаар	02	

2023 5 29






		сарын 06-ны өдрийн 575 дугаар тушаал	
9	Үнэт цаас гаргах, худалдах, худалдан авах	Монголбанкны 1991 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 06 тоот зөвшөөрлийн гэрчилгээ	02
10.	Санхүүгийн түрээсийн үйл ажиллагаа	Монголбанкны Ерөнхийлөгчийн 2010 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн 269 дүгээр тушаал	02
11	Зээл болон санхүүгийн бусад хэрэгслийг худалдах, худалдан авах	Монголбанкны Ерөнхийлөгчийн 2010 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 684 дүгээр тушаал	02
12	Даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа	СЗХ-ны 2012 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн № 234 дугаар тогтоол	T3 210/16
13	Үнэт цаасны тухайлсан бүртгэлийн үйл ажиллагаа эрхлэх үйл хавсран	СЗХ-ны 2017 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн № 237 дугаар тогтоол	321/03
14	Кастодианы үйл ажиллагаа	СЗХ-ны 2015 оны 06 дугаар сарын 24-ны өдрийн №284 дугаар тогтоол	321/03
15	Банк бус санхүүгийн факторингийн үйлчилгээ	СЗХ-ны 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн №34 дүгээр тогтоол	—

2023 5 20

Зөвшөөрлийн тухай хуулийн 2.2 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт: “Энэ зүйлийн 2-т зааснаас бусад зөвшөөрлийг хуульд заасан тохиолдолд хугацаагүй олгож болно.”, Банкны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дахь хэсэгт: “Банк байгуулах, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан банкны эрхлэх үйл ажиллагааны зөвшөөрлийг хугацаагүй олгоно”, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2019 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн А-82 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар батлагдсан “Банкны үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн журам”-ын 1.3 дахь хэсэгт: “Монголбанкны шийдвэрт өөрөөр заагаагүй бол банк байгуулах тусгай зөвшөөрлийг хугацаагүй олгоно...”, Үнэт цаас гаргагчийн дүрмийн 3.1-д: “Банк нь Монголбанк болон СЗХ-ноос олгосон тусгай зөвшөөрлийн дагуу дараах банк, санхүүгийн үйл ажиллагааг эрхэлнэ.” хэмээн тус тус заасны дагуу Үнэт цаас гаргагч нь Банкны тухай





хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 болон 6.2 дахь хэсэгт заасан үйл ажиллагааг хугацаагүй эрхэлж байна.

Зөвшөөрлийн тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 19 дахь хэсэгт: “Хуульд зааснаас бусад тохиолдолд энэ зүйлийн 18-д зааснаас бусад зөвшөөрлийг худалдах, бэлэглэх, барьцаалах болон бусад хэлбэрээр шилжүүлэхийг хориглоно.” хэмээн заасан бөгөөд Банкны тухай хуулийн 6.1, 6.2 дахь хэсэгт тусгагдсан банк, санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг бусдад шилжүүлэх, барьцаалах боломжгүй байна. Энэхүү Дүгнэлт үйлдэх өдрийн байдлаар Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаатай холбоотой аливаа тусгай зөвшөөрөл нь бусдад шилжээгүй, барьцаалагдаагүй Үнэт цаас гаргагч өөрөө эзэмшиж, ашиглаж байна.

Монголбанкнаас 2023 оны 05 дугаар сарын 23-ны өдөр ирүүлсэн Б-10/424 тоот хариу хүргүүлэх тухай албан бичгээс үзвэл Банк нь Банкны тухай хуулийн 6.1 дэх хэсэгт заасан үйл ажиллагааг Монголбанкны тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхэлдэг бөгөөд эдгээр тусгай зөвшөөрлүүд нь хүчин төгөлдөр бөгөөд цуцлах, хүчингүй болгох аливаа нөхцөл байдал үүсээгүй болохыг тодорхойлсон байна.

Мөн СЗХ-ны 2023 оны 05 дугаар сарын 16-ний өдрийн мэдээлэл хүргүүлэх тухай 9/2027 тоот албан бичигт дурдсанаар Үнэт цаас гаргагчид СЗХ-ны 2015 оны 284 дүгээр тогтоолоор кастодианы үйл ажиллагаа эрхлэх, 2012 оны 234 дүгээр тогтоолоор даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх, СЗХ-ны 2017 оны 237 дугаар тогтоолоор үнэт цаасны тухайлсан бүртгэлийн үйл ажиллагаа хавсран эрхлэх, СЗХ-ны 2023 оны 34 дүгээр тогтоолоор банк бус санхүүгийн факторингийн үйлчилгээний тусгай зөвшөөрлийг тус тус олгосон байна. Түүнчлэн, СЗХ-ноос Үнэт цаас гаргагч нь холбогдох дүрэм, журмыг зөрчсөн талаарх мэдээлэл бүртгэгдээгүй бөгөөд аливаа албадлагын хариуцлага хүлээлгэж байгаагүй болохыг тус тус тодорхойлсон байна.

Нэгтгэн дүгнэвэл, Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа эрхлэх дээрх тусгай зөвшөөрлүүд нь Дүгнэлт гарах өдрийн байдлаар хүчин төгөлдөр бөгөөд тэдгээрийг цуцлах үндэслэл бүрдээгүйн дээр бусад этгээдэд шилжээгүй, барьцаалагдаагүй байна.

3.6.2. Үнэт цаас гаргагчийн лиценз, зохиогчийн эрх, патент, бараа, үйлчилгээний тэмдэг эзэмших эрх нь хүчин төгөлдөр эсэх, тэдгээрийн хугацаа дүүсах, цуцлагдах, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангуулах үүрэг хүлээсэн зэргээр үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд нь бодитой нөлөөлж болохуйц нөхцөл бүй эсэх

Оюуны өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт: “Зохиогч сайн дурын үндсэн дээр өөрийн бүтээлийн мэдээллийг оюуны өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн мэдээллийн нэгдсэн санд бүртгүүлж болно.”, мөн хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэгт: “Оюуны өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага зохих журмын дагуу энэ хуулийн 7.1.1, 7.1.2, 7.1.3 дахь хэсэгт заасан зүйлийг бүртгэж патент, 7.1.4, 7.1.5 дахь хэсэгт заасан зүйлийг бүртгэж гэрчилгээ тус тус олгоно.” хэмээн тус тус заасны дагуу Хуулийн фирмийн





зүгээс Үнэт цаас гаргагчийн нэр дээр бүртгэгдэж, эрхийн хамгаалалт хийгдсэн зохиогчийн эрхэд хамаарах бүтээл, шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загварын патент, барааны тэмдгийн гэрчилгээ бий эсэх, байгаа бол тэдгээр патент, гэрчилгээ нь хүчин төгөлдөр эсэх, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар үүрэг хүлээсэн эсэхийг нягталсан болно.

Оюуны өмчийн газрын даргын 2021 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн А/07 дугаартай тушаалын хавсралтаар батлагдсан “Оюуны өмчийн бүртгэлийн мэдээллийн нэгдсэн санг цахим хэлбэрт оруулах, мэдээллийн санг үүсгэх, ашиглах, түүний байнгын тасралтгүй үйл ажиллагаа, хадгалалт, хамгаалалт, нууцлалын найдвартай байдлыг хангах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт: “Оюуны өмчийн цахим мэдээллийн нэгдсэн сан (цаашид “цахим мэдээллийн сан” гэх) нь Оюуны өмчийн газарт мэдүүлсэн болон бүртгүүлсэн Аж үйлдвэрийн өмчийн цахим мэдээллийн сан, Зохиогчийн эрхийн цахим мэдээллийн сан, Хяналтын цахим мэдээллийн сан, Тусгай зөвшөөрөл, хамтран ажиллах этгээдийн цахим мэдээллийн сангуудаас бүрдэнэ.” хэмээн заасан байна.

Мөн тус журмын 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсэгт: “Оюуны өмчийн газар нь цахим мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл бүртгэх, хөтлөх, шинэчлэх, мэдээллийн нэгдсэн сангаас оюуны өмчийн холбогдох хууль, журамд нийцүүлэн мэдээллийг түгээх, цахимаар хэвлэн нийтлэх үйл ажиллагааг зохион байгуулна.” хэмээн заасны дагуу (i) Аж үйлдвэрийн өмчийн мэдээллийн <https://publish.ipom.mn> цахим сан, (ii) Зохиогчийн эрхийн цахим мэдээллийн <http://copyright.ipom.mn> цахим сангаас Үнэт цаас гаргагчийн нэр дээр бүртгэгдсэн, эрхийн хамгаалалт хийгдсэн оюуны өмчийн эрхийн талаар бидний зүгээс хийсэн судалгаа болон Монгол Улсын Оюуны өмчийн газрын 2023 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн № 3/328 тоот хариу хүргүүлэх тухай албан бичигт тусгагдсанаар Үнэт цаас гаргагчийн нэр дээр зохиогчийн эрхэд хамаарах “харилцагчид үйлчилгээ үзүүлэх стандарт, гарын авлага” 1 бүтээл, 41 барааны тэмдэг тус тус бүртгэгдэж, эрхийн хамгаалалт хийгдсэн бөгөөд Үнэт цаас гаргагчийн нэр дээр шинэ бүтээл, ашигтай загварын аливаа патент бүртгэгдээгүй болохыг тодорхойлсон байна.

Үнэт цаас гаргагчийн барааны тэмдгийн хүчинтэй байх хугацаа дуусаагүй, барааны тэмдэг эзэмшигч хуулийн этгээд татан буугдаагүй, эрх нь бусад этгээдэд шилжээгүй, барааны тэмдэг эзэмшигч барааны тэмдгийг хүчингүй болгуулах хүсэлт гаргаагүй байх тул үнэт цаас гаргагчийн нэр дээр бүртгэлтэй барааны тэмдэг эзэмшигчийн эрх Барааны тэмдэг газар зүйн заалтын тухай хуулийн 18 дугаар зүйлд заасны дагуу дуусгавар болоогүй, хүчин төгөлдөр байна.

Энэхүү Дүгнэлт гарах өдрийн байдлаар эдгээр оюуны өмчийн эрхүүд нь хүчин төгөлдөр бөгөөд дуусгавар болоогүй байна.

Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимын дэргэдэх Монголын олон улсын арбитраын 2023 оны 05 дугаар сарын 9-ны өдрийн № 4/705 тоот лавлагаа, Улаанбаатар хотын Худалдааны танхимын дэргэдэх Үндэсний ба олон улсын арилжааны арбитраын 2023 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн № А-23/43 тоот лавлагаа, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дэргэдэх Шүүхийн тусгай архивын 2023 оны 05 дугаар сарын 5-ны өдрийн 1/1396 тоот



2023 5 29



лавлагаа, Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2023 оны 05 дугаар сарын 9-ны өдрийн № 940 тоот лавлагаа зэргээс үзвэл Үнэт цаас гаргагчийн дээрх оюуны өмчийн эрхтэй холбоотой аливаа маргаан алга байна.

Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт: “Иргэний гүйлгээнээс хасагдаагүй бусдын өмчлөлд шилжүүлж болох бодитой байгаа, эсхүл ирээдүйд бий болох хөдлөх эд хөрөнгө, бүх төрлийн хувьцаа, үнэт цаас, шаардах эрх, шинжлэх ухаан, утга зохиол, урлагийн бүх төрлийн бүтээл, шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, барааны тэмдэг, ашигтай загвар болон бусад хөдлөх эд хөрөнгө, эдийн бус хөрөнгө нь барьцааны зүйл байж болно.” хэмээн заасны дагуу Үнэт цаас гаргагчийн оюуны өмчийн эрх (барааны тэмдэг, зохиогчийн эрх) нь аливаа үүргийн гүйцэтгэлийг хангуулах үүрэг хүлээсэн эсэхийг тодруулсан болно. Энэ хүрээнд Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1 дэх хэсэгт: “Цахим мэдээллийн санд бүртгэгдсэн барьцааны мэдэгдэл нийтэд нээлттэй болсон үеэс хүчин төгөлдөр болно” хэмээн заасны дагуу хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны мэдэгдлийг бүртгэх мэдээллийн www.mpr.gov.mn цахим сангийн бүртгэлд хийсэн судалгаагаар энэхүү Дүгнэлтийг гаргасан өдрийн байдлаар Үнэт цаас гаргагчийн нэр дээр бүртгэлтэй оюуны өмчийн эрхүүдэд үүрэг ногдуулсан аливаа барьцааны мэдэгдэл бүртгэгдээгүй байна.

Иймд Үнэт цаас гаргагчийн лиценз, зохиогчийн эрх, бараа, үйлчилгээний тэмдэг эзэмших эрх нь хүчин төгөлдөр, тэдгээрийн хугацаа дуусах, цуцлагдах, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангуулах үүрэг хүлээсэн зэрэг үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд нь бодитой нөлөөлж болохуйц нөхцөл байдал үүсээгүй байна.

3.6.3. Үнэт цаас гаргагчийн газар эзэмших эрх нь хүчин төгөлдөр эсэх, тэдгээрийн хугацаа дуусах, цуцлагдах, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангуулах үүрэг хүлээсэн зэргээр үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд нь бодитой нөлөөлж болохуйц нөхцөл буй эсэх

Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн мэдээлэл болон аймаг, нийслэл, сум, дүүргийн газрын албадаас ирүүлсэн лавлагаа, тодорхойлолт зэргээс үзвэл, Үнэт цаас гаргагч нь Хавсралт №2-д тусгагдсан газар эзэмших, ашиглах эрхийг эзэмшиж байна.

Үнэт цаас гаргагчийн эзэмшиж, ашиглаж буй Хавсралт №2-д тусгагдсан газрын эрхүүд нь Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 28.1 дэх хэсэгт заасны дагуу холбогдох төрийн байгууллагад бүртгэгдсэн бөгөөд газар эзэмших, ашиглах гэрээнд заасан газрын төлбөрийг хуульд заасан хугацаанд төлсөн, төлбөрийн үлдэгдэлгүй болох нь аймаг, нийслэлийн газрын албаны газрын төлбөрийн тооцоо нийлсэн актаар тогтоогдож байна.

Мөн Газрын тухай хуулийн 39, 44 дүгээр зүйлд заасны дагуу газар эзэмших, ашиглах эрх нь дуусгавар болоогүй, газрын эрх нь хүчин төгөлдөр, хуульд заасан шаардлагатай баримт бичгийн бүрдлийг хангасан байна.



2023 5 29



Газрын тухай хуулийн 35.1.7 дахь хэсэгт заасны дагуу газар эзэмшигч нь газар эзэмших эрхээ Газрын тухай хуульд заасны дагуу барьцаалж болох ба энэ тохиолдолд Газрын тухай хуулийн 35.3.6-д заасны дагуу эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд бүртгүүлэх шаардлагатай байдаг. Улсын бүртгэлийн ерөнхий газрын улсын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сангийн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн лавлагаа, тодорхойлолтоос үзвэл Банкны эзэмшиж буй газар эзэмших эрхэд үүрэг ногдуулсан аливаа хэлцэл бүртгэгдээгүй байна.

2023.06.20





3.7. Үнэт цаас гаргагчийн үнэт цаас, үл хөдлөх болон бусад эд хөрөнгө өмчлөх эрх нь хүчин төгөлдөр эсэх, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангуулах үүрэг хүлээсэн эсэх тухай

3.7.1. Үнэт цаас гаргагчийн үнэт цаас нь хүчин төгөлдөр эсэх, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангуулах үүрэг үүссэн эсэх

(i) Хувьцаа

“Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-ийн 2023 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн 01/973 тоот тодорхойлолтоос үзвэл Үнэт цаас гаргагч нь “МИК Холдинг” ХК-ийн 210,621 ширхэг энгийн хувьцааг буюу “МИК Холдинг” ХК-ийн 1.02 хувийг, “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн 2,880,109 ширхэг энгийн хувьцааг буюу “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн 0.82 хувийг тус тус эзэмшиж байна. Банкны тухай хуулийн 17.4-т заасны дагуу арилжааны банк нь нэг компанийн гаргасан хувьцааны 10 хувиас дээшгүй үнэт цаасыг худалдан авах боломжгүй байх хуулийн хязгаарлалтад нийцэж байна.

(ii) Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас

Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн мэдээллээс үзвэл, Үнэт цаас гаргагч нь дүгнэлт гаргах өдрийн байдлаар “МИК Холдинг” ХК-ийн охин компани болох “Монголын Ипотекийн Корпораци ОССК” ХХК-ийн үүсгэн байгуулсан хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий тусгай зориулалтын компаниудын гаргасан ипотекийн зээлээр баталгаажсан энгийн болон давуу эрхийн дараах үнэт цаасыг эзэмшиж байна. Үүнд:

Хүснэгт №8. Банкны эзэмшиж буй үнэт цаасны мэдээлэл

№	Үнэт цаас гаргагч	Үнэт цаасны нэр	Багц
1	“Мик Актив Нэг ТЗК” ХХК	8008-МИК1-Э-20.0-10.5%	148,400
2	“Мик Актив Хоёр ТЗК” ХХК	8010-МИК2-Э-20.0-10.5%	51,164
3	“Мик Актив Гурав ТЗК” ХХК	8012-МИК3-Э-20.0-10.5%	25,588
4	“Мик Актив Дөрөв ТЗК” ХХК	8014-МИК4-Э-20.0-10.5%	81,956
5	“Мик Актив Тав ТЗК” ХХК	8016-МИК5-Э-20.0-10.5%	54,526
6	“Мик Актив Зургаа ТЗК” ХХК	8018-МИК6-Э-20.0-10.5%	61,629
7	“Мик Актив Долоо ТЗК” ХХК	8020-МИК7-Э-20.0-10.5%	77,491
8	“Мик Актив Найм ТЗК” ХХК	8022-МИК8-Э-20.0-10.5%	57,682
9	“Мик Актив Ес ТЗК” ХХК	8024-МИК9-Э-20.0-10.5%	23,846
10	“Мик Актив Арав ТЗК” ХХК	8026-МИК10-Э-20.0-10.5%	20,810
11	“Мик Актив Арван нэг ТЗК” ХХК	8028-МИК11-Э-20.0-10.5%	15,232
12	“Мик Актив Арван хоёр ТЗК ХХК	8030-МИК12-Э-30.0-10.5%	62,096



СЭХ
2023.06.13 өдөр
БҮРТГЭВ
N 1

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
00000217
2023-06-09
БҮРТГЭВ-02

13	“Мик Актив Арван гурав ТЗК” ХХК	8032-МИК13-Э-30.0-10.5%	46,474
14	“Мик Актив Арван дөрөв ТЗК” ХХК	8034-МИК14-Э-30.0-10.5%	40,288
15	“Мик Актив Арван тав ТЗК” ХХК	8036-МИК15-Э-30.0-10.5%	36,560
16	“Мик Актив Арван зургаа ТЗК” ХХК	8038-МИК16-Э-30.0-10.5%	30,404
17	“Мик Актив Арван долоо ТЗК” ХХК	8040-МИК17-Э-30.0-10.5%	34,975
18	“Мик Актив Арван найм ТЗК” ХХК	8042-МИК18-Э-30.0-10.5%	30,364
19	“Мик Актив Арван ес ТЗК” ХХК	8044-МИК19-Э-30.0-10.5%	16,200
20	“Мик Актив Хорь ТЗК” ХХК	8046-МИК20-Э-30.0-10.5%	13,262
21	“Мик Актив Хорин нэг ТЗК” ХХК	8048-МИК21-Э-30.0-10.5%	15,062
22	“Мик Актив Хорин хоёр ТЗК” ХХК	8050-МИК22-Э-30.0-10.5%	22,842
	“Мик Актив Хорин хоёр ТЗК” ХХК	8053-МИК22-Д-III-30.0-13.0%	20,767
23	“Мик Актив Хорин гурав ТЗК” ХХК	8054-МИК23-Э-30.0-10.5%	18,876
	“Мик Актив Хорин гурав ТЗК” ХХК	8057-МИК23-Д-III-30.0-13.0%	21,239
24	“Мик Актив Хорин дөрөв ТЗК” ХХК	8058-МИК24-Э-30.0-10.5%	24,955
	“Мик Актив Хорин дөрөв ТЗК” ХХК	8061-МИК24-Д-III-30.0-13.0%	30,149
25	“Мик Актив Хорин тав ТЗК” ХХК	8063-МИК25-Э-30.0-10.5%	30,620
	“Мик Актив Хорин тав ТЗК” ХХК	8066-МИК25-Д-III-30.0-13.0%	37,833
26	“Мик Актив Хорин зургаа ТЗК” ХХК	8072-МИК26-Э-30.0-10.5%	31,378
	“Мик Актив Хорин зургаа ТЗК” ХХК	8074-МИК26-Д-II-30.0-9.0%	123,681
27	“Мик Актив Хорин долоо ТЗК” ХХК	8075-МИК27-Э-30.0-10.5%	11,973
	“Мик Актив Хорин долоо ТЗК” ХХК	8078-МИК27-Д-III-30.0-13.0%	13,473
28	“Мик Актив Хорин ес ТЗК” ХХК	8086-МИК29-Д-II-30.0-9.0%	369,903

2023 5 29

УЛААНБААТАР ПОТ
МХБ-ийн гишүүн
Андеррайтер
БРИСД, дийлэнх
“БИДИСЕК”
ҮЦБ/ХК
1115205447 ± 2052482

МОНГОЛ УЛС
УРХИООО9
ХААН БАНК ХХК



29	“Мик Актив Хорин ес ТЗК” ХХК	8084-МИК29-Э-30.0-9.0%	126,037
30	“Мик Актив Гуч ТЗК” ХХК	8094-МИК30-Д-III-30.0-13.0%	58,069
31	“Мик Актив Гуч ТЗК” ХХК	8091-МИК30-Э-30.0-10.5%	43,956
32	“Мик Актив Гучин нэг ТЗК” ХХК	8097-МИК31-Д-II-30.0-9.0%	14,392
33	“Мик Актив Гучин нэг ТЗК” ХХК	8095-МИК31-Э-30.0-10.5%	3,685

Мөн Үнэт цаас гаргагч нь “Үнэт Цаас Санхүүжилтийн Корпораци” ХХК-ийн үүсгэн байгуулсан хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий тусгай зориулалтын компаниудын гаргасан хэвийн зээлээр баталгаажсан давуу эрхийн болон энгийн үнэт цаас, мөн Монгол Улсын Засгийн газраас гаргасан дараах бонд эзэмшиж байна. Үүнд

Хүснэгт №9. Банкны эзэмшиж буй үнэт цаасны мэдээлэл

№	Үнэт цаас гаргагч	Үнэт цаасны нэр	Багц
1	“ҮЦСК актив хоёр ТЗК” ХХК	8082-ҮЦСК2-Э-3.0-9.5%	191,897
		8082-ҮЦСК2-Д-3.0-9.5%	128,945
2	“ҮЦСК актив дөрөв ТЗК” ХХК	8090-ҮЦСК4-Д-8.0-9.5%	184,004
		8089ҮЦСК4-Э-8.0-9.5%	65,304
3	“ҮЦСК актив гурав ТЗК” ХХК	8088-ҮЦСК3-Д-15.0-9.0%	188,693
		8087-ҮЦСК3-Э-15.0-9.0%	82,919
4	Засгийн газар	9062-ЗГЭБ-3640-333	5,000
		9070-ЗГЭБ-3612-341	3,833
		9082-ЗГЭБ-3654-353	5,000
		9093-ЗГЭБ-3612-364	2,000

Үнэт цаас гаргагчийн эзэмшиж буй дээр дурдсан үнэт цаас нь хүчин төгөлдөр бөгөөд СЗХ-ны 2018 оны 382 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан Үнэт цаас барьцаалах тухай журмын 2.1 дэх хэсэгт: “Барьцаалагч нь барьцаалуулагчтай байгуулсан гэрээний үндсэн дээр барьцааны мэдэгдлийг хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны мэдэгдлийг бүртгэх цахим мэдээллийн сан /цаашид “цахим мэдээллийн сан” гэх/-нд бүртгүүлж, баталгаажуулсны үндсэн дээр Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагад үнэт цаасаа тусгаарлуулна.”, мөн журмын 2.2 дахь хэсэгт: “Барьцааны мэдэгдэл нь цахим мэдээллийн санд бүртгэгдэж, баталгаажсанаар хүчин төгөлдөр болно!”

2023.5.29





хэмээн тус тус заасны дагуу хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны мэдэгдлийг бүртгэх цахим мэдээллийн сангийн бүртгэл (www.mpr.gov.mn)-д хийсэн судалгаанаас үзвэл 2023 оны 05 дугаар сарын 24-ны өдрийн байдлаар Үнэт цаас гаргагчийн нэр дээр бүртгэлтэй дээрх үнэт цаасанд үүрэг ногдуулсан аливаа барьцааны мэдэгдэл бүртгэгдээгүй байна.

3.7.2. Үнэт цаас гаргагчийн газрын эрх, үл хөдлөх болон хөдлөх эд хөрөнгө нь хүчин төгөлдөр эсэх, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангуулах үүрэг үүссэн эсэх

(i) Үл хөдлөх хөрөнгө

Үнэт цаас гаргагчийн өмчлөлд энэхүү Дүгнэлтийн Хавсралт №3-д жагсаасан нийт 405 (дөрвөн зуун тав) үл хөдлөх эд хөрөнгө бүртгэлтэй байх ба эдгээр үл хөдлөх эд хөрөнгө нь аливаа үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар барьцаалагдаагүй байна.

Үнэт цаас гаргагч нь Иргэний хуулийн 110.1 дэх хэсэг, 182 дугаар зүйлийн 182.1 дэх хэсэг, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 5.1 дэх хэсгүүдэд тус тус заасны дагуу дээрх үл хөдлөх хөрөнгүүдийг холбогдох улсын бүртгэлийн албанд бүртгүүлсэн байх тул тэдгээрийн өмчлөх эрх нь хуульд заасны дагуу үүссэн бөгөөд хүчин төгөлдөр ба Улсын бүртгэлийн ерөнхий газрын улсын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сангийн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн лавлагаа, тодорхойлолтоос үзвэл аливаа үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар уг эд хөрөнгүүдийг барьцаалсан тухай бүртгэл байхгүй байна.

(ii) Авто тээврийн хэрэгсэл болон бусад хөдлөх хөрөнгө


Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн мэдээлэл болон “Авто тээврийн үндэсний төв”-ийн 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн лавлагаануудаас үзвэл Үнэт цаас гаргагчийн нэр дээр Хавсралт №4-д зааснаар 147 (нэг зуун дөчин долоо) ширхэг авто тээврийн хэрэгсэл бүртгэлтэй байх ба тэдгээр нь аливаа үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар барьцаалагдаагүй байна.

Үнэт цаас гаргагчийн мэдээлж байгаагаар дээрх 147 авто тээврийн хэрэгсэл нь Банкны өөрийн хөрөнгө бөгөөд үүнд фидуцийн гэрээний дагуу Банк нь зээлийн үүргийн гүйцэтгэлийг хангах зорилгоор түр өмчилж буй автомашинууд ороогүй болно.

Үнэт цаас гаргагчаас бидэнд ирүүлсэн мэдээллээс үзвэл Банк нь нийт 158,445,254,000 (нэг зуун тавин найман тэрбум дөрвөн зуун дөчин таван сая хоёр зуун тавин дөрвөн мянга) төгрөгийн үнэ бүхий хөдлөх хөрөнгө (авто тээврийн хэрэгслийг оролцуулаад) бүртгэлтэй байх бөгөөд хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны мэдэгдлийг бүртгэх цахим мэдээллийн сангийн бүртгэл (www.mpr.gov.mn)-д хийсэн судалгаанаас үзвэл Дүгнэлт гарах өдрийн байдлаар Үнэт цаас гаргагчийн нэр дээр бүртгэлтэй дээрх хөдлөх хөрөнгөнд үүрэг ногдуулсан аливаа барьцааны мэдэгдэл бүртгэгдээгүй байна.



2023.5.24



3.8. Үнэт цаасыг бүртгүүлэх танилцуулгад тусгагдсан хууль зүйн мэдээлэл нь хүчин төгөлдөр баримтаар нотлогдож байгаа эсэх тухай

Хуулийн фирм нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10.6 дахь хэсэгт заасан үнэт цаасны танилцуулгад тусгасан мэдээллийн үнэн зөв, хүчин төгөлдөр эсэх тухай дүгнэлтийг СЗХ-ны Үнэт цаасны бүртгэлийн журмын 11.14.8 дахь хэсэгт заасныг үндэслэн танилцуулгад тусгагдсан хууль зүйн мэдээлэл нь хүчин төгөлдөр баримтаар нотлогдож байгаа эсэхийг тулган шалгах замаар хийсэн болно.

Хуулийн фирм нь хууль, журамд заасан Үнэт цаасны танилцуулгад тавигдах шаардлагын хүрээнд түүнд тусгагдсан хууль зүйн мэдээллийг олон нийтэд ил болсон мэдээ баримт, төрийн болон эрх бүхий бусад байгууллагуудаас гаргаж өгсөн тодорхойлолт, лавлагаа, Үнэт цаас гаргагч болон үнэт цаас гаргах ажиллагаанд оролцсон байгууллагуудаас амаар болон бичгээр гаргаж өгсөн мэдээлэлтэй харьцуулан судалсны үндсэнд дүгнэсэн.

Хуулийн фирм нь “БиДиСекҮЦК” ХК-иас эцсийн хувилбар гэж мэдэгдэн 2023 оны 5 дугаар сарын 26-ны өдөр Хуулийн фирмд ирүүлсэн Үнэт цаасны танилцуулгыг дүгнэсэн бөгөөд хэрэв бидний хянасан тус үнэт цаасны танилцуулгад засвар, нэмэлт, өөрчлөлт оруулж СЗХ, МХБ-д хүргүүлсэн тохиолдолд түүнтэй холбоотой үүсэх аливаа хариуцлагыг Хуулийн фирм хүлээхгүй болно.

Ийнхүү дүгнэхэд хууль зүйн ач холбогдол бүхий мэдээллээс бусад Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан Үнэт цаас гаргагч болон бусад этгээдийн танилцуулга, үйл ажиллагаа, түүхэн замнал, алсын хараа, эрхэм зорилго, үнэт зүйлс, санхүүгийн болон статистик тооцоолол, тоо баримт, бизнес төлөвлөгөө, өгөөжийн төсөөлөл, зах зээл, эдийн засгийн төлөв байдал, өнөөгийн болон ирээдүйн төлөв, бүтээгдэхүүн үйлчилгээ, урьдчилсан таамаглалууд, бизнесийн үйл ажиллагаа, Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд учирч болох эрсдэл, эрсдэлийн удирдлагын төлөвлөгөө, аудитын дүгнэлт, санхүүгийн шинжилгээ, бизнесийн үнэлгээ, тооцоолол, тайлан, төсөөлөл, татан төвлөрүүлсэн хөрөнгийн хөрөнгийн зарцуулалт, үнэт цаас гаргагчийн холбоотой этгээдийн мэдээлэл, эрх бүхий албан тушаалтны эзэмшиж буй хувьцааны тоо, Банкны сүүлийн 5 жилийн байдлаарх зохистой засаглалын үнэлгээний товч мэдээлэл, ногоон үйл ажиллагаа, ногоон бондын зах зээлийн орчин, байгаль, орчин, эдийн засагт үзүүлэх нөлөө, чиг хандлага, хэрэгцээ, шаардлага, төрийн эрх бүхий байгууллагын бодлого, Үнэт цаас гаргагчийн зээлжих зэрэглэл, бонд гаргах үндэслэл, хүү тогтоосон үндэслэл, мэргэжлийн баталгаажуулалтын байгууллагын танилцуулга, түүнтэй байгуулсан гэрээ, хараат бус байгууллагуудын хийсэн дүн шинжилгээ, тэдгээрийн баталгаа, мэдэгдэл, тодорхойлох захидалд тусгагдсан мэдээлэл зэрэг хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанаас бусад мэргэжлийн ур чадварын үндсэн дээр боловсруулсан мэдээлэлд Хуулийн фирмийн зүгээс дүн шинжилгээ хийгээгүй болохыг дурдаж байна.

2023.06.29






Иймд Хуулийн фирм нь дээр заасан үндэслэл, хязгаарлалтын хүрээнд Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан хууль зүйн мэдээллийг дүгнэхэд:

Үнэт цаасны танилцуулга нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10.5, СЗХ-ны Өрийн хэрэгслийн бүртгэлийн журмын 3.4, 3.5 болон Биржийн бүртгэлийн журмын 4 дүгээр зүйлд заасан шаардлагыг тус тус хангасан байх шаардлагатай байдаг. Үнэт цаас гаргагчийн Үнэт цаасны танилцуулга нь нийт үндсэн 3 бүлгээс бүрдэх бөгөөд үнэт цаасны танилцуулгад заавал тусгах суурь мэдээллийг бүрэн багтаасан байх ба дараах хууль зүйн мэдээллүүд нь Үнэт цаас гаргагчийн үүсгэн байгуулах баримт бичиг, дүрэм журам мөн холбогдох хууль тогтоомж, оролцогч этгээдүүд болон төрийн эрх бүхий байгууллагын тодруулга, лавлагаа зэрэг хүчин төгөлдөр баримтаар нотлогдож байна. Үүнд:

- Үнэт цаас гаргах тухай шийдвэр;
- Санал болгож буй үнэт цаасны хураангуй;
- Үнэт цаас гаргагчийн хуулийн этгээдийн улсын бүртгэл;
- Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл;
- Үнэт цаас гаргагчийн хувь нийлүүлсэн хөрөнгө;
- Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшлийн бүтэц;
- Банкны хувьцаа эзэмшигч, төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрх;
- Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн, төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороод;
- Удирдлагын багын бүрэлдэхүүн;
- Үнэт цаас гаргагчийн байгуулсан гэрээ, хэлцлүүд;
- Үнэт цаас гаргах тухай эрх бүхий этгээдийн шийдвэр;
- Нийтэд санал болгох үнэт цаасны төрөл тоо, хэлбэр, нэрлэсэн үнэ, хугацаа, үндсэн төлбөр, хүү төлөх нөхцөл;
- Нийтэд санал болгох, арилжих арга, нөхцөл;
- Ногоон бонд гаргах хөтөлбөр;
- Бондын гэрээний үндсэн нөхцөл;
- Үнэт цаасаар гэрчлэгдэх эрх, үүрэг;
- Үнэт цаас гаргах ажиллагаанд хамтран ажилласан байгууллагууд, тэдгээртэй байгуулсан гэрээний тухай.

2023 5 29





3.9. Компанийн толгой, охин, хараат, зэрэгцээ компанийн тухай мэдээлэлд үндэслэн үнэт цаас гаргагч компанийн хяналтыг хэрэгжүүлэгч, эцсийн өмчлөгч этгээдийг тодорхойлох нь

Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль, тогтоомжид компанийн хяналтыг хэрэгжүүлэгч этгээд гэдэгт хэнийг хамааруулан тооцох талаар тодорхойлон зааж өгөөгүй байдаг. Түүнчлэн, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх тухай хуулиар хуулийн этгээдийн эцсийн өмчлөгч гэдэгт компанийн хяналтыг хэрэгжүүлж буй этгээдийг агуулгын хувьд хамруулан авч үзсэн байна. Иймд Хуулийн фирмийн зүгээс компанийн хяналтыг хэрэгжүүлэгч этгээд болон эцсийн өмчлөгчийг агуулгын хувьд нэгтгэн авч үзэж Банкны тухай хууль, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх тухай хууль болон УБЕГ-ын даргын 2020 оны 8 дугаар сарын 19-ний өдрийн А/1270 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн мэдээллийг улсын бүртгэлд хөтлөх журам”-ын хүрээнд тодорхойлон дүгнэсэн болно.

МХБ-ийн албан ёсны цахим хуудсанд нийтлэгдсэн 2023 оны 5 дугаар сарын 2-ны өдрийн байдлаарх Банкны нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл, ҮЦТХТ-өөс гарган өгсөн 2023 оны 5 дугаар сарын 1-ний өдрийн байдлаарх Банкны үнэт цаас эзэмшигчдийн судалгаа болон Банкны 2023 оны 5 дугаар сарын 4-ний өдрийн 11/2111 тоот Хувьцаа эзэмшлийн бүтцийн тухай албан бичгээс үзвэл Үнэт цаас гаргагчийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийн бүтэц дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт №10. Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчдийн бүтэц

№	Хувьцаа эзэмшигч	Эзэмшиж буй хувьцааны хувь	
		хэмжээ	
1	Эйч Эс Холдингс ХК	40.99%	
2	Таванбогд Трейд ХХК	22.78%	
4	Монгол улсын иргэн Д.Хулан	13.22%	
3	Эйч Эс Интернэйшнл (Ази) Лимитед	8.78%	

Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль, тогтоомжийн хүрээнд эцсийн өмчлөгчийг дараах байдлаар тодорхойлсон байна. Тодруулбал:

- Банкны тухай хуулийн 3.1.17 дахь хэсэгт: ““эцсийн өмчлөгч” гэж банкны үйл ажиллагааг удирдан чиглүүлдэг, эсхүл өөрийн энэ эрхээ бусдаар төлөөлүүлэн гүйцэтгүүлдэг, эсхүл банкны хувьцааг нэг болон түүнээс дээш үргэлжилсэн хэлхээ холбоо бүхий хуулийн этгээдээр дамжуулан эзэмшиж байгаа, тухайн хуулийн этгээдийг үүсгэн байгуулсан буюу банкны хувьцаа, үйл ажиллагаанаас үүсэх үр шимийг хүртэх эрх бүхий өмчлөгч хүнийг”;
- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх тухай хуулийн 3.1.6 дахь хэсэгт: “эцсийн өмчлөгч” гэдэгт “харилцагч нь хуулийн этгээд бол (тухайн хуулийн



2023 5 29



этгээдийн хөрөнгийн дийлэнх хэсгийг дангаараа, эсхүл бусадтай хамтран өмчилж байгаа, эсхүл тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааг удирдан чиглүүлж, эсхүл өөрийн үйлдлийг бусдаар төлөөлүүлэн хийлгэж байгаа, эсхүл хуулийн этгээдийг болон уг хуулийн этгээдээс хийх аливаа хэлцэл, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг удирдах замаар тухайн хуулийн этгээдийг өмчилж үр шим, ашиг орлогыг хүртээж байгаа хүнийг” ойлгохоор тусгасан. Мөн уг хуулийн 4¹ хэсэгт компанийн эцсийн өмчлөгчийг тогтоох дарааллыг зохицуулсан байх бөгөөд 4^{1.1.1} дэх хэсэгт: “хувьцааны дийлэнх хэсгийг дангаараа, эсхүл бусадтай хамтран өмчилж байгаа хүнийг”; 4^{1.1.2} дахь хэсэгт: “энэ хуулийн 4^{1.1.1}-д заасан хүнийг тогтоох боломжгүй бол хуулийн этгээдийн үйл ажиллагааг шууд бусаар удирдаж байгаа, эсхүл өөрийн эрхээ бусдаар төлөөлүүлэн хийлгэж байгаа хүнийг”; 4^{1.1.3} дахь хэсэгт: “энэ хуулийн 4^{1.1.1}, 4^{1.1.2}-т заасан хүнийг тогтоох боломжгүй бол хуулийн этгээдийн удирдлагыг хэрэгжүүлэгч хүнийг” хэлэхээр заасан.

- Монголбанкны Ерөнхийлөгчийн 2019 оны А-26 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журмын 4.3 дахь хэсэгт: “4^{1.1.1}-д заасан дийлэнх хэсэг гэдгийг шууд болон шууд бус хэлбэрээр нийт хувьцааны 33 хувийг өмчилж байгаа гэж ойлгоно”.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 10.3 дахь хэсэгт заасны дагуу Банк нь эцсийн өмчлөгч өөрчлөгдөх тухай бүр бүртгэлийн байгууллагад бүртгүүлэх үүрэгтэй бөгөөд ХЭУБГ-ын 2023 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн лавлагаа болон УБЕГ-ийн нээлттэй мэдээллийн санд тусгагдсан мэдээллээс үзвэл Банкны эцсийн өмчлөгч нь Япон улсын иргэн Хаттори овогтой Жүничи (Hattori Junichi) байна. Тодруулбал, Хаттори овогтой Жүничи нь Эйч Эс Холдингс ХК болон Эйч Эс Интернэйшнл (Ази) Лимитед компаниудын 33 буюу түүнээс дээш хувийг эзэмшдэг хуулийн этгээд болох “Upsilon Investment Business Limited Liability Partnership”-ийн эцсийн өмчлөгч юм.

Иймд Хуулийн фирмийн зүгээс ХЭУБГ-ийн лавлагааны мэдээллийг үндэслэн Үнэт цаас гаргагчийн эцсийн өмчлөгч нь Япон улсын иргэн Хаттори овогтой Жүничи (Hattori Junichi) гэж дүгнэв.





3.10. Үнэт цаас гаргагч нь аж ахуйн үйл ажиллагааны эсрэг гэмт хэрэг, иргэн, захиргааны хэрэгт хариуцагчаар татагдаж байсан эсэх тухай

3.10.1. Арбитрын маргаан

Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимын дэргэдэх Монголын олон улсын арбитрын 2023 оны 05 дугаар сарын 09-ны өдрийн № 4/705 тоот лавлагаанаас үзвэл, Үнэт цаас гаргагч нь лавлагаа гарах өдрийн байдлаар тус арбитраар шийдвэрлэгдсэн болон арбитрын ажиллагаа явагдаж байгаа хэрэгт нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээдээр оролцоогүй болохыг тодорхойлсон байна.

Улаанбаатар хотын Худалдааны танхимын дэргэдэх Үндэсний ба олон улсын арилжааны арбитрын 2023 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн № А-23/43 тоот лавлагаанаас үзвэл Үнэт цаас гаргагч нь лавлагаа гарах өдрийн байдлаар тус арбитрын хэрэг маргаанд нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээдээр оролцоогүй байна.

3.10.2. Иргэний шүүхийн маргаан

Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн дэргэдэх Шүүхийн тусгай архивын 2023 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 1/1396 тоот лавлагаанд тусгагдсанаар Үнэт цаас гаргагч нь сүүлийн гурван жилийн байдлаар Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхээр шийдвэрлэгдсэн 9 (ес) иргэний хэрэгт хариуцагчаар оролцож байсан болохыг тодорхойлсон байна.

Дээрх маргаануудын 4 (дөрөв) нь хөдөлмөрийн харилцаатай холбоотойгоор ажилтан, ажил олгогч Банкны хооронд үүссэн хэрэг байх ба урьд эрхэлж байсан ажилд эгүүлэн тогтоолгох, ажилгүй байсан хугацааны цалин хөлс, гаргуулж, эрүүл мэнд болон нийгмийн даатгалын дэвтэрт нөхөн бичилт хийхийг даалгуулах тухай нэхэмжлэлийн шаардлага бүхий маргаан, үлдэх 5 (тав) маргааны тухайд, (i) төрлийн шинжээр тодорхойлогдох эд хөрөнгө гаргуулах шаардлага бүхий 4 (дөрөв) маргаан, (ii) зээлийн гэрээг цуцлах нэхэмжлэлийн шаардлага бүхий 1 маргаан тус тус байна. Эдгээр 9 (ес) маргаанаас шүүх 2 (хоёр) маргааны нэхэмжлэлийн шаардлагыг шүүх хангаж, 4 (дөрөв) маргааны нэхэмжлэлийн шаардлагыг хангахгүй орхиж, 3 (гурав) маргаан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад талууд эвлэрсэн учир хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн байна.

Дээрх маргаанууд нь Банкныг өндөр хэмжээний өр төлбөрт оруулах, Банкны үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх үр дагавар үүсгэхээргүй байна.

Нэхэмжлэлийн шаардлагыг шүүхээс хангаж шийдвэрлэсэн 2 маргааны хувьд Үнэт цаас гаргагч шүүхийн шийдвэрийг сайн дурын үндсэн дээр биелүүлсэн байх бөгөөд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын 2023 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн лавлагаагаар Үнэт цаас гаргагч нь шүүхийн шийдвэрээр иргэн, хуулийн этгээдэд төлбөргүй болохыг тогтоосон байна.

3.10.3. Захиргааны хэргийн маргаан

(i) Татварын албанд үйлчлүүлэгчийн мэдээлэл хүргүүлэх асуудлаар



2023 5 29



Монгол Улсын Их Хурлаас Татварын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулга (2019 онд баталж, 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн)-ын 34.4.2-т: “*татвар төлөгч нь банк, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоо болон бусад санхүүгийн эрх бүхий байгууллагад шинээр төлбөр тооцоо, хадгаламжийн болон бусад төрлийн данс, нээсэн, эсхүл өмнө нээсэн дансанд өөрчлөлт, хөдөлгөөн хийлгэсэн бол энэ тухай мэдээллийг тухай бүр*”, мөн хуулийн 34 дүгээр зүйлийн 34.4-т: “*Арилжааны банк болон банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоо болон бусад санхүүгийн эрх бүхий байгууллага дараах мэдээллийг гаргаж татварын албанд хүргүүлнэ.*” хэмээн хуульчилжээ. Өөрөөр хэлбэл, Банк санхүүгийн байгууллага нь татвар төлөгч үйлчлүүлэгчийн мэдээллийг татварын албанд хүргүүлж байх тухай шинэ зохицуулалт шинэчилсэн хуулиар үйлчилж эхэлсэн.

Хуулийн дээрх зохицуулалтыг хэрхэн хэрэгжүүлэх талаар Татварын ерөнхий газраас Монгол Улсад үйл ажиллагаа явуулдаг арилжааны банкнуудад 2020 оны 3 дугаар сарын 27-ны өдөр хамтран ажиллах тухай албан бичгээр Татварын ерөнхий хуулийн 34 дүгээр зүйлийн 34.4.1-34.1.3-т заасан хуулийн зохицуулалтын дагуу татвар төлөхөөс зайлсхийх явдлыг бууруулах, татварын эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор мэдээлэл харилцан солилцож “Хамтран ажиллах гэрээ”-ний төслийг боловсруулан, хүргүүлж байна гэх агуулга бүхий албан тоот ирүүлсэн байна.

Үнэт цаас гаргагчийн зүгээс 2020 оны 05 дугаар сарын 17-ны өдөр *** тоот албан бичгээр хамтран ажиллах гэрээнд тусгах саналаа, 2020 оны 06 дугаар сарын 17-ны өдөр гэрээний төсөлд өгсөн зарчмын шинжтэй саналыг, 2020 оны 07 дугаар сарын 21-ний өдөр хамтран ажиллах гэрээг баталгаажуулж, гэрээ байгуулах тухай, 2020 оны 12 дугаар сарын 21-ний өдөр хамтран ажиллах гэрээ байгуулж гэрээ байгуулах тухай мэдэгдлүүдийг тус тус хүргүүлсэн боловч талууд гэрээний нэг нөхцөл дээр санал нэгдээгүй учир гэрээг байгуулж чадаагүй байна.

Үр дүнд нь 2021 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн Татварын Ерөнхий газрын улсын байцаагч нь Үнэт цаас гаргагчийг Татварын ерөнхий хуулийн 34.4.2 дахь хэсэгт заасан үүргээ биелүүлээгүй гэж үзэн Зөрчлийн тухай хуулийн 11.19.7-д заасны дагуу торгох шийтгэл ногдуулсан байна. Үнэт цаас гаргагч дээрх шийдвэрийг эс зөвшөөрч, шийтгэлийн хуудсыг хүчингүй болгуулах шаардлага бүхий нэхэмжлэл Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд гаргасан байна.

Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүх дүгнэхдээ хэдийгээр Үнэт цаас гаргагчаас албан бичгүүдээр гэрээнд тусгах санал, гэрээний төсөл зэргийг хүргүүлж байсан хэдий ч энэ нь Татварын ерөнхий хуулийн 34 дүгээр зүйлийн 34.4.2-т заасан мэдээлэл хүргүүлэх үүргийг биелүүлээгүй үйлдлийг зөвтгөх үндэслэл болохгүй хэмээн үзэж, Үнэт цаас гаргагчийг Зөрчлийн тухай хуулийн 11.19 дүгээр зүйлийн 7.3-д заасан зөрчлийг гаргасанд тооцож, маргаан бүхий захиргааны акт гаргасан нь хуульд нийцсэн хэмээн дүгнэсэн ба Захиргааны хэргийн Давж заалдах шатны шүүхээс анхан шатны шүүхийн дээрх шийдвэрийг хэвээр үлдээж шийдвэрлэсэн байна.





(iii) Ипотекийн зээлийн үйлчилгээний шимтгэлтэй холбоотойгоор

Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын даргын 2022 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн 01/07 дугаартай удирдамжийн дагуу арилжааны банкуудаас аж ахуй эрхлэгч, иргэдэд олгож буй зээлийн шимтгэл, хураамж нь Өрсөлдөөний тухай хууль, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль тогтоомжид нийцэж байгаа эсэхэд 2022 оны 05 дугаар сарын 10-ны өдрөөс 05 дугаар сарын 27-ны өдрийг хүртэлх хугацаанд хяналт шалгалтыг явуулсан ба тус хяналт шалгалтаар арилжааны банкууд нь иргэдэд олгож буй ипотекийн хөнгөлөлттэй зээл олголтын шимтгэлийг ижил хэмжээгээр тогтоож, өрсөлдөөнийг хязгаарлахад чиглэсэн бараа бүтээгдэхүүний үнийг хэлэлцэн тогтоох гэрээ, хэлцэл (картель) байгуулсан байж болзошгүй”, “хууль ёсны ашиг сонирхолд харшлах болон хэрэглэгчийг зүй бусаар хохироох худалдааны арга хэрэглэсэн байж болзошгүй” гэсэн 2 зөрчилд нэр бүхий банкууд (Үнэт цаас гаргагчийг оролцуулан нэр бүхий бусад 7 банк)-ад холбогдуулан 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдөр Зөрчлийн тухай хуулийн тусгай ангийн 10.7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.1 дэх заалт, 10.7 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 4.7 дахь заалтаар зөрчлийн хэрэг нээж, хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулж, улсын байцаагч 2022 оны 08 дугаар сарын 12-ны өдөр Зөрчлийн тухай хуулийн 10.7 дугаар зүйлийн 4.7 дахь заалтад “хэрэглэгчийг хууль бусаар хохироох худалдааны арга хэрэглэсэн” гэх зөрчилд тус бүр 20,000,000 төгрөгөөр торгох шийтгэл оногдуулж, мөн өдөр “зөрчлийн үр дагаврыг арилгуулах” эрх бүхий албан тушаалтны даалгавраар “орон сууцны хөнгөлөлттэй ипотекийн зээл олголтын шимтгэлийг гарч буй зардалтай нь уялдуулан үндэслэлтэй тогтоож, харилцагчтай байгуулж буй зээлийн гэрээнд өөрчлөлт оруулах арга хэмжээ авах”-ыг даалгасан байна. Үнэт цаас гаргагч болон нэр бүхий бусад арилжааны банкууд дээрх шийдвэрийг эс зөвшөөрч Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын улсын байцаагчийн шийтгэлийн хуудсууд, зөрчлийн үр дагаврыг арилгуулах тухай эрх бүхий албан тушаалтны даалгавруудыг тус тус хүчингүй болгуулах шаардлага бүхий гомдлыг гаргасан байна.

10005

Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүх 2023 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн 0346 дугаар шийдвэрээр Зөрчлийн тухай хуулийн 10.7 дугаар зүйлийн 4.7-д заасан зөрчил үйлдэгдсэн гэж эрх бүхий албан тушаалтан тогтоох ажиллагаа хийгээгүй, зөрчил тогтоогдоогүй байхад шийтгэл оногдуулсан шийтгэлийн хуудас, зөрчлийн үр дагаврыг арилгуулахаар бичсэн эрх бүхий албан тушаалтны даалгавар хууль бус бөгөөд гомдол гаргагч нарын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хууль бусаар зөрчсөн, түүнчлэн ипотекийн зээлийн үйлчилгээний зардлыг шингээсэн шимтгэлийг банк өөрөө тогтоож, гэрээндээ тусгах замаар зээлдэгчээр төлүүлэх үйл ажиллагаа нь хууль болон захиргааны хэм хэмжээний актаар зөвшөөрсөн үйл ажиллагаа хэмээн дүгнэж “арилжааны банкууд ипотекийн зээлийн үйлчилгээ үзүүлэхдээ авах шимтгэлийн хэмжээг зээлийн дүнгийн 1 хувиар тогтоон авч буй үйлдлийг Өрсөлдөөний тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.10 дахь “аж ахуй эрхлэгч өрсөлдөөнийг хязгаарлахад чиглэсэн хууль ёсны ашиг сонирхолд харшлах болон хэрэглэгчийг хууль бусаар хохироох худалдааны арга хэрэглэх хориглосон үйл ажиллагаа” биш” хэмээн дүгнэж нэр бүхий арилжааны банкуудад торгох шийтгэл оногдуулж, зөрчлийн үр дагаврыг арилгахыг даалгасан улсын байцаагчийн





шийтгэлийн хуудас, эрх бүхий албан тушаалтны даалгаврыг хүчингүй болгож шийдвэрлэсэн байна.

Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн мэдээллээр хариуцагч нь Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн дээрх шийдвэрийг эс зөвшөөрч давж заалдах гомдол гаргасан бөгөөд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа үргэлжилж байна.

3.10.4. Эрүүгийн хэргийн маргаан

Цагдаагийн ерөнхий газрын харьяа цагдаагийн байгууллагын мэдээллийн сан хариуцсан нэгжийн 2023 оны 5 дугаар сарын 26-ны өдрийн хуулийн этгээдийн эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх тухай, эрүүгийн хариуцлага хүлээж байгаа эсэх тухай тодорхойлолтоос үзвэл үнэт цаас гаргагч нь аливаа гэмт хэрэгт эрүүгийн хариуцлага хүлээгээгүйн дээр өмнө нь эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй болохыг тодорхойлсон байна.

Нэгтгэн дүгнэвэл, Үнэт цаас гаргагч нь аж ахуйн үйл ажиллагааны эсрэг гэмт хэрэгт хариуцагчаар оролцож байгаагүй бөгөөд Иргэний хэргийн анхан шатны шүүхээр шийдвэрлэгдсэн хэрэгт хариуцагчаар, Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхээр шийдвэрлэгдсэн захиргааны хэрэгт нэхэмжлэгчээр тус тус оролцож байсан ба Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 12.2 дахь хэсэгт тус тус заасны дагуу хуулийн хүчин төгөлдөр болсон шүүхийн шийдвэр, магадлалд заасныг сайн дураар биелүүлсэн байна.

Түүнчлэн, энэхүү Дүгнэлт гарах өдрийн байдлаар Үнэт цаас гаргагч нь шүүхийн шийдвэрээр аливаа иргэн, хуулийн этгээдэд өр төлбөргүй болохыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын 2023 оны 5 дугаар сарын 8-ны өдрийн лавлагаагаар тогтоогдож байна.





3.11. Үнэт цаас гаргагч нь татвар, нийгмийн даатгал болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт өр төлбөртэй эсэх тухай

Банк нь татвар, нийгмийн даатгал болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар өр төлбөртэй эсэхийг тодруулах зорилгоор Бид төрийн эрх бүхий байгууллагуудаас холбогдох лавлагаа, мэдээллийг гаргуулан авсан болно. Тодруулбал:

- Шийдвэр гүйцэтгэх албаны 2023 оны 5 дугаар сарын 8-ны өдрийн 1132 тоот тодорхойлолтод дурдсаны дагуу Банк нь шүүхийн шийдвэрээр иргэн, хуулийн этгээдэд төлбөргүй байна;
- Нийгмийн даатгалын ерөнхий газраас олгосон 2023 оны 5 дугаар сарын 3-ны өдрийн O2353Y08L000026379254 тоот Ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тодорхойлолтоос үзвэл Банк нь нийгмийн даатгалын шимтгэлийн өглөггүй байна;
- Монголын гаалийн 2023 оны 5 дугаар сарын 4-ний өдийн T23EMDT2N тоот тодорхойлолтод дурдсаны дагуу Банк нь гаалийн байгууллагад өргүй байна.
- Монголын татварын албаны 2023 оны 5 дугаар сарын 3-ны өдрийн 23.1003.6eedfe46-ffde-439f-a5ad-edc83dbee616 тоот тодорхойлолтоос үзэхэд Банк нь татварын 12,304,055,025.80 төгрөгийн дутуу, 74,453,298,187.74 төгрөгийн илүү төлөлттэй байна.

2023 5 29

Дүгнэлт гаргасан:

.....
Гомбосүрэнгийн Батжаргал
Хуульч, нөхөрлөлийн гишүүн
.....
Идэрхангайн Учралбаяр
Гүйцэтгэх захирал, хуульч, нөхөрлөлийн гишүүн



20230929

БҮРТГЭВ-02

СЭХ
2023 оны 09 сар 29 өдөр
БҮРТГЭВ
№ 1

ХАВСРАЛТ № 1- БАНКНЫ ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНУУД НЬ ХУУЛЬД ЗААСАН ШААРДЛАГЫГ ХАНГАЖ
БАЙГАА ЭСЭХ ТАЛААРХ ХУУЛЬ ЗҮЙН ШИНЖИЛГЭЭ, ДҮГНЭЛТ



№	Нэр	Албан тушаал	Төрийн болон нутгийн захиргааны байгууллага, тэрэг, цаглаа, шүүх, прокурорын байгууллагад улирдах албан тушаал хашдаггүй байх	Ял шийтгэл эдлээгүй байх	Компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан байх	Тохиромжтой этгээдийн шаардлага хангаж байгаа эсэх	Банкны тухай хууль, Компанийн тухай хууль болон Компанийн засаглалын кодекст заасан шаардлагыг хангаж байгаа эсэх
1	Харада Ясунари	ТУЗ-ийн ердийн гишүүн	Харада Ясунаригаас Хуулийн фирмд гаргаж өгсөн 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн Баталгаанаас үзэхэд энэхүү шаардлагыг хангаж байна.	Харада Ясунаригаас Хуулийн фирмд гаргаж өгсөн 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн Баталгаанаас үзэхэд энэхүү шаардлагыг хангаж байна.	Компанийн засаглалын үндэсний зөвлөлөөс зохион байгуулсан сургалтад хамрагдаж, № 0230533 дугаар бүхий гэрчилгээ 2022 оны 02 дугаар сарын 10-ны өдөр авсан байх тул тухайн шаардлагыг хангаж байна	Энэхүү шаардлагыг хангаж байгаа болох нь түүний анкет, Харада Ясунаригаас Хуулийн фирмд гаргаж өгсөн 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн Баталгаа, Монголбанкны 2022 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн А-1/1053 тоот зөвшөөрөл, Монголбанкаас Хуулийн фирмд ирүүлсэн 2023 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн Б-10/424 тоот албан бичгээр нотлогдож байна.	Энэхүү шаардлагыг хангаж байгаа болох нь түүний анкет, Ц.Баатарсайханаас Хуулийн фирмд гаргаж
2	Ц.Баатарсайхан	ТУЗ-ийн ердийн гишүүн	Ц.Баатарсайханаас Хуулийн фирмд гаргаж өгсөн 2023 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн	Цагдаагийн ерөнхий газраас олгосон "Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байгаа эсэх тухай	Компанийн засаглалын хөгжлийн төлөөс зохион байгуулсан сургалтыг амжилттай дүүргэж	Энэхүү шаардлагыг хангаж байгаа болох нь түүний анкет, Ц.Баатарсайханаас Хуулийн фирмд гаргаж	Энэхүү шаардлагыг хангаж байгаа болох нь түүний анкет, Ц.Баатарсайханаас Хуулийн фирмд гаргаж

УЛААНБААТАР ХОТ
МХУ-ийн гишүүн
Брокер, дилерийн
"ИЛДСЕК"
УИСК ХК
1102034174 7097072

2023 5 29

2023.09.23

БҮРТГЭВ-02

2023.09.23
БҮРТГЭВ-02

<p>3 Иший Кисабуро</p>	<p>ТУЗ-ийн ердийн гишүүн</p>	<p>Баталгаанаас үзэхэд энэхүү шаардлагыг хангаж байна.</p>	<p>Баталгаанаас үзэхэд энэхүү шаардлагыг хангаж байна.</p>	<p>2012 оны 05 дугаар сарын 26-ны өдөр гэрчилгээ авсан байх тул шаардлагыг хангаж байна</p>	<p>Хуулийн фирмд гаргаж өгсөн 2023 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн Баталгаа, Цагдаагийн ерөнхий газраас олгосон "Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байгаа эсэх тухай тодорхойлолт", "Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх тухай тодорхойлолт"-оор нотлогдож байна.</p>	<p>өгсөн 2023 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн Баталгаа, Монголбанкны 2022 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн А-1/1182 тоот зөвшөөрөл, Монголбанкнаас Хуулийн фирмд ирүүлсэн 2023 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн Б-10/424 тоот албан бичиг, Монгол банкны зээлийн мэдээллийн сангийн лавлагаа болон Шүүхийн шийдвэрээр буцаад төлбөргүй эсэх тухай тодорхойлолтоор нотлогдож байна.</p>
<p>Иший Кисабуроос Хуулийн фирмд гаргаж өгсөн 2023 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн Баталгаанаас үзэхэд энэхүү шаардлагыг хангаж байна.</p>	<p>Иший Кисабуроос Хуулийн фирмд гаргаж өгсөн 2023 оны 05 дугаар сарын 24-ний өдөр амжилттай дүүргэж 2022 оны 08 дугаар сарын 01-ний өдөр гэрчилгээ авсан байх тул тухайн шаардлагыг хангаж байна.</p>	<p>Иший Кисабуроос Хуулийн фирмд гаргаж өгсөн 2023 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн Баталгаагаар нотлогдож байна.</p>	<p>Энэхүү шаардлагыг хангаж байгаа болох нь түүний анкет, диплом, Иший Кисабуроос Хуулийн фирмд гаргаж өгсөн 2023 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн Баталгаа, Монголбанкны 2022 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн А-1/1118 тоот зөвшөөрөл, Монголбанкнаас Хуулийн фирмд ирүүлсэн 2023 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн Б-10/424 тоот албан бичгээр нотлогдож байна.</p>	<p>Энэхүү шаардлагыг хангаж байгаа болох нь түүний анкет, диплом, Иший Кисабуроос Хуулийн фирмд гаргаж өгсөн 2023 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн Баталгаагаар нотлогдож байна.</p>	<p>Энэхүү шаардлагыг хангаж байгаа болох нь түүний анкет, диплом, Иший Кисабуроос Хуулийн фирмд гаргаж өгсөн 2023 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн Баталгаа, Монголбанкны 2022 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн А-1/1118 тоот зөвшөөрөл, Монголбанкнаас Хуулийн фирмд ирүүлсэн 2023 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн Б-10/424 тоот албан бичгээр нотлогдож байна.</p>	<p>Энэхүү шаардлагыг хангаж байгаа болох нь түүний анкет, диплом, Иший Кисабуроос Хуулийн фирмд гаргаж өгсөн 2023 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн Баталгаа, Монголбанкны 2022 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн А-1/1118 тоот зөвшөөрөл, Монголбанкнаас Хуулийн фирмд ирүүлсэн 2023 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн Б-10/424 тоот албан бичгээр нотлогдож байна.</p>

2023.09.23



СЭХ
2023.08.13 өдөр
БҮРТГЭВ-02
№

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023.08.13
БҮРТГЭВ-02

МОНГОЛ УЛС
Д.Хулан
УКН0009
ХААР
БАНК ХХК

УЛААНБААТАР ХОТ
МХБ-ийн гишүүн
Андеррантер
Брокер, дилерийн
"БИДСЕК"
ҮНД ХА
1115205447 4 2052482

4	ТУЗ-ийн ердийн гишүүн, ТУЗ-ийн орлогч дарга	Д.Хулангаас Хуулийн фирмд гаргаж өгсөн 2023 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн Баталганаас үзэхэд энэхүү шаардлагыг хангаж байна.	Цагдаагийн ерөнхий газраас олгосон "Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байгаа эсэх тухай тодорхойлолт", "Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх тухай тодорхойлолт" болон Д.Хулангаас Хуулийн фирмд гаргаж өгсөн 2023 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн Баталганаас үзэхэд тухайн шаардлагыг хангаж байна.	Компанийн засаглалын хөгжлийн төвөөс зохион байгуулсан сургалтыг амжилттай дүүргэж 2012 оны 05 дугаар сарын 26-ны өдөр гэрчилгээ авсан байх тул тухайн шаардлагыг хангаж байна	Энэхүү шаардлагыг хангаж байгаа болох нь түүний анкет, диплом, Д.Хулангаас Хуулийн фирмд гаргаж өгсөн 2023 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн Баталгаа, Монголбанкны 2022 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн А-1/1183 тоот зөвшөөрөл, Монголбанкаас Хуулийн фирмд ирүүлсэн 2023 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн Б-10/424 тоот албан бичиг, Монгол банкны зээлийн сангийн мэдээллийн сангийн лавлагаа болон Шүүхийн шийдвэрээр бусдад төлбөргүй эсэх тухай тодорхойлолтоор нотлогдож байна.	Энэхүү шаардлагыг хангаж байгаа болох нь түүний анкет, диплом, Жон Логоос Хуулийн фирмд гаргаж өгсөн 2023 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн Баталгаагаар нотлогдож байна.
5	Жон Ло	Жон Логоос Хуулийн фирмд гаргаж өгсөн 2023 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн Баталганаас үзэхэд энэхүү шаардлагыг хангаж байна.	Жон Логоос Хуулийн фирмд гаргаж өгсөн 2023 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн Баталганаас үзэхэд энэхүү шаардлагыг хангаж байна.	Risks, Opportunities, Assessment and Management (ROAM), Inc-ээс зохион байгуулсан Компанийн засаглалын сургалтыг амжилттай дүүргэж 2016 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр гэрчилгээ авсан байх тул тухайн шаардлагыг хангаж байна.	Энэхүү шаардлагыг хангаж байгаа болох нь түүний анкет, диплом, Жон Логоос Хуулийн фирмд гаргаж өгсөн 2023 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн Баталгаагаар нотлогдож байна.	Энэхүү шаардлагыг хангаж байгаа болох нь түүний анкет, диплом, Жон Логоос Хуулийн фирмд гаргаж өгсөн 2023 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн Баталгаагаар нотлогдож байна.

2023 54.5.29

СЗУ
ОНЦ
БҮРТ
А

<p>дугаар сарын 23-ны өдрийн Б-10/424 тоот албан бичгээр нотлогдож байна.</p>	<p>Энэхүү шаардлагыг хангаж байгаа болох нь түүний анкет, диплом, Б.Амарсанагаас Хуулийн фирмд гаргаж өгсөн 2023 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн Баталгаа, Монголбанкны 2022 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн А-1/1105 тоот зөвшөөрөл, Монголбанкнаас Хуулийн фирмд ирүүлсэн 2023 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн Б-10/424 тоот албан бичиг, Монгол банкны зээлийн мэдээллийн сангийн лавлагаа болон Шүүхийн шийдвэрээр бусдад төлбөргүй эсэх тухай тодорхойлолтоор нотлогдож байна.</p>	<p>Энэхүү шаардлагыг хангаж байгаа болох нь түүний анкет, диплом, А.Тамираас Хуулийн фирмд гаргаж өгсөн 2023 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн Баталгаа, Цагдаагийн ерөнхий газраас олгосон "Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байгаа эсэх тухай тодорхойлолт", "Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх тухай тодорхойлолт"-оор нотлогдож байна.</p>	<p>Компанийн засаглалын үндэсний зөвлөлөөс зохион байгуулсан сургалтыг амжилттай дүүргэж 2012 оны 10 дугаар сарын 17-ны өдөр гэрчилгээ авсан байх тул тухайн шаардлагыг хангаж байна.</p>	<p>Цагдаагийн ерөнхий газраас олгосон "Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байгаа эсэх тухай тодорхойлолт", "Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх тухай тодорхойлолт" болон Б.Амарсанагаас Хуулийн фирмд гаргаж өгсөн 2023 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн Баталгаанаас үзэхэд тухайн шаардлагыг хангаж байна.</p>	<p>Б.Амарсанагаас Хуулийн фирмд гаргаж өгсөн 2023 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн Баталгаанаас үзэхэд энэхүү шаардлагыг хангаж байна.</p>	<p>ТУЗ-ийн ердийн гишүүн</p>	<p>Б.Амарсанаа</p>
<p>дугаар сарын 23-ны өдрийн Б-10/424 тоот албан бичгээр нотлогдож байна.</p>	<p>Энэхүү шаардлагыг хангаж байгаа болох нь түүний анкет, диплом, А.Тамираас Хуулийн фирмд гаргаж өгсөн 2023 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн Баталгаа, Цагдаагийн ерөнхий газраас олгосон "Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байгаа эсэх тухай тодорхойлолт", "Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх тухай тодорхойлолт"-оор нотлогдож байна.</p>	<p>Энэхүү шаардлагыг хангаж байгаа болох нь түүний анкет, диплом, А.Тамираас Хуулийн фирмд гаргаж өгсөн 2023 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн Баталгаа, Цагдаагийн ерөнхий газраас олгосон "Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байгаа эсэх тухай тодорхойлолт", "Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх тухай тодорхойлолт" болон А.Тамираас Хуулийн фирмд гаргаж өгсөн 2023 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн Баталгаанаас үзэхэд энэхүү шаардлагыг хангаж байна.</p>	<p>Компанийн засаглалын үндэсний зөвлөлөөс зохион байгуулсан сургалтад хамрагдаж, № 0230494 дугаар бүхий гэрчилгээг 2021 оны 04 дүгээр сарын 09-ний өдөр гэрчилгээ авсан байх тул тухайн шаардлагыг хангаж байна.</p>	<p>Цагдаагийн ерөнхий газраас олгосон "Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байгаа эсэх тухай тодорхойлолт", "Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх тухай тодорхойлолт" болон А.Тамираас</p>	<p>А.Тамираас Хуулийн фирмд гаргаж өгсөн 2023 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн Баталгаанаас үзэхэд энэхүү шаардлагыг хангаж байна.</p>	<p>ТУЗ-ийн хараат бус гишүүн</p>	<p>А.Тамир</p>

2023.5.29

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
УРБИ000
ХААН БАНК ХХК

УЛААНБААТАР ХОТ
МХБ-ийн гишүүн
Андерраугер
Брокер, дилерийн
"БИДСЕХ"
УИХ-ХУ
111020447 2058482

ОН 2023.06.13
 БҮРТ
 №

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЭК
 MONGOLIAN STOCK EXCHANGE
 202309233
 БҮРТГЭВ-02

			<p>Хуулийн фирмд гаргаж өгсөн 2023 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн Баталгаанаас үзэхэд тухайн шаардлагыг хангаж байна.</p>	<p>шаардлагыг хангаж байна</p>	<p>эрүүгийн хариуцлага хүлээж байгаа эсэх тухай тодорхойлолт", "Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх тухай тодорхойлолт"-оор нотлогдож байна.</p>	<p>оны 03 дугаар сарын 10-ны өдрийн А-1/232 тоот зөвшөөрөл, Монголбанкнаас Хуулийн фирмд ирүүлсэн 2023 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн Б-10/424 тоот албан бичиг, Монгол банкны зээлийн мэдээллийн сангийн лавлагаа болон Шүүхийн шийдвэрээр бусдад төлбөргүй эзэх тухай тодорхойлолтоор нотлогдож байна.</p>
